



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Мударга ёс, хөгжил дэвшилд

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ **2022**
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 он



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР НЬ

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий **ХАРААТ БУС, БИЕ ДААСАН, ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГА** мөн.

Алсын хараа:

Шударга ёсны төлөө иргэдийн итгэл хүлээсэн байгууллага байна.

Бидний уриа:

Шударга ёс, хөгжил дэвшилд

Эрхэм зорилго:

Авлигатай тэмцэж, шударга ёсыг тогтоон хөгжил дэвшилд хүргэнэ.

АГУУЛГА

НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	4
Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	9
Судалгаа, шинжилгээний ажил	22
Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	25
Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах үйл ажиллагаа	37
Авлигын хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа	43
ХОЁР. АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	49
Гадаад судалгааны үр дүн	50
Дотоод судалгааны үр дүн	64
ГУРАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (2017-2022)	79
ДӨРӨВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2022	305
ХАВСРАЛТ	356

МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан болон авлигын ерөнхий нөхцөл байдлыг үүгээр мэдээлж байна.




01.




**НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ**





ӨГҮҮЛБЭРЭЭР



Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын **47.3** хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн.



518,039,332,298 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан.



Гадаад улс орнуудаас нийт **12.2** сая ам.долларын хөрөнгийг буцаан авах үндэслэлийг тогтоож, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон.



42 шийдвэр, дүрэм, журам хянасан. Үүнээс **33** нь хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй нөхцөл байдал тогтоогдсон.



Монгол Улс дахь авлигад нөлөөлж буй хүчин зүйлийн системийн динамик загвар боловсруулав.



Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагууд дунджаар **73.9** оноо авсан.



Хүүхдийн шударга байдлын түвшин **3.96** оноотой гарсан.



Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс **621**-т нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.



ДҮРЭМ, ЖУРАМ ХЯНАВ

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны «Заавар батлах тухай» А/183 дугаар тушаалаар баталсан «Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар»-ын дагуу нийт **42** шийдвэр, дүрэм, журмыг хянасан. Үүнээс **33** нь хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй нөхцөл байдал тогтоогдсон. Иймд тухайн дүрэм, журмын бүхэлд нь хүчингүй болгох тухай **23**, өөрчлөлт оруулах **6**, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх **4** саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Хүргүүлсэн саналын дагуу **2** шийдвэрийг хүчингүй болгож, **3** шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч байгаа тухай хариу ирүүлээд байна.

МЭДЭГДЭЛ, ШААРДЛАГЫН МӨРӨӨР АЖИЛЛАВ

2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахаар хуулийн этгээдэд хүргүүлсэн **53** мэдэгдлийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийв. Үүнээс **39** мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авч, авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгасан байлаа. Мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээг аваагүй **12** байгууллагад зөвлөмж, шаардлага хүргүүлээд байна.



Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомж зөрчсөн нийтийн албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн **130** шаардлага, албан бичгийн мөрөөр тухайн зөрчил, гэмт хэргийг давтан гаргуулахгүй байх, шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр ажиллав.

ХЯНАЛТ ТАВЬЖ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ



Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн **6** дүүргийн **20** сургууль, **9** цэцэрлэгийн элсэлт, түүнтэй холбогдох бусад үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав. Сургууль, цэцэрлэгийн элсэлтийн үйл ажиллагаанд хамран сургах тойргийн бус хүүхдийг элсүүлэх явдлыг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг

үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өглөө. Нийслэлийн **9** дүүрэгт зохион байгуулагдсан хугацаат цэргийн албаны татлагын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил, бусдад давуу байдал олгох нөхцөл гаргахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн зөрчил гаргахгүй байх шаардлагаар тандалт хийж, тухайн ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдад мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, албан хаагчдын ёс суртахууныг дээшлүүлэх, дотоод хяналыг сайжруулах чиглэлээр дараах байгууллага, албан тушаалтанд **47 зөвлөмж** хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна:



- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд (4 удаа)
- Зам, тээврийн хөгжлийн сайд (3 удаа)
- Боловсрол, шинжлэх ухааны сайд (3 удаа)
- Эрүүл мэндийн сайд (2 удаа)
- Боловсролын ерөнхий газрын дарга (2 удаа)
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Эрчим хүчний сайд
- Соёлын сайд
- Барилга, хот байгуулалтын сайд
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон, Ховд, Хөвсгөл, Увс аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- “Хүрээ” амаржих газрын дарга
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн захирал
- Нийслэлийн боловсролын газрын дарга
- Орхон аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Баянзүрх дүүргийн Боловсролын газрын дарга
- Сонгинохайрхан дүүргийн Боловсролын газрын дарга
- Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дарга
- Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга
- Дотоод хэргийн Их сургууль

УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Дэлхийн улс орнуудын удирдагчид 2003 онд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцод нэгдэн, гарын үсэг зурах бага хурлыг Мексикийн Мерида хотноо зохион байгуулсан ба энэхүү өдрийг Авлигын эсрэг олон улсын өдөр хэмээн НҮБ-аас албан ёсоор тунхагласан билээ.

Монгол Улс тус Конвенцод 2005 онд нэгдэн орсон бөгөөд Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан хүүхэд багачууд, оюутан залууст шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын хор хөнөөлийг ухуулан, таниулах, уриалах контент бэлтгэн түгээх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг зэрэг олон талт арга хэмжээг хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, иргэд, олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулж, өргөн хүрээнд тэмдэглэж иржээ.

2022 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан “Дэлхий нийтээрээ авлигын эсрэг

нэгдье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан дараах сэдвээр холбогдох салбар, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар цуврал хэлэлцүүлэг өрнүүлж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг харьяалах салбар хариуцсан Засгийн газрын гишүүн, төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв:



- 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр төрийн байгууллагын ажлын уялдааг сайжруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системийг бий болгох зорилгоор “Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход тулгарч буй асуудал, цахимжуулалт, гарц шийдэл” сэдвээр;
- 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр бүх шатны боловсролын байгууллагын удирдах албан тушаалтан, багш, ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлага, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Авлигаас ангид боловсрол: Ёс зүй ба шударга байдал” сэдвээр;



- 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт, түүний үр шимийг хүртэх явцад үүсч буй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор “Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” сэдвээр;
- 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр авто замын салбарт авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, таслан зогсоох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, ил тод хүргэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах зорилгоор “Зам дагасан авлига” сэдвээр;
- 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр барилгын салбарыг авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, инженерүүдийн ёс зүйг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх зорилгоор “Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй” сэдвээр;
- 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, амьжиргаа дэмжих зөвлөлийн хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор “Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа: уялдаа холбоо” сэдвээр;

- 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, түүнд тавих хяналт, ил тод байдлыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой шийдэлд хүрэх зорилгоор “Байгалийн нөөц ашиглалт: Орлого ба Зарлага” сэдвээр;
- 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр уул уурхайн салбарт авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, таслан зогсоох, гүйцэтгэх удирдлагын ёс зүйг бэхжүүлэх, ил тод болгох, хүнд суртал, чирэгдлийг арилгах зорилгоор “Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэл ба гүйцэтгэх удирдлагын ёс зүй, ажлын үр дүнг тооцох нь” сэдвээр.
- Хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоодын санал санаачилга, хүчин чармайлтыг идэвхжүүлэх, өргөжүүлэх, бизнесийн орчин дахь авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангах, бизнесийн ёс зүйг дээшлүүлэх, цаашид хамтран ажиллах зорилгоор “Бизнесст ёс зүйг эрхэмлэнэ” уулзалтыг зохион байгуулав.



АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2021 оны үнэлгээгээр 21 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл дунджаар **77.6** хувь, яамдынх **76.0** хувьтай үнэлэгдсэн бөгөөд цаашид төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах асуудлын талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛД МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭВ



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлд **22** шүүгчид холбогдуулан хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлээгүй нь “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн гэх үндэслэлээр 2021 онд гомдол гаргасныг 2022 онд Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаан, тус хорооны бүх шүүгчдийн хуралдаанаар үргэлжлүүлэн хянан хэлэлцэж, нэр бүхий **11** шүүгч ёс зүйн зөрчил гаргасан болох нь тогтоогдсон тул энэхүү нөхцөл байдал, цаашид шүүгч нарын ёс зүй, хууль дээдлэх, үнэнч шударга байх зан суртахууны төлөвшлийг дээшлүүлэх шаардлагатай байгаа талаар Шүүхийн Ерөнхий зөвлөлд мэдэгдлээ.

“МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБОО” ТББ-ТАЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Монголын шүүгчдийн холбоо” ТББ-аас гаргасан саналыг хүлээн авч, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах” 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчдээс “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ёс зүйн дүрмээр хүлээсэн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлдэг байх ёс зүйн хэм хэмжээг баримталдаг байх зэрэг асуудлаар санал солилцох зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Энэ хүрээнд “Шүүх ба Олон нийт” сэдвээр бүрэн хэмжээний нэвтрүүлэг, Дэлхийн Монголчуудын радио MGL радио 88.3-аар богино хэмжээний контентийг нэвтрүүлж, “Шүүгч ба олон нийт” хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагыг хамтран зохион байгууллаа.



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭВ



■ Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газрын дарга, эрх бүхий албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газарт албан ёсны айлчлал хийлээ. Талууд айлчлалын хүрээнд албан ёсны уулзалт хийж, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд харилцан зөвшилцөх, мэдээлэл солилцох, авлигатай тэмцэх чиглэлд туршлага солилцох, шударга ёсыг дэлгэрүүлэх болон талуудын ашиг сонирхлын хүрээнд бусад салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцов.



■ Эрх бүхий албан хаагчид Бүгд Найрамдах Латви Улс, ХБНГУ-ын Авлигатай тэмцэх газарт албан ёсны айлчлал хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



■ Малайз Улсын Куала Лумпур хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн жилийн хуралд оролцож, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хамгааллаа.



■ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээнээс Франц Улсад зохион байгуулсан “Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг шийдвэр гаргагчдын Өндөр түвшний уулзалт”, Сүлжээний “Удирдах зөвлөлийн 27 дугаар хурал”-д байгууллагын удирдлага, эрх бүхий албан хаагчид оролцож, Истанбулын Авлигын эсрэг мониторинг хийх аргачлалыг баталж, ажлын төлөвлөгөөг эцэслэв.



- НҮБ-ын МБГХТА-наас Австри Улсын Вена хотноо зохион байгуулсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хэрэгжилтийн талаарх бүгд хуралд оролцов



- Австри Улсын Вена хотноо зохион байгуулагдсан “НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганы үеэр баталсан улс төрийн тунхаглалын хэрэгжилтийг хэлэлцэх Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн орнуудын чуулган хоорондын уулзалт”-д Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал оролцож “Хөрөнгө буцаан авах нь” сэдэвт панелд илтгэл хэлэлцүүллээ.



- Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (АРИН-АП)-ний жилийн бүгд хуралд Монгол Улсын авлигын нөхцөл байдал, гадаад улсаас хулгайлагдсан хөрөнгө хураасан, буцаасан сайн туршлагын талаар илтгэл хэлэлцүүлсэн нь хуралд оролцогчдын зүгээс өндрөөр үнэлэгдсэн.



- Турк Улсад зохион байгуулагдсан ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ (АСН)-ний Хууль сахиулагчдын 12 дугаар хурал, Испани Улсад зохион байгуулагдсан Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (Globe)-ний гуравдугаар чуулганд эрх бүхий албан хаагчид оролцож, Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаар зөвшилцөв.



- НҮБ-ын МБГХТА-аас Кени Улсад зохион байгуулсан “Хөрөнгө буцаан авах ажиллагааны талаарх олон улсын хурал”-д оролцов.

- Авлигын эсрэг олон улсын академи (IACA)-аас дэвшүүлсэн Авлигын эсрэг дэлхийн хотуудын сүлжээ буюу “Global Anti-Corruption Cities Network” шинэ санаачилгад Улаанбаатар хотыг нэгдэн оруулах ажиллагаанд Авлигатай тэмцэх газар зохицуулагч байгууллагаар ажиллахаар боллоо.
- ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тайлан боловсруулах, Алжир болон Ливан Улсын тайланг хянах” ажлын дэд хэсгийн хуралд оролцож, Алжир Улсын тайлангийн холбогдох дүгнэлтийг боловсруулан хүргүүллээ.
- Байгууллагын 2021 оны болон 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан (Anti-Corruption Annual Report 2021, 2022 II Mongolia)-г англи хэл дээр бэлтгэн Монгол Улс дахь гадаад улсын Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллага, олон улсын байгууллага, Транспэрэнси Интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индекстэй холбогдолтой байгууллага, гадаад улсын мэдээний цахим хуудас болон гадаад улсын адил чиг үүрэг бүхий байгууллага, албан хаагч, судлаачдад хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ



Гадаад, дотоодын дараах байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан ойлголцлын Санамж бичиг, Гэрээ байгуулав:

- Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газартай “Харилцан ойлголцлын Санамж бичиг”
- Монголын Хөлбөмбөгийн холбоотой “Хамтын ажиллагааны Санамж бичиг”
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ)-тэй “Хамтын ажиллагааны Санамж бичиг”
- “Монголын олон суваг дамжуулагчдын холбоо” ГҮТББ-тай хамтран ажиллах Санамж бичиг
- ЦЕГ-тай “Хамтран ажиллах гэрээ”



АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЖ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГААС СУРАЛЦАВ



Албан хаагчдын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулах бодлого баримтлан ажиллалаа. 2022 онд танхимаар болон цахимаар зохион байгуулагдсан дараах сургалтад албан хаагчид хамрагдав:

- Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-нээс зохион байгуулсан «Санхүүгийн аудит хийх техник, стратеги» сэдэвт сургалтад 30 албан хаагч;
- АНУ-ын ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох нь” сэдэвт сургалтад 10 албан хаагч;
- Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас зохион байгуулсан “Удиртгал: Хөрөнгийн менежмент” сургалтад 52 албан хаагч;
- БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооноос зохион байгуулсан “ACRC Авлигын эсрэг виртуал сургалтын курс зохион байгуулах сургалт”-д 10 албан хаагч;
- Дэлхийн Банк, НҮБ-ын МБГХТА-тай хамтран Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сургалтад 15, «Виртуал валютын тухай ахисан түвшний семинар» сэдэвт сургалтад 30 албан хаагч;

Түүнчлэн зөвхөн байгууллагын албан хаагчдаас гадна бусад хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа:

- Дэлхийн Банк, НҮБ-ын МБГХТА-тай хамтран Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” анхан шатны сургалтад тус байгууллагын болон ЦЕГ, УЕПГ-ын 47 албан хаагч;
- Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга(StAR)-ын удирдагч Найжел Бартлетт, Лиза Боствик нарын Монгол Улсад зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт сургалтад тус байгууллагын болон УЕПГ, ЦЕГ, ДХИС-ийн нийт 26 албан хаагч;
- Дэлхийн Банк, НҮБ-ын МБГХТА-тай хамтран Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сургалтад УПЕГ, ШШГЕГ, ДХИС-ийн 20 албан хаагчийг хамруулан суралцууллаа.

АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ХОЁР БОЛОН ТАВДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭВ



Монгол Улсаас хүргүүлсэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн тайлангийн хүрээнд нэмэлт мэдээлэл авах, тодруулга авах, хамтран ажиллах буюу Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хоёр болон тавдугаар бүлгийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний уулзалт, хэлэлцүүлэг, холбогдох бусад ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, дэмжлэг үзүүлж, хариуцан ажиллав.



Үнэлгээг хийхээр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын 2 шинжээч, Буркина Фасо Улсын 3, Сингапур Улсын 2 шинжээч хүрэлцэн ирсэн бөгөөд үнэлгээний уулзалтад Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг нийт 36 байгууллагын төлөөлөл оролцлоо.



НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II болон V бүлгийн Монгол Улстай холбогдох хэрэгжилтийн үнэлгээний хураангуй тайланг урьдчилсан байдлаар хүлээн авч, гэмт хэргийн гаралтай хөрөнгө буцаах ажиллагаатай холбоотой жишээ, баримт, холбогдох бусад мэдээллийг нэмж хүргүүлэв.

АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр баталсан Авлигын төсөөллийн индексийг сайжруулах зорилго бүхий ажлын хэсэгт тус байгууллагын эрх бүхий албан хаагч томилогдон ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгээс хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлтийг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

ЦАХИМ СИСТЕМИЙН ИНТЕГРАЦЧИЛАЛ

Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Ухаалаг засаг” төслийн хүрээнд байгууллагад ашиглагдаж байгаа meduuleg.iaac.mn, iad.iaac.mn, e-office, smart.iaac.mn, search.iaac.mn, хасхот.iaac.mn цахим системүүдийг интеграцчилах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, системийн хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах ажлыг өнгөрсөн оны 12 дугаар сараас эхлүүлсэн бөгөөд системийг 2 үе шаттай хөгжүүлэхээр ажиллаж байна.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээг хөндлөнгийн судалгааны байгууллага, шинжээчдээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулав.

Авлигатай тэмцэх бодлогын тасралтгүй байдлыг хангах, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт заасан засаглалын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлыг Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын суурин төлөөлөгчийн газартай хамтран гүйцэтгэж байна.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ДЭХ ОРОЛЦОО

Байгууллагын албан хаагчид дараах хуулийн төслийн ажлын хэсгүүдэд ажиллав:

- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл

МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийндарга, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагууд, яамд, Засгийн газрын агентлагуудад, нийслэлийн болон 21 аймгийн Засаг дарга нарт:

- Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээллийг хүргүүлэв.

Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороонд:

- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан байгууллагын мэдүүлэг гаргавал зохих албан хаагчдын 2021 оны мэдүүлгийн

бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчилсэн бүртгэлийн тухай мэдээллийг хүргүүлэв;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн “Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар”, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх танилцуулгыг хүргүүлэв;

Үндэсний статистикийн хороонд:

- ХАСХОМ-ийн тайлан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг хүргүүлэв;


ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ

Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг **e-Mongolia** системд байршуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хүрээнд e-Mongolia платформ дээр **contact@iaac.mn** хаягт хандан авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах тусдаа талбар үүсгэн мэдээлэл хүлээн авах цонхны хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн.

Төрийн үйлчилгээний иргэд, олон нийттэй харилцах төвийн **11-11** тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг АТГ-ын **110** тусгай дугаарт шууд шилжүүлэн

холбох ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулав.

Байгууллагын хэмжээнд 2022 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг өмнөх онтой харьцуулбал **471** нэгжээр буюу **20.4** хувиар өссөн үзүүлэлттэй байна.



The screenshot shows the 'e-mongolia' portal interface for submitting complaints. The header includes the logo and navigation links. The main heading is 'АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАХ'. Below this, there are several input fields: 'Овог', 'Нэгж', 'Сурвалж/суугаа хэлт', 'Холбогдох утас/цахт', 'Утас', 'Утас 2', and 'Мэдээлэл'. At the bottom, there is a 'Файл хураагч' section with a 'Энд дарж файлаа хууна уу' button and a 'Зөвхөн PDF файлуудыг оруулна уу' note.

АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Дараах байгууллагуудад Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, судалгааны дүнг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулав:


- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Монголын төмөр зам ТӨХК
- Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын алба



ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ


Шударга байдлын үнэлгээнд яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ буюу нийтдээ 78 байгууллагаас үйлчилгээ авсан нийт 15,160 оролцогч (10,600 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 2,620 төрийн албан хаагч, 1,940 шинжээч, бодлогод оролцогч)-ийг хамруулан зохион байгууллаа. Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагууд 100 оноо авахаас дунджаар 73.9 оноо авсан нь 2021 оноос 1.0 пунктээр өссөн үзүүлэлт гарсан.

Яамдын ШБҮ, 2022 он, оноогоор



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийн шударга байдлын судалгаанд аймаг, нийслэлийн хэмжээнд 5,605 сурагч, 2,332 эцэг эх, 1,334 багш, албан хаагч, нийт 9,271 хүн хамрагдсан байна. Судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 3.96 оноотой гарч өмнөх оноос 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй гарсан. Хүүхдийн шударга байдлын түвшин анги дэвших, нас ахих тусам буурах, эрэгтэй эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин зөрүүтэй байх чиг хандлага хадгалагдсаар байна.



БУСАД СУДАЛГАА

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг дээрх давтамжит судалгаанаас гадна дараах судалгааг хийсэн байна:

- Хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хороонд хандаж, үйлчилгээ авсан иргэдийн бүртгэл, статистикийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг 9 дүүргийн 82 хороог хамруулан гүйцэтгүүлсэн.
- Авлигатай тэмцэх газрын олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг боловсруулах чиглэлээр судалгаа хийж, үр дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг тодорхойлж, баримт бичгийг баталгаажуулав.
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах, “Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024) боловсруулах”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнд, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа



бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)” 4 төрлийн судалгаа хийгдсэн. Эдгээр судалгааны ажлын үр дүнд суурилан авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратегийг боловсруулаад байна.

- Монгол Улс дахь авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийн динамик загварыг боловсруулсан.
- Байгууллагын соёлын нөхцөл байдлын судалгааг зохион байгуулав. Судалгааны дүнгийн талаар албан хаагчдын оролцоог ханган ярилцлага, хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан саналыг тайланд тусган, баталгаажуулав. Судалгааны дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.
- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг судалж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж бүхий үнэлгээ, санал боловсруулах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэв.
- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн талаарх судалгааг хийж, үр дүнг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулав.




Танилцуулга, мэдээлэл

Дараах танилцуулга, мэдээллийг боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн:

- Дэлхийн Засаглалын Үзүүлэлт (Worldwide Governance Indicators)-ийн 2020 оны үр дүнгийн талаарх танилцуулга
- Бертелсман сангаас гаргадаг Шилжилтийн индексийн Монгол Улсын 2022 оны үнэлгээний талаарх танилцуулга
- Төрийн албан дахь авлигын нөхцөл байдал, авлигын гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөл болон авлигаас урьдчилан сэргийлэх талаарх, санал танилцуулга
- Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)-ээс гүйцэтгэсэн “Олон нийтийн санал бодлын судалгаа”-ны талаарх танилцуулга
- Монгол Улс дахь авлигын суурь шалтгааны талаарх, шүүхийн байгууллага дахь авлигын нөхцөл байдлын талаарх танилцуулга зэрэг.

АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ

2022 онд авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран **277** удаагийн сургалтыг (цахимаар болон танхимаар) зохион байгуулж, **53,183** хүнийг хамруулснаас төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд **255** удаа **47,294** хүнийг, хувийн хэвшлийн байгууллагад **8** удаа **452** хүнд, **12** удаагийн сургалтаар **4,917** хүнд, **2** удаагийн сургалтад **520** оюутан, залуусыг хамруулсан. Сургалтад хамрагдсан хүний тоог 2021 онтой харьцуулбал **1.9** дахин өссөн үзүүлэлттэй байна.



Нийслэл, дүүргийн Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвүүдтэй хамтран иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулснаар тайлант хугацаанд хууль зүйн туслалцааны төвүүдээр дамжуулан давхардсан тоогоор **1,171,608** иргэнд хүрч ажилласан байна.

ХУВИЙН ХЭВШИЛД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Хувийн хэвшлийн байгууллагыг чадавхжуулах авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувийн хэвшлийн оролцоо, анхаарах асуудал сэдвээр сургалтыг үе шаттай зохион байгуулж, Дорнод аймгийн «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо», Өвөрхангай аймгийн «Оновчтой шийдэл», Дорнод аймгийн «Буйр нуур», Ховд аймгийн «Ховдын толь сонин», Орхон аймгийн «Эрдэнэт хүмүүний нийгэмлэг», “Буурь нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн НҮТББ”, “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” зэрэг ТББ-ын төлөөлөл, Эрдэнэс Таван Толгой ХК, Скайтел ХХК, Түмэн төмөрт ХХК, ЧПМ ХХК, Жакаранда ХХК, МУИС-ийн Бизнесийн сургууль, Сити их сургууль (20), Говь ХХК (захирлууд 30), Капитрон банк (удирдлага, тооцооны төвийн захирал, эрхлэгч, банкны ахлах менежер, эдийн засагч 131), Гаалийн бүрдүүлэлтийн аж ахуйн нэгж (195), Зууны мэдээ сонин, (сэтгүүлч 12), Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ын (6) нийт 478 хүнийг хамруулсан.

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ



“Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ-тай хамтран “Авлигатай тэмцэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо” сэдэвт сургалт, семинарыг 2 удаа зохион байгуулж, нийт орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 69 сэтгүүлчийг, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын төслийн санхүүжилтээр Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагатай хамтран эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр ажилладаг 54 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан юм.

ХЭСГИЙН АХЛАГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Нийслэлийн **9** дүүргийн **191** хорооны **17,234** хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулж, хороодын хэсгийн ахлагч нарт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөөг түргэн шуурхай өгч, хамтран ажиллах зорилгоор “Таны эрх, таны оролцоо” фэйсбүүк группийг ажиллуулж байна.

СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭВ

Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран 21 аймагт авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах **35** сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд сургагч багш нар **55** удаагийн сургалтыг зохион байгуулж **5,730** төрийн албан хаагчийг, соён гэгээрүүлэх чиглэлээр 5 удаагийн өдөрлөг зохион байгуулж, **2,576** иргэн хамрагдсан байна. Цагдаагийн байгууллагын сургагч багш нарын давтан сургалтад **52** сургагч багшийг бэлтгэснээр сургагч багш нар авлигын эсрэг **96** удаагийн **266** цагийн сургалтад давхардсан тоогоор **15,710** алба хаагчийг хамруулсан дүнтэй байна. 21 аймгийн Хууль зүйн туслалцааны төвийн **52** өмгөөлөгчийг анхан шатны сургагч багшаар, нийслэлийн төрийн өмчийн **29** сургуулийн багшийг сургагч багшаар тус тус бэлтгэлээ.

Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Өвөрхангай аймгийн бүх сумдын ЕБС-ийн **80** гаруй багш, нийгмийн ажилтныг сургагч багшийн анхан шатны сургалтад хамруулав. Сургагч багш нар **127** удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор **57,425** нийтийн албан тушаалтныг, нийт **37** удаагийн соён гэгээрүүлэх өдөрлөгт **21,457** иргэнийг хамруулсан байна. Сургагч багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлыг тогтмол хийж байна. Мөн нийслэлийн болон орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн **114** багш, **77** сурагчийг сургагч багш бэлтгэх сургалтад хамруулав.



СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ӨДӨРЛӨГ

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан танилцуулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа болон “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг сурталчлах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгийг Багануур, Налайх дүүрэгт болон Төв, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон аймгуудад зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад чиглэсэн шударга ёсны боловсрол олгох хөтөлбөр, иргэд рүү чиглэсэн авлигын хор хөнөөлийг таниулах хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт **3,219** иргэн оролцов.



“Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад “Шударга ёсны клуб” байгуулах санал санаачилга, үйл ажиллагааг дэмжсэнээр Нийслэлийн ерөнхий боловсролын 24, 12, 1, 40, 32, 84 дүгээр сургууль, Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори цогцолбор сургууль, Хэнтий аймгийн Хэрлэн 2 дугаар сургууль, Тэмүүжин цогцолбор, Бор-Өндөр сумын цогцолбор сургуульд “Шударга ёсны клуб” байгуулан тус байгууллагаас клубын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, сургалт, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж байна.



Батлан хамгаалах яамтай хамтран Зэвсэгт хүчний жанжин штабын тусгай хүчний командлалын харьяа 013, 084, 150, 350, 345 дугаар нэгтгэл ангиудын бие бүрэлдэхүүнд сургалт, соён гэгээрүүлэх өдөрлөг, Үндэсний Батлан хамгаалах Их сургууль, Дотоод хэргийн Их сургуультай хамтран “Таны эрх, таны оролцоо-өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөг, МУИС-ийн “Бизнесийн сургууль”, Анагаах ухааны шинжлэх ухааны үндэсний их сургуулийн оюутнуудтай хамтран “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” арга хэмжээг зохион байгуулав.



Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбортой хамтран хүүхэд багачуудад шударга, зөв байх талаарх сургалт хүмүүжлийг олж авах талаар харилцан ярилцаж, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх зорилго бүхий “Шударга байх хамгийн гоё” арга хэмжээг зохион байгуулсан ба тус арга хэмжээнд тус цогцолборт амарч буй **400 гаруй** хүүхдийг хамрууллаа.



Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Нийтийн хөлбөмбөг” арга хэмжээнд “Зөв шүүлт-шударга тоглолт” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, багийн спортоор дамжуулан үнэнч, шударга, зөв дадалд сургах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, тэмцээн уралдаан зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Өдөрлөгт **1500** гаруй хүн оролцсон ба өдөрлөгийн явцад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн **49** төрлийн сурталчилгааны материалыг түгээсэн.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн 665 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр төрийн албаны хүнд суртал, чирэгдлийг арилгах ач холбогдолтой ажил болсон талаар олон нийтэд сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэднийг татан оролцуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк” хуудсыг сурталчлах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам, и-Монголиа академитай хамтран “Хүнд сурталгүй цахим үйлчилгээ” өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгөөр Байгууллагаас гаргасан 10 төрлийн ном, гарыг авлагыг цахим хэлбэрт шилжүүлсэн тухай, “Сонголт” видео контентын өрнөлийг нь үзэгчид өөрсдөө сонгох боломжтой хэлбэрээр боловсруулсан тухай сурталчлах, “Хүнд суртал, чирэгдэлгүй үйлчилгээ” танилцуулга 3,000 ширхэгийг түгээж, “Шударга ёсны клуб”-ын сурагчид жүжигчилсэн тоглолт хийх зэрэг шинэлэг ажлуудыг зохион байгууллаа. Өдөрлөгт 600 хүн оролцож, мэдээлэл авсан байна.



УРАЛДААН, ТЭМЦЭЭН



Их дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан “Оюутны эрдэм шинжилгээний илтгэл, эсээ бичлэгийн уралдаан”-д 23 илтгэл, 45 эсээ ирүүлснээс “Монгол Улсын авлигын өнөөгийн нөхцөл байдал макро эдийн засагт нөлөөлөх нь” сэдэвт илтгэл (СЭЗИС-ийн Бизнесийн эдийн засгийн 3 дугаар курсийн оюутан А.Буянзаяа, П.Номуунзаяа, Т.Мөнхцэцэг), “Эргэж ирэхгүй амь насыг мөнгөөр бүү үнэлээч” эсээ (Отгонтэнгэр” их сургуулийн

Хууль зүйн сургуулийн 2 дугаар курсийн оюутан А.Энхжин) тус тусын төрөлд нэгдүгээр байрт шалгарсан бөгөөд шалгарсан бүтээлүүдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөөд байна.

“Монголын Гэрэл зурагчдын нэгдсэн холбоо”-той хамтран “Авлигын хор хөнөөл” сэдэвт гэрэл зургийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд нийт 79 бүтээл ирүүлснээс 44-г шалгаруулж, тус бүтээлүүдээр гэрэл зургийн үзэсгэлэн гаргах, авлигын эсрэг постер, зурагт хуудас бүтээхэд ашиглах зэргээр байгууллагын үйл ажиллагаанд цаашид тогтмол ашиглах боломжийг бүрдүүлж, гэрэл зургуудыг чанар, стандарт хангуулсан байдлаар хэвлүүлэн, байгууллагын өмчлөлд хүлээн авлаа.



“Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв”-тэй хамтран авлига, ашиг сонирхлын улмаас хохирсон нийтийн эрх ашиг, хулгайлагдсан боломж, эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны бодит түүхийг эрэн сурвалжлан нийтэд хүргэх, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад олон нийтийн анхаарлыг хандуулах, оролцоог бий болгох зорилгоор “Түүний түүх” сэдэвт Storytelling сэтгүүл зүйн бүтээлийн уралдааныг зохион байгуулж, оролцогчдын бүтээлийг шалгаруулав. Уралдаанд ирүүлсэн бүтээлээс сэдэвлэн богино хэмжээний кино контент, сурталчилгаа, нэвтрүүлэг хийх зэрэг арга хэмжээг 2023 онд зохион байгуулахаар төлөвлөөд байна.



Шударга ёсны агуулгыг хичээлийн хөтөлбөрт тусгах, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багшийг бэлтгэх, тэдгээрээр дамжуулж сурагч, эцэг эхэд нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын багш нарын дунд хичээлийн хөтөлбөрийн уралдааныг 2 үе шаттайгаар зарласан. Уралдаанд нийт 251 хөтөлбөр ирүүлснээс анхан шатны шалгаруулалтыг хийж, 2 дахь шатанд тэнцсэн 96 хөтөлбөрийн шалгаруулалтыг Боловсролын ерөнхий газартай хамтран хийснээс бага, дунд, ахлах анги гэсэн ангиллаар 15 хөтөлбөрийг шалгаруулж, шагнал гардууллаа.



Монгол Улс дахь авлигын мөн чанарыг танин мэдэх, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачдын бүтээл, санал санаачилгыг дэмжих, нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрдэмтэн, судлаачдын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав. Тус хуралд 12 бүтээл ирснээс 5 бүтээлийг шилдэгээр шалгарууллаа.

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ КОНТЕНТ

Тайлант хугацаанд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор “Түрийвч”, “Цахим хичээл” “Сонголт”, “Үйлийн үр хаяг андуурдаггүй юм”, Ачлалт багш” (жүжигчин Г.Отгонцэцэг), Зохиолчид авлигын эсрэг” нэгдмэл контент, “Уран зохиолоор дамжуулж нөлөөлөх нь” 1, 2, 3, 4, 5 (Төрийн соёрхолт, зохиолч Б.Догмид, Зохиолч До.Цэнджав, С.Оюун, Д.Данзан, яруу найрагч Н.Гантулга), “Уран бүтээлээрээ авлигын эсрэг” (гэрэл зураг), (эсээ), “Түүний түүх” сэдэвт нийт 14 видео контентыг, мөн “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд 18 шторк, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, эерэг, зөв хандлагыг төлөвшүүлэх, түүнд уриалсан агуулга бүхий богино хэмжээний цуврал видео контент буюу “Тик Ток” 10 цувралыг бүтээв. Эдгээр видео контентуудыг Улаанбаатар хотын 7 байршилд 7 лед дэлгэцээр, R&P Entertainment TV, Оргил TV, Богц TV, Гэгээ TV, Дуу шүлэг TV, Сэдэв TV зэрэг онлайн телевизүүдээр дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.



МҮОНТ-тэй хамтран 14 хоног тутам “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” нэвтрүүлгийг бэлтгэн орон даяар түгээж байна. Тайлант хугацаанд 24 удаагийн дугаарыг тодорхой сэдвээр бэлтгэн МҮОНТ төдийгүй Малчин, Лайв телевизээр болон байгууллагын фэйсбүүк хуудсаар олон нийтийн хүртээл болгов. 2022 онд бэлтгэсэн 24 нэвтрүүлгийн 1 нэвтрүүлгийг байгууллагын пэйж хуудсаар дамжуулан дунджаар 5,000 орчим хүн үзсэн байна. Нэвтрүүлэг тус бүрт тодорхой сэдвийг онцлон мэдээлэл хүргэснээс гадна нийт

дотоод, гадаад 96 видео мэдээг бэлтгэлээ. Мөн байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар 20 секунд үргэлжлэх стори мэдээ болгож, англи хадмал орчуулгаар бэлтгэж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн нь шинэлэг үр дүнтэй ажил боллоо.



“110-Иргэдэд мэдээлэл өгөх аппликэйшн”-д 139 мэдээлэл оруулсан бөгөөд тус аппликэйшнд сард 631 хандалт хийгдэж, нийт хандалтын тоо 16,745 болсон байна.



“110 подкаст нэвтрүүлгийг “Хахууль өгөх, авах гэмт хэрэг зөвхөн төрийн албан хаагчдад хамаатай юу?”, “Эмнэлгийн салбарт үйлдэгдсэн гэмт хэргийн тухай”, “Хөдөлмөрийн чадвар алдалтыг хуурамчаар тогтоосон тухай”, “Шударга ёсны клубийг байгуулахын ач холбогдол”, “Дулааны цахилгаан станцын асуудлаар”, “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах ажил үр дүнтэй байна уу?”, “Хүүхдийн шударга байдлын 2022 оны судалгаа хийгдэж дууслаа”, “Авлигын эсрэг олон улсын өдөрт зориулсан тусгай дугаар”, “Азын дугаарын борлуулалтаас олсон орлогын тодорхой хувийг хүүхдийн хөгжилд зарцуулдаг уу”, “АТГ-аас хийж, хэрэгжүүлсэн 2022 оны онцлох ажлуудаас” зэрэг 10 сэдвээр бэлтгэж түгээлээ.

Urug.mn сайттай хамтран Авлигатай тэмцэх газраас гадна Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл, судлаачдыг оролцуулан “Авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зөв үү”, “Авлигын гэмт хэргийн ялын бодлого” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг “Тэнгэр” телевиз, “Өрөг сайт”, түүний сошиал сувгууд болон байгууллагын албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.



Олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ, мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой “Авлигатай тэмцэх газар”, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилготой “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг хөтлөн хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна. Тус фэйсбүүк хуудаснуудын дагагчдын тоо **20,394** хүнээр нэмэгдсэн байна.

“Авлигатай тэмцэх газар” фэйсбүүк хуудсанд видео контент/шторк 115, үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, инфографик 213 нийтлэл (пост) нийт 308 нийтлэл шинээр оруулж давхардсан тоогоор **3,097,413** хүнд хүрсэн байна. Өдөрт дунджаар **18,114** хүнд авлигын эсрэг мэдээ, мэдээлэл хүрсэн бөгөөд дагагчдын тоо 8,642 хүнээр нэмэгдэж **32,971** болсон байна.

ХЭВЛЭЖ ТҮГЭЭСЭН СЭТГҮҮЛ, НОМ, ГАРЫН АВЛАГА






- “Шударга ёс” онол, арга зүйн цуврал сэтгүүлийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг хийж, эрхлэн хэвлүүлснээс хойших хугацааны бүх дугаарыг legaldata.mn сайтад байршуулж, International Standard Serial Number (ISSN) буюу цувралаар хэвлэгддэг хэвлэлийн олон улсын стандарт дугаар (ISSN 2791-3619)-ыг албан ёсоор авлаа. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, 2021 оны сүүлийн дугаар, 2022 оны №1 (23) дугаарыг эрхлэн хэвлүүлж, түгээсэн байна.
- Улс орнуудын авлигын нөхцөл байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар туршлага судлах, мэдээ, мэдээллээр хангах шаардлагаар гадаад мэдээний тойм, танилцуулга бэлтгэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлж байгаагаас гадна 2020, 2021 онд орчуулсан гадаад мэдээ, мэдээллийг эмхэтгэж, “Авлигатай тэмцэх үйл

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022



ажиллагаа: Дэлхий дахинд” нэртэйгээр Байгууллагын цахим хуудас болон legaldata.mn сайтад байршуулсан.

- Авлигын эсрэг үндэсний чуулганы илтгэлүүдийн эмхэтгэл
- Авлигын гэм хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл 2019, 2020
- “ТББ авлигатай тэмцэх нь - Гарын авлага”
- Авлигатай тэмцэх газрын 2021 оны болон 2022 оны хагас жилийн тайланг англи хэлээр хэвлүүлсэн.



Ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад зориулан сэтгэхүй хөгжүүлэх бодлого, математик үг хэллэгээр дамжуулан шударга ёсны үзэл санааг ойлгон, зөв буруу үйлийг ялган, найз нөхдөдөө зөв үлгэр дуурайлал үзүүлэхэд төлөвшүүлэн авлигын эсрэг боловсролын суурь мэдлэгийг олгох дараах ном, гарын авлагыг хэвлүүлэн түгээсэн:

- “Шударга ёс: Сэтгэхүй хөгжүүлэх бодлого” гарын авлага
- “Шударга тоглоё” хүүхдэд зориулсан ном зурагт ном
- “Шударга тоглоё” буддаг ном
- “Зөв зөвд шударга зөв” гарын авлага
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын танилцуулга
- “110” тусгай дугаарын утасны сурталчилгаа бүхий авто стикер
- “Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол хэрхэн гаргах вэ?”
- “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?”
- “Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ” брошюр



“DM SKY” ХХК-тай хамтран галт тэрэгний 40,000 тасалбар дээр авлигын талаар мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын сурталчилгааг хэвлүүллээ.



04

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


АЛБАН ТУШААЛТНЫ ХАСХОМ-ИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 15- ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт **120** байгууллагын **47,554** (цахимаар-42648, хэвлэмэл байдлаар-4906) мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 100 хувь мэдүүлгээ гаргаж баталгаажуулсан.

ХАСХОМ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчийн 15,872 буюу **34.0** хувь нь төрийн тусгай, 10,904 буюу **23.0** хувь нь төрийн захиргааны, 7,741 буюу **16.0** хувь нь улс төрийн, 6,838 буюу **14.0** хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 3,074 буюу **7.0** хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах, 1,053 буюу **2.0** хувь нь ажлын албаны, төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах албан тушаалтан 220 буюу **1.0** хувь нь, төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан 38 буюу **0.1**, 1,814 буюу **4.0** хувь нь бусад албан тушаалтан тус тус эзэлж байна.

Мэдүүлэг гаргагчийн харьяалал



2021 онд Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Шүүхийн сахилгын хороо, Боловсролын ерөнхий газар, Стратегийн судалгааны хүрээлэн, Үндэсний итгэмжлэлийн төв зэрэг байгууллага, яамд шинээр үүсэн байгуулагдаж, Мэргэжлийн хяналтын байгууллагаас Гаалийн ерөнхий газарт 365, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 28 буюу нийт 393 албан тушаалтан шилжсэнтэй холбогдуулан 2021 оны ХАСХОМ мэдүүлэгчийн тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 311 албан тушаалтнаас шинээр томилогдсон, сонгогдсон 158, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 26 албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн байна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 1022 албан тушаалтан “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 34,485 албан тушаалтан “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл”, 389 нь “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2021 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох хүрээнд **42,657** албан тушаалтны ХАСХОМ-ийн мэдээлэлд эрсдэл тооцлоо. Эрсдэлийн дүн шинжилгээгээр дунд болон түүнээс дээш эрсдэлтэй **6,895** (16.2 хувь), түүний дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гадаад харилцааны яам, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Эрүүгийн цагдаагийн алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Замын-Үүд дэх гаалийн газар, УБТЗ ХНН, Монгол банк, Улсын Их Хурлын Тамгын Газар, Нийслэлийн ЗДТГ, Шүүхийн шинжилгээний хүрээлэн, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Баянгол дүүргийн Татварын хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Баянзүрх дүүргийн ЗДТГ зэрэг байгууллагын нийтийн албан тушаалтны ХАСХОМ өндөр хувийг эзэлж байгаа дүн гарав.

МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлого нь **1 тэрбум**, түүнээс дээш хэмжээгээр өссөн болон давтамжтайгаар өсч байгаа **24** албан тушаалтны цэвэр хөрөнгийн байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийж, энэ нь мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн татварын орлоготой нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж байна. Татварын ерөнхий газраас харьяа аймаг, дүүргийн Татварын хэлтсүүдэд чиглэл хүргүүлж шалгалтын ажиллагаа хийж Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасныг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад нийт **312.5** сая төгрөгийн шийтгэлийн хуудсаар төлбөр ногдуулсан дүнтэй байна.

2022 оны 9 дүгээр сард Хөвсгөл, Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад ажиллаж, мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар хууль зөрчсөн **28** (Хөвсгөл-11, Орхон-2, Баянхонгор-2, Дархан-Уул-10) албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.

Эрүүл мэндийн яам, түүний харьяа 20 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв (Эрүүл мэндийн яам, Нэгдүгээр эмнэлэг, Өргөө амаржих газар, Амгалан амаржих газар, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн төв, Улсын хоёрдугаар эмнэлэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2, Хүрээ амаржих газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв)-үүдэд ажиллаж, нийт **679** албан тушаалтныг хамруулан хянан шалгав.


Эрүүл мэндийн салбарын 21 эмнэлэг, байгууллагад ажиллаж байгаа **600** гаруй мэдүүлэг гаргагчаас Авлигын эсрэг хууль, тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй гэх үндэслэлээр нарийвчлан **49** албан хаагчаас **15** буюу **30.6** хувь нь үндсэн ажлаас гадуур ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, зөвлөх болон эмчээр ажиллаж, тодорхой хэмжээний цалин урамшуулал авч, нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлүүлж байгаа нь тогтоогдсон тул Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах, хуульд заасан хугацаанд ХАСХОМ мэдүүлж байх талаар анхааруулж, зөвлөмж хүргүүлэв. Түүнчлэн төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудыг мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад бүрэн хамруулж байх талаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Тайлант хугацаанд **120** төрийн байгууллагад ажиллаж байгаа нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг гүйцэтгэж байгаа **1,806** эрх бүхий албан тушаалтнуудын **362** буюу 20 гаруй хувь нь өөрчлөгдөн томилогдсон тул тэднийг сургаж, мэргэшүүлэх, чиглэлд анхаарал хандуулж, **1,720** ЭБАТ-ыг сургалтад хамруулсан.

Нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтын арга хэлбэрийг өөрчлөн, нийтлэг гарч буй алдаа зөрчлийн жишээ дээр ажиллуулах, хамтран ярилцах, санал солилцох хэлбэрээр сургалтыг зохион байгууллаа. Тайлант хугацаанд **63** удаагийн удаагийн сургалт (цахим, танхимаар)-д **7,174** нийтийн албан тушаалтныг хамруулан суралцуулсан өмнөх оны мөн үетэй харьцуулбал, **9.2** дахин, нийт сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо **12.7** дахин өссөн өссөн үзүүлэлттэй байна.


Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлт



ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2022 онд шинээр хүлээн авсан **330**, өмнөх оны үлдэгдэл **57**, нийт **387** албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах аас **366**-г хянан шийдвэрлэж, **22** мэдүүлэг ажиллагаанд хянагдаж байна. Нийт шалгасан мэдүүлгийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хянан шийдвэрлэсэн мэдүүлэг 51 нэгжээр буюу 16.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Хянан шалгасан ХАСХОМ:



ХАСХОМ-т төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд **309** мэдүүлэг, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд **78** мэдүүлэг, нийтдээ **387** мэдүүлэгт хяналт шалгалт зохион байгуулсан байна. Дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд өмнөх оны үлдэгдэл **57**, Гаалийн ерөнхий газрын **183**, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны **2**, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн **11**, Нийслэлийн улсын бүртгэлийн газрын **49**, ХАСХОМ-ийн эрсдэл тооцох аргачлалын дагуу **7** мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт хяналт шалгалт хийсэн бол өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу **18**, Гүйцэтгэх ажлын хэлтэс болон Мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсний дагуу **60** мэдүүлгийг шалгасан байна.

Тайлант хугацаанд шалгавал зохих **387** мэдүүлэг (төлөвлөгөөт-309, гомдол, мэдээлэл 18, хэлтэс, албадаас шилжүүлсэн-60)-ээс тайлант хугацаанд **366** мэдүүлэг буюу **94.6** хувийг шалгаж шийдвэрлэсэн.

Мэдүүлгийн хяналт, шалгалтын тоон үзүүлэлт



Хяналт шалгалтаар нийт **93** албан тушаалтны **8** мэдүүлэг гаргагчид сануулах, мөн зүйлийн 13.8.2-т зааснаар **37** мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар **37** мэдүүлэг гаргагчид албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.4-т зааснаар **8** мэдүүлэг гаргагчид албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2-т заасан үндэслэлээр **2** мэдүүлэг гаргагчид мөн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, **1** мэдүүлэг гаргагчид 29.2.3-т заасан албан тушаал бууруулах хариуцлага тооцох үндэслэл тогтоогдсон.

Хяналт шалгалтаар **35** мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбогдуулан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдэл, мэдээллийг шалгуулахаар тус газрын харьяалах хэлтэст шилжүүлжээ.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2022 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан **653** (өмнөх оны үлдэгдэл 39), нийт **692** гомдол, мэдээллийг хянан шалгах аас тайлант хугацаанд **662** гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 30 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт **95.6** хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, **2.12** хувиар, хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл **101** нэгж (561)-ээр өссөн үзүүлэлттэй байна.

Хянан шалгасан гомдол, мэдээлэлд дурьдагдсан **135** албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, үүнээс **37** албан тушаалтанд хариуцлага тооцуулж, үлдэх хувьд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, зөрчилтэй захиргааны актыг хүчингүй болгуулах зэргээр шаардлага, зөвлөмж хүргүүлэв.

Хуульд заасан үндэслэлээр буцаасан **24**, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл гэж үзэн МШХ, ГАХ-т шилжүүлсэн **62**, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн **110**, гомдлоо буцаасан **14**, зөрчил илрээгүй **316**, Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл ногдуулсан **1** байна.

Тайлант хугацаанд хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 348 буюу 53.3 хувийг Улаанбаатар хотоос, 305 буюу 46.7 хувийг орон нутгаас ирүүлсэн байна. Тоон үзүүлэлт, мэдээллээс харахад аймгуудаас Баян-Өлгий аймгаас 66 буюу 10.1 хувь, Архангай аймгаас 25 буюу 3.8 хувь, Говь-Алтай аймгаас 22 буюу 3.4 хувь, Сэлэнгэ аймгаас тус бүр 21 буюу 3.2 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр үзүүлэлттэй байна.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн **21.0** хувийг, хууль бус шийдвэр гаргаж, бусдад давуу байдал олгосон **23.0** хувийг, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан **22.0** хувийг, хууль бус томилгоо хийсэн **27.0** хувийг, бусад зөрчил **7.0** хувийг тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон зөрчил **3.0** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хяналт шалгалтын явцад хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Байгаль, орчин аялал жуулчлалын яам, Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гаалийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Засаг дарга, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, “Эрдэнэс Монгол” ХК, “Улаанбаатар Төмөр зам” Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг зэрэг нийт **98** байгууллага албан тушаалтанд зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН ЭТГЭЭДИЙН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ (ХАСУМ)-ИЙН ХЯНАЛТ

Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **14,861** этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас **14,695** этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, **166** мэдүүлэг хянагдаж байна. 2022 онд хүлээн авсан ХАСУМ-ийн тоо 2021 оны мөн үетэй харьцуулахад **2,227** нэгжээр буюу **17.9** хувиар өссөн байна.

Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг


Он	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс				Үлдэгдэл
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт АСЗ үүсэх	Хуульд зааснаар буцаасан	
2021	12,504	12,468	11,162	1,018	22	266	36 (0.3)
2022	14,861	14,695	13,616	918	37	124	166 (1.1)
	+2,357	+2,227	+2,454	-100	+15	-142	+130 (+0.8)

ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

2022 онд өмнөх оны үлдэгдэл **125**, шинээр хүлээн авсан гэмт хэргийн талаарх **1,716**, нийт **1,841** гомдол, мэдээллээс **336**-г Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн шинжтэй **1,413** гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна.


Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс **350** нэгжээр буюу **23.5** хувиар өссөн байна.

Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл




Хүлээн авсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл: төрийн тусгай **418**, төрийн захиргааны **393**, төрийн улс төрийн **233**, төрийн үйлчилгээний **142**, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн **158** этгээдийн, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын **69** байна.

Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал



Тайлант хугацаанд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан өмнөх оны үлдэгдэл **46**, 2022 оны **1,367**, нийт **1,413** гомдол, мэдээллээс **621** гомдол, мэдээлэл буюу **43.9** хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, **684** гомдол, мэдээлэл буюу **48.4** хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, **52** гомдол, мэдээлэл буюу **3.7** хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, **56** гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт **96.0** хувьтай байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан **1,413** гомдол, мэдээллийн **767** буюу **54.3** хувийг Улаанбаатар, **646** буюу **45.7** хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын **1,806** үйлдэлтэй, **1,184** холбогдогчтой, **1,520** хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал **16.3** хувиар өссөн байна. (2021 онд **1,307** хэрэг шалгасан.)

Нийт шалгасан хэргийн **262** буюу **17.2** хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, **389** буюу **25.6** хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, **50** буюу **3.3** хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, **93** хэргийг нэгтгэн шалгаж, **11** хэргийг түдгэлзүүлж, одоо **715** эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн **633** хэрэг, мөрдөн байцаалтын **82** хэрэг байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт **52.2** хувьтай, шүүхээр **188** хэрэг шийдвэрлэгдсэн дүнтэй байна.

Хэргийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах) гэмт хэрэг-1011 буюу 55.9 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл (Хахууль авах) гэмт хэрэг-239 буюу 13.2 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл (Хахууль өгөх) гэмт хэрэг-138 буюу 7.6 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах) гэмт хэрэг-22 буюу 1.2 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих) гэмт хэрэг-52 буюу 2.9 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэмт хэрэг-34 буюу 1.9 хувь,
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах) гэмт хэрэг-37 буюу 2.0 хувь, Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл (Эрүү шүүлт тулгах) гэмт хэрэг-15 буюу 0.8 хувь, Бусад хэрэг 258 буюу 14.3 хувийг тус тус эзэлж байна.


Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн **56** буюу **4.7** хувийг төрийн улс төрийн, **127** буюу **10.7** хувийг төрийн захиргааны, **103** буюу **8.7** хувийг төрийн тусгай, **84** буюу **7.1** хувийг төрийн үйлчилгээний, **814** буюу **68.8** хувийг бусад этгээд эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан




2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас **5 их наяд 24 тэрбум 895 сая 829 мянга 317** төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **2 их наяд 374 тэрбум 934 сая 309 мянга 243** төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг **518 тэрбум 39 сая 332 мянга 298** төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Нийт учирсан хохирлын **47.3** хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.


Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол:



Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн:




Битүүмжлэн хамгаалсан эд хөрөнгө болон бэлэн мөнгө:



Хахуулийн **18,874,521,566** төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол **5** дахин, нөхөн төлүүлэлт **24.7** дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө **4.3** дахин өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



ГАДААД УЛСААС БУЦААН АВСАН ХӨРӨНГӨ

Мөрдөн шалгах ажиллагааны явцад 2021, 2022 онд гадаад улс орнуудаас нийт **12.2 сая ам. долларын** хөрөнгийг буцаан авах үндэслэлийг тогтоож, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон. Үүнд:

- ИБУИНВУ-д байрлах **1 орон сууц, 1.8 тэрбум** төгрөг (бэлэн мөнгө), **269.0 сая төгрөгийн** үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө 2 ширхэг, нийт **6.4 тэрбум төгрөг** буюу **4.7 сая ам. долларыг** улсын орлого болгож,
- Британийн Виржинийн арлаас **2.2 тэрбум төгрөгийн** буюу **1.6 сая ам.долларын** үнэ бүхий газар, үл хөдлөх хөрөнгийг улсын өмчид бүртгүүлж,
- Мэн арлаас **11.3 тэрбум төгрөг** буюу **5.7 сая ам, долларыг** тус тус улсын орлого болгон хураан авсан байна.

ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2021 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 160 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2022 онд **188** хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оныхоос **17.5** хувиар өссөн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс дурдвал:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирал З.Ганбаатар, Техникийн хэлтсийн автоматжуулалт хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн Л.Дэлгэрбат нарт холбогдох,
- Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дарга Б.Мягмарт холбогдох,
- Гаалийн ерөнхий газрын харьяа Гашуунсухайт дахь гаалийн газрын Байгаль орчны хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч С.Энхтайванд холбогдох,
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Барилга байгууламжийн хэлтсийн дарга Д.Жүрмэддоржид холбогдох,
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Тамгын газрын дарга М.Баянмөнх нарт холбогдох,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбатад холбогдох,
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэргэжилтэн Н.Чимэдлхам нарт холбогдох,
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн захирал Ж.Байгалмаа нарт холбогдох,
- Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дарга Д.Одончимэг нарт холбогдох,
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Насанцэнгэлд холбогдох,
- Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн Зам, замын байгууламж хариуцсан мэргэжилтэн А.Ариунсанаад холбогдох,
- Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Н.Уламбаяр нарт холбогдох,
- Сэлэнгэ аймгийн Автотээврийн төвийн дарга Ж.Батцогтод холбогдох,
- Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Гансүх нарт холбогдох,
- Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэлд холбогдох зэрэг хэргүүд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдээд байна.

02.



**ХОЁР. АВЛИГЫН ЕРӨНХИЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛ**



Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг ерөнхийд нь олон улсын болон дотоодын судалгаа гэсэн хоёр чиглэлээр боловсруулсан. Эдгээр судалгаа, үнэлгээ бүр олон дэд үзүүлэлтийг хамардаг боловч дэлгэрэнгүй тайлантай тухайн судалгааны эх сурвалжаас танилцах боломжтой тул энд зөвхөн гол, ерөнхий үр дүнг оруулсан болно.


ГАДААД СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1.1 Авлигын төсөөллийн индекс

Транспэрэнси Интернэшнл (ТИ) байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ээр Монгол Улс 2012-2021 онд доод тал нь 33, дээд тал нь 39, дунджаар 36.45 оноо авсан.

2021 оны индексийг тооц соны дараа дэлхийн дундаж оноо арав дахь жилдээ өөрчлөгдөөгүй буюу 43 гарсан байна (боломжит 100 онооноос). Сүүлийн 10 жилд 131 улс орон (180 орчим улс орноос) авлигын эсрэг дорвитой ахиц дэвшил гаргаагүй бөгөөд улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан болохыг ТИ байгууллага онцлон тэмдэглэсэн байна.

Авлигын төсөөллийн индекс, 2012-2022 он



Монгол Улсын АТИ-ийг тооцоход олон улсын 10 орчим судалгаа, индексийг ашигладаг бөгөөд тэдгээрт дараах асуудлыг үнэлдэг:

- Төрийн удирдах албан хаагчид институцийг удирдах, төрийн албан хаагч өөрсдийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээдэг эсэх
- Иргэний нийгэм төрийн үйл ажиллагааны мэдээллийг авах боломжтой эсэх
- Төрийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигладаг эсэх
- Бизнес эрхлэгчид авлигад өртдөг эсэх
- Төсвийн хөрөнгийг шамшигдуулж, зориулалтын бусаар зарцуулдаг эсэх
- Төрийн албан хаагч авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээдэг, олон нийт шүүмжилдэг эсэх
- Засгийн газраас авлигатай үр дүнтэй тэмцдэг, авлигатай тэмцэх механизмтай эсэх
- Иргэд авлигатай тулгардаг эсэх
- Гүйцэтгэх, шүүх, цэрэг цагдаа, хууль тогтоогч нь эрх мэдэл, албан тушаалаа хувийн сонирхлын үүднээс ашигладаг эсэх

- Улс төрийн хүрээнд авлига байдаг эсэх
- Төсвийн хуваарилалт, захиран зарцуулалтад тодорхой процесс, хариуцлагын тогтолцоо байгаа эсэх
- Төсвийн хөрөнгийг сайд, албан тушаалтнууд хувийн, эсхүл улс төрийн намын зориулалтаар зарцуулдаг эсэх
- Хариуцлага, хяналтгүй зарцуулах боломжтой тусгай сан байдаг эсэх
- Мэргэжлийн төрийн албан хаагчид байдаг эсэх, эсхүл ихэнх төрийн албан хаагчдыг засгийн газраас шууд томилдог эсэх
- Төсвийн хөрөнгийн захиран зарцуулалтыг аудит хийх бие даасан байгууллага байдаг эсэх
- Сайд, төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх хараат бус шүүх байдаг эсэх
- Гэрээ байгуулах, давуу байдал бий болгох зорилгоор хахууль өгөх заншил байдаг эсэх гэх мэт.

1.2 Дэлхийн авлигын хэмжүүр

ТИ байгууллагаас гаргадаг Дэлхийн авлигын хэмжүүр¹⁷ (Global Corruption Barometer) судалгаа нь иргэд хахуультай нүүр тулж байгаа эсэх, тухайн улсад авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгаа, мөн засгийн газар нь авлигатай үр дүнтэй тэмцэж чадаж байгаа эсэх талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа юм. Энэ судалгааны 7 (2010 он), 8 (2013 он), 10 (2020 он) дахь дугаарт манай улсыг хамруулан судалсан байх бөгөөд үр дүнгээс харахад иргэд жил ирэх бүр авлигын түвшин өссөн гэж үзэх нь багасч, буурсан гэж үзэх нь нэмэгдсэн байна. Гэхдээ 2010 оны судалгаанд “Өнгөрсөн 3 жилийн хугацаанд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэж асуусан бол 2013 онд “өнгөрсөн 2 жилд”, 2020 онд “өнгөрсөн 1 жилд” гэж асуужээ.

Судалгаанд оролцсон иргэд “Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэдэг асуултад хариулсан байдал, хувиар



Харин авлига хаана хамгийн түгээмэл байна вэ гэдэг дээр эхний 5 байрт дараах хариултыг өгсөн байна:

Хүснэгт 1 Авлига түгээмэл салбар, албан тушаалтан, хувиар


2010	2013	2020
Парламент (82%)	Төрийн албан хаагч (77%)	Парламентын гишүүн, ИТХ-ын төлөөлөгч (43%)
Улс төрийн нам (81%)	Шүүх (73%)	Шүүгч (42%)
Шүүх (75%)	Эрүүл мэнд (71%)	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, түүний ажлын албаны ажилтнууд (32%), Бизнес эрхлэгчид (32%)
Цагдаа (67%)	Цагдаа (66%)	Төрийн албан хаагч (30%)
Төрийн албан хаагч (56%)	Улс төрийн нам (65%)	Нутгийн удирдлагын байгууллагын албан тушаалтнууд (29%)

TRACE-ийн Хахуулийн эрсдэлийн матриц

Трасе интернэшнл байгууллагаас гаргадаг Хахуулийн эрсдэлийн матриц¹⁸ (Bribery Risk Matrix) нь улс орнуудын бизнесийн салбар дахь хахуулийн эрсдэлийг Засгийн газар ба бизнесийн харилцаа; Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа; Засгийн газар болон төрийн албаны ил тод байдал; Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх гэсэн багц үзүүлэлтүүдээр хэмждэг. НҮБ, Дэлхийн банк, Гётебургийн их сургуулийн V-Dem институт, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагуудын холбогдох өгөгдлийг нэгтгэн TRACE Интернэшнл байгууллага 2014 оноос эхлэн гаргаж байна. Эрсдэлийг 0-100 оноогоор үнэлэх бөгөөд оноо нэмэгдэх бүр эрсдэл нэмэгдэж байна гэж үзнэ.

Манай улсын хувьд 2014 онд 72 оноотой 156-д эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 51 оноотой 96 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Хахуулийн эрсдэл 2014 оноос хойш ерөнхийдөө буурах хандлагатай байгаа ч 2022 оны судалгааны дүн өмнөх оныхоос 4 оноогоор нэмэгдсэн байна.

Зураг 3 Хахуулийн эрсдэлийн матрицын оноо, оноор



Хууль дээдлэх ёсны индекс

Улс орны авлигын түвшинд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг бол хууль дээдлэх ёсны хэрэгжилт юм. Мөн авлига, хахуулийн түвшин, эрсдэлийг хэмжихэд олон улсын байгууллагуудын ашигладаг чухал үзүүлэлт бол Дэлхийн эрх зүйн төсөл (World Justice Project) байгууллагаас гаргадаг Хууль


18 <https://www.traceinternational.org/trace-matrix>

дээдлэх ёсны индекс¹⁹ юм.

Зарим судалгаанд АТИ болон Хууль дээдлэх ёсны индекс нь үндсэндээ нэг зүйл гэж үзсэн байдаг. АТГ-аас 130 улс орны 2021 оны АТИ болон Хууль дээдлэх ёсны индексийг ашиглан хоорондын хамаарлыг тооцоход шууд, хүчтэй хамаарал тогтоогдсон²⁰. Өөрөөр хэлбэл, Хууль дээдлэх ёсны индекс нэмэгдэхэд түүнийг дагаад улс орны АТИ мөн сайжирдаг байна.

Энэ индекс нь Төрийн эрх мэдлийн хязгаарлалт, Авлигаас ангид байдал, Төрийн нээлттэй байдал, Хүний үндсэн эрх, Эрүүгийн болон Иргэний хэргийн шүүх ажиллагаа зэрэг 8 багц, 44 дэд үзүүлэлтийг хэмжиж 0-1 оноогоор үнэлдэг. Манай улсын хувьд 2015 оноос хойш тогтмол 0.53-0.55 оноогоор үнэлэгдсэн.

Зураг 4 Хууль дээдлэх ёсны индекс, оноор



Индексийн оноо ийнхүү тогтмол дундаж байгаа нь уг индексээр хэмждэг дараах хүчин зүйлс болон дэд үзүүлэлтэд нөлөөлөх дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна:

Төрийн эрх мэдлийн хязгаарлалт:

1. Төрийн эрх мэдлийг хуулиар үр дүнтэй хязгаарладаг эсэх
2. Төрийн эрх мэдлийг шүүх засаглал үр дүнтэй хязгаарладаг эсэх
3. Төрийн эрх мэдлийг хараат бус аудит, хяналт шалгалтаар үр дүнтэй хязгаарладаг эсэх
4. Төрийн албан тушаалтан буруутай үйлдэлдээ шийтгэл хүлээдэг эсэх
5. Төрийн эрх мэдэл нь төрийн бус хяналт шалгалтад өртдөг эсэх
6. Эрх мэдэл шилжүүлэх үйл явц хуулийн дагуу явагддаг эсэх

Авлигаас ангид байдал:

1. Гүйцэтгэх засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
2. Шүүх засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
3. Цагдаа, цэргийн албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх
4. Хууль тогтоох засаглалын салбар дахь албан тушаалтнууд хувийн ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа ашигладаг эсэх

19 <https://worldjusticeproject.org/about-us/overview/what-rule-law>

20 Оюунбаатар Х. Хууль дээдлэх ёс ба авлига: Түүх, сургамж. Шударга ёс, 2022 №1 (23), х. 91.

Төрийн нээлттэй байдал:

1. Нийтлэгдсэн хууль тогтоомж болон төрийн өгөгдөл (мэдээлэл)
2. Мэдээлэл авах эрх
3. Иргэний оролцоо
4. Өргөдөл, гомдлын механизм

Хүний үндсэн эрх:

1. Хуулийн өмнө эрх тэгш байх ба ялгаварлалгүй байдал
2. Хүний амьд явах эрх болон аюулгүй байдлыг үр дүнтэй хамгаалдаг эсэх
3. Яллагдагчтай холбоотой хууль болон түүний эрхийн зохистой хэрэгжилт
4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
5. Шашин шүтэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
6. Хувийн нууц халдашгүй байх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
7. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг үр дүнтэй хамгаалдаг эсэх
8. Хөдөлмөрлөх суурь эрхийг үр дүнтэй хамгаалдаг эсэх

Дэг журам, аюулгүй байдал:

1. Гэмт хэргийг үр дүнтэй хянадаг эсэх
2. Иргэдийн мөргөлдөөнийг үр дүнтэй хязгаарладаг эсэх
3. Иргэд дургүйцлээ илэрхийлэхдээ хүчирхийлэл хэрэглэдэг эсэх

Зохицуулалтын хэрэгжилт:

1. Төрийн зохицуулалт үр дүнтэй хэрэгждэг эсэх
2. Төрийн зохицуулалтыг зүй бус нөлөөлөлгүйгээр мөрдүүлж, хэрэгжүүлдэг эсэх
3. Захиргааны үйл ажиллагаанд шалтгаангүй хүлээгдэл байдаг эсэх
4. Захиргааны үйл ажиллагааг зохих ёсоор явуулахыг эрмэлздэг эсэх
5. Төр хууль бусаар, хангалттай нөхөн төлбөргүйгээр өмчлөх эрхийг хүчингүй болгодог эсэх

Иргэний хэргийн шүүх ажиллагаа:


1. Хүмүүс иргэний хэргийн шүүхэд хандах, үйлчлүүлэх боломжтой эсэх
2. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд ялгаварлан гадуурхалт байдаг эсэх
3. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд авлига байдаг эсэх
4. Иргэний хэргийн шүүхэд төрийн зохисгүй нөлөөлөл байдаг эсэх
5. Иргэний хэргийн шүүх ажиллагаанд шалтгаангүй хүлээгдэл байдаг эсэх
6. Иргэний хэргийн шүүх ажиллагаа үр дүнтэй хэрэгждэг эсэх
7. Маргаан шийдвэрлэх хувилбарт механизм нь хялбар, шударга, үр дүнтэй эсэх

Эрүүгийн хэргийн шүүх ажиллагаа:

1. Гэмт хэрэг мөрдөн шалгах тогтолцоо нь үр дүнтэй эсэх
2. Эрүүгийн хэргийн шүүх тогтолцоо нь тодорхой хугацаатай бөгөөд үр дүнтэй эсэх
3. Засан хүмүүжүүлэх тогтолцоо нь гэмт зан үйлийг бууруулах үр дүнтэй эсэх
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо нь шударга эсэх
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд авлига байдаг эсэх
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд төрийн зохисгүй нөлөөлөл байдаг эсэх
7. Яллагдагчтай холбоотой хууль болон түүний эрхийн зохистой хэрэгжилт

Эдгээр хүчин зүйлс, дэд үзүүлэлт тус бүрийн 2015-2022 оны оноог дараах зурагт үзүүлэв.

Зураг 5 Хууль дээдлэх ёсны индексийн хүчин зүйлсийн оноо, оноор



1.5 Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд

Дэлхийн засаглалын үзүүлэлт (Worldwide Governance Indicators) нь Дэлхийн банкны олон жилийн судалгааны хөтөлбөрт үндэслэн 1996-2002 онд хоёр жил тутам, 2002 оноос хойш жил тутам гарч байгаа индекс бөгөөд улс орнуудын засаглалын гүйцэтгэлийг -2.5 (сул) -аас 2.5 (хүчтэй) хүртэлх оноогоор үнэлж, 0 (хамгийн бага)-ээс 100 (хамгийн дээд) хувиар зэрэглэл тогтоон жил бүрийн 9 дүгээр сарын сүүлээр танилцуулдаг.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт Засаглалын зорилтуудын шалгуур үзүүлэлтэд Дэлхийн засаглалын үзүүлэлтээс 1) Иргэдийн дуу хоолой ба хариуцлага, 2) Засгийн газрын үр нөлөө, 3) Зохицуулалтын чанар, 4) Хуулийн засаглал, 5) Авлигын хяналт гэсэн 5 үзүүлэлт болон НҮБ-ын Цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг ашиглахаар заасан тул энэхүү үзүүлэлтүүдийн талаар бага зэрэг дэлгэрүүлэн авч үзлээ.

Засаглалын тухай олон янзын тодорхойлолт байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь хэт явцуу хүрээг хамардаг бол зарим нь хэт өргөн хүрээг хамардаг. Дэлхийн банк эдгээрийн дундын хувилбарыг

эрэлхийлж, “тухайн улс оронд эрх мэдлийг хэрэгжүүлж буй уламжлал ба институц” гэж тодорхойлсон. Үүнд (а) засгийн газрыг сонгох, хянах, солих үйл явц; (б) оновчтой бодлогыг үр дүнтэй боловсруулж, хэрэгжүүлэх засгийн газрын чадавх; (в) иргэн ба төрийн хоорондын эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулдаг институцүүдэд хандах тэдний (иргэн ба төрийн) хандлага гэсэн гурван чиглэлд хамаарах тус бүр хоёр хоёр, нийт зургаан хэмжигдэхүүнийг бий болгосон байна²¹.

Мөн уг үзүүлэлтийн суурь мэдээлэлд жил бүр засвар ордог бөгөөд тэдгээрийн зарим нь өмнөх жилүүдийн өгөгдөлд нөлөөлж, үзүүлэлт өөрчлөгддөг. Мөн жил бүрийн үзүүлэлтийн өгөгдлийн багцыг шинэчлэн гаргахдаа “Энэхүү Дэлхийн засаглалын үзүүлэлтүүдийн шинэчлэлт нь өмнөх жилүүдийн өгөгдлийн засваруудыг багтаасан тул энэхүү өгөгдлийн хувилбар нь өмнөх бүх хувилбарын өгөгдлийг орлож байгааг анхаарна уу” гэсэн анхааруулгатай түгээдэг²².

Хүснэгт 2 Монгол Улсын 2018 оны Дэлхийн засаглалын 6 үзүүлэлтийн үнэлгээ ба эрэмбийн өөрчлөлтийн харьцуулалт, 2019 ба 2021 он

№	Үзүүлэлт	2018 оны Үзүүлэлт				Өөрчлөлт	
		Анх гаргасан (2019)		Шинэчилсэн (2021)		Үнэлгээ	Эрэмбэ
		Үнэлгээ	Эрэмбэ	Үнэлгээ	Эрэмбэ		
	Иргэдийн дуу хоолой ба хариуцлага	0.26	57.14	0.24	56.04	-0.02	-1.1
	Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал	0.79	74.29	0.83	73.11	+0.04	-1.18
	Засгийн газрын үр нөлөө	-0.23	45.67	-0.23	45.19	0	-0.48
	Зохицуулалтын чанар	-0.03	54.81	0.02	55.77	+0.05	+0.96
	Хуулийн засаглал	-0.27	44.71	-0.27	44.23	0	-0.48
	Авлигын хяналт	-0.43	39.90	-0.42	39.90	0.01	0

Дэлхийн засаглалын үзүүлэлтийн үнэлгээг гаргахад үндэслэл болдог эх сурвалжийн багцад жилээс жилд бага зэрэг өөрчлөлт ордог. Зарим эх сурвалжийг шинээр нэмж ашиглах, заримыг нь ашиглахаа болих тохиолдол байдаг. Уг Үзүүлэлтэд цаг хугацааны хувьд хамгийн дээд хэмжээнд харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэхийн тулд эдгээр өөрчлөлтийг бүх онуудын түүхэн өгөгдөлд тогтмол хийдэг учраас жил бүрийн шинэчлэлтээр өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдийг шинээр орлуулдаг байна²³.

Үүнээс шалтгаалан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт тогтоосон суурь түвшнийг 2025, 2030 онд тооцохдоо тухай тухайн үеийн шинэчилсэн өгөгдлийн багцад үндэслэх шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл, “Авлигын хяналт” гэсэн шалгуурын суурь түвшин 2018 онд 39.9 хувь байсан нь цаашид өөрчлөгдөж болзошгүй гэсэн үг.

Монгол Улсын 2012-2020 оны Дэлхийн засаглалын үзүүлэлтүүдийн 2021 оны шинэчлэлтийг танилцуулав²⁴:

21 Kaufmann D., Kraay A., and Mastruzzi M. The Worldwide Governance Indicators. Methodology and Analytical Issues. 2010. pp. 3-4.

22 <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Documents#wgiDataCrossCtry>


23 Kaufmann D., Kraay A., and Mastruzzi M. The Worldwide Governance Indicators. Methodology and Analytical Issues. 2010. p. 6.

24 Дэлхийн засаглалын үзүүлэлтийг 2022 онд шинэчлэн гаргаагүй болно.

а) Засгийн газрыг сонгох, хянах, солих үйл явц


Иргэдийн дуу хоолой ба хариуцлага – тухайн улсын иргэд төр засгаа байгуулах, сонгоход оролцох боломж, үзэл бодлоо илэрхийлэх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх ойлголт.

Зураг 5 Иргэдийн дуу хоолой ба хариуцлага үзүүлэлтийн хувь, оноор



Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал – улс төрийн сэдэлтэй хүчирхийлэл, терроризм зэрэг үндсэн хуулийн бус, хүчирхийллийн арга хэрэгслээр засгийн газрыг тогтворгүй болгох, түлхэн унагах магадлалын талаарх ойлголт.


Зураг 6 Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал үзүүлэлтийн хувь, оноор



(б) Оновчтой бодлогыг үр дүнтэй боловсруулж, хэрэгжүүлэх засгийн газрын чадавх

Засгийн газрын үр нөлөө – төрийн үйлчилгээний чанар, төрийн албаны чанар, улс төрийн дарамт шахалтаас ангид байдлын түвшин, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чанар, мөн засгийн газар эдгээрт чиглэсэн бодлого баримталж буйд итгэх итгэл үнэмшлийн талаарх ойлголт.


Зураг 7 Засгийн газрын үр нөлөө үзүүлэлтийн хувь, оноор



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

Зохицуулалтын чанар – хувийн хэвшлийн хөгжлийг хүлээн зөвшөөрч, дэмжсэн оновчтой бодлого, зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх засгийн газрын чадавхын талаарх ойлголт.


Зураг 8 Зохицуулалтын чанар үзүүлэлтийн хувь, оноор



(в) иргэн ба төрийн хоорондын эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулдаг институцүүдэд хандах тэдний (иргэн ба төрийн) хандлага


Хуулийн засаглал – Албан хаагчид итгэл хүлээж, нийгмийн дүрэм журмыг дагаж мөрддөг эсэх, ялангуяа гэрээний хэрэгжилт, өмчийн эрх, цагдаа, шүүхийн чанар, мөн гэмт хэрэг, зөрчилд өртөх магадлалын талаарх ойлголт.

Зураг 9 Хуулийн засаглал үзүүлэлтийн хувь, оноор



Авлигын хяналт – Жижиг болон их хэмжээний авлигын хэлбэрээр төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, төрд элитүүд ба хувийн ашиг сонирхлын нөлөөлөл хэр зэрэг байдаг талаарх ойлголт.

Зураг 10 Авлигын хяналт үзүүлэлтийн хувь, оноор



Дээрх зургуудаас харахад Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал гэдэг

үзүүлэлт хамгийн их сайжирсан (2012 онд 62.09 байсан бол 2020 онд 72.64 болж 10.55 оноогоор нэмэгдсэн²⁵) бол бусад үзүүлэлт өөрчлөлт багатай байна.


1.6 Цахим засгийн хөгжлийн индекс

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” баримт бичигт Засаглалын зорилтуудын шалгуур үзүүлэлтэд Дэлхийн банкны Дэлхийн засаглалын 5 үзүүлэлтээс гадна НҮБ-ын Цахим засгийн хөгжлийн индексийг ашиглахаар заасан.

Цахим засгийн хөгжлийн индекс²⁶ (EGDI буюу E-Government Development Index) нь НҮБ-ын гишүүн орнуудын цахим засаглалын хөгжлийн төлөв байдлыг судалдаг бөгөөд (1) онлайн үйлчилгээний хамрах хүрээ, чанар (Онлайн үйлчилгээний индекс, OSI), (2) харилцаа холбооны дэд бүтцийн хөгжлийн байдал (Харилцаа холбооны дэд бүтцийн индекс, TII), (3) хүний төрөлхийн капитал (Хүний капиталын индекс, HCI) гэсэн цахим засаглалын хамгийн чухал гурван хэмжигдэхүүний онооны жигнэсэн дундаж юм.

ЦЗХИ-ийн утга 0.0-ээс 0.25 хүртэл бол “бага”, 0.25-0.50 хүртэл бол “дунд”, 0.50-0.75 хүртэл бол “өндөр”, 0.75-аас 1.00 бол “маш өндөр” гэж үзнэ.

Зураг 11 Монгол Улсын Цахим засаглалын хөгжлийн индексийн оноо, оноор



Манай улсын ЦЗХИ тогтмол өсөж байгаа бөгөөд “өндөр” гэдэг ангилалд багтаж байна.

1.7 Төсвийн нээлттэй байдлын индекс

Энэхүү индексийг Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org) байгууллагаас хоёр жил тутамд эрхлэн гаргадаг. Олон улсын төсвийн түншлэл байгууллагын түншээр Нээлттэй нийгэм Форум ажиллаж улсын төсвийн ил тод байдал, төсвийн үйл явцад иргэд оролцох боломжийг олгож буй байдал, төсвийн хяналтын тогтолцооны түвшнийг судалж, дүнг олон нийтэд танилцуулдаг.


Төсвийн ил тод байдлын 61 болон түүнээс дээш оноо нь тухайн улсын иргэд төсвийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнд мэдээлэлтэйгээр оролцоход хангалттай мэдээллийг Засгийн газрын зүгээс нийтэлж буйг²⁷, харин 41-60 оноо нь хязгаарлагдмал мэдээлэл өгч буйг илтгэнэ.

25 Дээр дурдсан шалтгаанаар эдгээр үзүүлэлтийн өсөлт, бууралт нь харьцангуй шинжтэй болохыг анхаарна уу.

26 <https://publicadministration.un.org/egovkb/en-us/About/Overview/-E-Government-Development-Index>

27 <https://forum.mn/post/121035>

Зураг 12 Монгол Улсын Төсвийн нээлттэй байдлын индекс, оноор




Дээрх зургаас харахад Төсвийн нээлттэй байдлын индекс 2010 оноос хойш буурах хандлагатай байсан бол 2019 оноос сэргэж, 2021 онд 60 оноонд хүрсэн байна.

1.8 Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг илтгэх зарим үзүүлэлт

Хүний хөгжлийн индекс

АТИ болон Хүний хөгжлийн индекс шууд, хүчтэй хамааралтайг олон судалгаанд дурдсан байдаг. АТГ-аас 174 улс орны 2021 оны индексийн өгөгдлийг ашиглан эдгээр үгүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тооцоход шууд, хүчтэй хамаарал тогтоогдсон. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 2012 оноос хойш дунджаар 0.734 орчимд (0-1 оноогоор үнэлдэг) хэлбэлзэж байна²⁸. Өөрөөр хэлбэл, Хууль дээдлэх ёсны индексийн нэгэн адил Хүний хөгжлийн индексэд сүүлийн 10 орчим жилд дорвитой өөрчлөлт гараагүй:

Зураг 15 Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн оноо, оноор




Инновацийн индекс

Улс орны авлигын нөхцөл байдалд нийгмийн бүтээлч давхаргын хэмжээ, шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулж буй төсөв, ажилгүйдлийн түвшин, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл зэрэг нийгэм-эдийн засгийн чухал үзүүлэлтүүд нөлөөлдөг. Эдгээрийн үндэс суурь болдог, тогтвортой өсөлтийн чухал элемент бол инновац юм. Манай улс Инновацын индекс (Дэлхийн оюуны өмчийн байгууллага²⁹)-ээр 2012 оноос хойш дараах оноог авсан (0-100 оноогоор үнэлдэг):

28 <https://hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG>
29 www.wipo.int

Зураг 16 Монгол Улсын Инновацын индексийн оноо, оноор



Мөн Инновацын индекс ба нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, Хууль дээдлэх ёсны индекс ба нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь хоорондоо шууд, хүчтэй хамааралтай үзүүлэлтүүд болох нь АТГ-аас 100 гаруй улс орны 2021 оны өгөгдөлд суурилсан шинжилгээний үр дүнгээс харагдаж байна. Мөн энд дурдсан бусад үзүүлэлтүүд ч АТИ-тэй нарийн холбоо хамааралтай болохыг дараах харьцуулалтаас харж болно.

Хүснэгт 3 Харьцуулалт, Шинэ Зеланд улс, Монгол Улс, БНАКАУ

	Шинэ Зеланд	Монгол	БНАКАУ
АТИ	88	35	19
Хууль дээдлэх ёсны индекс	0.83	0.54	0.34
Инновацын индекс	47.5	34.2	21.9 (Йемен ³⁰)
Хүний хөгжлийн индекс	0.97	0.74	0.48
Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ	41,000 орчим	4,100 орчим	600 орчим


Жини индекс

Жини индекс (Gini Income Inequality Index) нь нийгэм дэх орлогын хуваарилалт буюу цалин хөлсний хэмжээ хүн амын бүлгүүдэд хэрхэн хуваарлагдаж байгааг хэмждэг үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, хүн амын бүлгүүдийн мөнгөн орлогын ялгаа буюу нийгэмд орлого хэр жигд хуваарилагдаж буйг илэрхийлдэг тоон үзүүлэлт. Жини индексийг 0-100 хүртэл тоогоор илэрхийлдэг бөгөөд 0 рүү ойртох тусам тухайн улс орны хүн амд нийгмийн баялаг, улсын орлого тэгш хуваарилагдаж буйг, 100 руу ойртох тусам баян, ядуугийн ялгаа гүнзгийрч байгааг илэрхийлдэг. Дэлхийн банкнаас гаргадаг энэхүү индексэд манай улс жигд давтамжтай хамрагдаж чадаагүй.

Монгол Улсын үзүүлэлт 1998 онд хамгийн бага (30.3), 2007 онд хамгийн өндөр (35.8), харин дундаж нь 33 оноотой байна:

30 Инновацын индексэд БНАКАУ хамрагдаагүй тул АТИ-ийн оноогоор ойролцоо (16) гэдэг үндэслэлээр Йемен улсын оноог оруулав.

Зураг 18 Монгол Улсын Жини индекс, оноор



Эдийн засгийн өсөлт

Авлига нь эдийн засгийн өсөлт ба хөгжилд ямагт саад болдогийг судлаачид онолын болон эмпирик олон төрлийн судалгаагаар нотолсон байдаг. Энэ нь манай улсын эдийн засгийн нөхцөл байдлаас ч тод харагдана. 2022 оны 3-р улирлын мэдээллээс харахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт 7.07 хувьтай байна.

2012-2021 оны Монгол Улсын ДНБ, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ болон эдийн засгийн өсөлтийн түвшинг дараах хүснэгтэд харуулав³¹.


Хүснэгт 4 Монгол Улсын ДНБ, Нэг хүнд ногдох ДНБ ба өсөлтийн түвшин, оноор

Он	ДНБ (тэрбум ам.доллар)	Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)	Өсөлтийн түвшин
2012	12.29	4,352	12.32%
2013	12.58	4,366	11.65%
2014	12.23	4,159	7.89%
2015	11.62	3,875	2.38%
2016	11.18	3,658	1.49%
2017	11.48	3,687	5.64%
2018	13.18	4,157	7.74%
2019	14.21	4,405	5.60%
2020	13.31	4,061	-4.56%
2021	15.10	4,535	1.42%

31 <https://www.macrotrends.net/countries/MNG/mongolia/economic-growth-rate#:~:text=Mongolia%20economic%20growth%20for%202021,a%2014.78%25%20increase%20from%202017.>

Үүнээс эдийн засгийн өсөлтийн түвшинг графикаар үзүүлвэл:


Зураг 19 Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн түвшин, оноор, хувиар



Инфляци

Инфляци бол авлигад идэгдсэн тогтолцооны нэг шинж тэмдэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, инфляци нь төсвийн талаарх төрийн бодлого, төв банкны мөнгөний бодлого хариуцлагагүй байгаагийн, мөн төсвийн зардал болон алдагдал асар их байгаагийн шинж юм. 2011-2021 оны Монгол Улсын инфляцийн түвшнийг дараах зурагт харуулав³²:

Зураг 20 Монгол Улсын инфляцийн түвшин, оноор, хувиар




32 <https://www.macrotrends.net/countries/MNG/mongolia/inflation-rate-cpi#:~:text=Mongolia%20inflation%20rate%20for%202021,a%202.5%25%20increase%20from%202017>.

ДОТООДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1 Шударга байдлын үнэлгээ


Шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагын шударга байдлын түвшнийг үнэлдэг бөгөөд тухайн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ, тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын үнэлгээ, бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын үнэлгээнд суурилдаг. Төрийн байгууллагын шударга байдлыг 0-100 оноогоор үнэлдэг бөгөөд 100-д ойртох тусам шударга байдал нэмэгдэж байна гэж үздэг.

Зураг 21 Шударга байдлын үнэлгээ, оноор



Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад дараах байдлаар хариулжээ:

Зураг 22 Авлигын түгээмэл байдлын талаарх иргэдийн үнэлгээ, оноор



Өөрөөр хэлбэл, жил бүр судалгаанд оролцогчдын 70 гаруй хувь нь манай улсад авлига түгээмэл буюу их түгээмэл байна гэж үздэг байна. Мөн авлигын шалтгааныг цалин хөлс бага, хууль, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй, төрийн үйлчилгээ удаан хойрго байгаатай холбон тайлбарлажээ.

2015 оноос хойших 6 удаагийн судалгаанд хамгийн багаар үнэлэгдсэн 5 яамны тоонд БОАЖЯ, ЭМЯ тус бүр 5 удаа, УУХҮЯ 4 удаа, БХБЯ, ЗТХЯ, ХЗДХЯ тус бүр 3 удаа бичигдсэн байна.

Хүснэгт 5 Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан 5 яам, оноор

2015	2016	2018	2019	2021	2022
БХБЯ	ЗТХЯ	УУХҮЯ	УУХҮЯ	БОАЖЯ	ЭМЯ
ЭМСЯ	УУХҮЯ	ЭХЯ	ЗТХЯ	ЭМЯ	БХБЯ
ЗТЯ	БОАЖЯ	БОАЖЯ	БСШУСЯ	БХЯ	БШУЯ
БОНХАЖЯ	БХБЯ	ХЗДХЯ	ХНХЯ	ХЗДХЯ	БОАЖЯ
ХАХНХЯ	ХЗДХЯ	ЭМЯ	ЭМЯ	ХХААХҮЯ	УУХҮЯ

2012 оноос хойших 8 удаагийн Шударга байдлын үнэлгээгээр бага оноо авч, хамгийн сүүлийн байрт жагссан 5 байгууллагад гаалийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага тус бүр 5 удаа, Ашигт малтмал, газрын тосны газар, Биеийн тамир, спортын улсын хороо тус бүр 4 удаа, цагдаагийн байгууллага, татварын байгууллага тус бүр 3 удаа бичигдсэн байна.

Хүснэгт 6 Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан 5 байгууллага, оноор

2012	2014	2015	2016	2018	2019	2021	2022
Цагдаагийн байгууллага	Цагдаагийн байгууллага	Мэргэжлийн хяналтын байгууллага	Биеийн тамир, спортын газар	Биеийн тамир, спортын газар	Гаалийн ерөнхий газар	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Гаалийн ерөнхий газар
Газрын алба	Мэргэжлийн хяналтын байгууллага	Ашигт малтмалын газар	Цагдаагийн ерөнхий газар	Татварын ерөнхий газар	Биеийн тамир, спортын газар	Ашигт малтмал, газрын тосны газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Эрүүл мэндийн байгууллага	Эрүүл мэндийн байгууллага	Гаалийн ерөнхий газар	Соёл, урлагийн газар	Ашигт малтмал, газрын тосны газар	Үндэсний хөгжлийн газар	Мал эмнэлгийн ерөнхий газар	Биеийн тамир, спортын улсын хороо
Мэргэжлийн хяналтын байгууллага	Татварын байгууллага	Татварын ерөнхий газар	Зэвсэгт хүчний жанжин штаб	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Иргэний нисэхийн ерөнхий газар	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Боловсролын ерөнхий газар
Улсын бүртгэлийн байгууллага	Гаалийн байгууллага	Иргэний нисэхийн ерөнхий газар	Ашигт малтмал, газрын тосны газар	Архивын ерөнхий газар	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Гаалийн ерөнхий газар	Мал эмнэлгийн ерөнхий газар

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийн талаар асуухад сүүлийн 5 удаагийн судалгаанд шүүх, газрын алба, эрүүл мэндийн байгууллага тогтмол нэрлэгдсэн, харин гаалийн байгууллага 4 удаа бичигдсэн байна.

Хүснэгт 7 Авлига хамгийн их тархсан 5 институц, оноор

2016	2018	2019	2021	2022
Газрын алба (46.4%)	Шүүх (49.2%)	Шүүх (53.3%)	Эрүүл мэндийн байгууллага (48.3%)	Эрүүл мэндийн байгууллага (52.0%)
Эрүүл мэндийн байгууллага (44.7%)	Газрын алба (47.0%)	Гаалийн байгууллага (48.0%)	Шүүх (48.0%)	Шүүх (50.5%)
Шүүх (38.6%)	Эрүүл мэндийн байгууллага (46.4%)	Мэргэжлийн хяналтын байгууллага (44.6%)	Газрын алба (41.8%)	Газрын алба (48.9%)
Гаалийн байгууллага (37.7%)	Төрийн захиргааны байгууллага, яам, агентлаг (43.9%)	Газрын алба (42.9%)	Гаалийн байгууллага (36.9%)	Гаалийн байгууллага (46.4%)
Төрийн захиргааны байгууллага, яам, агентлаг (33.0%)	Боловсролын байгууллага (41.0%)	Эрүүл мэндийн байгууллага (42.6%)	Цагдаагийн байгууллага (35.3%)	Цагдаагийн байгууллага (41.6%)

Сүүлийн 6 удаагийн судалгаанд Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага үнэлэгдсэн 7 аймагт Баян-Өлгий аймгийн ЗДТГ 6 удаа, Ховд аймгийн ЗДТГ 5 удаа, Дундговь, Өмнөговь аймгийн ЗДТГ 4 удаа, Говь-Алтай аймгийн ЗДТГ 3, Төв, Дорноговь, Дархан-Уул, Архангай, Завхан, Хөвсгөл аймгийн ЗДТГ тус тус 2 удаа бичигджээ.

Хүснэгт 8 Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан 7 ЗДТГ, оноор


2015	2016	2018	2019	2021	2022
Төв	Ховд	Архангай	Нийслэл	Өмнөговь	Баянхонгор
Дархан-Уул	Төв	Өвөрхангай	Сүхбаатар	Завхан	Дархан-Уул
Хэнтий	Дундговь	Ховд	Дундговь	Дорноговь	Ховд
Өмнөговь	Өмнөговь	Говь-Алтай	Өмнөговь	Архангай	Хөвсгөл
Дундговь	Говьсүмбэр	Орхон	Говь-Алтай	Ховд	Баян-Өлгий
Завхан	Баян-Өлгий	Баян-Өлгий	Баян-Өлгий	Баян-Өлгий	Говь-Алтай
Баян-Өлгий	Дорноговь	Дундговь	Ховд	Хөвсгөл	Сэлэнгэ

2.2 Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа

2008-2017 онд улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайлан гаргаж байгаад 2018 оноос тус тусад нь судалж байна. Энэ судалгаа нь тухайн салбар, хүрээн дэх авлигын шалтгаан, цар хүрээ, хэлбэр, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх иргэдийн төсөөлөл, хандлагыг тодорхойлдог. Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг 0 (огт үгүй) – 5 (маш их) оноогоор үнэлдэг.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2021 оны үр дүнг дараах зурагт харуулав:

Зураг 23 Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин, оноор




Улс төрийн хүрээн дэх авлигын тархалтын цар хүрээг судалгаанд оролцогчид дараах байдлаар үнэлжээ:

Хүснэгт 9 Улс төрийн хүрээн дэх авлигын цар хүрээ, оноор

2017	2018	2019	2020	2021
Улс төрийн намууд (4.48)	Засгийн газар / яам, агентлаг/ (4.23)	Засгийн газар / яам, агентлаг/ (4.22)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ (4.15)	Улс төрийн намууд (4.08)
УИХ (4.25)	Улс төрийн намууд (4.21)	Улс төрийн намууд (4.08)	УИХ (3.98)	УИХ (3.71)
Засгийн газар / яам, агентлаг/ (4.21)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ (3.97)	УИХ (4.04)	НӨУБ /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ (3.95)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ (3.67)
Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ (3.93)	УИХ (3.87)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ (3.85)	Засгийн газар / яам, агентлаг/ (3.74)	НӨУБ /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ (3.60)
Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ (3.90)	НӨУБ /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ (3.75)	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ (3.75)	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ (3.74)	Засгийн газар / яам, агентлаг/ (3.55)
НӨУБ /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ (3.89)	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ (3.75)	НӨУБ /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ (3.56)	Улс төрийн намууд (0)	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ (3.53)

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2021 оны үр дүнг дараах зурагт харуулав:

Зураг 24 Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын түвшин, оноор



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд 10 байгууллагыг багтаан судалгааг зохион байгуулдаг бөгөөд эдгээр салбарууд дахь авлигын тархалтын цар хүрээг судалгаанд оролцогчид дараах байдлаар төсөөлж байна:


Хүснэгт 10 Авлигын цар хүрээгээр эхний 4-т эрэмбэлэгдсэн байгууллагууд, оноор

2017	2018	2019	2020	2021
Тагнуулын байгууллага (4.08)	Прокурор (4.02)	Шүүх (4.07)	Прокурор (4.02)	Прокурор (3.83)
Прокурор (4.04)	Шүүх (3.97)	Прокурор (4.05)	Шүүх (3.90)	Шүүх (3.73)
Шүүх (4.02)	Цагдаагийн байгууллага (3.68)	Цагдаагийн байгууллага (3.64)	ШШГБ (3.79)	Цагдаагийн байгууллага (3.59)
Цагдаагийн байгууллага (3.96)	ШШГБ (3.54)	ШШГБ (3.51)	Шүүхийн шинжилгээний байгууллага (3.79)	ШШГБ (3.53)

Хүүхдийн шударга байдлын судалгаа

Хүүхдийн шударга байдлын судалгаа нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, төлөвшил, мөн дүрэм журам сахих болон авлигыг үл тэвчих чадвар, хандлага ямар түвшинд байгааг тодорхойлох зорилготой юм. Хүүхдийн шударга байдлыг 1-5 хүртэлх оноогоор үнэлдэг бөгөөд 5-д ойртох тусам шударга байна гэж ойлгоно.

Зураг 25 Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, оноор



Хүүхэд анги дэвших, нас ахих бүр шударга байдлын үнэлгээ буурах, хөвгүүдээс илүү охид шударга байх, хувийн өмчийн сургуулийн сурагчдаас илүү төрийн өмчийн сургуулийн сурагчид шударга байх хандлага тогтмол ажиглагддаг.

2.4 АТГ-ын үйл ажиллагааны талаарх зарим статистик мэдээлэл


- АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст 2012-2022 онд шалгагдсан эрүүгийн хэрэг болон тэдгээр хэрэгт холбогдогчдын талаарх тоон мэдээллийг дараах зурагт үзүүлэв. Энэ хугацаанд нийт 8,086 хэрэгт 7,293 хүн холбогджээ:

Зураг 26 2012-2021 онд Авлигатай тэмцэх газарт шалгагдсан эрүүгийн хэрэг болон тэдгээр хэрэгт холбогдогчдын тоо, оноор



2012-2022 онд шалгасан эрүүгийн хэргийн 7,296 холбогдогчийг албан тушаалын ангиллаар нь авч үзвэл 9.3 хувийг нь улс төрийн албан тушаалтан, 11.8 хувийг үйлчилгээний албан тушаалтан, 17.0 хувийг нь захиргааны албан тушаалтан, 17.8 хувийг нь тусгай албан тушаалтан, 44.1 хувийг бусад буюу энгийн иргэд эзэлж байна:


Зураг 27 Эрүүгийн хэрэгт холбогдогчдын албан тушаалын ангилал, хувиар



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

■ АТГ-т шалгагдсан эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг дараах зурагт үзүүлэв:

Зураг 28 Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ (тб.төг), оноор



Энэ хугацаанд нийт 20.7 их наяд төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалж, 2,558.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

■ Нийт шалгасан болон шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо:

Зураг 29 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо, оноор



Тухайн жилд шалгасан нийт хэргийн тоотой харьцуулвал дунджаар 9.5 хувь (дээд тал нь 13.8 хувь /2014 он/, доод тал нь 5.2 хувь /2019 он/) нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

■ АТГ-т ирсэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл болон түүнийг шалгаж хариуцлага хүлээлгэсэн байдлын талаарх тоон мэдээллийг дараах зурагт үзүүлэв:

Зураг 30 Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн хяналт, шалгалт, оноор



Тухайн жилд хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн тоотой харьцуулвал дунджаар 7.3 хувьд (дээд тал нь 20.8 хувь /2015 он/, доод тал нь 3.8 хувь /2020 он/) нь хариуцлага хүлээлгэсэн байна.

2.5 Бусад судалгаа, индекс

2.5.1 Авлигын эрсдэлийн үнэлгээ

2015 оноос хойш АТГ-аас нийт 60 төрийн байгууллага, төрийн өмчит компанид Авлигын эрсдэлийн үнэлгээг зохион байгуулсан.

Хүснэгт 11 2019-2022 онд Авлигын эрсдэлийн үнэлгээ зохион байгуулсан төрийн байгууллага, оноор

Д/д	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	Нийт	
1	Нийт байгууллагын тоо	15	10	7	4	36	
2	Үүнээс	Яам	-	-	-	1	1
3		Агентлаг	-	7	4	2	13
4		ТӨХК болон ТӨҮГ	15	1	1	1	18
5		Засаг даргын Тамгын Газар	-	1	-	-	1
6		Засгийн газрын тусгай сан	-	1	2	-	3

Эрсдэл өндөр гэж үнэлэгдсэн байгууллагуудад дараах зөрчил, дутагдал түгээмэл байгаа нь үнэлгээний явцад тогтоогдсон:

1. Төсөв, санхүү:

- Байгууллагын хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан, өр төлбөрийг гэрээний хугацаанд барагдуулах санхүүгийн чадваргүй болсон.
- Хариуцлагатай байх, үнэн зөв байх, уялдаатай байх зарчим алдагдсан.
- Санхүү, төсвийн тайлан гаргадаггүй, санхүүгийн сахилга бат алдагдсан, санхүүгийн тодруулга тайлан бэлтгэдэггүй, санхүүгийн шинжилгээ хийж үр дүнг хэлэлцэн баталгаажуулдаггүй.
- Хөрөнгө, авлага эргэн төлөгдөхгүйгээс санхүүгийн хүндрэл тулгарсан, хөрөнгө зүй зохисгүй ашиглагдах, шамшигдах, үнэгүйдэх нөхцөл үүссэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчдөг.

2. Чиг үүрэг, бүтэц:

- Тусгай сангийн зээлийн эх үүсвэрийг зүй зохистой ашиглах, нэмэгдүүлэх, сангийн төсөв, ХАА, түүний мэдээг хэлэлцэх, өр авлага барагдуулах чиглэл өгөх, Засгийн газрын гишүүнд танилцуулах, шийдвэрлэх эрхээ хариуцлагатайгаар хэрэгжүүлэн ажилладаггүй.
- Улсын бүртгэлд бүртгэж, баталгаажсан нэрээ байгууллагын дүрэмд тодорхойлон хэрэглээгүйн улмаас банкны харилцах данс болон бусад бүхий л процесст санхүүгийн эрсдэлтэй байдал үүссэн.
- Хөтөлбөр, хөрөнгийг оновчтой зохион байгуулан удирдах байдал хангалтгүй.
- Чанартай техник хэрэгсэл тоног төхөөрөмжийг захиалж, нийлүүлсэн хугацаандаа эзэндээ очиж хэрэглэгдэж, үр ашгаа нөхдөг байхаар зохион байгуулдаггүй.
- Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатны төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг тогтолцоог бүрдүүлээгүй.
- Сахилга хариуцлага, төрийн албан хаагчийн манлайлал хангалтгүй.
- Удирдлагын түвшний өндөр эрсдэлтэй ажиллаж байгаа нь хараат байдалд нөлөөлж, тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг үгүйсгэсэн.
- Үйл ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий удирдах албан тушаалтан үүрэгт ажлаа зохих ёсоор хэрэгжүүлж ажилладаггүй.
- Орон тоо зөрчигдөх, батлаагүй албан тушаалд ажилтан авч ажиллуулдаг.

3. Шийдвэр гаргах үйл явц

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендэр зохион байгуулдаггүй, яамны тушаалаар санхүүжилт хийгдэж гэрээ байгуулдаг.
- Гадаад улсаас нийлүүлэгдэж буй их хэмжээний үнийн дүнтэй тоног төхөөрөмж сонгон шалгаруулалтгүй явагддаг.
- Бараа бүтээгдэхүүний урамшуулал, үнийн хөнгөлөлт, дэмжлэгийг хэрхэн олгодог шалгуур журам тодорхойгүй, сонгон шалгаруулалт зохион байгуулдаггүй.
- Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл борлогддоггүй, чанарын шаардлага хангадаггүй. Худалдан авагчдад түрээсээр олгодог техник, тоног төхөөрөмжийг хэрхэн олгодог талаар зохицуулсан шалгуур, журамгүй.
- Зээл, дэмжлэг, урамшуулал, хөнгөлөлттэй санхүүжилт нь гадаад валютаар хийгддэг нь байгууллагын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлдөг.
- Монгол Улсын хөгжлийн бодлогын гол баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшинтэй нийцээгүй байх, өөрөөр хэлбэл, биелэлт хагас дутуу, үр дүн тодорхойгүй, тухайн арга хэмжээд тохирохгүй биелэлт гаргах, түүнчлэн хийсэн ажлаа бүрэн тусгадаггүй, тухайн арга хэмжээ хэрэгжээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой бичдэггүй.
- Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд улс төрийн нөлөөлөл байдаг.
- Хяналт, шалгалтын ажлын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх маш их эрсдэлтэй.

4. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт

- Байгууллагын удирдлага богино хугацаанд маш олон удаа солигддог.

- Ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийг зорьж ажилладаггүй, урамшууллын систем бий болгоогүй.
- Хариуцлагын тогтолцоо сул, ажлын байрны тодорхойлолтыг баримтлан ажилладаггүй.
- Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийн биелэлтийн талаар байгууллага дотооддоо бүртгэл, судалгаа гаргаж, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй.
- Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа бодит нөхцөл байдалд тохирсон, үндэслэл бүхий байх зарчмыг зөрчдөг.
- Шинээр ажилд орж байгаа иргэнд тавигдах ажлын байрны тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй иргэнийг томилдог.

4. Өргөдөл, гомдол мэдээлэл

- Өргөдөл, гомдлыг хэрхэн хүлээж авдаг нь тодорхойгүй, өргөдөл гомдлын бүртгэл хөтөлдөггүй, хэрхэн шийдвэрлэж, хариу өгдөг нь тодорхойгүй.
- Алдаатай, буруу шийдвэрээс болж иргэн, хуулийн этгээд хохирсон болохыг тогтоосон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд дүгнэлт хийдэггүй.
- Ёс зүй, шударга байдлын түвшин
- Удирдах албан тушаалтнууд байгууллагын үйл ажиллагаанд зохих журам, шалгуур үзүүлэлтийг батлан мөрдөж ажилладаггүй, үр дүнг тооцох, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэггүй.
- Ажлын хариуцлага сул, аливаа асуудлыг хэлэлцэн үр дүнг тухай бүр тооцох дотоод хяналтын журам, тогтолцоогүй.
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа тухай мэдээлэл, тайлан гаргадаггүй, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан хороог зохион байгуулаагүй.

5. Мэдээллийн хүртээмж

- Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгч, харилцагчдад дүрэм журмыг энгийн ойлгомжтойгоор, шалгуур, нөхцөл, болзол тодорхой байх, үндэслэлтэй байх зарчмыг баримтлан нээлттэйгээр, цахим хэлбэрээр тогтмол давтамжтайгаар хүргээгүй.
- Төрийн байгууллагын вебсайтад тавигдах шаардлагыг мөрдлөг болгоогүй, байршвал зохих мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн оруулаагүй, хамтын ажиллагаа, инновацын талаарх мэдээллийг оруулаагүй.
- Цахим мэдээлэл оруулсан ч гүйцэтгэлийг анхаарч, хэрэгжилтийг хангаагүй.

6. Хариуцлага тооцох механизм

- Харилцагч байгууллагуудын өр, авлагын эргэн төлөлтөд хяналт тавих, хариуцлага тооцох байдал хангалтгүй.

7. Сургалт, давтан сургалт

- Нэг албан хаагчид ногдох сургалтын зардал жил бүр буурдаг.
- Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд огт анхаардаггүй, сургалтын төсөв хангалтгүй, үр дүнгүй.

8. Бүртгэл

- Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө УСНББОУС-ын дагуу тайлан гаргадаггүй, орлого, зардлыг

уялдуулан хамаатуулан бүртгэх зарчмыг баримтлаагүй.

- Бүх хөрөнгө, бүх орлого, бүх эх үүсвэр, хөрөнгийн хөдөлгөөн бүрийг бүртгэж тайлагнана гэсэн хуулийн шаардлага хангагдаагүй.
- Бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйн улмаас хөрөнгө, авлага, өр төлбөр, эх үүсвэр үнэн зөв, шударга илэрхийлэгдэхгүй байх, санхүүгийн өр төлбөр, авлагыг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүйн улмаас хөрөнгө алдах, шамшигдах нөхцөл бий болсон.
- Санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгө, шатахуун зарцуулалтын талаар өгөгдсөн зөвлөмж бүрэн хэрэгждэггүй.
- Мөнгөн хөрөнгө төвлөрүүлэлт зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй, шатахууны тооцоог нотлох баримтад үндэслэн хийдэггүй, хөрөнгийн хөдөлгөөнийг хөрөнгийн ангиллаар үнэн зөв бүртгэж тайлагнадаггүй, баримтын иж бүрдэл хуульд заасан шаардлагад нийцээгүй.

9. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл

- Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хангалтгүй.
- Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаа дутмаг.

10. Авлигын эсрэг бодлого

- Авлигаас урьдчилан сэргийлэх, байгууллагад бий болж буй авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн үйл ажиллагааны бодлогыг батлаагүй, энэ талаар хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан хангалтгүй.

11. Ил тод байдал

- Санхүүгийн И баланс, Татварын цахим тайлан, мэдээ мэдээлэл, Нийгмийн даатгалын тайлан, мэдээлэл, Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний мэдээлэл цахимаар авах боломжийг бүрдүүлээгүй, нэвтрэх нэр, нууц үг буруу өгөх, харилцан үл ойлголцол үүсэх, ажилтан халагдсан шалтгаанаар цахим мэдээллийг өгөх хүсэл эрмэлзэлгүй байна.
- Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах, мэдээлэл авах хэлбэрээ сонгох, мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх эрхийг хангадаггүй.
- Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авдаггүй.
- Төрийн байгууллагын вебсайтад тавих шаардлага Монгол Улсын MNS 6285:2017 стандартад нийцээгүй гэх мэт.

2.5.2 “Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага дахь авлигын эрсдэл” судалгаа¹⁷

- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын тоо зөрүүтэй байна (тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын www.opendata.burtgel.gov.mn сайтаас нэгдсэн тоон мэдээлэл харах боломжгүй байгаа бол Сангийн яамнаас ХЗДХЯ-нд өгсөн мэдээллээр 399, ТӨБЗГ-аас ХЗДХЯ-нд өгсөн мэдээллээр 467, Шилэн дансны мэдээллээр 477, ҮСХ-ны Бизнес регистрийн сангийн мэдээллээр 495, Үндэсний Аудитын газраас ХЗДХЯ-нд өгсөн мэдээллээр 537).
- ТӨБЗГ-ын мэдээлснээр бүх төрийн өмчит компани (орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээс бусад) 2020 онд 7.4 их наяд төгрөг (2.6 тэрбум ам.доллар)-ийн орлого олсон нь тухайн

17 Энэ судалгааг АТГ-аас 2022 онд зохион байгуулсан.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

жилийн ДНБ-ий ойролцоогоор 16.7 хувийг эзэлж, улсын нийт экспортын тал илүү (50.7) хувийг бүрдүүлж байна.

- Гэвч ТӨК-уудын нийт цэвэр ашиг 2020 онд дөнгөж 688.6 тэрбум төгрөг (244.7 сая ам.доллар), үүний 412 тэрбум төгрөг нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэс Тавантолгой ХК гэсэн зөвхөн хоёрхон уул уурхайн компаниас бүрдсэн байна.
- 2020 онд АТГ-т нийт хүлээн авсан ӨГМ-ийн 8.9 хувийг, 2021 онд 8.5 хувийг, 2022 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 9.0 хувийг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой ӨГМ эзэлж байна.

Хүснэгт 12 Өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, оноор

Д/д	Үзүүлэлт	2020	2021	2022.08.31-ний өдрийн байдлаар	Нийт
1	Хүлээн авсан нийт ӨГМ-ийн тоо	2,282	2,314	1,775	6,371
2	Төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой ӨГМ-ийн тоо	204	297	159	560
3	Нийт ӨГМ-д Төрийн өмчит болон орон нутгийн өмчит ААНБ-тай холбоотой ӨГМ-ийн эзлэх хувь	8.9	8.5	9.0	8.8

ТИ байгууллагын зөвлөмжид дурдсанаар төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дараах хүрээнд авлигын эрсдэл өндөр байна. Үүнд:

- Худалдан авах үйл ажиллагаа, гэрээ, хэлцэл
- Худалдаа, маркетинг, бизнес хөгжүүлэлт
- Судалгаа, хөгжүүлэлт
- Харилцагч, гуравдагч этгээдийн үйл ажиллагаа, удирдлага
- Ханган нийлүүлэлт
- Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах болон худалдан авах
- Үндсэн чиглэлийн үйл ажиллагааны хүрээнд нийтэд үйлчлэх
- Хүний нөөц
- Оюуны өмч ба дата мэдээлэл
- Удирдлагын шийдвэр
- Бэлэг, зочин төлөөлөгч, холбогдох зардал
- Санхүү, нягтлан бодох
- Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, урсгал зардал

АТГ-аас зохион байгуулсан Авлигын эрсдэлийн үнэлгээгээр төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад дараах төрлийн эрсдэл өндөр тогтоогдож байна:

- Төсөв, санхүүгийн зарцуулалт, тайлагнал

- Худалдан авах ажиллагааны ил тод байдал
- Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаа
- Авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзлэл


2.5.3. Цахим ил тод байдлын индекс

Энэ судалгааг анх 2010 онд IRIM судалгааны хүрээлэн АТГ-ын захиалга, НҮБХХ-ийн санхүүжилтээр хийж эхэлсэн бөгөөд төрийн байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх, цаашдид ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой судалгаа юм¹⁸.

2018 оноос өмнө тус судалгаагаар 1) Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance), 2) Мэдээллийн найдвартай байдал (Reliability), 3) Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness), 4) Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility), 5) Хэрэглэхэд хялбар байдал Usability) гэсэн үзүүлэлтүүдийг хувиар тооцож, шалгуур үзүүлэлт бүрийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг “Хаалттай” (0-40), “Зарим талаар ил тод” (41-60), “Ил тод” (61-80), “Бүрэн ил тод” (81-100) гэсэн 4 түвшингээр үнэлдэг байсан.

2010-2018 оны индексийг дараах зурагт харуулав. Төрийн байгууллагуудын цахим ил тод байдал 2010-2014 онд “хангалтгүй” гэж үнэлэгдэж байсан бол 2015-2018 онд “зарим талаараа ил тод” гэж үнэлэгдсэн. Судалгааг хийж эхэлснээс хойш 2018 оныг хүртэл энэ үзүүлэлт 35 хувиар сайжирсан ч 2017 оны үзүүлэлтээс хоёр хувиар буурсан байна.

Зураг 34 Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс, оноор




2019 оноос “Цахим ил тод байдлын индекс” болгон аргазүйг шинэчилж, 1) эрх зүйн орчин, 2) Байгууллагын чадамж, 3) Цахим нээлттэй байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгт багтах 9 дэд бүлэг, 26 үзүүлэлтийг 0-1 оноогоор “Сайн” (≥ 0.80), “Хангалттай” (0.65-0.79), “Сул” (0.50-0.64), “Хангалтгүй” (0.35-0.49), “Муу” (< 0.35) гэсэн 5 түвшинд үнэлдэг болсон.

Судалгааны 2019-2021 оны дүнг харахад улсын дундаж “Сул” үнэлгээтэй байна:


18 <https://www.irim.mn/web-monitoring>

Зураг 35 Цахим ил тод байдлын индекс, оноор



2021 оны судалгаанд хамрагдсан 88 байгууллагын хувьд 28 хувь нь л “Хангалттай”, харин 62 хувь нь “Сул” үнэлэгдсэн байна:

Зураг 36 Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



03.



**ГУРАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ (2017-2022)**



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (2017-2022)

Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 10 үйл ажиллагаа, 26 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулбал:

4.1.1.1-Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох /АТГ, ТАЗ, 2017-2022/

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу АТГ 2017 онд 11,143, 2018 онд 10,461, 2019 онд 8,682, 2020 онд 13,030, 2021 онд 12,504, 2022 онд 14,861, 2017-2022 онд нийт 70,681 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч, хянан шийдвэрлэсэн бөгөөд нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсэж болзошгүй, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал тогтоогдсон эсэх талаар долоо хоног тутам иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэв. Хянан шалгасан мэдүүлгээс 2020 онд 848, 2021 онд 1,018, 2022 онд 918, 2017-2022 онд нийт 5,050 нэр дэвшигчийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан, шаардлага хангаагүй үндэслэлээр 2020 онд 490, 2021 онд 266, 2022 онд 124, нийт 2,619 мэдүүлгийг буцаасан, 2020 онд 8, 2021 онд 22, 2022 онд 37, нийт 159 нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл

байдал тогтоогдож байгаа талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2020-2021 онуудад ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг Сонгуулийн ерөнхий, Хүний эрхийн үндэсний комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Ашигт малтмал, газрын тосны газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай, Дундговь, Увс, Баян-Өлгий, Орхон, Хэнтий, Булган, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Ховд аймгууд, холбогдох цахим хуудсандаа байршуулж хэвшүүлжээ. АТГ-аас нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийн цахим мэдээллийн санд өөрчлөлт оруулж, ХАСУМ хянах процессийг нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд болон мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтанд нээлттэй болгосон.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийг нэр дэвшүүлэх тогтоолыг тухайн байгууллагын удирдлагад хүргүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст тухай бүр мэдээлж байна.

Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх, шалгалтын үйл явцыг иргэд олон нийт хөндлөнгөөс ажиглах боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх /АТГ, 2017-2019/

АТГ-аас УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын “Б” хэсэгт заасны дагуу “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” БАТАЛГААНЫ МАЯГТ-ыг ашиглан мэдүүлэг гаргах ажлыг зохион байгуулж байна. ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2017 онд эхлүүлсэн.

2020 онд төрийн болон нутгийн захиргааны 884 нэгж буюу нийт холбовол зохих нэгжийн 80 орчим хувийг, 2021 онд бүх төрийн байгууллагыг цахим системд холбон ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.1-3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах /АТГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.6-д “Нэр дэвшигчийг томилохоос өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасан мэдүүлгийг авсан байна.” гэж тусган хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна. ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд ХАСУМ-ийн цахим мэдээллийн санд төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн огноо, шалгалтад тэнцсэн эсэх тухай мэдээллийг оруулж хэвшүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-4. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /АТГ, ТАЗ, 2017-2019/

АТГ-аас яам, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүрэг, 21 аймаг, зарим сумдад ажиллаж хуулийн хэрэгжилт болон төрийн албан дахь хүний нөөцийн томилгоонд хяналт тавин ажиллаж байна.

Энэ хүрээнд албан тушаалын томилгоотой холбоотой асуудлыг нарийвчлан судалж, нөхцөл байдлыг тогтоон Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хариуцлагын асуудал тусгагдаж УИХ-ын чуулганаар хэлэлцэж байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг АТГ хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдийг дур мэдэн томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх эрсдэлийг бий болгож байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дагаврын талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд саналаа хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох /ТАЗ, 2017-2019/

Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын

нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ыг баталсан. Уг журамд төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сантай байх, уг сан нь төрийн албан тушаал эрхэлж байгаа болон эрхэлж байсан иргэний мэдээлэл, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтны нөөцөд байгаа иргэний мэдээлэл, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн төрийн албан хаагч, иргэний тухай мэдээллээс бүрдэхээр тусгажээ. Мөн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийг ашиглахаар тусгасны дагуу нэгдсэн системийг боловсронгуй болгох ажлыг хийж байна.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд бүртгэгдсэн албан хаагчдын мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин бодогдохоос гадна төрийн албан хаагчдын нарийвчилсан статистик мэдээ гарч, төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх бодитой нөхцөл бүрдэх давхар ач холбогдолтой юм.

Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолд "Тоо бүртгэлийг хөтлөх, тайлан гаргахад хамрагдах байгууллагуудын жагсаалтыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон холбогдох эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийг үндэслэн Төрийн албаны зөвлөл батална" гэж заасны дагуу бүртгэлд хамрагдвал зохих байгууллагуудын жагсаалт гаргасан. Жагсаалтад 11 байгууллагын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа 3206 байгууллагыг хамруулсан. 2020 онд системд 46 байгууллагыг шинээр бүртгэж, 65 байгууллагын мэдээллийг шинэчлэн зассан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам"-ын 11.4-т "Шалгалтад тэнцсэн иргэнийг зөвхөн тухайн аймаг, нийслэлийн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэж, бүртгэлийн жагсаалтыг Зөвлөлийн цахим хуудсанд байршуулна." гэж заасны

дагуу 2019, 2020, 2021, 2022 онд төрийн албаны ерөнхий шалгалт өгч төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас /<https://csc.gov.mn/s/35/805/>-д нээлттэй байна. Тус цахим хуудсанд төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн 2019 оны 1,116, 2020 оны 3,823, 2021 оны 2,292, 2022 онд 3,739 иргэнийг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэн мэдээллийг байршуулсан байна.

2021 онд Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны замын зургийг боловсруулан гаргахад шаардлагатай тоо мэдээллийг гарган, танилцуулгыг бэлтгэсэн. "Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт боловсруулах" Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан мэдээлэлд тулгуурлан Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан гаргах загварыг боловсруулан нийт 100 гаруй үзүүлэлт бүхий 22 маягтыг батлуулан, 11 маягтын дагуу төрийн 4,147 байгууллагаас тайлан цахимаар ирүүлсэн тайланг хүлээн авч нэгтгэсэн. Төрийн албаны зөвлөлийн баталсан 22 маягт, Үндэсний статистикийн хорооны баталсан 3 маягт, нийт 25 маягтаар байгууллага, салбар зөвлөл, улсын хэмжээний гэсэн ангиллаар тайлан гардаг болгох хөгжүүлэлтийг гүйцэтгэн төрийн албаны тоо бүртгэлийн тайлан гаргаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.2-1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2022/

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 23 дугаар зүйлд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг тус тус хуульчилсан. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага", мөн оны 3 дугаар тогтоолоор "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам", мөн оны 16 дугаар тогтоолоор "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам"-ыг тус тус батлан хэрэгжүүлж

байна. Албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд уг албан тушаалыг үндэслэн сонгон шалгаруулалт зарлаж, сул орон тоог нөхөх арга хэмжээ авч байна.

Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, сайжруулах, өөрчлөх арга хэмжээг авч байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор “Төрийн албанд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг баталлаа. Үүнд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн төрийн жинхэнэ албанд анх орох иргэнд туршилтын хугацааг хэрэглэх нийтлэг болзол, шаардлагыг шинэчлэн тогтоох, туршилтын хугацаанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг зохицуулалтыг тусгасан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 244 дүгээр тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-д өөрчлөлт орууллаа. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын үнэлгээний босго оноонд өөрчлөлт оруулж, тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэгийг сорилоор шалгаж 20 хүртэл оноогоор үнэлэх, дүн шинжилгээ хийх чадвар, асуудал шийдвэрлэх чадварыг сорил болон бодлогоор шалгаж тус бүр 10 хүртэл оноогоор тус тус үнэлж, нийт оноо нь 60 ба түүнээс дээш оноо авснаар тэнцэх зохицуулалт оруулсан байна.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэг, салбарын эрдэмтэн, судлаачдын тусламжтайгаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудын төрийн албаны томилгоо, хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, хийдэл, давхардлыг арилгах, Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, хэм хэмжээтэй уялдуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн.

2021 онд албан тушаалтанд тавигдах боловсрол, туршлага, ур чадварын

ерөнхий болон тусгай шалгуурыг агуулсан албан тушаалын тодорхойлолтыг хянан баталгаажуулах зөвшөөрөл олгох цахим системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, 2022 онд Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн албаны ерөнхий, тусгай шалгалтын болон төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах, төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмуудыг нэгтгэн “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталсан.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолын дагуу “төрийн захиргааны 56 57 байгууллага, 150785 албан хаагчийг хамруулан Чадахуйн зарчмын хэрэгжилт” сэдвээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, түүний харьяа орон нутгийн байгууллагууд, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, Сэргэлэн, Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны 2019-2021 оны үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийв.

“Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журам”-д заасны дагуу аудит хийснээс хойш 2 жилийн туршид хүний нөөцийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, хамтран ажиллаж төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах ёстой. Энэ хүрээнд хүний нөөцийн аудитад хамрагдсан байгууллагуудын хүний нөөцийн үйл ажиллагаанд эерэг үр дүн гарч байна. 6 яам, 5 агентлаг, 3 аймгийн Засаг даргын Тамгын газарт “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”-ын арга барилыг “Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран хэрэгжүүлэв. Энэ хүрээнд төрийн захиргааны удирдах албан тушаалтан, хүний нөөцийн мэргэжилтэн зэрэг төрийн 862 албан хаагчийг “Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад хамрууллаа. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-2. Мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар тусгасан.

Тус хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”, мөн оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, мөн оны 5 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”, мөн оны 14 дүгээр тогтоолоор “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”, мөн оны 15 дугаар тогтоолоор “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, мөн оны 16 дугаар тогтоолоор “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, мөн оны 17 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”, мөн оны 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам” зэргийг батлав. Ийнхүү холбогдох дүрэм, журмуудыг батлан мөрдүүлснээр төрийн албаны томилгоо мерит буюу чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бүрдлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав. Нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан төрийн албаны

мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бэхжүүлэх, төрийн албаны ангилал хооронд ур чадварын шилжилт хийх боломжийг нэмэгдүүлэх, төрийн захиргааны албан тушаалын ахлах түшмэл, түүнээс дээш албан тушаалд тавигдах ажилласан жилийн шаардлагыг төрийн албанд ажиллаж буй албан хаагчид болон хөдөө орон нутгийн төрийн захиргааны албан хаагчдын хомсдол, төвлөрлийг сааруулах шинэтгэлийн бодлоготой уялдуулан уян хатан болгох, төрийн албаны шалгалтын цахим арга хэлбэрийг гүнзгийрүүлэх, давтамжийг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-3. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг олон улсын стандартад нийцүүлэх /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлүүд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний сонгон шалгаруулах шалгалтын сорилын буюу тестийн шалгалтыг цахим хэлбэрээр авч хэвшсэн. Төрийн албаны ерөнхий шалгалтын цахим систем (<https://exam.csc.gov.mn/>)-ийг шинээр хөгжүүлж 2019 оны 09 дүгээр сараас, нэмэлт хөгжүүлэлт хийсэн тусгай шалгалтын цахим систем (<https://hh.csc.gov.mn/>)-ийг 2021 оны 09 дүгээр сараас эхлэн ашиглаж байна. Мөн e-TAZ аппликейшнийг нэвтрүүлж, e-mongolia системд холбон, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, хэрэглэгчдийн тоог 39 мянгад хүргэв. Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах тусгай шалгалтыг цахим технологи ашиглан, хараат бус, ил тод, шударга явуулах нөхцөлийг хангах зорилгоор гар утасны аппликейшнийг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын II болон V бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны төлөөлөл бүхий олон улсын шинжээчдийн тайланд төрийн албан тушаалд нэрдэвшигчийг сонгон шалгаруулах шалгалтыг тогтмол зохион байгуулдаг, шалгалтын үйл явцыг бүрэн цахимжуулсныг “сайн туршлага” хэмээн онцлон тэмдэглэсэн.

Төрийн албаны сонгон шалгаруулалтын цахим системийн дэвшилтэт байдлыг төрийн өмчит үйлдвэрийн газар, хувийн хэвшлийн зарим байгууллагууд хүлээн зөвшөөрч үйл ажиллагаандаа ашиглаж, хамтран ажиллаж эхэллээ. Тухайлбал, “Эрдэнэс монгол” Төрийн өмчит үйлдвэрийн газрын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын бүртгэл болон цахим системд оруулсан шалгалтын сорил даалгавраар шалгалтыг амжилттай зохион байгуулав. Төрийн жинхэнэ албаны шалгалтыг хөндлөнгийн нөлөөлөлгүй, шударга зохион байгуулдаг болсноор сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдол, маргаангүй, оролцогчдод хүлээн зөвшөөрөгдөх болсон нь хамгийн чухал үр дүн болж байна¹⁹. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-4. Шалгалтын тестийн агуулгыг сайжруулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д төрийн жинхэнэ албаны шалгалтын агуулгыг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, монгол хэлний ярианы болон бичгийн, багаар ажиллах (бусад) зэрэг чадварыг шалгах аар зохицуулсан. Өмнө нь төрийн албаны шалгалтын агуулгад хууль, эрх зүйн мэдлэг зонхилсон, монгол хэл, мэдээллийн технологийн мэдлэг багтдаг байсан бол 2019 оноос Монгол Улсын түүх, нийгэм, эдийн засаг, соёлын мэдлэгийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д заасан дээр дурдсан чадвартай холбогдох сорил, даалгавар нэмэгдэж, агуулгын хүрээ өргөжсөн.

Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран төрийн албаны шалгалтын агуулгыг шинэчилсэн. Тухайлбал, Монгол Улсын түүх соёл, нийгэм эдийн засгийн шалгалтын сорил даалгаврыг магадлан шалгах 663, Хууль эрх зүйн мэдлэг шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, хүчингүй болсон, нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн тестийг хасч, засварлан, шинээр 2939, Монгол хэлний ур чадварыг 19 Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, шинээр 700, дүн шинжилгээ хийх ур чадварыг шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, шинээр 1000 сорилыг тус тус боловсруулсан.

Мэдээлэл технологийн дэвшлийг ашиглаж цахим зөвлөмж, цахим ном, шалгалтад хамтдаа бэлтгэх цахим булан ажиллуулсны зэрэгцээ иргэдээс ирүүлсэн саналыг харгалзан шалгалтын сорил, хариултыг товхимол болгон хэвлэж, хэрэглэгчдийн гар дээр хүргэсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-5. Төрийн захиргааны албан хаагчийн сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батлахаар хуульчилсан бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 34/31 дүгээр хамтарсан тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Журам батлагдсанаар төрийн байгууллагын ажлын ачааллыг зохицуулах, төрийн албанд ажиллаж туршлага хуримтлуулсан албан хаагчийн мэдлэг, ур чадварыг үр өгөөжтэй ашиглах, дадлага, туршлагыг нь бусдад эзэмшүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-6. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, “Албан тушаалын тодорхойлолтын маягт”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас”, “Хяналтын хуудас”-ыг тус тус баталсан.

Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг дээрх журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал бүрээр батлах, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд албан тушаалын тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байхаар хуульчилсан. Үүний дагуу төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр батлан мөрдүүлж байна. Өнгөрсөн жилүүдэд төрийн захиргааны нийт албан хаагчид хамаарах 24589 албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцэж, томилох эрх бүхий албан тушаалтанд батлах зөвшөөрөл олгосон. Тухайлбал, 2022 онд 10 яам, 8 агентлаг, 22 нутгийн захиргааны, бусад 4 байгууллагын удирдах, гүйцэтгэх 1077 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, 861 албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж, 217 албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулан, Төрийн захиргааны албан тушаалын нийт 2155 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон байна. Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, хянах, батлах зөвшөөрөл олгох ажлыг бүрэн цахимжуулж, ашиглаж эхэллээ. Мөн Албан тушаалын тодорхойлолт нь төрийн байгууллагын бүтэц, орон тоонд хяналт тавих, төлөвлөлт, тайлагналтын цахим тогтолцоог бүрдүүлэх суурь болохтул төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалын тодорхойлолт, түүнийг баталгаажуулах процессыг журамд заасны дагуу бүрэн цахимжуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.3-1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох зохицуулалтыг бий болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшнийг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж, дүгнэх талаар тусгасан ба “Төрийн жинхэнэ

албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журам”-ыг Засгийн газар батлахаар хуульчилсан. Үүний дагуу Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, мөн оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлж байсан бол 2020 онд “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ыг тус тус шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2020 оны 217, 218 тогтоолоор баталсан. Мөн журмын хэрэгжилтийг хангахаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар стратеги болон байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлж, уг асуудлаар бүх шатны төрийн байгууллагад цахим орчинд /cabinet.gov.mn, igovernment.mn/ чиглэл өгч, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, гүйцэтгэлийн мөнгөн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг тус тус баримталж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.4-1.Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн нөлөөллөөс ангид томилох, чөлөөлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус зохицуулсан.

Мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус төрийн албыг бэхжүүлэхтэй холбогдсон зарчмын нэг бол Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийн сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албаны тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.” гэж заасан явдал юм. Энэ тохиолдол буюу дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д заасныг зөрчсөн тохиолдолд улс төрийн албан тушаалтныг огцруулах үндэслэл болохоор хуульчилсан.

Мөн төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульчилж, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн баталж, хэн нэгэн хүнд тохируулан дураар өөрчлөх боломжгүй болсон нь төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх ажлыг хүний хүчин зүйлийн нөлөөллөөс ангид явуулах нэг нөхцөл болсон.

Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг

томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус тогтоосон бөгөөд иргэнийг төрийн албанд томилох, чөлөөлөхдөө хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан.

Мөн хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгохоор заасан.

Төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульчилж, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн батлах, хэн нэгэн хүнд тохируулан дураараа өөрчлөх боломжгүй болсон зэрэг зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг тусгасан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-аар албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг чадахуйн зарчимд үндэслэн шатлан дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.5-1. Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах /АТГ, 2017-2022/

АТГ авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны а/185 дугаар тушаалаар Авлигын эрсдэлийн үнэлгээний

аргачлал20-ыг батлан 2019 оны А/40 тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна. Уг аргачлалын дагуу 2018-2022 онд 11 яам, 27 агентлаг, 18 ТӨҮГ, 1 ЗДТГ, 3 Засгийн газрын тусгай сан, нийт 60 байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй, үүсгэж болзошгүй шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох зорилготой эрсдэлийн үнэлгээг төрийн бус байгууллагуудаар хийлгүүлсэн. Үнэлгээний үр дүнг тухайн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлсон. Тухайлбал, 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлагт, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар 15 байгууллагад, 2020 онд Шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагддаггүй, хамрагдаж байгаа ч нарийвчлан үнэлгээ хийх шаардлагатай агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумын ЗДТГ зэрэг 9 байгууллагад, 2021 онд Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сан, Замын Үүд дэх гаалийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар зэрэг 14 байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ зохион байгуулж, үр дүнг тухайн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлж ажилласан. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын бүтэц, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт, төсөв санхүү, шийдвэр гаргах үйл явц, ил тод байдал, мэдээллийн хүртээмж, ёс зүйн шударга байдлын түвшин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, авлигын эсрэг бодлого, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт тодорхой эрсдэл байна гэж дүгнэсэн.

20 https://cdn.greensoft.mn/uploads/site/1152/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/atg_argachlal_2019.pdf

- Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой байгууллагын ажилчдын хөдөлмөрлөх эрхэд халдсан шийдвэр гаргах, төрийн албан хаагчийг орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам тодорхой бус, төрийн байгууллагад “орон сууцны зориулалтаар” газар эзэмшүүлсэн, газар эзэмших эрхийг холбогдох хууль тогтоомж зөрчин иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагаас болон улс төрийн зүй бус нөлөөлөл их байдаг, хууль бус шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуулиас давсан журам үйлчилж буй байдал;
- Төсөв санхүү, худалдан авалттай холбоотой худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг олон давтамжтай ажиллуулах мөн үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн;
- Тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэцтэй холбоотой эрх зүйн байдлын хувьд хууль зүйн зөрчилтэй нөхцөл байдал үүсэх;
- Авлигын эсрэг бодлого болон удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлтэй холбоотой авлигын эсрэг бодлого, төлөвлөгөөг батлаагүй, үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл дутмаг, хангалтгүй;
- Ил тод байдалтай холбоотой байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй, шалгуур үзүүлэлтэд нийцээгүй;
- Ёс зүй, шударга байдлын түвшинтэй холбоотой ёс зүй хяналт хариуцлагын тогтолцоо сул, тогтворгүй байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-аас хүргүүлсэн Зөвлөмжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор АТГ-ын ажлын баг 2017 онд 21 аймагт

Зудаа, давхардсан тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд, 2019, 2022 онд 21 аймгийн төвийн 21 сумдад ажилласан.

Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна дүгнэлтэд хүрсэн болно. Иймд авлигын түвшнийг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн нөхцөл байдлын талаар танилцуулж, Засгийн газарт “Зөвлөмж” хүргүүлсэн. Мөн Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдал талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2020-2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Бүртгэл хяналтын төв, Авто тээврийн үндэсний төв, Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын алба, Налайх, Багануур дүүрэг, Баян-Өлгий, Дорнод аймаг, Төв аймгийн Заамар сум, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэг зэрэг 23 байгууллагад тус

тус ажилласан байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны батлан гаргасан дүрэм, журам, шийдвэрт авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал үүсгэх эрсдэл байгаа эсэхийг судалж, өөрчлөх, хүчингүй болгуулах зорилгоор 2018 онд 98, 2019 онд 43, 2020 онд 18, 2021 онд 18, 2022 онд 42 дүрэм, журам, шийдвэрийг хянан үзэж, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж 15 дүрэм, журмыг хүчингүй болгуулсан байна.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 91 журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авлаа. Тухайлбал, энэ ажлын хүрээнд Баянхонгор аймгийн 5, Говь-Алтай аймгийн 3, Завхан аймгийн 2, Өвөрхангай аймгийн 11, Өмнөговь аймгийн 3, Дундговь аймгийн 7, Увс аймгийн 5, Баян-Өлгий аймгийн 13, Хэнтий аймгийн 6, Дорнод аймгийн 9, Сүхбаатар аймгийн 4, Булган аймгийн 7, Орхон аймгийн 5, Дархан-Уул аймгийн 8, Ховд аймгийн 10 шийдвэрийг тус тус хянан үзсэн байна.

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8, 2019 онд 42, 2020 онд 83, 2021 онд 40, 2022 онд 53 байгууллагад хүргүүлсэн АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр газар дээр нь болон цахим хэлбэрээр ажиллахад мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд ирүүлээгүй, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй хэлбэрийн төдий байгаа зэрэг нийтлэг дутагдал илэрсэн бөгөөд төрийн байгууллагууд Авлигын эсрэг хуулийн 6.1.12-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ

авах” нийтлэг үүргийн хэрэгжилт хангалтгүй байв.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил, дутагдал гаргасан, хүнд суртал, чирэгдэл үүссэн, албан тушаалтны ёс, хариуцлага алдсан, авлига үүсэх үүсэх нөхцөл байдал бий болсон байж болзошгүй тохиолдол бүрийг анхааралтай авч үзэж Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу 2018 онд 3, 2019 онд 14, 2020 онд 15, 2021 онд 10, 2022 онд 47 удаагийн зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг тухай бүр үнэлэн, санал, дүгнэлт гаргаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

АТГ-аас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

АТГ-аас 2020 онд Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Бүртгэл хяналтын төв, Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн Заамар суманд хүрч ажиллан, Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн биелэлттэй танилцах, шалган туслах, зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх, түүний хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг гүйцэтгэв. Тухайлбал, Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулсан “Авто тээврийн улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй авлигын эрсдэл” сэдэвт уулзалтыг зохион байгуулж, зөвлөмж өгөв. Зөвлөмжийн хүрээнд импортоор орж ирж буй авто тээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төлбөрийг давхардуулан тогтоосноор жилд дунджаар 30 орчим тэрбум төгрөг иргэд, аж ахуйн нэгж төлөх байсныг илрүүлэн таслан зогсоож, Автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөр авто машинд шилжүүлэх

үйл ажиллагаанд хяналт тавин ажиллав. Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын албаны үйл ажиллагаанд дахь авлига, ашиг сонирхлын зөрчил гарах шалтгаан, нөхцөл, үйлчилгээний хүнд суртлыг тогтоох чиглэлээр Дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба болон Газрын алба, дүүргийн Мэргэжлийн Хяналтын хэлтэс, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газарт тус тус ажиллан, газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох чиглэлээр холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэв. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ажиллаж, АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээсэн нийтлэг үүргийн биелэлттэй танилцаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, тус яамнаас олгодог зарим төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын 19 төрлийн эрхийн гэрчилгээ олгоход баримталдаг хууль тогтоомж, дүрэм журам, Засгийн газрын тусгай сан болох Байгаль орчин, уур амьсгалын сангийн үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн захиран зарцуулалтын байдал, тус яамны харьяа “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ, “Монгол Ус” ТӨҮГ, “Монгол кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТУҮГ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний биелэлтийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

Эрүүл мэндийн салбарын авлигын эрсдэлийг тогтоож, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дүн шинжилгээ хийн, түүнд тулгуурласан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын

хууль тогтоомжийн судалгааг эхлүүлж, нийт 21 хуулийг хянан үзэж, батлан хэрэгжүүлж буй дүрэм, журам, зааврын жагсаалтыг гарган, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эсэхийг шүүн нягтлав. Тус салбарт 2018-2020 оны хооронд гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн, тус салбарт хийгдсэн аудитын байгууллагын дүгнэлттэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж байна. Эрүүл мэндийн салбарын авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал чирэгдлийг таслан зогсоох, эмч, эмнэлгийн мэргэжилтний давхар ажил эрхлэлтийн байдлыг судлан тогтоох зорилгоор Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг гуравдугаар шатлалын хоёр эмнэлэгт давхар ажил эрхэлж буй эмч нарын судалгааг гаргуулан авч, дүн шинжилгээ хийлээ. Судалгаанд 2501 эмнэлгийн ажилтныг хамруулснаас 28 эмч, ажилтан давхар ажил эрхэлдэг нь тогтоогдсон. Аймгуудын нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан мэдээллээ shilendans.gov.mn сайтад байршуулсан байдал, тус байгууллагууд цахим хуудастай эсэх, цахим хуудсандаа шилэн дансны мэдээллээ байршуулсан эсэх эрүүл мэндийн салбарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх тоон мэдээлэл, судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийсэн. Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ашигт малтмалын олборлолт явуулж байгааг таслан зогсоох чиглэлээр Төв аймгийн Заамар суманд ажлын хэсэг ажиллаж, илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулав. АТГ-аас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон нэр бүхий аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилттэй танилцаж, авлигын эрсдэл, нөхцөл байдлыг тодорхойлон илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авсан. “Хүнд суртлын мэдээлэл”-ийн мөрөөр Нийслэлийн захирагчийн ажлын албаны харьяа Хог хаягдал, удирдлагын хэлтэст ажиллаж, хог, хаягдал, золбин нохой, муур устгал, сэг зэмийг зайлуулах ажилд зориулсан төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны процесс, хяналт тавьж буй

байдалтай танилцаж, холбогдох мэдээллийг гаргуулан авч, дүн шинжилгээ хийж байна. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Газрын алба, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Ашигт малтмал, газрын тосны газраас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үйл ажиллагааны зохион байгуулалтад тандалт, ажиглалт хийж, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй фокус ярилцлага өрнүүлэн, нөхцөл байдлыг тогтоон, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулж ажилласан.

Төрөөс хэрэгжүүлж байгаа цаг үеийн шинжтэй асуудал, хорио цээрийн дэглэм, онцгой нөхцөл байдлын үед авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эрсдэлээс сэргийлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын онцгой комисс, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Халдварт өвчин судлалын үндэсний төвд зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмжөөр Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд “Ковид-19” вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Эрүүл мэндийн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудад сайн дурын үндсэн дээр бэлэн мөнгө болон эд материал хандивлах, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх зэрэг хэлбэрээр дэмжиж байгаатай холбогдуулан хандивын бүртгэл, ил тод байдлыг хангуулах, Нийтийн албанд өгсөн сайн дурын хандивыг хүлээн авах, захиран зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх, орлого, зарцуулалтын талаар иргэд, олон нийт нээлттэй мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийн тайлан гаргах, хууль тогтоомж зөрчиж авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллахыг зөвлөсөн.

Түүнчлэн АТГ-аас байгалийн аюулт үзэгдэл, осол, гоц халдварт өвчин зэрэг гамшгийн

нөхцөл байдлын үед хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс хандив, тусламж хүлээн авахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг чанд мөрдөх, хандив, тусламж, түүний зарцуулалтыг ил тод, нээлттэй мэдээлэх чиглэлээр харьяа байгууллагуудын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Нийслэлийн засаг дарга нарт мэдэгдсэн.

Төрийн байгууллагуудад хяналт шалгалтаар ажиллах явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд Монгол Улсын Ерөнхий сайд болон 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нар, Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчид, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Орон сууц, нийтийн аж ахуйн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг 20 байгууллагад 111 асуудал бүхий Зөвлөмж хүргүүлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газарт авлигын эрсдэл үүсэж болох нөхцөл байдлыг судлан үзэж, эрсдэлийг таслан зогсоох чиглэлээр холбогдох зөвлөмжийг хүргүүлэв. АТГ-ын иргэд, олон нийтээс гомдол мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсаар иргэдэд үйлчилгээ үзүүлж буй улсын бүртгэгчид иргэдтэй зүй бус харьцдаг, ёс зүйн зөрчил гаргаж байгаа талаар мэдээлэл удаа дараа ирсэн ба энэхүү ёс зүйн зөрчил үүсэх боломжийг бүрдүүлсэн гол шалтгаан нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас ийм төрлийн зөрчилд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, салбарын хэмжээнд ёс зүйн зөрчилд холбогдох арга хэмжээг тухай бүрд нь авдаггүй, хяналт шалгалтын холбогдох нэгжийг ажиллуулдаггүй ба энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах талаар зөвлөн тусалж ажиллав. Сонгинохайрхан дүүргийн зарим хороодод хүнд суртлын мэдээллийн мөрөөр ажиллаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр тус дүүргийн Засаг

даргын Тамгын газарт 5 асуудал бүхий, АТГ-ын ажлын хэсэг автомашины улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаатай танилцаж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг тогтоож, хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдад 5 асуудал бүхий, АТГ-ын иргэд, байгууллагаас гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсанд ирүүлсэн гомдлын мөрөөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт, мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт (8 асуудал бүхий), Налайх дүүргийн цагдаагийн хэлтэст(-3 асуудал бүхий), Чингэлтэй дүүргийн цагдаагийн газарт(6 асуудал бүхий), Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт(5 асуудал бүхий), Төв аймгийн Сэргэлэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт (7 асуудал бүхий), Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1 болон 3 дугаар хэлтэст(5 асуудал бүхий) зөвлөмжийг тус тус хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг тооцох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэх, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, чадавхжуулах, цахимжуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав.

Төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээний дундаж 2021 онд 72.9 байсан бол 2022 онд 73.9 оноотой гарч 1.0 пунктээр өссөн байна.

2021 онд Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

- “Их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Монгол улсын Ерөнхий сайдад;

- Дорнод аймгийн албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээнд үндэслэн ил тод байдлыг хангах талаар тус аймгийн Засаг даргын Тамгын газарт;
- Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад;
- Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад;
- Авлигын гэмт хэрэг үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдад;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад;
- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, мөрдөгчийн мэдэгдлийн гүйцэтгэлийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газарт тус тус зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Амгалан амаржих газар, Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнд ажиллаж төрийн байгууллагын 3 үйлчилгээ авахад үүсч буй хүнд суртал, чирэгдлийн тухай нэгтгэн үнэлэлт, дүгнэлт хийж, байгууллагын авлигын эсрэг хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийв. Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр гүйцэтгэсэн ажил, арга хэмжээтэй танилцаж, дүн шинжилгээ хийх, зарим зөрчлийг газар дээр нь арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтран ажиллах

төлөвлөгөө боловсруулах зэрэг арга хэмжээг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн харьяа байгууллагууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Баян-Өлгий, Дорнод аймаг, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Зам, тээвэр хөгжлийн яам, Улсын нэгдүгээртөв эмнэлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт авч хэрэгжүүлэв. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-1. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлах, дүн шинжилгээ хийх, төрийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлуулах /ТАЗ, 2017-2019/

2018 онд Удирдлагын академийн судалгааны баг Төрийн албаны үнэт зүйлс: “Тулгамдаж буй асуудлууд” судалгааг гүйцэтгэж, тайланг олон нийтийн хүртээл болгосон. 2021 онд “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ” судалгааг мөн Удирдлагын академийн баг гүйцэтгэж, үр дүнг холбогдох байгууллагын төлөөллийг хамруулан хэлэлцүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн захиалгаар төрийн албаны ёс зүйн талаарх эрх зүйн зохицуулалтын судалгааг Удирдлагын академийн баг гүйцэтгэж байна.

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталж, байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд 2019 оны 122 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний нэгдсэн зохицуулалтыг боловсронгуй болгох, нийтлэг хэм хэмжээг тогтоож зохицуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс санаачлан боловсруулж, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-2. Үлгэрчилсэн дүрмийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг салбар бүрээр батлуулах /ТАЗ, ЗГХЭГ, УИХТГ 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Энэ хуулийн 10.1.1, 10.1.3- т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.”²¹, мөн зүйлийн 40.2-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”²² гэж тус тус заасан.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө АТГ-аас санал авах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд АТГ-аас 2017-2022 онд 33 байгууллагын ёс зүйн дүрмийн төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.

Төрийн улс төрийн албан тушаалтны хувьд УИХ-ын 2021 оны 105 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Тус дүрэмд УИХ-ын гишүүний ёс зүй, сахилгын асуудал, чуулганы хуралдааны дэг сахиулах, гишүүний хөрөнгө орлогын мэдүүлэг, гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, нэгдсэн хуралдааны ирцийн асуудал, гишүүний ёс зүйн асуудлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, УИХ-ын гишүүн нь ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд ёс зүйн хариуцлага ногдуулах зэрэг асуудлыг илүү нарийвчлан зохицуулснаараа ач холбогдолтой болсон.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.5-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд ёс зүйн дүрмийг Хурал батална.” гэж заасны дагуу зарим иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ёс зүйн

21 Төрийн улс төрийн болон төрийн тусгай албан тушаал

22 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаал

дүрмээ баталсан.

Харин бусад төрийн улс төрийн албан тушаалтны хувьд Засгийн газрын гишүүд, зөвлөх, туслах, бүх шатны Засаг дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалтнуудын хувьд үйлчлэх ёс зүйн дүрэм тусгайлан батлагдаагүй байна.

Төрийн тусгай албан тушаалтны хувьд ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоохоор хуульчилсан ба өнөөдрийг хүртэлх хугацаанд хуулиар буюу Улсын Их Хурлын тогтоолоор баталсан төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн дүрэм байхгүй, төрийн тусгай чиг үүргийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаандаа баримталдаг салбарын хуулиудад нь ёс зүрмийг батлахыг тодорхой субъектэд эрх олгох байдлаар зохицуулсан байна. Энэ хүрээнд төрийн тусгай албан хаагчдын эрх зүйн байдлыг тодорхойлсон 14 хуульд тухайн салбарын албан хаагчид тусгайлсан ёс зүйн дүрэмтэй байхаар заасны дагуу ёс зүйн дүрмээ батлан мөрдүүлж байна.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2-т “төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Төрийн албан тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр төрийн албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн дүрэм бус төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм мөрдөгдөж эхэлсэн ба төрийн бусад байгууллага өөрийн онцлогт тохируулан ёс зүйн дүрэм батлах нь нээлттэй байгаа болно. Энэ хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний 31 байгууллага албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлжээ.

Тухайлбал, Прокурорын тухай хууль/ Шинэчилсэн найруулга/-ийн 65 дугаар зүйлийн 65.2-т “Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.” гэж заасан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны

12 дугаар сарын 27-ны өдрийн 268 дугаар зарлигаар Прокурорын ёс зүйн дүрмийг баталсан нь хүчин төгөлдөр үйлчилж байна.

Харин Шүүгчийн ёс зүйн дүрмийн тухайд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан байх ба уг дүрмийг батлах эрхийг олгосон зохицуулалттай Шүүхийн захиргааны тухай хууль нь 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Монгол Улсын Шүүхийн тухай хууль(шинэчилсэн найруулга) баталсантай холбогдуулан тус хуулийг хүчингүй болсонд тооцсон.

Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Энэ хуулийн 81.1-д заасан цагдаагийн алба хаагчийн ёс зүй, сахилгын дүрмийг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 281 дүгээр зүйлийн 281.2-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийг тус тус батлан мөрдүүлж байна. Түүнчлэн 2019 онд Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 байгууллага салбарын ёс зүйн дүрмийг баталсан байна.

“Төрийн захиргааны болон үйлчилгээний албанхаагчдын ёс зүйн дүрэм”-ийн 6.1-д “Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллана” гэсний дагуу бүх төрийн байгууллагуудад ёс

зүйн зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа нь хэвшсэн. Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний загварыг хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна. Улсын Их Хурал, Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канад Улсын Элчин сайдын яам хамтран “Итгэл даах төрийн албаны төлөө” уриатай зөвлөгөөнийг 2020 онд зохион байгуулж “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын төслийг хэлэлцүүлэн, саналыг авч тусган баталсан. (Биелэлт 70 хувь)

4.1.1.6-3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах /ТАЗ, 2017-2022/

2018 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар АНУ-ын Азийн сантай хамтран нийслэлийн хэмжээн дэх төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээлэл, зөрчлийн агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлсэн.

Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.1.2- т заасан хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд буюу 3.1.2.г-д зааснаар “төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих”, 3.1.5-д заасан мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд буюу 3.1.5.в-д зааснаар “ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах” чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сахилга, хариуцлагыг сайжруулах, ажлын байрны дарамтгүй орчин бүрдүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаар зөвлөмжийг төрийн байгууллагын удирдах албан тушаалтан болон нийт төрийн албан хаагчдад хүргүүлж ажиллалаа. Зөвлөмжид төрийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг баримтлах, иргэдийн өргөдөл гомдол, санал

хүсэлтийг үндэслэлтэй шийдвэрлэх, төрийн үйлчилгээг аливаа хэлбэрийн ялгаварлал гадуурхалгүй адил тэгш хүргэх, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан нь хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавих, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг сайжруулах гэсэн агуулга туссан байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 1422 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан бөгөөд үүнээс төрийн тусгай 809 албан хаагч, төрийн захиргааны 353 албан хаагч, төрийн үйлчилгээний 260 албан хаагч тус тус хамаарч байгаа бөгөөд 2019 оны ёс зүйн зөрчилтэй харьцуулахад 24 нэгж буюу 4.8 хувиар буурсан байна. Төрийн тусгай албан хаагчаас бусад албан хаагчдын ёс зүйн зөрчлийг шалгасан үндэслэлийг авч үзвэл, байгууллагын дотоод хяналтаар 328, иргэдийн гомдлоор 209, мэдээллээр 50, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн 26 мэдээллээр тус тус ёс зүйн зөрчлийг шалгасан байна.

2021 онд төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлүүд нийт 1,591 ёс зүйн зөрчил шийдвэрлэснээс 475 албан хаагчид уучлал гуйхыг үүрэг болгож, 1,050 албан хаагчид сануулах шийтгэл ногдуулж, 11 албан хаагч сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөж, 55 албан хаагчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцсон. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг гомдлоор 945, мэдээллээр 240, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 15, олон нийтийн сүлжээгээр 22, байгууллагын дотоод хяналтаар 895-ыг тус тус илрүүлсэн байна.

2022 онд төрийн 415 албан хаагч ёс зүйн зөрчил гаргаснаас төрийн захиргааны албан тушаалтан 221, төрийн үйлчилгээний албан тушаалтан 194 байна. Ёс зүйн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн болон ажлын хариуцлага алдсан 19, албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архи дан согтуурсан 153, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй 25, ажлын цаг ашиглалтын 57, харилцаа, хандлагын 158, бусад буюу нууц задруулах, захирах захирагдах ёсыг зөрчих, албаны нэр барих, байгууллагын эд хөрөнгийг

хувийн зорилгоор ашигласан зэрэг 3 зөрчил тус тус гаргасан байна.

2022 онд төрийн 2,961 байгууллагын дэргэд төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл ажилласан. Ёс зүйн зөрчлийг шалгаж төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад зохих хариуцлага ногдуулсны 225 нь сануулах, 149 нь уучлал гуйхыг үүрэг болгосон хариуцлага хүлээлгэж, 11 тохиолдлыг ёс зүйн хариуцлага тооцох үндэслэлгүй гэж үзсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийн уялдааг сайжруулах, нэгдсэн зохицуулалттай болгох зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс байгуулагдсан ажлын хэсэг төрийн 668 байгууллагаас санал авч нэгтгэн, Улсын Их Хурлын даргын 2021 оны 25 дугаар захирамжаар байгуулагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн, сахилгын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлжээ.

2021 онд “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ” судалгааг Удирдлагын академийн баг гүйцэтгэж үр дүн, тайланг олон нийтэд хүргэсэн байна.

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын модулийг хөгжүүлж, нэвтрүүлж, төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн болон ажлын төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийг бүртгэх ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр ёс зүйн зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт, ёс зүйн зөрчил хүлээсэн албан хаагчдын талаар нэгдсэн мэдээллийн сантай болж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг судалгаанд суурилан явуулах нөхцөл бүрдэж байна.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн бүртгэлээс сахилгын зөрчил болон гэмт хэрэгт холбогдсон байдлыг авч үзэхэд гэмт хэрэг үйлдсэн нь

нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноор 79, Төрийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр 1809, 3 ба түүнээс дээш удаа албан үүргээ хангалтгүй биелүүлсэн шалтгаанаар 417, сахилгын шийтгэлээр 92, хөдөлмөрийн гэрээ, дотоод журам зөрчсөн үндэслэлээр 4219, бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр 681, нийт 7296 албан хаагч төрийн албанаас халагдсан байна. “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд шүүхээр ял шийтгүүлсэн төрийн албан хаагч болон шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн иргэдийг “Хар жагсаалт”-д бүртгэн хөтөлж байна. 2022 оны дүн мэдээнээс харахад 2019-2022 онд Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан нийт 579 этгээд санд бүртгэгдсэнээс 227 нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон байна. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан (Биелэлт 100 хувь)

4.1.1.7-1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх /АТГ, ТАЗ, 2017-2019/

Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, <https://iaac.mn/> цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос болон тусгай дугаарын утсаар хүлээн авах, мөн АТГ-ын байранд биечлэн ирж өгөх боломжийг бүрдүүлсэн. АТГ нь өргөдөл, гомдол, мэдээллийг 2007 оноос 1969, 2014-2019 онд 1800-1969 хүлээн авч байсан бол 2019 оноос 110 тусгай дугаарын утсыг ажиллуулж байна.

110 тусгай дугаарын утсанд 2019 онд 4,464, 2020 онд 17,851, 2021 онд 13,474, 2022 онд 10,858, нийт 46,647 дуудлага ирсэн байна. Гомдол, мэдээлэл хүлээн авах утасны програмд 2020 онд 317, 2021 онд 285, 2022 онд 553, нийт 1,155

гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна.

Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг e-Mongolia системд байршуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хүрээнд e-Mongolia платформ дээр contact@iaac.mn хаягт хандан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах тусгайлсан талбар үүсгэсэн.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг АТГ-ын 110 тусгай дугаарт шууд шилжүүлэн холбох ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан.

АТГ-ын гомдол, мэдээллийн програмыг шинэчлэх ажлыг зохион байгуулж програмын болон гэрээний маягтуудыг Үндэсний статистикийн хорооны хурлаар батлуулан, ашиглаж байна. Ингэснээр гомдол, мэдээллийг шалгах хугацаа, явц байдал, шийдвэрлэлтэд нэгжийн дарга тухай бүр хяналт тавих, байгууллагын дотоод хяналтыг давхар хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам”-ыг АТГ-ын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Энэхүү журмын хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудсанд “Сахилгын шийтгэл” (https://iaac.mn/posts?category_id=13809&page=1) цэсийг шинээр нээн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтны талаарх мэдээллийг байршуулж байна.

АТГ бусад орны сайн туршлагыг судалж, авлигын талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг иргэдэд ойртуулах зорилгоор Иргэний хяналтын төвүүдийг нээн ажиллуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.8-1. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, ШЕЗ, УЕПГ, 2018-2019/

Төрийн албаны тухай хуульд иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж төрийн албаны төв байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргахаар тус тус хуульчилсан.

Мөн Төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд тавих хяналтыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйл, Төрийн аудитын хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу захиргааны байгууллага хохирлоо барагдуулах зохицуулалттай уялдуулан эдгээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй актыг ойлгох тухай болон 47 дугаар зүйлийн 47.1-д захиргааны акт илт хууль бус болох, 48 дугаар зүйлд сөрөг нөлөөлөл бүхий болон хууль бус захиргааны актыг хүчингүй болгох, 55 дугаар зүйлд захиргааны гэрээ илт хууль бус болох тохиолдол, 98 дугаар зүйлд захиргааны актыг хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх, бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, өөрчлөх, мөн хуулийн аравдугаар бүлэг (100-104 дүгээр зүйл)-т хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирол арилгахыг шаардах эрх, хохирол барагдуулах этгээд, хохиролтой холбоотой маргаан шийдвэрлэх, хохирол барагдуулах, нөхөн олговор, түүний хэмжээг тогтоох, арваннэгдүгээр бүлэг (105-107 дугаар зүйл)-т хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсэн тухай маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг зохицуулж, 76 дугаар зүйлд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, мөн хуулийн 76 дугаар зүйлийн 76.4-т “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.” гэж, 76 дугаар зүйлийн 76.5-д “эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.” гэж, түүнчлэн тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах зохицуулалтыг тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Прокурорын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн

байгууллагын хүсэлтээр "...төрийн нэрийн өмнөөс оролцоно." гэсэн заалтын дагуу төрийг төлөөлж прокуророор оролцсон тохиолдолд ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлд заасны дагуу иргэд мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас өөрт учирсан эдийн болон эдийн бус гэм хорын хохирлоо төр(Засгийн газар)-өөс нэхэмжилж байна.

2019 онд АТГ, Үндэсний аудитын газар хамтран Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, "Онч шийдэл" ТББ, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн албан хаагчид, холбогдох яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагуудыг оролцуулан "Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, төрийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвийг хэлэлцэж зөвлөмж гаргасан.

Нийслэлийн прокурорын газраас 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр "Авлигаас урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал" сэдэвт онол, практикийн бага хурлыг зохион байгуулж, авлигын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулан, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн иргэн эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг Төрийн албаны зөвлөл эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг.

Төрийн албаны зөвлөлөөс ЗГХЭГ-тай

хамтарсан ажлын хэсэг байгуулж, 2021 оны 10, 11 дүгээр сард 10 аймагт ажиллаж, төрийн 350 гаруй байгууллагын 4,606 албан хаагчийг хамруулан төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, томилгооны байдалд хяналт шалгалт хийж, улмаар томилгоотой холбогдсон 95 шийдвэрийг хүчингүй болгосон. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож, нийтийн албанд ажиллах эрх хасуулах шийтгэл хүлээсэн 91 иргэнийг төрийн албанаас чөлөөлүүлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс 2020 онд төрд бодит хохирол учруулсан илтэд хууль бус тушаалыг илрүүлж, 4.5 орчим сая төгрөгийг хууль бус шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлж, төрийн сангийн дансанд шилжүүлсэн байна. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 04/993 дугаар албан бичгээр төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай шаардлага хүргүүлсний дагуу төрд учруулсан хохирол болох 2,055,699 төгрөгийг нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн. Төрд учирсан нийт 221,696,774 төгрөгийг нөхөн төлүүлэх шаардлагыг хууль бус шийдвэр гаргасан 20 иргэнд хүргүүлж, төрд учирсан 215,096,774 төгрөгийг нөхөн төлүүлэх 19 нэхэмжлэлийг Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан. 2022 онд төрд хохирол учруулсан хууль бус шийдвэр гаргасан 27 албан тушаалтанд холбогдох 303 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагыг хүргүүлж, уг шаардлагыг биелүүлээгүй 7 албан тушаалтанд холбогдох 107 сая төгрөгийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг харьяаллын дагуу нийслэл болон орон нутгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. Иргэний хэргийн шүүхээр 13 хэрэг эцэслэн хянан шийдвэрлэгдэж, төрд учруулсан 145.7 сая төгрөгийн хохирлыг хууль бус шийдвэр гаргаж, төрд хохирол учруулсан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагаас гадна Төрийн албаны зөвлөл болон шүүхийн шийдвэрийн дагуу 39.5 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Шүүхийн шийдвэрээр буруутай нь тогтоогдсон

төрд хохирол учруулсан 7 албан тушаалтанд холбогдох 102.2 сая төгрөгийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаад байна.

2019-2021 онд гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн хүний нөөцийн томилгоотой холбоотой шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэлийг хөтлөн ажиллав. (Биелэлт 100 хувь)

4.1.1.8-2. Хууль бус шийдвэр гаргаж, улсад хохирол учруулсныг шүүх тогтоосон тохиолдолд албан тушаалтныг нийтийн албанд дахин томилохгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх /ЗГХЭГ, ХЗДХЯ. ТАЗ, АТГ, ШЕЗ, УЕПГ, УАГ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтөйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулахаар тусгасан. Мөн хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т зааснаар тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.” зэрэг шийтгэл оногдуулахаар заасан.

Мөн эрх зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд дээрх хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т заасан шийтгэл оногдуулаагүй, эсхүл тохирсон шийтгэлийг оногдуулаагүй тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилсан ба “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.” шийтгэл ногдуулсан тохиолдолд дээрх хуулиас бусад хуулиар тогтоосон нөхцөл журам хэрэглэгдэхгүй болно.

Төрийн албаны тухай хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр

хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг “төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах” эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ.” гэж тусган, шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно, мөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулахаар хуульчилсан. Хуульд зааснаар шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.9-1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /ЗГХЭГ, ХХМТГ, 2017-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас дижитал шилжилтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд энэ хүрээнд “Төрийн

байгууллага хооронд албан бичиг солилцох суурь систем (www.docx.gov.mn)-ийг хөгжүүлж “Үндэсний дата төв” УТУГ-т хүлээлгэн өгсөн. Ингэснээр “ХУР” үйлчилгээний тоог нэгээр нэмэгдүүлж, төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн системүүдийг нэг үйлчилгээгээр холбох боломж бүрдсэн болно.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас эрхлэн “Төрийн байгууллагын дотоод удирдлагын систем”-ийг хөгжүүлэн 2020 оны 4 дүгээр сардашиглалтад оруулсан. Уг системийг 21 аймгийн төв, 330 суманд суурилуулсан “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн системээр дамжуулан төрийн бүх шатны байгууллага ашиглах боломжийг бүрдүүлсэн. Уг систем нь албан хэрэг хөтлөлтийн модулийг багтааж байгаа ба төрийн байгууллагын хооронд албан бичгийг цахим хэлбэрээр төлөвлөх, солилцох, бүртгэх, архивт шилжүүлэх боломжтой болсон.

Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журмын хэрэгжилтэд хийсэн дүгнэлт болон улсын хэмжээнд төрийн байгууллагууд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийн талаарх судалгаа хийж, цахим хэлбэрээр архив албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах программ хангамжийн нийтлэг шаардлагыг боловсруулж, Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ыг баталсан.

Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоол болон Засгийн газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай” 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Архивын ерөнхий газрын даргын 2020 оны 04 сарын 24-ний өдрийн А/52/А-47 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, төрийн байгууллагад нийтлэг ашиглаж байгаа цахим албан хэрэг хөтлөлтийн систем, түүний үйл ажиллагааг шалган туршсан.

Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын систем (erp.e-mongolia.

mn)-ийг 2020 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан ба 2022 оны 12 дугаар сарын байдлаар төрийн 2085 байгууллага холбогдож, нийт 32426 хэрэглэгч тус системээр дамжуулан байгууллага хооронд цахим хэлбэрээр албан бичиг солилцсон байна. Мөн тус системийн хүний нөөцийн цэсийг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системтэй холбох хөгжүүлэлтийг хийсэн. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийн ERP цахим харилцааны модуль/ ERP E-chat / нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтэрсэн бөгөөд андройд утасны 161 хэрэглэгч, ios 111 хэрэглэгч нийт 272 хэрэглэгч албан харилцаандаа хэрэглэж байна. Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын систем (digital office), мөн төрийн болон хувийн хэвшлийн ялгаатай 15 төрлийн дотоод удирдлагын систем (5,483 байгууллагын)-ийг албан бичиг солилцооны дундын систем (DocX)-тэй холбосон бөгөөд нийт 71,424 файл бүхий 51,421 бичгийг илгээж, 55,939 бичиг хүлээж авсан байна. Уг системд нийтийн түлхүүрийн дэд бүтцийн холболт хийгдэж тоон гарын үсгээр системд нэвтрэх (төрийн 14,249 албан хаагч тоон гарын үсэг авсан), тоон гарын үсгээр баталгаажуулсан баримт бичиг солилцох боломж бүрдсэн. (2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 508,129 хүн хуулийн этгээд тоон гарын үсэг авсан байна.)

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар дэмжих системийн төрлийг хуульчилсан бөгөөд Албан бичиг солилцооны дундын систем нь дэмжих систем юм. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар “Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг баталсан бөгөөд тушаалын 5 дугаар хавсралтад “Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг тусгасан болно. (Биелэлт 100 хувь)

4.1.1.9-2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний

платформоор дамжин хүрэх “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг 2017 онд ашиглалтад оруулсан. Уг системийн үйл ажиллагаа тогтмол өргөжсөөр 2022 оны байдлаар нийт 71 байгууллагын 578 сервисийг төрийн 110, хувийн хэвшлийн 276 байгууллага ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийт амжилттай дуудсан хандалтын тоо 974,788,359 байна.

Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолоор “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ыг батлуулж үндсэн системээр дамжуулан мэдээлэл солилцох, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах нөхцөл, журам, нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор, 12.6 дахь хэсэгт заасан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ыг Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор, 12.9 дэх хэсэгт заасан “Нээлттэй өгөгдлийн жагсаалтад тусгагдаагүй нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”-ыг Засгийн газрын 2022 оны 202 дугаар тогтоолоор тус тус батлуулсан. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын дагуу “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (www.opendata.gov.mn)”-д 56 байгууллагын 518 нээлттэй өгөгдлийн бүрдлийг байршуулсан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар Үндэсний дата төв нь төрийн мэдээллийн нэгдсэн сан буюу үндсэн мэдээллийн сангийн үйл ажиллагааг хариуцан ажиллахаар заасан ба тус төвөөс мэдээллийн сангийн хэвийн, тасалдалгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

“Төрийн байгууллага хооронд албан бичиг солилцох суурь систем”-ийн хүрээнд албан бичиг солилцооны нэгдсэн сүлжээ, дараах нэгдсэн мэдээллийн сан үүснэ. Үүнд:

1. Төрийн байгууллага хооронд солилцсон албан бичгийн нэгдсэн сан.

2. Төрийн байгууллагын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан.

3. Албан бичиг солилцооны түүх, хандалтын мэдээллийн нэгдсэн сан.

Дээрх мэдээллийн сангууд үүссэнээрээ төрийн байгууллага хооронд солилцсон албан бичгийн тухай статистик мэдээлэл гаргах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дүн шинжилгээ хийх, цаашид албан бичиг солилцооны цахим архив үүсэх боломж бүрдэх ач холбогдолтой юм. (Биелэлт 70)

4.1.1.10-1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллахаар заасан. Үүний дагуу Засгийн газрын 2018 оны “Удирдлагын академийн талааравах заримарга хэмжээний тухай” 366 дугаар тогтоолыг батлан, Удирдлагын академид 2019 оноос өмнө төрийн захиргаа, төрийн удирдлага болон бизнесийн удирдлагын чиглэлээр элсэн хувийн зардлаар суралцаж байгаа суралцагчдын сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн дуусгавар болгох арга хэмжээ авч, Засгийн газрын захиалгат сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байхаар шийдвэрлэсэн. Мөн тогтоолоор Удирдлагын академийн дүрмийг шинэчлэн баталсан ба тус байгууллага нь төрийн албан хаагчдын мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага юм. (Биелэлт 100 хувь)

4.1.1.10-2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах /АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасныг үндэслэн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын хэрэгцээг тодорхойлж, төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулан Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар, Төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар тус тус баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, Удирдлагын академи хамтран үе шаттай сургалт зохион байгуулсан.

АТГ авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулав. АТГ-аас 2019 онд нийт 40 сэдвээр, Удирдлагын Академи, Монгол Улсын Их Сургууль, Монголын Улсын Боловсролын Их Сургуулиудтай хамтран нийт 20 сэдвээр тус тус сургалтын модуль боловсруулан нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан байна. Мөн ТББ-уудтай хамтран иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль, ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль, сэтгүүлчид зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж сургалтыг үе шаттай зохион байгуулсан.

Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр 2019 онд “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг боловсруулсан бол 2020 онд Засгийн газар, аймаг, нийслэл, яам агентлаг зэрэг байгууллага албан тушаалтны үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой тохиолдол (кейс)-ын дүн шинжилгээнд суурилсан төрийн байгууллагын худалдан авах, санхүү, хууль эрх зүй, дотоод хяналт шалгалт, аудитын болон удирдах албан тушаалтанд зориулсан 5 төрлийн сургалтын 20 модуль, сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургалтад ашиглаж байна.

АТГ-аас 2017-2022 онд нийт 78 сургалтын хөтөлбөр, модуль, гарын авлагыг боловсруулж, сургалт зохион байгуулж хэвшсэн. Тухайлбал, авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулав. Мөн “Шударга ёс, хөгжил дэвшилд-Хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, хувийн хэвшлийн байгууллагуудад иж бүрэн сургалт зохион байгуулах боломжтой болсон.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны боловсрол олгох хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн болох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас эрхлэн хэвлүүлсэн “Шударга байдлын боловсрол” гарын авлагыг орчуулан түгээн сургалтад ашиглаж байна.

Төрийн албаны зөвлөлөөс “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим

системд төрийн албан хаагчийн сургалтын модулийг нэмж хөгжүүлэн ашиглалтад нэвтрүүлж, цахим системийн сургалтын модулийг Удирдлагын академийн сургалтын системтэй интеграци хийж нэгтгэснээр төрийн захиргааны албан хаагчийн суралцах болзол, шаардлага хангаж байгаа болон суралцаж төгссөн үнэлгээ, түүнд зарцуулсан төсөв хөрөнгийг нэгтгэн хянах боломж нээгдэж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.10-3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2022/

АТГ нийтийн албан тушаалтнууд, зорилтот бүлэгт зориулсан авлигын эсрэг сургалтаас гадна иргэдэд мэдээлэл хүргэх, гомдол мэдээлэл хүлээн авах, гарын авлага, материал түгээх, дотоодын болон гадаадын хурал, зөвлөгөөн хэлэлцүүлгүүдийг тус байгууллагын Олон нийтийн төвд зохион байгуулж байсан бол цар тахлын улмаас сургалт хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр түлхүү зохион байгуулсан. АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулсан авлигын эсрэг сургалтад 2017 онд 11,345, 2018 онд 14,783, 2019 онд 25,007, 2020 онд 13,820, 2021 онд 134 удаагийн сургалтад 27,645, 2022 онд 53,183 нийт 145,783 этгээдийг хамруулсан.

Давтан сургалтын хүрээнд боловсруулсан 5 модуль хөтөлбөрийн дагуу "АТГ-Олон нийтийн төв"-ийн сургалтын танхимд удирдах болон хууль зүйн асуудал хариуцсан албан тушаалтнуудад зориулсан 5 удаагийн сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулсны зэрэгцээ төрийн улс төрийн албан тушаалтнуудад чиглэгдсэн сургалтыг төлөвлөгөө гарган УИХ-ын Тамгын газар, УИХ-ын гишүүд, зөвлөх, туслах болон аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгч нарт зориулсан сургалтыг 31 удаа зохион байгуулж, 8,419 тушаалтныг хамруулсан, мөн МАН-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу намын анхан шатны 80 гаруй гишүүдэд цахимаар авлига, ашиг сонирхлын зөрлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн ойлголт сэдвээр цахим сургалтыг тус тус зохион байгуулсан нь онцлог байв. 2021 уг онд авлигын эсрэг сургагч багш нарыг чадавхжуулж, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилт тавьснаар орон нутгаас бэлтгэгдсэн сургагч багш нар 4480 хүнд, "Шударга ёсны боловсрол" хөтөлбөрийн хүрээнд

ЕБС-ийн багш нар нийт 20,892 хүүхэд, 332 эцэг эхэд хүрч сургалт зохион байгуулсан. Сургалтын дараах судалгааг тогтмол авч, холбогдох мэдээг нийтэд мэдээлж хэвшсэн. Мөн сургалтыг салбар, мэргэжил тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулж байна.

Төрийн байгууллагууд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор холбогдох сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллагын захиалгаар иргэдэд зориулсан эрх зүйн сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд 15 удаагийн сургалтаар 481912 иргэнд мэдлэг олгож, үйл ажиллагаагаа сурталчилсан байна.

"Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр", "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөр"-т "Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл", "Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй" болон "Харилцааны соёл, ур чадвар" зэрэг сэдвээр төрийн албан хаагчдад сургалт явуулахаар тусган хэрэгжүүлж байна.

2019-2022 онд 22353 төрийн албан хаагчийг, үүнээс 5534 албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад, 3240 албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан сургалтад, 13579 албан хаагч чиглүүлэх болон богино хугацааны сургалтад тус тус хамруулсан байна.

2022 онд 9320 төрийн албан хаагч мэргэшүүлэх 6 төрлийн сургалтад хамрагдсанаас мэргэшүүлэх багц сургалтад 1141, чиглүүлэх болон богино дунд хугацааны сургалтад 8179 албан хаагч хамрагдсан байна. Чиглүүлэх болон богино хугацааны сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Төрийн албаны шинэтгэл, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар мэргэшил, арга зүйн зөвлөгөө, сургалт, үйлчилгээгээр хангах ажлыг төрийн байгууллагуудын захиалгаар "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөлтэй хамтран

хэрэгжүүлээ. Тухайлбал, Төрийн албаны үнэт зүйл, ёс зүй, манлайлал, Эмэгтэйчүүдийн манлайлал зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, 10 яам, 33 агентлаг, 4 аймгийн нийт 9371 төрийн албан хаагчийг хамруулсан. Төрийн албаны хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангахад учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулах арга зам болон хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийг тайлбарлан таниулах сургалтыг ТА3-өөс хийсэн хяналт шалгалтын явцад 58 байгууллага, 1012 албан хаагчид, аудит хийсэн 52 байгууллагын 1130 албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, дагалдан гарах журам болон холбогдох бусад асуудлаар сургалт зохион байгуулав. Төрийн албаны зөвлөл төрийн бүтээмж, төрийн албан хаагчдын ёс зүй, цогц ур чадварыг дээшлүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл түгээхэд чиглэсэн "7:4:10" арга зүйн цахим сургалтыг долоо хоног бүр уламжлал болгон зохион байгуулж 2022 онд 6 багц сэдвээр 32 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 92335 хэрэглэгчийн эрхээр 150 гаруй мянган албан хаагчийг хамруулсан.

Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг төрийн зарим байгууллагууд онцлог байдлаар зохион байгуулсан байна. Тухайлбал, нийслэлийн ЗДТГ Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй "Хотын засаглалыг сайжруулах" төслийн хүрээнд "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын сургалтын хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн агуулга" боловсруулан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрт тусгагдсан модуль сургалтуудыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Сургалтын төв"-ийг түшиглэн зохион байгуулав. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, хэрэгжүүлэгч 14 агентлагийн хүний нөөц хариуцсан ажилтнуудад зориулсан "Хувь хүнийг хөгжүүлэх нь" сэдэвт олон улсын сертификаттай сургалт; Герман-Монголын хамтарсан Афа академитэй хамтран "Төрийн албан хаагчийн хувь хүний хөгжил ба ёс зүй" сэдэвт сургалт; Ёс зүйн хорооны дарга,

гишүүдэд зориулсан сургалтыг; "Төрийн албаны тухай хуулийн зохицуулалт, төрийн албаны соёл, стандарт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ" сэдэвт сургалт; Дүүргийн хороодод шинээр томилогдсон хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хорооны зохион байгуулагч нарт зориулсан суурь сургалт, төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчдэд зориулсан сургалт; Төрийн жинхэнэ албан тушаалд анх удаа орж байгаа албан тушаалтнуудад ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг тус тус зохион байгуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.10-4 Бүс нутгийн хэмжээнд авлигын эсрэг сургалт, семинарыг зохион байгуулах /АТГ, ЗГХЭГ, 2020-2022/

Ази, Номхон далайн бүс нутагт эрүүгийн хэргийн асуудлаар байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох, гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг царцаах, буцаах чиг үүрэгтэй "АРИН-АП" хэмээх сүлжээг анх БНСУ-ын Прокурорын дээд газрын санаачилгаар 2013 онд бий болгожээ. Монгол Улсын хувьд Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний 2019 оны даргалагч улсаар ажилласан бөгөөд Монгол Улсын Авлигатай тэмцэх газар Даргалагч улсын эрх, үүргийг хэрэгжүүлж Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний 6 дугаар бүгд хурлыг удирдан зохион байгуулсан. Энэхүү бүгд хуралд 22 улс, олон улсын 5 байгууллага, дотоодын төрийн 7 байгууллагын нийт 110 орчим төлөөлөгч оролцов. Бүгд хурлын дараа АРИН-АП сүлжээний гишүүн улс орнуудын төлөөлөгчид харилцан туршлага нээлттэй хуваалцах, албан болон албан бус шугамаар мэдээлэл солилцох зөв зохистой арга замыг тогтоож, хууль бус хөрөнгийг буцаах чиглэлээр урт хугацаанд, үр дүнтэй, найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Нуугдмал хөрөнгө илрүүлэх: Гэмт хэрэг үйлдэх замаар олсон хөрөнгөөс ашиг хүртэх эцсийн өмчлөгчийг олж тогтоох нь" сэдэвт сургалтыг 2019 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо мөн зохион байгуулсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн авлигын эсрэг сүлжээ, Ази номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээ, ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR) зэрэг гадаад улсын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн сургалтад давхардсан тоогоор байгууллагын 307 албан хаагч, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, ШШГЕГ зэрэг бусад хууль сахиулах байгууллагын 701 албан хаагчийг хамруулсан. (Биелэлт 70 хувь)

Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дахь зорилтын хүрээнд нийт 7 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгагдсан.

4.1.2.1-1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ХХМТГ, Бүх шатны төрийн байгууллагууд. 2017-2018/

Цахим засаглалыг хөгжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-д 176 үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбохоор холбогдох яам, үйлчилгээний нэрээр нь баталсан бол “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний жагсаалт”-д 38 байгууллагын 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр тусгасан.

Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан.

УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу төрийн цахим үйлчилгээ, нийтийн мэдээллийн дэд бүтцийн цогц журмуудыг батлан мөрдүүлж байна.(Биелэлт 100 хувь)

4.1.2.1-2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” баталж, нийслэл, орон нутагт нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа нэг цонх жилд дунджаар 3150 удаа, өдөрт 13 удаа үйлчилгээ үзүүлж байсан.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээ” болон “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг «Үйлчилгээний нэгдсэн төв» болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад «Үйлчилгээний нэгдсэн төв» байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр болсон. Мөн уг тогтоолын хүрээнд «Үйлчилгээний нэгдсэн төв»-ийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбох асуудлыг шийдвэрлэжээ.

Энэ нь иргэд төрийн үйлчилгээ авахдаа олон цонх дамжиж байгаа шатлалыг арилгах,

давхардсан бүтэц үүсгэхгүй байх, орон нутагт төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх, үйлчлүүлэгч олон цонх дамждаг шатлалыг арилгаж, тухайн нэг цонхноос бүх үйлчилгээг авах бололцоог бүрдүүлэх, үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргах эрх бүхий албан хаагчид цахим хэлбэрээр дамжуулах, шийдвэрлэлтийн явцыг иргэнд мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шийдвэрлэлтийн явцын талаар нэгдсэн хяналт тавих боломжийг бий болгосон.

Уг тогтоол гарснаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Дүнжингарав, Мишээл, Драгон болон Оргил төв (4²³ цэг)-д болон 21 аймагт ажиллаж байсан Төрийн үйлчилгээний төвийн зохион байгуулалтыг Үйлчилгээний төв болгон өөрчлөн зохион байгуулж, Төрийн үйлчилгээний операторын www.operator.e-mongolia.mn системийг хөгжүүлж, 21 аймгийн төв болон 330 сум суурин газрын ЗДТГ-г нэвтрүүлсэн. Улмаар 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эдгээр төвүүд нь операторын горимоор төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 2.1. Төрийн үйлчилгээний цахим системээр үзүүлсэн үйлчилгээний тоо.

Он	Цахимаар үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын тоо	Цахим үйлчилгээний тоо
2020 он	23	181
2021 он	59	606
2022 он	69	897
2023 оны I улирал	71	979

Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хүрээнд 2020 онд 23 байгууллагын 181 үйлчилгээ, 2021 онд төрийн 59 байгууллагын 606 үйлчилгээ, 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээг И-Монголиа системээр үзүүлжээ. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс 2020 онд 111753, 2021 онд 187540, 2022 онд 186039 удаагийн үйлчилгээг иргэд авчээ. Эндээс үзэхэд цар тахлын үед тавигдсан хязгаарлалтын улмаас үйлчлүүлэгчдийн

тоо буурахад нөлөөлсөн нь харагдаж байна. Үйлчилгээний хандалт жил тутам нэмэгдэж байгаа нь төрийн үйлчилгээг авах иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэгдсэн төвүүдийг шинээр зохион байгуулж, үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өргөжүүлсэн, түүнчлэн иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж хэвшсэнтэй холбоотой.

23 2022 оны байдлаар эдгээр төвүүд дээр Баянгол, Баянхошуу дахь салбарууд нэмэгдэж, Нийслэлийн хэмжээнд 6 төв үйл ажиллагаа явуулж байна.

Цахим үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn порталаар дамжуулан цахим хэлбэрээр төлбөр төлөх, үйлчилгээний хүсэлтийн шийдвэрлэлтийг харах, хувь хүний өгөгдөлд хандсан тухай мэдээллийг иргэнд мэдээлэх, Чат бот ашиглан харилцах, өргөдөл гомдол гаргах, үндэсний цахим шуудангийн системтэй холболт хийж, нэвтрэхдээ арилжааны банкны эрх, бүртгэлтэй гар утасны дугаар болон тоон гарын үсгээр нэвтрэх боломжийг бүрдүүлэв.

Хүснэгт 2.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем²⁴-д шинээр холбосон байгууллага, үйлчилгээний тоо /өссөн дүнгээр/.

Он	Үйлчилгээ нь цахимжсан/ холбогдсон нийслэл дэх байгууллагын тоо	Тэдгээрийн шинээр хөгжүүлсэн/холбосон үйлчилгээний тоо	Үйлчилгээ нь цахимжсан/ холбогдсон орон нутаг дахь байгууллагын тоо	Тэдгээрийн шинээр холбогдсон үйлчилгээний тоо
2020	23	181	-	-
2021	59	606	5 аймаг	348
2022	71	806	21 аймаг	1288

2022 оны байдлаар Төрийн үйлчилгээний нэгдсэн системд нийслэл дэх 71 байгууллагын 806 үйлчилгээ холбож, нийт 21 аймгийн 1288 үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 2.3. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем²⁵-ээс үйлчилгээ авсан байдал.

Он	Нийслэлээс үйлчилгээ авсан хэрэглэгчид / давхардсан тоо/	Орон нутгаас үйлчилгээ авсан хэрэглэгчид /давхардсан тоо/
2020	146,795	127,746
2021	4,116,351	2,541,333
2022	8,162,522	5,994,761

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем нэвтрэхийн сацуу энэхүү системээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай төрийн мэдээлэл солилцооны ХУР, танилт нэвтрэлтийн ДАН системийг ашиглаж эхэлсэн. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар төрийн 120, төрийн бус 300 байгууллага холбогдож, 1,463,372,476 удаагийн мэдээлэл солилцжээ.

Хүснэгт 2.4. “Төрийн мэдээлэл солилцооны ДАН систем”-д шинээр холбогдсон байгууллага, бүртгүүлсэн хэрэглэгчид.

Он	Төрийн байгууллагын тоо	Хувийн байгууллагын тоо	Бүртгүүлсэн хэрэглэгчдийн тоо
2017	0	0	0
2018	8	4	9,794
2019	10	6	59,889
2020	24	21	338,566
2021	17	46	831,241
2022	33	49	460,475

2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн систем бий болгох” төслийг 2012 оноос эхлэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд Мэдээллийн технологи, Шуудан,

24 /E-Mongolia.mn/ систем болон бусад мобайл аппликейшн

25 /E-Mongolia.mn/ систем болон бусад мобайл аппликейшн

Харилцаа, Холбооны газраас “Төрийн түгжрэлгүй үйлчилгээ” зорилтын дор “Төрийн үйлчилгээний цахим машин” буюу “ТҮЦ МАШИН”-ыг 2013 онд нэвтрүүлж байв. ТҮЦ машинаар 2013 онд 10 төрлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байсан бол 2017 онд үйлчилгээний нэр төрөл 2 дахин нэмэгдсэн, 2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 110 ширхэг ТҮЦ машин ажиллаж байна. ТҮЦ машины хэрэглээг нэмэгдүүлэх, хуурамч лавлагааны эрсдэлээс сэргийлэх зорилгоор ТҮЦ машины мобайл аппликейшныг “iOS” болон “Android” үйлдлийн системд зориулан хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв.

Хүснэгт 2.5. Төрийн үйлчилгээний цахим машины тоо, тэдгээрийн хэрэглээ

Он	ТҮЦ машины тоо	Үүнээс:		ТҮЦ-ээр үзүүлж байгаа үйлчилгээний нэр, төрлийн тоо	Үйлчилгээ авсан хэрэглэгчийн тоо	Үйлчилгээ авсан тоо /давхардсан байдлаар/
		Нийслэл	Орон нутаг, алслагдсан дүүрэг			
2017	110	78	32	11	684,923	1,640,041
2018	110	78	32	14	784,965	2,068,575
2019	110	78	32	17	808,300	2,175,077
2020	110	78	32	19	669,919	1,677,934
2021	110	78	32	25	541,256	1,245,900
2022	110	78	32	27	521,532	1,198,561

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг хүргэдэг төрийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудыг тэдгээрийн ашигладаг техник, программ хангамж, платформын ялгаатай байдлаас үл хамааран хоорондоо холбогдон, өгөгдөл мэдээлэл солилцох боломж бүхий “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”²⁶-г бий болгон хөгжүүлэх замаар төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод байдлаар хүргэх боломжийг бүрдүүлжээ.

Цахим засаглалыг хөгжүүлж иргэн төвтэй төрийн үйлчилгээний хэлбэрт шилжих зорилтын хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн систем²⁷-ийг хөгжүүлж, вэб хувилбарыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр, мобайл хувилбарыг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн үйл ажиллагаа тогтмол өргөжиж, 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн 71 байгууллагын 806 үйлчилгээг, орон нутгийн 1284 үйлчилгээг нэгтгэсэн ба нийт 26 <https://erp.e-mongolia.mn/>. Энэхүү систем нь байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем бөгөөд албан бичиг солилцооны дундын системтэй холбогдон ажилладаг.
27 И-Монголиа

1,488,566 хэрэглэгч бүртгүүлсэн. Тус систем ашиглалтад орсноос хойш ТҮНТ/НҮНТ, Вэб портал, Мобайл аппликейшнээр дамжуулан хүн, хуулийн этгээд 21,136,559 хандалт хийж, 20,489,550 үйлчилгээг амжилттай авсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.1-3. Төрийн байгууллагуудын цахим засгийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангах бүтцийг бий болгох /ЗГХЭГ, ХХМТГ, 2020 он/

Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрийн үйл ажиллагаа дахь мэдээллийн технологийн дэвшлийн хэрэглээ нэмэгдэж, байгууллага хооронд мэдээлэл солилцох дэд бүтэц сайжирч, цахим хэлбэрт шилжих төрийн үйлчилгээний төрөл, тоо өсөж, хүнд суртал, авлига, хээл хахууль буурах, төсвийн болон иргэдийн зардал хэмнэх, төрийн үйлчилгээг хурдан шуурхай, цаг алдалгүй, орон зайнаас үл хамааран хүртэх давуу талууд бий болно.

Энэ төрлийн системийг хурдан шуурхай нэвтрүүлэх, олон улсын жишигт нийцсэн, иргэн, хуулийн этгээдэд, хялбар, хүртээмжтэй, аюулгүй төрийн цахим үйлчилгээг бий болгож, нэг цонхонд төвлөрүүлэх, энэ салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх

зорилгоор Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 458 дугаар тогтоолоор Цахим хөгжлийн үндэсний хороог байгуулж, дүрмийг батлуулсан.

Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоол, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 86 дугаар тогтоолоор Засгийн газрын бүтцэд Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүлээ. Мөн Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолоор “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан. Энэхүү үйлдвэрийн газар нь мөн төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.2-1. Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах /ЗГХЭГ, 2017-2018/

УИХ-аас 2001 онд баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд салбарын яамдаас олгох 18 чиглэлийн 103 ерөнхий төрөл, түүнд хамаарах 210 гаруй дэд төрлийн үйл ажиллагаа болон аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргаас олгох 7 төрлийн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр заасан боловч бодит байдалд 54 байгууллага, 914 төрлийн зөвшөөрөл олгож ирсэн. Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай болон Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс санаачилсан Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлтэй нэгтгэн боловсруулж, 2021 оны 05 дугаар сараас хойш төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, эрдэмтэн, судлаачид, олон улсын байгууллагын төлөөлөлтэй 40 гаруй удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, хурлыг зохион байгуулж, тэдгээр ирүүлсэн 550 гаруй санал тус бүр дээр ажилласан. Хуулийн төслийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Энэхүү хуульд зөвшөөрөл, түүний ангилал, бүртгэл, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг

шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох үндэслэл, журмыг тогтоосон. Мөн уг хуулиар хориглосон болон зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх иргэний эрхийг баталгаажуулж, эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийн төрлийг хуульчлан тогтоож, хуульд заагаагүй зөвшөөрлийг шинээр бий болгохыг хориглов. Зөвшөөрөл эзэмшигчдэд хүнд суртал, чирэгдэл учруулдаг ач холбогдолгүй, хэт хавтгайруулсан шаардлагыг халж, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах, түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, журмыг тодорхойлж, олон шат дамжлагыг цөөлж, зөвшөөрөл олгох ажиллагааг хялбаршуулсан. Түүнчлэн энэ хуульд зөвшөөрөл олгох ажиллагаатай холбоотой төрийн байгууллага, албан тушаалтны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгох асуудал тусгагджээ.

УИХ-ын 2022 оны 35 дугаар тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Зөвшөөрлийн хуульд нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газарт даалгасны дагуу зөвшөөрөл олгох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн зөрчил, давхардал, хийдлийг арилгах хүрээнд Зөвшөөрлийн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нийт 89 хуулийн төсөл, 1 Улсын Их хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулан өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.

Төрөөс олгодог зөвшөөрлийг хялбарчлах чиглэлээр шинэтгэлийн ажил үргэлжилсээр байна. 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн дараах агуулга бүхий нэмэлт орсон. Үүнд:

Тодорхой төрлийн тусгай болон энгийн зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаандаа

холбогдох техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх, зөвшөөрөл олгогч этгээдээс тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг баталгаажуулалтын байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээг үндэслэн хялбаршуулсан журмаар явуулж болно. Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 5.2-т заасан техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүйд тооцох үндэслэл болно гэх өөрчлөлтүүд орсон.

(Биелэлт 100 хувь)

4.1.2.2-2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх /ЗГХЭГ, 2018-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны 10 сард Засгийн газрын шийдвэрээр төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, явцын мэдээллийг нэгтгэн үнэлгээ хийсэн. Уг судалгаанаас харахад 2020 оны байдлаар Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авалгүйгээр төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг 10 байгууллага байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажил, үйлчилгээг үзүүлж байна.

Эдгээр байгууллагыг дурдвал, Хустайн цогцолбор газар, Монголын барилгын үндэсний ассоциаци, Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага, Монголын ахмадын холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн зэрэг болно. Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Журам, шалгуур үзүүлэлт батлах тухай" А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбарын зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам" батлагдсан. Тус журмын 1.3-т төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх дараах 6 үйл ажиллагааг зааж

өгсөн. Журмын хэрэгжилтийг дараах хүрээнд ханган ажиллаж байна. Үүнд:

1. Эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах чиглэлээр эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг мэргэжлийн нийгэмлэг холбоод зохион байгуулсан..

2. Багц цагийн сургалт олгох чиглэлээр 627 хөтөлбөрт 58 төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллаж байна.

3. Улсын хэмжээнд 7 эрүүл мэндийн байгууллагад ТУЗ байгуулагдаж, 3 эрүүл мэндийн байгууллагын ТУЗ-ийн гишүүд сонгон шалгаруулалтаар шалгарч батламжлуулахаар хүлээгдэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүний 3 нь эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл, даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн төлөөлөл, эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийг төлөөлсөн олон нийтийн төлөөлөл хамаардаг.

4. Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах үйл ажиллагаанд Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооноос 1 гишүүн төлөөлөн оролцдог.

5. Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаанд Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооноос 1 гишүүн төлөөлөн оролцдог.

6. Эмийг бүртгэх, баталгаажуулах, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хүрээнд Хүний эмийн зөвлөлд төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогдон ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шийдвэр гарган 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Барилгын салбарт өнөөдрийн байдлаар 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байгаа

бөгөөд эдгээрт барилга байгууламжийн ажил гүйцэтгэх, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл багтаж байна. Барилга, байгуулалтын яамнаас “Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-д барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг гэрээгээр гүйцэтгүүлэх эрхийг олгосон бол үлдэж буй гурван төрлийн тусгай зөвшөөрлийг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ тэргүүтэй найман байгууллагын түншлэлд олгосон байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын хэмжээнд Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр-ийн хүрээнд хийгдэх ачаа, зорчигч тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг солилцох, тээвэрчдэд олгох, тооцоо хийх, хяналт тавих, Автотээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгох ажлыг “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклийн спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Мөн «Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам»-ын 2.1, 2.2, 2.4, 2.6 болон 2.7 дахь заалтуудад заасан аж ахуйн нэгж, байгууллагуудаас тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авах авах, хүсэлтийг ажлын хэсгээр хэлэлцүүлж дүгнэлт гаргах зэрэг эрх үүргийг “Монголын авто замчдын холбоо ТББ”-д шилжүүлсэн бөгөөд тус ТББ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийг олгож байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.2-3. Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; /ЗГХЭГ, ТББ, 2020-2021/

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх төрийн үйлчилгээний төрөл, хүрээ тодорхойгүйгээс төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна. 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль нь энэ төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулаагүй. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд ашгийн төлөө бус хуулийн этгээдийг төрөл тус бүрээр нь нарийвчлан зохицуулахаар, ялангуяа Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр холбооны төрөл, ангилал, дотоод зохион байгуулалт, удирдлага, төлөөлөл, үүсгэн байгуулагчийг тодорхой болгож, бүртгэл, хяналт, тайлагналт, ил тод байдал, татан буугдах нөхцөл, журмыг боловсронгуй болгож, онцлог бүхий холбоо, төрөөс холбоонд үзүүлэх дэмжлэг, төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг тус тус эцэслэн боловсруулж, төслийг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлыг гүйцэтгүүлэн үнэлгээний тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөө” сэдэвт хэлэлцүүлэгт нийт 15 төрийн бус байгууллагын 42 төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлэгт оролцогчдоос 5 чиглэлээр гаргасан санал, дүгнэлтэд тулгуурлан Зөвлөмж боловсруулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх

газраас төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний хүртээмж, түүнд тавих хяналтыг сайжруулах, цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, төрийн захиргааны байгууллагуудад чиглэл болгохоор ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.3-1. Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох / СХЗГ, 2018-2020/

Олон улсын стандарт хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.2-т “Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрнө”, 14.7-д “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.” гэж тус тус заасны дагуу олон улс бүс нутгийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэг баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй байхаар зохицуулсан.

Мөн УИХ-аар 2019 оны 05 дугаар сарын 09-нд хэлэлцэн баталсан Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалтын хүрээнд Хууль эрхийн хэмжил зүйн Олон улсын байгууллага /OIML/, зохих гэрээ хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллагаас загварыг баталж, гэрчилгээ олгосон тохиолдолд хэмжих хэрэгслийн загварын туршилтыг давтан хийхгүйгээр хүлээн зөвшөөрөх хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөж байна. Хэмжил зүйн Олон улсын байгууллага /OIML/-с загварыг баталсан хэмжих хэрэгсэлд давтан загварын

туршилт хийлгүйгээр хүлээн зөвшөөрч зохих сертификат авсан хэмжих хэрэгслийн загварын тоо 2020 онд 4, 2021 эхний улирлын байдлаар 3 байх бөгөөд 2020 онд үйлдвэрлэгчийн анхдагч баталгааг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгжийг баталгаажуулсан.

Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.2.3-д заасны дагуу 2022 онд Стандарт, хэмжил зүйн газраас олон улс, гадаад орны дэвшилтэт стандартыг хэрэглэхээр нийт 17 байгууллагын 35 стандартад бүртгүүлэн хэрэглэх зөвшөөрлийг олгосон. Энэ нь тухайн байгууллага өөрийн нутагшуулсан технологи, олон улсын стандартаар бараа, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.2.3-2. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох; СХЗГ, ХЗДХЯ 2018-2020/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.1, 5.1, 5.2-д Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ гэсэн заалтыг шинээр оруулснаар хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах техникийн зохицуулалтыг нийтээр заавал даган мөрдөж, бусад стандартыг сонгон хэрэглэх зохицуулалтыг тусгажээ. Доорх хүснэгтэд хүчингүй болгосон, цөөрүүлсэн стандартын талаарх мэдээллийг тусгавал:

Хүснэгт 2.6. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгосон байдал.

Он	Нийт стандартын тоо	Үүнээс			
		Хүчингүй болгосон стандартын тоо	Нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартын тоо	Шинэчилсэн стандартын тоо	Шинээр баталсан стандартын тоо
2017	5640	63	7	70	105
2018	5860	41	4	41	122
2019	6420	57	1	23	66
2020	6666	96	10	81	161
2021	6702	74	5	49	166
2022	6536	308	7	40	104

Үгцэсний хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд нийт 639 стандартыг хүчингүй болгож, шинээр 724 стандартыг баталжээ. Мөн нэмэлт 34 стандартад өөрчлөлт оруулж, 304 стандартыг шинэчилжээ. Үүнийг 2022 оны эцсээр Монгол Улсад мөрдөгдөж байсан 6536 стандарттай харьцуулвал, тайлант хугацаанд нийт стандартын 9.7%-тай тэнцэх тооны стандарт хүчингүй болж, 11%-тай тэнцэх тооны стандарт шинээр батлагдсан байна.(Биелэлт 70 хувь)

4.1.2.4-1.Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ЗГХЭГ, МХЕГ, ТЕГ 2018-2019/

“Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хэлбэрүүдийг нарийвчлан тогтоож, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг шалгалттай хослуулан хэрэгжүүлэх замаар аюул, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн шинэчлэн боловсруулж, МХЕГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан. Хуучнаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг орчныг боловсронгуй болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч байв. Тухайлбал, “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хяналтын хэлбэрүүдийг нарийвчлан тогтоож, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах

үйлчилгээг шалгалттай хослуулан хэрэгжүүлэх замаар аюул, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн шинэчлэн баталж, 2021 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг хийж олон нийтэд зарласан. 2020 оны ээлжит эрсдэлийн үнэлгээг 79076 аж ахуйн нэгж, байгууллагын хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 137171 объектод 31 нэгжийн 1560 улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд бүртгэсэн. Эрсдэл ихтэй гэж үнэлэгдсэн объектын тоог 2019 оныхтой харьцуулж үзэхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл их үнэлэгдсэн объектын тоо 1469-өөр өсч, эрсдэл үүсэх магадлал багатай объектын тоо 3630-аар буурсан. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээ хийж, аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон олон нийтэд хүргэсэн. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 147 дугаар тушаалаар хяналт шалгалтын эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг баталж, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулсан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг олон нийтэд 12 дугаар сарын 01-ний өдөр хуулийн хугацаанд khyanalt.gov.mn, shienkhyanalt.gov.mn цахим системээр, inspection.gov.mn цахим хуудсаар зарлаж байв. Түүнчлэн төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн найруулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагуудыг судлан үзэж, энэ талаарх танилцуулгыг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 417 дугаар тогтоолд зааснаар Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, чиг үүргийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудад шилжүүлсэн.

Татвар төлөгчийн эрсдэлийг тооцох, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлд "Татварын албаны эрсдэлийн удирдлага", 41-45 дугаар зүйлд татварын хяналт шалгалтын талаар зохицуулалт хийгдсэний дагуу холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн баталсан. Үүнд: Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 305 тоот тушаалаар "Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны ажиллах журам", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/264 тоот тушаалаар "Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам"-ыг тус тус шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. "Татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, санг бүрдүүлэх, ашиглах, сангийн нууцыг хамгаалах журам"-ын төслийг ОУВС-ын зөвлөмж болон Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан "ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-тэй уялдуулан боловсруулж, ТЕГ-ын даргын А/113 дугаар тушаалаар батлуулсан. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээлэл харилцан солилцох үүрэг бүхий байгууллагуудтай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 35 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна.

Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлын хүрээнд татвар төлөгчдийн 2022 оны эрсдэлийн үнэлгээг тооцохдоо дараах эх сурвалжуудаас 2018-2021 оны мэдээлэл

цуглуулан ажилласан. Үүнд: Татварын удирдлагын нэгдсэн систем /TAIS/, Цахим тайлангийн систем /ETAX/, Цахим төлбөрийн баримтын систем /E-BARIMT/, Цахим санхүүгийн тайлангийн систем /E-BALANCE/, Хөндлөнгийн мэдээллийн сан /TPI/, Гаалийн импорт, экспортын мэдээлэл, Нийгмийн даатгалын тайлангийн мэдээлэл, Төрийн сангийн зарлагын гүйлгээний мэдээлэл, Арилжааны банкны холбогдох мэдээлэл, Тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Хөрөнгийн мэдээлэл, Хяналт шалгалтын явцад байцаагчийн цуглуулсан мэдээлэл, БХБЯ-ны Байнгын ашиглалтад оруулсан барилгын байгууламжийн мэдээлэл, Монгол Улсын далд эдийн засгийн судалгаа /Салбарын ангиллаар/, Эдийн засгийн салбарын ангиллын дундаж ашгийн судалгаа, Санхүү болон татварын хуурамч баримт бичиг бүрдүүлсэн татвар төлөгчдийн судалгаа, Татвар төлөгчийн бүртгэлийн харилцан хамаарлын судалгаа, татварын хяналт шалгалтын түүхэн мэдээлэлд тулгуурлан хяналт шалгалтаар зөрчил илрэх магадлалыг дундаж утгаар таамаглах загвар, ААНОАТ-ын орлого зардлын харьцааны регрессийн шинжилгээнд үндэслэж сонгосон байна. 2022 онд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтад том сегментийн 196, дунд сегментийн 273, жижиг сегментийн 653, бичил сегментийн 655 татвар төлөгч, нийт 1777 татвар төлөгчийг хамруулж 5.1 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, 454.3 тэрбум төгрөгийн нөхөн татвар, хүү торгууль алданги тавигдсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.4-2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ 2018-2020/

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 23 хуульд "дотоод хяналт"-ыг хэрэгжүүлэх талаар туссан боловч хууль бүр өөр өөр байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, "дотоод хяналтын журам, хөтөлбөр"-тэй байхаар 9 заалт, "дотоод хяналт хариуцсан нэгж, алба, ажилтан"-тай байхаар 6 заалт, "дотоод хяналтын тайлантай, түүнийгээ тайлагнадаг" байхаар 4 заалт, "дотоод хяналтыг хэрэгжүүлнэ", "дотоод хяналтыг зохион байгуулна" гэсэн 8 заалт, "дотоод хяналтын тогтолцоотой байх" талаар 2 заалтад тусгагдсан. Тухайлбал, "Дотоод хяналт"-ыг Дотоод хяналт, шалгалт, дотоод аудит, ISO,

НАССР, зохистой дадал нэвтрүүлж дотоод хяналт тавих гэх мэт арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр томьёолсон. Салбарын холбогдох хууль, дүрэм, журамд “Дотоод хяналтын алба, Хөдөлмөрийн аюулгүй байдлын алба, Эрүүл ахуй халдвар хамгааллын алба, Чанарын алба” гэх мэтээр бүтцийг олон янз байхаар тусгасан байна. Хэдийгээр хууль, дүрэм, журамд “дотоод хяналт”-ын талаар заалтууд туссан байгаа ч салбар бүрд хамаарах хуульд янз бүрээр томьёологдсон. Гэвч аж ахуйн нэгжүүдэд зориулагдсан дотоод хяналтын стандартыг холбогдох байгууллагаас баталж байгаа нь хувийн хэвшлийн байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлж байна.

Стандартчилал, хэмжил зүйн газраас Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх (2018-2020) ажлын хүрээнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 8.1.3-т стандартчиллын баримт бичигт “олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандарт” хамаарахаар, 12.1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ” гэсний дагуу Менежментийн стандартчиллын Техникийн Хорооны ажлын төлөвлөгөөний хүрээнд Менежментийн тогтолцооны аудитын заавар ISO 19011:2018 олон улсын стандартыг орчуулан үндэсний стандартаар батлан мөрдүүлж байна.

Тус газраас «Менежментийн тогтолцооны аудитын заавар ISO 19011:2018» стандартыг шинэчлэн баталсан. Энэхүү стандарт нь аж ахуйн нэгж, байгууллага өөрийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг бий болгохын тулд тусгайлсан хөтөлбөр бий болгож дотоод болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтыг төлөвлөх, ажилтнуудын чадамжийг үнэлэхэд зориулагдсан байна.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн үйл ажиллагааны эрсдэлээ үнэлэх, төлөвлөх байгууллагын өмнө тулгарч буй эрсдэлийг удирдах, шийдвэр гаргах, салбарын онцлог шинж чанараас үл хамааран бүх төрлийн эрсдэлийг үнэлэх боломжтой «Эрсдэлийн менежмент-Удирдамж MNS ISO 31000:2020» стандарт, үйл ажиллагааны дотоод болон хөндлөнгийн аудитад хамрагдах, ажилтнуудаа үнэлэх зорилго

бүхий «Менежментийн тогтолцооны аудитын заавар MNS ISO 19011: 2020» стандартыг тус тус баталж, холбогдох байгууллагуудад дагаж мөрдөхийг зөвлөсөн.

Түүнчлэн Аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг мөрдөж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд 38 хуулийн этгээдэд хуульд заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн ба баримтын хяналт шалгалтад 11, системийн хяналт шалгалтад 11, гүйцэтгэлийн хяналт шалгалтад 10, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 6 хуулийн этгээдийг хамруулсан. Төрийн өмчийн хяналт шалгалтын 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу баримтын болон системийн 46 хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах талаар зөвлөмж өгч ажиллажээ. (Биелэлт 70)

4.1.2.4-3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ 2018-2022/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2021 онд төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлал болон төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлалыг мөн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/125 дугаар тушаалаар тус тус баталж, төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагуудад хүргүүлсэн. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг

хяналтын чиглэл бүрээр нэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилт дэвшүүлэн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх 25 зорилтын хүрээнд 185 арга хэмжээг хяналтын 7 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, тус газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/131 тоот тушаалаар батлуулж, байгууллагын цахим хуудаст олон нийтэд нээлттэй байршуулж мэдээлсэн. Засгийн газраас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг өмнөх оноос 50% бууруулан төлөвлөжээ. 2021 онд нийт 8188 шалгуулагч этгээдийн 9920 объектод шалгалт, 5407 объектод 6819 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн ба шалгалт хийх объектын тоо нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 95230 аж ахуйн нэгж, байгууллагын 10.4%-ийг эзэлж байв.

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 417 дугаар тогтоолд зааснаар Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, чиг үүргийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудад шилжүүлсэн.

Татварын ерөнхий газар нь 2020 оны жилийн эцсийн хяналт шалгалтад хамрагдаагүй үлдсэн 202 татвар төлөгч дээр 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар 1522 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөгөө батлагдсанаас нас барсан, хилээр гарсан гэх мэт тодорхой шалтгааны улмаас 161 татвар төлөгчийн томилолт цуцлагдсан. Үүнээс 2021 онд 1483 татвар төлөгч хяналт шалгалтад хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай байна. 2021 онд 4 зөвлөмж боловсруулж, “Монголын татварын алба” фэйсбүүк группт байршуулсан нь 15,6 мянган татвар төлөгчийн хандалт авч, 569 татвар төлөгчид таалагдаж, 1547 татвар төлөгч бусдад түгээсэн байна. Сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулж 3915 татвар төлөгчийг хамруулж, “Монголын татварын алба” болон орон нутгийн пэйж хуудсанд зөвлөмж байршуулсан нь 13372 татвар төлөгчийн хандалт авч, 1014 татвар төлөгч бусдад түгээж, 778 татвар төлөгчид таалагдсан байна.

2021 онд төлөвлөгөөт татварын хяналт шалгалтыг 2780 татвар төлөгчид хийхээс 2632 татвар төлөгчийн татварын ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалтыг хийж 5.5 их наяд төгрөгийн зөрчилд 254.5 тэрбум төгрөгийн нөхөн татвар, торгууль, алдангийг ногдуулж байсан бол 2022 онд 787 татвар төлөгчийг хууль хяналтын болон бусад хүсэлтээр, эрсдэлд суурилсан 669 татвар төлөгч нийт 1456 татвар төлөгчийг шалгаж 5.7 их наяд төгрөгийн зөрчилд нөхөн татвар торгууль алданги нийт 263.1 тэрбум төгрөгийн ногдуулсан байна. Өөрөөр хэлбэл хяналт шалгалтад хамруулах татвар төлөгчийн тоог 45 орчим хувиар бууруулсан боловч хяналт шалгалтаар ногдуулсан төлбөр 8.6 тэрбумаар өссөн үзүүлэлттэй байна.

Стандарт хэмжил зүйн газар нь үнэт эдлэлийн худалдаа эрхлэгч, талбай түрээслэгчдэд зөвлөн туслах зорилго бүхий сорьцын хяналт, шалгалтыг 2022 онд нийт 10 удаа зохион байгуулсан. Үүнд: 1/Үнэт эдлэлийн худалдааны үйл ажиллагаа явуулдаг 15 дэлгүүрийн 520 орчим худалдаа эрхлэгчдэд зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан бөгөөд 5965 үнэт эдлэлийг сорьцын шинжилгээнд хамруулж, сорьц дарж баталгаажуулсан. 2/Монголбанкнаас экспортод гаргах үнэт металлын сорьцыг хянаж баталгаажуулахаар Монголбанкны Эрдэнэсийн санд 25 удаа ажиллаж, давхардсан тоогоор 459 аж ахуйн нэгж, 245 иргэний нийт 5362 ширхэг үнэт металлыг сорьцыг хянаж баталгаажуулсан. 3.Алт олборлогч “Баян айраг” ХХК, “Степ голд” ХХК-уудын нийт 526 ширхэг гулдмайнаас дээж авч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.

УИХ зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай хуулийг 2022 оны 12 дугаар сард баталсан. (Биелэлт 70 хувь)

4.1.2.5-1. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах / АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын

судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь “Шударга байдлын үнэлгээ” судалгаа юм. Төрийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ” судалгааг 2016-2022 онд жил бүр зохион байгуулсан бөгөөд үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулдаг бөгөөд шударга байдлын үнэлгээний дэд үзүүлэлт болох ил тод, хариуцлагатай байдлын индексийн оноо 2016 онд 57.5, 2018 онд 56.5, 2019 онд 61.6, 2020 онд 74.1, 2021 онд 72.9, 2022 онд 63.75 гарчээ.

Шударга байдлын үнэлгээний үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшний үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт болгон ашиглаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөлөл”-ийг тодруулах судалгааг 2020 онд зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн судалгааны үр дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлснээр судалгааны үр дүнг үндэслэн уулзалт зохион байгуулсан.

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах,

хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын ил тод байдлын үнэлгээг 2020, 2021 онуудад гүйцэтгэв. Үнэлгээг Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад үндэслэн боловсруулсан ба 2020 онд 13 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд судалгаа хийсэн бол 2021 онд яамд, Засгийн газрын агентлаг, 21 аймгийн болон нийслэлийн 9 дүүргийн ил тод, нээлттэй байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Энэхүү үнэлгээг 2022 оноос эхлэн Цахим хөгжил, харилцаа холбооны яам хариуцсан хийж эхэлсэн бөгөөд 2023 оноос эхэлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан²⁸-аар дамжуулж, байгууллагууд өөрсдөө үнэлэх журамд шилжсэн байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.6-1. Монгол Улсын иргэн бүрт цахим гарын үсэг олгох /ХХМТГ, 2017-2022/

Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 байгууллагаас иргэдэд 54 мянга гаруй тоон гарын үсгийн гэрчилгээ олгожээ.

2021 онд Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж олгохоор тогтоосон. 2022 оны 5 сарын 01-ээс эхлэн иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг суулгаж, иргэдэд олгохоор бэлтгэл ажлууд хийгдэж байна. Улсын бүртгэлийн байгууллагаас 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгож эхэлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 508,330 иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг суулгажээ.

“Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл”-ийн 3.8 дахь заалтыг үндэслэн тусгааргаас “Үндэсний дата төв” УТҮГ-т Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосноор төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох ажлыг 2022 он хүртэл

хэрэгжүүлсэн. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон “Үндэсний дата төв” ҮТҮГ-тай хамтран тоон гарын үсгийн гэрчилгээний дундын санг бий болгож, гэрчилгээ олгогч байгууллагууд гэрчилгээний мэдээллээ тухай бүр оруулсны дүнд 2022 оны байдлаар тус санд 18596 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээлэл байна.

Тоонгарынүсэгашиглахнэгдсэнхэрэглэгчийн программ хангамж /Esign client/-ийг хөгжүүлж, гэрчилгээ олгогч байгууллагуудын ашиглаж байгаа е-Токен төхөөрөмжүүдийн драйверуудыг нэгтгэж, ашиглаж эхлээд байгаа бөгөөд төхөөрөмжийн үнэ 30-50 хувиар буураад байна.

Тоон гарын үсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас-үнэгүй олгож байгаа бол хувийн хэвшлийн 3 байгууллага²⁹ болох Monpass - 77>000 төгрөг; New compass - 50>000 төгрөг; Tridium - 80>000 төгрөгийн төлбөртэйгөөр тоон гарын үсгийг олгодог.(Биелэлт 70 хувь)

4.1.2.6-2. Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх /ХХМТГ, ЗГХЭГ, ХЗДХЯ, 2018 он/

Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдсан. Энэ журмын 3.2-т “Байгууллагын албан ёсны цахим хаягаар ирсэн баримт бичгийг бичиг хэрэгт хүлээн авч, бүртгэн, удирдлагад дотоод сүлжээгээр шилжүүлэх, эсхүл хэвлэж танилцуулна.”, 6.1.2-т “Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, яаралтай шийдвэрлэх болон хариу шаардлагатай бүх баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр бүртгэж, хяналтад авна.” гэж тус тус заасан. Мөн байгууллагын цахим хуудаст ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг (6.2.1.2) “цаасан болон цахим хэлбэрээр ирсэн баримт бичгийг бичиг хэрэгт бүртгэж, хүлээн авсан өдрөөс” эхэлж, (6.2.2.5) “иргэдийн өргөдөл, гомдлын хариуг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд” багтааж шийдвэрлэхийг тусгажээ.

Хэдийгээр цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай тухайлсан

29 Тоон гарын үсэг олгох зөвшөөрлийг 4 байгууллага авсан ч 1 нь үйл ажиллагаагаа явуулахгүй байна.

журам боловсруулагдаагүй боловч төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тогтмол хангах, тухай бүр шинэчлэх ажлыг хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох “Үндэсний цахим шуудан”-ийн систем /www.mail.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлж, 1,6 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. Үндэсний цахим шуудангийн системд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага (193 хаяг)-ын албаны цахим шууданг холбож, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн.

2. Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia системд “Авлигатай тэмцэх газарт өргөдөл гомдол гаргах» цэсийг шинээр нэмж, хөгжүүлсэн.(Биелэлт 30 хувь)

4.1.2.6-3. Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлэх /АТГ, ЗГХЭГ 2018 он/

АТГ-аас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээллийг факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос,18001969 тусгай дугаарын утсаар болон байгууллагын байранд биеэр ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд биечлэн өгөх хэлбэрээр хүлээн авч байсан.

Авлигын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай 110 дугаарын утсыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Энэ дугаар нь ярианы төлбөр үнэ төлбөргүй, иргэд тус 3 оронтой дугаарыг цээжлэхэд амар хялбар гэдгээрээ онцлог юм. 110 дугаарын утсыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав” дахь салбар болон “Бөмбөгөр” худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдэд сурталчлан, үүрэн телефоны операторуудын харилцагч нарт мессеж хэлбэрээр хүргэх, Улаанбаатар хотын 6 дүүргийн 40 байршилд байрлах самбаруудад 110 дугаарын утасны сурталчилгааг үнэ төлбөргүй

байршуулж ажиллав. Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарын утсыг цахим орчинд сурталчлах, мөн тус газраас зохион байгуулж буй аян, арга хэмжээг сошиал медиа сувгаар түгээх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

110 тусгай дугаарын утсанд 2020 онд 17851, 2021 онд 13474, 2022 онд 10858 дуудлага ирсэн байна. 2021 онд нийт дуудлагын 46.5 хувь нь зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, дуудлага андуурах, санал хүсэлт хэлэх, утсаар тоглох зэргээр холбогдож ярьсан бол 53.5 хувь нь дуудлага тасарсан, дуудлага холбогдсон ч яриагүй тасарсан байна. 110 тусгай дугаарын утсанд 2021 онд нийт 285 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэн шалгасан байна. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 57.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 28.8 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 3.2 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна. 110 дугаарын утсаар гомдол мэдээлэл түгээмэл ирүүлдэг салбарыг дурдвал: Зам, тээвэр, эрүүл мэнд, цагдаа, гааль, боловсрол, газар зохион байгуулалт, барилга, цахилгаан дулаан, ус хангамж зэрэг салбарт хамаарч байна.

2022 онд нийт дуудлагын 52.2 хувь нь зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, дуудлага андуурах, санал хүсэлт хэлэх, утсаар тоглох зэргээр холбогдож ярьсан бол 47.8 хувь нь дуудлага тасарсан, дуудлага холбогдсон ч яриагүй тасарсан байна. 110 тусгай дугаарын утсанд 2022 онд нийт 553 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэн шалгасан байна. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 47.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 32.5 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 11.2 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна. 110 дугаарын утсаар гомдол мэдээлэл түгээмэл ирүүлдэг салбарыг дурдвал: Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах, боловсрол, эрүүл мэнд, цагдаа, газар зохион байгуулалт, зам тээвэр, барилга,

уул уурхай, байгаль орчин зэрэг салбарт хамаарч байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.7-1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх /ЗГХЭГ, 2017-2022/

Засгийн газраас 2019 оны 12 дугаар сард “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-г улс орон даяар зохион байгуулав. Судалгаанд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн 291 сум, 545 багийг хамруулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэг хувийг хөдөө, орон нутгийн багт амьдардаг иргэд эзэлж байна. Төрийн үйлчилгээний салбар, чиг үүргийг нийт 13 салбарт хуваан иргэдээр үнэлүүлсэн. Салбарууд дунджаар 3.1 гэсэн үнэлгээтэй байгаа бол 7 салбар дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад нь дунджаас доогуур үр дүнг харуулж байна. Төрийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой бүлэг асуултаас мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдалтай холбоотой асуултауд илүү өндөр үнэлгээтэй байна. Харин үйлчилгээний ачааллын хэвийн байдлыг хамгийн тааруу үнэлжээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баталж, салбар чиг үүргийн үнэлгээний 63 үзүүлэлт, үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээний 19 үзүүлэлт, 16 асуудлаас бүрдсэн санал асуулгын хуудсаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Энэхүү судалгаанд 30,068 иргэн оролцож, ерөнхий сэтгэл ханамж 58.7 хувь, салбарын дундаж үнэлгээ 55.3 хувь, чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ 67.8 хувьтай тус тус гарчээ.

Цаашид Төрийн албаны тухай хуульд “төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ” гэж заасны дагуу тус зөвлөлийн дүрмийг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 212 дугаар тогтоолоор баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.2.7-2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018-2019 он/

Засгийн газраас 2019 оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам”-ыг батлан мөрдүүлж байсан. Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэжлийн түвшнийг үнэлэх журам” болон Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалыг баталж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэжлийн түвшнийг үнэлэх журам” болон Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалыг баталсан бөгөөд нэгжийн дарга албан хаагчийг улирал тутам, нэгжийн даргыг төсвийн шууд захирагч хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхээр зохицуулж өгөв. Дээрх журмаар төрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн нэг үзүүлэлт болох үйлчилгээ үзүүлэх хандлагыг хэрэглэгч буюу үйлчлүүлэгчээр үнэлүүлэхээр тусгасны дагуу иргэд төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулж цаг тухайд нь үнэлснээр үнэлгээ илүү бодитой, албан хаагчдыг цаг тухайд нь урамшуулах, хариуцлага тооцох боломжтой эрх зүйн орчин бүрдэв. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгжийн даргаас гадна байгууллага бүрд үнэлгээний баг албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг байгууллагын бүхий л түвшинд жигд, бодитой, шударга хийгдэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ажилтнуудын үнэлгээг давхар хянаж эцсийн үнэлгээ өгөх зохицуулалтыг хийсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй

Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр иргэд олон нийттэй харилцах төвийн санал хүсэлтийг хүлээн авах төвийн системийг шинээр хөгжүүлэн, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж, 2020 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр илэрхийлэх боломжтой цахим үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn систем болон 11-11.mn системийг харилцан мэдээлэл солилцох боломжтой байдлаар холбосон.

Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-ийн ашиглалтыг сайжруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг мэдэх зорилгоор “Хэрэглэгчтэй харилцах цэс” болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх «Customer Effort Score» цэс хөгжүүлжээ.

Төрийн үйлчилгээний операторын www.operator.e-mongolia.mn системд үйлчилгээний ажилтанд иргэн үнэлгээ өгөх модулийг 2020 оны 06 дугаар сарын 01 нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй иргэдээр төрийн үйлчилгээний чанар, үр дүнг төхөөрөмж ашиглан “Маш сайн”, “Сайн”, “Дунд”, “Муу” гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлж, тухайн салбарын нийт үнэлгээний дундаж дүн мэдээг нэгтгэн, статистик тоон үзүүлэлт хэлбэрээр өдөр бүр иргэдэд нээлттэйгээр байршуулан хүргэж байна.

**Хүснэгт 2.7. Төрийн үйлчилгээний операторт
иргэдээс өгсөн үнэлгээ**

Он	Үнэлгээ өгсөн иргэдийн тоо	Үүнээс:				Иргэдийн өгсөн дундаж үнэлгээ /хувиар ² /
		Маш сайн	Сайн	Дунд	Муу	
2020	2167	1867	244	45	11	86.1%
2021	7938	7,208	674	40	16	90.8%
2022	862	832	27	3	0	96.5%

(Биелэлт 70 хувь)

4.1.2.7-3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор төрийн байгууллага бүрд ажил дүгнэх үзүүлэлт бий болгож мөрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018 он/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин /31 үзүүлэлтээр/ болон төрийн байгууллагын ажлыг үнэлэх /70 үзүүлэлтээр/ ажлыг улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд явуулсан. Энэ үнэлгээний хүрээнд төрийн албан хаагчийн сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдалтай газар дээр танилцаж, албан хаагчдаас ярилцлага авах ажлыг зохион байгуулсан.

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх журам” шинэчлэгдсэн. Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх журам” болон журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалын дагуу нэгжийн дарга албан хаагчийг улирал тутам, нэгжийн даргыг төсвийн шууд захирагч хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж байна.

Сангийн яам Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор яамны цахим хяналт-шинжилгээ үнэлгээний “Лидер мониторинг” (LM) программыг ашиглалтад оруулсан. Цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний “Лидер

мониторинг” программ нь:

Бодлогын баримт бичгүүдэд туссан Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ;

- Дээд байгууллагын тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар;
- Үндэсний аудитын газар, ТАЗ болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж;

Сангийн яамны дотоод аудитын хорооноос өгсөн зөвлөмж гэх мэт байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнах шаардлагатай баримт бичиг, заавар, зөвлөмжийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэснээр ажилтнууд холбогдох мэдээллийг цаг алдалгүй тайлагнах, нэг ажлыг олон дахин тайлагнаж тэр бүрд газар хэлтсүүд хоорондоо бичиг бичих зэрэг ажлын давхардлыг арилган үйл ажиллагааг хөнгөвчилж байна. Сангийн яамны дотоод бүтцийн нэгжүүдийн долоо хоног, сар, жилийн төлөвлөгөө, тайланг тус программаар нэгтгэн, ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг оруулж өгснөөр “Үр дүнгийн гэрээ”-г программыг ашиглан боловсруулж, дүгнүүлдэг болсноор илүү шударга, үнэн зөв дүгнэгдэх, нөгөө талаас гэрээ байгуулах, дүгнэх ажлыг хөнгөвчлөн цаг хугацаа хэмнэсэн, ажлын давхардал арилсан байна. (Биелэлт 100 хувь)

Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дахь зорилтын хүрээнд тусгагдсан 10 үйл ажиллагаа, 35 арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.3.1-1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгох /СЯ, 2017-2022/

Сангийн яамнаас улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын нөхцөл байдал тухай бүр дүгнэлт хийж, үүнд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ. Тухайлбал, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, тайлагналтын журам”-ыг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан журмаар хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааны зохицуулалт, процессыг илүү ойлгомжтой, тодорхой тусгаж, мөн энэ үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Уг журам болон Сангийн сайдын 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтыг “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем” буюу <https://publicinvestment.gov.mn/> хаягт байрлах веб хуудас болон гар утасны “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшнийг ашиглаж байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний санхүүжилтийн явц байдлын талаар судалгаа, анализ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 51 дүгээр

тэмдэглэлээр баталгаажуулсан. Тэмдэглэлд хөрөнгө оруулалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс Сангийн яамнаас гүйцэтгэгч нарт шууд шилжүүлэх цахим системийг нэвтрүүлэхийг Сангийн яаманд тус тус даалгасан. Үүний дагуу “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”³⁰-ийг өргөжүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хүсэлтийн баримт материалыг цахимаар хүлээж авдаг болсноор төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагаа 100 хувь цахим хэлбэрт шилжсэн.

2022 онд энэхүү системээр санхүүжилтийг шууд гүйцэтгэгчийн дансанд цахимаар шилжүүлдэг болсон нь цаг хугацаа хэмнэсэн, шат дамжлага багасгасан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг түргэсгэж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах чухал алхам боллоо.

Мөн Сангийн яам нь Орон нутгийн хөгжлийн сангийн “Удирдлагын мэдээллийн систем”³¹ болон олон нийтэд зориулсан портал сайтыг шинэчлэн боловсруулж, 2020 онд ашиглалтад оруулсан. Үүгээр орон нутгийн хүрээнд санхүүжүүлэх болон цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг нэгтгэх, холбогдох төрийн болон орон нутгийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд зорилготой юм.

Уг системийг нэвтрүүлснээр санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн байдлаар түргэн шуурхай бэлтгэх, төсөл бүрээр нарийн мэдээлэл авах, орон нутаг болон салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцах, хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүй, тоон болон цаг үеийн мэдээллийг авах боломж бүрдсэн.

Эцэст нь, 2022 оны 04 сарын 22-ны өдөр батлагдсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлээр “Улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ”, 29¹ дүгээр зүйлээр “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага” зэргийг хуульчилсан. Ингэснээр

30 <https://publicinvestment.gov.mn/>

31 <https://onhs.mof.gov.mn/>

улсын нийт хөрөнгө оруулалтын төслүүдийг оновчтой эх үүсвэрийг тодорхойлох, түүний дагуу жилийн төлөвлөгөө, төсвийн төсөлд тусгах боломж бүрдсэн болно. Мөн үүнийг “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-д хэрэгжүүлэхээр хөгжүүлэлтийг хийжээ.

Дээр дурдсанаас гадна тодорхой салбарын хэмжээнд төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцооны бүтцийг оновчтой болгох асуудлаар дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн салбарт чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан “иргэнээ дагасан” санхүүжилтийн тогтолцоог 2021 оноос хэрэгжүүлж эхлүүлсэн. Энэ хүрээнд иргэн эрүүл мэндийн даатгалаараа, өмчийн төрлөөс үл хамааран бүх төрлийн эмнэлгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах, бүх шатлалын эмнэлгийн эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт авах боломжийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвийн одоогийн санхүүжилтийг өвчин, эмгэгийн нэр төрөл, тусламж, үйлчилгээний өртөг, тоо хэмжээнд үндэслэн тооцож, эрүүл мэндийн даатгалын санд жил бүр шилжүүлдэг болов. Энэ хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг тус тус боловсруулж батлуулсан.

Уг шинэчлэлийг 2022 онд үргэлжлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас нэг худалдан авагчийн зарчмаар санхүүжүүлэх зарчмаар хэрэгжүүлж, эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн хуваарилалтын бодлогоор дамжуулан иргэнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлсэн.

2. 2022 оноос боловсролын салбарт суралцагчийн сурлагын чанар, үр дүнд чиглэсэн санхүүжилтийн тогтолцоог эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд сургалтын хөтөлбөр, хичээл бүрийн

бодит өртгийг тооцсон, сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчийн тоотой уялдсан хувьсах зардлын санхүүжилтийг ерөнхий боловсролын сургуулиудад олгосон. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургалтын орчин, тоног төхөөрөмж, материалын зардлыг шингээснээр багшийн тухайн хичээлийн хүрээнд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүртээмж нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлж, сургуулийн удирдлагад өөрийн сургалтын орчин нөхцөл, сургалтын чанарыг сайжруулахад нь зориулж санхүүгийн эрх мэдлийг олгосон. Уг үйл ажиллагаанд нь эцэг эх, багш, ажиллагчдаас бүрдсэн зөвлөлөөр дамжуулж, төсвийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлсэн. Мөн суралцагчдын ахиц дэвшлийн үнэлгээг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хэмждэг үнэлгээний хараат бус, бие даасан тогтолцоог бий болгож, сургуулиудын санхүүжилтийг тус үнэлгээний үр дүнтэй уялдууллаа. Багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын ахиц дэвшлээр хэмжиж, түүнд тохирсон цалин, урамшууллыг олгох тогтолцоог бий болгож байна. Ингэснээр ур чадвартай, сурган хүмүүжүүлэх арга барил сайтай багш өөрийн хөдөлмөрийг шударгаар үнэлүүлж, түүндээ тохирсон цалин, урамшууллыг авах нөхцөл бүрдлээ. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх /ТӨБЗГ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад төрийн хяналт шалгалт хийж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тус газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалд иж бүрэн баримтын буюу төлөвлөгөөт

хяналт шалгалтыг, улсын төсөвт хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй төрийн өмчийн эд хөрөнгийн байдалд системийн хяналт шалгалтыг, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, гомдол эсхүл дээд шатны байгууллагын өгсөн үүрэг даалгавар, удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тус тус гүйцэтгэж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдэд 2 жил тутамд хийх хууль эрх зүйн зохицуулалттай бөгөөд түүний үр дүнд авсан арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулдаг.

Хүснэгт 3.1. 2016-2022 онд гүйцэтгэсэн хяналт шалгалт.

Он	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо			Нийт шалгалт /байгууллага/-ын тоо	Зөрчлийн дүн (тэрбум төгрөгөөр)
	Төлөвлөгөөт шалгалт	Системийн шалгалт	Төлөвлөгөөт бус шалгалт		
2016	14	-	-	14	10.5
2017	33	-	-	33	74.8
2018	32	8	4	44	74.3
2019	23	0	1	24	41.3
2020	19	7	7	33	21.86
2021	11	11	6	28	304.56
2022	45	11	6	62	1,278.0
Нийт дүн	177	37	24	238	1,805.3

2016-2022 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газар, улсын төсөвт нийт 238 байгууллага (давхардсан тоогоор)-ыг төрийн өмчийн хяналт шалгалтад хамруулсан бөгөөд шалгалтын дүнд 1,805.3 тэрбум төгрөгийн зөрчил, алдаа дутагдлыг илрүүлжээ. 2021 оны зөрчлийн дүнд Засгийн газрын 2020 оны 48 дугаар тэмдэглэл, Сангийн сайдын удирдамжийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хийсэн төлөвлөгөөт бус шалгалтаар илрүүлсэн 290.6 тэрбум төгрөгийн зөрчил, 2022 оны зөрчлийн дүнд Засгийн газрын 2022 оны 148 дугаар тогтоол, 24 дүгээр тэмдэглэлийн дагуу төрд буцаан авсан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн өмнөх 8.5 жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илрүүлсэн 1.2 их наяд төгрөгийн зөрчил, мөн Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоолын дагуу “Цемент шохой” ТӨХК-д хийсэн шалгалтаар илрүүлсэн 43.4 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлын дүн тусгагдсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дахин гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авахын зэрэгцээ төрийн өмчийн үр ашгийг

нэмэгдүүлэх, эрсдэл болон зардлыг бууруулах талаар дүгнэлт гаргаж, шалгалтын тайланг тус газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол, шийдвэрт тусгадаг. Мөн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох байгууллагад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажилладаг. Тайлант хугацаанд санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх асуудлыг тусгасан нийт 146 арга хэмжээ бүхий үүрэг даалгавар, 141 арга хэмжээ бүхий зөвлөмж өгч ажиллажээ.

Төрийн өмчийн хяналт шалгалтын дүнд илэрсэн түгээмэл зөрчил дутагдлуудаас дурдвал:

- төлөвлөгөөгүй болон зориулалтыг нь өөрчилсөн худалдан авалт хийсэн;
- үргүй зардал гаргасан;
- зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгө;
- түрээсийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- газар эзэмших, ашиглах эрхээ үнэлж, санхүүгийн тайланд тусгаагүй, эзэмших эрхийн газартай холбоотой зөрчил гаргасан;
- төрийн өмчийн эд хөрөнгөтэй холбоотой тогтоол шийдвэрийн биелэлт хангалтгүй;

- төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлсэн;
- баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн.

Дээрх түгээмэл зөрчил дутагдлаас дүгнэхэд Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж, Төрийн болон орон өмчийн тухай хууль тогтоомж, Төсвийн тухай хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолыг зөрчсөн зөрчил дийлэнх хувийг эзэлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2016-2022 онд төрийн өмчийн эд, хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын байдал болон төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнд зөрчил, дутагдал гарган хохирол учруулсан, буруутай шийдвэр гаргасан зэрэг холбогдох хуулийн этгээдийн удирдлагад Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн акт, албан шаардлагыг хүргүүлж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулах, хохирол барагдуулах арга хэмжээ авсан. Төрийн өмчийн хяналт шалгалтын ажлын үр дүнгээс дурдвал:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын Бээжин хот дахь төлөөлөгчийн газрын 112 м.кв бүхий конторын барилга, 120 м.кв бүхий орон сууцыг БНХАУ-ын хууль хяналтын байгууллагаар шийдвэр гаргуулан Монгол Улсын төрийн өмчид авах, АШУҮИС-ийн эзэмшлийн 66.4 м.кв газрыг бусад хуулийн этгээдийн эзэмшлээс чөлөөлүүлэх, МУИС-ийн 391 м.кв газар, 6 орон сууц, 2 гараашийг буцаан авах, ШУТИС-ийн 158 м.кв сургалтын талбайг чөлөөлүүлэх, шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн хуримтлагдсан, хугацаа хэтэрсэн авлагыг 776.1 сая төгрөгөөр бууруулах гэх мэт асуудлуудыг шийдвэрлүүлсэн.

- Улсын төсөвт нийт 815.8 сая төгрөгийн төрийн өмчийн ногдол ашиг болон түрээсийн орлогыг нөхөн төвлөрүүлсэн. (2016-2020 онд нийт 382.8 сая төгрөгийн орлого, 2021 онд 243.0 сая төгрөгийн орлого, 2022 онд 190.0 сая төгрөгийн орлого)
- “Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь хариуцсан ажилдаа алдаа гаргаж, үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн ерөнхий

нягтлан бодогчийг ажлаас чөлөөлсөн.

- Монгол Улсын Консерваторын хашаанд байрлах хариуцах эзэнгүй зар сурталчилгааны самбарыг буулгаж, төрийн өмчийн газар, талбайг чөлөөлсөн.
- Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн хөдөлмөрийн гэрээ, өгсөн үүрэгт ажилдаа хайнга хандсан үндсэн хөрөнгийн нярав, эргэлтийн хөрөнгийн няравт сануулах сахилгын шийтгэл ногдуулан, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авсан.
- “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨААТҮГ нь “И Эс Энержи” ХХК-аас техник хяналтын үлдэгдэл төлбөр болох 170.0 сая төгрөгт дүйцүүлж хүлээн авч, “Module Tester” хэмжилтийн тоног төхөөрөмжийг гэрээлэгч талд буцаан өгч, 170.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар Баянгол дүүргийн иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд төрийн өмчийн үр өгөөжийг сайжруулах ажлыг зохион байгуулсан.

Мөн тус газар нь төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах хүрээнд төрийн өмчит байгууллагуудтай “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г байгуулан жил бүр дүгнэж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Уг ажлыг хэрэгжүүлэхдээ 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”, 2020 оны 715 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, аргачлал”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх, сунгах, шинэчлэн байгуулах ажлыг гүйцэтгэсэн байна. Уг гэрээнд талуудын үүрэг, хариуцлагыг тусган биелэлтийг жил бүр дүгнэдэг.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дараах 5 үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг. Үүнд:

1. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал (Үл хөдлөх хөрөнгөтэй бол 30 оноо, үгүй бол 25 оноо);
2. Хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлт, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналын байдал (40 оноо);
3. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал (10 оноо);
4. Газар эзэмших, ашиглах эрхийн байдал (Үл

хөдлөх хөрөнгөтэй бол 10 оноо, үгүй бол 0 оноо);

5. Гэрээ дүгнүүлэх бэлтгэл хангасан байдал (10 оноо).

Хүснэгт 3.2. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байдал.

Он (гэрээний он)	“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэсэн он	“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнүүлсэн байгууллагын тоо	Улсын дундаж үнэлгээ (хувь)
2016	2017	923	90.9
2017	2018	801	90.8
2018	2019	972	92.1
2019	2020	961	94.1
2020	2021	985	93.03
2021	2022	1030	85.3
6 жилийн дундаж:		944	91.0

(Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу уг гэрээг 2020, 2021 онд цахимаар шинэчлэн байгуулах, 2020 оны гэрээг дүгнэхэд шаардагдах баримт, материалыг цахим хэлбэрээр хүлээн авч, дүгнэсэн бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулсан.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэсэн дүнг жил бүр Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцэн цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гарган хэрэгжүүлж ажилласан байна. Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулдаг. Тухайлбал, хяналт шалгалтын мөрөөр Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол гарч, уг тогтоолын хэрэгжилтийг хангажээ.

Хүснэгт 3.3. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийн үнэлгээ.

Он (гэрээний он)	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын нийт тоо	Үүнээс:		
		“Сайн” үнэлгээ авсан (96-100 хувь)	“Хангалттай” үнэлгээ авсан (76-95 хувь)	“Хангалтгүй” (75 болон түүнээс доош хувь)
2016	923	721	202	-
2017	801	708	90	3
2018	972	904	63	5
2019	961	182	779	-
2020	985	213	752	-
2021	1030	168	861	1

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн 4 дүгээр улиралд багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг эрхлэн явуулж, дүнг нэгтгэн гаргаж,

уг хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу дүнг Засгийн газар, УИХ-д танилцуулах үүрэгтэй. Төрийн өмчийн хороо байгуулагдаж, төрийн өмчийн анхны үзлэг, тооллогыг 1997 онд хийж гүйцэтгэснээс хойш хуулийн дагуу 4 жил тутамд 1 удаа буюу 2001, 2004, 2008, 2012, 2016 онд тус

тус уг ажлыг улс орон даяар зохион байгуулж, дүнгээ Засгийн газар, УИХ-д тайлагнан түүний мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. 2020 онд зохион байгуулах ёстой байсан улсын үзлэг тооллогыг (Ковид-19)-ын цар тахлын улмаас Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогод нийт 6614 нэгж байгууллага (хуулийн этгээд)-ын хөрөнгө хамрагдсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд нийцүүлэн зөвхөн төрийн болон орон нутгийн өөрийн өмчийг тооллогод хамруулжээ.

Хүснэгт 3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хамрагдсан байгууллагууд.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, харьяа дээд байгууллага	Санхүүгийн тайлан гаргасан нэгжийн тоо	Хуулийн этгээдийн гэрчилгээтэй нэгжийн тоо	Гэрчилгээгүй нэгж	
				ТЕЗ-ийн дотоод сан	төсөл
1	Төрийн өмчийн дүн	1273	1153	4	116
2	Орон нутгийн өмчийн дүн	5341	4331	1010	
	Нийт дүн	6614	5484	1014	116

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тасалбар болгосон 91,798.55 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө хамрагдсанаас 39,737.23 тэрбум төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна гэсэн дүн гарсан.

Хүснэгт 3.5. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хамрагдсан хөрөнгө.

Өмчлөгч	Тооллогод хамрагдсан нийт хөрөнгийн дүн /тэрбум төгрөг/		Өөрийн өмчийн цэвэр дүн /тэрбум төгрөг/	
	2015.12.31	2021.12.31	2015.12.31	2021.12.31
Орон нутаг	4,387.4	11,901.70	3,839.27	10,305.36
Төр	25,687.5	79,896.85	12,425.38	29,431.86
НИЙТ ДҮН	30,074.9	91,798.55	16,264.65	39,737.23

Төрийн болон орон нутгийн өмчийн зарим хөрөнгийг хувьчилсан боловч 2018 онд хийгдсэн хөрөнгийн дахин үнэлгээ, жил жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламжийн үр дүнд нийт хөрөнгийн дүн нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Орон нутгийн өөрийн өмчийн цэвэр дүн 6,423.83 сая төгрөгөөр, төрийн өөрийн өмчийн цэвэр дүн 17,006.49 сая төгрөгөөр тус тус өсөж, нийлбэр дүнгээрээ 39,737.23 сая төгрөгт хүрчээ.

Улсын үзлэг, тооллогын дүн, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах

арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангуулахаар тогтсон. Уг арга хэмжээний хүрээнд улсын үзлэг, тооллогын мөрөөр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, мэдээллийн санг бүрдүүлж, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Улсын үзлэг, тооллогоор илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах асуудлаар цаашид авах зарим арга хэмжээний талаарх дүгнэвэл:

- Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон түүнийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах мэдээ мэдээллийг ашиглах, тооллогын үр дүнд үүссэн

мэдээллийн баазыг програм хангамжийн тусламжтай Улсын бүртгэлийн ерөнхий газрын дундын мэдээллийн санд байршуулах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай.

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, цахим бүртгэлд бүрэн хамруулах, үнэлгээгүй байгааг үнэлж, санхүүгийн тайланд тусгах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай хамтран хэрэгжүүлэх боломжтой юм.
- Төрийн болон орон нутгийн өмчид хамаарах автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, тэдгээрийн санхүүгийн тайлан дахь бүртгэлийн уялдааг сайжруулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллах, мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь шинэчилж байх шаардлагатай байна.
- Төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх, татан буулгахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдээгүй, хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөнийг төрийн өмчийн бүртгэлд тусгуулаагүй байснаас Улсын бүртгэлийн байгууллага дахь төрийн өмчит хуулийн этгээдийн тоо, нэр их хэмжээний зөрүүтэй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн хүрээнд бий болж буй хөрөнгийг ашиглалтад хүлээн авах тухай бүр эзэмших, ашиглах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллагын данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ аваагүйгээс яамдын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгө орон нутгийн өмчид давхар бүртгэгдэх зөрчил илэрч байгаа тул цаашид ашиглагч байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгч, бүртгэлийг цэгцлэх шаардлага гарч байна.
- Концессын гэрээний хүрээнд төрийн өмчид шилжиж буй хөрөнгийг хүлээн авч тооцоо нийлэх, эзэмших, ашиглах хуулийн этгээд, байгууллагын данс бүртгэлд тусгуулах асуудлыг тухай бүр хийж гүйцэтгэснээр хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах боломж бүрдэнэ.
- Орон нутагт бий болсон Хөгжлийн сан,

Мал хамгаалах сан зэрэг сангуудын санхүүжилтээр бий болж буй хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, хяналт тавих шаардлагатай байна.

- Үйл ажиллагаа нь доголдсон, зогсонги байдалд орсон (Гаалийн “Горхи хад” амралт г.м), үйл ажиллагаа нь хувийн хэвшилтэй давхацсан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагыг татан буулгах, өөрчлөн байгуулах, нэгтгэх, нийлүүлэх зэргээр бүтцийн өөрчлөлт хийх, хөрөнгийг нь шилжүүлэх, худалдах ажлыг зохион байгуулах саналтай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар (Орон нутгийн өмчийн газар), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.1-3. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх /СЯ, ХХМТГ, 2017-2020/

Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг шинэчлэх, нэгдсэн цахим хуудас (цаашид “ШДНЦХ” гэх)-ыг хөгжүүлэх дэд ажлын хэсгийг Сангийн яамны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн А37 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, эрх зүйн орчны шинжилгээ хийсэн. Үүнд:

- Дээрх шинжилгээгээр шилэн дансны харилцааг зохицуулсан нийт 78 заалт

өөрчлөлт орох шаардлагатай гэж үзсэнээс 3 заалт (байгууллагын ангилал, хяналт, хариуцлагатай холбоотой заалтууд)-ыг холбогдох бусад хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Зөрчлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль)-д өөрчлөлт оруулах замаар, 75 заалтыг журамд нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар холбогдох өөрчлөлтийг журамд тусган боловсруулсан.

- Байгууллагын төрөл буюу ангиллыг тодорхой болгохтой холбоотой заалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дагалдах хуулиар батлуулах саналыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг хууль нь Монгол Улсын Их Хурлын 2023 оны чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад туссан болно. Хариуцлагын тогтолцоог иж бүрэн болгохтой холбоотой заалтыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгах саналыг хүргүүлж тус хуулийн 36 дугаар зүйл “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна”, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт “Төсвийн захирагч, энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтан үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол ажлаас халах үндэслэл болно.”, 21.2 дахь заалт “Хууль зөрчсөн үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж тусгаснаар хариуцлагын тогтолцоог илүү тодорхой болгож, төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг бодитоор хангах боломжийг бүрдүүллээ.

Хуулийн шинэчлэлтэй уялдуулан журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам болон шинэчилсэн журмын заалтуудын харьцуулсан судалгааг хийсэн.

Журмын нэмэлт өөрчлөлтийн төсөлд ажлын хэсгийн саналыг тусгаснаас гадна нийт 42

байгууллагын 141 заалтад ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан.

Нэгдсэн цахим хуудсыг хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахуйц, иргэдэд энгийн ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар ШДНЦХ-ыг шинэчлэн хөгжүүлсэн³².

Мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг сайжруулах, цаашлаад системд мэдээлэл оруулах гар ажиллагааг автоматжуулах зорилгоор Сангийн яамны дотооддоо ашиглаж буй Төрийн сангийн И-хуулга, И-баланс, Орон нутгийн хөгжлийн сангийн систем, Эрхийн бүртгэлийн систем, Төрийн худалдан авах ажиллагааны И-тендер, ГТСМТТ³³-ийн Нэгдсэн нэвтрэлтийн систем, Татварын удирдлагын нэгдсэн системүүдтэй веб сервисээр болон шууд холболт хийгдсэн. Шинэчилсэн системд дараах мэдээллийг үндсэн системээс татаж оруулах боломжийг бүрдүүлсэн. Үүнд:

- Төрийн сангийн И-хуулга системээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, орлого, зарлагын гүйлгээний мэдээлэл;
- Орон нутгийн хөгжлийн сангийн системээс ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл;
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээ буюу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах жилийн төлөвлөгөө, тендерийн ерөнхий мэдээлэл;
- Татварын удирдлагын нэгдсэн системээс байгууллагын бүртгэлийн ерөнхий мэдээлэл;
- Эрхийн бүртгэлийн системээс байгууллагын дансны мэдээлэл.

Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагууд нээлттэй өгөгдлийн сангаар дамжуулан тайлан, мэдээллийг олон улсын нээлттэй тоон өгөгдлийн стандартын дагуу өөрийн хүссэн загвараар гарган авах, боловсруулах боломжийг бүрдүүлсэн бөгөөд Шилэн дансны тухай хуулийн дагуу иргэдийн санал гомдлыг цахим хуудсаар дамжуулан хүлээн авах боломжтой болсон.

Улсын Их хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталсан. Уг хуулиар мэдээлэл 32 Төсвийн байгууллагын нэвтрэх хэсэг: <https://info.shilendans.gov.mn/>, Олон нийт хандах холбоос: <https://shilendans.gov.mn/>.

33 Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв.

хариуцагч байгууллага нь нийт 68 төрлийн мэдээллийг байнга, ил тод нээлттэй байлгахаар зохицуулсан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч нь уг хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг цахим хуудас буюу интернэтэд домэйн нэрээр хандах боломжтой веб сайтад байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 201 дугаар тогтоолоор баталсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-аар зохицуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг батлуулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагуудаас санамсаргүй байдлаар 18 байгууллагыг сонгон цахим хуудсанд мэдээллийг ил тод байлгаж байгаа явцад үнэлгээ хийж, үнэлгээний дундаж 43,34% гарсан. Мөн Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг хэлэлцүүлэн батлуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-4. Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах /СЯ, 2017-2022/

Засгийн газрын зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний төсөв, гүйцэтгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилт, гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянаж шийдвэрлэх зорилгын дагуу Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний нэгдсэн цахим систем (ODAMIS)-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн бөгөөд гадаад зээл тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний болон санхүүжилтийн мэдээллийг

олон нийтэд нээлттэй байхаар 2021 оноос хөгжүүлж, шинэчлэл сайжруулалтыг тогтмол хийж байна.

Системийг олон нийтэд инфографик, тайлан хэлбэрээр харах боломжтой хөгжүүлж байгаа бөгөөд санхүүжилтийн цахим үйлчилгээг нэвтрүүлж өгснөөр үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломж бүрдэж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт аймаг, сум бүрд хүрч, бүтээн байгуулалт хийгдэн ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Үүнтэй зэрэгцэн тус сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг бий болгох зорилгоор Сангийн яам орон нутгийн хөгжлийн сангийн “Удирдлага мэдээллийн систем”-ийн бүх модулийн хөгжүүлэлтийг дуусгаж, 2020 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. Тус системд хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлан, хяналт, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, санал хүсэлт, гомдол, олон нийт хандах сайт болон веб гарын авлага гэсэн цэсүүдийг багтаасан. Удирдлага мэдээллийн системийг ашиглалтад оруулснаар иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, тайлан зэрэг мэдээллийг бүрэн авах боломж бүрдэж байна. Түүнчлэн төслийн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байхаар 2021 онд хөгжүүлсэн.

Удирдлага мэдээллийн системд <http://onhs.mof.gov.mn/> вэбсайт болон <http://tusuv-oronnutag.mof.gov.mn/> вэбсайтын үндсэн цэс дунд байрлах «МЭДЭЭЛЛИЙН САН» гэсэн холбоосоор дамжин хандах боломжтой боллоо.

<http://onhs.mof.gov.mn> нь ОНХС-ийн удирдлагын мэдээллийн сан бөгөөд үүнд 330 сумын баг/хороодын түвшнээс аймаг/нийслэл ОНХС-ийн бүх үе шатны мэдээллийг оруулж ашиглаж явдаг ба үндэсний хэмжээнд нэгтгэгдэж тайлагнахаас гадна үйл ажиллагаанд

хяналт тавихад зориулагдсан санхүүгийн болон төрийн үйлчилгээний улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа холбогдох системүүдтэй холбогдсон систем.

<http://tusuv-oronnutag.mof.gov.mn> нь ОНХС болон ТА-З төслийн талаарх мэдээ, мэдээллийг орон нутгийн иргэд, болон төрийн албан хаагчдад зориулан хүргэх зорилготой төслийн вэб хуудас юм.

ОНХС гар утасны аппликейшн нь ОНХС-ийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэхээс гадна ОНХС-аар хэрэгжүүлэх төслийн саналыг иргэдээс авахад зориулагдсан.

Эдгээр нь мэдээ, мэдээллийг түгээх, иргэдээс санал гомдол авахад адил ашиглагддаг ба дата ашиглалтын хувьд хоорондоо холбогдож УМС-д нэгтгэгддэг. Энэ системд аймаг, нийслэл, сум, дүүргийн мэргэжилтнүүдтэй хамтран 2018-2020 оны түүхэн мэдээллийг нөхөж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 онд <http://onhs.mof.gov.mn/>-д 207,916 хандаж, 207,916 санал өгсөн бол <http://tusuv-oronnutag.mof.gov.mn/>-д жилд дунджаар 3500 удаа ханджээ. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-5. Олон улсын төсвийн түншлэлээс хийгддэг “Нээлттэй төсвийн индекс”-ийн үнэлгээг ахиулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх / СЯ, УАГ, 2018-2022/

“Нээлттэй төсвийн түншлэл” олон улсын байгууллагаас эрхлэн гаргадаг “Нээлттэй төсвийн индекс”-ийн 2017 оны судалгааны дүнгээр Монгол Улс 46 оноо авч, 26 дугаар байрт орж байв. Хоёр жил тутам хийгддэг энэхүү үнэлгээгээр 2021 онд 60 оноогоор үнэлэгдэж, 38 дугаар байрт жагсжээ. Энэ нь Үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн үеэс хойш Монгол Улс даруй 14 оноогоор ахиж, 3 байраар урагшилсан үзүүлэлт юм. Уг судалгаагаар төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 8 баримт бичгийг ил болгохыг шаарддаг бөгөөд 61 ба түүнээс дээш оноо авсан улсыг төсвийн талаар олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох хэмжээнд мэдээллээ ил тод байршуулсан гэж үздэг.

Монгол Улсын хувьд 2019 оны байдлаар улсын төсөв, санхүүгийн 7 баримт бичгийг боловсруулан ил тод байршуулж байсан бол 2021 онд анх удаа улсын төсвийн хагас жилийн

тоймыг бэлтгэж, бусад баримт бичгийн агуулга, иж бүрдлийг боловсронгуй болгох, иргэдийг бодлого төлөвлөлтөд илүү идэвхтэй оролцох боломжоор хангах “Иргэдийн төсвийн цахим хуудас”³⁴-ыг нэвтрүүлэх зэргээр үнэлгээг сайжруулахад анхаарч ажиллажээ. Тухайлбал, төсвийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийг санхүү төсвийг энгийн ойлгомжтой мэдээллээр хангах зорилгоор “Иргэдийн төсвийн эмхэтгэл”, жилийн төсвийн гүйцэтгэлийн улирлын эмхэтгэл, төсвийн төслийн эмхэтгэл зэргийг тогтмол бэлтгэж, Сангийн яамны цахим хуудас, Иргэдийн төсвийн цахим хуудсанд тус тус байршуулах ажлыг хэрэгжүүлж байна.

Мөн цаг үеийн байдлаас шалтгаалан цар тахлын эсрэг Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор “Иргэдийн төсвийн цахим хуудас”-ны “Ковид-19” дэд цэсийн нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн. Энэ хүрээнд цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг хадгалах, малчин өрх болон эмзэг бүлгийн иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний зарцуулалтын мэдээлэл болон хөгжлийн түнш орнуудаас өгсөн гадаадын зээл, тусламжийн дүн, зарцуулалтын мэдээллийг бэлтгэн, уг цахим хуудсанд нийтэлж байв.

34 www.iltod.mof.gov.mn - Уг цахим хуудас нь Нэгдсэн төсвийн мэдээллийг иргэдэд энгийн ойлгомжтой инфографик хэлбэрээр түгээх “Иргэдийн төсвийн цэс”; төсвийн баримт бичгүүдийг нийтлэх “Төсвийн эрхзүйн орчин цэс”; иргэдэд зориулсан эмхэтгэл, видео сантай “Иргэдийн боловсрол цэс”, төсвийн тоон мэдээлэл, дата татах боломжтой “Төсвийн мэдээллийн сан цэс”, төсвийн байгууллагуудад бараа, ажил, үйлчилгээ үзүүлж буй бэлтгэн нийлүүлэгчдийн мэдээллийг үйлчилгээ хүлээн авсан байгууллага, эдийн засгийн ангилал, гүйлгээний утга, мөнгөн дүнгээр хайх боломжтой “Хайлтын цэс” зэргээс бүрдэж байна.

Хүснэгт. Монгол Улсын “Нээлттэй төсвийн индекс”-ээр үнэлэгдсэн байдал.

Он	Нээлттэй төсвийн индексийн оноо	Нээлттэй төсвийн индексээр эзэлсэн байр
2006	18	-
2008	36	-
2010	60	Олон улсын дундаж оноо 42
2012	51	Олон улсын дундаж оноо 43
2015	51	Олон улсын дундаж оноо 47
2017	46	Олон улсын дундаж оноо 42
2019	56	41 дүгээр байр /117 орноос/
2021	60	38 дугаар байр /120 орноос/

Түүнчлэн иргэдэд зориулсан төсвийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн яамнаас 2010-2021 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг Дэлхийн банкны BOOST мэдээллийн сангийн загвар файлын дагуу боловсруулсан. Эдгээр түүхэн мэдээллийг “Иргэдийн төсвийн цахим хуудас”-ны “Төсвийн мэдээллийн сан” цэсэд байршуулж, олон нийт ашиглах, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлээ.

Мөн Төрийн аудитын байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлж, аудитад иргэд, харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлж, аудитын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөө”-г, 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ийг тус тус батлан хэрэгжүүлсэн. Эдгээр баримт бичгүүд нь иргэд, оролцогч талууд болон төрийн аудитын байгууллагуудын хооронд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжих, аудитын үр өгөөж, үр дүнг дээшлүүлэхэд зохих хувь нэмрээ оруулжээ. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-6. Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2018-2022/

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар

зүйлийн 6.3.5-д “6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”-ыг тогтмол мэдээлж байхаар заасны дагуу төсвийн байгууллагууд хандив, тусламжийн санхүүжилтийн зарцуулалтын мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулж ажиллах үүрэгтэй.

Мөн “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор хувь хүн, хуулийн этгээдээс эрүүл мэнд, онцгой байдлын байгууллагуудад өгсөн мөнгөн болон материал хандив тусламжийн орлого, түүний зарцуулалтын мэдээг сар бүр Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулж байхаар тус цахим хуудаст шинээр цэс үүсгэж, холбогдох мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-1. Улсын болон орон нутгийн төсөвт хөндлөнгийн байгууллага, эрдэмтэн, судлаачаар санхүүгийн шинжилгээ хийлгэх боломжийг судлах, холбогдох арга хэмжээг авах /СЯ, 2017-2019/

Төсвийн бодлогын чиглэлээр бие даасан, хараат бусаар мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гарган Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулагдсан. Энэхүү зөвлөлийн ажиллах дүрмийг УИХ-ын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан. Энэ Зөвлөл нь дарга болон орон тооны бус 8 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос 2, Засгийн газраас 2, Монголбанкнаас 2 хүнийг нэр дэвшүүлж, хараат бус 3 гишүүнийг Төсвийн байнгын хорооны ажлын албанаас нээлттэй сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлж,

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос томилдог. Тус Зөвлөл нь Сангийн яамнаас боловсруулсан төсвийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж, хуулийн төслийн цахим хуудсанд байршуулсны дараа Зөвлөлийн дүрмийн 3.1-д заасны дагуу судалгаа, шинжилгээ хийж, зөвлөмж гаргадаг. Эдгээр зөвлөмжийг УИХ-ын цахим хуудаст нийтэлдэг.

Монгол Улсын холбогдох төрийн байгууллагууд олон улсын байгууллагуудын тусламжтайгаар төсвийн бодлогод эрдэмтэн судлаачдаар дүн шинжилгээ хийлгүүлэх ажлыг зохион байгуулж иржээ. Тухайлбал, Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд олон улсын зөвлөх 2019 оны 4 дүгээр ажиллаж, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-д зөвлөгөө өгч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын замын зураглал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.

Сангийн яам нь Дэлхийн банкны “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-тэй хамтран орон нутгийн засаг захиргааны түвшинд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хэрхэн хангаж байгаа талаар болон орон нутгийн төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр засаг захиргааны үйл ажиллагаанд үнэлгээ хийх замаар зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

Мөн НҮБХХ-өөс 2020 онд Орон нутгийн чиг үүрэг, төсвийн орлого, зарлага, зарцуулалтын талаарх судалгааг бодлогын судлаачдаар гүйцэтгүүлж олон нийтэд танилцуулсан. Судлаачид нь 2023 оны төсвийн орлого төлөвлөлт бодитой бус, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт оновчгүй байгаад анхаарах, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг ирэх оны төсвийн тухай хуулиас тусад нь хэлэлцэх шаардлагатай зэрэг болон бусад зөвлөмжүүд өгснийг холбогдох байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн төсөв, санхүүд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуухоолойг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төсвийн Зөвлөл”-ийг Нээлттэй Нийгэм Форумас санаачлан 2021 оны 3 дугаар сард байгуулсан. Төсвийн Зөвлөл

нь хараат бус 8 шинжээчээс бүрдэж буй бөгөөд улсын төсөв, санхүүгийн асуудлаар тогтмол хэлэлцэн, бодлогын шинжилгээ хийж, үр дүнг бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд, олон нийтэд хүргэх зорилготой ажилладаг. (Биелэлт 70 хувь)

4.1.3.2-2. Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх /СЯ, 2017-2022/

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д заасан “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих”, 12.1.16-д “төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтад хамрагдсан хугацаа, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн хэмжээ, түүнийг барагдуулах талаар зохиосон ажил зэргийг харгалзан хяналт шалгалтад хамрагдах байгууллагыг сонгож, санхүүгийн хяналт шалгалт хийж байна.

Хүснэгт. Сангийн яам³⁵-аас хэрэгжүүлсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, тэдгээрийн биелэлт.

Он	Төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо	Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоо	Өгсөн зөвлөмжийн тоо	Биелэлт
2017	14	13	128	93%
2018	16	10	139	89%
2019	19	5	93	91%
2020	5	11	44	100%
2021	12	8	44	100%
2022	12	10	165	70%

Үндэсний хөтөлбөр хэрэгжсэн 2017-2022 оны хооронд Сангийн яамнаас төрийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудад төлөвлөгөөт 78, төлөвлөгөөт бус 57 удаагийн хяналт шалгалт явуулж, нийт 613 зөвлөмж хүргүүлжээ. Энэ нь тус яам нь холбогдох байгууллагуудад жилд дунджаар төлөвлөгөөт 13, төлөвлөгөөт бус 9 удаагийн хяналт шалгалт явуулж, 102 зөвлөмж хүргүүлж ажилласан үзүүлэлттэй байна. Зөвлөмжийн хэрэгжилт жилд дунджаар 90.5 хувьтай байв.

Хүснэгт. Сангийн яам³⁶-аас явуулсан хяналт шалгалтын хүрээнд тавьсан акт, албан шаардлага, тэдгээрийн биелэлт.

Он	Тавигдсан акт /сая төгрөг/	Албан шаардлага /сая төгрөг/	Биелэлт /сая төгрөг/
2017	3,026.5	114,241.6	117,633.5
2018	27,121.8	266,464.7	271,189.3
2019	525.5	353,340.9 төгрөг, 879 мянган ам.доллар	353,416.6
2020	38.2	536.8	275.0
2021	24,455.4	60,146.1	25,717.3
2022	1,727.6	1,959.8	1,509.5

Мөн тайлант хугацаанд Сангийн яамнаас явуулсан хяналт шалгалтын үр дүнд 56 тэрбум 895 сая төгрөгийн акт тавигдаж, нийт акт, албан шаардлагын мөрөөр 769 тэрбум 741 сая төгрөгийг төлүүлжээ.(Биелэлт 70 хувь)

4.1.3.2-3. Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, давхардлыг арилгах /СЯ, 2017-2019/

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.5 дах заалт “Дотоод аудитын чанарын хяналтын үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны

дагуу Сангийн сайдын 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”, 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг тус тус боловсруулан баталжээ.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д “Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төсөл”-ийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг

35 Сангийн яамны Дотоод аудит, хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэс.

36 Мөн хэлтэс.

байгуулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон боловч 2022 онд Засгийн газар дахь хяналтын тухай хууль батлагдсантай холбогдуулан уг ажил хойшлогдсон. Дотоод аудитын хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Хоёроос дээш байгууллагыг хамруулан дотоод аудитыг хэрэгжүүлэх тохиолдолд дотоод аудитын жилийн төлөвлөгөөг тухайн байгууллагуудын дотоод аудитын жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.”, мөн 18.6-д “Дотоод аудитын нэгжийн дарга, эсхүл дотоод аудитор жилийн төлөвлөгөөгөө харьяалах дотоод аудитын нэгжийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулна.” гэж тус тус заасан.

Сангийн яамнаас дотоод аудитын үйл ажиллагааны давхардлыг арилгах чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн тушаалаар Улсын төсвөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний барилга, байгууламж, захиалагчийн техник, хяналтын байдалд дотоод аудит, хяналт шалгалтыг хийх удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу Барилга, хот байгуулалтын яам, Хөвсгөл, Завхан, Төв, Дорноговь, Сүхбаатар аймгуудын дотоод аудитын нэгжтэй хамтран хийж гүйцэтгэсэн.

Улсын салбарын 86 байгууллага, 450 дотоод аудитор, санхүүгийн хяналт, шалгалтын байцаагч нар оролцсон зөвлөгөөнийг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх нэгжүүдтэй төлөвлөгөөг уялдуулах, нэг байгууллагад нэг цаг хугацаанд хяналт шалгалт хийж шалгалтад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх, ажлын уялдаа холбоог хангахыг зөвлөсөн.

Сангийн сайдын 2021-2022 онд баталсан удирдамжийн дагуу яам, аймаг, нийслэлийн Дотоод аудитын нэгжийн дотоод аудитын 2020-2022 оны үйл ажиллагаанд чанарын үнэлгээг цахим болон газар дээр биечлэн хийж, стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн тусалж ажилласан.

“Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-д Сангийн яамнаас чанарын үнэлгээг ТЕЗ-ийн дотоод аудитын албанд 2 жил тутамд

1 удаа, харин тухайн дотоод аудитын алба нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр зохицуулсан нь дотоод аудитын ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх ач холбогдолтой байна. Тус чанарын үнэлгээгээр хяналт, шалгалтын давхардлын бууруулахдаа жилийн төлөвлөгөөнд бусад хяналт шалгалт, хөндлөнгийн аудитын байгууллагаас санал авч, хамтарч ажиллах зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.

Улсын салбарын дотоод аудитыг Олон Улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, Засгийн газрын зөв, үр дүнтэй дотоод аудитын тогтолцоог бий болгох, мэргэшсэн дотоод аудитортай болох, тэдгээрийн үр дүнд төрийн үйлчилгээ чанар, хүртээмжийг системтэй, алсын хараатай улсын салбарын дотоод аудитаар дамжуулан сайжруулах үүднээс Сангийн сайдын 2023 оны 35 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-г баталсан.(Биелэлт 70 хувь)

4.1.3.2-4. Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулан батлуулах /СЯ 2018-2019/

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7-д “Хууль тогтоомжийн төслийн, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, нэр дэвшигчийн, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой сонсголын нарийвчилсан журмыг энэ хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн Улсын Их Хурал, захиргааны хэм хэмжээний сонсголын нарийвчилсан журмыг энэ хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Засгийн газар баталж болно.” гэж заасны дагуу Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ыг баталсан байна. Уг журмын 1.1-д “Энэ журмын зорилт нь ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах үндэслэл, нарийвчилсан журам, сонсголын дэгийг тогтооход оршино”, 2.4-т “Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага төсвийн хяналтын сонсголыг жилд нэг удаа өөрийн эрхлэх асуудал, хамаарах төсвийн хүрээнд зохион байгуулна” гэж тус тус заажээ. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-5. Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /СЯ, УАГ 2018-2019/

Сангийн яамнаас санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7.3-т “санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон” бол хариуцлага хүлээлгэхээр заасны дагуу санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, Зөрчлийн тухай хуулийн 11.1-д заасан хариуцлага ногдуулах арга хэмжээг авч байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй”, Аудитын тухай хуульд заасан хориглосон заалт болох хуулийн 20.4. “Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх, бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажиллахыг хориглоно”, Аудитын тухай хуульд заасан аудитын хуулийн этгээдэд тавигдах шаардлага болох хуулийн 19.4-т “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх эрхтэй аудитын хуулийн этгээд нь дөрвөөс доошгүй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байна.” гэснийг зөрчсөн нэр бүхий нягтлан бодогч, аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох нөхцөл бүрдсэн.

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх авсан аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн нар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар

тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй” гэсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагын ерөнхий нягтлан бодогч нарт хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдсэн.

Сангийн сайдын 2020 оны 93 дугаар тушаалаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх зорилгоор татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий 21 хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажил явуулж, Сангийн сайдын 2020 оны “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 153 дугаар тушаалаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэн ажилласан.

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, 42.2-т “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж тус тус зааснаар хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин боловсронгуй болсон.

Зарим тохиолдолд санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхэд хуульд заасан хугацаатай холбогдуулан боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 42.4-т зааснаар “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасны дагуу тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад бусад хуульд заасан үндэслэл, журам үйлчлэхгүй.” байх зохицуулалтай болж, хариуцлага гарцаагүй

байх зарчмыг баталгаажуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.3.3-1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах /СЯ, 2017-2019/

Засгийн газрын тусгай сан, бусад төсвийн хөрөнгөөр санхүүждэг сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, хяналт, үр нөлөөг дээшлүүлэх саналыг боловсруулж, улмаар Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоол батлагдсан. Тогтоолоор төсвийн хөрөнгөнөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдлийг Шилэн дансны тухай зэрэг хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан тогтмол мэдээлэх зэрэг нийт 14 арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан

Тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулан, санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох, олон нийтийн оролцоог хангах замаар тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулан 2020 оноос мөрдөж байна. Уг хуулийн “Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт” бүлэгт тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж байхаар тусгасан. Тусгай сангийн хөрөнгийн

зарцуулалттай холбоотой шийдвэр гаргаж, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг shilendans.gov.mn сайтын “Засгийн газрын тусгай сан” цэсэд байршуулж байгаа тул иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломж бүрдсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.3-2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх /СЯ, тусгай санг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан, 2017-2020 он/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 24 болон 25 дугаар зүйлд дараах заалтуудыг тусгаснаар тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Үүнд:

- Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.
- Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19-д заасан тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.
- Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19, 5.3.20-д заасан тусгай сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес

төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

- Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.

Засгийн газрын 2019 оны “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” 87 дугаар тогтоолд сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй

байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх чиглэлээр дараах заалтуудыг тусгасан. Тухайлбал, төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдэл, шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулж мэдээлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх арга хэмжээ авах зэргийг дурдаж болно. (Биелэлт 70 хувь)

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

Хүснэгт. Засгийн газрын тусгай сангуудын төлөвлөлт, гүйцэтгэл 2018-2022

Д/д	Сангууд	ТЭЗ	2018		2019		2020		2021		2022	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Нийгмийн даатгалын сан		1,808,255.22	1,814,624.41	2,068,539.63	2,062,270.03	2,494,043.30	2,449,391.90	2,490,544.50	2,533,004.70	3,328,702.01	94,036.93
2	Нийгмийн халамжийн сан		3,375,584.12	3,258,350.54	6,695,286.45	6,695,286.45	1,643,835.50	1,559,347.90	2,988,344.90	2,849,913.60	482,984.80	548,102.10
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	ХНХС	508,432.00	536,349.83			88,957.21	68.9	198	148.17	83,427.90	73,861.72
4	Хүүхдийн төлөө сан		-	-	-	-	-	-	2021.4.08-ны хуулиар нэмсэн		0	81.7
5	Засгийн газрын нөөц сан		22,500.00	22,379.72	25,000.00	21,626.36	65,000.00	65,000.00	100,000.00	100,000.00	95,000.00	61,178.71
6	Ирээдүйн өв сан	Сангийн сайд	-	-	-	-	-	-	-	-	1,461,737.75	1,488,146.20
7	Төсвийн тогтворжуулалтын сан		-	-	-	-	138,767.10	138,767.10	612,800.00	728,753.00	643,389.30	1,394,643.06
8	Кино урлагийг дэмжих сан		-	-	2019.11.13-ны хуулиар нэмсэн	0*	10,000.00	0*	-	-	0	10,000.00
9	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан	Соёлын сайд	-	-	2019.12.12-ны хуулиар нэмсэн	-	-	-	Үйл ажиллагаа эхлээгүй			
10	Соёл, урлагийг дэмжих сан		18,000.00	17,177.28	20,000.00	19,900.00	-	-	1,846.00	1,840.20	1,511.07	1,337.45
11	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан		59,936.34	62,055.07	34,079.95	34,390.24	51,635.81	23,810.34	21,120.00	810	32,000.00	4,931.77
12	Хөдөө аж ахуйг дэмжих сан	ХХААХУС	-	-	2019.11.13-ны хуулиар нэгтгэсэн		39,039.46	23,173.17	33,898.40	32,617.10	0	38,407,197.21
13	Эрүүл мэндийг дэмжих сан		4,500.00	4,500.00	3,000.00	3,000.00	3,000.00	3,000.00	3,000.00	2,488.40	3,000.00	2,834.64
14	Эрүүл мэндийн даатгалын сан	ЭМС	341,330.50		407,667.30		494,538.30	426,380.10	1,074,303.30	1,200,892.70	1,481,369.20	1,466,823.94
15	Боловсролын зээлийн сан		779,713.54	368,077.24	585,163.93	504,560.78	42,012.29	20,987.56	65,602.50	64,890.80	78,110.11	52,304.42
16	Шинжлэх ухаан, технологийн сан	БШУС	6,139.68	5,268.11	49,024.33	24,313.80	4,377.73	4,023.53	6,271.30	6,199.60	10,113.76	10,010.11
17	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан		6,139.68	5,268.11	49,024.33	24,313.80	10,900.97	6,592.22	65,917.10	63,892.90	90,531.53	18,065.51
18	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	ЕС	20,152.50	19,407.12	1,915.56	1,902.20	3,932.05	3,931.46	3,932.00	3,145.30	4,161.44	3,475.04
19	Спортыг дэмжих сан		22,500.00	21,655.76	20,000.00	18,634.05	-	-	-	-	2,117.85	-
20	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	ХЗДХС	5,346.00	9,125.60	594	49.5	594	411.78	594	347.7	594	493.28
21	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	БХС	36,000.00	22,958.55	35,000.00	28,544.72	35,000.00	19,582.71	35,000.00	34,999.80	35,000.00	31,761.69
22	Улсын авто замын сан	ЗТС	19,349.66	35,932.41	2,149.96	3,690.10	60,800.00	54,282.28	55,000.00	39,267.00	67,100.00	55,621.51
23	Хилийн чанадад байгаа МУ-ын иргэдэд туслах сан	ГХС	224	223.99	224	223.99	224	216.38	194.1	188.9	200	195.51
24	Байгаль орчин, уур амьсгалын сан	БОАЖС	1,693.29	1,401.67	1,881.88	1,756.19	1,351.94	1,121.46	1,026.00	853.1	623.4	513.7

4.1.3.3-3. Тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг олон нийтэд ил тод мэдээлэх /СЯ, 2017-2022/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Засгийн газрын 29 тусгай сангаас 20 тусгай сан үйл ажиллагаагаа явуулахаар анх хуульчлагдсан бөгөөд чиг үүрэг нэгтэй, нэг салбарын 3 санг нэгтгэж, 7 санг татан буулгах зохион байгуулалт

хийжээ. Үүнээс одоогийн байдлаар 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байна.

“Засгийн газрын тусгай сан”-д хийсэн хяналт, шалгалтын ажлын үр дүнд төсөв, санхүүгийн үйл ажиллагаа дахь алдаа, зөрчлүүдийг илрүүлж, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний зөвлөмжийг өгч, акт, албан шаардлагыг хангуулахад анхаарч ажилласан.

Хүснэгт. Сангийн яамнаас Засгийн газрын тусгай санд хэрэгжүүлсэн хяналт шалгалт.

Он	Хяналт шалгалтад хамрагдсан тусгай сангийн тоо	Өгсөн зөвлөмжийн тоо	Тавигдсан акт /тэрбум төг-өөр/	Албан шаардлага / тэрбум төг-өөр/	Биелэлт /тэрбум төгрөгөөр/
2017	2	ЦЕГ-ын ЭЗГХТХ-ийн хүсэлтийн дагуу Сангийн яамнаас шинжээчээр ажиллаж, дүгнэлт гаргасан.			
2018	7	66	26.3	289.4	229.6
2019	13	97	0.1	106.9	1.5
2020	1	АТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Сангийн яамнаас Боловсролын зээлийн санд шинжээчээр томилогдож, дүгнэлт гаргасан.			
2021	1	ХХААХҮЯ-ны сайдын баталсан удирдамжаар ХААД Сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хамтарсан хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг Засгийн газрын хурлаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр ХААД Сангийн өр төлбөр, зээлийн асуудлыг шийдвэрлэн ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цагдаагийн ерөнхий газрын Эдийн засагтай тэмцэх хэлтэст тус тус үүрэг болгосон.			

Дээрх шалгалтын тайлангуудыг Сангийн сайдын дэргэдэх Аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулдаг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж, дэлгэрэнгүй тайланг яамны www.mof.gov.mn вэб сайтад <https://mof.gov.mn/article/entry/tailan-delgerengui> холбоосоор байршуулж, нийтэд ил тод хүргэсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.4-1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах /СЯ, 2017-2022/

Сангийн яам болон бусад байгууллагын зүгээс жил бүрийн Орон нутгийн хөгжлийн сан(цаашид “ОНХС” гэх)-ийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг орон нутагт танилцуулж, аль бүлэг үзүүлэлтийг сайжруулах хэрэгцээтэй байгааг тодорхойлон дүн шинжилгээ хийж ажилладаг. Сангийн яамнаас орон нутагт хэрэгцээтэй байгаа сургалтуудыг цахим болон танхимаар хослуулан зохион байгуулснаар

иргэдийн оролцоотой төлөвлөлт сумдад илт сайжирсаар байна. Түүнчлэн иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж ил тод байдлыг хангах үүднээс удирдлага мэдээллийн системийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Тухайлбал, олон нийтийн оролцоог хангах, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтыг зөвхөн иргэдийн саналыг дагуу зарцуулахад онцгойлон анхаарч, иргэдээс санал авах гар утасны аппликейшн хөгжүүлж ашиглалтад оруулсан. Гар утасны аппликейшнийг 2022 онд нийслэлийн бүх дүүрэг, 21 аймгийн төвийн сумдад амжилттай туршиж санал авсан бол 2023 онд бүх сумдад ашиглан, санал авах зорилт тавьж байна.


Мөн нийслэл, орон нутгийн өөрийгөө удирдах байгууллагын зүгээс шилэн данс, ИТХ болон Засаг даргын Тамгын газрын цахим хуудсуудад орон нутгийн төсвийн төслийг байршуулж, иргэдээс санал авдаг билээ. Доорх хүснэгтэд 2017-2022 оны хооронд Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой иргэдээс авсан саналыг тоог үзүүлэв.

Хүснэгт. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд иргэдээс өгсөн санал.

№	Аймаг	2017	2018	2019	2020	2021	2022	
		Цаасан санал	Цаасан санал	Цаасан санал	Цаасан санал	Цаасан санал	Цахим	Цаасан санал
1	Архангай	9,158	33,137	55,594	61,191	84,717	1,052	89,357
2	Баян-Өлгий	13,577	43,227	44,266	34,752	48,424	193	64,344
3	Баянхонгор	5,558	96,954	136,456	125,300	116,690	6,243	167,489
4	Булган	17,374	30,872	43,607	50,122	49,852	292	59,422
5	Говь-Алтай	15,774	47,792	82,936	79,404	78,248	996	87,566
6	Дорноговь	4,187	31,049	31,714	40,859	39,512	800	62,085
7	Дорнод	23,852	115,219	78,939	49,848	64,206	5,935	197,117
8	Дундговь	21,458	27,818	25,908	30,323	34,666	165	51,272
9	Завхан	16,080	36,834	55,732	43,523	82,244	609	120,521
10	Өвөрхангай	19,752	61,994	134,786	97,148	96,902	1,438	111,415
11	Өмнөговь	71,333	44,955	47,214	64,006	68,671	967	53,467
12	Сүхбаатар	8,545	27,566	43,607	37,121	49,589	631	78,397
13	Сэлэнгэ	22,356	39,358	75,929	70,365	83,155	344	73,141
14	Төв	22,569	36,711	78,682	67,819	59,642	191	66,375
15	Увс	7,873	13,989	31,623	28,819	46,502	23	27,301
16	Ховд	19,090	55,451	79,335	84,429	76,108	452	75,519
17	Хөвсгөл	63,226	83,292	81,215	92,467	99,895	1,066	113,057
18	Хэнтий	18,380	41,145	48,156	61,241	150,984	6,533	193,758
19	Дархан-уул	1,460	24,671	49,305	24,211	31,590	23	34,140
20	Орхон	176,389	55,259	35,259	18,505	39,599	24	48,841
21	Говьсүмбэр	9,695	14,313	16,454	17,470	16,828	14	33,355

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс авсан саналын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгааг доорх графикаас харж болно. Иргэдээс ирүүлсэн саналын тоо “Ковид-19” цар тахлын үед бага зэрэг буурах хандлагатай болсон боловч 2021 оноос хойш өссөн хандлагатай байна. (Биелэлт 100 хувь)

График 3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс авсан саналын тоо.



4.1.3.4-2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх /СЯ, 2018-2022/

Сангийн яам нь 2018 оноос эхлэн иргэн бүрд ойлгомжтой байдлаар “Иргэдийн төсөв” товхимлыг жил бүр болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр файл хэлбэрээр бэлтгэн www.mof.gov.mn болон iltod.mof.gov.mn цахим сайтад байршуулж байна. Иргэдийг санхүү төсвийн мэдээллээр хангах зорилгоор 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, 2019 оны улирлын гүйцэтгэлүүд, 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, 2022 оны 1-12 дугаар сарын гүйцэтгэл, 2020 оны төсвийн төсөл болон батлагдсан төсөв, 2021, 2022 оны төсвийн төслийн Иргэдийн төсөв, 2023 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн Иргэдийн төсөв товхимол, 2021, 2022 оны эхний хагас жилийн эдийн засаг, төсвийн тойм эмхэтгэл, товхимол, 2020 болон 2022 оны төсвийн номыг хэвлэмэл байдлаар, 2021, 2023 оны төсвийн номыг цахим хэлбэрээр Сангийн яамны цахим хуудас, Иргэдийн төсвийн цахим хуудсанд байршуулсан. Уг товхимолд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн талаарх танилцуулга, тоо, баримт, графикийг боловсруулж нэгтгүүлсэн.

Төсвийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийг бодлого төлөвлөлтөд илүү идэвхтэй оролцох боломжоор хангах зорилгоор Иргэдийн төсвийн цахим хуудас (<http://iltod.mof.gov.mn>)-ыг хөгжүүлж, 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс олон нийт ашиглах боломжтой болсон.

Дэлхийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Тогтвортой амьжиргаа-3 төслөөс Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх, орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээнд иргэд, төрийн албан хаагчдад зориулсан 40 төрлийн /брошюр, нугалбар, гарын авлага, журам, комик, зурагт хуудас гэх мэт/ 427,705 ширхэг хэвлэмэл материал, үндэсний болон орон нутгийн түвшинд шинээр бэлтгэх, шинэчлэх байдлаар 63 төрлийн аудио болон видео /мэдээ, нэвтрүүлэг, шторк гэх мэт/ хийж үндэсний болон орон нутгийн телевиз, радио, нийгмийн сүлжээний хуудаснуудаар цацсан. Давхардсан тоогоор орон нутгийн зорилтот бүлгийн дор хаяж 1 сая гаруй хүнд хүрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг жил бүр, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн талаарх мэдээллийг сар бүр www.iltod.gov.mn <https://publicinvestment.gov.mn/> зэрэг сайтад байршуулж олон нийтэд

мэдээлдэг. Мөн улирал болгон шилэн данс дээр төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээлэл байршуулж байна. Үндэсний хөтөлбөр хэрэгжсэн 2016-2022 онд www.il.tod.mn-д нийт 55 удаа мэдээлэл оруулжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд тус сан болон төслийн үйл ажиллагаатай холбоотой нийт шторк, нэвтрүүлгийн хийж, үндэсний болон орон нутгийн түвшинд цацалт хийж, холбогдох тараах материалыг олон нийт болон сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад түгээжээ.

2022 оны 10 дугаар сард УИХ-аас зохион байгуулсан «Төсөв-2023» олон нийтийн хэлэлцүүлэг, түүний салбар хуралдаануудад оролцож, «D Parliament» цахим хуудсаар 794 иргэн санал өгсөн бөгөөд иргэдийн санал хүсэлтэд тайлбар бэлтгэж, хүргүүлсэн.(Биелэлт 100 хувь)

4.1.3.5-1. Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах/Монголбанк, 2017-2020/

“Ковид-19” цар тахлын үеэр Монгол Улсын Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт тогтоож, хөл хорио тогтоосон үед аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хумигдаж, өрхүүдийн орлого тасалдах, улмаар банк, санхүүгийн салбарт төлөх зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учрах нөхцөл байдал үүссэн.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А-122 дугаар, 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А-320 дугаар, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А-423 дугаар тушаалын дагуу эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас 2020 оны 02 дугаар сараас эхлэн эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлүүдийн үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар, зээлийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр сунгахыг банкнуудын гүйцэтгэх захирал нарт зөвшөөрсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд банкнууд 2022 оны эцсийн байдлаар нийт 63,396 зээлдэгчийн 455.4 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан. Энэ нь нийт хэрэглээний зээлийн багцын 5.2%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт. Хэрэглээний зээлд өөрчлөлт оруулсан байдал

Он	Зээлдэгчдийн тоо	Хэрэглээний зээлийн хэмжээ /их наяд төгрөгөөр/
2020	138,535	1.19
2021	113,870	0.90
2022	63,396	0.45

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А-155/134 дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан.

“Ковид-19” цар тахлын улмаас энэхүү журамд түр хугацаагаар өөрчлөлт³⁷ оруулж, хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон активт тогтоох хугацааны ангиллын нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах, гамшгаас хамгаалах бүх

37 Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020.03.19-ний өдрийн А-69 - А-81, 2020.08.10-ны өдрийн А-321 - А-332, 2020.12.08-ны өдрийн А-437 - А-448, 2021.06.30-ны өдрийн А-168 - А-179 дүгээр тушаалаар тус тус түр зохицуулалт хийсэн.

нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хоногийг активт хугацааны ангилал хийхдээ хасаж тооцох, зээлдэгч нь банкандаа хандаж зээлийн эргэн төлөлтийн хуваарьтаа өөрчлөлт оруулах боломжоор хангах, ийм зээлийг журмын дагуу бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй, эцсийн ангиллыг нь өөрчлөхгүй байх зэрэг арга хэмжээг түр хугацаанд буюу 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хэрэгжүүлжээ.³⁸

Монголбанкнаас “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Өр, 38 Энд дурдсан хугацааг МБЕ-ийн 2021.06.30-ны өдрийн А-168 - А-179 дүгээр тушаалаар 2022.03.31-ний өдрийг дуустал сунгаж, зохицуулалтын хэвийн нөхцөлд шилжих хуваарийг баталсан.

орлогын харьцааг тооцох аргачлал”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тус тус холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, зээлийн хугацаа болон бүтцэд өөрчлөлт оруулах, хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнтэй холбоотой мэдээлэл, сургалт, тайлбарыг бэлтгэж хүргэснээс гадна арилжааны банкны харилцагчид зөвлөх ажилтнуудад заавар өгч иргэдэд тэгш мэдээлэл өгөх чиглэлийг өгч ажиллажээ.³⁹

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4, 8, 11 дүгээр сарын ээлжит бус хурлаар “Ковид-19” цар тахлын улмаас орлого буурч, зээлийн эргэн төлөлт хийх боломжгүй болсон зээлдэгчдийн хэрэглээний зээлийн хугацааг макро зохистой бодлогын зохицуулалтаас үл хамааран 12 хүртэлх сараар сунгах боломжийг банк болон зээлдэгчдэд олгов.

Энэхүү хөнгөлөлтийн арга хэмжээ 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжсэн бөгөөд 100,410 зээлдэгчийн 779.3 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн бүтцэд өөрчлөлт орсон. Энэ нь нийт хэрэглээний зээлийн багцын 9.3%-ийг бүрдүүлсэн байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар банкны актив ангилах журамд өөрчлөлт оруулж, ипотека, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээлийн ангилал бууруулах хугацааг уртасгах, бизнесийн зээлийн бүтцийг өөрчлөх боломжийг бүрдүүлэх зэрэг шийдвэрүүд гаргасан. Банкнууд 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1,077 ААН-ийн 1.2 их наяд төгрөгийн бизнесийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгээд байна.

Хүснэгт. Бизнесийн зээлд өөрчлөлт оруулсан байдал.

Он	Зээлдэгчдийн тоо	Бизнесийн зээлийн хэмжээ /их наяд төгрөгөөр/
2020	2,540	2.83
2021	1,752	1.90
2022	1,077	1.21

Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкнууд хамтран Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах шийдвэрийг 2020 оны эхнээс хойш 3 удаа гаргав. Энэхүү хөнгөлөлтийн хүрээнд давхардсан тоогоор 25,176 зээлдэгчийн 2.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй ипотекийн хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулжээ.

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Зээлийн хүүг бууруулах стратеги” баримт бичгийг батлав. Уг баримт бичигт Монгол Улсын санхүүгийн салбар дахь санхүүжилтийн зардлыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал туссан. Энэ хүрээнд “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” чиглэлд

³⁹ Ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан тухайн үеийн нөхцөл байдлыг дордуулахгүйн үүднээс бусад улсын хийж хэрэгжүүлж буй арга хэмжээ, туршлагыг судалсан. Үүний үндсэн дээр холбогдох журмын төслийг боловсруулж, Монголын банкны холбооноос санал авч, нөлөөллийн шинжилгээг хийсэн. Энэхүү өөрчлөлтийн үр дүнд банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаагаа хангах, зээлдэгчид банканд хандан зээлийн төлбөрийн хуваарийг хойшлуулах, зээлийн ангилал нь муудахгүй байх, алданги нэмэгдүүлсэн хүү төлөхгүй байх үр нөлөөг бий болгосон.

тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 329/187 дугаар хамтарсан тушаалаар төрийн болон төрийн бус байгууллага, зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг банкны системд нөлөө бүхий банкнууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулахад шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр зохих ажлыг хэрэгжүүлсэн.⁴⁰

Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос нэр бүхий 10 Банк бус санхүүгийн байгууллагаас зээлийн гэрээг авч, судалгаа хийж, дор дурдсан дүгнэлтийг гаргаад байна. Үүнд:

1. Зээлдүүлэгчийн эрх ашигт илүү давуу байдал олгосон, зээлдэгчийн эрх үүргийг тодорхой сайн тусгаагүй, зээлдэгчийн эрхийг дутмаг тусгасан зэрэг зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүргийг тэгш биш тусгасан;
2. Зээлийн хүүг гэрээнд үндсэн хүүг зээлийн гэрээний эхний хуудсанд, хавсралтад хөнгөлөлттэй хүүг тусгасан зэрэг 2 ялгаатай хүүг гэрээнд тусгасан. Зээлийн гэрээгээ сайн уншиж танилцсан зээлдэгчид хөнгөлөлттэй хүүгийн талаарх мэдээлэлтэй танилцаж үр шимийг нь хүртэж чадна. Харин зээлийн гэрээтэй сайн танилцаагүй зээлдэгчид энэхүү хөнгөлөлттэй хүүгийн талаар мэдэхгүй өнгөрөх зэрэг зээлдэгчийг төөрөгдүүлэх шинж чанартай;
3. Цахим зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй Банк бус санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний нөхцөл, зээлийн гэрээний эрх зүйг хууль тогтоомжоор нарийвчлан 40 Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны А-90/85 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны А-262/262 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”

зохицуулах шаардлагатай;

4. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн гэрээ нь хууль тогтоомжоор заасан гэрээний эрх зүйн ерөнхий заалтуудыг зарим нь хэт дэлгэрэнгүйгээр, зарим нь хэт товчхон, ойлгомжгүй, тодорхой бусаар заасан зэрэг хэт ялгаатай байдлаар зээлийн гэрээг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тиймээс зээлийн гэрээний ерөнхий жишиг загварыг нэгдсэн байдлаар гаргаж, зээлдэгчдэд хэт давуу байдал олгосон зээлийн гэрээ хийхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай;

Мөн цар тахлын санхүүгийн зах зээлд нөлөөлж болзошгүй дам нөлөөг илрүүлэхээр “Шинэ корона вирусийн улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ” судалгааг гүйцэтгэж, иргэд, ажахуйн нэгжүүдийг өрийн дарамтад орох, санхүүгийн байгууллагуудын зээл чанаргүйдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж зээлийн хоршоодын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдүүлсэн.

Ингэснээр 451.5 мянган зээлдэгч 604.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд 380 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 436.9 мянган зээлдэгчийн 468.0 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан байна. Түүнчлэн 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Корона вирусийн халдвараас сэргийлэх “Зохицуулалтын байгууллагуудад хүргүүлэх зөвлөмж”-ийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсаар дамжуулан хүргүүлсэн.

2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах салбарын хөгжлийг дэмжих, мэдлэг олгох техникийн туслалцаа” үзүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулсан. Ажлын хэсгийн зүгээс

хуулийн төслийг 2021 онд хууль санаачлагчид уламжилсан ба 2022 онд УИХ-д өргөн барих бэлтгэлийг хангаж байна.

Уг хуулийн төслийн онцлог зохицуулалтаас дурдвал:

1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь нарийвчилсан мэдээллээр санхүүгийн хэрэглэгчийг хангах. Мөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа эдгээр мэдээллээр хангаснаа нотолж, хяналтын хуудсаар баталгаажуулах;
2. Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийг эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
3. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл олгохдоо зээлийн хүүг гагцхүү бодит хүүгээр илэрхийлэх, зээлийн бусад нөхцөлийн талаарх мэдээллийг нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх замаар зээлдэгчийг төөрөгдөлд оруулахгүй байх зэргээр зээлийн бодит өртгийг танилцуулах;

4. Санхүүгийн хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж батлуулан, хэрэгжүүлэх;

5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн маргааныг шийдвэрлэх чиг үүргийг бие даасан, мэргэшсэн омбудсман хэрэгжүүлж болох бөгөөд түүний харилцааг хуулиар зохицуулах зэрэг асуудлыг хуулийн төсөлд тусгажээ.

Монголбанк Засгийн газартай хамтран 2013 оноос хойш "Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна. Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, зорилтот бүлэгт илүү чиглүүлэх зорилгоор Монголбанкнаас орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн журамд өөрчлөлт оруулж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 6 хувь байхаар тогтоосон. Тус өөрчлөлтийг оруулснаар зээлийн сарын төлбөрийн хэмжээ буурч, бага орлоготой өрхүүд ипотекийн зээл авах боломж нэмэгдсэн.

Хүснэгт. Ипотекийн зээл олголт.

Он	Ипотекийн зээлийн хэмжээ	Ипотекийн зээлдэгч
2017	353.58	5,585
2018	309.78	4,683
2019	443.29	6,476
2020	368.17	5,122
2021	1,011.95	13,452
2022	732.34	7,847

Санхүүгийн зохицуулах хорооноос зээл авч буй иргэд, аж ахуйн нэгжийн барьцаа хөрөнгийг зах зээлийн ханшаар үнэлж авах, харилцагчдыг хохироохгүй байх зорилгоор «Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам»-ыг боловсруулж байна. Мөн Хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 527 дугаар «Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоох тухай» тогтоолыг баталсан. Ингэснээр нэг харилцагч олон финтек зээлийн аппликейшнээс давхар зээл авч, өрийн дарамтад орохоос сэргийлнэ. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар

тогтоолоор «Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам»-ыг баталсан. Энэ журмын 2.1.1-т «зээлийн бүтээгдэхүүн, зориулалт, жилийн хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг нийтэд ил тод мэдээлдэг байх»; 2.1.2-т «зээлдэгчид зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хүлээх эрх, үүргийг танилцуулдаг байх»; 3.4-т «Зээлийн гэрээг зээлдэгчтэй бичгээр эсхүл техникийн хэрэгсэл, программ хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан цахимаар байгуулж болно.» гэж тус тус заасан. Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны веб сайт дээр нэр бүхий 46 банк бус санхүүгийн

байгууллагын зээлийн хүү, шимтгэлийн мэдээллийг ил тод байршуулсан байгаа. Энэ нь иргэд харилцагчид банк бус санхүүгийн байгууллагуудын хүү, шимтгэлийг харьцуулж сонголтоо хийх боломжийг бүрдүүлсэн.⁴¹

2022 оны байдлаар иргэдэд банк бус санхүүгийн байгууллагуудын мэдээллийг ил тод байлгах зорилгоор зээлийн хүү, шимтгэл, зээлийн бүтээгдэхүүний талаарх мэдээллийн санг үүсгэн нийт 160 ББСБ мэдээг нэгтгэж, МББСБХ-ны www.bbsb.mn цахим хуудаст 47 ББСБ-ын тайланг байршуулжээ.

Мөн банк бус санхүүгийн байгууллагын технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүн гаргахад тавигдах шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрхэн бүртгэх талаарх зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д тусгасан. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 434 дүгээр тушаалаар Цахим зөвлөлийн дүрмийг, мөн өдрийн 433 дугаар тушаалаар Цахим зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан.

2021 оны 10 дугаар сард явуулсан судалгаанд нийт 144 ХЗХ хамрагдаж, нийт гишүүдийн 18.9 хувь буюу 9,151 гишүүн өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлдэг гэсэн үр дүн гарсан. Судалгааны үргэлжлэл болгон Улаанбаатар хотын ХЗХ-дын 200 гишүүнээс 2022 оны 4 дүгээр сарын 11-27-ны өдрүүдэд судалгааг хийхэд зарим гишүүд хамрагдахаас татгалзсан, ХЗХ-ны гишүүнээс гарсан зэрэг шалтгааны улмаас нэр бүхий 53 ХЗХ-ны 175 гишүүн судалгаанд хамрагдсан. Судалгаагаар санхүүжилт, дэмжлэгтэй холбоотойгоор өрхийн болон бичил ЖДҮ эрхлэн явуулахад ямар дэмжлэг, тусламж хэрэгцээтэй байгаа талаар гишүүдийн 68.0 хувь нь хөнгөлөлттэй зээл, тусламж, 52.0 хувь нь санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, 31.4 хувь нь зээл авахад тавигдах шаардлагыг хөнгөлөх, 27.4 хувь нь татварын хөнгөлөлт үзүүлэх, 18.9 хувь нь НӨАТ-аас чөлөөлөх, 12.6 хувь нь эрх зүйн орчин, үйл ажиллагаа эрхлэхтэй

41 http://www.frc.mn/resource/frc/Document/2022/10/14/d9euerxqn23vq0tf/20221014_527.pdf
http://www.frc.mn/resource/frc/Document/2022/05/02/e6iisuvs405z9lu/2022_160.pdf

холбоотой зөвлөгөө, мэдээлэл авах, 10.9 хувь нь сургалт, мэдээлэлд тогтмол хамрагдах хүсэлтэй гэсэн үр дүн гарсан.

- СЗХ-ны Ажлын албаны даргын 2022.04.21-ний өдрийн А/19 дугаар тушаалаар Хороо, ЗБДС, МХЗХҮХ-ны хамтарсан ХЗХ-дыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, хоршооны гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийг батлан даах боломжийг судлах, боломжит шийдлийг тодорхойлох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд холбогдох судалгаа, үнэлгээг хийж, хамтран ажиллах бүтээгдэхүүний нөхцөл, санал холбогдох шийдлийг гарган, ЗБДС-нд 10 ХЗХ-г хамруулахаар тогтсон.

Тус Хороо нь Азийн хөгжлийн банктай хамтран ТА-6883 MON: “Хүртээмжтэй ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийг 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 9 дүгээр сарыг дуустал хэрэгжүүлэхээр тогтсон. Уг төслийн хүрээнд ХЗХ-ын эмэгтэй удирдлага бүхий бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийж, БЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй саад бэрхшээлийг үнэлж тодорхойлно. (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-2. Банк зээл олгоходоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох /Монголбанк, 2017-2019/

Төв банкны зүгээс тухайн зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинэчлэн баталж, банкны салбараас санхүүгийн үйлчилгээ авах иргэд, аж ахуйн нэгжид бодит мэдээллийг хүргэх үүднээс банкнуудын хадгаламж, зээлийн үйлчилгээний зарласан хүү, шимтгэл, бодит өртгийн талаарх мэдээллийг сар бүр Монголбанкны цахим хуудас (Холбоос: <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=0>)-д байршуулдаг. Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам түүнтэй

холбоотой зохицуулалтуудыг сурталчлах, мэдээлэл түгээх ажлуудыг тогтмол зохион байгууллаа. Тухайлбал, сэтгүүлчдэд эдийн засаг, санхүүгийн мэдлэг олгох сургалтын хүрээнд Татварын Ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар болон бусад төрийн болон хувийн байгууллагуудад зээл, зээлийн хүү, шимтгэл сэдвээр сургалт хийв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан “Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу банкны жилийн тайланд харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, харилцагчийн эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийг банкууд цахим хуудсандаа мэдээлж байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зээлийн хүүгийн дээд хэмжээг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл тогтоох зохицуулалтыг тусгасан. Уг хууль 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөнө.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 1.1-д зааснаар Хороо ... “Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасан. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.6-д “Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагуудын хүү, шимтгэлийн хэмжээнд хяналт тавьж ажиллаж байна.⁴² Дээрх хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10-т “Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон

журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Энэхүү журмын 3.13-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасны дагуу зээлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийг үндэслэлгүйгээр өндөр тогтоосон тохиолдолд Хорооноос бууруулах саналыг албан бичгээр мэдэгдэнэ.”, 3.14-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 3.13-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор үйлчилгээний хураамж шимтгэлийн хэмжээг бууруулсан талаарх саналыг буцаан мэдэгдээгүй тохиолдолд Хороо шийдвэрийг хүчингүй болгоно.” гэсэн заалтуудыг оруулсан бөгөөд энэхүү журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Журмын зохицуулалтаар ББСБ нь зээлийн шимтгэл хураамжийг үндэслэлтэй тогтоох, зээлдэгчид зээлийн хүү шимтгэлийн талаар танилцуулдаг байх, гэрээнд тусгагдаагүй шимтгэл хураамж авахгүй байх зэрэг зохицуулалтыг тусгасан.⁴³ Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагуудын хүү, шимтгэлийн судалгааг банк бус санхүүгийн 529 байгууллагаас авсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 287 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Журамд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Хорооноос тогтоосон “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д заасан зээлдэгчид зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл, хүлээх эрх үүргийг танилцуулаагүй, банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлд зайлшгүй тусгах зохицуулалтыг тусгаагүй, зээлийн хүүг шимтгэл, төлбөр хэлбэрээр авах, зээлдэгчээр хүүг урьдчилан төлүүлэх, зээлдэгчээс гэрээнд тусгаагүй шимтгэл хураамж төлөхийг шаардсан тохиолдолд Хороо нь банк бус санхүүгийн

42 <https://legalinfo.mn/mn/detail?law-id=16230554816671>

43 <http://www.frc.mn/frc/o/c/78/d/gc/8387>

үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхээр зохицуулсан.⁴⁴ (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-3. Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх /Монголбанк, 2017-2020/

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт «банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах» гэсэн шинэлэг зохицуулалт орсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А-15 дугаар тушаалаар Санхүүгийн хэрглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагчид уламжилсан бөгөөд улмаар хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-ын даргад өргөн мэдүүлсэн боловч 2020 онд хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасан.

Азийн хөгжлийн банк, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Азийн хөгжлийн банкнаас «Монгол Улсын санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх техник тусалцаа»-ны төслийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөл хэрэгжихтэй зэрэгцээд Монгол Улсад тархсан Ковид-19 цар тахлын улмаас төлөвлөгөөний дагуу хийх ажлууд удааширсан ч Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэг нь хөл хорионы үеэр АХБ-ны техник тусалцааны зөвлөхүүдтэй хамтран Монгол Улс дахь санхүүгийн бүх салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах цогц хуулийн төсөл болох Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу судалгаа, шинжилгээний хамт боловсруулан 44 <https://legalinfo.mn/mn/detail/14909>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Энэ хуулийн төслийг санхүүгийн хэрэглэгчийн эрх, үүрэг, ерийн дарамтаас сэргийлэх, санхүүгийн боловсрол, санхүүгийн омбудсман (санхүүгийн маргаан хянан шийдвэрлэх), мөнгө хүүлэлтийн эсрэг арга хэмжээ, мэдээллийн нууцлал болон хамгаалалт, санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага ба мэдээллийн ил тод байдал зэрэг харилцааг зохицуулсан 10 бүлэгтэйгээр боловсруулсан.

Монголбанкнаас Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит чуулганаар баталж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.2.-д “Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлэх үүрэгтэй.” гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.2.-д “зээлдэгчид зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хүлээх эрх, үүргийг танилцуулдаг байх” зарчмыг баримталж ажиллахыг үүрэг болгосны дагуу 47 ББСБ зээлийн хүү, шимтгэл, зээлийн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг МБСБХ-ны www.bbsb.mn цахим хуудаст байршуулсан. Салбарын нөлөө бүхий, олон харилцагчтай, финтек үйлчилгээ үзүүлж буй 37 ББСБ-ууд нь өөрийн цахим сайт, аппликэйшнээр дамжуулан, Монголын хөрөнгийн биржийн цахим сайтад олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ санхүүгийн болон компанийн засаглал, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр олон нийтэд мэдээлж байна.(Биелэлт 70 хувь)

4.1.3.5-4. Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах /Монголбанк, 2017-2019/

Банкны салбар дахь банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах судалгааг Монгол

Улс болон бусад улс орнуудын туршлагыг судлан боловсруулж, «Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр»-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 9 дүгээр сарын 14-ний А-366 тоот тушаалаар баталсан. Энэхүү банкны шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох, банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд банкиг зөвхөн хувьцаат компани хэлбэртэй үүсгэн байгуулж, үйл ажиллагаа явуулах, банкны хувьцаа эзэмшлийн хувьд аливаа этгээд, түүний холбогдох этгээд банкны нийт саналын эрхтэй хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг тусган, хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганаар хэлэлцэн баталсан.

Банкны системд арилжааны 12 банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанк энэ салбарт тэгш, шударга өрсөлдөөн бий болгох үүднээс нэгдсэн зохицуулалтын орчин бүрдүүлэн ажилладаг. Тухайлбал, Төв банкнаас гаргасан бодлого, журам банкны онцлог, хэмжээ зэргээс үл хамааран ижил үйлчилдэг. Мөн банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож тухайн банкны нэгдлийн оролцогч, өөрийн салбар, төлөөлөгчийн газар зэргээр үйлчлүүлэхийг харилцагчаас шаардахыг хориглосон Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүд буюу санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, зээлийн нөхцөлийн талаар тэгш, хүртээмжтэй

мэдээллийг олгох ажлын хүрээнд Монголын банкны холбоотой хамтран банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргах зорилготойгоор вэб хуудасны дэд бүтцийг 2020 оноос ажиллуулж байна.

Салбарын нөлөө бүхий, олон харилцагчтай, финтек үйлчилгээ үзүүлж байгаа 24 ББСБ-уудын хувьд өөрийн цахим сайт, аппликэйшнээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн Монголын хөрөнгийн биржийн цахим сайтад олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ санхүүгийн болон компанийн засаглал, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр байршуулсан.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус баталсан. Банкны тухай хууль тогтоомжоор банкны системд нөлөө бүхий банкнууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр IPO хийх замаар 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах үүргийг тус тус хүлээсэн. Дээрх системийн банкнууд хөрөнгийн зах зээл дээр IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос Монголбанктай хамтран дараах нэр бүхий журмуудыг батлан мөрдүүлж, тодорхой бодлого, зохицуулалтаар тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам";

- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10

дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөх оруулах зөвшөөрлийн журам” зэрэг болно.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 6 дугаар сарын хуралдаанаар дотоодын аж ахуйн нэгж хөрөнгийн зах зээл дээр IPO хийхтэй холбоотой харилцааг зохицуулж буй “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг зах зээлийн нөхцөл байдал, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталж, нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагааг хялбаршуулж, зардал, өртөг, цаг хугацааг хэмнэх боломжийг бий болгосон. 2021 онд 1 банк, 2022 онд системд нөлөө бүхий 3 банк Санхүүгийн зохицуулах хорооноос IPO гаргах зөвшөөрөл авсан.

Мөн Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан банкны хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээдийн мэдээллийн санг үүсгэх, эрх бүхий байгууллага болон зохицуулалттай этгээдийн хоорондын мэдээлэл солилцох уялдаа холбоог сайжруулах талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Хорооны дарга, Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А-4/02 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.3.5-5. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах /Монголбанк, 2017-2022/

Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг улам боловсронгуй болгохоор тусгасан. Энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 4 дүгээр сард батлуулсан бөгөөд УИХ-ын сонгуулийн дараах шинэ засгийн газар үүссэнтэй холбоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн бичвэрүүдийг гүйцэтгэж бусад шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулж байна. Үнэт цаасны арилжааны горимд олон улсын стандартын дагуу Төлбөрийн-эсрэг-Нийлүүлэлт/Т+2 нэвтрүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 149 дүгээр тушаалаар “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “DvP/Т+2 горим” буюу “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” олон улсын зарчмыг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлийн бусад дэд бүтцийн байгууллагууд болон Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулан ажиллаж холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах ажлуудыг гүйцэтгэсэн.⁴⁵

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоог DvP/Т+2 горимд 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гэхэд шилжиж орохыг зах зээлийн оролцогчдод даалгаж тус өдрөөр DvP/Т+2 горим зах зээлд амжилттай нэвтэрсэн. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээл олон улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмыг амжилттай нэвтрүүлж, гадны хөрөнгө оруулагчид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх таатай орчин бүрдсэн бөгөөд үнэт цаасны арилжаанд ороход шаарддаг байсан 100 хувь мөнгөө байршуулах механизмыг халж, 30 хувийн дэнчин байршуулж арилжаанд оролцох, арилжааны шат дамжлага, зардалбуурч, хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл байдлыг бий болгосон. Уг тогтоолд нэвтэрсэн болон хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлж буй бусад арга хэмжээний хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн шимтгэлийг 0.24 хувь байсныг үнэт цаасны төрөл тус бүрд тохирсон хувь хэмжээгээр буюу 45 Үүний дагуу Банкныг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтын хүрээнд “Банкийг хувьцаат хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 тоот хамтарсан тушаалаар батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн.

хувьцааг цэвэршүүлсэн үнийн дүнгээс (ЦҮД) 0.12 хувь (50 хувиар бууруулсан), Засгийн газрын бонд ЦҮД-ээс 0.00375 хувь, компанийн бонд ЦҮД-ээс 0.0075 хувь болгон тус тус бууруулсан. Ингэснээр зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөл бүрдэх зэрэг эерэг нөлөөтэй юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан Хорооны 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 758 дугаар тушаалаар батлуулсан. Ингэснээр гадаад улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй манай улсын томоохон компаниуд хувьцаагаа давхар арилжаалах, уг ажиллагаатай холбоотой бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх, дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах, бирж хоорондын хувьцааны хөрвүүлэлтийг хийх зэрэг томоохон зохицуулалтын өөрчлөлтийг бий болгох боломжийг бүрдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 253 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам"-ыг Захиргааны ерөнхий хууль болон олон улсын санхүүгийн зах зээлд ашиглагдаж буй хадгаламжийн бичиг гаргах үе шат, дараалал, стандартын дагуу шинэчлэн боловсруулж, Хорооны 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаар тогтоолоор батлуулсан. Дээрх хоёр журам батлагдсанаар гадаадын болон дотоодын зах зээл хооронд үнэт цаас хөрвүүлж арилжаалах, хадгаламжийн бичгийг үнэт цаасанд хөрвүүлэх, бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаанд "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК болон арилжаа эрхлэх байгууллагын үүрэг оролцоо, хариуцлага нэмэгдэж байна.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 85/А-106 дугаар тушаалаар баталсан "Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-ын

10.1 дэх заалтад Кастодиан банк нь хадгаламж хэлбэрээр татсан үнэт цаасны үнийн дүнгээс Монголбанкны тогтоосон хувиар эрсдэлийн сан байгуулах бөгөөд тус эрсдэлийн сан байгуулах хувийг жил бүрийн эцэст Монголбанк шинэчлэн тогтоохоор заасан байдаг. Энэ хүрээнд цаашид хөрөнгийн зах зээлийг дэмжих, кастодианы үйл ажиллагааг өргөжүүлэх, цар тахлын үед банкуудын үйл ажиллагаанд хөнгөлөлт туслалцаа үзүүлэх үүднээс кастодиан үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хэмжээг 2020-2021 онд "0" хувь болгосон.

Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталж, захиргааны хэм хэмжээний актын 2021 оны 06 дугаар 25-ны өдрийн 5333 дугаарт бүртгүүлсэн. Дээрх журамд Хорооны 2013 оны 451, 452, 453 дугаар тогтоолоор баталсан журмуудыг нэгтгэж, үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх этгээдээр Хороонд бүртгүүлсэн хууль, үнэлгээ, аудитын компаниудыг чадавхжуулах, тэдгээрт тавигдах нөхцөл, шаардлагыг олон улсын жишигт нийцүүлж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд санал болгон амжилттай гарах бүтээгдэхүүний тоог өсгөх, хөрөнгө оруулагчдад бодит үнэлгээнд суурилсан үнэт цаасны үнийн талаарх мэдээллийг өгөх чиглэлийн хүрээнд IOS-CO болон бусад олон улсын зөвлөмжийн хүрээнд холбогдох зохицуулалтыг тусгасан. Даатгалын компаниудын үндсэн үйл ажиллагааны нэг болох хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлж олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулах, эрсдэлийг тархах зорилгоор Хорооны 2021 оны 64 дүгээр тогтоолоор "Даатгалын багц дүрэм"-ийн хоёрдугаар хавсралт "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам" болон дөрөвдүгээр хавсралт "Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй

холбоотойгоор “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг боловсруулж, Хорооны 2021.06.11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд улмаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 5334 дугаарт бүртгүүлсэн. “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг боловсруулж, Монгол банкны Ерөнхийлөгч, Хорооны даргын хамтарсан тушаалаар батлуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 302 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөрөнгийн зах зээлийн дундын сан”-ын ажлын хэсгийг байгуулж ажиллаж байна. Үнэт цаасны чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд дээрх нэмэлт, өөрчлөлт орсноор нийтэд санал болгон гаргах аймаг, нийслэлийн үнэт цаасыг гаргах, бүртгэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт бий болсон. “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ыг Хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 275, 276 дугаар тогтоолоор тус тус баталсан. Дээрх журмуудыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 5850, 5851 дугаарт тус тус бүртгэсэн.

Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг Хорооны 2022 оны 6 дугаар 22-ны 360 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Сүүлийн жилүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүд IPO хийх болон хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах замаар хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах идэвх сонирхол ихээр нэмэгдэх болсон. Үүнтэй холбогдуулан Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д үнэт цаас гаргагч хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотой зохицуулалтыг шинээр тусган дээрх

журмын нэмэлт, өөрчлөлтийг Хорооны 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 378 дугаар тогтоолоор баталсан. УИХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан бөгөөд тус хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй ХК-ийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”-ыг батлуулсан.(Биелэлт 70 хувь)

4.1.3.6-1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Сангийн яамнаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Энэ дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Хуулийн төсөлд санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудитуудын хараат бус, бие даасан байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх асуудлыг тусгасан.

Дотоод Аудитуудын Олон Улсын Институтээс 2017 оны 1 дүгээр сард дотоод аудитын баримт бичиг, стандартад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2013 онд гаргаж байсан холбогдох гарын авлагыг шинэчлэн боловсруулж, Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтэд чанарын үнэлгээ хийж ажиллаж байна. Дотоод аудитын олон улсын стандарт болон Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын

аргачлал"-д дотоод аудитын хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулан, зөвлөн туслах чиглэлээр ажиллах талаар дэлгэрэнгүй тодорхойлж өгсөн байдаг.

Мөн улсын салбарын дотоод аудитуудыг тасралтгүй мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор дотоод аудитын сургалтын портал сайт⁴⁶-ыг хөгжүүлж, "Улсын салбарын дотоод аудит" пэйж хуудсыг нээн ажиллуулж байна.

Сангийн яам, Дэлхийн банкны "Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-тэй хамтран "Улсын салбарын дотоод аудитуудын зөвлөгөөн-2020"-ийг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд төрийн 88 байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын нэгжийн дарга, мэргэжилтэн, нийт 450 оролцогч хамрагджээ.

Түүнчлэн Сангийн сайдын 2021 онд баталсан удирдамжийн дагуу 20 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019-2021 оны дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээг анх удаа цогц байдлаар хийсэн бөгөөд уг үйл ажиллагааг "Ковид-19" цар тахлын үед цахимаар зохион байгуулж, дотоод аудитуудыг стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн тусалж ажиллажээ.

2016 оноос Сангийн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулж буй гэрээндороннутгийн санхүүгийн хяналт, аудитын албадын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тусгаж хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Эдгээр гэрээний 2022 оны хэрэгжилтээс харахад аймгуудын Санхүүгийн хяналт, аудитын албадыг тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай орон тоог бий болгож санхүүжилтийг орон нутгийн эх үүсвэрээс шийдвэрлэн ажиллах нөхцөл бололцоог сайжруулах чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулан ажилласан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.6-2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын одоогийн тогтолцоонд шинжилгээ хийх, эрх зүйн орчныг судлах, холбогдох арга хэмжээг авах/СЯ, 2017-2022/

Сангийн сайдын 2017 оны 236, 309 дүгээр тушаалаар Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан дотоод аудитын тогтолцоо болон эрх зүйн орчны судалгааг хийсэн.

Манай улсад улсын салбарын дотоод аудитын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй тул төсвийн сахилга батыг сайжруулах, төсөвт байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, хөгжүүлэх, эрсдэлийн удирдлагаар тогтмол хангахад улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бий болгож, холбогдох хууль эрх зүйн зөв, тогтвортой орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Мөн эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог сайжруулах үүднээс журам, бодлогын баримт бичгийг шинэчлэх ажил хийгдсэн. Тухайлбал, дотоод аудитын хорооны дүрэм, аудитын стратеги төлөвлөгөө болон аргачлал шинэчлэгдэж, дотоод аудитыг олон улсын стандартын дагуу хийж, гүйцэтгэх нөхцөл бүрдсэн. Дотоод аудитын ажлын үе шатыг цахимжуулах, нэгдсэн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр "Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем"⁴⁷-ийн программ хангамжийн техникийн даалгаврыг боловсруулж, үүний дагуу нэвтрүүлэлт, сайжруулалтын ажлыг хийж байна.

Түүнчлэн дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлыг хийжээ. Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах үүднээс 2019 онд Сангийн сайдын 268, 274 дугаар тушаалаар "Улсын салбарын дотоод аудитын аргачлал", "Чанарын үнэлгээний аргачлал" болон "Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам"-уудыг 2019 оны 12 дугаар сард 268, 274 дүгээр тушаалаар тус тус батлуулан, аргачлалуудыг хэвлэж, 2020 оны 10 дугаар сард улсын салбарын бүх байгууллагын дотоод аудитын нэгжид хүргүүлэв. Мөн Сангийн яамнаас "Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам"-д заасан чанарын үнэлгээг Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албанд 2 жил тутамд 1 удаа, харин тухайн ДАА

46 <https://surgalt.mof.gov.mn/>

47 www.audit.mof.gov.mn

нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр зохицуулсан нь дотоод аудитын тогтолцоог сайжруулах, ажлын үр дүнг дээшлүүлэхэд хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.7-1. Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2017-2019/

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, боловсронгуй болгох зорилгоор “Хүлүгү санаачилга” судалгаа шинжилгээний институттэй 2019 оны 12 дугаар сараас 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хамтран ажилласан. Судалгааны баг 2018, 2019 оны төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжөөс түүвэрлэн авч, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд судалгааны дүнд үндэслэн санал дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон зөвлөмж, тайлан боловсруулж ирүүлсэн. Судалгаанд 2018-2019 оны 3,639 төлбөрийн акт, 5,758 албан шаардлага, 16,607 зөвлөмж буюу нийт 26,004 шийдвэрээс

түүврээр 1298-г бүрэн хамруулжээ.

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) болон дээр дурдсан судалгааны ажлын тайлан, зөвлөмжид үндэслэн “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5034 дугаарт бүртгүүлсэн.


Мөн төрийн аудитын байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн суурь системүүд болох 1. Шалгагдагч этгээдийн бүртгэлийн; 2. Хүний нөөцийн бүртгэлийн; 3. Шилэн дансны мэдээний нэгтгэлийн; 4. Статистикийн мэдээний нэгтгэлийн; 5. «Нээлттэй аудит» портал сайт; 6. Санхүүгийн тайлангийн аудитын систем зэрэг системүүдийг амжилттай хөгжүүлээд байна.

Санхүүгийн тайлангийн аудитын системийн хувьд олон улсын стандартын дагуу санхүүгийн аудит хийх бүх процесс үйл ажиллагааг бүрэн цогцоор нь автоматжуулж хөгжүүлсэн бөгөөд жил бүр шалгагддаг 6900 гаруй санхүүгийн тайлангийн аудитын 2021, 2022 оны мэдээллийн санг үүсээд байна. Уг системийг төрийн аудитын байгууллагын аудит хийх эрх бүхий бүх албан хаагчид ашиглахаас гадна аудитын хуулийн этгээдүүд ашиглаж, аудит хийж буй үйл ажиллагааг тухай бүр шивж мэдээллийг оруулж байна.

Хүснэгт. Төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт / тухайн оны 4 дүгээр улирлын байдлаар/

Он	Зөвлөмж	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/	Акт	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/	Албан шаардлага	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/
2017	7694	5963	77.5%	1249	988	79.1%	2152	1812	84.2%
2018	9083	7366	81.1%	1955	1476	75.5%	2871	2076	72.3%
2019	7524	6160	81.9%	1687	1252	74.2%	2889	2371	82.1%
2020	9890	8652	87.5%	1934	1669	86.3%	3313	2851	86.1%
2021	10009	8461	84.5%	2012	1695	84.2%	4958	4233	85.4%
2022	10235	8585	83.9%	2038	1718	84.3%	6959	5707	82.0%

График. Төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт.



Дээрх хүснэгт дэх мэдээлэл болон графикаас үзэхэд төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт тогтмол сайн биелэлттэй байна.(Биелэлт 100 хувь)

4.1.3.7-2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Энэ хүрээнд 2022 онд Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу 2016-2021 онуудад төрийн албанаас халагдаж, шүүхэд нэхэмжлэл гарган хөдөлмөрийн маргаан үүсгэн, шүүхийн шийдвэрээр буцаан ажилд нь томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлс, нөхөн олговрыг олгож, эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг нь нөхөн төлж, дэвтэрт нь нөхөн бичилт хийхийг ажил олгогчид даалгасан шийдвэрийг шүүхээс гаргаж хэрэгжүүлсэн байдал, түүнийг холбогдох хуульд зааснаар хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө, шүүхийн шийдвэр гарсан боловч төлөгдөөгүй авлагыг санхүүгийн тайланд тусгасан эсэх, холбогдох хуульд зааснаар хуулийн этгээдийн дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжээс хохирлыг нөхөн төлүүлэхээр зохион байгуулж явуулсан ажил, түүний явц, үр дүнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн.

Шалгалтын үр дүнд төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар, нийслэл, дүүргийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын

албадын санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчид Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дах заалтыг баримтлан, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх акт тогтоон, хохирлыг барагдуулах, актын биелэлтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллан, үр дүнг нь актын биелэлт хангагдах хүртэлх хугацаанд Сангийн яаманд хагас жил тутамд мэдээлж байхыг үүрэг болгосон.

Уг шалгалтад хамрагдсан хугацаанд төрийн албанаас хууль бусаар халагдсаны улмаас, хөдөлмөрийн маргаан үүсгэж шүүхэд нэхэмжлэл гаргасан 1996 төрийн албан хаагчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, ажлаас үндэслэлгүй халагдсан болохыг нь шүүхээс тогтоон, тэдгээрийн нөхөн олговорт 14.7 тэрбум төгрөгийг ажил олгогчоос гаргуулахаар шийдвэрлэж, 12.2 тэрбум төгрөгийг олгосон байх бөгөөд үүний дотроос 95 албан хаагчид 772.7 сая төгрөгийн нөхөн олговрыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар «Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны нөхөн төлбөрийн данс"-аас олгосон.

Хүснэгт. Хууль бусаар ажлаас халагдсан нь шүүхээр тогтоогдож, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн нөхөн олговрын хэмжээ.

Он	Хууль бусаар халагдсан	Шүүхийн шийдвэрээр нөхөн олгох дүн /сая.төгрөг/	Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлсэн мөнгөн дүн /сая.төгрөг/
2016	383	2,280.1	689.8
2017	443	2,699.9	
2018	415	3,194.2	
2019	288	2,359.6	
2020	186	1,726.5	
2021	281	2,419.8	
Нийт	1996	14,680.1	689.8

Хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн дөнгөж 5.7 хувь буюу 689.8 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 94.3 хувь буюу 11.5 тэрбум төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх тогтолцоо Үндэсний хөтөлбөр хэрэгжих хугацаанд бүрэн бүрдээгүйг харуулж байна. Үүнд дараах саад бэрхшээлүүдийг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Нэгдүгээрт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хэрэгжүүлэх ажилд оролцдог Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх зэрэг байгууллагуудын үүрэг оролцоог хуулиар зохицуулах шаардлагатай. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны зөвлөл төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаж байхаар заасан.

Үүнээс үзэхэд, төрийн тусгай албан хаагчийг

хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал Улсын ерөнхий прокурор газартай хамааралтай байна. Гэвч шүүх дээр маргаан шийдвэрлэгдэх тохиолдолд төрийн нэрийн өмнөөс төрийн хохирлыг барагдуулахаар хуралдаанд оролцож байгаа прокурорын хэргийг буцаах, түүний оронд Төрийн албаны зөвлөл нэхэмжлэх гаргах ёстой гэсэн практик шүүх дээр тохиолдож байна.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллага өөрт учирсан хохирлыг барагдуулах талаар заасан. Хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, хэрэв тийм нэгж байхгүй бол энэхүү үүргийг төрийн аудитын байгууллага хариуцахаар тус тус хуульчилсан. Иймд төрийн үйлчилгээний албан тушаалтан зэрэг төрийн албаны бусад ангилал болон төрийн жинхэнэ албан тушаалтныг албан тушаал бууруулсан, шилжүүлэн ажиллуулсан зэрэг бусад шийдвэрээс болж үүссэн хохирлыг нөхөн төлсний улмаас төрд учирсан хохирлыг аль байгууллага хариуцан шүүхэд нэхэмжлэл гаргах асуудлыг тодорхой болгож, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Улсын Ерөнхий прокурорын газрын хариуцах хэргийн харьяаллыг тогтоох шаардлагатай. Мөн шүүхийн практикт энэ асуудлыг тодорхой тусгах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, Төрийн албаны зөвлөлөөс

хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж байгаа боловч уг харилцаанд дээр дурдсан олон байгууллагууд гар бие оролцдог тул «Төрд учруулсан хохирлын мэдээллийн нэгдсэн сан» үүсгэх шаардлага тулгарч байна. Мэдээллийн нэгдсэн сан үүсгэснээр төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хамтарсан хяналт тавих, оролцогч байгууллагуудыг нэгдсэн мэдээллээр хангах, нөхөн төлөлтөөс цуглуулсан мөнгөн хөрөнгийг зохистой зарцуулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд ач тустай арга хэмжээ болох юм. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлөөс нэхэмжилсэн хохирлын нөхөн төлөлт зөвхөн Төрийн сан дахь Төрийн албаны зөвлөлийн нэр дээр цуглардаг. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-д “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэж заасны дагуу Төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөрт гарах зардлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад суулгаж өгдөг.

Гуравдугаарт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх буруутай албан тушаалтны ажил өөрчлөгдсөн, ажлаасаа гарсан, хаяг байршил нь тодорхойгүй болсон, гадаадад урт, богино хугацаагаар явсан, нас барсан зэрэг олон шалтгааны улмаас хохирол төлүүлэх, захиргааны акт гаргах зэрэг процесс ажиллагаанд хүндрэл үүсжээ. Хариуцагчийн хаяг байршлыг тогтооход нэхэмжлэгч тал Иргэний журмаар нэхэмжлэл гаргах шаардлага үүсдэг нь цаг хугацаа алдах, улмаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хүндрэлтэй байдал үүсгэдэг. Иймд энэ чиглэлээр холбогдох хуульд зохих өөрчлөлтийг оруулах асуудлыг авч үзэх шаардлагатай.

Дөрөвдүгээрт, Сангийн яамнаас явуулсан шалгалтад хамрагдсан хугацааны тоон үзүүлэлтээс үзвэл, 2016, 2017, 2018 онуудад ажлаас халагдсан ажилтнуудын тоо хэмжээ өсөлттэй байгаа нь Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль явагдсаны дараагийн онд нь ажлаас хууль бусаар халагдсан хөдөлмөрийн маргаан үүсгэсэн, шүүхээр маргаанаа шийдвэрлүүлсэн хүний тоо өссөнтэй холбоотой.

Харин Улсын Их Хурлаас баталсан Захиргааны ерөнхий хууль /2017.07.01-ээс мөрдсөн/, болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдсөн хуулиудад албан тушаалтныг хууль бусаар ажлаас халсан нь шүүхээр тогтоогдсон бол тухайн албан тушаалтны ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтан төлөх болсон тул “ажлаас хууль бусаар халагдсан” хүний тоо буурах хандлагатай болсон. Гэвч зөвхөн хууль хэрэгжсэнээр сонгуулийн жилтэй холбоотой ажлаас үндэслэлгүй халагдах, тушаал буурах зэрэг төрийн албан хаагчдад учрах хүндрэл бүрэн арилна гэж үзэх нь өрөөсгөл талтай. Иймд цаашид холбогдох байгууллагууд төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ тогтмол авч байх шаардлагатай байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.7-3. Аудитын дүгнэлтийн мөрөөр хийсэн ажлын үр дүнг хянах, үнэлэх нэгдсэн журмыг батлан мөрдүүлэх /СЯ, 2018-2020/

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах үүднээс 2019 онд Сангийн сайдын 268, 274 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын үнэлгээний аргачлал” болон “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-уудыг тус тус боловсруулан батлуулсан. Тус аргачлалуудыг 2020 оны 10 дугаар сард төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжүүдэд хүргүүлсэн. “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-д зааснаар Сангийн яам чанарын үнэлгээг төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албанд 2 жил тутамд 1 удаа, харин тухайн дотоод аудитын алба нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр зохицуулсан нь дотоод аудитыг ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх ач холбогдолтой байна.

Мөн Дотоод аудитын дүрмийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын

дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасны дагуу дотоод аудиторудын аудитын дүгнэлт, ажлын материалд чанарын баталгаажуулалт хийж,

хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгч байна.

Энэ хүрээнд Сангийн яамнаас тайлант хугацааны туршид дараах тооны дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээг хийж, стандарт, арга зүйн удирдлагаар ханган ажиллажээ.

Хүснэгт. Дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээ хийсэн байдал.

Он	Чанарын баталгаажуулалт хийж, хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгсөн дотоод аудитын нэгжийн тоо	Үнэлгээ
2017	Орхон, Ховд, Дорнод - 3	Хэсэгчлэн нийцсэн-1, нийцээгүй-2
2018	ЭХЯ, ГХЯ, Нийслэл - 3	Хэсэгчлэн нийцсэн-1, нийцээгүй-2
2019	Сангийн сайдын 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх аргачлал”-ыг батлуулж хэвлүүлэн нийтийн хүртээл болгох ажлууд хийгдсэн тул чанарын үнэлгээ тус онуудад хийгдээгүй болно.	
2020		
2021	21 аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба	Хэсэгчлэн нийцсэн-12 Нийцээгүй-2 Үнэлэх боломжгүй-7
2022	13 яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, 10 нийслэл, дүүргийн Дотоод аудитын алба	Хэсэгчлэн нийцсэн-14 Нийцээгүй- 6 Үнэлэх боломжгүй - 3

Арга хэмжээний мөрөөр хийсэн ажлын үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу хийжээ.(Биелэлт 70 хувь)

4.1.3.8-1. Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах /СЗХ, СЯ, 2017-2022/

Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад холбогдох зохицуулалтыг тусгаж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-19.6, 19.4 дэх заалтад заасан нөхцөл шаардлагын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бүх аудитын компаниудад адил түвшний нөхцөл шаардлага тавигдаж байна. Хэрэв гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах бол Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад заасан нэмэлт шаардлага тавигдаж, ажиллах тэгш нөхцөлийг хангуулж байна. Сангийн яамны <https://mof.gov.mn/> цахим хуудасны “Ил тод” цэсийн “Тусгай зөвшөөрөл” дэд цэсэд 2022 оны

байдлаар Улаанбаатар хотод 139, орон нутагт 19 аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд бүртгэлтэй байна.

Мөн даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ явуулах эрхтэй компаниуд, аудиторудын мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудасны “Зохицуулалтын салбарууд” цэс⁴⁸-ийн аудитын компани хэсэгт байршуулан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий байгууллага 40 байсан бөгөөд 2022 онд нэмж эрх олгогдоогүй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийг баталсан бөгөөд энэхүү дүрмийн 7 дугаар хавсралтаар “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах нөхцөл шаардлагыг тогтоож өгсөн. Тус хорооны 2013 оны 451, 452, 453 дугаар тогтоолуудаар баталсан аудит, хууль, үнэлгээний компаниудын бүртгэлийн журмыг IOSCO болон бусад зөвлөмж, зааврууд, мөн холбогдох мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн санал зэрэгт

⁴⁸ <http://www.frc.mn/o/c/562?orderColumn=startedDate>

тулгуурлан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын 11 дүгээр бүлэгт оруулсан бөгөөд уг журмыг Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталж, захиргааны хэм хэмжээний актын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 5333 дугаарт бүртгүүлсэн.

Хүснэгт. Сургалтад хамрагдсан аудиторууд /давхардсан тоогоор/.

Он	Даатгалын байгууллагад аудит хийх аудиторуудад зориулсан сургалт ³		Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудиторуудад зориулсан сургалт ⁴	
	Сургалтад хамрагдсан аудитор	Шалгалтад тэнцсэн аудиторуудын тоо	Сургалтад хамрагдсан хүний тоо	Шалгалтад тэнцсэн хүний тоо
2020	92	46	103	64
2021	63	59	192	162
2022	58	41	81	60

Тус хороо нь Сангийн яамнаас аудитын эрх авсан этгээдэд даатгал болон үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудиторуудад зориулсан сургалт зохион байгуулж, эрх олгодог. Өөрөөр хэлбэл, СЗХ-ноос эрх авсан аудиторууд нь СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан компаниудад аудит хийх эрхтэй болдог аж. Дээрх хүснэгтээс уг сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн аудиторуудыг мэдээллийг үзэж болно. (Биелэлт 100 хувь)

4.1.3.8-2. Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад төрийн захиргааны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах/СЯ, 2017-2018/

Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээлэх тухайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.” гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага өөрөө мэдээлэх боломжтой юм.

Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасны дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд чанарын хяналтыг жил бүр хэрэгжүүлдэг бөгөөд чанарын хяналтын дүнг Сангийн яамны www.mof.gov.mn сайтаар олон нийтэд нээлттэй мэдээлж байна.

Сангийн сайдын 2019 оны 119 дүгээр

тушаалаар аудитын тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар баталсан “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ыг дагуу хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын нэгдсэн дүнгийн шийдвэрийг Сангийн яамны “Ил тод” цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж ажиллажээ. Мөн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Сангийн яамнаас “Тусгай зөвшөөрлийн цахим систем”-ийн цахим хуудас⁴⁹-д байршуулан олон нийтэд мэдээлж ажиллажээ. (Биелэлт 100 хувь)

⁴⁹ <https://license.mn/licensed-organizations>

Хүснэгт. Аудитын байгууллагуудад чанарын баталгаажуулалт хийж, хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгсөн байдал.

Он	Аудитын байгууллагын тоо	Үнэлгээ
2018	56	Хангалтай – 29 Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай – 23 Хангалтгүй – 4
2019	28	Хангалттай – 16 Сайжруулах шаардлагатай – 9 Хангалтгүй – 1 Хяналт шалгалтын явцад тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах хүсэлт гаргасан – 2
2020	-	-
2021	44	Хангалттай – 39 Сайжруулах шаардлагатай – 5
2022	70	Хангалттай – 35 Сайжруулах шаардлагатай – 28 Хангалтгүй – 7

4.1.3.9-1. Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн аудитын тухай(шинэчилсэн найруулга) хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж заасан нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт бий болсон.

Төрийн аудитын тухай хуульд нийцүүлэн “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлуулсан. Журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх зохицуулалтыг тусгасан.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн

тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, илтгэх хуудас бэлтгэж төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга нарт хүргүүлдэг.

Мөн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнд өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 2018-2020 онд нэгтгэн товхимол бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчдад гардуулдаг болсноор харьяа байгууллагуудад нийтлэг илэрдэг алдаа дутагдлыг дээд удирдлагын түвшинд олж харах, тус зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхааран ажиллах, төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг төлөвшүүлэхэд илүү үр дүнтэй байв.(Биелэлт 100 хувь)

4.1.3.9-2. Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах, аудитын байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох /ҮАГ, 2017-2018/

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн

хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүрэг, зарчмыг баталгаажуулсан.

УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэсэн үзэл баримтлалын чиглэл болгон тусгасан. Энэ хүрээнд Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байна. Хуульд төрийн аудитын байгууллагын хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн баталгааг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгахын зэрэгцээ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Энэ хуулийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”, 39.2-т “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.” гэж заажээ. Үүний дагуу Үндэсний аудитын газраас журмын төслийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/93 дугаар тушаалаар баталжээ.

Аудитын дээд байгууллагын хараат бус байдлыг санхүү төсөв, хүний нөөц, үйл ажиллагааны хувьд хараат бус байх гэсэн 3 түвшинд авч үздэг.

Санхүү, төсвийн хараат бус байдал: Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 40 дүгээр зүйл /Эдийн засгийн баталгаа/ ийн 40.1-д “Төрийн аудитын байгууллага улсын

төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана”. 40.4-т “Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасан.

Хүний нөөцийн хараат бус байдал: Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т зааснаар төрийн аудитын байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан тушаалын ангилалд хамаардаг. Төрийн аудитын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д зааснаар Төрийн аудитын байгууллагын албан хаагч тусгайлан тангараг өргөдөг.

Үйл ажиллагааны хараат бус байдал: Төрийн аудитын тухай хуульд заасан чиг үүргээ чанартай, дэлхийн бусад төрийн аудитын байгууллагын жишигт нийцсэн аудитыг гүйцэтгэхэд томоохон үүрэг гүйцэтгэх, үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахад үндэсний стандарттай байхыг шаарддаг. Энэ хүрээнд 2020 онд MNS 6817 : 2020 Төрийн аудитын 8 стандартыг батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага, /ИНТОСАИ/-ын Мэргэжлийн стандартын хорооноос баталсан “Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт” /АДБОУС/-ыг баримталдаг. Энэхүү стандартыг хуулийн шаардлагад нийцүүлэн “Төрийн аудит MNS 6817:2020” стандарт болгон батлуулсан нь Төрийн аудитын байгууллагын бодлого, аудитын арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар үр нөлөөг дээшлүүлэх чухал алхам болжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-3. Удаа дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, дотоод хяналт хангалттай үнэлгээ авсан байгууллагын санхүүгийн тайланд жил бүр аудит хийдэггүй байх нөхцөл, шалгуурыг боловсронгуй болгох /УАГ, СЯ, 2017-2020/

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан холбогдох дүрэм, журам, бусад баримт бичгийг хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн аудитын байгууллагаас тухайн

санхүүгийн жилийн зохих хугацаанд завсрын аудит хийгдсэн, тайлант хугацаанд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт ороогүй, олон нийтийн болон хууль тогтоох байгууллагын анхаарал татсан асуудал хөндөгдөөгүй зэрэг үзүүлэлт шаардлагыг хангасан байгууллагуудыг түүвэрт хамруулан илэрсэн алдаа, зөрчлийг харьяалагдах дээд байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн дүнд оруулж, дүгнэлт өгдөг.

Мөн төрийн аудитын байгууллагаас төсвийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд гадаадын болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа зээл тусламжийн санхүүгийн тайланг аль болох бүхэлд нь хамруулах зорилго тавьж, түүврийн болон итгэл үзүүлэх байгууллагуудын тоог цөөн байлгахыг зорьж байна.

Он	Санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын тоо	Итгэл үзүүлсэн байгууллагын тоо
2017	Нийт хамрагдсан 6213, Бие дааж ⁵ дүгнэлт гаргасан 3179	506
2018	Нийт хамрагдсан 6536, Бие дааж дүгнэлт гаргасан 3806	369
2019	Нийт хамрагдсан 6424, Бие дааж дүгнэлт гаргасан 3958	318
2020	Нийт хамрагдсан 6542, Бие дааж дүгнэлт гаргасан 3825	387
2021	Нийт хамрагдсан 6740, Бие дааж дүгнэлт гаргасан 3906	-
2022	Нийт хамрагдсан 6783, Бие дааж дүгнэлт гаргасан 4069	-

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгад зохих шаардлагыг хангасан байгууллагуудад итгэл үзүүлэх талаарх хуулийн зохицуулалт ороогүй тул өмнө нь хэрэгжиж байсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэх баримтлах журам”-ыг баримталж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.9-4. Төрийн аудитын байгууллага зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах/ҮАГ, 2018-2020 он/

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэх аудитын хуулийн этгээдийг 2017-2019 онуудад худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж байсан бөгөөд “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу ажлын гүйцэтгэлийг үнэлж байв. 2020 онд Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.11 дэх хэсэгт өөрчлөлт орсноор аудитад шинжээч оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах харилцааг уг хуулиар зохицуулахгүй болсон.

Энэ хүрээнд Төрийн аудитын тухай хууль,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн аудитын үйл ажиллагаанд оролцох шинжээчийн сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан зохион байгуулах зорилгоор “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/82 дугаар тушаалаар баталгаажуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4906 дугаарт бүртгүүлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2021, 2022 онд санхүүгийн тайланд аудит хийх аудитын хуулийн этгээдийг болон аудитад оролцох шинжээчийг энэхүү журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, гүйцэтгэсэн ажлыг үнэлж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/92 дугаар тушаалаар “Шинжээч (шинжээч/санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд)-ийн ажлын даалгавар”-ын загвар, “Шинжээч сонгох саналын жишиг баримт бичиг”-ийг тус тус батлан

мөрдүүлж байна. Эдгээр журмын хэрэгжилтийг ханган ажилласнаар төрийн аудитын байгууллага нь зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах нарийвчилсан эрх зүйн зохицуулалт бий болж байна. Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх төсвийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитыг гурван талт гэрээний дагуу хараат бус аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлдэг.

Санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх аудитын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд аудит гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын олонулсын стандарт, УАГ-ын Санхүүгийн аудитын гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, холбогдох бусад эрхзүйн актуудыг мөрдөж хараат бус, авилгаас ангид, ёс зүйг сахиж ажиллахыг тусгасан.

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашигтай аудитыг хийхийн тулд шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ” гэж заасны хүрээнд аудитад шаардлагатай цахим мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх зорилгоор “Санхүүгийн тайлангийн аудитын систем”⁵⁰-ийг цогцоор нь бүрэн ажилд оруулсан бөгөөд олон улсын стандартын дагуу аудит хийх үйл ажиллагааг цогцоор нь автоматжуулсан.

Уг мэдээллийн нэгдсэн системийн суурь системүүд болох 1. Шалгагдагч этгээдийн бүртгэлийн; 2. Хүний нөөцийн бүртгэлийн; 3. Шилэн дансны мэдээний нэгтгэлийн; 4. Статистикийн мэдээний нэгтгэлийн; 5. «Нээлттэй аудит» портал сайт; 6. Санхүүгийн тайлангийн аудитын систем зэрэг системүүдээс бүрдэнэ.

Мөн энэхүү системд жил бүр шалгагддаг 6900 гаруй санхүүгийн тайлангийн аудитын 2021, 2022 оны мэдээллийн санг үүсгэсэн. Уг системийг төрийн аудитын байгууллагын аудит хийх эрх бүхий бүх албан хаагчдаас гадна аудитын хуулийн этгээдүүд ашиглаж, аудит

50 <http://fas.audit.mn/#/>

хийж буй үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр оруулж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.10-1. Төрийн аудитын хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд мэдээлэх/УАГ, 2017-2022/

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор баталгаажуулан тухай бүр байгууллагын албан ёсны цахим хуудас болох audit.mn сайтад ил тод байршуулж, МҮОНРТ, ТВ25, NTV, Ийгл тв, asu.mn, tovch.mn, zuv.mn, ikon.mn, gogo.mn, Зууны мэдээ, Өдрийн сонин, Үндэсний шуудан, Өнөөдөр зэрэг өдөр тутмын сонин, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг.

Үндэсний аудитын газраас Дэлхийн банкны төслийн хүрээнд аудитын тайланг иргэдэд нээлттэй ил тод болгох үүднээс “Нээлттэй аудит”⁵¹ портал сайтыг хөгжүүлэх ажлыг хамтран хийж гүйцэтгэсэн. Уг портал сайт нь визуаль тайлан, статистик мэдээ, тайлан, иргэдийн оролцоо гэсэн 4 үндсэн цэстэй бөгөөд 5 төрлийн визуаль тайлангийн мэдээллийг ухаалаг тайлангийн BI болон flipbook хэлбэрээр харуулж байршуулжээ.

Мөн төрийн аудитын байгууллагын www.audit.mn сайтад “аудитын тайлан” баннерыг хэрэглэхэд амар байдлаар системийн хөгжүүлэлтийг шинээр хийж ашиглалтад оруулснаар иргэд, олон нийт аудитын байгууллагын хийсэн аудитын тайлантай саадгүй танилцах боломжийг бий болгосон. Аудитын тайланг www.audit.mn сайтад байрлуулах хэрэглэгчийн эрхийн тохиргоог тухай бүр хэрэгжүүлж, Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллагуудын хэрэгжүүлсэн аудитын тайланг олон нийтэд мэдээлдэг ажлыг хэвшүүлээд байна. Тухайлбал, «Нээлттэй аудит» портал сайтад 2021 онд 308 аудитын тайлан, 2022 онд 3322 аудитын тайлан, Төрийн аудитын байгууллагын цахим хуудас⁵²-д 2021 онд 2438 аудитын тайлан, 2022 онд 1994 аудитын тайланг тус тус байршуулсан. (Биелэлт 100 хувь)

51 open.audit.mn

52 www.tailan.audit.mn

Хүснэгт. Цахим сайтад байршуулсан аудитын тайлан

Он	Audit.mn-д байршуулсан тайлангийн тоо	Иргэдийн үзэлт, хандалтын тоо	open.audit.mn-байршуулсан тайлангийн тоо	Иргэдийн үзэлт, хандалтын тоо
2019	1004	-	-	-
2020	2933	-	-	-
2021	2438	-	308	11885
2022	1994	-	3322	34196

4.1.3.10-2. Аудит хийхдээ эрсдэлтэй сэдэв, чиглэлийн талаар олон нийтээс санал, судалгаа авах үйл ажиллагааг цахим технологи ашиглан нэвтрүүлэх/ҮАГ, 2017-2019/

Төрийн аудитын байгууллага нь аудитын сэдэв сонголт, чиглэлийн талаар олон нийтээс санал судалгаа авч тусгах, эрсдэлтэй сэдэв сонгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тухайлбал,

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги 2020-2023”-ыг баталсан. Стратегийн зорилтыг хангах хүрээнд 2020-2023 онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Төрийн аудитын үйл ажиллагаа, үр дүнг түгээх арга зүйг хөгжүүлэх;
- Төрийн аудитын үе шатанд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох зэрэг болно.

Төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийг хэрэгжүүлэхдээ төрийн аудитын ил тод, нээлттэй байдлыг хангах зарчмыг удирдлага болгон аудитын тодорхой үе шатанд иргэдийн оролцоог хангах, харилцагч талуудаас мэдээлэл, санал, санаачилга, зөвлөмжийг хүлээн авч, аудитын үр нөлөөг сайжруулах бодлого баримталж байна.

Дээрх стратеги төлөвлөгөөний дагуу аудитын сэдвийн санал хүсэлтийг иргэд, иргэний нийгмийн байгууллагаас цахимаар, судалгаа хийх болон харилцагч талуудтай оролцоот уулзалт зохион байгуулах замаар

хүлээн авах нөхцөл бүрдэж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд иргэдээс Засгийн газрын тусгай сан, газар олголт, байгаль орчин, эрүүл мэнд, “Ковид-19” цар тахалтай холбоотой асуудлыг аудитын сэдэвт хамгийн ихээр санал болгон ирүүлжээ.(Биелэлт 70 хувь)

4.1.3.10-3. Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг болох /СЯ, 2017-2019/

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор,” энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тогтмол мэдээлэх хуулийн зохицуулалт үйлчилж байна. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “энэ хуулийн 3.1.1-д төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу ТЕЗ нарын дэргэдэх дотоод аудитын алба, нэгжүүд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаг.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2020 онд хийсэн аудитаар холбогдох байгууллагууд байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлдэггүй хуулийн

6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нийтлэг илэрсэн. ТЕЗ-дад холбогдох мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан хугацаанд иж бүрэн мэдээлдэг байх чиглэл хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 15 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.4.1-1. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг боловсронгуй болгох үйл ажиллагааг дуусгах /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аас батлан, 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Хуулийн 5 дугаар зүйлд “5.1.25. “Худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог”, “5.1.26. Цахим худалдан авах ажиллагаа гэж цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг”, “5.1.27. “Цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг.” гэж тус тус нэмж тусгасан.

Мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинээр дараах 6 журмыг Засгийн газрын тогтоолоор болон Сангийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна. Үүнд:

1. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
2. “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
3. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаал);
4. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн

- ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” (Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаал);
5. “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал);
 6. “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал);

Энэхүү хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” буюу www.tender.gov.mn-ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулсны зэрэгцээ шаардлагатай хөгжүүлэлтийн ажлыг хийж, уг системийг дагалдах дэд системүүдийг үе шаттай нэвтрүүлэн ашиглаж байна. Тухайлбал, 2019 онд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлж, түүнтэй дагалдах хууль журамд холбогдох өөрчлөлтүүдийг хийж, 2020 онд үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Үүнд:

- Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- Гомдлын процессыг бүрэн цахимжуулж, 2020 оны байдлаар 292 гомдлыг бүртгэсэн;
- Гэрээний гүйцэтгэлийн модулийг ашиглалтад оруулж, системд 19652 гэрээний мэдээлэл бүртгэсэн;
- Тендерийн материалыг тухайн тендерт оролцогчдод цахим системээр дамжуулан хүсэлт гаргаж тендерийн материалтай танилцах боломжийг бүрдүүлсэн;
- Цахим системд тендерт эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг байршуулсан;
- Тодруулгыг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг нэмж бүрдүүлсэн ба 2020 оны байдлаар уг системд 879 тодруулгыг бүртгэсэн;
- Түншлэлийг цахим хэлбэрээр гаргах нөхцөл бүрдүүлж, уг системд 1141 хүсэлт бүртгэгдэж, 769 түншлэлийн гэрээг байгуулсан байна.

2021 онд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн дэд системүүдийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төстийн

ажлыг гүйцэтгэсэн. Мөн цахим системийг ашиглах гарын авлагыг шинэчлэн боловсруулан цахим хуудсанд байршуулж, захиалагч байгууллагуудад түгээжээ. Түүнчлэн тендерийн үнэлгээнд хүний оролцоог багасгах, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийсэн. Үүнд:

- Тендерийн баримт бичигт шаардагддаг хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр хүлээн авах, илгээх;
- Бараа, ажил, үйлчилгээний каталогийн системд өмнө бүртгэгдсэн мэдээллийг эмхэтгэх, шинээр хөгжүүлэх, өгөгдлийг зөв кодлолын дагуу эмх цэгцтэй, давхардалгүй үүсгэх;
- Ижил төстэй ажлын мэдээллийг нотлох зорилгоор гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээллийг гүйцэтгэгч, нийлүүлэгчээр цахим системд нөхөн оруулах захиалагч хянах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч, цахим системд оруулах;
- Цахим каталогийн системийн хөгжүүлэлтийг дуусгаж, өгөгдөл цуглуулах ажлыг эхлүүлсэн.

Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын журам”, 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалаар “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, 145 дугаар тушаалаар “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”, 146 дугаар тушаалаар “Зөвлөхөөс бусад үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендерийн жишиг баримт бичиг”, мөн 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалаар “Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг”, “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” болон “Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийг тус тус шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан мэдээллийг цахим системд оруулах, нэмэлт хөгжүүлэлтийг хийв. Тендерийн үнэлгээнд ашиглагдах лавлагаа, тодорхойлолт олгодог байгууллага, системүүдийг “Төрийн

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

худалдан авах ажиллагааны цахим систем"-д холбох ажлын хүрээнд нэмэлтээр Дээд боловсролын баримт бичгийн лавлагаа; Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, өртэй эсэх лавлагаа; Хуулийн этгээдийн шинэчилсэн лавлагаа; Тоног төхөөрөмж, машин механизмын ерөнхий мэдээлэл; Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өртэй эсэх; Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар шүүхэд хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай шүүхийн тусгай архивын тодорхойлолт зэрэг мэдээллүүдийг авах боломж бүрдсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, мэдээллийн ил тод байдал, худалдан авах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхээр заасан. Үүнтэй холбогдуулан тендер шалгаруулалтыг төлөвлөх, зарлан мэдээлэх, тендерийн нээлт хийх, тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэх ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн боловч тендерийг үнэлэх, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсэж байна. Үүнтэй холбогдуулан

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд Засгийн газраас Улсын Их Хуралд 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж дэмжсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.4.1-2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх /СЯ, 2017-2019/

Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Төрийн худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, хялбаршуулсан цахим тендер шалгаруулалтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 12 арилжааны банктэй цахим систем /www.tender.gov.mn/-ийг холбосон бөгөөд тус байгууллагуудын тендерийн баталгаа гаргах үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Худалдан авах ажиллагааны тендерийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглаж эхэлснээр тендерийн үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжих боломж бүрдсэн.

Хүснэгт.

Он	Захиалагчийн тоо	Цахим системд нийтлэгдсэн тендерийн урилгын тоо	Цахимаар зохион байгуулагдсан тендерийн тоо	Тендерт оролцогчдын тоо	Цахимаар зохион байгуулагдсан тендерийн хувь
2018	1,433	11491	10136	6305	88.2
2019	2,035	18143	17773	9888	98.0
2020	2,345	22703	22436	13305	98.8
2021	2,694	22666	22482	15740	99.3
2022	2,694	26715	26542	18338	99.6

Энэ нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааны мэдээллийн нээлттэй байдлыг хангаж, өрсөлдөх боломжийг бий болгох, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим системийн ашиглалтад дэвшил гарч байгааг харуулж байна.

"Худалдан авах ажиллагааны цахим систем"-ийн гар утсанд зориулсан хувилбаруудыг 5143 (100%), удаа (Android үйлдлийн системд

зориулсан хувилбар нь 3270 удаа, iOS үйлдлийн системд зориулсан хувилбар нь 1873 удаа) татагдсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-1. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хянан шийдвэрлэх чиглэлээр журам боловсруулах /СЯ, 2017-2019/

2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр УИХ-

аас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн дагуу Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 131 дүгээр тушаалаар «Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам»-ыг батлан мөрдөж эхэлсэн.

Сангийн яам 2020 онд нийт тендерт оролцогчдын 316 гомдол, 2021 онд нийт 589 гомдол, 2022 онд нийт 727 гомдлыг цахим системээр дамжуулан тус тус хүлээн авч хянан хуулийн хугацаанд хянан шийдвэрлэлээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу цахимаар ирүүлсэн гомдлыг албан бичгээр баталгаажуулах шаардлагатай тул цахим системээр ирүүлсэн гомдлыг хуулийн хугацаанд хүлээн авсанд тооцож, гомдол гаргагчид гомдол хянан шийдвэрлэх хугацаанд албан бичгээр ирүүлэхийг мэдэгдэж ажиллажээ.

Цахим системийн шинэчлэлттэй холбогдуулан Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 241 дүгээр тушаалаар өмнө нь батлагдсан «Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам»-д нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлын модулийг тестэлж, холбогдох сайжруулалтыг хийж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ашиглалтад нэвтрүүлж, тендер шалгаруулалттай холбоотой бүх гомдлыг бүртгэх боломжийг бүрдүүлжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-2. Иргэд тендерийн үйл ажиллагаа, явц байдлын талаар санал, бодлоо илэрхийлэх, харилцах, гомдол гаргах асуудлыг “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-д тусгах /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/

Иргэд, олон нийт тухайн тендертэй холбоотой тодруулгыг цахим хэлбэрээр гарган зохион байгуулагчид ирүүлэх, захиалагч тал цахим тодруулгыг хүлээн аваад хариуг нийт сонирхогч, оролцогчдод нээлттэйгээр системд байршуулан мэдээлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, Шударга

өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч, хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн. Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд тендерийн материалтай тухайн тендерт оролцогч цахим системээр дамжуулан танилцах боломжийг системд бүрдүүлсэн.

Иргэд, олон нийт, тендерт оролцогч, захиалагч байгууллагын төлөөлөлд худалдан авах ажиллагаатай холбоотой шуурхай үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр холбоо барих утас, албаны цахим шуудангаар ирсэн санал хүсэлтэд шуурхай хариулахаас гадна худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д LiveHelpDesk-ийг ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлэв. Ингэснээр ажлын бус цагаар үйлчлүүлэх, цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөөг цаг алдалгүй шуурхай авах, иргэд, олон нийт, тендерт оролцогч, захиалагч байгууллагын үлдээсэн цахим зурвас, захидал, асуултад цахим шуудангаар хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлэн зөвлөгөө, мэдээллийг өгч байна. Мөн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэгдсэн тендерийн урилгыг олон нийтийн сүлжээний нийтлэг хэрэгсэл болох твиттер хуудсанд дамжуулан нийтлэх боломжийг бий болгон иргэд, олон нийтэд шуурхай мэдээлэл түгээх арга хэлбэрийг нэмэгдүүлсэн.

Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар «Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам»-ыг баталсан. Уг журмын 9.1-д «Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдийн 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гаргасан гомдлын хувийг гомдол гаргаснаас хойш 1 хоногийн дотор цахим системд оруулна.» гэж заасан.

2021 онд Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын хэрэгжилтэд дүгнэлт хийж, тендерт оролцогчдод мэдээлэл хүргэх зорилгоор “Тус журам тендерт оролцогч

нарт ямар боломж олгож байгаа вэ?”, “Хэзээ танилцаж болох вэ?”, “Захиалагч ямар үүрэгтэй вэ?” зэрэг асуултад хариулт авах боломжтой мэдээ бэлтгэн олон нийтэд түгээсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-3. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/:

Сангийн яам тендер оролцогчоос ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг цахим хуудас /www.mof.gov.mn/-аар дамжуулан сар бүр мэдээлж байна. Мөн тус яам гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланд дурдаж, шаардлагатай асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулдаг.

Хүснэгт. Гомдол шийдвэрлэлт.

Он	Нийт шийдвэрлэсэн гомдол	Үүнээс	Сангийн яам	Шүүх
		ШӨХТГ		
2018	1446	198	1187	61
2019	1352	219	1060	74
2020	1163	154	914	95
2021	1207	262	870	75
2022	1216	182	969	65

Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын тоо 2017-2018 онд өсөх хандлагатай байсан боловч сүүлийн 2 жил тасралтгүй буурсан. Энэ нь 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, тендер оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг улсын орлого болгох болсонтой холбоотой байж болох юм.

Захиалагчийн шийдвэрт буюу Сангийн яаманд тендер оролцогч тендерийн баталгаагаар барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах шинэ зохицуулалт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Сангийн яаманд тендер оролцогч тендерийн баталгаагаар барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах хуулийн зохицуулалтын дагуу 2021 онд 41 үндэслэлгүй гомдолд барьцаалсан 209,700,613.93 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгох шийдвэр гаргаж, Төрийн сангийн “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 550 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг

тендер оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Сангийн яамнаас тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгжээс 2014-2021 онд ирүүлсэн гомдлыг хянан үзсэн байдлыг зургаар үзүүлбэл:



/2022 онд нийт гомдол 1365, захиалагчийн шийдвэр хуульд нийцээгүй 795, захиалагчийн шийдвэр хуульд нийцсэн 174, бусад 396/

2022 онд захиалагч хуульд заасан журам зөрчсөн тул тендер шалгаруулалтыг хүчингүй болгож хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн 55, захиалагчийн шийдвэр үндэслэлгүй бөгөөд тендерийн үнэлгээг дахин хийхийг мэдэгдсэн 740 шийдвэр гаргасан буюу тендерт оролцогчдоос ирүүлсэн нийт гомдлын 82% үндэслэлтэй байсан байна.

Хүснэгт 1. 2020-2022 онд Сангийн яаманд тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал

Гомдол шийдвэрлэлтийн төрөл	Ирсэн гомдол		
	2020	2021	2022
Захиалагчийн шийдвэр гараагүй, гомдолд дурдсан асуудлыг хуулиар захиалагч хянан шийдвэрлэхийг мэдэгдсэн	8	18	16
Хуулийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг гомдол гаргагчид буцаасан	10	43	39
Тендерт оролцогч гаргасан гомдлыг эргүүлэн татсан	35	42	50
Сангийн яамны эрхлэх асуудалд хамаарахгүй гомдлыг гомдол гаргагчид буцаасан	49	-	65
Захиалагч хуульд заасан журам зөрчсөн тул тендер шалгаруулалтыг бүхэлд хүчингүй болгож хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн	71	55	55
Сангийн яамны гаргасан гомдлын бүрдүүлбэрийн шаардлага хангахгүй тул гомдол гаргагчид буцаасан	88	-	153
Хуулийн 55 дугаар зүйлд хамаарахгүй тул гомдол хүлээн авах боломжгүй мэдэгдэж шүүхэд хандахыг мэдэгдсэн	95	63	73
Гомдол үндэслэлгүй буюу захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байгааг мэдэгдсэн	134	154	174
Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй тендерийн үнэлгээг дахин хийх шийдвэр гаргасан	519	495	740
Нийт	1009	870	1365

Сүүлийн 3 жилийн хугацаанд гэрээ байгуулахын өмнөх шатанд захиалагчийн шийдвэрт тендерт оролцогчдоос гаргасан гомдлын тоо буурсан боловч захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрийн тоо буурахгүй байна.

2021 онд Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд 33 гомдол гарсан бөгөөд шийдвэрийг ангилан харуулбал:

1/ Сангийн яаманд 30 гомдол гарсан бөгөөд шийдвэрлэгдсэн байдлыг харуулбал. Үүнд: Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй - 4 (13%); Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй - 14 (47%), Гомдлоо эргүүлэн татсан - 8 (27%), Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах - 4 (13%);

2/Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 3 гомдол гарч, тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулахыг ШӨХТГ-аас шийдвэрлэсэн.

Шүүхэд 2021 онд худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 75 гомдол маргааныг хүлээн авсан байна.

Сангийн яаманд гарсан гомдлын хувьд инженер, техникийн ажилчдын боловсролын диплом, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тээврийн хэрэгслийн даац, үзүүлэлт, эзэмшигчийн мэдээлэл, ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл, захиалагчийн ирүүлсэн тодорхойлолт зэрэг мэдээлэл дээр үндэслэн гомдол гарч байна. Мөн тендерт ирүүлсэн материал нь цахим системийн мэдээллээс зөрөх тохиолдол гарч байна. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ холбогдох төрийн байгууллагуудаас тодруулга, нэмэлт мэдээллийг авч, үнэлгээг хийж байгаа боловч зарим тохиолдолд төрийн бусад байгууллагуудын мэдээллийн баазад байгаа мэдээлэл зөрүүтэй байх, татвар болон нийгмийн даатгал, авто тээврийн системд шивэгдээгүй байх зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан тендерийн үнэлгээг хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байна.

Тендерт оролцогчдын хувьд шалгарсан тендерт оролцогчийн материалыг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногт үзэх боломжтой бөгөөд энэ хугацаанд үзэж танилцаад холбогдох гомдлоо Сангийн яаманд гаргаж байгаа. Цаашид тендерт гарч буй гомдлын шийдвэрлэлтийг оновчтой болгохын тулд тендерийн үнэлгээнд төрд байгаа мэдээллийн баазад үндэслэх, тендерт оролцогчдын хувьд өөрсдийн мэдээллээ холбогдох мэдээллийн

системүүдэд бүрэн гүйцэд оруулах зэргээр чадавхжуулах арга хэмжээ авах шаардлагатай.

Тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдол болон шийдвэрлэсэн байдлын талаарх мэдээллийг Сангийн яамны цахим хуудас / www.mof.gov.mn/-д сар бүр нийтэлж байгаа бөгөөд хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.4 болон 52.1.5 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тендерт оролцогч нараас гаргасан гомдлын талаарх дүн шинжилгээг жил бүр Засгийн газарт тайлагнаж үнэлгээг нийтэд мэдээлдэг.

Сангийн яаманд хянагдсан нийт 870 гомдлын 63 хувь буюу 550 үндэслэлтэй гомдлыг хүлээн авч шүүхийн өмнөх шатанд зөрчлийг арилгажээ. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох /СЯ, 2017-2020/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг бие даасан агентлаг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

“Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” зэрэг журмыг баталсан.

Тухайлбал, Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 132 дугаар тушаалаар «Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам»-ыг баталсан. Дээрх журмаар тендерт оролцогч

шалгарсан оролцогчийн тендертэй танилцаж захиалагч байгууллага болон үнэлгээний хорооны шийдвэрийг хянах боломж олгосноор үндэслэлтэй гомдол гаргахад томоохон дэмжлэг олгоод байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, журам, заавар батлагдсанаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих, худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл буюу хар жагсаалтыг хөтөлж, чанаргүй, гэрээний үүргээ биелүүлдэггүй компанийг дахин тендерт оролцуулахгүй байх, чанар, стандартын шаардлага хангасан дотоодын бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгох, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахгүй байх, урьдчилан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын журам”, 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалаар “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, 145 дугаар тушаалаар “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”, 146 дугаар тушаалаар “Зөвлөхөөс бусад үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендерийн жишиг баримт бичиг”, мөн 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалаар “Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг”, “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” болон “Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”-ийг тус тус шинэчлэн баталсан.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт оруулах саналыг боловсруулж, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Зөрчлийн хуульд уг санал тусгагдаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 253 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д, 2021 оны 242 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-д, 2021 оны 241 дүгээр тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, мөн Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг, 2021 оны 103 дугаар тушаалаар “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд тэдгээрийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж дэмжсэн. Төсвийн байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг жагсаалтад тусгажээ. Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь бүхэлдээ ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжин өөрчлөгдөж,

техник, технологийн дэвшлийг нийгмийн харилцаанд өргөнөөр ашиглах шаардлага үүссэн энэ үед худалдан авах ажиллагаа ч шинэ шатанд гарах шаардлагатай болсон. Хүний эрх, эрх зүйн суурь зарчимд тулгуурласан, өрсөлдөөн, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчин үеийн хөгжлийн чиг хандлага болох хүний оролцоог бууруулсан худалдан авах ажиллагааг зохион байгуулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгохыг цаг үе шаардаж байна. Түүнчлэн тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь зарим талаар хуулийн үндсэн зарчим, үзэл баримтлалаас хазайсан, нөгөө талаар хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо агуулгын хувьд холилдсон нь хуулийн бүтцийн системчлэл алдагдахад хүргэсэн асуудал байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасны дагуу Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2021 онд үнэлгээ хийсэн бөгөөд уг үнэлгээний тайлангийн дүгнэлтэд “хуулийг шинэчлэн найруулах” гэж зөвлөмж гарсан нь хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл болж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах /СЯ, 2017-2020/

2017 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <http://pcsp.gov.mn> цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны <https://tender.gov.mn> системд тус тус байршуулж, олон нийтээс санал авч, төсөлд тусгасан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг аймгуудын Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд, яамдын холбогдох албан тушаалтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөл 80 гаруй хүнийг оролцуулан 2017 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. 2018 онд Сангийн яам Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн улсын хэмжээнд зохион байгуулж 21 аймгийн орон нутгийн өмчийн газар холбогдох 30 гаруй мэргэжилтэн, 830 иргэн, 180 аж ахуйн нэгжийн саналыг авч, төсөлд тусгасан. Түүнчлэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүх шатны төсөвт байгууллагын төлөөлөлд танилцуулж, санал авч хэлэлцүүлсэн. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа олон нийтийн саналыг авч тусган, Сангийн яаманд хүргүүлсэн. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу боловсруулсан Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам - Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол; Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам - Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал; Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам - Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал; Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам - Сангийн сайдын 2019 оны 208 дугаар тушаал, 13 тендерийн жишиг баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, Сангийн сайдын 2019 оны 122, 123, 124, 125, 126, 127, 128 болон 129 дүгээр тушаалд олон нийтээс санал авч батлуулсан. Эдгээр төслүүдэд бүх төсвийн ерөнхийлөн захирагчаас санал авч, мөн Сангийн яамны цахим хуудас (www.mof.gov.mn), Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас (www.tender.gov.mn)-д байршуулж санал авч, төсөлд тусган батлуулсан.

Дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах,” гэж захиалагчийн эрх, үүрэг заасан хэсгийг өөрчлөн найруулсан. Энэ нь цахим худалдан авах ажиллагаа-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд

хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлж байна.

Худалдан авах ажиллагааны бодлогын баримт бичгийг шинэчлэхээр Сангийн яамны цахим хуудас /www.tender.gov.mn/ болон төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.tender.gov.mn/-д байршуулан 2019 онд 1, 2020 онд 4 удаа, 2021 онд албан бичгээр санал авахаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлж давхардсан тоогоор 113 байгууллагаас 228 санал ирүүлснийг төсөлд тусган боловсруулж дараах тендерийн жишиг баримт бичиг, журам, зааврыг баталсан:

1. Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар “Харьцуулалтын аргаар бараа, ажил, зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг”-ийг шинэчлэн;
2. Сангийн сайдын 2021 оны 144 дүгээр тушаалаар “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийг шинэчлэн;
3. Сангийн сайдын 2021 оны 145 дугаар тушаалаар “Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг шинэчлэн;
4. Сангийн сайдын 2021 оны 146 дугаар тушаалаар “Зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийг шинэчлэн;
5. Сангийн сайдын 2021 оны 174 дүгээр тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”-ыг шинэчлэн;
6. Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг шинэчлэн;
7. Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт;
8. Сангийн сайдын 2021 оны 241 дүгээр тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”- д

нэмэлт, өөрчлөлт;

9. Сангийн сайдын 2021 оны 242 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт;
10. Сангийн сайдын 2021 оны 242 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан тус тус баталсан.

Сангийн Сайдын 2021 оны 110 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэлэлцүүлгийг 2021 оны 7-12 дугаар саруудад танхимаар болон цахимаар зохион байгуулж 34 төсвийн ерөнхийлөн захирагчаас нийт 327 санал, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Татварын ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, «Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт, хөгжлийн төв» УТҮГ-аас болон иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоос хуулийн төсөлтэй холбогдуулан 314 санал тус тус ирүүлсэн. Төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоос өгсөн холбогдох саналыг тусган Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-3. “Цахим худалдан авах ажиллагаа”-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2020/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулан дээрх хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг Зөрчлийн хуулиар зохицуулахаар тусгасан боловч Зөрчлийн хуульд холбогдох заалт ороогүй тул хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх боломжгүй байдлыг үүсгэсэн. Өөрөөр хэлбэл,

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.7-д заасан засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд урилга, үр дүн, мэдээллээ бүрэн оруулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох заалт хүчингүй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасны дагуу «Цахим худалдан авах ажиллагаа»-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулиар хариуцлага ногдуулах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

Тендерт оролцогчийн зүгээс Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар «Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам» болон тендерийн жишиг баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу тендерийн материалаа цахим системээр дамжуулан илгээхдээ Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж ирүүлэх ба тэдгээрийг хуулийн дагуу ил болгохыг хориглосон зайлшгүй үндэслэлийг бичгээр тайлбарласан байхыг журмаар зохицуулсан. Зарчмын хувьд төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх тогтолцоог хуулиар улам бүрдэг болгосон байгаа.

Сангийн сайдын 2021 оны 241 дүгээр тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан захиалагчийн шийдвэрийг цахим системд байршуулж, тендерт оролцогчдод системд бүртгэлтэй цахим шуудангаар мэдээлэл хүргүүлж, улмаар шалгарсан оролцогчийн тендерийг ил болгосон өдрийг захиалагчийн цахим системд шийдвэр

нийтэлсэн өдрөөр тооцохоор заасан. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шийдвэр гаргасантай холбоотой гомдлыг хүлээн авах хугацааг тоолоход цахим системийн олон нийтэд нээлттэй хэсэгт үр дүн нийтэлсэн өдрийг үндэслэл болгохоор заасан байна.

Мөн тендерт оролцогч нь цахим системд бүртгэлтэй цахим шуудангийн хаягийн дагуу захиалагч холбогдох шийдвэр, мэдээллийг хүргүүлэхээр заасны дагуу тендерт оролцогч бүртгэлтэй цахим шууданг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран захиалагчийн шийдвэрийг хүлээн авсанд тооцохоор Сангийн сайдын 2021 оны 242 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ нь тендерт оролцогч цахим системд бүртгэлтэй мэдээлэлд өөрчлөлт орох бүрд ажлын 5 хоногт багтаан өөрчлөлт оруулах үүргээ зайлшгүй гүйцэтгэх нөхцөл болж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.4.3-4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.14-т заасны дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-ээр дамжуулан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлжээ. Эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлж, Сангийн яамны цахим хуудас¹⁷ болон худалдан авах ажиллагааны цахим систем¹⁸-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байна. Уг жагсаалтад орсон аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд цахим системээр дамжуулан аливаа тендер шалгаруулалтад оролцох боломжгүй

17 <https://mof.gov.mn/article/tender/blacklist>

18 <https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist>

байхаар цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн.

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталсан. Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталсан. Дээрх журамд заасны дагуу холбогдох нотлох баримтыг авч хяналт, шалгалтыг удирдамжийн дагуу зохион байгуулж, нэр бүхий 60 компанийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэсэн байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэй мэдээлсэн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 20 нь эрх сэргэсэн, 40 нь эрх сэргээгүй төлөвт байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.4-1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3-т “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах эрхтэй” гэж заасан байна. Энэ хүрээнд Сангийн яамнаас “Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх заавар”-ын төслийг боловсруулсан.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн саналыг үндэслэн “Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх заавар”-ыг боловсруулах явцад Монгол Улсын дээд шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 126 дугаар тогтоолоор гэрээ шууд

байгуулахтай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 52.1.3-т заасан бүрэн эрхэд гэрээ шууд байгуулах заавар батлах тусгайлсан эрхийг олгоогүй тул дээр дурдсан шүүхийн практикийг таниулан сурталчлах, хууль хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр захиалагч нарт тодорхой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх бүрэн эрхийн хүрээнд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн б-1/6076 тоот албан бичгээр «Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхэд анхаарах асуудлын талаар зөвлөмж» хүргүүлсэн. Зөвлөмж нь хуульд заасан гэрээ шууд байгуулах үндэслэлийг нийтлэг 6 хэсэгт хувааж тус бүрд нь анхаарах шаардлагатай асуудлын талаар дурдсанаас гадна тендерт оролцогчтой хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад алдаа гаргахгүй байх дараалал журмыг тодорхой тусгасан. (Биелэлт 100 хувь)

4.1.4.4-2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах /ҮХГ, 2017-2018/

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч улмаар концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг тухайн үед ажиллаж байсан Үндэсний хөгжлийн газраас Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 104 дүгээр тушаалаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хурлаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталж, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болов. Эдийн засаг, хөгжлийн яамнаас уг хуультай нийцүүлэн батлах 12 журмын төслийг боловсруулж байгаа бөгөөд үүнд хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний

стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг, түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлалын төсөл багтаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.4.4-3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах /ҮХГ, 2017-2019/

2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам, хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг зэргийг Засгийн газраас батлахаар байна. (Биелэлт 70 хувь)

4.1.4.5-1. Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аар баталсан нэмэлт, өөрчлөлтөөр “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэж өөрчлөн найруулсан.

Үүний дагуу Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмын 3.1-д эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсан шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэхээр, 3.2-т төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж нь эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг тухай бүр шинэчилж, худалдан авах

ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д олон нийтэд нээлттэй байршуулахаар заасан.

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд нийт 60 тендерт оролцогчдыг хамруулсан байна. 2020 онд тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд нийт 35 тендерт оролцогчдыг бүртгэж, 2021 оны байдлаар уг бүртгэлд нийт 51 тендерт оролцогчдыг хамруулж, олон нийтэд мэдээлсэн бол 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 20 нь эрх сэргэсэн, 40 нь эрх сэргээгүй төлөвт байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.5-2. Гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах албадлагын арга хэмжээ авах эрхийг төрийн байгууллагад олгох, хариуцлагыг чангатгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх /СЯ, 2017-2019/

Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх заалт хүчингүй болж, хууль зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр болсон. Гэтэл Зөрчлийн тухай хуульд уг асуудал тусгагдаагүйгээс үүдэн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэхэд хүндрэл учирч байв.

Иймд Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг батлуулсан. Энэхүү журмын 2.5-д “Иргэн, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа нь энэ тухай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 3 жил байна” гэж, 2.6-д “Захиалагч хуулийн 14.5-д заасны дагуу эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзана” гэж тус тус тусган баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.4.5-3. Тендерторолцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах /СЯ, 2017-2019/

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу Сангийн яам тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж байна.

Захиалагч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах үүрэг хүлээж, энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан. (Биелэлт 70 хувь).

Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагаа, 34 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны байдлаар тоймлон танилцуулбал:

4.1.5.1-1. Шүүгч, прокурорын сонгон шалгаруулалт, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан, дэвшүүлсэн, шагнаж урамшуулсан, чөлөөлсөн, хариуцлага тооцсон байдалд судалгаа хийж, дүнг олон нийтэд мэдээлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг баталж, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байна. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүгчийг сонгон шалгаруулах журам, шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигчийн шалгалт, шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх, томилох, бүрэн эрх үүсгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох процессыг дэлгэрэнгүй тусгаж, шүүгчийг сонгон шалгаруулах процесс олон нийтэд нээлттэй, ил тод байх эрх зүйн орчин бүрдсэн.

2017-2022 онд шүүх байгууллагад 120 шүүгч шинээр томилогдож, 25 шүүгчийг сэлгэн ажиллуулж, 107 шүүгчийг шилжүүлэн ажиллуулж, 76 шүүгчийг дэвшүүлж, 210 шүүгчийг шагнаж урамшуулж, 82 шүүгчийг чөлөөлж, 6 шүүгчид хариуцлага тооцжээ. Эдгээр мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны цахим хуудас¹⁷-д тухай бүр мэдээлсэн.

¹⁷ /<https://www.judcouncil.mn>

Хүснэгт 5.1. Шүүгчийн томилгоо болон бусад шилжилт хөдөлгөөний байдал.

Он	Томилогдсон	Сэлгэн ажиллуулсан	Шилжүүлэн ажиллуулсан	Дэвшүүлсэн	Шагнаж урамшуулсан	Чөлөөлсөн	Хариуцлага тооцсон/огцруулсан
2017	26	-	21	26	41	-	-
2018	13	-	34	14	17	-	-
2019	14	-	15	2	6	17	-
2020	30	-	21	7	30	20	-
2021	-	-	16	1	75	18	3
2022	37	25	-	26	41	27	3

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүхийн захиргааны ажилтны шагналд тодорхойлох, шүүхийн шагналын журмыг баталж мөрдүүлэх, шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох, шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг тус тус батлах эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Шүүгчийн сэлгэн ажиллуулах журам”-ыг баталжээ. Энэхүү журмын дагуу шүүгч сэлгэн ажиллуулах захиалгыг хүлээн авч, зарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсанд байршуулж, хүсэлтээ ирүүлсэн шүүгчийн материалыг

хүлээн авч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанд танилцуулагддаг. 2022 онд ШЕЗ-ийн хуралдаанаар нийт 25 шүүгчийг сэлгэн ажиллуулахаар шийдвэрлэжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчдээс ирүүлсэн материалыг хуульд заасан болзол шаардлагын дагуу хүн нэг бүрээр шалгаж, нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг чиг үүргийн хороогоор хэлэлцэж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанд танилцуулдаг. Мөн сонгон шалгаруулалтын хуваарийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор баталж, www.judcouncil.mn сайтад байршуулж, хуваарийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулдаг.

Хүснэгт 5.2. Шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулсан байдал.

Он	Сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийн тоо	Бүртгэсэн нэр дэвшигчдийн тоо	Зарлагдсан сул орон тоо	Томилогдсон
2017	167	146	40	26
2018	335	134	17	13
2019	80	27	25	14
2020	-	-	61	30
2021	-	-	-	-
2022	226	143	56	37

Үндэсний хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд нийт 199 шүүгчийн сул орон тоонд 808 иргэн өрсөлдөхөөр материалаа ирүүлснээс 450 нэр дэвшигчийг бүртгэж, 120 шүүгчийг шалгаруулан томилжээ.

Прокурорын байгууллагын томилгоо, шилжилт хөдөлгөөний асуудлыг Улсын ерөнхий прокурорын 2011 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”, мөн Улсын ерөнхий прокурорын 2022 оны А/19

дугаартай тушаалаар батлагдсан “Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам”-аар тус тус зохицуулж байна.

Мөн 2022 онд “Прокурорыг сонгон шалгаруулах, дэвшүүлэн томилох, сэлгэн ажиллуулах” журмын төслийг шинэчлэн боловсруулсан. Уг журмын төсөлд прокурорыг мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлага, байгууллагын ажлын ачааллыг зохицуулах, ашиг сонирхлын

зөрчил үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор чадахуйн зарчимд үндэслэн албан тушаалд дэвшүүлэх, бууруулан томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулахаар заасан. Түүнчлэн Прокурорын ажлын байранд тавигдах шаардлага, эрхэлсэн ажлын чанар,

үр дүн, ажлын дадлага туршлагыг харгалзан албан тушаалд шатлан дэвшүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулах бөгөөд холбогдох хууль тогтоомж, мэргэжил, ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам зөрчсөн нь албан тушаал бууруулах үндэслэл болгох зохицуулалт оржээ.

Хүснэгт 5.3. Прокурорын томилгоо болон бусад шилжилт хөдөлгөөний байдал.

Он	Шинээр томилогдсон	Сэлгэн ажиллуулсан	Шилжүүлэн ажиллуулсан	Дэвшин томилогдсон	Шагнаж урамшуулсан	Чөлөөлсөн	Хариуцлага тооцсон/ Ажлаас халсан
2017	18	0	73	73	121	9	35/0
2018	41	0	161	62	86	18	45/0
2019	32	1	83	58	77	27	31/1
2020	71	2	100	88	454	21	19/3
2021	54	6	141	69	366	18	39/0
2022	64	11	148	89	319	13	27/3

Үндэсний хөтөлбөр хэрэгжих хугацаанд прокурорын байгууллагад нийт 280 прокурор шинээр томилогдож, 20 прокурорыг сэлгэн, 706 прокурорыг шилжүүлэн ажиллуулж, 439 прокурор дэвшин томилогдож, 1423 прокурор шагнал урамшуулалд хамрагдаж, 106 прокурор чөлөөлөгдсөн бол 196 прокурор хариуцлага тооцуулж, 7 прокурор ажлаас халагдсан. Улсын прокурорын ерөнхий газраас сахилгын шийтгэл хүлээж, ажлаас халагдсан прокуроруудын талаар олон нийтэд мэдээлж ажилласан.¹⁸

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар зарлигаар баталсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын 7.4-т “Зөвлөл нь Прокурорын ёс зүйн дүрмийн хэрэгжилт, хариуцлага хүлээсэн байдал,

цаашид анхаарах зүйлсийн талаар тайлан, зөвлөмжийг хагас, бүтэн жилээр гаргаж олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу прокурорын байгууллагын prokuror.mn сайт болон УЕПГ-ын Олон нийттэй харилцах албанаас зохион байгуулсан хэвлэлийн бага хурлын үеэр прокуроруудын сахилга, ёс зүйн талаар гаргасан гомдол, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар олон нийтэд мэдээлдэг.

Мөн прокуророор шинээр томилсон болон дэвшүүлэн томилсон, чөлөөлсөн, халсан, шагнаж урамшуулсан, хариуцлага тооцсонтой холбоотой нэгдсэн дүн, мэдээг прокурорын байгууллагын үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн ажлын тайланд нэгтгэн тусгадаг.

Хүснэгт 5.4. Прокурорын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулсан байдал.

Он	Сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийн тоо	Бүртгэсэн нэр дэвшигчдийн тоо	Зарлагдсан сул орон тоо	Томилогдсон
2017	96	96	17	17
2018	104	104	14	14
2019	108	108	12	12
2020	Цар тахлын улмаас сонгон шалгаруулалт зарлагдаагүй.			
2021	Цар тахлын улмаас сонгон шалгаруулалт зарлагдаагүй.			
2022	228	227	49	40

18 <https://news.mn/r/2168158/>, <https://zogii.mn/post/7539295> 2021-07-09, <https://medee.mn/p/144781>, <https://isee.mn/n/19894>, <https://asu.mn/content/9853>

Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг сонгон шалгаруулахдаа, “Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам”-д заасны дагуу 2022 онд зарлагдсан 2 удаагийн сонгон шалгаруулалтын зарыг прокурорын байгууллагын “Prokuror.mn” цахим хуудас, “УЕПГ-ын Олон нийттэй харилцах алба” фэйсбүүк пэйж хаягаар 30-аас дээш хоног нийтэлж, бүртгүүлсэн иргэдийг шалгалтад хамруулсан.

Тайлант хугацаанд прокурорын байгууллагаас зарласан 92 сул орон тоонд өрсөлдөхөөр 536 иргэн материалаа ирүүлснээс 535 нэр дэвшигчийг бүртгэж, 83 иргэнийг прокурорын туслах ажилтнаар шалгаруулан томилжээ.(Биелэлт 70 хувь)

4.1.5.1-2. Шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах, шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр зарлигаар шинэчлэн баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу шүүгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байв. 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгчийг сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулсан. Тухайлбал, шүүгчийг сонгон шалгаруулах, томилох процессыг дэлгэрэнгүй тодорхой болгож, шүүгчийг сонгон шалгаруулах процесс олон нийтэд нээлттэй, ил тод байхаар, мөн хуульчаас шүүгчийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нээлттэй сонгон шалгаруулж томилох процессыг хуульд тодорхой тусгасан.

Мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолоор “Шүүгчид тавих болзол, шаардлагыг

үнэлэх, сонгон шалгаруулах журам»-ыг баталж, уг тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 5767 дугаарт бүртгүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 76 дугаар тогтоолоор “Шүүгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах аргачлал”-ыг баталсан. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хамтарсан 76.А/206 дугаар тушаалаар батлагдсан “Шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болох эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журам»-ыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5790 дугаарт, мөн өдрийн 75А/205 дугаар тушаалаар батлагдсан «Шүүгчээр ажиллахад харшлах өвчний жагсаалт-ыг 5789 дугаарт тус тус бүртгүүлсэн.

2017 онд шинэчлэн батлагдсан Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Прокурорын мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын Ерөнхий прокурор батална.” гэж, 45 дугаар зүйлийн 45.1-д “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, хуульчийн мэргэжлээр 3-аас доошгүй жил, эсхүл прокурорын туслах ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан, гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй, мэргэжлийн шаардлага хангасан, хорин таван насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно” гэж тус тус заасан.

Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчмыг баримтлан, Улсын ерөнхий прокурорын 2022 оны А/19 дугаар тушаалаар “Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам”-ыг батлан мөрдөж байна.(Биелэлт 70 хувь)

4.1.5.1-3. Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуулиар тодорхой болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2019/

2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн

36.4-т “Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ.” гэж заасан. Мөн хуулийн 31 дүгээр зүйлд шүүгчид тавих болзол, шаардлагыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол;
- эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;
- шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй;
- шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх;
- хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
- шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх.

Дээрх болзлоос гадна давж заалдах шатны шүүхийн шүүгч анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан байх бол Улсын дээд шүүхийн шүүгч дор дурдсан шаардлагыг аль нэгийг хангасан байхаар тусгажээ:

- шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан эсхүл прокурор;
- өмгөөлөгчөөр дагнан 10-аас доошгүй жил ажилласан;
- магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан.

Мөн сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглох бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан шүүгч байх, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байхаар хуульчилсан. Өөрөөр хэлбэл, шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуулиар тодорхой болгосон байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.1-4. Шүүгчид нөлөөлөх үйлдэл хийсэн, нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох

/ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2021/

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын Ерөнхий прокурор зэрэг албан тушаалтан нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд өгч байх, түүнчлэн Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор ийм шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Шүүхийн ерөнхий зөвлөл нэн даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхээр уламжлуулан хүргүүлж, шийдвэрлүүлж байхаар хуульчлаад байна. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх процессыг тодорхой болгожээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам”, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”, “Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримт”, “Нөлөөллийн мэдүүлгийн бүртгэл”, - “Тэмдэглэлийн бүртгэл”, “Баталгааны тэмдгийн загвар”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийн материалыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр мэдүүлэг хөтлөгч нарт мэдэгджээ. 2013-2022 оны байдлаар шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс нийт 72 удаагийн нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсэн байна.

Хүснэгт 5.5. Шүүгчид нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал.

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Тоо	1	8	5	5	7	9	8	10	4	15

Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим сайтад “Хараат бус байдал” гэсэн цэс¹⁹ нэмж, иргэд олон нийтэд шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн хүргэж байна.

Зөрчлийн тухай хуулийн 15.4 дүгээр зүйлд “Шүүгчийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх, шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 21.6 дугаар зүйлд шүүгч болон бусад этгээдэд хууль бусаар нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг заасан. Үүнд:

1. “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”;

2. “Энэ гэмт хэргийг дээд шатны албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд дарамт шахалт үзүүлж, давуу байдал бий болгож, бий болгохоор амлаж, ятгаж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” (Биелэлт 100 хувь)

4.1.5.1-5. Шүүгч, прокурорын ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах, Ёс зүйн хорооны шийдвэр шүүхийн хяналтад байгааг өөрчлөх /ШЕЗ, УЕПГ, 2017-2020/

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд шүүгчид хориглох зүйлийг нарийвчлан тусгасан. Энэ нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ болж, зөрчсөн талаарх гомдол, мэдээллийг Шүүхийн сахилгын хороогоор шийдвэрлүүлэхээр зохицуулсан. Мөн шүүгчийн ашиг сонирхлын зохицуулалт, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг, шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт зэргийн хуульчилж, энэ талаарх зөрчлийг Шүүхийн сахилгын хороо шийдвэрлэхээр тусгаж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Хуулийн 95, 96 дугаар зүйлд Сахилгын хороо байгуулах, үйл ажиллагааны журам, 101 дүгээр зүйлд шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл, 105 дугаар зүйлд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, 112 дугаар зүйлд Сахилгын хорооны хуралдааны шийдвэр, 114 дүгээр зүйлд Сахилгын хорооны хяналтыг тогтоолд гомдол гаргах зэрэг үйл ажиллагаа нарийвчлан зохицуулсан байна. Хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1-д “Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 115.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно” гэж заасан нь шүүхэд давж заалдах эрхийг Шүүхийн сахилгын хороонд үлдээж, хяналтын гомдол гаргах эрхийг талуудад эдлүүлэхээр үлдээсэн зохицуулалт болсон юм.

Прокурорын тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 65 дугаар зүйлд 65.2 дахь хэсэгт “Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална” гэж заасны дагуу Монгол Улсын

¹⁹ <https://www.judcouncil.mn/site/news/40/>

Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар зарлигаар “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Улсын ерөнхий прокурорын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.

Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын 6.1-д “Зөвлөл нь үйл ажиллагаагаа хараат бусаар, бие даан явуулна”, 6.12-т “Зөвлөлийн дүгнэлтийг прокурор, санал хүсэлт, гомдол гаргагч этгээд эс зөвшөөрвөл дүгнэлт мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Улсын ерөнхий прокурорт гомдол гаргах эрхтэй”, 6.13-т “Заасан хугацаанд гомдол гаргаагүй бол дүгнэлтийг Улсын ерөнхий прокурорт танилцуулна. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Улсын ерөнхий прокурор өөрт олгогдсон бүрэн эрхийн дагуу шийдвэрийг гаргана”, 6.14-т “Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно” гэж тус тус заасан байна. Мөн журмын 6.15-д “Зөвлөл нь хууль, эсхүл энэ журам зөрчиж дүгнэлт гаргасан гэж үзэх үндэслэлтэй бол Зөвлөлийн дарга хуралдааныг дахин нэг удаа хуралдуулах талаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд хуралдаанд Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос дээш хувь нь оролцож, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ”, 6.16-д “Энэ журмын 6.15 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд зөвлөлийн дүгнэлт эцсийн байна” гэж тус тус заасан нь Прокурорын ёс зүйн зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаа шүүхийн хяналтад бус, хараат бусаар үйл ажиллагаа явуулахаар зохицуулагдсан болно. (Биелэлт 100 хувь)

4.1.5.1-6. Шүүх хуралдаанд нууцтай холбоотой асуудал хэлэлцэх хэсгийг хаалттайгаар бусад хэсгийг нээлттэй явуулахаар эрх зүйн орчныг бүрдүүлэх /ШЕЗ, ХЗДХЯ, 2018-2019/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 3.2 дугаар зүйлд “Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна”, 36.10 дугаар

зүйлд “Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох”, Монгол Улсын Шүүхийн тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Шүүх хуралдааныг хуульд зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.”, мөн зүйлийн 12.6-д “Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлж болох бөгөөд холбогдох журмыг Ерөнхий зөвлөл батална.” зэрэг зохицуулалт туссанаар холбогдох эрх зүйн орчин бүрдсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор баталсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх» журам хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тус журмын 3-д “3.1. Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр бүрэн эсхүл хэсэгчлэн мэдээлэхийг зөвшөөрөх, татгалзах, түүнийг хязгаарлах, дуусгавар болгох асуудлыг шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Шүүх хуралдааныг нээх, шийдвэр уншиж сонсгох хэсэг нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нээлттэй байна.» гэж заасны дагуу хаалттай шүүх хуралдааны нээлт болон тогтоох хэсгийг нээлттэй хийж байна.(Биелэлт 100 хувь)

4.1.5.2-1. Ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журмыг шинэчлэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2017-2018/

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар бүх шатны шүүх Ерөнхий шүүгч, шүүгчээс бүрдэх ба тухайн шатны шүүхийг Ерөнхий шүүгч удирдахаар тусгасан. Хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй, шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх, шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх зэрэг нийтлэг болзол, шаардлагыг хангасан байхын зэрэгцээ тусгайлсан зарим

шалгуурыг хангасан байхаар хуульчилсан байна. Тухайлбал, давж заалдах шатны шүүхийн шүүгч нь хуульд зааснаар анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан байх ба тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг мөн шатны шүүгчид дотроо сонгох асуудлыг тус шүүхийн нийт шүүгчдээс бүрдсэн Шүүгчдийн зөвлөгөөн хэлэлцэн шийдвэрлэнэ. Мөн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар сонгох ба анхан, давж заалдах шүүхийн Ерөнхий шүүгчийг 3 жилийн хугацаагаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно гэж хуульчилсан.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хувьд шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байх ба Улсын дээд шүүхийн санал болгосноор Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа томилохоор Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7-д заасан. Ийнхүү Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шүүхийн ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журмыг тодорхой зохицуулжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.5.3-1. Прокурор, шүүгчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг оруулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

2017-2022 онд прокурорын байгууллагын сургалтын хөтөлбөрийг 4 удаа шинэчилж, прокурорын байгууллагаас сургалтын талаар баримтлах үзэл баримтлалыг шинээр батлан хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх чиглэлээр прокуроруудыг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталж, сургалтуудыг үе шаттай зохион байгуулж хэвшжээ. Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/46 тушаалаар баталсан “Прокурорын сургалтын хөтөлбөр”-т “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар 4 цагийн сургалт буюу нийт 12 цагийн сургалтыг, 2019 онд “Прокурорын сургалтын хөтөлбөр”-т “Авлига, албан тушаалын гэмт хэрэг” сэдэвт 4 цагийн сургалтын хөтөлбөр, модулийг нэмж тусгасан.

Улсын ерөнхий прокурорын 2020 оны 10 дугаар

сарын 22-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар “Прокурорын байгууллагаас сургалтын талаар баримтлах үзэл баримтлал”-ыг шинээр, А/83 дугаар тушаалаар “Прокурорын байгууллагын сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн тус тус баталсан. Сургалтын талаар баримтлах үзэл баримтлалд прокурор, прокурорын туслах ажилтнаар шинээр томилогдохын өмнө заавал судлах, сонгон судлах сургалтын талаар тусгасан ба мөн прокурорын байгууллагын сургалтын төлөвлөгөөг хяналтын ажлын мэдээ, шалгалт судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, прокурор, ажилтны сургалтын эрэлт хэрэгцээ, ирүүлсэн санал зэрэгт үндэслэн жил бүр гарган, хэрэгжүүлж ажиллах талаар тусгасан.

2021 онд Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн системд хөгжүүлэлт хийж “Судалгааны модуль”-ийг шинээр бий болгож, 2021 оны 10 дугаар сараас эхлэн ашиглалтад оруулсан. Энэхүү системээс прокурорын хяналтад орсон авлигын гэмт хэрэг, түүний төрөл, зүйл хэсэг, шийдвэрлэлтийн болон бусад мэдээллийг аль ч нэгж прокурорын газраас улсын хэмжээнд болон тодорхой бүс, нутаг дэвсгэрээр судлах, дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн Прокурорын байгууллагаас цаашид авах арга хэмжээг тодорхойлох, албан хаагчийг сургах, дадлагажуулах, чадавхжуулах зэрэг үйл ажиллагаанд ашиглах нэгдсэн мэдээллийн санг бий болгосон.

Мөн “Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлига, албан тушаалын гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт(2019-2021)”-ийн талаарх судалгааг хийж, судалгааны үр дүн болон хяналтын шатны шүүхээр авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практикийн талаар онолын сургалтыг тус тус аймаг, нийслэл, дүрэг, сум дундын прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан нийт прокуроруудад цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах,

хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллахаар, түүнчлэн Хүрээлэн нь сургалтын хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий орон тооны бус хороотой байхаар тусгасны дагуу хүрээлэн нь 2021 оны 8 дугаар сард байгуулагдан Сургалтын хөтөлбөрийн хорооны 2022 оны 07 тоот тогтоолоор “Шүүгчийн сургалтын 2022-2024 оны нэгдсэн бодлого”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Сургалтын хөтөлбөрийн хорооны Хорооны 2022 оны 10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар дэмжсэн “Авлигын зарим болон мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт” сэдэвт сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 24 дүгээр захирамжийн 6 дугаар хавсралтаар батлан Хүрээлэн 2022 онд Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 226 шүүгчийг сургалтад хамруулсан.(Биелэлт 100 хувь)

4.1.5.3-2. Шинээр томилогдсон шүүгч, прокурорт сургалтын хөтөлбөрийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалтыг зохион байгуулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 2018 онд “Авлигын эсрэг сургалтын сургагч багш бэлтгэх” сургалтыг 2 удаа зохион байгуулж 500 шүүгчийг хамруулсан. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын тушаалаар шинээр томилогдсон шүүгчдэд зориулсан сургалтыг “Ашиг сонирхлын зөрчил, анхаарах асуудал”, “Албан тушаалтны ХАСХОМ, анхаарах асуудал” сэдвээр, эрүүгийн хэргийн шүүгчдэд зориулсан сургалтыг “Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр 2020 оны 05 дугаар сард зохион байгуулав.

2017-2022 онд шүүгч нарт зориулж зохион байгуулсан сургалтын тоо, сэдэв, хамрагдсан шүүгч нарын талаарх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5.6. Шүүгчдэд зориулсан авлигын эсрэг сургалт.

Он	Сургалт/Хичээлийн сэдэв	Сургалтын тоо	Оролцогчдын тоо
2018	“Авлигын эсрэг сургалтын сургагч багш бэлтгэх”	2	500
2020	“Ашиг сонирхлын зөрчил, анхаарах асуудал”, “Албан тушаалтны ХАСХОМ, анхаарах асуудал”, эрүүгийн хэргийн шүүгч нар “Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”	1	13
2022	Авлигын зарим болон мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт	5 удаа	226

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс шинээр томилогдсон прокуроруудад хөтөлбөрийн дагуу сургалтыг жил бүр зохион байгуулж, хөтөлбөрийн дагуу “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь” сэдэвт сургалтыг тогтмол явуулж байна.

2017-2022 оны хугацаанд шинээр томилогдсон прокуроруудад зориулж, 9 удаагийн сургалтаар 175 прокурорыг хамруулжээ. Дэлгэрэнгүйг хүснэгтэд харуулбал:

Хүснэгт 5.7. Прокуроруудад зориулсан авлигын эсрэг сургалт.

Он	Сургалт/Хичээлийн сэдэв	Сургалтын тоо	Оролцогчдын тоо
2017	"Авлига, мөнгө угаах гэмт хэргийн уялдаа, холбоо", "Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд анхаарах асуудал"	2	20
2018	"Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Авлига, албан тушаалын гэмт хэрэг"	2	32
2019	Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд, "Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн чадавхийг нэмэгдүүлэх, холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх нь"	2	35
2020	Цар тахлын улмаас сургалт зохион байгуулагдаагүй.		
2021	Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгахад анхаарах асуудал" сэдэвт сургалт, Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгахад анхаарах асуудал"	2	48
2022	Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт"	1	40

(Биелэлт 100 хувь)

4.1.5.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах /АТГ, 2017-2021/

Авлига албан тушаалын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг судлан яамдын харьяа байгууллагууддаа тавих хяналт болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шат шатны удирдлагын хяналт сул, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангадаггүй, төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалт сул, хууль, журамд заасан шаардлагын хэмжээнд хяналт тавьдаггүй, мөн хүний нөөцийн томилгоо хууль, тогтоомжид нийцээгүй, сул орон тоог нээлттэй зарладаггүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилладаггүй, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй мэргэжлийн бус хүнийг ажлын байранд томилдог зэрэг нийтлэг зөрчлүүд тогтоогдсон тул гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтанд 2020 онд 103, 2021 онд 162 мөрдөгчийн мэдэгдэл,

аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар 2020 онд 43, 2021 онд 61 албан бичгийг хүргүүлэн, мэдэгдэл, албан бичгийн мөрөөр нөхцөл байдал арилсан эсэхийг шалгахад газар дээр нь ажилласан. Тухайлбал, 2021 онд мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн харьяа байгууллагууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Баян-Өлгий, Дорнод аймаг, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр Үндэсний музей, Чингис Хааны музейд ажиллав.

2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахад хуулийн этгээдэд хүргүүлсэн 53 мэдэгдлийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийв. Үүнээс 39 мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авч, авлигын гэмт хэргийн

шалтгаан, нөхцөлийг арилгасан байлаа. Мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээг аваагүй 12 байгууллагад зөвлөмж, шаардлага хүргүүлээд байна. Мөн онд Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомж зөрчсөн нийтийн албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 130 шаардлага, албан бичгийн мөрөөр тухайн зөрчил, гэмт хэргийг давтан гаргуулахгүй, шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр ажиллав.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналыг Засгийн газарт хүргүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр мөрдөн шалгах ажлын шуурхай байдалд тодорхой ахиц гарсан. Тухайлбал мөрдөн шалгах албаны дарга гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл шалгах хугацааг 14 хүртэл хоногоор сунгах, мөрдөгч нар төрийн болон иргэний хувийн захидал харилцаа, эрүүл мэндийн нууцаас бусад мэдээллийг бие даан иргэд байгууллагаас авдаг болсон.

2011-2020 онд шүүхээр шийдвэрлэгдсэн “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” 7 ботийг хэвлүүлэн олон нийтэд түгээв. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой. (Биелэлт 70 хувь)

4.1.5.4-2. Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх / Real name financial Transaction act/ эрх зүйн орчныг бий болгох /СЗХ, 2017-2018/

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4¹ дүгээр зүйлд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох шалгуурыг зааж өгсөн бөгөөд мөн хуулийн

5 дугаар зүйлд банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгагч, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч зэрэг хуулийн үйлчлэлд хамаарах тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэг хүлээлгэсэн.

Мөн дээр дурдсан байгууллагууд нь харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар хуулийн дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгалахаас гадна эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх үүрэг хүлээжээ. (Биелэлт 30 хувь)

4.1.5.5-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх / АТГ, 2017-2022/

Авлигын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай 110 дугаарын утсыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Энэ дугаар нь ярианы төлбөр үнэ төлбөргүй, иргэд тус 3 оронтой дугаарыг цээжлэхэд амар хялбар гэдгээрээ онцлог юм. 110 дугаарын утсыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав” дахь салбар болон “Бөмбөгөр” худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдэд сурталчлан, үүрэн телефоны операторуудын харилцагч нарт мессеж хэлбэрээр хүргэх, Улаанбаатар хотын 6 дүүргийн 40 байршилд байрлах самбаруудад 110 дугаарын утасны сурталчилгааг үнэ төлбөргүй байршуулж ажиллав. 110 тусгай дугаарын утсыг цахим орчинд сурталчлах, мөн тус газраас зохион байгуулж буй аян, арга хэмжээг сошиал медиа сувгаар түгээх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулав. 110 тусгай дугаарын утсанд 2020 онд 17,851, 2021 онд 13,474, 2022 онд 10,858 дуудлага ирсэн байна.

Тусгай дугаарын утсыг зорилтот бүлгүүдэд

сурталчилсан видео контент, зурагт хуудас, сурталчилгааны материалыг тогтмол түгээн ажилласнаар иргэдийн АТГ-т хандах хандалт эрс нэмэгдэж, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус үйлдлийн талаар шүгэл үлээх соёл нэмэгдэж байна.

Мөн 110 тусгай дугаараас гадна Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, факс, шуудангаар, биечлэн уулзаж гомдол мэдээлэл хүлээн авахын зэрэгцээ АТГ-Олон нийтийн пэйж хуудас, албан ёсны цахим хуудас, шуудангаар болон Авлигатай тэмцэх газраас яам агентлагт авлигын эсрэг булан, мэдээллийн самбарыг байршуулан, санал хүсэлтийг хайрцгаар санал хүсэлт, мэдээлэл хүлээн авч байна. Байгууллагад хүлээн авч хянан шийдвэрлэж байгаа өргөдөл гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг мессеж хэлбэрээр хүргэх технологийн шийдлийг боловсруулснаар тухайн өргөдөл, гомдол, мэдээлэл өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэн телефоны утсанд шийдвэрлэлтийн талаар 2 удаа мэдээллийг хүргэдэг болов. (Биелэлт 100 хувь)

4.1.5.5-2. Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2021/

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлэв. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй холбогдуулан бий болсон орлого, буруутай этгээдээр төлүүлсэн хохирол, урьдчилан сэргийлсэн нөхцөл байдал, хууль зүйн үр дагаврыг харгалзан мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг хэрхэн тооцож олгох, эдгээрийн хоорондын ялгаа, баримтлах мөнгөний хэмжээг тодорхой тусгасан. Мөн Авлигатай тэмцэх газраас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвд захиалан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг үнэлгээг хийлгүүлсэн болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Шүгэл үлээгчийг эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг сайжруулан боловсруулж яамд, холбогдох байгууллагаас санал авч нэгтгэн хуулийн төслийг 2021 оны

11 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхий сайд төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ хуулийн төслийг хэлэлцэхээр дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна” гэж заасныг үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулах зорилгоор “Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан, холбогдох судалгааг хийж, төсөлд 22 салбар зөвлөлөөс санал авах ажлыг зохион байгуулсан. Журмын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эцэслэж, Сангийн яаманд хүргүүлжээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгож, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан ба энэхүү журам Засгийн 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан. (Биелэлт 30 хувь)

4.1.5.6-1. Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2019/

УИХ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газраас санал авч, тусган Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн

40.1.2-т заасан бүрдүүлбэрт хамаарах Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр гүйцэтгүүлэн тайланг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн.

Хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайд 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, Хууль зүйн байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлсэн. Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар эхний хэлэлцүүлэгт орох төлөвтэй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.6-2. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2019/

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс дараах сургалт, нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Налайх болон Багахангай дүүргийн шүүгч, прокуроруудад “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” сэдвээр сургалт, Обдугаар сард УИХ-ын зарим гишүүд болон ЦЕГ-ын удирдлагуудтай хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, гүтгэх зөрчлийн асуудлаар санал солилцох уулзалтыг зохион байгуулж, Нийслэлийн цагдаагийн газраас зохион байгуулсан “Зарим зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа” сургалтад “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэн, 12 дугаар сард ОХУ-ын Олон нийтийн хэвлэл мэдээллийг хамгаалах төвийн захирал, ахлах хуульч Галина Араповатай хамтран “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: олон улсын шүүхийн практик” сургалтыг шүүгч, прокуроруудад зориулан зохион байгуулсан.

2019 онд Авлигатай тэмцэх газраас Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй,

сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газрын 57 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулж, Монгол улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, сэтгүүлчийн аюулгүй байдлын өнөөгийн түвшний тухай судалгаанд тулгуурласан мэдээллийг танилцуулж эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн ойлголт, ёс зүй, олон улсын чиг хандлага, хуурамч мэдээллийг таних арга, алхмууд, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл өгсөн.

2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр авлигын болон бусад төрлийн гэмт хэргийг эрэн сурвалжлах, хууль зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, сэтгүүлчидтэй нягт хамтран ажиллах арга замыг нээх зорилгоор Авлигатай тэмцэх гарын “Олон нийтийн төв”-д “Авлига ба эрэн сурвалжлах сэтгүүлчид” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад оролцогчдоос сургалтын үнэлгээний хуудсаар авсан саналын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.

2022 онд “Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагыг нийт 7 удаа зохион байгуулж, Зөрчлийн хууль ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, Цахим орчин дахь үзэн ядалтын үг хэллэг, Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль, Сонгуулийн тухай хууль ба хэвлэл мэдээлэл, Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн зохицуулалт ба ёс зүй, Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт, Геополитик ба хэвлэл мэдээлэл сэдвүүдийг сонгон оролцогч талуудыг урьж оролцуулав. Хэвлэл мэдээлэл нь иргэний нийгмийн нэг хэсэг болохын хувьд хяналт тавих, мэдээлэх чиг үүргээрээ дамжуулан авлигыг эсэргүүцэх хүчтэй салбар юм. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь авлигын хэргийг илрүүлэх, уг хэргийг олон нийтийн анхаарлын төвд оруулахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүлчдийг жил бүр авлига, ашиг сонирхлын талаар сургалтад хамруулан тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нь онцгой ач холбогдолтой. (Биелэлт 100 хувь)

4.1.4.6-3. Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх / МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2020/

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Глоб интернэшнл төв” ТББ-тай хамтран “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”²⁰-г 2018 оноос эхлүүлэн явуулж байна. Уг судалгааны тайлан, зөвлөмжийг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр олон нийтэд мэдээлж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон Улсын Их Хуралд хүргүүлжээ. Энэхүү судалгаа нь цаашид тогтмол хийгдэх бөгөөд “Ковид-19” цар тахлын улмаас түр завсарласан бөгөөд 2020-2022 оны мониторингийн тайланг 2023 оны 05 дугаар сарын 03-нд бэлэн болгож, олон нийтэд танилцуулах юм. (Биелэлт 70 хувь)

4.1.5.7-1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах/АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг гадаадулсорон, олон улсын байгууллагаас зохион байгуулдаг сургалтуудад өргөнөөр хамруулах бодлого баримтлан ажилладаг. Энэ хүрээнд 2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад 4, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 22 албан хаагчийг, мөн хорооноос 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Олон улсын авлигын эсрэг салбарын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”-д Авлигатай тэмцэх газрын 6 албан хаагчийг тус тус хамруулав. 2020 онд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монголбанкны холбогдох 29 алба

20 http://resource4.sodonsolution.org/mediacouncil/File/2021/01/25/v02syozco4zucrvp/Setguulchdiin_ayulgui_baidliig-hangah_erh_zuin_zohitsuulalt-Tailan_2019-MNG.pdf

хаагчийг хамруулан зохион байгуулсан. Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга/StAR санаачилга/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгч, ахисан түвшний сургалтад 4 дүгээр сард 2 удаа, 5 дугаар сард 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд 9 албан хаагчийг хамруулав. StAR санаачилгаас “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 9 дүгээр сарын 30-ны өдөр, 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд зохион байгуулсан Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтад АТГ, УЕПГ, ЦЕГ-ын 18 албан хаагчийг хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад 20 алба хаагч, Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба, Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Сингапурын Үндэсний Их Сургууль (NUS), Удирдлагын академи хамтран зохион байгуулсан “Их өгөгдөлд суурилсан бодлогын инноваци” хөтөлбөрийн дагуу 2 өдрийн сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдав.

2021 онд StAR санаачилгаас “Удиртгал хичээл: Дарк Вэб” буюу тактикийн ажиллагааг заасан тул зөвхөн хууль сахиулах салбарын алба хаагч нарт зориулсан нууцлалын зэрэгтэй сургалт семинарт оролцов. StAR санаачилгатай хамтран 2021 онд “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл - Дарквэб” богино хугацааны цахим семинарыг АТГ, ЦЕГ, УЕПГ-ийн 400 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Мөн 2021 оны 11 дүгээр сарын 09-нөөс 12 дугаар сарын 08-ны өдрүүдэд “Санхүүгийн мөрдлөг” сургалтыг зохион байгуулж, АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 24 албан хаагчийг хамруулав.

2022 онд дараах сургалтуудад АТГ-ын албан хаагчид (танхимаар болон цахимаар)-ыг хамруулжээ. Үүнд Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-оос зохион байгуулсан «Санхүүгийн аудит хийх техник, стратеги» сэдэвт 2 удаагийн сургалтад 30 албан хаагчийг, АНУ-ын ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан “Худалдаанд суурилсан мөнгө угаалт

ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох” сэдэвт 2 өдрийн сургалтад 10 албан хаагчийг, StAR санаачилгаас зохион байгуулсан “Удиртгал: Хөрөнгийн менежмент” сургалтад 52 албан хаагчийг, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооноос зохион байгуулсан Авлигын эсрэг виртуал сургалтын курс зохион байгуулах сургалтад 10 албан хаагчийг, StAR санаачилгаас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сэдэвт 4 өдрийн сургалтад 15 албан хаагчийг, «Виртуал валютын тухай ахисан түвшний семинар» сэдэвт 4 өдрийн сургалтад 30 албан хаагчийг тус тус суралцуулсан.(Биелэлт 100 хувь)

4.1.5.7-2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох /АТГ, 2017-2019/

Авлигад нөлөөлж байгаа хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн албаны тогтвортой байдал, иргэдийн орлого, шүүхийн хараат бус байдал, сонгууль, улс төрийн намын санхүүжилтэд дүн шинжилгээ, авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн авлигын эсрэг дагнасан шүүх байгуулах, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, УИХ-ын гишүүдийн тангарагт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг тусгах, авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлдэг байх, мэдээлэгчийг хамгаалах, олон нийтийн зөвлөлийн гишүүдийн болон шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, Авлигатай тэмцэх газрын салбар, нэгжийг орон нутагт байгуулах, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажилласан. Эдгээр санал, санаачилгуудын хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжуудад дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Нэгдүгээрт, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд 7 дахь хэсэг “Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.”, 8 дахь

хэсэг “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.”, 9 дэх хэсэг “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.” гэж тус тус нэмж тусгасан.

Эрүүгийн хуульд орсон эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь авлига, албан тушаалын гэмт хэрэг, ялангуяа Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болоод байгаа дээд түвшний авлигатай тэмцэхэд чухал хувь нэмрээ оруулах хуулийн нэмэлт өөрчлөлт болж чадсан.

Хоёрдугаарт, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, Хууль зүйн байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлсэн. Гуравдугаарт, ХАСХОМ-ээ мэдүүлснээ нийтийн албан тушаалтнууд Баталгааны маягтыг бөглөн баталгаажуулах тогтоол батлагдан мөрдөгдөж байна. Мөн Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд энэхүү төсөлд хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаалтнуудыг оновчтой тогтоох, мөн тэдгээр албан тушаалтнуудтай хамаарал бүхий этгээдүүдэд тавигдах хязгаарлалтыг шинээр оруулжээ. Энэ нь дотоодын эрх зүйн орчин дахь “улс төрд нөлөө бүхий этгээд”-д хамаарах албан тушаалтнуудын хүрээг шинэчлэн тодорхойлж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Дөрөвдүгээрт, 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн санал тусгагдаж “Монгол Улсын Их Хурлын гишүүний тангарагт “...авлига, ашиг

сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая...” гэсэн заалт, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-аар мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дээрх агуулга бүхий 2, 3 дахь өгүүлбэр нэмэлтээр орсон.

Тавдугаарт, Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/, төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ХАСХОМ гаргах албан тушаалтны хамрах хүрээг оновчтой тогтоох, ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох зорилгоор УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд хууль тогтоогчид хүргүүлэхэд бэлэн болгосон. (Биелэлт 70 хувь)

4.1.5.7-3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгож, хөгжүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг олон арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэн, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг цахим хэлбэрээр оруулах, үнэлгээг цахимд шилжүүлэх зорилгоор мэдээллийн нэгдсэн цахим сан khutulbur.iaac.mn хөтлөн ажиллалаа.

Мөн тус хөтөлбөрийн мэдээллийн нэгдсэн цахим сангийн програм хангамжийг хөгжүүлэх чиглэлээр “Ухаалаг Засаг” ТББ-тай хамтран ажиллаж, Авлигын эсрэг нэгдсэн сүлжээ болгон өргөжүүлсэн. Тухайлбал, 2020 онд 4 дэд санг хөгжүүлсэн бол 2021 онд 7 дэд санг хөгжүүлэн ажиллуулжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.5.8-1. Гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар сургалт явуулах /АТГ, 2017-2022/

2020 онд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-

тай хамтран Монгол улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны 4 өдрийн сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ДХИС, УЕПГ, Монгол банкны 29 алба хаагчдыг, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR)-аас зохион байгуулсан “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад АТГ-т шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгчийг, ахисан түвшний 3 удаагийн цахим сургалтад 9 албан хаагчийг, “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтад АТГ, УЕПГ, ЦЕГ-ын 18 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн “Иргэний нэхэмжлэлээр олон улсад хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт цахим сургалтад Авлигатай тэмцэх газрын 65 албан хаагч, 2021 онд “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл-Дарквеб” богино хугацааны цахим семинарт АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 400, “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт сургалтад АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 24 албан хаагчийг тус тус оролцуулсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн авлигын эсрэг сүлжээ, Ази номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээ, ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг гадаад улсын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн сургалтуудад давхардсан тоогоор 120 гаруй албан хаагч, бусад хууль сахиулах байгууллагын 555 албан хаагчийг хамруулсан.

2022 онд АТГ-аас гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулж, туршлага судлууллаа. Үүнд: Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-оос зохион байгуулсан «Санхүүгийн

аудит хийх техник, стратеги» сэдэвт 2 удаагийн сургалтад 30 албан хаагчийг, АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох” сэдэвт 2 өдрийн сургалтад 10 албан хаагчийг, StAR санаачилгаас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сэдэвт 4 өдрийн сургалтад 15, «Виртуал валютын тухай ахисан түвшний семинар» сэдэвт 4 өдрийн сургалтад 30 албан хаагчийг тус тус хамруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санг бий болгох /АТГ, ХЗДХЯ 2018-2019/

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлсэн. Энэхүү мэдээллийн сан дээр үндэслэсэн иргэдэд мэдээлэл өгөх зориулалт бүхий Шүүх эрх мэдлийг болон хууль сахиулах байгууллагуудын цахим мэдээллийн нэгдсэн систем²¹ портал хуудсыг 2018 оны 06 сарын 15-ны өдөр туршилтын журмаар ажиллуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгаж, тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх тухай” А/134 дүгээр тушаалын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг Прокурорын байгууллага хариуцан ажиллаж байна.

Улсын ерөнхий прокурорын газраас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр цахим мэдээллийн нэгдсэн системийн портал хуудсыг 2020 оны эхний хагас жилд ашиглалтад оруулсан. Уг систем нь төрийн үйлчилгээний “ДАН” системийн тусламжтай иргэн өөрийн регистрийн дугаарт бүртгэлтэй утасны дугаарыг ашиглан, зөвхөн өөрт холбогдох мэдээлэл буюу гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гаргагч иргэн болон мөрдөх байгууллага, прокурор, шүүхийн шатанд шалгагдан, шүүгдэж байгаа иргэдэд өөрт хамааралтай мэдээллийг цаг тухайд нь хүргэх, хууль, эрх зүйн тусламж өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг таниулах зорилго бүхий иргэний портал систем 21 www.e-justice.mn

юм. Тухайлбал, уг системээс иргэн дараах мэдээллийг авах боломжтой. Үүнд:

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад гаргасан гомдлын явц, шийдвэрлэлтийн байдалтай танилцах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явц, шийдвэрлэлттэй танилцах;
- Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээлэлтэй танилцах;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын зураглалтай танилцах;
- Тухайн шатанд хамаарах хуулийн зүйл, хэсэг, заалт, эрх зүйн зөвлөмжтэй танилцах зэрэг мэдээллийг авах боломжтой.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 54 дүгээр хуралдааны тэмдэглэлээр зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Зөрчлийн бүртгэлийн нэгдсэн систем”-ийг боловсруулсан, нэвтрүүлэхэд бэлэн болсон бөгөөд Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар тус системийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэхтэй холбогдуулан туршилтын журмаар 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан. Уг системд зөрчил шалган шийдвэрлэх, хянах эрх бүхий 32 байгууллагын 12,000 гаруй албан хаагч суурин болон зөөврийн төхөөрөмж ашиглан холбогдож, үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах юм. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-2. Мэдээллийн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх /АТГ, 2017-2020/

2020 онда ашиглалтад оруулсан Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын цахим мэдээллийн нэгдсэн систем²²-ийн портал сайт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээллийг иргэнд шуурхай хүргэж, хуулийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон.

Улсын ерөнхий прокурорын газраас иргэдэд портал сайтыг сурталчлах, хэрхэн нэвтэрч 22 www.e-justice.mn

ашиглах талаарх мэдлэгийг олгосон богино хэмжээний шторкуудыг бэлтгэж, олон нийтэд хүргэж эхэлсэн байна. Мөн Прокурорын байгууллагын мэдээлэл лавлагааны Нэг цонхны үйлчилгээний төвийг байгуулснаар, тус байгууллагын чиг үүргийн хүрээнд хамаарах мэдээлэл, лавлагааг нэг дор төвлөрүүлэн, иргэдэд үйлчлэх боломж бүрдсэн бөгөөд 2022 оны 07 сарын 07-ны өдрөөс хойш нийт 264 иргэнд үйлчилгээ үзүүлжээ.(Биелэлт 70 хувь)

4.1.5.10-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах /ШЕЗ, 2017-2022/

Монгол Улсын шүүхийн цахим сан буюу www.shuukh.mn сайтад төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг бүрэн эхээр байршуулан, иргэд, олон нийтэд мэдээлдэг. Дээрх цахим хуудсыг 2011 оноос хойш технологийн шинэчлэл хийгдээгүй байсныг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр шинэчилснээр иргэд, олон нийт тухайн цахим хуудсаар шүүхийн шийдвэрт хайлт хийхэд хэргүүдийг Эрүүгийн хуулийн бүлэг тус бүрээр нь ангилсан нь хялбар болсон. Тус цахим санд 2020 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн 377212, 2021 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн 403542, 2022 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн 452305 анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хадгалагдаж байгаа бөгөөд 2021 онд тус цахим санд 1,994,189 удаагийн хандалт, 2022 онд 2,388,367 удаагийн хандалт хийгджээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”²³, мөн Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 343 дугаар тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам”-ыг тус тус шинэчлэн баталсан нь цахимаар болон бусад хэлбэрээр иргэдэд шүүхийн шийдвэрийг танилцуулах нөхцөлийг боловсронгуй болгожээ.

23 Энэхүү журмын мөн оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон байна.

Тухайлбал, Тус Зөвлөлөөс шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан хэргийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулдаг. Тус хэвлэлийн бага хурлаар олон нийтийн анхаарал татсан, авлига албан тушаалын хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн дүн мэдээг танилцуулж хэвшээд байна. “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг 2020 онд 8 удаа, 2021 онд 7 удаа, 2022 онд 4 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд эдгээр 3 жилийн хугацаанд давхардсан тоогоор 255 хэвлэл мэдээллийн байгууллага, 543 сэтгүүлч хэвлэлийн хуралд оролцож, олон нийтэд мэдээлэл түгээжээ.

Хэвлэлийн бага хурлыг телевиз, радио, сайт, фейсбүүк хуудас зэрэг хэвлэл мэдээллийн бүх хэлбэрээр хүргэдэг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”-д 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулснаар хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, ажилтнууд урьдчилан хүсэлт гаргах шаардлагагүйгээр сурвалжилга бэлтгэх боломж бүрдсэн. Улмаар “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлаар 2021 онд 254 олны анхаарал татсан мэдээллийг олон нийтэд түгээснээс авлига, албан тушаалын хэрэг буюу төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсантай холбоотой 55 мэдээллийг, 2022 онд 450 олны анхаарал татсан хэргийн мэдээллийг олон нийтэд түгээснээс авлига, албан тушаалын хэрэг буюу төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсантай холбоотой шүүхээр шийдвэрлэсэн 120 гэмт хэргийн талаарх мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүн таслах ажлын дүн мэдээг хагас, бүтэн жилээр жилд 2 удаа олон нийтэд мэдээлж,²⁴ Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журмын дагуу shuukh.mn цахим хуудаст шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг, маргааны талаарх мэдээллийг хаалттай, эсхүл нээлттэй байдлаар нийтэлж хэвшсэн. Мөн Дээрх цахим хуудаснаас

24 “www.judcouncil.mn” цахим хаягаас дээрх мэдээллийг авах боломжтой.

шүүх, хуулийн зүйл, хэсэг, огноо зэрэг түлхүүрээр мэдээллийг хайж, танилцах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

Мөн 2022 оноос эхлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан цэсээр олон нийтийн санал хүсэлт²⁵-ийг авч эхэлсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.5.10-2. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

Шүүн таслах ажлын болон шүүхийн захиргааны мэдээ мэдээллийг “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч” сургалтад хамрагдсан сэтгүүлчдээр дамжуулан олон нийтэд үнэ төлбөргүй түгээж байгаа нь олон нийтэд үнэн бодит мэдээлэл хүрэх ач холбогдолтой хамтын ажиллагаа болж байна.

Хэвлэл мэдээллийн мониторингоос үзэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрч байгаа шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийн 96 хувь нь шүүхийн албан ёсны эх сурвалжтай байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүн таслах ажлын дүн мэдээг хагас, бүтэн жилээр жилд 2 удаа олон нийтэд мэдээлж хэвшсэн, мөн “www.judcouncil.mn” цахим хаягт байршуулж хэвшсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.5.11-1. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг үүсгэн, сургалтад ашиглах /АТГ, ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Улсын ерөнхий прокурорын газраас эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалт, судалгаа, хяналт шинжилгээний мөрөөр харьяа прокурорын газрын прокуроруудад зориулан гаргасан мэдээлэл, зөвлөмж, ажлын чиглэл зэрэг баримт бичгийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйлчлэл, прокурор, шүүхийн шийдвэрийн төрөл, олны анхаарал татсан, шүүхийн практик тогтоосон шийдвэр зэрэг байдлаар төрөлжүүлэн, PDF файл хэлбэрээр нэгдсэн мэдээллийн санг бий болгосон.

Мөн Улсын ерөнхий прокурорын газраас

25 <https://judcouncil.mn/site/application>

улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэсэн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх гэмт хэргийн тоон үзүүлэлт, авлигын гэмт хэргийн үйл баримт, бодит байдалд хууль зүйн дүгнэлт хийж буй байдал, хууль тогтоомжийн хэрэглээ, улсын яллагчийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх дүгнэлт, шүүхээс оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ, төрөл, хэмжээ түүнийг сонгосон үндэслэлийг оновчтой тодорхойлох чиглэлээр “Зөвлөмж” гарган, нэгж прокурорын газруудад хүргүүлж, 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр цахим сургалт зохион байгуулсан.

Прокурорын байгууллагын цахим бүртгэлд авлигын гэмт хэрэгт шүүгдэгчийн хувийн байдал, зүйлчлэл, гэмт хэргийн шинж, үе шат, хамтран оролцоо, шүүхээс оногдуулсан ял, прокурорын ялын саналын харьцаа, хохирол, хор уршиг, зэрэг мэдээллийг багтаасан судалгааны модулийг бий болгосноор судалгаа шинжилгээ, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын газар нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ял, улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын дүгнэлтийг 2020, 2021 оны байдлаар харьцуулан судалж, эрүүгийн хариуцлагыг хэргийн бодит байдал, нийгмийн аюулын шинж чанар, учруулсан хохирол, үр дагавар, шударга ёсны зарчимд нийцүүлж, үндэслэл бүхий дүгнэлт хийх, үйл ажиллагаандаа хэвшил болгох асуудлын талаар 2022 онд мэдээлэл, зөвлөмж гарган нэгж прокурорын газарт хүргүүлсэн. Энэ төрлийн зөвлөмжийг урд онуудад прокуроруудад хүргүүлж байсан бөгөөд энэ ажил нь тогтмол хэрэгжиж хэвшжээ.

Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсээс Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирол төлөгдөөгүй шалтгаан нөхцөл, төлөгдөөгүй хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх боломжтой эсэхийг 2019 он, 2020 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн прокурорын газруудын хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тогтоол, шүүхийн тогтоол, магадлалын хэмжээнд судалж, анхаарах асуудлаар 5/71 дугаартай мэдээлэл бичиж, харьяа прокурорын газруудад хүргүүлсэн байна. Судалгааны мөрөөр төр, нийтийн ашиг

сонирхолд учирсан хохирол төлөгдөөгүй 14 хэрэгт нэхэмжлэл гаргуулах, түүнчлэн 18 хэрэгт авагдсан нотлох баримтуудад үндэслэн холбогдох ажиллагааг явуулж, прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаар дүгнэлт хийлгүүлэхээр харьяа прокурорын газарт албан бичгээр үүрэг өгч, гэмт хэргийн шинжтэй хэргийг тус прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст хянуулахаар тус тус шийдвэрлэсэн. Мөн төрийн байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах, шаардлагатай тохиолдолд төрд учирсан хохирлыг нэхэмжлэхэд өмгөөлөгчийн байр сууринаас, эрх зүйн туслалцаа үзүүлж хамтран оролцох талаар сурталчлан таниулах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн.

Судалгааны дүнгээс үзэхэд прокурор төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах боломжтой, өөрөөр хэлбэл гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон ч хэрэгт авагдсан баримтаар гэрээ хэлцэл, үүргийн гүйцэтгэл, тендер, сонгон шалгаруулалт зэрэг иргэний маргаанд Иргэний хуулийн тохирох зүйл заалтыг баримтлан нэхэмжлэл гаргах, эсхүл төрийн байгууллагаар нэхэмжлэл гаргуулах, хийж гүйцэтгэсэн ажил, худалдан авсан бараа бүтээгдэхүүний чанарт дүгнэлт хийн, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт зааснаар иргэн байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай нотлох баримт болон мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагаа явуулж, иргэний журмаар нэхэмжлэх эсэхийг тодорхойлж төрийн байгууллагуудтай хамтран ажиллах боломж байна гэж дүгнэсэн.

Авлигатай тэмцэх газраас “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл”-ийн 2011-2020 оны шүүхийн шийдвэрийн эмхэтгэлүүдийг хэвлүүлэн олон нийтэд түгээв. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой.

Монгол Улсын хэмжээнд 2021 онд Эрүүгийн хууль /2002 он/-ийн Хорин наймдугаар бүлэг Албан тушаалын гэмт хэрэг, Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулгын Хорин хоёр дугаар бүлэгт заасан 636 холбогдогчтой, 235 хэрэг хүлээн авснаас 33 хэргийг прокурорт буцааж, 4 хэргийг түдгэлзүүлж, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 155 хэргийг хянан шийдвэрлэж 42 хэргийн үлдэгдэлтэй байна. Эрүүгийн 155 хэрэгт холбогдох 299 хүнд ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ ногдуулсан байна.

АТГ 2021 онд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан бол 2022 онд хуульд заасан харьяаллын 1806 үйлдэлтэй, 1184 холбогдогчтой, 1520 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16.3 хувиар өссөн байна.

2021 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 1,002,100,805,191 /нэг их наяд хоёр тэрбум нэг зуун сая найман зуун таван мянга нэг зуун ерэн нэг/ сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 96,207,070,220 /ерэн зургаан тэрбум хоёр зуун долоон сая далан мөнгө хоёр зуун хорь/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 119,502,691,958 /нэг зуун арван есөн тэрбум таван зуун хоёр сая зургаан зуун ерэн нэгэн мянга есөн зуун тавин найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөлт 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 5,024,895,829,317.00 (таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 2,374,934,309,243.00 (хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг

518,039,332,298.00 (таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөнтөлөлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт учирсан хохирлын 47.3 хувийг нөхөн төлүүлээд байна. Хахуулийн 18,874,521,566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.(Биелэлт 70)

4.1.5.11-2. Олон улсын байгууллага, гадаад орноос багш, мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулах /АТГ, 2017-2019/

2020 онд Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга/STAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалт, ахисан түвшний сургалтыг 3 удаа, “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний хоёр шатны сургалт, “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг, 2021 онд “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл-Дарквеб” богино хугацааны цахим семинар, “Санхүүгийн мөрдлөг” сургалтыг тус тус зохион байгуулсан.

2022 онд АТГ-аас гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулж, туршлага судлуулсан. Тухайлбал, Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-ээс зохион байгуулсан «Санхүүгийн аудит хийх техник, стратеги» сэдэвт 2 удаагийн сургалтад 30 албан хаагчийг, АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох” сэдэвт 2 өдрийн сургалтад 10 албан хаагчийг, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (STAR)-аас зохион байгуулсан “Удиртгал: Хөрөнгийн менежмент” сургалтад 52 албан хаагчийг, БНСУ-ын Авлигын эсрэг,

иргэний эрхийн хорооноос зохион байгуулсан ACRC Авлигын эсрэг виртуал сургалтын курс зохион байгуулах 4 өдрийн сургалтад 10 албан хаагчийг, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (STAR)-аас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сэдэвт 4 өдрийн сургалтад 15 албан хаагчийг, “Виртуал валютын тухай ахисан түвшний семинар” сэдэвт 4 өдрийн сургалтад 30 албан хаагчийг тус тус хамруулсан. (Биелэлт 100)

4.1.5.12-1. Сургуулиудын давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгуулах /АТГ, ХЗДХЯ, 2017-2018/

“Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв туссан байдалд дүн шинж илгээ хийх” үйл ажиллагааг хэрэгжүүлж “Шүтэлцээт Оюу” ТББ-ын боловсролын салбарын шинжээч, судлаачидтай хамтран хичээл, сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийлгүүлэх ажлыг зохион байгуулж, шинжилгээний дүгнэлтийн дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан санал дүгнэлтийг нэгтгэн Боловсрол, шинжлэх ухааны сайдад зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжөөр боловсролын салбарт бүх түвшний сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд нийтийн алба, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, мэдлэгийг түгээх, авлигаас ангид байх заан үйлийг дадал хэвшил болгох хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлэх, сургалтын байгууллагуудад тавигдах стандарт шаардлага, магадлан итгэмжлэлийн сонгон шалгаруулалт, тэдгээрийн хариуцлага, урамшууллын үзүүлэлтэд авлигаас ангид байх, шударга ёсны зарчимд нийцсэн шалгуурыг тусгах саналыг хүргүүлсэн. Улмаар 2019 онд батлагдсан “Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн сонгон судлах хөтөлбөрийн 10 дугаар ангийн сурагчдад зориулсан хөтөлбөрийн 10.6 дахь хэсэгт “Шударга ёс ба авлига” сэдэв тусгагджээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо” төслийн хүрээнд зөвлөх

үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан Боловсролын хүрээлэнгээс “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн мэргэжлийн бус 1-2 дугаар курсийн оюутнууд, мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагсдад зориулсан эрх зүйн албан бус хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг хийж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Мөн “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн мэргэжлийн бус 1-2 дугаар курсийн оюутнууд, мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчид, багш нарт зориулсан нийт 6 гарын авлага /модуль/ боловсруулсан. Энэхүү модульд ёс суртахуун, шан харамж, авлига гэж юу болох, хэрхэн шударга иргэн байх талаар насны онцлогоос хамаарсан агуулгууд оржээ. Модулийн хүрээнд Нийслэл хотод 120 сургагч багш бэлтгээд байгаа бөгөөд 2023 оноос 21 аймагт сургагч багш бэлтгэхээр төлөвлөж байна. Цаашид сургалтын модульд орсон агуулгыг албан боловсролын хөтөлбөрт тусгуулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яаманд санал хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.5.13. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх /АТГ, 2017-2022/

Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, гаргах үүрэг бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэх чиглэлээр холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, төслийг эцэслэн боловсруулж, хууль тогтоогчид хүргүүлэхэд бэлэн болгосон. Мэдүүлэг гаргах албан тушаалтны хүрээг тодорхойлоход тухайн албан тушаалын авлигад өртөх эрсдэлийг үндэслэл болгохоос гадна хуулиар тогтоосон хэрэгжүүлэх чиг үүрэг, албан тушаалын ангилал зэрэглэл зэргийг баримталж харгалздаг. **Тухайлбал**, мэдүүлэг гаргагчийн тоо өмнө онд 43692 байсан бол 2022 онд 47553 болж өссөн нь 2021 оны сүүлчээр Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Шүүхийн сахилгын хороо, Боловсролын ерөнхий газар, Үндэсний итгэмжлэлийн төв зэрэг байгууллага шинээр үүсэн байгуулагдсан, нөгөө талаас, тус газраас 2021 онд Төрийн болон төрийн

өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компаниудад мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалт явуулж, төсөв, хөрөнгө захиран зарцуулах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгжид төрийн тодорхой үйлчилгээг хэрэгжүүлэх бие даасан нэгжийг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий албан тушаалтныг илрүүлэн тодорхойлж, тэднийг мэдүүлэг гаргагчаар нэмсэнтэй холбоотой юм. Цаашид ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байх тул төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албаны төсөв хөрөнгө захиран зарцуулах, ажилтныг томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, зөвшөөрөл олгох зэрэг талаарх судалгааг АТГ-тай шууд харилцдаг 118 байгууллага, түүний харьяа 1700 гаруй салбар нэгжийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудаас гаргуулж саналыг нэгтгэн боловсруулсан болно. (Биелэлт 70 хувь)

4.1.5.14-1. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгох /АТГ, 2017/

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг шинэчлэн боловсруулж, маягтыг

нөхөх зааврын төслийг боловсруулсан. Төсөлд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудаас саналыг авч тусгаж, төслийг эцэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлахад бэлэн болгосон. (Биелэлт 100 хувь)

4.1.5.14-2. Мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжих /АТГ, 2017-2022/.

Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Ухаалаг засаг” төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газарт ашиглагдаж байгаа meduuleg.iaac.mn, iad.iaac.mn, e-office, smart.iaac.mn, search.iaac.mn, xasxom.iaac.mn гэх цахим системүүдийг интеграцичлах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх

ажлыг 2021 оны 12 дугаар сараас эхлүүлсэн. Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цахим системийн програм хангамж, өгөгдлийн сан, техник хангамж болон сүлжээний зохион байгуулалтын хувьд бүрэн шинэчлэх зорилгын хүрээнд системийг 2 үе шаттай хөгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) болон хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг бүрэн цахим26-аар хүлээн авч хэвшсэн.

Тухайлбал, 2022 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 14861 этгээдийн ХАСУМ-ийг цахимаар хүлээн авснаас 14695 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 166 мэдүүлэг хянагдаж байна.

Хүснэгт 5.9. Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн тоо (өмнөх оны мөн үетэй харьцуулбал).


Он	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс				Үлдэгдэл
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт АСЗ үүсэх	Хуульд зааснаар буцаасан	
2021	12,504	12,468	11,162	1,018	22	266	36 (0.3)
2022	14,861	14,695	13,616	918	37	124	166 (1.1)
	+2,357	+2,227	+2,454	-100	+15	-142	+130 (+0.8)

2022 онд хүлээн авсан ХАСУМ-ийн тоо 2021 оны мөн үетэй харьцуулахад 2227 нэгжээр буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын 15872 буюу 34.0 хувь нь төрийн тусгай, 10904 буюу 23.0 хувь нь төрийн захиргааны, 7741 буюу 16.0 хувь нь улс төрийн, 6838 буюу 14.0 хувь нь төрийн үйлчилгээний

удирдах, 3074 буюу 7.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах, 1053 буюу 2.0 хувь нь ажлын албаны, төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах албан тушаалтан 220 буюу 1.0 хувь нь, төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан 38 буюу 0.1, 1814 буюу 4.0 хувь нь бусад албан тушаалтнууд тус тус эзэлж байна.

Зураг 5.1. Цахимаар ХАСХОМ гаргасан албан тушаалтны тоо (төрийн албан тушаалын ангиллаар).



Нийт мэдүүлэг гаргагчийн 23302 буюу 55.0 хувь нь Улаанбаатар хотод, 18384 буюу 45.0 хувь нь орон нутагт, мөн 12102 буюу 29.0 хувийг ахлах мэргэжилтэн, болон удирдах, 29583 буюу 71.0 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан эзэлж байна. Орон нутгаас Хөвсгөл аймгаас 1308 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.(Биелэлт 70 хувь)

4.1.5.15-1. Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох /АТГ, 2017-2019/

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төсөлд төрийн дээд албан тушаалтнуудад хориглох хууль бус нөлөөллийн хэлбэрийг тогтоох чиглэлийн зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал, зарим улс төрд нөлөө бүхий этгээд болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдэд төрөөс хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, эсхүл төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллах зэрэг асуудлыг хориглохоор хуулийн төсөлд тусгажээ. Хуулийн төслийг УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар хэлэлцэгдэнэ.

Мөн шүүх засаглал дахь хууль бус нөлөөллийг тодорхойлох зорилгоор 2021 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 45 дугаар зүйлийн 45.1-д “Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.” гэж заажээ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам”, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”, “Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримт”, “Нөлөөллийн мэдүүлгийн бүртгэл”, - “Тэмдэглэлийн бүртгэл”, “Баталгааны тэмдгийн загвар”-ыг тус тус шинэчлэн баталсан.(Биелэлт 70 хувь)

4.1.5.15-2. Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох /ЗГХЭГ, 2017-2019/

Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2-т “29.6.Энэ хуулийн 20.2 дахь хэсэг, 20.1 дүгээр зүйлд заасныг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн бол Авлигатай тэмцэх газар энэ талаарх мэдээллийг прокурорт хүргүүлнэ.” гэж заажээ. Ингэснээр холбогдох хуулийн заалтыг зөрчсөн

албан тушаалтан, иргэнд зохих хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдэхээр байна. Хуулийн төслийг УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар хэлэлцэнэ.(Биелэлт 70 хувь)

4.1.5.16-1. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2019/

Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд заавал авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар санал, зөвлөмж гаргах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны а/183 дугаар тушаалаар “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү зааврын дагуу тус газраас 2021 онд төрийн байгууллага, албан тушаалтны батлан гаргасан нийт 18 дүрэм, журам, шийдвэрт авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал үүсгэх эрсдэл байгаа эсэхийг судалж, өөрчлөх, хүчингүй болгуулах талаар санал, зөвлөмж боловсруулж, 9 шийдвэрт захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эсэх талаар лавлагааг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргуулж, 3 байгууллагад шийдвэрийг хүчингүй болгуулах санал хүргүүлж, 2 шийдвэрийг хүчингүй болгох ажлыг зохион байгуулсан.

2022 онд нийт 42 шийдвэр, дүрэм, журмыг хянаснаас 33 нь хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй нөхцөл байдал тогтоогдсон. Иймд тухайн дүрэм, журмын бүхэлд нь хүчингүй болгох тухай 23, өөрчлөлт оруулах 6, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх 4 саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Хүргүүлсэн саналын дагуу 2 шийдвэр хүчингүй болж, 3 шийдвэрийг холбогдох байгууллагаас хуульд нийцүүлэх арга хэмжээ авч байгаа тухай хариу ирүүлээд байна.(Биелэлт 30 хувь)

4.1.5.17-1. Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид тусгаж нэр томъёог тодорхой болгох /АТГ, 2017-2018/

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн тайлбар хэсэгт:

“-Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө.” гэж тусгасан. Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь хахууль өгсөн иргэнийг нөхцөл байдлаас нь хамааруулан хуулийн хариуцлагаас чөлөөлөх, хүлээх хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөлийг тодорхой зааж өгсөн онцлог зохицуулалт болжээ. (Биелэлт 100 хувь)

Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 18 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.6.1-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, Авлигын эсрэг түншлэл /PACI/-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Авлигын эсрэг түншлэлийн гол зарчмуудыг сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх /МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ 2017-2019/

4.1.6.1-2. Дэлхийн эдийн засгийн форумын Авлигын эсрэг түншлэлд нэгдсэн компаниудад ил тод байдлын үнэлгээ хийх, хариуцлагыг дээшлүүлэх /МҮХАҮТ/

4.1.6.1-3. Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан сурталчлах /МҮХАҮТ, МБЗ 2017-2020/

Авлигын эсрэг түншлэл /PACI/-ийн удирдах зөвлөлийн ажиллах хугацаа дууссан бөгөөд шинээр зөвлөл байгуулаагүй тул дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй.

4.1.6.2-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах /АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, ОӨУБЕГ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас 2020 онд “Таван богд” групп, “Improve program” хөтөлбөр, “Шунхлай” групп, “MNAgency”, “Viral”, “Orgilmedia”, “Global Event”, “EMOZ agency”, “IDlabAgency”, “Boomerang Mongolia”, “iLAB Production”, “IMGroup”, “Shogun Art Studio” зэрэг хувийн хэвшлийн 21 байгууллагын 320 хүнд “Бизнесийн ёс зүй ба авлига”, “Авлигын гэмт хэрэг, анхаарах асуудал” зэрэг сэдвээр чадавхжуулах сургалтын зохион байгуулж, хувийн хэвшил, бизнес эрхлэгчдэд зориулан гаргасан “Авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, Шударга ёс хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо” зэрэг гарын авлагыг сурталчлан түгээсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас үл хөдлөх хөрөнгийн 60 зуучлагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 3 удаагийн сургалт, Стандарт, хэмжил зүйн газраас олон улсын стандарт, хэм хэмжээг үйл ажиллагаандаа тусгаж нэвтрүүлэх чиглэлээр чадавхжуулах 38 удаагийн цахим сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж компаниудын 1140 хүнийг хамруулан тус тус зохион байгуулсан.

2021 онд МҮХАҮТ-ын дэргэдэх “Бизнесийн Ёс Зүйн Төв”-өөс Хариуцлагатай бизнес, бизнесийн шударга байдлын аргачлал хэвшүүлэх” модуль сургалтад Монголын криминологичдын холбоо, Санхүү бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэн, Скайтел групп ХХК, М Си Эс холдинг, Макс импекс ХХК, СҮҮ ХК, Инвескор ББСБ, Хаан банк, Эдүкэйтэд энтерпрайз ХХК, Бороо гоулд ХХК, Таван богд трэйд ХХК-ийн төлөөлөл 150 хүнийг, “Хариуцлагатай бизнес, бизнесийн шударга байдлын аргачлал хэвшүүлэх” сургалтад 30 гаруй аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас “Шунхлай групп”-ийн ШТС-ын 85 эрхлэгч, ажилтнуудад давтан сургалт, Стандарт хэмжил зүйн газраас аж ахуйн нэгж байгууллагад тохирлын үнэлгээ, хэмжил зүйн чиглэлээр 235 аж ахуйн нэгж байгууллагын 989 ажилтанд сургалтыг тус тус зохион байгуулсан. Татварын ерөнхий газраас Улсын хэмжээнд 2147 удаагийн сургалт зохион байгуулж, том сегмент 26418, дунд сегмент 8128, жижиг сегмент 20159, бичил сегмент 19674, хувь хүн 77948 нийт 142327 татвар төлөгчийг хамруулсан. Том татвар төлөгчдийн газар, Нийслэл, аймаг, дүүргийн татварын албадаас татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн татвар төлөгчийн ангилал тус бүрд тохирсон сургалтыг цахимаар зохион байгуулж, видео хичээл бэлтгэн түгээсэн. Тухайлбал, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд Татвар төлөгчөө сонсьё цахим хэлэлцүүлэг, Монгол Такс ТМЗ-тэй хамтран ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан “Татвар бидний амьдралд” цахим хичээл, Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэгтэй хамтран “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?” 14 дэх удаагийн оюутны цахим

тэмцээнийг тус тус зохион байгуулав. УБЕГ-аас “Улсын бүртгэлийн байгууллагын цахимжилт” сэдэвт 10 минутын видео бэлтгэн түгээсэн.

2022 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Авлигатай тэмцэх газартай хамтран хувийн хэвшлийн 70 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөлд чадавхжуулах сургалт, Стандарт, хэмжил зүйн газраас стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн чиглэлээр төлөвлөгөөт, захиалгат, нэмэлт нийт 60 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Цахим монгол хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-ээр дамжуулан улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээг цахимаар авах мэдээллийг багтаасан Улсын бүртгэлийн байгууллагын цахимжилт гэсэн 10 минутын видео бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж иргэдэд мэдээлэл хүргэсэн. Уг видео мэдээг нийт 18100 гаруй хүн үзэж хандалт хийсэн байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.2-2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх /ҮХГ, ЗГХЭГ, СЯ, АТГ 2018-2022/

Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Сангийн сайдын тушаалаар олгодог байсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Мэргэшсэн нягтлан бодогчийн институт ТББ-д, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн үйлчилгээг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, ашиглах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2019 оны А/16, А/07 дугаар хамтарсан тушаалаар “Олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар

хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулснаар Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоонд шилжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодод эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэхээр тусгагдсан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх /ЗГХЭГ, ҮХГ, 2018-2022/

Бизнес, хөрөнгө оруулалтын орчинд тулгарч буй түгээмэл саад, бэрхшээлийг төр, хувийн хэвشلүүд хамтран шийдвэрлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо”-г 2017 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар «Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл»-ийн дэргэд байгуулсан. 2017-2020 оны хугацаанд Зөвлөлдөх хорооны хурлыг нийт 10 удаа, техникийн ажлын хэсгийн хурлыг нийт 3 удаа зохион байгуулж, 3 зөвлөмж гаргаж, дараах асуудлыг авч хэлэлцсэн. Тухайлбал,

1. Татварын багц хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн талаар зөвлөмж;

2. Үндэсний хөгжлийн газар, Дэлхийн банкны группийн ОУСК-тай хамтран хийсэн “Хөрөнгө оруулалтын шинэчлэлийн зураглал”-ын үр дүнгийн тухай зөвлөмж;

3. Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн шимтгэлтэй холбоотой асуудлын

хүрээнд зөвлөмж;

4. Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

5. Баялаг бүтээгчдийг дэмжих цогц хуулийн төсөл боловсруулах тухай;

6. Үндэсний үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих тухай багц хуулийн төслийн үзэл баримтлал;

7. “Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах стратеги төлөвлөгөө”-ний төсөлд хорооны гишүүдээс цахимаар санал авч, саналуудыг тусгав.

Мөн “Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем”-ийг 2020 онд ашиглалтад оруулсан. Уг систем нь хөрөнгө оруулагчийн өргөдөл, гомдлыг төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэх нөхцөлийг бий болгосон.

Төр хувийн хэвшлийн түншлэл, харилцан итгэлцлийг сайжруулах, бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор шилдэг топ 150 аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын удирдлагуудтай уулзалт хийж, зөвлөмж гаргасан байна.

Авлигатай тэмцэх газраас 2021 онд Авлигын эсрэг үндэсний чуулганыг 4 салбар хуралдаантайгаар зохион байгуулсан. “Хувийн хэвшил ба шударга өрсөлдөөн” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан уг хуралдаанаар “Авлигаас ангид шударга өрсөлдөөнийг дэмжих нь”, “Хувийн хэвшлийн шударга байдал”, “Бизнесийн орчныг сайжруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангах нь”, “Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал: ил тод, хариуцлага, шударга байдлыг бэхжүүлэх нь”, “Монгол Улс ба Авлигын эсрэг сүлжээ/CAN/ бизнесийн шударга байдлыг дэмжих авлигын эсрэг шинэчлэл”, “Төрийн худалдан авах ажиллагааны ил тод шударга байдлыг нэмэгдүүлэх нь” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулагдав. Хуралдаанд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцож, тулгарч буй асуудлыг хэлэлцэж санал, байр сууриа илэрхийлсэн. Хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-т хүргүүлэн хэрэгжилтэд

хяналт тавин ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газрын удирдлага МҮХАҮТ-ын гишүүн байгууллагууд, бизнесийн холбоодын 60 гаруй төлөөлөлтэй “Business breakfast” уулзалтыг зохион байгуулж, хувийн хэвшлийнхэнд тулгарч буй асуудал болон авлигыг бууруулах талаарх хэлэлцэж, санал солилцсон.

Сангийн яамнаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулан олон нийт, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд танилцуулж, МҮХАҮТ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Бизнесийн хууль, эрх зүйн орчныг сайжруулахад хамтарч ажиллах талаар УИХ-ын зарим гишүүн МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийж, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төрөөс олгох тусгай зөвшөөрлийн тоог бууруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог сайжруулах чиглэлээр эдийн засаг, хөрөнгө оруулалттай холбоотой томоохон хуулийн өөрчлөлтүүдийг хийх чиглэлээр хэлэлцсэн. МҮХАҮТ-ын ерөнхийлөгч, танхимын тэргүүлэгч гишүүд ТӨБЗГ-ын дарга, дэд дарга нартай уулзалт зохион байгуулж, төрийн өмчит, хуулийн этгээдийн эрх зүйн байдал, засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ярилцаж, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд санал өгсөн (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах /ҮХГ, СЯ 2017-2018/

Сангийн яам 2018 онд Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний 3.2-т авлигаас урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчлөөс ангид байх агуулгыг тусган мөрдсөн.

Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллагад “Авлигын эсрэг үйл ажиллагааны

төлөвлөө”-г хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд “төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах” зорилтыг 2021 оноос эхлэн тусгасан. Барилга, хот байгуулалтын яам, ОБЕГ, ШШГЕГ, Үндэсний аудитын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Орхон, Хэнтий, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Ховд аймгийн ЗДТГ зэрэг 50 гаруй байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх агуулга бүхий заалтыг хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон иргэнтэй байгуулсан гэрээндээ тусгасан. Тухайлбал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар “Гэрээг байгуулах, хэрэгжүүлэх үйл явцад аливаа шан харамж, урамшуулал, давуу байдал олгохгүй байх”, “Авлига ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн зөрчил гаргахгүй байх”, ХХААХҮЯ “Энэхүү гэрээнд талууд ашиг сонирхлын зөрчилтэй аливаа саналыг шууд болон шууд бус хэлбэрээр тавихыг хориглоно”, “Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх явцад авлига, ашиг сонирхлын зөрчил, аливаа хууль бус үйлдэл гарсан тохиолдолд хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч гэрээг цуцлах үндэслэл болно”, Дархан-Уул аймгийн ЗДТГ “Гэрээний талууд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана”, Төрийн худалдан авах ажиллагааны газар “Талууд хамтын ажиллагаанд ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, өрсөлдөх тэгш боломжтой, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналт тавих зарчмыг баримтална”, “Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл нь үнэлгээний хороонд ажиллах явцдаа ашиг сонирхлын зөрчил бүхий аливаа үйлдэл, эс үйлдэл гаргасан тохиолдолд үнэлгээний хорооноос хасаж, үнэлгээний хорооны үйл ажиллагааны зардал, учирсан хохирлыг шаардана” гэх мэт зохицуулалтуудыг тусгажээ.

2022 онд батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлд “хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлгүй, төрийн түншлэгч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, эсхүл хамаарал бүхий этгээд биш, ашиг сонирхлын

зөрчилгүй байх;”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд тухайн этгээдийг түншлэлд оролцуулахгүй.” хэмээн заасан. Энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас “Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар”-т авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна. Төрийн худалдан авах ажиллагааны газар худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 48 төрийн бус байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2.3 дах заалтад “Талууд хамтын ажиллагаанд ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, өрсөлдөх тэгш боломжтой, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналт тавих зарчмыг баримтална.” гэж, 4.4-т “Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл нь үнэлгээний хороонд ажиллах явцдаа ашиг сонирхлын зөрчил бүхий аливаа үйлдэл, эс үйлдэл гаргасан тохиолдолд үнэлгээний хорооноос хасаж, үнэлгээний хорооны үйл ажиллагааны зардал, учирсан хохирлыг шаардана.” гэж, 5.5-д “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах гишүүдийг хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бөглөж, ашиг, сонирхлын зөрчлөөс ангид байх талаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.” гэж, 5.6-д “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төрийн бус байгууллагын төлөөлөл нь ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаарх мэдэгдлийг үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон өдрөөр илэрхийлэх бөгөөд ашиг сонирхол үүссэн бол энэ тухай мэдэгдлийг тендер шалгаруулалтын аль ч үе шатанд гаргах үүрэгтэй.” гэж тус тус зааж үнэлгээний хорооны гишүүдийг авлигаас урьдчилан сэргийлэхийг анхааруулан ажиллав. (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-3. Олон улсын болон дотоодын бизнесийн орчин дахь авлигатай тэмцэх сайн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг судлах, нэвтрүүлэх санаачилга өрнүүлэх /МҮХАҮТ, Гишүүн байгууллага. АТГ 2018-2019/

2020 онд МҮХАҮТ-ын дэргэдэх “Комплаенсын үндэсний зөвлөл”-ийг байгуулж, уг зөвлөлөөс

2021 оны 11 дүгээр 30-ны өдөр зохион байгуулсан “Комплаенс, бизнесийн ёс зүй анхдугаар чуулган”-д 200 орчим бизнесийн байгууллагын төлөөлөл оролцож, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга, ил тод, ёс зүйг эрхэмлэн, итгэлцэл, үнэт зүйлсэд тулгуурлаж урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах нь бизнесийн хөгжлийн тулгуур, авлигын эсрэг тэмцэх нь зөвхөн төрийн байгууллагын үүрэг биш, хувийн хэвшлийн оролцоо, манлайлал чухал болж байгаа талаар ярилцаж, бизнес орчин дахь шударга, ёс зүйтэй байдлыг бэхжүүлэхийн төлөө хамтран ажиллахаар санал нэгдсэн. Монгол Улс дахь бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх, бизнесийн таатай орчныг дэмжих зорилгоор МҮХАҮТ, “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ болон “Рио Тинто Монгол” ХХК нь хамтран “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэн 2021 онд МҮХАҮТ-ын дэргэд “Бизнесийн ёс зүйн төв”-ийг байгуулан тус төвөөр дамжуулан бизнесийн байгууллагуудад ёс зүйн дүрэм боловсруулах, хянах, засаглалын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, бизнесийн болон мэргэжлийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, бизнесийн ёс зүйн болон хууль зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ном, гарын авлагаар баяжуулсан номын сан ажиллуулж байна. Бизнесийн ёс зүйн төвөөс бизнесийн ёс зүйн талаарх олон нийт тэр дундаа бүх түвшний бизнес эрхлэгчдийн ойлголтыг нэмэгдүүлж, ёс зүйтэй бизнес эрхлэгч болоход сэдэлжүүлэх, сайн туршлагыг түгээх зорилгоор “Ёс зүй тогтвортой бизнес” цахим аяныг өрнүүлж, томоохон аж ахуйн нэгжүүд бизнесийн ёс зүйн тогтолцоог бүрдүүлж байгаа, сайн жишээ, туршлагаас таниулан, сурталчилсан байна.

“Бизнесийн үйл ажиллагаанд шударга, ёс зүйтэй, авлигаас ангид эрх зүйн орчныг бий болгох арга зам” сэдэвт онол, арга зүйн бага хурал, илтгэлийн уралдааныг зарлаж, дүгнэсэн байна. Уралдаанд 50 гаруй оролцогчийн 28 илтгэл өрсөлдсөн. (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-4. Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй бодлого, тогтолцоог санаачилж хэрэгжүүлсэн байгууллагыг урамшуулах механизм бий болгох/АТГ, МҮХАҮТ, ХЗДХЯ 2020-2022/

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн батлагдсан бөгөөд тус хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна”, мөн зүйлийн 34.2-т “Иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл ногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно”, мөн 34.3-т “Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж тус тус заасан. Энэ хүрээнд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулж, батлуулсан.

МҮХАҮТ-аас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг авлигаас ангид, бизнесийн ёс зүйг эрхэмлэх, комплаенсыг хэрэгжүүлэх бодлого зохицуулалтыг дотоод дүрэм журамдаа оруулах, хэрэгжүүлэх, ёс зүйн кодтой болох шаардлагыг тавьж ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах ёслолын ажиллагаанд “Комплаенс бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэгч энтрепринер” номинацийг 2021 онд шинээр оруулж өгсөн. “Комплаенс, бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэгч Энтрепринер” Хүрэл Меркурий цомын эзэнээр “Скайтел” ХХК шалгарсан байна. “Скайтел” групп нь ёс зүйн хороог нийт ажилтнууд дундаас нээлттэй сонгон шалгаруулан байгуулж, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлдэг төдийгүй ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг нууцлалтайгаар хүлээн авах шүгэл үлээх системийг ажиллуулж байна. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хувийн ашиг сонирхол нь группийн ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдлаас сэргийлэх зорилгоор эрх бүхий албан

тушаалтнуудаасаа хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шинэчлэн гаргуулдаг, худалдан авалт нь сонирхсон этгээдэд нээлттэй, шударга, өрсөлдөөнт зарчимд үндэслэн хараат бус сонгон шалгаруулалтын хэлбэрээр зохион байгуулж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг бизнесийн үйл ажиллагаандаа мөрдүүлэх, тэдгээрийн нийцлийг хангах хянан нийцүүлэлтийн тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг зэрэг бусад аж ахуйн нэгжүүдэд сайн жишээ болохоор ажил, арга хэмжээг хэрэгжүүлжээ. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулж, төслийг 2021.01.15-ны өдөр хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон иргэд, олон нийтэд, 2021.01.22-ны өдөр хууль, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн, судлаач багш нарын хүрээнд, 2021.01.29-ний өдөр Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ (MORA) түүний гишүүдийн хүрээнд тус тус нийт 10 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төслийг сайжруулах зорилгоор 2022 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах үүрэг бүхий МУИС-ын Хууль зүйн сургуулийн багш нарын зөвлөх багийг ажиллуулан хуулийн төслийн үзэл баримтлалыг Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон иргэд, олон нийтэд, хууль, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн, судлаач багш нарын хүрээнд, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ (MORA) түүний гишүүдийн хүрээнд тус тус цахимаар хэлэлцүүлсэн бөгөөд нийт 10 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулан, төслийг эцэслэн боловсруулж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-2. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

2020 онд Улсын Их Хурлын дэргэд Инновац, цахимбодлогын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, мөн Засгийн газрын бүтцэд Соёлын яам байгуулагдснаар 2018 онд боловсруулсан Өрсөлдөөний тухай хуулийн төслийг дахин боловсруулж, харилцаа, холбоо, мэдээллийн технологи, зам тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын төлөөлөл, багш, эрдэмтэн судлаачид, эм хангамжийн болон эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч, газрын тосны бүтээгдэхүүний салбарын аж ахуй эрхлэгч, барилгын салбарын аж ахуй эрхлэгч зэрэг 14 салбарын төлөөллийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, санал авсан.

2022 онд Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төслүүдэд төрийн захиргааны төв байгууллагуудаас ирсэн саналуудыг нэгтгэн зарим саналыг хуулийн төсөлд тусган сайжруулан боловсруулж, төслийг холбогдох судалгаануудын хамт 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн. Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин боловсруулж төслийг агентлагийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-3. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлал, хуулийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг боловсруулж, холбогдох төлөөллөөс саналыг авч тусгасан. НҮБ-ын Хүүхдийн сангийн Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхдийн хоол тэжээлийн зар сурталчилгааны асуудлаар гаргах саналыг хэлэлцүүлэх хүсэлтийн дагуу хуулийн төслийг боловсруулсан зөвлөх багийн гишүүд болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Ази номхон далайн орнуудын төслийн удирдагчтай агентлагийн удирдлага уулзалт

хийж хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, төслийн удирдагчийн зүгээс Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бусад улс орнуудын Зар сурталчилгааны тухай хуультай нийцүүлэхэд санал боловсруулж ирүүлэхээр тогтсон. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх /ШӨХТГ 2018-2020/

“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайд, Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан хөтөлбөр дэмжигдээгүй.

ШӨХТГ, ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй “Шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх хоёрдугаар шатны төсөл”-ийн хүрээнд Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг олон нийтэд сурталчлах зорилгоор 3 цуврал комикс ном бэлтгэн гаргаж тус номоо анимэйшн хэлбэрт оруулан олон нийтэд түгээсний зэрэгцэ, Өрсөлдөөний тухай хуулийг сурталчилсан гарын авлага боловсруулсан.

Патентын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Мөн Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Өрсөлдөөний чиглэлээр хэрэгжүүлэх 3 арга хэмжээг Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төсөд тусгуулахаар санал боловсруулж холбогдох яаманд хүргүүлсэн. Стандарт, хэмжил зүйн газраас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжаар байгуулан ажиллуулж, хуулийн төсөлд баталгаажуулалтын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг чөлөөт зах зээлийн зарчимтай уялдуулан тогтоох, төр хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн баталгаажуулалтын байгууллагуудыг бодлогоор дэмжих талаарх зохицуулалтыг тусгасан. Стандартын хэрэгжилт, бодлогоор

дамжуулан худалдаан дахь саад тотгорыг бууруулах, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор “Стандарт ба хөгжил” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулж байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр бичил бизнес эрхлэгчид, болон хүнсний дэлгүүрүүдэд хүнсний чанар аюулгүй байдлыг хангаж хүнсний бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалт гормыг баримтлан ажиллах талаар 2 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийж ажилласан. Сумдад ажиллах шинжээч бэлтгэх мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиар нийт 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 357 иргэнийг хамруулсан. 73 хэрэглэгчээс гомдол санал хүлээн авч, мэдээллийг тухай бүр тэмдэглэл хөтөлж баталгаажуулан, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг цахимаар болон албан бичгээр мэдэгдсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах /ШӨХТГ 2017-2019/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2021 онд төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэр нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн эсэхэд 13 хяналт шалгалтыг хийсэн. Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн 9 шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, Гадаад улсад зорчих иргэдээс ПСР шинжилгээг Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Интермед эмнэлэгт төлбөртэйгөөр авахуулах агуулга бүхий Эрүүл мэндийн сайдын тушаал нь нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгосон байх тушаалыг хүчингүй болгуулсан.

Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

2014 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам” нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 67 дугаар зүйлийн 67.2, Худалдаа, үйлчилгээг гэрээ байгуулж, зөвшөөрөл, эрх, батламж авсны үндсэн дээр явуулах талаар аливаа хуульд заагаагүй байхад аж ахуй эрхлэгчдээс дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх гэрээ хийж, батламж авахыг шаардаж, зөрчсөн тохиолдолд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч буй нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Хуульд зааснаас бусад тохиолдолд ...нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, ..., эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн болох нь тус тус тогтоогдсон тул журмыг хүчингүй болгох, хуульд заагаагүй гэрээ байгуулан, батламж олгож буй үйл ажиллагааг таслан зогсоож, хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах тухай албан бичгийг холбогдох газарт хүргүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2021.09.10-ны өдрийн 53 дугаар тогтоолын хавсралтаар “Ай эн мобайл нэтворк” ХХК-д Мэдээлэл холбооны үйлчилгээ эрхлэх /ярианы үйлчилгээ/ гэсэн тусгай зөвшөөрлийг олгохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг зөрчиж, журамд заагаагүй эрхлэх үйлчилгээний төрлөөр, сонгон шалгаруулалтгүйгээр олгосон, мөн суурин холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 10 жилээр олгосон нь тус тус Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж, 13.2.7-д “аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн” гэж заасныг зөрчсөн тул холбогдох зөрчлийг арилгуулж, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийг Харилцаа холбооны зохицуулах

хороонд хүргүүлсэн.

Өрсөлдөөний тухай хуулийн төслийг 2019 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч 2020 оны Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус хуулийн төслийг Шадар сайдын ажлын алба болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас дахин боловсруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэн, байнгын хороонд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-6.Өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг жил бүр зохион байгуулах /ШӨХТГ 2017-2019/

2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих хүрээнд Зар сурталчилгааны хууль, тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийслэл, орон нутгийн 173 хэвлэл мэдээллийн байгууллага, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тендер захиалагч байгууллагуудын уулзалтыг зохион байгуулж, 20 гаруй захиалагчдад зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэ чиглэлээр 21 аймгийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад цахим сургалт зохион байгуулсан.

Гудамж талбайд байршуулсан самбар, аж ахуйн нэгж, байгууллагуудын нэр зэрэг нь Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлэв.

Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах ажилд олон нийтийн оролцоог хангах, аж ахуй эрхлэгчдийн эрхийг дээдлэх, үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын сайжруулах зорилгоор нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн

дарга, мэргэжилтэн, харилцаа холбоо, банк, санхүү, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон байгууллагуудын хэрэглэгчийн төв хариуцсан захирал, менежерүүд зэрэг 34 байгууллагын төлөөлөлд цахим сургалт зохион байгуулав.

“Койка” олон улсын байгууллагатай хамтран “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төрийн байгууллага, аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах нь” цахим сургалтыг 50 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулсан.

2021 онд зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Зар сурталчилгааны хууль, тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улс төрийн намуудад 1, Улаанбаатар хотын болон орон нутгийн радио, телевизүүдэд 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудад, хэвлэл мэдээллийн 199 байгууллагад хуулийн дагуу сурталчилгаа явуулах талаар 2 удаагийн зөвлөмж хүргүүлэн ажилласан. Мөн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын цахим сайтаар 3 удаагийн мэдээ, фэйсбүүк хуудсаар 3 удаагийн постер, 10 телевиз, 20 гаруй сайтуудад сонгуулийн хяналтын талаар ярилцлага, мэдээлэл өгч улсын байцаагчид улсын хэмжээнд нийт 94 телевиз, 35 богино долгионы радио, сайтууд болон олон нийтийн цахим сүлжээнд бүхэлд нь хяналтыг тавьж ажилласан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /УУХҮЯ 2017-2019/

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилсан тандалт судалгаа, үр нөлөө, зардлын тооцооны судалгааг хийн, тайлан боловсруулж, олон нийтэд танилцуулсан.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилсан тандалт судалгаа, үр нөлөө, зардлын тооцооны судалгааг хийж, хуулийн үзэл баримтлалыг 2020 оны 08 дугаар сард шинэчлэн баталсан бөгөөд төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан

хэлэлцүүлэг зохион байгуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны цахим хуудсаар дамжуулан иргэдээс санал авч нэгтгэсэн. Хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэн батлах зорилгоор Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр олон улсын болоод дотоодын зөвлөхүүдийг ажиллуулж, 2021 оны 6-р сард УУХҮЯ-наас Эрдэс баялгийн ил тод байдлын салбарын хуулийн төслийг эцэслэн бэлтгэсэн бөгөөд улмаар 2022 онд Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон бусад судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. ХЗДХЯ Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төсөл”-ийг боловсруулан холбогдох яамдаас санал авч УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах /УУХҮЯ 2017-2019/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба хамтран «www.iltodqeree.mn” гэрээний ил тод байдлын цахим санг бий болгож, 2019 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулсан. Үүнд: Хөрөнгө оруулалтын гэрээ, Концессын гэрээ, Тогтвортой байдлын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ, Газрын тосны хайгуулын гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, Газрын түрээсийн гэрээ, Ус ашиглах гэрээ, Бичил уурхайн зэрэг нийт 15 төрлийн гэрээг хамруулаад байна.

2021 онд мэдээллийг шинэчлэн 883 гэрээ байршуулснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ 26, Хөрөнгө оруулалтын гэрээ 4, Тогтвортой байдлын гэрээ 11, Орон нутагтай хамтран ажиллах гэрээ 167 багтжээ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/246 тоот тушаалаар “Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Журам батлагдсантай холбогдуулан 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох ажилтнууд, ОУИТБС-ын Дэд зөвлөлийн нарийн бичгийн

дарга нарыг сургалтад хамруулав. Уг цахим санг ажиллуулах журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас 2021 оны А/246 дугаар тушаалаар баталсан.

Уул уурхайн салбарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ашигт малтмалын нийт 2591 /үүнээс: ашиглалтын 1705, хайгуулын 886/ тусгай зөвшөөрлийг 1664 аж ахуйн нэгж эзэмшиж байна. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшлийн 74.3% (1332)-ийг дотоодын аж ахуйн нэгж, 21.5% (242)-ийг гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, 4.2% (90)-ийг гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эзэмшиж байна. Ашигт малтмалын нийт 381 тусгай зөвшөөрөл банк, банк бус санхүүгийн байгууллага /ХХБ, Голомт, ХААН, Анод, Хас, Капитал, Чингис хаан, Кредит, Богд банк зэрэг/-ын зээлийн барьцаанд байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар ОУИТБС-ын тайлагналын маягтыг шинэчлэн баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.6.5-3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох /ЗГХЭГ, УУХҮЯ 2020-2022/

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 2021.12.17-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэрийг нээлттэй байхаар тусгасан ба 2022.05.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд сайн дураар Эцсийн өмчлөгчийн мэдээллээ ил болгосон компаниуд 2016 онд 46, 2017 онд 184, 2018 онд 60, 2019 онд 291, 2020 онд 687, 2022 онд 733 компани байна. (<https://www.eitimongolia.mn/a/209>)

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/37 тоот тушаалаар ОУИТБС-ын тайлангийн маягтын шинэчлэн баталсан (<https://legalinfo.mn/mn/detail/15277>) бөгөөд “Ашиг хүртэгч эздийн мэдээллийг тайлагнах маяг”-ыг боловсруулан баталсан.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд эрдэс баялгийн салбарын эцсийн эзэмшигчийг ил тод болгох талаар Засгийн газар журам батлах, мэдээллийн санг бүрдүүлж, нийтэд ил болгох талаар улсын

бүртгэлийн болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт холбогдох заалтуудыг тусгасан. Мөн эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулагч аж ахуйн нэгж, байгууллагуудыг эцсийн эзэмшигч, хамаарал бүхий компанийг ил болгохоор хуулийн төсөлд тусгасан.(Биелэлт 70 хувь)

4.1.6.5-4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх /УУХҮЯ 2017-2020/

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөний дагуу газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т талбайнуудад байгаль орчин менежментийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, хянан батлах журмын хүрээнд жил бүрийн 12 дугаар сард дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчин менежментийн төлөвлөгөөний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг Байгаль орчин менежментийн төлөвлөгөөг боловсруулах хянан батлах тайлагнах журмын дагуу гаргадаг.

2020 онд байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т 19 болон 21 дүгээр талбайд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-138 тушаал болон “эвдэрсэн газрыг ургамалжуулах”, техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 зэрэг стандарт, журмыг тус тус үндэслэн нийт 1400 ширхэг мод суулгах ажил хийгдсэн. Мөн 75 га газарт хөрс сийрэгжүүлэх ажил, замуудын дунд хаагдсан газарт байгаа эвдэрсэн замуудыг хаах ажил 50 хувьтай, нийт 200 цооногт 10 метрийн өргөнтэй галаас хамгаалах зурвас бүс барих ажил, усны мониторингийн төхөөрөмж суурилуулах зэрэг ажлууд хийгдсэн байна. Мөн дэлхийн улс орнуудад Ковид-19 цар тахлын дэгдэлт ихэссэнтэй холбогдуулан гэрээлэгч компани болох “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК-ууд гадаадад байгаа шаардлагатай инженер техникийн ажилтнуудаа 2020 оны 08 дугаар сар хүртэл Бүтээгдэхүүн хуваах гэрээт

талбайнууд дахь ажлын байрандаа авчирч чадаагүй. Үүний улмаас 2020 онд хийгдэхээр төлөвлөгдсөн байсан өрмийн шингэн хаягдлын санг саармагжуулах болон нөхөн сэргээх ажил, дүйцүүлэн хамгаалах зэрэг ажлууд хийгдээгүй.

Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-нд тогтмол хүргүүлэн, дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тухай хууль журмын хэрэгжилтэд хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2021 онд Газрын тосны хайгуулын талбайдад Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж буй "Метан газ ресурс" ХХК, "Жи Өү Эйч" ХХК, "Түмэн ойл" ХХК, "Смарт-ойл монголиа" ХХК, "Зон Хэн Юу Тиан" ХХК, "Монголын Алт" ХХК болон "Петровис ресурс" ХХК-иудын 2021 оны жилийн хайгуул, судалгааны болон байгаль орчныг нөхөн сэргээх ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулахаар төлөвлөгөө, төсөв батлагдсан. Газрын тосны хайгуулын талбайдад БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй "Тэлмэн ресурс" ХХК, "Метан газ ресурс" ХХК, "Жи Өү Эйч" ХХК, "Түмэн ойл" ХХК, "Смарт-ойл монголиа" ХХК, "Зон Хэн Юу Тиан" ХХК, "Монголын Алт" ХХК, "Капкорп монголиа" ХХК болон "Петровис ресурс" ХХК-иудын 2022 оны жилийн хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг баталсан. Дээрх гэрээлэгчид 2022 онд хайгуул, судалгааны болон байгаль орчныг нөхөн сэргээх ажилд нийт 33,510,673.7 ам.доллар зарцуулахаар төлөвлөгөө, төсөв батлагдсан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-5. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-д хамруулах /УУХҮЯ 2017-2019/

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад газрын тосны хайгуул ашиглалтын

үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгж хамрагдсан боловч тайланд бүх аж ахуйн нэгжүүдийг хамруулдаггүй бөгөөд тайлан бичихээр шалгарсан компани тодорхой нөхцөлүүдийг харгалзаж, ямар аж ахуйн нэгжийг тайланд хамруулахыг шийдвэрлэдэг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2019 оны тайланд «Петроматад» ХХК, «Петрочайна Дачин Тамсаг» ХХК, «Доншен газрын тос Монгол» ХХК, «Мак» ХХК, «Макс-Ойл» ХХК, «Магнай Трэйд» ХХК, «Смарт ойл» ХХК, «Вүльф Петролиум» ХХК зэрэг 8 гэрээлэгчийн үйл ажиллагааг тусгуулсан. 2021 онд 18 компани <http://ereporting.eitimongolia.mn/reportList> сайтад байршуулсан байна. (Биелэлт 100 хувь)

Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах

7 дугаар зорилтын хүрээнд нийт 6 үйл ажиллагаа, 18 арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.7.1-1 Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах /АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ 2017-2018/

АТГ-аас 2020 онд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт”-ийн үнэлгээг хийлгэн, үр дүнг нийгмийн халамжийн үйлчилгээний салбарын мэргэжилтнүүд, 21 аймгийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлсэн. Мөн Монголын хуульчдын холбоо, “Баасанжав Консалтанг” ХХК-тай хамтран 2020 онд “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлэн үнэлгээний тайланг 15 байгууллагын 42 хүнийг оролцуулан танилцуулж, төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээнд гарсан үр дүн, үр нөлөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцүүлэв. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо, үр ашигтай байдалд хөндлөнгийн үнэлгээ хийх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг “Транспарэнси интэрнэшнл-Монгол” ТББ, “Хууль тогтоомж, бодлого судлалын төв” ТББ-тай хамтран хэрэгжүүлж, тус байгууллагад ажилласан тайлан, үр дүнгийн талаар салбарын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж

буй төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан тухайн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сангууд болон төрийн бус байгууллагаас төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөлөл”-ийг тодруулах судалгааг зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.

АТГ-аас шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын чиглэлээр иргэд, төрийн бус байгууллагыг чадавхжуулах, олон улсын сайн туршлага бүхий авлигын эсрэг ном, гарын авлага орчуулж түгээх зорилгоор холбогдох гарын авлагыг англи хэлнээс орчуулан, агуулгын хүрээнд иргэд, ТББ-д сургалт зохион байгуулсан.

АТГ-аас 2020, 2021, 2022 онд Авлигын эрсдэлийн үнэлгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн бөгөөд холбогдох салбар, байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд анхаарах асуудал, алдаа дутагдлыг хөндлөнгийн үнэлэлт, дүгнэлтээр гаргуулан түүний мөрөөр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 онд “Нээлттэй нийгэм форум” ТББ-тай хамтран “Хувьцаат компанийн комплаенс, мэдээллийн ил тод байдал” хэлэлцүүлгийг мэргэжлийн холбоод болон хувьцаат компаниудын ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл, зах зээлийн судлаач, мэргэжилтнүүд зэрэг нийт 150 гаруй хүн оролцуулан зохион байгуулж, Хорооноос компанийн засаглалыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын шинэчлэл, хувьцаат компаниудын хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээсэн үүргийн нийцэл, хувьцаат компанийн мэдээлэл, тайлагналын ил тод байдал, цаг үеийн болон цаашид чухалчлан анхаарах асуудлыг хэлэлцсэн. Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоо, Монголын зуучлагчдын холбоо, Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоодтой хамтран ажиллаж, даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх олгох сургалтыг мэргэжлийн холбоод зохион байгуулж, шалгалтыг Хороо авч байна.

Санхүүгийн зохицуулах хороо Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран ажиллах гэрээг 2019 онд байгуулан ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалт, “Комплаенс ба ёс зүй” цахим сургалтуудыг хамтран зохион байгуулж, 2020 онд ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалтыг 2 удаа, “Комплаенс ба ёс зүй” цахим сургалтыг 8 удаа явуулсан. Санхүүгийн зохицуулах хороо салбарын мэргэжлийн холбоод (ХААГБТЭБНМБНХ, ММНБИ, ММУИ, МХХ, МБХ, ММНБИ, ММУИ, МДХ, МДЗХ, ҮМҮЧАЭҮХ)-той хамтран ажиллах гэрээг байгуулж салбарын ажилтнуудад эрх олгох, мэргэшүүлэх зэрэг сургалтыг хамтран хэрэгжүүлэхээр тогтсон. Хорооны цахим хуудсанд Хууль, журмын төсөлд санал авах хэсэгт 30 хоногийн хугацаатай 2020 онд 22 журам байршсан бөгөөд үүний үр дүнд 91 төрийн бус байгууллагууд саналаа өгч оролцов.

Авлигатай тэмцэх газар нь төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2021 онд “Шүтэлцээт оюун хөгжил” ТББ-ын судлаачдаар “Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв туссан байдалд судалгаа, мониторинг” хийлгэж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулсан “ЕБС болон их дээд, сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд залууст шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг, “Нээлттэй нийгэм форум” ТББ, “Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл” ТББ-тай хамтран Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар,

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, “Мон-Атом” ХХК, “Хил хязгааргүй алхам” ТББ, “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл, судлаачдыг оролцуулан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, зөвлөмжийг гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн, нийгэмд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын удирдлага, төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг хамтын ажиллагаа: Төрийн бус байгууллагын оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг, АТГ-аас “Бодлогод залуусын оролцоо”, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд”, “Нээлттэй нийгэм форум” зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагуудын худалдан авалтын дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний ил тод байдалд иргэдийн зүгээс хяналт тавих арга зүйд сургах, үр дүнтэй хяналт, оролцоог төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Орон нутгийн төсвөө хяная-BudgeThon” хакатон, “Бодлогод залуусын хяналт” ТББ, “Тунгаахуй” өгөгдлийн урлан зэрэг ТББ-тай хамтран “Дата эрх чөлөө: Мэдэх эрх” дата, гэрэл зураг, түүх хосолсон үзэсгэлэн-г зохион байгууллаа. (Биелэлт 70 хувь)

4.1.7.1-2. Иргэдийн оролцоо, санал, санаачилгыг нэгтгэх, төрийн бодлого, шийдвэр гаргахад тусгах боломжийг бүрдүүлсэн бизнес анализийн систем хөгжүүлэх /ХХМТГ 2020-2022/

Төрийн нэгдсэн санал асуулга хүлээн авах, шийдвэр гаргахад иргэд оролцох боломжийг бүрдүүлсэн <https://e-tanhim.gov.mn/> системийг Үндэсний дата төв УТУГ-аас хөгжүүлсэн. Иргэд танилт, нэвтрэлтийн системийн тусламжтай өөрийгөө баталгаажуулан тус системд нэвтэрч,

төрийн бүх шатны байгууллагаас явуулж буй санал асуулга, хэлэлцүүлэгт оролцох, санал, гомдол хүсэлтээ илгээх боломжтой бөгөөд энэхүү цахим оролцооны систем нь төрийн байгууллагуудад тус системийг ашиглан өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэлийн хүрээнд холбогдох иргэдээ сонгож санал асуулга, хэлэлцүүлгийг үүсгэн явц, үр дүнг хянах боломж олгох зорилго бүхий систем юм. Түүнчлэн Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвийн өргөдөл гомдлын www.11-11.mn систем нь иргэдийн санал, хүсэлтийг утас, биечлэн, мессеж, мобайл, веб сайт, вэб чат, социал зэрэг 12 сувгаар хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэлтэд хяналт тавьдаг бөгөөд энэ систем дээр ажиллах бизнес аналитикийн Tableau системийг Дэлхийн банкны Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр худалдан авч ашиглаж байна. Tableau бол орчин үеийн бизнесийн байгууллагуудын өргөнөөр ашиглах болсон хамгийн өртөг багатай, ямар ч мэргэжлийн хүн хялбархан эзэмших боломжтой бизнес шинжилгээний программ юм. Энэхүү программ дээр суурилан байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй бүхий л систем, аппликэйшн дах өгөгдлийг өөр хооронд нь холбох, шинжлэн нэгтгэх, интерактив дашбоард боловсруулах боломжтой. (Биелэлт 0 хувь)

4.1.7.1-3 Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилтын хүрээнд “Ил тод Улаанбаатар Академи”-тай хамтран ажиллах АТГ, Нийслэлийн ЗДТГ, ГХУСАЗСЗ 2017-2019/

Авлигатай тэмцэх газар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2020 онд 117, 2021 онд 68 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын санал санаачилгыг дэмжин хамтран ажиллаж, 2020 онд 47, 2021 онд 23, 2022 онд 72 удаагийн уулзалт, ярилцлагыг тус тус зохион байгуулав. Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн

сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт, төрийн албаны удирдах албан тушаалтан, худалдан авах алба, хуулийн хэлтэс, санхүү, дотоод хяналт, аудитын албан тушаалтнуудад зориулсан 5 төрлийн 20 сургалтын модулийг боловсруулан сургалтад ашиглаж байна. Хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах сургалтын интерактив модуль бүхий аппликэйшний зохиомжийн төслийг боловсруулах, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэсэн. Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, энэ дагуу тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Ухуулга сурталчилгааг видео контент, зурагт хуудас, брошюр нугалбар, подкаст, үзүүлэн таниулах, радио контент, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео цахим хичээл, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээврийн сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн сурталчилгаа, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл жанраар бэлтгэн, түгээж ажилласан.

Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллага, маркетинг, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын залуусыг татан оролцуулах, сургах, туршлага хуваалцах, хамтран ажиллахад зорилгоор сэтгүүлч, байгууллагын маркетинг, сошил медиа хөгжүүлэгч мэргэжилтнүүдийг хамруулан 2020 онд 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран 2020 онд Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал” хакатон /тодорхой өгөгдсөн сэдвийн

хүрээнд төрөл бүрийн мэргэжил, чадвартай хүмүүсээр үр дүнтэй багийг бүрдүүлэн, богино цаг хугацаанд шинэ санааг хөгжүүлж асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх нэг төрлийн уралдаант үйл ажиллагаа/, 2021 онд “Бодлогод залуусын оролцоо”, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд”, “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагуудтай хамтран улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагуудын худалдан авалтын дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний ил тод байдалд иргэдийн зүгээс хяналт тавих арга зүйд сургах, үр дүнтэй хяналт, оролцоог төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Орон нутгийн төсвөө хяная-BudgeThon” хакатоныг зохион байгуулсан.

2020 онд Шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Үнэгүй фитнес” ТББ-тай хамтран “Эрүүл бие-Эрүүл нийгэм Амьдралын хэв маягаа өөрчилъе» арга хэмжээг Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, шударга ёсны зөв хандлага төлөвшүүлэх, авлигын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, түүний хор уршиг, үр дагаврыг ухуулан таниулах зорилгоор иргэдийн амьдралд, бүтээгдэхүүний үнэ, эдийн засаг, иргэдийн тэгш хүртээмжтэй үйлчилгээ авах боломжид авлигын үзүүлэх нөлөөллийг энгийн, ойлгомжтой хялбаршуулсан байдлаар харуулах 6 төрлийн сэдэвчилсэн видео контентууд, авлигын эсрэг сурталчилгааны чиглэлээр 10 төрлийн зурагт хуудсыг тус тус бүтээж олон нийтэд түгээв. 2021 онд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хамтран хэрэгжүүлсэн байна:

Иргэдийн авлигын эсрэг үйл ажиллагаан дахь оролцоог нэмэгдүүлэх, төрийн албаны хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийг мэдээлэл 110 тусгай дугаарыг сурталчлах агуулга бүхий 816 ширхэг мэдээллийн самбарыг хэвлүүлэн, нийслэлийн

орон сууц, хотхоны лифтний хажууд байршуулах ажлыг хороодын хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан 21 шторк, видеог ТВ7, ТВ8, ТВ9, С1, ПАРЛАМЕНТ, UBS, SBN, NTV, MNC, ETV, MN25, TM телевизүүдээр 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд тухайн телевизүүдийн оргил цагаар өдөрт 3 ба түүнээс дээш удаагийн давтамжтайгаар цацаж, олон нийтийн хүртээл болгосон.

Авлигатай тэмцэх газраас иргэд, олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бүтээсэн авлигын эсрэг зурагт хуудсыг нийслэлийн гудамж, талбай, автобусны буудалд байрлах самбарт 9 төрлийн зурагт хуудсыг 66 автобусны буудал 45 мэдээллийн самбарт 28 хоногийн турш байршуулан, иргэдийн авлигын эсрэг оролцоог нэмэгдүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авах 110 дугаарын утсыг сурталчилсан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.2-1 Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, тогтвортой, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг нь баталгаажуулах зэрэг чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох /ХЗДХЯ 2017-2019/

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий Консорциумаас 2021 онд “Эс Ай Си Эй” ХХК-тай хамтран “Нээлттэй нийгэм форум” ТББ, “Форум Ази” бүсийн байгууллагын дэмжлэгтэйгээр ТББ-ын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулахтай холбоотой нөлөөллийн үйл ажиллагааг баримт, дүн шинжилгээ бүхий мэдээллээр хангах, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа болон оролцогч талуудын зураглалыг тодорхойлох, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, Монгол Улс дахь иргэний орон зайн өнөөгийн төлөв байдлыг судлах зорилго бүхий “Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” судалгаа явуулжээ. Уг судалгаанд 683 төрийн бус байгууллага хамрагдсан бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд эдгээр байгууллагаас

орон нутаг болон үндэсний хэмжээний 512 бодлогын баримт бичиг, эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, 2,850 удаа нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж, 8,526 судалгаа эрхлэн гүйцэтгэсэн (<https://www.icnl.org/wp-content/uploads/ngostudymong.pdf>).

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд 1 ашгийн төлөө бус хуулийн этгээдийг төрөл тус бүрээр нь нарийвчлан зохицуулахаар, ялангуяа Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр холбооны төрөл, ангилал, дотоод зохион байгуулалт, удирдлага, төлөөлөл, үүсгэн байгуулагчийг тодорхой болгож, бүртгэл, хяналт, тайлагналт, ил тод байдал, татан буугдах нөхцөл, журмыг боловсронгуй болгож, онцлог бүхий холбоо, төрөөс холбоонд үзүүлэх дэмжлэг, төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэсэн бол ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа төрийн байгууллагад хүргүүлэх, тухайн төрийн байгууллага болон ашгийн төлөө бус хуулийн этгээд нь тайлангаа нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар тусгасан. Төрөөс иргэний нийгмийн хөгжлийг дэмжих суурь тогтолцоог бүрдүүлэх зорилгоор иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлаар төртэй харилцах, зөвшилцөх, холбон ажиллах чиг үүрэг бүхий "Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл"-ийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон. Уг зөвлөл нь Монгол Улсын иргэний нийгмийн хөгжил, чадавхыг дэмжих хөгжүүлэх, дотоод засаглал, ёс зүйн жишгийг тогтоож хөгжүүлэх, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтлэг хөгжлийн асуудлаар төр болон олон улсын байгууллагуудтай харилцах, бүртгэлийн болон статистикийн байгууллагуудтай хамтран мэдээлэл боловсруулалт хийх, нийгэмд үйлчилдэг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн болон нийтэд тустай үйл ажиллагааны үр нөлөөг нэгтгэх, тэдгээрийг татварын хөнгөлөлт,

чөлөөлөлт болон бусад дэмжлэгт хамруулахтай холбоотой санал, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байхаар зохицуулсан. Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх санг байгуулан ажиллуулснаар иргэний нийгмийн нийтлэг хөгжлийн асуудлуудаар төртэй харилцах, хамтран ажиллах, түншлэлийн үр дүн нэмэгдэхийн зэрэгцээ тус зөвлөлөөр дамжуулан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн чадавхыг бэхжүүлэх, дотоод засаглал, ёс зүйн, хариуцлагыг сайжруулах, олон нийтийн ойлголт дэмжлэгийг нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх болно. (Биелэлт 30 хувь)

4.1.7.2-2 Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх /УБЕГ 2019-2020/

Улсын бүртгэлийн багц хуулийг 2018 онд Улсын Их Хурлаас баталж, хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй болгосон. 2019 оны 9 дүгээр сараас ашгийн төлөө бус төрийн бус байгууллагын анхны үүсгэн байгуулагч, эцсийн өмчлөгч, удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж эхэлсэн.

Улсын Их Хурлаас 2021 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.19-д зааснаар "хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл" нээлттэй мэдээлэлд хамаарахаар болсон, мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-д "хувьцаа эзэмшигчийн нэр," гэсний дараа "эцсийн өмчлөгчийн нэр" гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан нь ТББ-уудын үүсгэн байгуулагчийн мэдээлэл олон нийтэд ил тод болох эрх зүйн орчин бүрдсэн. Дээрх хуулиудын

заалтыг үндэслэн “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл”-ийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нээлттэй мэдээлж эхэлсэн. Татварын ерөнхий хууль/шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу тайлангийн хугацаанд 25985 хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээллийг шинээр болон мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө улсын бүртгэлд бүртгүүлээд байна.

УБЕГ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль/шинэчлсэн найруулга/-ийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Санхүүгийн тайлангаа 8 ба түүнээс дээш улирал ирүүлээгүй бол Сангийн яамны саналыг үндэслэн хасна” гэж заасны дагуу саналаа ирүүлэх асуудлаар Сангийн яамтай уулзалт хийж санал солилцон, 2022 оны 10 дугаар сард Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн 58630 хуулийн этгээдийн жагсаалтыг байгууллагын цахим хуудаст байршуулсан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12-д “Энэ хуулийн 12.2-т заасан сан нь үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй байлгана”, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-д “Холбооны дүрэмд дараах зүйлийг тусгана”, 11.2.14-т “хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилт болон зарцуулалтыг олон нийтэд нээлттэй тайлагнах журам” гэж, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Энэ хуулийн 13.2 /Нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа холбоо, эсхүл мэргэжлийн холбоо нь/, 13.3 /Холбоо хууль, эсхүл гэрээний дагуу төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэсэн бол/-т заасан холбоо үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй байлгана” гэж, 39 дүгээр зүйлийн 39.2-т “Зөвлөлөөс үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ”, 40 дүгээр зүйлийн 40.6-д “Энэ хуулийн 40.1-д заасан дансан дахь хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг улирал тутам гаргаж, зөвлөлийн цахим хуудсаар олон нийтэд

нээлттэй мэдээлнэ” гэсэн зохицуулалтыг тусгасан байна. (Биелэлт 30 хувь)

4.1.7.2-3 Төрийн бус байгууллагуудын мэдээллийн идэвхтэй солилцоог бий болгох, хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ, түншлэлийг дэмжих /Холбогдох ТББ 2018-2020/

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоор төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газар, ХХААХҮЯ, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөөс олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах нь” сэдэвт цахим сургалтыг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан болон 21 аймгийн хөдөө аж ахуйн газрын төсөл сонгон шалгаруулалтын хороо, дэд хорооны бүрэлдэхүүнийг хамруулан 2020 онд зохион байгуулав. “Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах” чиглэлийн хүрээнд 2020 онд Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвсэл, Сэтгүүлчид, Хэвлэл мэдээллийн байгууллага, Төрийн бус байгууллагын төлөөлөл, ХЗДХЯ-тай хамтран Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

АТҮХ-ийн хэрэгжилт, авлигын индексийн судалгаа, шударга байдлын үнэлгээний дүн, шалтгаан нөхцөл болон авлигатай тэмцэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллага хэрхэн оролцох талаар мэдээлэл өгч, чадавхжуулав. Авлигатай тэмцэх газраас 2021 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагын албан тушаалтнуудтай болон

иргэд, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор “Монголын телевизүүдийн холбоо”, “Нээлттэй нийгэм форум”, “Хөгжлийн шийдэл”, “Ухаалаг засаг”, “Монгол википедиа нийгэмлэг”, “Мэдлэгтэй иргэд”, “Захиргааны шинэ санаачилга” зэрэг ТББ-ын төлөөлөл зэрэгтэй 23 удаагийн ажил хэргийн уулзалт зохион байгуулж ажилласан.

“Дата эрх чөлөө: Мэдэх эрх” дата, гэрэл зураг, түүх хосолсон үзэсгэлэнг Бодлогод залуусын хяналт ТББ, “Тунгаахуй” өгөгдлийн урлан зэрэг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэнд нээлттэй өгөгдөл ашиглан нийгмийн чухал сэдвүүдэд хувь нэмрээ оруулахаар зорин ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, сэтгүүл зүйн салбар, сайн дурын клубууд зэрэг олон тал хамтран оролцоноороо ач холбогдолтой болсон.

Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр 2021 онд 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Тухайлбал, “Шүтэлцээт оюун” ТББ-тай хамтран Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулан “Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд, залууст шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт шударга ёсны хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгатуссанбайдалдхийсэндүншинжилгээтэй танилцаж, илтгэл хэлэлцүүлж, хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан санал, санаачилга, үр дүн холбогдох зөвлөмжийг боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайд болон Боловсрол, шинжлэх ухааны сайдад хүргүүллээ. Мөн “Транспарэнси интэрнэшнл Монгол” ТББ-тай хамтран зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ажилласан үр дүн буюу тухайн үйл

ажиллагааны эрх зүйн орчин, үйл ажиллагаа, албан хаагчдын ажлын ур чадвар, хүртээмж, хамрагдалтын талаарх тайланг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

“Нээлттэй нийгэм форум”, Монголын тогтвортой хөгжил нийгмийн хариуцлагын зөвлөлтэй хамтран УУХҮЯ, СЯ, ХЗДХЯ, ХААГ, ТӨБЗГ, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд, “Мон-Атом” ХХК, “Хил хязгааргүй алхам” ТББ, “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” зэрэг төрийн бус байгууллага, холбоодын төлөөлөл, судлаачдыг оролцуулан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, шилэн данс, худалдан авах ажиллагааны төлөвлөлт болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж гаргасан.

АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн, нийгэмд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын удирдлага, төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг хамтын ажиллагаа: Төрийн бус байгууллагын оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгээр авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд иргэдийг татан оролцуулах, сургаж чадавхжуулах, соён гэгээрүүлэх ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх, санал санаачилгыг өрнүүлэхэд төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцохыг уриалсан. (Биелэлт 100 хувь)

4.1.7.3-1 Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх /АТГ 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж ирсэн. Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх,

хүнд суртал, чирэгдлийг арилгах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд олон нийтийн хяналтыг бий болгох, нийтийн албан тушаалтын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2017-2019 онуудад иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээ байгуулан ажиллуулсан. Иргэд, олон нийтээс төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилго бүхий "Иргэний хяналтын төв"-ийг 2018-2021 онуудад Дүнжингарав худалдааны төв, Мишээл Экспо, Драгон төв, 6 буудал дахь нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд нээн 8 иргэнийг ажиллуулсан бөгөөд уг төвийн үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн хяналтын зөвлөл хариуцан хяналт тавьж, удирдлагаар ханган ажилласан.

2021 онд олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан цаг үеийн онцлог, ээдрээтэй байдал, түүнтэй холбогдон үүсэж байгаа авлигын эрсдэлийг хөндсөн "Ковид ба Авлига": Иргэдийн чөлөөт индэр" цахим хэлэлцүүлгийг иргэний нийгэм, мэргэжлийн холбоод, судлаач нарын дунд зохион байгуулав.

Эрчим хүчний салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт, үндэсний стандарт, судалгаа шинжилгээ, ТЭЗҮ боловсруулах, баталгаажуулах үе шатанд тухайн төсөлд талуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах, зөвшилцөх, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд салбарын үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрчим хүчний ассоциаци, Эрчим хүчний инженерүүдийн холбоо зэрэг мэргэжлийн ТББ-тай нягт хамтран ажиллаж байна. Энэ чиглэлээр яамны ШУТЗ, нормчлолын удирдах зөвлөл болон бусад холбогдох ажлын хэсгүүдийн гишүүдийн 17-20 хувьд мэргэжлийн ТББ-ын төлөөллийг томилон ажиллуулснаар тухайн төрийн байгууллагын үйл ажиллагаанд ТББ хяналт тавих боломжийг

бүрдүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас жил бүр гаргадаг Шударга байдлын үнэлгээгээр яамд, агентлагийн дунджаас доогуур үнэлэгдсэн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тулгарч буй асуудал, бэрхшээлийг тэдний дэмжлэгтэйгээр шийдвэрлэх, тухайн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг багасгах талаар тогтмол зөвлөмж хүргүүлснээр худалдан авах ажиллагааг үнэлэх Үнэлгээний хороог төрийн бус байгууллагын төлөөлөлгүй байгуулах зөрчил эрс буурсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна гэж заасны дагуу төрийн бус байгууллагын төлөөллийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулан ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгохтой холбоотой зохицуулалтыг тусгуулж, үүний дагуу "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлуулсан. Ингэснээр төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэн, судалгаа шинжилгээний болон иргэний нийгмийн байгууллагаас хэрэгжүүлэх хяналтын чиглэл тодорхой болж, хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүллээ. Авлигатай тэмцэх газраас олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр шалгарсан иргэн, иргэдийн бүлэг, иргэний нийгмийн байгууллагад тусгайлсан сургалт хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэн ажиллах юм.

Төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаар тодорхой төрлийн үйл ажиллагаанд хяналт тавих

боломжийг Төрийн бус байгууллагуудад олгож, энэ талаарх мэдээ, мэдээллийг Авлигатай тэмцэх газартай харилцан солилцож ажиллах болсон. Тухайлбал, 1/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулиудад дотоодын төрийн бус байгууллагууд нэгдэж «Шударга сонгууль-Иргэний нийгмийн хяналт сүлжээ» байгуулан сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж оролцсон; 2/ Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь “Монголын байгаль орчны иргэний зөвлөл”-тэй 2018, 2019, 2020 онуудад хамтын ажиллагааны гэрээ байгуулж, аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр болон шинээр байгуулагдах хог хаягдлын ложистикийн төвүүд байрлах Багануур, Багахангай, Эмээлт, Барын хумс, Хар мухартын ам, Налайх дүүрэг, Дархан-Уул, Говь-Алтай, Өвөрхангай аймгуудад ажилласан; 3/ “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” ТББ-аас Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын “Сум хөгжүүлэх сан”-ийн үйл ажиллагаа, зээл олголт, тэдгээрийн бодит үр дүн, зээлийн эргэн төлөлтийн чанарт мониторинг хийж зөвлөмж өгсөн ба мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хүргэж, иргэд төсвөө хянах оролцоог сайжруулахад нөлөөлөх зорилготой судалгааг 2020 оны 09 дүгээр сарын 01-нээс 2021 оны 03 дугаар сарын 01 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Мөн нутгийн захиргааны байгууллага “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулж, хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажилласан; 4/ Говь-Алтай аймаг төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа олон нийтэд ойлгомжтой арга хэлбэрээр тайлбарлан таниулах, авлигын эсрэг шударга ёсны төлөө аливаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, үйл ажиллагааг дэмжиж ажиллах хүрээнд “Иргэнээ сонсох цаг” уулзалтын долоо хоног бүрийн бямба гараг бүр зохион байгуулж хэвшсэн, 5/ Говьсүмбэр аймгийн Чойр сумын

“Сум хөгжүүлэх сан”-ийн үйл ажиллагаанд “Хотол Чойр” иргэний нийгмийн байгууллага хяналт тавьж ажилласан; 6/ Дорнод аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг орон нутгийн хөтөлбөрүүдэд иргэний иргэний нийгмийн байгууллагаас дүн шинжилгээ хийж, зөвлөмж, уриалга гаргасныг төрийн байгууллагууд хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн.

ХЗДХЯ: Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, Иргэний хуулийн зохицуулалт, Эвлэлдэн нэгдэх эрхийн тухай НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоолуудын ерөнхий зөвлөмжүүд, Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын суурь зарчим, Хүний эрхийн тусгай илтгэгчийн зөвлөмж, тайланд тулгуурлан дараах агуулгаар өргөжүүлэн шинэчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэрийг Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болгон өөрчлөн боловсруулсан. Тус хуулиар зохицуулагдах харилцааны хүрээ, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхойлж, нэр томьёог Иргэний хууль болон бусад хуультай нийцүүлэн томьёолсон. Түүнчлэн эрх зүйн байдлыг нь тусгай хуулиар тогтоосон, албан ёсны гишүүнчлэлтэй мэргэжлийн холбоод, нийтийн чиг үүрэг гүйцэтгэж буй нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллагаас ялгах бөгөөд эдгээр байгууллагад хамаарах хуулийн үйлчлэлийн хүрээг нарийвчлан тодорхойлж тусгасан. Төрийн зарим чиг үүргийг холбоогоор гэрээлэн гүйцэтгэх нөхцөлийг үл ялгаварлах, нээлттэй, ил тод байх, хараат бус байдлыг хүндэтгэх, урьдчилсан магадлан итгэмжлэл үүсгэх замаар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн өрсөлдөх боломжийг хязгаарлахгүй байх зэрэг нийтлэг зарчимд нийцүүлэн төр, холбооны хамтран ажиллах харилцааг бизнесийн байгууллагаас ялгаатай байдлаар тодорхойлсон. Холбооноос гадна бусад ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа бол тухайн үйл ажиллагаатай холбоотой санхүү, татвар, үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад

гаргах эрх зүйн орчныг тодруулан тусгасан.

БШУЯ: Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой 2022-2023 онд боловсрол, шинжлэх ухааны салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалалтай холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор 2022 оны 03 дугаар сард хамтын хэлэлцээр байгуулсан бөгөөд тус хэлэлцээрийн хүрээнд дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/364 дүгээр тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил үүрэгт дүн шинжилгээ хийх, ажил мэргэжлийн стандарт боловсруулах ажлыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Ажил мэргэжлийн стандарт, хүний нөөцийн хөгжлийн хүрээлэн болон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлтэй хамтран ажиллаж байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/263 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 3. 2022 оны 5, 6 дугаар сард “Боловсролын төсвийн шинэчлэлийн эрх зүй, хэрэгжилтийг түгээн дэлгэрүүлэх уулзалт”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, 528 ерөнхий боловсролын сургуулийн 3128, 686 цэцэрлэгийн 2622 багш, ажилтан танхимаар, 43658 албан хаагчийг тус тус цахимаар хамруулж, уулзалт, хэлэлцүүлэгт аймаг, нийслэлийн сургууль цэцэрлэгийн үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл оролцлоо. 4. “Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам”-ийн төслийг нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах ажилтан, орон нутгийн мэргэжилтэн, үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оролцуулан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусган ажиллав. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг БШУ-ы сайдын 2022.11.2-ний өдрийн А/500 дугаар тушаалаар баталсан.

СХЗГ: 1. Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд хэмжил зүйг хөгжүүлэх, хэмжил зүйн бодлогыг хэрэгжүүлэх, салбар хоорондын

уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөлд төр, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын төлөөлөл орж ажилладаг. Тус зөвлөлөөр хэмжих хэрэгслийн загварын баталгаажуулалт хийх, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын чадавхыг үнэлэх асуудлыг хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэдэг. 2. Үндэсний болон олон улс, бүс нутгийн стандартын төслийг хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий орон тооны бус стандартчиллын техникийн хороо салбар тус бүрд байдаг бөгөөд бүрэлдэхүүн нь төр, иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон мэргэжлийн бусад байгууллагын төлөөллөөс бүрддэг. Үндэсний стандартын төслийг хэлэлцэх, батлах үйл явцад нийт 60 техникийн хороо ажилладаг бөгөөд техникийн хороонд нийт 800 гаруй төр, иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон мэргэжлийн бусад байгууллагын төлөөлөл ажиллаж байна.

УБЕГ: Улсын бүртгэлийн ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн Сайдын баталсан 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд УБЕГ-ын баталсан төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас нээлттэй тендер шалгаруулалт 2, шууд гэрээ 5, урсгал зардлаас шууд гэрээ 3, нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт 5, хязгаарлагдмал тендер шалгаруулалт 1, шууд худалдан авалт 24, ХЗДХЯ-ны санхүүжилтээр 4 нууц, нээлттэй тендер шалгаруулалт 1 тендерийг тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажилласан.

ЦЕГ: Хүний эрхийн үндэсний комиссоос энэ оны 08 дугаар сарын 31-ний өдөр цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага хоорондын хүний эрхийн асуудлаарх зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад Хүний эрхийн үндэсний комисс, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн төлөөлөл оролцож, Цагдаагийн алба хаагчдад хэвлэлийн эрх чөлөөг хангах, сэтгүүлчдэд хууль эрх зүй хүний эрхийн тухай харилцан сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, сургалтын модулийг хамтран боловсруулах, мөн сэтгүүл зүйн салбарын болзошгүй авлига, хаалтын гэрээний тухай, худал мэдээлэл тараах

асуудлаар гарсан аливаа асуудал, зөрчлийг талууд бүртгэн хөтөлж/кейс цуглуулж/, тодорхой цаг хугацаанд эргэн хэлэлцэж шийдвэрлэж байхаар харилцан нэгдсэн ойлголтод хүрсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, иргэн, аж ахуй нэгжийн хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр энэ оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийг бэлтгэн, иргэд, олон нийтэд хүргэсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-2022”, “Тэнэмэл-1,2,3”, “Зөвийг зөвлөө”, “Цахим соёл”, “Мал мах-Хяналт”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “РС-бүртгэл”, “Халхавч”, “Эрэлч нохой-2022”, “Илрүүлэлт-Оргодол-2022”, “Тэрбум мод” аяны хүрээнд “Байгалиа бүтээе-I.II”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Залилан”, “Хичээл эхэллээ”, “Unsend”, “Намайг алгас” зэрэг тусгай арга хэмжээ 12, хэсэгчилсэн 1755, нийт 1767 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага 35 цахим сайт, 57 нүүр хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг нэг цонхоор дамжуулж байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн талаар 2045, урьдчилан сэргийлэх чиглэлээр 10214, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавьяаг алдаршуулах чиглэлээр 3854, бусад 2204 мэдээ, мэдээллийг хүргэсэн. Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүдийг олон нийтэд 100 хувь хугацаанд нь мэдээлсэн, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын 44 тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан 75 тушаал, Улсын Ерөнхий прокурорын 19 тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан 56 тушаалын жагсаалтыг гаргаж, холбогдох эрх зүйн актуудад баяжилт хийж, тухай бүр цагдаагийн байгууллагын www.police.gov.mn, www.system.police.gov цахим хуудсанд тус тус

байршуулсан нь удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа, төсвийн ил тод байдал хангагдаж, иргэд болон Төрийн бус байгууллагаас байгууллагын төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн.

СЕХ: Байгууллын үйл ажиллагааны онцлогоос хамааран ээлжит, нөхөн сонгуультай жилүүдэд сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх ТББ байгууллага, Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хөндлөнгийн хяналт тавьж оролцох, сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж оролцох эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулиудад дотоодын төрийн бус байгууллагууд нэгдэж «Шударга сонгууль-Иргэний нийгмийн хяналт сүлжээ» байгуулах сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж оролцсон. 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын ажиглагч 35 ажиглагч, Сонгогчдын боловсрол төвийн Залуу сонгогчийн 32 хөтөчид сургалт зохион байгуулж сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийх боломжоор ханган ажиллав. 2. ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Сонгууль ажиглах тусгай багийн 8 орны 11 ажиглагч, Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны шугамаар Филиппин улсын Сонгуулийн төв комиссын 2 ажиглагч, Их Британи, АНУ, Япон, Австрали улсын Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын 39 хүний бүрэлдэхүүнтэй ажиглагчдын баг ажилласанаас гадна манай улсад үйл ажиллагаа явуулж буй Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Бодлогод залуусын хяналт төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 44 ажиглагч сонгуулийг ажиглалаа. 3. Мөн сонгуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж оролцох чиглэлээр дотоодын төрийн бус байгууллагуудын нэгдсэн сүлжээ болох “Хараат бус сонголт-Иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нд сонгууль ажиглах боломжоор хангаж хамтран ажиллав. Сонгуулийн үйл ажиллагаанд оролцогч төрийн

болон төрийн бус байгууллага, нам, эвсэл, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах уулзалтуудыг зохион байгуулав.

СЭХ: «Эйч Ар Мензор» судалгааны байгууллагаас «Санхүүгийн зохицуулах хорооны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах» судалгааны ажил, судалгааны SICA байгууллагаас «Санхүүгийн зохицуулах хорооны баримт бичгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох» судалгааны ажил, МУИС-ийн Бизнесийн сургуулийн профессор багш нарын гүйцэтгэсэн «Санхүүгийн зохицуулах хорооны бүтцийг боловсронгуй болгох» судалгааны ажил, “Эерэг өөрчлөлт сайн сайхны Ану хүрээлэн” ТББ-аас “Санхүүгийн зохицуулах хорооны соёл, ёс зүй, мэдлэгийн менежмент, уламжлал” зэрэг хөндлөнгийн судалгааны ажлыг тус тус гүйцэтгүүлж, үр дүнг 2022 оны 9 дүгээр сарын 21-нд Захиргаа удирдлагын газрын нийт албан хаагчид болон бусад газар, нэгжийн албан хаагчдын төлөөллийг оролцуулан, 11 дүгээр сарын 10-нд бүх газар, нэгжийн удирдлагуудыг оролцуулан тайлагнаж, судалгааны тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүлээлгэж өгсөн. Төрийн албаны зөвлөлийн даргын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 137 дугаар тушаалаар Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 609 дүгээр тогтоолоор нэр бүхий 8 албан хаагч, иргэнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгохыг үүрэг болгосны дагуу Хорооны Ажлын албанаас тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. Хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж Сангийн яамны Э-Тайланд шивж баталгаажуулан санхүүгийн нэгтгэсэн тайланг хуульд заасан хугацаанд Хорооны даргын 2022 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 1/1257 албан тоотоор Аудитын төв байгууллагад хүргүүлж санхүүгийн тайлангийн аудит хийлгэсэн. Аудитын явцад шаардлагатай материал, судалгааг цаг тухай бүрд гаргаж мэдээллээр

хангаж аудит хийлгэж ажилласан. Аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авч амжилттай ажилласан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн аудитийн зөвлөмжийн биелэлтийг 100%-ийн гүйцэтгэлтэй хуулийн хугацаанд нь гаргаж нотлох баримтын хамт Хорооны даргын 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 1/3766 албан тоотоор аудитын байгууллагад хүргүүлж биелэлтийг тооцуулан “Төрийн аудитын байгууллага”-ын программ хангамжид шивж байршуулан олон нийтийг мэдээлэлээр хангаж ажилласан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд нээлттэй байрлуулах мэдээллийг хуульчилсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаа ил тод байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны газар: Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагын 2-оос доошгүй төлөөллийг томилон ажиллуулах хэрэгжилтийг ханган Төрийн худалдан авах ажиллагааны газрын <https://www.spa.gov.mn/> цахим хуудас, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/)- ээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах тухай зарыг олон нийтэд хүргэж, нийт 44 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Нийт 200 гаруй үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын 96 төлөөллийг давхардсан тоогоор 320 гаруй удаа томилон ажиллуулж, холбогдох журмын дагуу урамшуулал олгосон. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон төлөөллийн мэдээллийн санг үүсгэн, тухай бүр мэдээллийг шинэчилэн, байгууллагын [/www.spa.gov.mn/](http://www.spa.gov.mn/) цахим хуудасны “Ил тод байдал” хэсэгт байршуулсан.

АМГТГ: Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоосон. Уг талбайн солбицлын хүрээнд сонгон

шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдаж 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/275 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг баталсан. Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/282 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнд салбарын төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжийн төлөөллийг комиссын гишүүнээр томилон ажиллуулж байна.

Архангай аймаг: 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалт бүхий 116 тэр бум 891, сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сан, төсвийн хөрөнгө оруулалтаар 5 тэр бум 302, сая 860 мянган төгрөгийн 17 төсөл арга хэмжээ, Төсөл хөтөлбөр болон Захиалгат хөрөнгө оруулалтаар 9 төсөл арга хэмжээний 3 тэр бум 731 сая 689 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 306 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 1 тэр бум 156 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ нийт 67 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсны 72 тэр бум 192 сая төгрөгийн төсөв өртөг бүхий 39 төсөл арга хэмжээний ажлуудыг зохион байгуулж гэрээний дүн 70 сая 338 сая төгрөг ба хэмнэлт нь 1 тэр бум 854 сая төгрөг байна. 2022 онд 16 тэр бум 788 сая төгрөгийн санхүүжилт тусгагдсаныг tender.gov.mn сайтад байршуулан төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Баянхонгор аймаг: ЖДҮ нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн төсөл сонгон шалгаруулах, тус сангаас зээл олгохтой холбоотой хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргах явцад төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж, шударга ёсыг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид нийтийн эрх ашгийн төлөө ил тод нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах мэдлэг ойлголтыг

нэмэгдүүлэх зорилгоор Хууль эрх зүйн хэлтэс BEST хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэгч Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөл хөтөлбөр хариуцан ажилладаг мэргэжилтнүүдэд “Төрийн албан хаагчийн харилцаа ба ёс зүй”, “Хандлага”, “Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт” сэдвүүдийн хүрээнд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан.

Говь-Алтай аймаг: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар 12 хэм хэмжээний акт батлагдсан бөгөөд улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хүчин төгөлдөр мөрдүүлж байна. Ингэснээр төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломж нөхцөл бүрдээд байна. Түүнчлэн Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт болон худалдан авалт, өмнөх оны болон сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг өмнөх оны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, аймгийн Засаг даргын гаргасан шийдвэр, бусад хууль тогтоомжид заасан мэдээллийг тухай бүр шилэн дансанд байршуулан ажилласан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах нийт 185 байгууллага, сан, нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан эсэхэд улирал тутам хяналт тавьж ажилласан бөгөөд Шилэн дансны хуулийн хэрэгжилт 1 дүгээр улиралд 96.02 хувь, 2 дугаар улиралд 96.61 хувь, 3 дугаар улиралд 96.46, жилийн эцсийн байдлаар 96.92 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс гадна аймгийн албан ёсны цахим хуудсанд аймгийн Засаг даргын захирамжийг ил тод нээлттэй, иргэд татан авч болох хэлбэрээр байршуулан ажиллаж хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Говьсүмбэр аймаг: Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, төслийн захирлын баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн чадавх бэхжүүлэх багийн даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн

“Ажлын хэсэг томилох тухай” А/57 дугаар тушаалаар “Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төлөвлөлт, гүйцэтгэлд олон нийтийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын Тамгын газраас 3, сумдын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэний төлөөлөл тус бүр 1, Тогтвортой амьжиргаа-3 төслийн орон нутаг дахь зохицуулагч нар томилогдон 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 11 сарын 04-ний өдрүүдэд сумдад тус бүр 2 удаагийн давтамжтай хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн. Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих иргэдийн төлөөлөл болон хяналтын бүлгийн нийт 34 гишүүнтэй хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 20 шалгуур үзүүлэлтийг боловсруулан 2022 оны ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 4-ний хооронд зохион байгуулж хэрэгжилтийг сайжруулах зөвлөмжийг хүргүүлэн, давтан үзлэгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Дархан-Уул аймаг: Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнд Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах үйл ажиллагаанд хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.

Дорноговь аймаг: Төрийн байгууллагуудын мэдээлэл технологи хариуцсан албан хаагчдын нэгдсэн уулзалтыг зохион байгуулж төрийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын цахим уялдаа холбоог сайжруулах чиглэлээр заавар, зөвлөмжийг өгсөн. Төрийн байгууллагын албаны цахим хуудсыг Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг сум болон 18 агентлагууд нэвтрүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албаны цахим хуудасны шинэчлэлт хөгжүүлэлтийг “Ухаалаг Засаглал” ТББ-аар гүйцэтгүүлэн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлсэн. Олон нийтэд төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж орон нутгийн DTV, DSB телевиз, “Өнөөдрийн ялалт”, “Өнөөгийн Дорноговь” сонинд сар бүр онцлох

үйл ажиллагааны 231 мэдээ мэдээллийг нийтэлж 27500 иргэдэд хүргэж ажилласан. Хэвлэл мэдээллийн “www.dornogovipost.mn”, “www.dornogovi.gov.mn”, “www.montsame.mn”, “www.facebook.com/Дорноговь ЗДТГ”, www.facebook.com/Дорноговь АОК” цахим хуудсанд цаг үеийн нөхцөл байдлын 1586, шторк болон постер хэлбэрээр 955 мэдээлэл бэлтгэн оруулж нийт давхардсан тоогоор 301887 иргэнд хүргэсэн бөгөөд үүнээс 106731 иргэнд цахимаар нэмэлт мэдээлэл хүргэсэн. Төрийн байгууллагын албаны цахим хуудсыг 6 сум, 18 агентлагт нэвтрүүлсэн нь өмнөх оноос 19 хувиар, “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг төрийн болон төрийн өмчит 125 байгууллагад нэвтрүүлэн албан бичиг солилцох, өргөдөл гомдол бүртгэх, цаг бүртгэл хөтлөх байдлаар ашиглаж байгаа ба төрийн байгууллагуудад цахим хэрэглээг нэмэгдүүлсэн. Мөн аливаа зөвлөл, ажлын хэсэг, салбар комисст холбогдох мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагыг гишүүнээр оролцуулж төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Дорнод аймаг: Орон нутагт Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-үүдийг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөл орон нутгийн хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж зөвлөмж, уриалга гаргасныг төрийн байгууллагууд дэмжин үйл ажиллагаатайгаа уялдуулж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр хэрэгжиж байгаа холбогдох хууль, үндсэн чиг үүрэг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих нөхцөл боломж бүрдүүлэн ажиллаж байна.

Дундговь аймаг: “Сэтгэлийн-Өнгө” ТББ-тай хамтран аймгийн ЗДТГ, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын албан хаагчдад “Тогтвортой ажил амьдралын суурь”, “Стрессийн менежмент”, “Хандлагын үндэс ямар байна, амжилтын өндөр тийм байна” зэрэг сэдвээр лекц уншуулж, төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Технож Бизнес Инкубатор төв ТББ-тай хамтран “Ашгийн бус төсөл хэрхэн

бичих” сургалтыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 хэлтэс агентлаг, 15 сумын 88 албан хаагчийг оролцуулан зохион байгуулж, төрийн байгууллага, албан хаагчдаас төсөл боловсруулан Засаг даргын “Шуурхай” цуглаанаар аймгийн удирдлагуудад танилцуулан ОУ-ын байгууллага болон бусад бусад холбогдох газруудад хандаж эхлээд байна.

Орхон аймаг: Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавин ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллагаас олгогдож буй хөнгөлөлттэй зээлүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгүүдэд чиглэлийн ТББ-ын төлөөллийг оролцуулан ажилласан. Мөн Нутгийн захиргааны байгууллага “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт иргэний төлөөлөл болон төрийн бус байгууллагын төлөөлөл орж хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, ил тод байдалд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж, 2022 онд 18 ТББ-тай 60,0 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээ байгуулан орон нутгийн төсвөөс олгож хамтран ажилласан.

Өвөрхангай аймаг: Аймгийн Засаг даргын 2022 оны А/238 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан, Залуусын Элч төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан, хууль сахиулах байгууллагуудаас аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрыг сонгон, байгууллагын үйлчилгээний стандарт, албан хаагчдын шийдвэр, үйл ажиллагаанд хүний эрх зөрчлийн талаар хөндлөнгийн мониторинг хийлгэн, дүн мэдээг холбогдох газруудад танилцуулан, цаашдын үйл ажиллагаанд анхаарч ажиллах асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.

Өмнөговь аймаг: Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчийн үйл

ажиллагаа, үйлчилгээ, харилцаа, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээх авах “www.omnigovi.gov.mn Даланзадгад сумын 70530001, 70530002 дугаар утас” тогтмол ажиллаж байна. Мөн иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах хүрээнд орон нутгийн 3 телевиз, 2 сонин, 1 студи, 2 сайт, 2 хэвлэл үйлдвэр, 6 хэвлэл мэдээллийн төрийн бус байгууллага, төвийн 8 сайт, 3 телевиз, 1 сонин, 1 сэтгүүлтэй нийт 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан орон нутгийн төсвөөс 180 гаруй сая төгрөгийг зарцуулан иргэдэд тогтмол мэдээ мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Сүхбаатар аймаг: “Сүхбаатар аймгийн Төр, хувийн хэвшлийн Зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 05 сарын 14-ны өдөр хуралдаж, ТХХЗөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар холбогдох албан тушаалтан мэргэжилтнүүдэд мэдээлэл, зөвлөмж өгч ажилласан.

Сэлэнгэ аймаг: Аймгийн Засаг даргаас Улаан загалмай хороо, Ахмадын хороо, “Сэлэнгэ аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нэгдсэн холбоо” ТББ-уудтай нутгийн удирдлагын байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж 117,8 сая төгрөгийн санхүүжилийг олгон гэрээг хэрэгжүүлэн ажиллаж, хагас бүтэн жилээр үр дүнг тооцон ажилласан. Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 133 дугаар тогтоолоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Иргэний зөвлөлийг дарга, гишүүд нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатайгаар томилон ажиллуулж байна. Иргэний зөвлөл нь хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, олон нийтийн хяналт тавих

чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж сумдын цагдаагийн хэлтэс, тасгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж ажиллав. Сумдад ажиллах үеэрээ иргэдийн төлөөлөлтэй уулзаж цагдаагийн үйл ажиллагаа, ажлын талаар санал хүсэлтийг сонсож цаашдын үйл ажиллагаандаа иргэд, аж ахуйн нэгжийн санал хүсэлтийг тусгаж ажиллахыг зөвлөн ажиллалаа.

Хөвсгөл аймаг: Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулж, хамтранажиллаж байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд хамтран ажиллаж байна. Мөн ахмад настан руу чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймгийн “Ахмадын хороо”-той хамтран уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Үүний зэрэгцээ аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөн, аймгийн баяр наадам, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй уулзалт, хэлэлцүүлэг, сургалтад Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, оролцоог хангах бодлого барьж байгаа юм. Аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай хамтран ажиллах чиглэлээр уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, ТББ-уудыг уулзах нөхцөл боломж, байр танхимаар дэмжин зохион байгуулалтыг ханган ажиллаж байна. ТББ-уудтай харилцаж, мэдээлэл солилцох цахим группийг үүсгэн мэдээлэл солилцож байна.

Хэнтий аймаг: Архидалтгүй хэтийн Хэнтий арга хэмжээний төлөвлөгөөг батлан бүрэн хэрэгжүүлж ажилласан. “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ, “Өндөрхаан Оршихуй” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 25 хүнийг эмийн эмчилгээнд, Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаарх сургалт сурталчилгаанд 5242 иргэнийг хамруулсан.

Увс аймаг: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа захиалагчаас үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, холбооны

төлөөллийг оролцуулж хэвшсэн. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Иргэний зөвлөлийг аймгийн ИТХ-аас тогтоолоор байгуулж, улиралд авах урамшууллыг нь давхар шийдвэрлэсэн. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд хяналт тавих боломж бүрдсэн ба хяналтаа бодитоор хэрэгжүүлж санал шүүмжээ илэрхийлж ажил хэрэг болгож хэвшсэн.(Биелэлт 100 хувь)

4.1.7.3-2 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх /ЗГХЭГ, Аймаг, нийслэлийн Засаг дарга 2018-2022/

Төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг батлан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Дор дурдсан чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна:

Сангийн сайдын тушаалаар олгодог байсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг “Мэргэшсэн нягтлан бодогчийн институт” ТББ-д, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг “Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг”, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээг “Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн”, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг нэр бүхий төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлсэн;

Төрийн зарим ажил үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлж, монгол иргэдэд консулын үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх, Виз мэдүүлэгчийн хувьд цаг хугацаа хэмнэх, визийн үйлчилгээ хялбар шуурхай болж, газар зүйн байршлаас үл хамааран виз авах нөхцөл бүрдүүлэх үүднээс Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын визийн төвийн байршлыг тогтоох,

сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журам” баталсан бөгөөд Монгол Улсын визийн төвийг ажиллуулах асуудлаар гадаадын зарим хуулийн этгээд сонирхлоо илэрхийлсэн бөгөөд Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжин “BLS international” ХК-ийн Бүсийн асуудал хариуцсан ерөнхий менежер Rajesh Dhutre нар 2021.03.19-ний өдөр цахим уулзалт хийж, санал солилцсон. УИХ-аас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-нд өөрчлөлт оруулан баталсан. Уг хуулиар Монгол Улсын цахим виз, хилийн боомтод олгох виз, виз мэдүүлгийн төвийг нээх зэрэг виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалт тусгагдсан. Гадаад харилцааны яамнаас “Монгол Улсын цахим визийн систем” нэвтрүүлэх ААН-ийг сонгон шалгаруулж, тус яаманд олгосон эрхийн дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, идэвхтэй хамтран ажиллаж Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийг 2021.10.01-ний өдрөөс амжилттай нэвтрүүлэв. Уг системээр нэн тэргүүнд Европын орнууд, Австрали, Шинэ Зеланд, БНСУ, БНХАУ зэрэг 36 улсын иргэнд цахим виз олгохоор шийдвэрлэж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар Улсын жагсаалтыг баталсан;

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээний хүрээнд 2021 онд Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөр, бодлогын зорилтыг хэрэгжүүлэх явцад төрийн зарим чиг үүргийг 16 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор нийт 721.439.820 төгрөгийн ажил, үйлчилгээг гүйцэтгүүлсэн;

Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т заасныг үндэслэн батлан хамгаалах болон зэвсэгт хүчний хангалт, үйлчилгээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээнд батлан хамгаалахын материаллаг нөөцийн зарим хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид байнгын нөөц хэлбэрээр хадгалах журмын төслийг боловсруулж, Батлан хамгаалахын сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/354 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Мөн харьяа байгууллага, аж ахуйн нэгжид гэрээт харуул, үйлчлэгч нарыг авч ажиллуулсан;

Засгийн газрын 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах арга хэмжээний тухай” 90 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2020 оны “Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-аас “Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сан”-гийн цахим систем хөгжүүлэх ажлыг 2020 оны 10 дугаар сараас эхлэн “Интерактив” ХХК-тай хамтран ажиллахаар гэрээ байгуулан барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим системийг хөгжүүлж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн бөгөөд энэхүү систем нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, нэмэлт ажлын төрөл нэмэх, нөхөн авах хүсэлтийн цахим системээр дамжуулан хүлээн авч шийдвэрлэх, хяналт тавих зорилготой систем юм. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой дараах үйлчилгээнүүдийг 100 хувь цахим хэлбэрт шилжүүллээ. Үүнд: 1/Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл; 2/Барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл; 3/Өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт заасны дагуу “Монголын Барилгын Үндэсний Ассоциаци” ТББ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг;

Зам, тээврийн хөгжлийн яам авто замын салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн материал хүлээн авах, хянах чиг үүргийг “Монголын авто замчдын холбоо” ТББ, олон улсын автотээвэр гүйцэтгэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг “Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоо”-нд тус тус шилжүүлсэн;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ахмад настны тухай хуулийн 15.1, Засгийн газрын “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 2016 оны 124 дүгээр тогтоолын дагуу “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Монголын ахмадын холбооны хооронд төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ”-г

2016 оноос хойш жил бүр шинэчлэн байгуулж, ахмад настны талаар төрөөс хэрэгжүүлэх зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлж, хуульд заасны дагуу санхүүжилтийг олгон ажиллаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настны үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх 58 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад, Ахмад настны тухай хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4-т заасан үйлчилгээг үзүүлэх 25 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан үйлчилгээг үзүүлэх 4 иргэнд магадлан итгэмжлэлийн гэрчилгээг нийт 87 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад магадлан итгэмжлэлийн гэрчилгээ тус тус олгосон. 2021 оны 2 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмайн нийгэмлэг хүмүүнлэгийн чиглэлээр хамтран ажиллах тухай 1/06 дугаар санамж бичгийг 4 жилийн хугацаатай дахин байгуулж, төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах тухай 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 3/70 дугаартай гэрээг байгуулав. Санамж бичиг, гэрээний хүрээнд дараах ажлыг хамтран хэрэгжүүллээ. Үүнд: 1/ Коронавируст / Covid-19/ халдварын хөл хорионы үед ганц бие ахмад настан, ажил орлогогүй болсон иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор дунд шатны Улаан загалмайн хороогоор дамжуулан зорилтот бүлгийн 898 өрхөд 35.2 сая төгрөгийн хүнсний багц олгосон; 2/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/50 дугаар тушаалаар Засгийн газраас хөл хорионы үед иргэн бүрт олгосон 300.000 төгрөгийн дэмжлэгт өрх, иргэдийг бүрэн хамруулах, бүртгэлжүүлэх, бичиг баримтжуулах, данс нээх үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулсан. Уг ажлын хэсэгт МУЗН-ийн төлөөлөл орж ажиллан Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Улаанчулуутын хогийн цэг дээр ажиллаж, бичиг баримтгүй иргэдийг бүртгэн

нийт 100 иргэнд хүнсний тусламж үзүүлсэн. Мөн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай, асрамжийн газарт амьдарч байгаа бичиг баримтгүй 106 иргэнийг бичиг баримтжуулахад шаардагдах зардал болох 1,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар Улаан загалмайн 15 дунд шатны хороо "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх" чиглэлээр магадлан итгэмжлэгдэж, нийслэл, дүүргийн халамжийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, 52.7 сая төгрөгийн санхүүжилтийг авсан;

БШУЯ: Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын хавсралтын 4.2.10 дах заалтад Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авах тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд боловсрол шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх боломжтой ажил, үйлчилгээний саналыг 2022 оны 10 сарын 14-ны өдрийн 1а/4928 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Боловсролын салбар дахь төрийн бус өмчийн байгууллага, түүгээр үйлчлүүлэгчдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Үүнд 2022-2023 оны хичээлийн жилийн байдлаар суралцагч: 2022 онд гүйцэтгэлээр СӨБ 483 цэцэрлэгийн 31764 хүүхдэд нийт 33,874.3 сая төгрөг санхүүжилт олгосон. 2022 онд гүйцэтгэлээр Төрийн бус өмчийн 172 ерөнхий боловсролын сургуулийн 55315 суралцагчдад 29,703.9 сая төгрөг санхүүжилт олгосон. Их дээд сургууль, коллежийн хувьд: Нийт суралцагчдын 79,718 буюу 54.9 хувь нь төрийн өмчийн, 58.828 буюу 40.5 хувь нь хувийн өмчийн, 6,721 буюу 4.6 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна. Суралцагчдын 135,993 буюу 93.6 хувь нь нийслэлд, 9,274 буюу 6.4 хувь нь орон нутагт суралцаж байна.

ЦЕГ: Цагдаагийн албаны тухай хуулийн 64.1 дэх хэсэгт "Цагдаагийн байгууллага нь нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, иргэдээс зохион байгуулж байгаа гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.”, 64.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.”, 64.3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага, алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь иргэн, хуулийн этгээд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.” гэж цагдаагийн байгууллагаас иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхой зааж өгсөн. Цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх нөхцөл боломжийг Засгийн газрын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Гэрээт харуул, хамгаалалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль болон холбогдох эрх зүйн актын хүрээнд судалж, цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрлүүд нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах асуудал тул төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй талаар Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулсан.

НЗДТГ: 2022 онд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор зарим ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх ажлын хүрээнд нийгмийн хамгааллын чиглэлээр 2, соёлын өв түгээн дэлгэрүүлэх 5, Хөдөлмөр эрхлэлтийн 4, спортын салбарыг хөгжүүлэх чиглэлээр 1, соён гэгээрүүлэх чиглэлээр 8, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн 7, эрүүл мэндийн чиглэлээр 2 нийт 29 байгууллагаар ажил, үйлчилгээг чанар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгүүлэн 410,800,000 төгрөгийн санхүүжилтийг олгож, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль бусад заавар журмын дагуу төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон холбогдох бусад мэдээллийг заагдсан хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулж ажилласан.

Архангай аймаг: Аймгийн хэмжээнд тулгамдаж буй уул уурхайн нөхөн сэргээлт,

агаарын бохирдол, гудамж талбайн гэрэлтүүлэг зэрэг асуудлын хүрээнд холбогдох агентлаг, газруудад чиглэл өгч хамтран ажиллалаа. ISO9001-2015 Чанарын менежментийн тогтоолцоог Цахир сумын ЗДТГ-т нэвтрүүлэх төслийг “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд хэрэглэгчийн, байгууллагын сэтгэл ханамжийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг сурч, туршилт хийж баримт бичгийн дадлага ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Баянхонгор аймаг: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд ирүүлсэн төсөл сонгон шалгаруулах, түүнд хяналт тавих дэд хороонд журмын дагуу төрийн бус байгууллагын 2-3 төлөөллийг томилон ажиллуулж, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэн ажилласан.

Говь-Алтай аймаг: Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 76 төсөл, арга хэмжээ тусгагдаж худалдан авах ажиллагааг зохион байгуулж дууссан байна. Давхардсан тоогоор цахим системд 111 урилга нийтэлсэн. Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд Сангийн сайдын баталсан журмын дагуу боловсруулсан тендерийн баримт бичиг, түүнд тавигдсан шалгуур үзүүлэлтүүдээр сонгон шалгаруулалт хийж 64 төсөл арга хэмжээний эцсийн шийдвэр гарч, үр дүнг нийтэд мэдээлсэн байна. Захиалагчид 73 төсөл арга хэмжээний /давхардсан тоогоор/ зөвлөмжийг хянуулж, баталгаажуулан үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлж, ил тод байдлыг хангасан.

Говьсүмбэр аймаг: 2022 онд спортын 19 холбоодтой хамтран ажиллах гэрээгээ байгуулж, гэрээний дагуу спорт холбоодыг аймгийн хэмжээнд тэмцээн уралдаан зохион байгуулах, бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Спортын салбар холбоодтой хамтран ажилласнаар 2022 онд Бүс, Улс, Олон улсын чанартай шалгаруулах тэмцээнд спортын 16 төрлөөр оролцож алт-37, мөнгө-43, хүрэл-60 нийт 140 медаль хүртээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Өөдрөг зөвлөл” холбооны ажлын байрны түрээсийг орон нутгийн төсвөөс 4.8 сая

төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа. Мөн тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр спорт, урлагийн үйл ажиллагааг зохион байгуулахад 10.0 сая төгрөгийг дэмжлэгийг үзүүлсэн. Аймгийн ахмадын хороотой 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулан 56.2 сая төгрөг, арга хэмжээ үйл ажиллагаа зохион байгуулах зардалд 2.0 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэн хамтран ажиллалаа.

Дархан-Уул аймаг: Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээнд Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, 5,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 520.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дэд бүтэц, нийгмийн чиглэлийн 31 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 26 төслийн хэрэгжилтийг бүрэн хангуулж 462.9 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Дорноговь: Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор 2022 онд аймгийн Ахмадын холбоонд 70,4 сая, Эмэгтэйчүүдийн холбоонд 8.0 сая, Улаан загалмайн нийгэмлэгт 10.0 сая нийт 88.4 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн. Санхүүжилтийн зарцуулалтыг тухай бүр шилэн дансанд байршуулан ажилласан бөгөөд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: Улаан загалмайн хороо нь 8 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 1604 иргэнийг хамруулсан. Аймгийн Ахмадын холбооноос Ковид-19 цар тахлын халдвараас сэргийлэх, малчид болон зорилтот өрхүүдэд 81,6 сая төгрөгийн тусламж дэмжлэгийг олгосон нь өмнөх оноос 16%-аар нэмэгдэж 58 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 13810 ахмадыг хамруулсан нь өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн. Best хөтөлбөрийн Дорноговь салбартай хамтран “модуль-4” “Би туршлагаасаа хуваалцаж чадна” сургалтад 35 залууг хамруулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2022-2023 онд хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг танилцуулж, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” болон бусад төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийн талаар мэдээлэл өгсөн, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-аас Эрдэнэ, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад хэрэгжүүлсэн “Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй” төслийг хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх сумдад 4 га талбайд

малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл хийсэн. АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр байгуулагдсан “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагын BEST хөтөлбөрт орон нутгийн нийт 6-н тариаланчийг хамруулж үр олгосон ба нэг аж ахуй нэгжид зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлсэн. Гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг 16 төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслээр (DTV) давхардсан тоогоор 14864 иргэдэд хүргэсэн. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлж хэвшсэн.

Дорнод: Төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд “Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зардалд 10,000,000 (арван сая), хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудтай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх зардалд 30,000,000 (гучин сая), аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлтэй гэрээ байгуулан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэх зардалд 8,000,000 (найман сая), “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-т 7,500,000 (долоон сая таван зуун мянга), “Оюутан, залуучуудын хөгжил” хөтөлбөрт 7,500,000 (долоон сая таван зуун мянга), Ахмадын зөвлөх багаар дамжуулан “Ахмадын ачлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 7,500,000 (долоон сая таван зуун мянга), өсвөр үе, хүүхэд, залуучуудын “Аз жаргал” төвийн үйл ажиллагааны зардалд 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг тус тус батлуулан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг. Эдгээр хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх танилцуулга, явцын мэдээллийг www.dornod.gov.mn, www.ja-gan.mn сайт болон аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон төрийн бус байгууллагуудын цахим хуудсууд, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд тогтмол хүргэдэг.

Дундговь: Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяан хоттой хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Гуяаны төгөл” төслийн мэдээлэл, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл, Канадын засгийн газрын санхүүжилттэй Мерит төсөл, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын “Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл”, Дэлгэрцогт суманд хэрэгжиж буй “Манай сургууль хүртээмжтэй боловсрол” төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа болон Эрдэнэдалай суманд хэрэгжиж буй гадаадын төсөл хөтөлбөрийн мэдээллийг, мөн Эрчим хүчний яамнаас “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 6 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөгжлийн төвийг барих, Япон Улсын Засгийн газрын 2022 оны Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд “Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн хичээлийн барилгын дээврийн засвар”-ын ажил, Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр аймгийн төвийн цэвэрлэх байгууламж, Эрдэнэдалай сумын ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ажил, Дэлхийн банкны санхүүжилттэй “Эрчим хүчний төсөл-2” ажлын хүрээнд БЗӨБЦТС ТӨХК-ийн харьяа Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарт хэрэгжүүлэх “Дундговь аймгийн төвийн 6кВ ба 0.4кВ хүчдэлийн түгээх сүлжээг шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулах ажил”-ын угсралтын ажил, Нийгмийн түншлэлийн сүлжээ төрийн бус байгууллагаас “дани-монголын нийгэмлэг хариуцлагатай орон нутаг төсөл, Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжлийн төсөл, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газрын хандив тусламж, Япон Монголын хамтарсан Тохокү-Монгол ТББ-ын хандив тусламжийн мэдээлэл зэрэг 2022 онд хэрэгжсэн гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн мэдээ, хийгдэж буй ажлын мэдээлэл, түүний хэрэгжилт, явцын мэдээллийг тухай бүрт dundgov.gov.mn сайтны Ил тод

байдал хэсгийн төсөл хөтөлбөр талбарт байнга байршуулан иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа.

Орхон: Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж, Төрийн бус байгууллагуудаас ажилгүйцэтгэх саналыг авч нэгтгэн, хэрэгжүүлэх боломжтой санал ирүүлсэн Төрийн бус байгууллагуудтай аймгийн Засаг дарга хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн ажил гүйцэтгэх саналуудыг дэмжин, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр 2022 онд 18 ТББ-тай 60,0 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээ байгуулан орон нутгийн төсвөөс олгосон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвүүдийг дэмжих, зорилтот бүлгийн болон хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх, иргэд хүүхдүүдэд сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх боловсрол олгох, эрүүл мэнд, боловсрол, соёл, хүүхэд залуучуудад зориулсан үйл ажиллагаа, жижиг дунд үйлдвэрлэл, холбоодын үйл ажиллагааг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх тэдэнд дэмжлэг үзүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн сургалт сурталчилгаа, гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль зүйн болон сэтгэл зүйн тусалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг тооцож ажилласан. Гэрээ байгуулан ажиллаж буй төрийн бус байгууллагуудын жагсаалт болон санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг www.erdenet.mn сайт болон шилэн дансанд байршуулсан. /Сайтын холбоос: <https://erdenet.mn/medee/newscategory/106/124>

Өвөрхангай: Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээнд 2022 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 телевиз, МҮОНРТ-ын орон нутаг дахь сурвалжлагч, нэг богино долгионы радио, нэг сар тутмын сэтгүүл, 3 сар тутмын сонин, 2 вэб сайт, МҮОНР-ийн сурвалжлагч нийт 12 байгууллагатай 60 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний гүйтэтгэлээр 48.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Нэмэлт санхүүжилтийн дансны 210801

зардлын зүйл ангиар хөрөнгийг зарцуулж, шилэн дансанд болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлд оруулж www.uvurkhangai.mn сайтын шилэн төсөв цэсний “Төсвийн гүйцэтгэл” цонхонд байршуулж олон нийтэд ил тод мэдээлж байна.

Өмнөговь: Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд аймгийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд туссан зарим хөтөлбөр арга хэмжээг төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор 21 иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажиллах гэрээ орон нутгийн төсвийг 213,5 сая төгрөгийн санхүүжилттэй байгуулсан байна. Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлуудад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тусгай хэрэгцээт хүүхэд, охид эмэгтэйчүүд, залуус гэх мэт хүн амын бүлгүүдийн 7000 орчим иргэд хамрагдсан байна. Охид, эмэгтэйчүүдийн оролцоо, хөгжил, хамгааллын чиглэлээр Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдийн холбоо, Даланзадгад сумын эмэгтэйчүүдийн холбоо байгууллагуудтай хамтран ажиллаж нийт 17,9 сая төгрөг; Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Нүүдлийн байгаль хамгаалал ТББ, Олон улсын хүүхдийн найрамдал төв, Буянт хотхон УТҮГ, Хүүхдийн ордон зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж 8,7 сая төгрөг; Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, хөгжил оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр Монголын тусгай олимпын хороо, Ротари клуб, Бялхам хайр дүүрэн ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо ТББ, Цовоо хөөрхөн дэгдээхэй ТББ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж 48,5 сая төгрөг; Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил хамгааллын чиглэлээр Өмнөговь аймгийн бие даан амьдрах төв, Говь пантера клуб, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ёл холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж 40,0 сая төгрөг; Ахмад настнуудын хамт олны дунд хөгжих, идэвхийг нэмэгдүүлэх, тэднийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах хүрээнд Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбоо, 3,4 дүгээр багийн ахмадын зөвлөлүүдтэй хамтран ажиллаж 25,6 сая төгрөг; Залуучуудын оролцоог

нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд татан оролцуулах, хөгжүүлэх, зөв хандлага, мэдлэг боловсролтой залуусыг нэмэгдүүлэх чиглэлээр Өмнөговь аймгийн Залуучуудын холбоо, Гэрэлт айгуул ТББ, Ардчилсан залуучуудын холбоо, Өглөөний клуб, залуу хүн бродерс зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж 72,8 сая төгрөгийг үйл ажиллагааны дэмжлэгт тус тус зарцуулжээ.

Сүхбаатар: Үндэсний давхар даатгал, Албан журмын даатгал, Монголын даатгалын холбоо хамтран даатгалын төлөөлөгчдийн эрх олгох сургалт, шалгалтыг 2022.03.24-25-ны өдрүүдэд Баруун-Урт суманд зохион байгууллаа. Сургалтад Ард даатгал, Монгол даатгал, Практикал даатгал, Бодь даатгал болон Миг даатгалын нийт 25 төлөөлөгч хамрагдсан. Даатгалын үйлчилгээний эрх горилогчдоос шалгалтад 10 иргэн тэнцэж “Монгол даатгал” ХК-д төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрлөө авлаа. Сүхбаатар аймагт энэ оны байдлаар даатгалын хохирол үнэлэгчийн 2 салбар, даатгал зуучлагчийн 7 салбар үйл ажиллагаа явуулж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу даатгалын байгууллагын нөхөн төлбөрийн асуудлаар 2 иргэн, үйл ажиллагааны талаар 1 иргэнээс гомдол, өргөдөл ирсэн бөгөөд иргэн Б.Энхтөр, иргэн Н.Уранчимэг нарын гомдлыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Иргэн Б.Энхтөр, Н.Уранчимэгийн гомдол СЗХ-оос шийдвэрлэгдэн ирж, тус шийдвэрийг тухайн иргэдэд танилцуулан ажиллалаа. Мөн орон нутгийн иргэдийг цахим гэмт хэрэгт татан оролцуулах, хууран мэхлэх гэмт хэргээс сэргийлэх үүднээс аймагт байгуулагдсан PLC Ultima койны газрыг татан буулгасан ба тус койнд хамрагдахаар судлаж байсан 2 иргэнийг мэдээлэл зөвлөгөөгөөр ханган, хөрөнгө мөнгөө залилуулахаас сэргийлэн ажиллалаа. Зохицуулалттай санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланг улирал бүр авч танилцан, шаардлагатай тохиолдолд уулзаж, санал солилцож, холбогдох шийдвэрийг гарган ажилласан болно. Аймгийн хэмжээнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 119 иргэн байдаг

бөгөөд аймгийн төвд болон 12 суманд гэнэтийн осол, эмчилгээний даатгал, хөрөнгийн даатгал, автотээврийн хэрэгслийн даатгал, мал амьтдын даатгал, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, урт хугацааны даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.- Улс, орон нутгийн төсвийн нийт 128 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн давхардсан тоогоор 1536 мэдээг хуулийн хугацаанд хянан хүлээн авч, тулган баталгаажуулж боловсруулан дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллаа. - Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн сарын гүйцэтгэлийн мэдээг 13 сумын ерөнхийлөн захирагч, төсөвт байгууллага, төсөл сан, татварын орлогыг тулган хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал бүрээр тулган баталгаажуулж холбогдох залруулгыг тухай бүр хийж ажиллаа. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг иргэд, олон нийтэд ойлгомжтой байх үүднээс боловсруулсан маягтын дагуу гаргаж аймгийн Статистикийн хэлтэст, мөн шилэн дансны цахим системд холбогдох маягтын дагуу оруулах зэрэг ажлыг сарын бүрийн 8-ны дотор хийж хэрэгжүүлсэн болно.

Сэлэнгэ: Аймгийн Засаг даргаас Улаан загалмай хороо, Ахмадын хороо, "Сэлэнгэ аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг" ТББ, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нэгдсэн холбоо" ТББ-уудтай нутгийн удирдлагын байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж 117,8 сая төгрөгийн санхүүжилийг олгон гэрээг хэрэгжүүлэн ажиллаж, хагас бүтэн жилээр үр дүнг тооцон ажилласан.

Ховд: Аймгийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн Ховд, Олон ястны телевиз, Ховдын мэдээ, Ховдын толь сонинтой гэрээ байгуулж ажиллаж, энэ хугацаанд Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдолтой 400 гаруй мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, видео шторк бэлтгэн <http://khovd.gov.mn/>, <https://www.facebook.com/khovdnews.mn> цахим хуудсанд нийтэлж мэдээлэл бэлтгэн, Монгол улсын шилдэг аймаг Ховд-2021 8000 ширхэг сэтгүүл хэвлэн олон нийтийн хүртээл болгов. Байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой үйлчилгээ авахад шаардагдах баримт бичгийн жагсаалт,

бүрдүүлэх материал, холбогдох дүрэм, журам, зааврыг http://khovd.gov.mn/?page_id=4302 цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр нь шинэчилж, иргэдэд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж ажиллав. Аймгийн ЗДТГ-ын зүгээс иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудтайгаа хамтран ажиллаж, тэдний санал бодлыг сонсон хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ирсэн. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, бусад асуудлаар хамтран ажиллах хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар 3 төрийн бус байгууллагатай санамж бичиг байгуулсан. Төсвөөс олгож байгаа ямар нэгэн санхүүжилтийн зарцуулалтыг шилэн дансны сайт болон аймгийн Khovd.gov.mn сайтад нийтэлж, эрх бүхий албан тушаалтнуудын захирамж, тушаал шийдвэрийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. http://khovd.gov.mn/?page_id=13632 http://khovd.gov.mn/?page_id=13630

Хөвсгөл: Аймгийн төв Мөрөн сумын хот тохижилтын ажлыг "Мөрөн Хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-иар гэрээ байгуулан гүйцэтгүүлж байгаа бөгөөд 2022 оны тухайд 1122.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлсэн бол 2023 онд 1238.2 төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан болно. Өгсөн санхүүжилт болон төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансанд тогтмол мэдээллэн ажилласан байна.

Хэнтий: "Хэрлэн Цэнхэр Алс" ТББ /10 сая/, "Өндөрхаан Оршихуй" ХХК /11.2 сая/, аймгийн "Улаанзагалмайн хороо" /10 сая/, "Монголын хог хаягдалыг дахин боловсруулах үндэсний холбоо" /1 сая/ зэрэг нийт 4 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж, санхүүжилтийг Хэнтий аймгийн албан ёсны цахим хуудсанд ил тод нийтэд мэдээллэж ажилласан.

Увс: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээнд 735 ахмад өдрийн үйлчилгээнд 267 ахмад, бүлгийн төсөлд 28 иргэн, нийт 1030 иргэнийг хамруулж 130.608 мянган төгрөгийг зарцуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.3-3 Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах / ЗГХЭГ, Аймаг, нийслэлийн Засаг дарга 2020-2022/

Энэ хүрээнд төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан ба үнэлгээг “Жи Би Эм Социал ресерч консалтинг” ТББ гүйцэтгэсэн. Хөндлөнгийн үнэлгээний тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтээр 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөө” сэдвийн хүрээнд цахим хэлбэрээр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, “Жи Би Эм Социал ресерч консалтинг” ТББ, Монголын хуульчдын холбоо, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, “Баасанжав Консалтинг” ХХК, “Монголын авто замчдын холбоо” ТББ, “Монголын авто тээвэрчдийн холбоо” ТББ, “Монголын барилгын үндэсний ассоциац” ТББ, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Нээлттэй нийгэм форум” ТББ, “Хүний хөгжил судалгааны төв” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 42 хүн оролцлоо. Хэлэлцүүлэгт оролцогчид төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа асуудал нь маш чухал гэдгийг онцолсон бөгөөд олон улсын нийтлэг туршлагад үндэслэж явж байгаа тул эрх зүйн баталгааг бий болгох, үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй гэдэгт санал нэгдэв.

Барилга, хот байгуулалтын яам төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхээр “Монголын барилгын үндэсний ассоциац” ТББ, “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” ТББ, “Монголын архитекторуудын эвлэл” ТББ, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-уудтай байгуулсан гэрээний 2020 оны хэрэгжилтэд

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2021 онд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. Түүнчлэн Барилга, хот байгуулалтын яам, “Монголын барилгын үндэсний ассоциац” ТББ хамтран «Барилгын салбарын төр, хувийн хэвшлийн түншлэл”-тэй ажил хэргийн уулзалтыг зохион байгуулж, тус салбарт дэвшүүлсэн бодлого, зорилт, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч танилцуулсан. Мөн барилгын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл болох 100 гаруй хүн оролцсон цахим уулзалтыг зохион байгуулж, тулгамдсан асуудал, шийдэх гарц, санал санаачилга, оновчтой шийдлийн талаар хэлэлцсэн нь үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэсэн бол ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа төрийн байгууллагад хүргүүлэх, тухайн төрийн байгууллага болон ашгийн төлөө бус хуулийн этгээд нь тайлангаа нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар тусгасан. Холбооны гүйцэтгэж байгаа аж ахуйн болон нийтэд тустай үйл ажиллагаанаас олсон орлогыг орлогын албан татвараас чөлөөлөх хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Төрийн зарим чиг үүргийг холбоогоор гэрээлэн гүйцэтгэх нөхцөлийг үл ялгаварлах, нээлттэй, ил тод байх, хараат бус байдлыг хүндэтгэх, урьдчилсан магадлан итгэмжлэл үүсгэх замаар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн өрсөлдөх боломжийг хязгаарлахгүй байх зэрэг нийтлэг зарчимд нийцүүлэн төр, холбооны хамтран ажиллах харилцааг бизнесийн байгууллагаас ялгаатай байдлаар тодорхойлсон. Холбооноос гадна бусад ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа бол тухайн үйл ажиллагаатай холбоотой санхүү, татвар, үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад гаргах эрх зүйн орчныг тодруулан тусгасан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.4-1 Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах /АТГ, ХЗДХЯ 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулахаар тусгагдсаны дагуу орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 30 байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүн, 2019 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулж байсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/53, А/44 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засгийн газрын яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам” хүчингүй болсонтой холбоотойгоор уг зөвлөлийн үйл ажиллагаа зогссон.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох” гэж заасан. Төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд

олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмаар олон нийтийн хэрэгжүүлэх чиглэлийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн төдийгүй төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулж, хэрэгжүүлэхээр журамласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Авлига, албан тушаалтын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийг байгуулсан. (Биелэлт 0 хувь)

4.1.7.4-2. Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдийг сургах, чадавхжуулах /АТГ 2017-2022/

Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам, агентлагийн дэргэд ажиллах Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийн 152 гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 01, 05 дугаар саруудад зохион байгуулан энэ хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хяналт шалгалт, үр нөлөө”, “Нээлттэй мэдээллийг ашиглаж албан тушаалтанд хяналт тавих нь”, “Цахим худалдан авалтын үйл ажиллагаа: Хөндлөнгийн хяналт, арга зам”, “Төсвийн төлөвлөлт ба үр ашгийг хянах арга зүйд суралцах нь”, “Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх арга зам, туршлага”, “Худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр сургалт хийж, иргэний хяналтыг орон нутагт бэхжүүлэх чиглэлээр ажиллах иргэдэд тусгайлсан мэдлэг, мэдээлэл, арга зүйд сургасан.

Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам” батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газар нь олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөлтэй хамтран

зохион байгуулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх иргэн, иргэдийн бүлэг, иргэний нийгмийн байгууллагад тусгайлсан сургалт хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх зэргээр дэмжлэг үзүүлэн ажиллах бэлтгэл ажлын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлох, хяналт хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбарын зөвлөлийн гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, онлайн сургалт, мэдээлэл хийсэн.(Биелэлт 100 хувь)

4.1.7.4-3. Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журмыг батлуулж, мөрдөх /АТГ 2017/

Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулан ажиллуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/53, А/44 тоот тушаалаар "Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засгийн газрын яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам"-ыг батлан иргэний хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулсан ба 2017-2019 онуудад иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.7.5-1. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох /АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018-2022/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар "Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-

ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын хоёрдугаар зүйлийн 2.1-д зөвлөл олон нийтийг төлөөлөх хэрэгжүүлэх асуудлаар авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, үнэлэх, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нийтийн сонсгол зохион байгуулах, төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжид АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулах сургалт, сурталчилгааны ажилд оролцох зэрэг нийт 23 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 186 дугаар зарлигаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэхүү зарлигаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд "Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн олон улсын болон үндэсний хөтөлбөр, төсөлд хамрагдах, оролцох" нөхцөлийг бүрдүүлсэн.

Мөн дээрх зарлигаар "Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1.3-т "Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтрасан нийтийн сонсголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах" гэснийг "Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтарсан нийтийн сонсголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах, энэ хүрээнд Олон нийтийн дэд зөвлөлийг ажиллуулж болно" гэж өөрчлөн найруулсан.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 сарын 26-ны өдрийн дугаар 21 зарлигаар "Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн батлан мөрдөж байна.(Биелэлт 100 хувь)

4.1.7.5-2. Олон нийтийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гишүүдийн урамшууллын асуудлыг шийдвэрлүүлэх /АТГ, ХЗДХЯ, АТГ-ын дэргэдэх ОНЗ, 2018-2020/

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох” гэж заасны дагуу төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох журамд хяналт хэрэгжүүлэх этгээдийн ажиллах нөхцөл боломж, урамшуулах асуудлыг тусгасан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 42 дугаар захирамжаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл шинэчлэн байгуулагдсан. Тус зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд байрлан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2017 оноос эхлэн зөвлөлийн гишүүдэд сар бүр урамшуулал олгож байна. (Биелэлт 100 хувь)

4.1.7.5-3. Олон улсын туршлагад тулгуурлан Олон нийтийн зөвлөлийн дэргэд Авлигын эсрэг иргэд, залуучуудын клубыг байгуулах / АТГ-ын дэргэдэх ОНЗ, АТГ 2018-2022/

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлөөс Их Британийн Засгийн газраас 2010 онд ашигласан сайн туршлага болох авлигыг мэдээлэхэд хэрэглэж буй Мэдээлж, Жигш аргад тулгуурлан “Авлигыг мэдээлж, Жигш (АМЖ)” клубыг 2017 онд үүсгэн байгуулан ажиллуулж Авлигыг мэдээлж, жигш буюу “АМЖ клуб” нь <https://www.facebook.com/naming.shaming> сувгийг ашиглан мэдээлэл хүлээн авч, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг мэдээллийг олон нийтэд хүртээмжтэйгээр түгээх, ард иргэдийн санал бодлыг нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авах, 110 дугаарын утсыг сурталчлах, холбогдох мэдээллийг иргэдэд хүргэх, хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажилласны зэрэгцээ иргэд, залуучуудын шударга ёсны ойлголт,

мэдлэгийг дээшлүүлэх 3 модультай сургалтын бэлтгэл ажлын ханган, сургалтуудыг явуулсан. “Авлигыг мэдээлж, Жигш” клуб нь 2021 онд Ковид-19 цар тахлын үед үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр зохион байгуулж ажилласан. (Биелэлт 100 хувь)

4.1.7.6-1. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх /АТГ, ХЗДХЯ, ОӨГ, ТББ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хуульд хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн, мөн шүүхийн шийдвэрийн нээлттэй ил тод байх зарчим үйлчилж байгаа учраас дээрх асуудлаар мэдээлэх боломж бүрдсэн.

Шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан авлига албан тушаалын хэргийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж байна. Мөн тухайн хэргүүдийн талаар иргэд олон нийтийг цаг алдалгүй мэдээллээр хангах зорилгоор олон нийтийн сүлжээг ашиглан “шүүхийн мэдээ” фейсбүүк пейж хуудсыг ажиллуулан шүүхийн шийдвэрүүдийн талаарх мэдээллийг хүргэж байна.

Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийн улмаас төр, иргэн, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийн хүрээнд 2020 онд 35,6 тэрбум төгрөгийн, 2021 онд 96,2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж төр, иргэн, нийтийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн бөгөөд энэ талаар байгууллагын цахим хуудас, iaac.mn мэдээллийн хуудас, “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлэг, твитер facebook пэйж хуудас, МҮОНР-ийн 110 мэдээллийн хөтөлбөр зэрэг хэвлэл мэдээллийн боломжит бүхий л хэлбэрээр иргэд олон нийтийн хүртээл болгосон. Тус газраас газраас авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон. (Биелэлт 70 хувь)

4.1.7.6-2. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох, нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, АТГ, ТББ, 2020-2022/

Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох эрх зүйн орчин бүрдээгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан. Уг хуультай холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, мөн өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцохоор холбогдох өөрчлөлтийг оруулсан болно. 2017 онд баталсан Прокурорын тухай шинэчилсэн найруулгын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах”, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээ авна” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсэгт “Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх дээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй” байхаар,

31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тогтоол, даалгавар, зөвшөөрөл, шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, санал, эсэргүүцэл, хүсэлт, нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана” гэж тус тус хуульчилсан.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Уг хуулийн төсөлд холбоо нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тусгасан. (Биелэлт 30 хувь)

4.1.7.6-3. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцаа авах арга хэмжээг зохион байгуулах /АТГ, ЦЕГ, мэргэжлийн холбоод, ТББ, 2020-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцаа авах арга хэмжээг Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, тэдгээрийн гишүүн аж ахуйн нэгж, мэргэшсэн үнэлгээчид, аудиторуд болон хууль зүй, санхүүгийн чиглэлээр дагнасан орчуулга хийдэг мэргэжлийн орчуулагчдыг мөрдөн шалгах ажиллагааны явцад шинжээч, орчуулагчаар томилж дүгнэлт гаргуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад 2021 онд санхүүгийн аудит хийлгэх, битүүмжилсэн болон эд мөрийн баримтаар тооцсон хөрөнгүүдэд үнэлгээ тогтоолгох, барилга байгууламж, үйл ажиллагааны өөрийн өртөг төсөв тогтоолгох, гадаад хэлний орчуулга хийлгэх чиглэлээр давхардсан тоогоор 93 мэргэжлийн холбоо болон ТББ-тай шинжээч томилох, гэрээ байгуулах зэргээр хамтран ажиллаж авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгахад тэдний тусгай мэдлэгийг ашиглан хамтран ажилласан. Тухайлбал, Хөгжлийн банкны албан тушаалтнууд албаны бүрэн эрх, албан тушаалын

байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан хэрэгт Монгол банк болон санхүүгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран зээл хөтөлбөр нь Хөгжлийн банкны тухай хуульд заасан шаардлага хангасан эсэх, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх зэргийг тогтоох зорилгоор, 5 дүгнэлт гаргуулж мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Мөн 17 хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.8-д заасны дагуу Сангийн яамнаас зөвлөмж гаргуулсан болно. (Биелэлт 100 хувь)

Найм. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр тусгагдсан 5 үйл ажиллагаа, 9 арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.8.1-1. Баримтад суурилсан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх /АТГ, ХХМТГ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдэх үе шатанд сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад Авлигатай тэмцэх газраас Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб интернешнл төв” ТББ байгууллагатай хамтран “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо”, “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн холбооноос «Орон нутгийн хэвлэл мэдээллийн II форум”-ыг, “Хуурамч мэдээлэл ба төөрөгдөл-Иргэдийн мэдэх эрхийг хамгаалах нь” сэдэвт анхдугаар чуулганыг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Германы Фридрих Эбертийн сан, Дойче Велле Академи болон Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран «Хэвлэлийн эрх чөлөө ба

Дижитал хувьсал» сэтгүүл зүйн ёс зүйн форумыг тус тус зохион байгуулсан.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс “Монгол-Оросын хэвлэл мэдээллийн форум”-ыг 2021 онд, “Монгол-Хятадын хэвлэл мэдээллийн XII форум”-ыг 2021 онд тус тус зохион байгуулж, хоёр талын 200 гаруй төлөөлөл оролцож, хамтарсан тунхаг гаргасан.

Иргэн, төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн сүлжээг зүй зохистой ашиглах мэдлэг ойлголт өгөх, цахим орчинд үйлдэгдэж байгаа аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээллийн алба, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Гадаад харилцааны яам, Цагдаагийн Ерөнхий газар хамтран «Нийтлэхээсээ өмнө бодъё, тунгаа» санаачилгыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, бүх нийтэд, төрийн байгууллагуудад, хэвлэл, мэдээллийн байгууллага болон мэдээллийн вэб сайтуудад түгээх зурагт хуудсыг тус бүр 10 төрлийн агуулгаар бэлтгэн түгээсэн.

Хэвлэлийн хүрээлэнгээс «Хуурамч мэдээлэлтэй хамтын хүчээр тэмцье» уриатай “TechCamp Mongolia-2019” Ази, Номхон далайн бүсийн цугларалтыг Монголд анх удаа АНУ-ын Элчин Сайдын яам, “Мидас” ТББ болон Хэвлэлийн Хүрээлэн хамтран зохион байгуулж, цахим орчинд мэдээлэл эрж хайх, нягтлан шалгах бүтээлч санаачилгыг өрнүүлэн худал мэдээлэлтэй тэмцэх аргад суралцах интерактив хэлэлцүүлэг хийсэн. “Fact checking and verification” сургалтын хөтөлбөр шинээр боловсруулж, сэтгүүлчдэд зориулсан нийгмийн сүлжээнд түгээж буй мэдээллийг ашиглах, бусдад түгээхээс өмнө нягтлан шалгах үндсэн алхам, баримтыг нягтлан шалгах, эх сурвалжийг баталгаажуулах зарим арга, нийгмийн мэдээллийн сүлжээ болон Интернэтийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэрхэн ашиглах талаарх мэдлэг олгосон цуврал сургалт зохион байгуулсан.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс мэргэжлийн ёс зүйн сургалтыг цахим сэтгүүл зүйн шинэ трэндтэй хослуулан сэтгүүлчдэд зориулсан “Цахим сэтгүүл зүй ба шинэ трэнд - мэргэжлийн

ёс зүй” сэдэвт интерактив 2 өдрийн сургалтыг Авлигатай тэмцэх газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Тус сургалтаар сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн түгээмэл гаргаж буй зөрчлийн талаар ярилцаж, хэрхэн сэргийлж болох тухай хэлэлцсэн юм. МУИС, Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн багш нар сургалтад оролцож цахим сэтгүүл зүйн шинэ трэндүүдийг танилцуулсан.

Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө” төслийн хүрээнд хийсэн «Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт» судалгааны тайланг зорилтот бүлгүүдэд танилцуулж, санал, мэдээлэл солилцсон. Мөн “Нийгмийн сүлжээ болон тоон контентын эрх зүйн орчин” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Мөн 2021 онд төв, орон нутгийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан “Шударга, ёс зүйт сонгууль ба хэвлэл мэдээлэл” сэдэвт 2 удаагийн 4 өдрийн цахим сургалтын үеэр оролцогчдоос гаргасан саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулсан. Тус төвөөс “Сонгууль ба хэвлэл мэдээлэл” цахим чуулга, уулзалтыг 2021 онд “Залуучууд, эмэгтэй сэтгүүлчдийг эрх мэдэлжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд, “Мэдэх эрх ба эрсдэлийн үед мэдээллийн хүртээмжийг илүү хангах нь” ба “Мэдээлэл олон нийтийн сайн сайхны төлөөх байх нь” сэдэвт цахим хэлэлцүүлгийг Улаанбаатар хот, есөн аймгийн төлөөлөл оролцуулан мэдээллийн ил тод байдал, хүртээмж, мэдэх эрх болон хууль эрх зүйн орчин, зөрчилтэй холбоотой асуудлыг олон нийтэд танилцуулж, нээлттэй харилцан ярилцах хэлбэрээр хүргэсэн. Мөн “Глоб интернэшнл төв” ТББ “Ус дээшээ урсдаг” олон ангит киноны 5 дугаар бүлэг “Ариун шүтээний харц” соёлын өвийн авлигын сэдэвт кино бүтээлийг ашиглан “Соёлын өв ба авлига” сэдэвт кино сургалтын модуль боловсруулан Авлигатай тэмцэх газар хамтран “Авлигын эсрэг чадавх бэхжүүлэх нь” сургалтыг 17 прокурор, 15 цагдаагийн алба хаагчийг хамруулан зохион байгуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.8.1-2. Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулсан байх / АТГ, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, 2018-2020/

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилго бүхий “Investigative Journalism Dialogue” эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын хурлыг хоёр жил дараалан зохион байгуулж, хуралд Германы Дойче Велле олон улсын мэдээллийн агентлагийн Судалгаа ба Хамтын ажиллагааны төсөл, Хонг Конгийн Их сургуулийн “Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл судлалын төв”, ЮНЕСКО-гийн Бээжин дэх салбарын Мэдээлэл, харилцааны салбар, Нээлттэй Нийгэм Сангийн Хараат бус сэтгүүл зүйн хөтөлбөр зэрэг байгууллагын төлөөлөл, зочид оролцож, Монголын сэтгүүлчид, сэтгүүлзүйн багш, судлаачид, иргэний нийгмийн төлөөлөлтэй харилцан туршлага солилцлоо.

ХБНГУ-ын Дойче Велле Академи, Фридрих Эбертийн Сангийн тэтгэлгээр Эрэн сурвалжлах сэтгүүлзүйн гурвандолоохоногийн сургалтад төв орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 17 сэтгүүлч хамрагдаж амжилттай төгссөн.

Монголын хэвлэлийн хүрээлэнгээс тоон мэдээллийг ашиглаж эрэн сурвалжилсан бүтээл бэлтгэх чадавхыг дээшлүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд цуврал 5 сургалт, 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд “Дата сэтгүүл зүйн удиртгал”, “Дата өгөгдлийг дүрсжүүлэх нь”, “Дата анализ” зэрэг сургалтыг Хэвлэлийн Хүрээлэнгийн багш нар, төслийн зөвлөлтэй хамтран зохион байгуулснаас гадна Үндэсний Статистикийн хороо болон МУИС-ийн багш нартай хамтран статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүйн нэмэлт сургалтуудыг тус тус зохион байгуулав. Төслийн сургалтуудад хамрагдсан 4 баг бүтээлийн тэтгэлэг авч, эрэн сурвалжилсан Дата сэтгүүл зүйн бүтээл бэлтгэж, төслийн төгсгөлийн шатанд олон нийтэд танилцуулсан. Авлигатай тэмцэх газраас 2022 онд Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр орон нутгийн сэтгүүлчдэд, мөн нийслэл дэх хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд зориулсан 2 удаагийн сургалтыг

зохион байгуулсан.

Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Азийн сангаас зохион байгуулсан “Залуусын дуу хоолой” чуулга уулзалтын “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба залуусын оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг Хэвлэлийн Хүрээлэн удирдан зохион байгуулав. Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэй хэрэгжсэн “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол төсөл”-ийн хүрээнд Хэвлэл мэдээлэл ба иргэдийн оролцоо, мэдээлэл авах эрх, эрх чөлөө, нийгмийн сүлжээ ба дижитал боловсрол, хуурамч мэдээллийг илрүүлэх тухай сэдвээр сургалт зохион байгуулав.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран “Мэргэшсэн ажилтан бэлтгэх бодлогыг сурталчлах нь” сэдэвт сэтгүүлчдэд зориулсан сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Цар тахлын үед орон нутгийн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд тулгамдаж буй сорилт, бэрхшээл” сэдэвт цахим уулзалтыг бүсээр хуваан Баруун бүс /Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан/, Зүүн бүс /Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Налайх, Багануур/, Төвийн бүс /Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хөтөл-ийн аймгууд дахь салбар зөвлөлийн тэргүүн болон гишүүн сэтгүүлчидтэй хамтран зохион байгуулав.

2021 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс 24 салбар зөвлөлийн нийт 100 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг оролцуулан “Орон нутгийн хэвлэл мэдээллийн III форум”-ыг, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумыг цахимаар тус тус зохион байгуулсан.

2022 онд Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран “Авлигатай тэмцэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо” сэдэвт сургалт, семинарыг 2 удаа зохион байгуулж, нийт орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 69 сэтгүүлчийг, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын

төслийн санхүүжилтээр Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагатай хамтран эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ур чадвар олгох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, сэтгүүлчдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр ажилладаг 54 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан. Мөн тус ТББ-аас Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалтыг нийслэл болон аймгийн телевиз, сонин, сайтын нийт 20 сэтгүүлчийг хамруулан явуулж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга барил, үр өгөөж, нууц эх сурвалжаа хэрхэн хамгаалж, харилцахаас эхлээд баримтаа нягтлан шалгахын ач холбогдол, мэргэжлийн ёс зүй зэрэг цэвэр мэргэжлийн түвшний мэдлэг олгов.

“Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв”-тэй хамтран авлига, ашиг сонирхлын улмаас хохирсон нийтийн эрх ашиг, хулгайлагдсан боломж, эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны бодит түүхийг эрэн сурвалжлан нийтэд хүргэх зорилгоор “Түүний түүх” сэдэвт Storytelling сэтгүүл зүйн бүтээлийн уралдааныг зохион байгуулж, оролцогчдын бүтээлийг шалгаруулсан.(Биелэлт 100 хувь)

4.1.8.2-1. Сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тохиолдолд “Нөлөөллийн мэдүүлэг” гаргах, хууль бус нөлөөлөлд хариуцлага хүлээлгэх асуудлыг судлах, санал боловсруулах /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, АТГ, ХЗДХЯ. 2018-2019/

Хэвлэлийн хүрээлэнгээс ХБНГУ-ын Ханс Зайдель Сан, Эрх зүйн боловсролын академийн дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн эрх зүйн асуудлаар гурван удаагийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд хэвлэл нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбартай холбоотой амин чухал хууль, эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал, “Гүтгэх үйлдлийн тухай ойлголт”, Төрийн ба албаны нууцын тухай хуулийн зохицуулалтыг хөндөв. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл болон 300 гаруй сэтгүүлч нэгдэж 2020.04.27-ны өдөр

хуулийн байгууллагын алба хаагч сэтгүүлчийн биед халдсан асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад мэдээлэл хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, албан ёсны цахим хуудастаа 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байршуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 13.14 “Худал мэдээлэл тараах” заалтыг нэмж, хэвлэлийн болон иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхий л талаар хянан цагдах, хязгаарлан боомилохоор тусгасан талаар МСНЭ-ээс байр сууриа илэрхийлэн, мэдэгдэл гаргасан. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэсэн байна.

Хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулж буй эвлэл, холбоод 2020.12.18-ны өдөр нэгдэж, Хэвлэлийн эрх чөлөөний төлөө Үндэсний түр зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь Хэвлэлийн эрх чөлөөг хангах, хамгаалах, баталгаажуулах үндсэн чиглэлээр ажиллах бөгөөд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг батлах хүртэл үндэсний хэмжээний зөвшилцлийн үйл ажиллагаа явуулж байхаар тогтсон байна.

“Глоб интернэйшнл төв” ТББ-аас “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох Олон улсын өдөр”-т зориулан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахын тулд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт нийт хэвлэл мэдээллийн болон төрийн байгууллагын төлөөлөл болох 27 хүн оролцсон.

2002-2017 онд гүтгэлэг, доромжлолыг Эрүүгийн хуулиар шийдэж ирсэн бөгөөд энэ хугацаанд 48 сэтгүүлч үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлсний төлөө эрүүгийн хуульд заасан үйлдэл гаргасан хэргээр

шүүхэд дуудагдсан. Иймд ХМЗ-өөс санаачлан эдгээр хэргүүдийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн болон зарим хэргүүдэд хараат бус судлаачаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлгэсэн. Ингэснээр гүтгэлгийг Эрүүгийн хуулиар шийдэж ирсний давуу болон сул талыг үнэлж дүгнэх боломжийг эрэлхийлж байна. Мөн зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтын хэрэгжилт, түүнийг хэрэгжүүлэх явцад сэтгүүлчдэд тулгарч буй бэрхшээлийн талаар шүүгч, прокурор болон сэтгүүлчдэд зориулсан 4 удаагийн сургалт, дугуй ширээний ярилцлагыг хийсэн болно. Мөн ЦЕГ-аас хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг тогтмол авч, сэтгүүлчдийн анхааралд хүргэж байна. 2018 оны арванхоёрдугаар сард хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагуудтай (МСНЭ, ГИТ, ОНХМХ, МСХ ГМ) хамтарсан гүтгэх зөрчлийг Зөрчлийн тухай хуулиас хасах мэдэгдэл гаргаж, тодорхой хүрээнд акц өрнүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.8.2-2. НҮБ-ын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй орчинг бүрдүүлэх уриалга, ЮНЕСКО-гоос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнах /ГХЯ, 2017-2020/

НҮБ-аас гаргасан уриалга, ЮНЕСКО-гоос Монголын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн дагуу сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулснаас гадна гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сурвалжлага, нэвтрүүлэг хийх гадаадын сурвалжлагчдын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, Гадаад харилцааны яам дээр бүртгэн, түр сурвалжлагчийн үнэмлэх олгож байна. Гадаад харилцааны чиглэлээр дагнан бичдэг, энэ сэдвийг сонирхон судалдаг сэтгүүлчдийн “Дипломат клуб”-ын үйл ажиллагааг сэргээн нээлтийн ажил болгож, 14 хоногийн сургалтыг Дипломат Академитай хамтран 30 хэвлэл мэдээллийн байгууллагын 32 сэтгүүлч, редакторыг хамруулан зохион байгуулав.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хараат бус судлаачидтай хамтран “УИХ-ын сонгуулийн

жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлт” судалгааг хийж, үр дүнг 2020 онд 2 удаа дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг дээр танилцуулсан. Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллага, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол” төслийн хүрээнд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын үндэсний форумыг Монголд анх удаа Монголын хэвлэлийн хүрээлэнгээс зохион байгуулав. Форумд төрийн болон болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөлөл, дунд сургуулийн багш, албан бус сургалтын байгууллагын төлөөлөгч нийт 100 гаруй хүн оролцож, Монголд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг хөгжүүлэхийн ач холбогдол, шаардлага хэрэгцээ, нөхцөл байдал, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэв.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын сурвалжлагчийг бүртгэх, Монгол Улсад виз, оршин суух зөвшөөрөл олгох журам”-ыг Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор хүчингүй болгож, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг баталжээ. Уг журмын “Гурав”-ын 3.1.5, 3.1.6-д зааснаар гадаад улсын олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт болон түүнийг төлөөлж ажиллах ажилтан албан хаагчдад “А2”, “А2-1” төрлийн албан хэргээр оршин суух хэлбэрийн зөвшөөрлийг олгох, эдгээр ажилтнуудын оршин суух үнэмлэх, мэдүүлгийн хуудасны загварыг гадаад харилцааны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар тусгажээ. Одоогоор албан ёсны зөвшөөрөлтэй гадаадын 21 хүн байнгын үйл ажиллагаа явуулдаг байна.

НҮБ-ын Ардчиллын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2021 оны 6 дугаар сард сэтгүүлчдийн ажил, үүргээ гүйцэтгэх явцад интернэтээс мэдээлэл эрж хайх, нягтлан шалгах, цахим орчинд эх сурвалжтай харьцах аюулгүй байдлыг хангах аргад суралцах, зайлшгүй мэдэх шаардлагатай зарим мэдээлэл, зөвлөмж бүхий “Сэтгүүлчийн аюулгүй байдал” гарын авлагыг бэлтгэн хүргэсэн.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах, өнөөгийн байдал үнэлгээ өгөх

чиглэлээр Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын хуульчдын холбоо, Глоб интернэшнл төв нягт хамтран ажиллаж байна. 2019-2022 онд гурван байгууллагын хамтарсан сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн хүрээнд хамтарсан дүн шинжилгээ хийлээ. Тухайлбал, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб интернэшнл төв ТББ-тай хамтран Монголын сэтгүүлчдийн аюулгүй байдлын төвшинг тодорхойлох зорилгоор 300 сэтгүүлчдийн дунд санал асуулгын судалгаа хийж, үр дүнг тухай бүр танилцуулсан болно. АТГ-ын дэмжлэгтэйгээр сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар тогтмол хэвлэл болон цахим хэвлэл мэдээллийн мониторинг хийж, санал асуулгын судалгааны үр дүнтэй нэгтгэсэн тайланг бэлтгэв. (Биелэлт 70 хувь)

4.1.8.3-1. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ 2017-2019/

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Авлигатай тэмцэх газар, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл хамтран зохион байгуулж, сэтгүүлзүй, хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага, редакц, сэтгүүлчдийн 150 орчим төлөөлөл оролцож, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас танилцуулсан хуулийн төслийг хэлэлцэж санал өгсөн. Хуулийн төсөл нь боловсруулалтын шатанд байгаа бөгөөд төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагын хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, редакцын талаарх мэдээлэл олон нийтэд ил тод байх зэрэг олон шаардлагууд тусгалаа олсон болно. (Биелэлт 30 хувь)

4.1.8.3-2. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч, хөрөнгө оруулагчийг олон нийтэд мэдээлж байх үүргийг хуульчлах, уг үүргийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /МСНЭ, ХМЗ 2020-2022/

2019 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна. Энэхүү хуулиар Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор

өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгах асуудлыг зохицуулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалт, эзэмшиж байгаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нэр, төрөл, тоо, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад хуулийн этгээдэд эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, хэрэв нөхөрлөл бол оруулсан эд хөрөнгийн хэмжээ зэргийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхээр заасан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшлийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээдэг бөгөөд эзэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авахаар хуульд тусгасан.

Монголын хэвлэлийн хүрээлэнгээс хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн талаар судалгааг зохион байгуулсан. Тухайлбал, 40 гаруй хэвлэл мэдээллийг оролцуулсан судалгаа хийхэд хэвлэл мэдээллийн байгууллагын 80 гаруй хувь нь улс төрчдийн болон эдийн засаг, бизнесийн нөлөө бүхий этгээдтэй хамааралтай байна гэсэн дүн гарсан.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газар боловсруулж байгаа бөгөөд төсөлд төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагын хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, редакцын талаарх мэдээлэл олон нийтэд ил тод байх шаардлагыг тусгасан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.8.4-1. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018-2022/

Хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан жил бүр асуудал хөндсөн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. 2019, 2020 онд “Хэвлэл мэдээлэл ба тав дахь засаглал”, «Хэвлэлийн Эрх чөлөө-Иргэдийн Эрх чөлөө» сэдэвт хэлэлцүүлгүүд, 2021 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс 24 салбар зөвлөлийн нийт 100 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг оролцуулан “Орон нутгийн хэвлэл мэдээллийн III форум”-ыг, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумыг цахимаар тус тус зохион байгуулж, монгол дахь хэвлэлийн эрх чөлөөг хадгалж, баталгаажуулах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад тулгарч буй асуудал, өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага, сэтгүүлчдийн итгэл үнэмшил, үүрэг, хариуцлага, эрх зүй зэрэг асуудлуудыг хэлэлцэв.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Сэтгүүл зүйн ёс зүйн форум (JEF)-ыг 2017 онд “Хэвлэл мэдээллийн эрх зүйн болон өөрийн зохицуулалт”, 2018 онд “Мэргэжлийн сэтгүүл зүй ба дижитал эрин үе”, 2019 онд “Хэвлэлийн эрх чөлөө – Дижитал хувьсал”, 2022 онд “Ковид 19- Мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй”, 2023 онд “Ёс зүйн үнэ цэн: Итгэлийг олж авч, эрх чөлөөгөө хадгалах нь” сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулж, 600 гаруй сэтгүүлч, редактор, хуульч, хүний эрх хамгаалагчдыг хамруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, сахилга батыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил хийж болох бизнесийн салбар болон талбарт төр бизнес эрхэлж өрсөлдөхгүй байх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, тус хуулийн төслийг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022

оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 9-д “Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана” хэмээн зааснаар далд сурталчилгаа, төлбөрт мэдээллийг сэтгүүл зүйн бүтээлээс ялгаж хэвшүүлж байна. (Биелэлт 0 хувь)

4.1.8.4-2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэвлэл мэдээллийн байгууллагаар хийлгэсэн сурталчилгаа нийтлэл нэвтрүүлэгт зарцуулсан хөрөнгө, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй хамтран ажиллах чиглэлээр байгуулсан гэрээг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх /ХЗДХЯ, МСНЭ 2019/

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/39 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд Ажлын хэсэг хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийсэн. Хуулийн төсөлд мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой заалтуудыг тусган, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан танилцуулсан. Шилэн дансны тухай хуулийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д мэдээ, мэдээллийг байршуулан мэдээлдэг. (Биелэлт 0 хувь).

4.1.8.5-1. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг редакци, сэтгүүлчдэд мөрдүүлэх, таниулан сургах, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах /Хэвлэл мэдээллийн зөвлөл 2017-2019/

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, радио, телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж, дүгнэлтээ

гаргаж, үйл ажиллагаа хэвшиж байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүл зүйн ёс зүйн форум (JEF)-ыг 2017 онд “Хэвлэл мэдээллийн эрх зүйн болон өөрийн зохицуулалт”, 2018 онд “Мэргэжлийн сэтгүүл зүй ба дижитал эрин үе”, 2019 онд “Хэвлэлийн эрх чөлөө-Дижитал хувьсал”, 2022 онд “Ковид 19- Мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй”, 2023 онд “Ёс зүйн үнэ цэн: Итгэлийг олж авч, эрх чөлөөгөө хадгалах нь” сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулж, 600 гаруй сэтгүүлч, редактор, хуульч, хүний эрх хамгаалагчдыг хамруулав.

Хэвлэл мэдээллийн бодлого цуврал дугуй ширээний ярилцлагыг нийт 7 удаа зохион байгууллаа. Энэ хүрээнд “Зөрчлийн хууль ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, “Цахим орчин дахь үзэн ядалтын үг хэллэг, “Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль”, “Сонгуулийн тухай хууль ба хэвлэл мэдээлэл”, “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн зохицуулалт ба ёс зүй”, “Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт, “Геополитик ба хэвлэл мэдээлэл” сэдвүүдээр хөндөн оролцогч талуудыг урьж оролцуулав.

ХМЗ-өөс редакторуудын зөвлөлдөх уулзалтыг 2020 оноос санаачлан тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал, “Цар тахлын үеийн редакцын бодлого ба өөрийн зохицуулалт”, “Бүх нийтийн бэлэн байдлын үед сэтгүүл зүйд тулгарч буй асуудлууд”, “Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөө ба ёс зүй”, “Ковид-19 дархлаажуулалт ба хэвлэл мэдээллийн редакторуудын оролцоо”, “Дайн, зэвсэгт мөргөлдөөний үеийн сэтгүүл зүйн ёс зүй”, “Мэдрэмжтэй мэдээлье: олон улсын хэвлэл мэдээлэлтэй түншлэх боломж”, “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх нь” зэрэг сэдвээр сэтгүүл зүйн чанар, хэвлэлийн эрх чөлөөнд тулгарч буй асуудлууд, түүнийг шийдэх арга замуудын талаар санал солилцсон хэвлэл мэдээллийн ерөнхий редакторуудтай зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах, иргэний мэдэх эрх, хэвлэлийн эрх чөлөөнд хамаарах хуулийн төслүүдэд санал өгөх уулзалтыг 2021 оноос тогтмол хийж байна. Үүнд: “Эрүүгийн хуулийн 13.14 Худал мэдээлэл тараах заалтын талаар” УЗ-ийн гишүүдийн цахим уулзалт, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд

өгөх санал” УЗ-ийн гишүүдийн уулзалт, “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, цаг үеийн асуудлууд” сэдэвт орон нутгийн сэтгүүлчдийн хэлэлцүүлэг, “Улс төрд нөлөө бүхий этгээд сэтгүүлчдэд гомдож болох уу буюу Эрүүгийн хуулийн 13.14 дэх заалтын эргэн тойронд” цахим хэлэлцүүлэг, “Мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх” цахим хэлэлцүүлэг, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн явц” эвсэл холбоодын өглөөний бизнес уулзалт, “Шүгэл үлээгчийн тухай хуулийн төсөлд өгөх санал” эвсэл холбоодын өглөөний бизнес уулзалт, “Нийтийн мэдээллийн хуулийн төсөлд өгөх санал” эвсэл, холбоодын өглөөний бизнес уулзалтуудыг хийсэн.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг бэхжиж байна. 2015 оны дөрөвдүгээр сараас 2022 оны арванхоёрдугаар сарын байдлаар тус зөвлөлд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 522 өргөдөл гомдол ирүүлснийг Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015-2022 онд нийт 522 өргөдөл, гомдол хүлээн авч, Ёс зүйн хороодын 56 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлээд байна. Хэвлэл мэдээллийн зөвлөл нийт хүлээн авсан гомдлынхоо 70 орчим хувийг Ёс зүйн хороодоороо хэлэлцүүлэн шийдвэрлэсэн бол 30 хувийг тус зөвлөлийн Гомдол хүлээн авах, барагдуулах журмын хүрээнд ажлын алба шийдвэрлэсэн. Ёс зүйн хороодын дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын “Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно”, “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”, “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ” гэсэн заалтуудыг зөрчжээ.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэн чадавхжуулахад онцгой анхаарч Ёс зүйн хорооны гишүүдийг олон улсын болон дотоодын мэргэжилтнүүдтэй сургалтуудад тогтмол хамруулж Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүх гишүүдийг чадавхжуулах 15 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд цахим болон хэвлэмэл танилцуулгыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээгээр идэвхтэй түгээв. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд түгээж байна. Мөн өөрийн нийгмийн сүлжээний хуудсуудаар дамжуулан ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах уриалга бүхий мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд Ёс зүйн асуудал яагаад чухал вэ? хэмээх сэдвээр видео контентууд, “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” гарын авлагыг гаргаж, хэвлэмэл (1000 хувь) болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээв. Гарын авлагын агуулгад Чөлөөт, хараат бус хэвлэл, Мэдэх эрх ба өөрийн зохицуулалт, Сэтгүүлчийн ёс зүй, Хүний эрх ба хэвлэл мэдээлэл, Зөрчигдсэн эрхээ сэргээх нь, Иргэний гомдлыг барагдуулах нь зэрэг сэдвүүд багтсан болно. (Биелэлт 70 хувь)

Ес. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9 дэх зорилтын хүрээнд нийт 8 үйл ажиллагаа, 17 арга хэмжээг тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.9.1-1. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод мэдээлэх, мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх чиглэлээр хууль тогтоомжид байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх / Сонгуулийн ерөнхий хороо, 2018-2019/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиудад холбогдох зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, Сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг төрийн аудитын дээд байгууллагаас тогтоож нийтэд мэдээлдэг. Төрийн аудитын дээд байгууллагаас зардлын дээд хэмжээ тогтоосон аргачлал буюу хэрхэн тооцож дээд хэмжээг тогтоох асуудлыг тодорхой болгосон. Тухайлбал, Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан байна. Тухайлбал, Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэхээр тусгасан. Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах болон сонгуулийн зардлыг бууруулахад чиглэгдсэн үр дүнтэй зохицуулалтуудыг холбогдох хуульд тусгасан (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин

ашиглах).

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуульд оролцсон нэр дэвшигч, нам эвслийн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны “УИХ сонгууль”/ “зардал” цэсэд 2008, 2012, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг байршуулан, нээлттэй мэдээлсэн. Мөн цахим хуудсыг шинэчилж, “Улсын Их Хурлын сонгууль 2020 “цэсийн “сонгуулийн зардал” цэсэд Сонгуульд оролцсон нам, эвслийн Улсын Их Хурлын сонгуулийн зардал, санхүүжилт, тайланг нээлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсаар олон нийтэд нээлттэй байршуулж, Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуульд оролцогчдод хандсан зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хуулиар чиг үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахаас гадна гадаадын болон дотоодын төрийн бус байгууллага хяналт шинжилгээ, мониторинг хийж, үр дүнгээ нийтэд танилцуулах нь сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой байдаг. Иймд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.13-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.” гэж хуульчлагдсан.

Улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаа, нэн ялангуяа сонгуулийн бус үеийн санхүүжилт, түүний ил тод байдлыг зохицуулсан хууль тогтоомж шинэчлэгдээгүй байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт. Улс төрийн намын санхүүжилтийн талаар зохицуулалтыг хуульчилсан бөгөөд 20 дугаар зүйлийн 20.3-т “Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй, мөн зохицуулалт нь хэт ерөнхий, аудит, хяналт шалгалт хийх тогтолцоо нь тодорхойгүй, олон

улсын стандартаас хол зөрүүтэй хэвээр байгааг олон улсын болон дотоодын судалгаануудад²⁷ дурдагдсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т зааснаар эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй иргэн төрийн жинхэнэ албанд томилогдох ёстой. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж хуульчилсан. Энэ жишгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж заасан.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн 17.1-д Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчлийн төрлүүдийг тодорхой хуульчилсан. 17.1 дэх хэсгийн 21-27 дугаар зүйлд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах, хандив өгөх, авах, шилжүүлэх, сонгуулийн явцын болон эцсийн тайланг гаргах хугацаа, журам, сонгуулийн зардлын данс ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагыг анх удаа тодорхойлон хуульчилсан. 2021 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны хувьд тайлан гаргаагүй нэр дэвшигчдийн талаарх холбогдох мэдээллийг 21 аймаг, нийслэлийн дүүргийн татварын хэлтэст зөвхөн тухайн шатны прокурорын зөвшөөрснөөр мэдээлэл өгсөн. СЕХ Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож тайлангаа нийтэд мэдээлээгүй, тайланг дутуу гаргаж өгсөн болон тайлан гаргаж өгөөгүй нийт 138 нэр дэвшигчид холбогдох зөрчилд аймаг, дүүргийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч зөрчил шалган

27 OECD. Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ. Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл. Стамбулын авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн тайлан. 2019 он, 132-133 дахь тал.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Нээлттэй нийгэм форум. Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: дүн шинжилгээ, санал зөвлөмж, 2018 он, 11, 18 дахь тал.

шийдвэрлэх ажиллагаа явуулж нийт 630000000 төгрөгийн торгууль оногдуулсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.9.1-2. Сонгуулийн зардлын тайлангийн хяналт, ил тод байдал, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох /Хууль зүй, дотоод хэргийн яам, 2018-2020/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан. Мөн холбогдох үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт тодорхойлон, тус хуульд 2019 онд нэмэлт оруулж, 2020 онд өөрчлөн найруулсан байна (Зөрчлийн тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйл). Уг хуульд хариуцлагын арга хэмжээг торгуулийн хэлбэрээр тодорхойлж өгчээ. Өмнөх Сонгуулийн тухай хууль (2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон)-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй” гэж заасан зохицуулалт шинэ хуульд тусгагдаагүй байгааг анхаарах, мөн сонгуулиас бусад үеийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтын асуудал Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд хамаарахгүй байгааг эргэж харах шаардлагатай.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 21 дүгээрт Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж байна. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгаж өгсөн:

Сонгуулиас бусад үеийн улс төрийн намын санхүүжилттэй холбоотой олон улсын жишгийг нэвтрүүлж буй нэг зохицуулалт намууд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа жилд хоёр удаа Сонгуулийн төв байгууллагад хүргүүлж олон нийтэд ил тод мэдээлэхээр төсөлд тусгасан. Намын тайланд оруулах мэдээлэл,

тайлангийн заалт бүрийг төсөлд нарийвчлан оруулж байна. Намууд тухайн тайлант хугацаанд дурдах бүх санхүүгийн орлого зарлагын зарцуулалтыг аудит хийлгэж Сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх, үүний дараа Сонгуулийн төв байгууллага тухайн намуудын санхүүгийн тайланд дахин аудит хийхээр төсөлд тусгасан.

Санхүүжилттэй холбоотой намд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн, тухайлбал, тайлангаа буруу мэдээлсэн, хуулиар хориглосон ямар нэг эх үүсвэрээс санхүүжилт авах, намын дотоод сонгууль намаас дэвших үйл явцад нэг дэвшигчдээс болон хувь хүнээс хуульд заагаагүй хэмжээний мөнгөн хандив авах, нэр дэвшигчээс дэнчин шаардах зэрэг санхүүгийн хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд төсвийг хязгаарлах буюу зогсоох арга хэмжээ авна. Тухайлбал тухайн улс төрийн нам санхүүжилтийн тайланг удаа дараа буюу хоёр ба түүнээс дээш удаа хугацаандаа өгөөгүй, тухайн улс төрийн нам санхүүжилтийн тайланг удаа дараа буюу хоёр ба түүнээс дээш удаа хугацаандаа дэвшигчдээс болон хувь хүнээс хуульд заагаагүй хэмжээний мөнгөн хандив авах, нэр дэвшигчээс дэнчин шаардах зэрэг санхүүгийн хууль зөрчилтэй, санаатай, илт худал мэдүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт орсон. Улс төрийн намууд жил бүрийн тайланг олон нийтэд нээлттэй ил тод байршуулна. Мөн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн дагуу зориулалт, үйл ажиллагааны тайланг тусад нь гаргаж өгнө. Тухайлбал, намын хандив гэх зэрэг санхүүжилттэй холбоотой тодорхой асуудлыг илрүүлэх, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдээс хандив авсан эсэхийг ил тод харах боломж бүрдэх юм. (Биелэлт 70 хувь)

4.1.9.2-1. Улс төрийн намуудад төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлыг тайлагнах, ил тод мэдээлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх /ХЗДХЯ, 2017-2019/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг цахим хуудаст ил тод байршуулж, тайлан гаргаагүй нэр дэвшигчид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулах ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч явуулахаар хуульд тусгасан.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд тайлан гаргаагүй нэр дэвшигчдийн талаарх холбогдох мэдээллийг 21 аймаг, нийслэлийн дүүргийн татварын хэлтэст зөвхөн тухайн шатны прокурорын зөвшөөрлөөр 24 удаагийн албан бичгээр нийт 185 нэр дэвшигчийн мэдээлэл өгч хамтран ажиллав.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчлийн төрлүүдийг тодорхой хуульчилсан. 17.1 дэх хэсгийн 21-27 дугаар зүйлд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах, хандив өгөх, авах, шилжүүлэх, сонгуулийн явцын болон эцсийн тайланг гаргах хугацаа, журам, сонгуулийн зардлын данс ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлагыг тодорхойлон хуульчилсан. Улс төрийн намын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина" гэж, 20.3-т "Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ" гэж тус тус заасан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөлд улс төрийн намуудын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, шилэн байх, нийтэд мэдээлэх өөрчлөлтийг хуулийн төсөлд тусган төрийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, судалгааны байгууллагууд хамтран ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.2-2. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх / Хууль зүй, дотоод хэргийн яам, 2018-2022/

Нэр дэвшигчдийн сонгуулийн явцын тайлан нь сонгогч сонголтоо хийхээс өмнө тухайн нэр дэвшигч ямар зардал, хөрөнгөөр сонгуульд нэр дэвшиж байгаа талаарх мэдээллийг нээлттэй авсны үндсэн дээр сонголтоо хийх боломжийг олгодог ач холбогдолтой зохицуулалт юм. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т "Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 26.3.6, 26.4.6, 38.5-д заасан мэдээллийг дүгнэлт гаргаж дууссан өдрөөс эхлэн, 58.4-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим

хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгоно.” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар холбогдох мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй мэдээлж ажилласан.

Сонгуулийн бус үед улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох нөхцөлийг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Тухайлбал, төсөлд намын санхүүгийн тайлан гаргах, тухайн санхүүгийн тайланд сонгуулийн төв байгууллагаас сонгон шалгаруулсан жагсаалтад орсон аудитын байгууллагаар хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулж, Шилэн дансны хуульд заасны дагуу мэдээлж байх зохицуулалт тусгагдсан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.9.3-1. Парламентад суудалгүй намуудад төрөөс олгох санхүүжилтийг хүртээмжтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх / Сонгуулийн ерөнхий хороо, 2017-2019/

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд сонгуулийн санхүүжилт, улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй, ил тод байлгахад чиглэгдсэн судалгаануудын үр дүн болон эрдэмтэн, судлаачдын саналыг хуулийн төсөлд тусгах талаар хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Дээрх хуулийн төсөлд улс төрийн намуудын гарааны тэгш өрсөлдөөнийг дэмжих үүднээс УИХ-д суудал аваагүй ч гэсэн сонгогчдын тодорхой хувийн дэмжлэг авсан намуудад төсвөөс хэсэгчилсэн санхүүжилт олгохоор зааж өгсөн. Намууд төсвөөс олгож буй санхүүжилтийг гишүүд, дэмжигчдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангах, намын дэргэдэх бодлогын судалгаанд зарцуулахаар хуулийн төсөлд тусгасан. (Биелэлт 0 хувь)

4.1.9.3-2. Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох /СЕХ, 2017-2022/

Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн

намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох чиглэлээр бусад улс орны туршлагын талаарх харьцуулсан судалгаа, шинжилгээ хийсэн. Мөн Улс төрийн намын тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан засаг, хүний эрхийн газрын дарга, экспертүүдтэй уулзалт зохион байгуулж ЕАБХАБ-аас Улс төрийн намын тухай хуулийн төсөлд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл болон Улс төрийн намын тухай хуулийн төсөлд ирүүлсэн санал, зөвлөмжүүдийг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, судлаачдын төлөөллийг оролцуулан “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль-Сонгуулийн санхүүжилт” хэлэлцүүлгийг 2019.12.25-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг ажлын хэсэгт хүргүүлсэн.(Биелэлт 70 хувь)

4.1.9.4-1. Сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох /Сонгуулийн ерөнхий хороо, 2018-2019/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр тус тус Улсын Их Хурлаас баталсан.

Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод нээлттэй болгох, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгасан. Тухайлбал:

- Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст

байршуулна.

- Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
- Нэр дэвшигч, нам, эвсэл нь авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
- Төрийн аудитын дээд байгууллага хуульд заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн мөрийн хөтөлбөр, зардлын талаарх хуульд заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, чөлөөтэй танилцах бололцоо олгоно. зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй шинэлэг зохицуулалтууд орсон. (Биелэлт 100 хувь)

4.1.9.4-2. Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ, 2018-2019/

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгаж өгсөн. Тухайлбал, Арванесдүгээр зүйлийн 19^{1.3}-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалтыг нэмж тусгасан. Уг заалтын агуулгад нийцүүлэн органик хуулиудыг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд Улс төрийн намын

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгийг УИХ-аас байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн улс төрийн намуудыг хариуцлагажуулах, үйл ажиллагаа нь хууль дээдлэх зарчимд суурилсан байх, тэдгээрийн хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр хуулийн төсөлд зарчмын өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгаж, төслийг боловсруулсан. 2021 онд Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ухааны салбарын судалгааны баг “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” судалгааг явуулж, санал, зөвлөмж гаргасан. (Биелэлт 0 хувь)

4.1.9.5-1. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах, УИХ-ын гишүүдийн шударга байдал, ёс зүйн дүрэм, шийдвэр гаргалтын үйл явцыг шинэчлэх, дагаж мөрдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох /Хууль зүй, дотоод хэргийн яам, 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг батлан мөрдүүлж байна. “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. УИХ-ын нэр бүхий гишүүд “Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.9.5-2. Оффшор бүсэд данс эзэмшдэг этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт тавих механизмыг бүрдүүлэх /Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, 2017-2019/

Улсын Их Хурал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 04 дүгээр сард, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 05 дугаар сард тус тус баталсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.3}-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244, 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны 91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэл”-ийн маягт»-ыг баталсан. Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт мэдүүлж, мэдэгдэж бүртгүүлсэн болно. Дээрх хуулийн хэрэгжилт болон хуулийн хугацаанд үүргээ биелүүлж мэдэгдсэн албан тушаалтнуудын талаарх мэдээллийг тус газрын цахим сайтад байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Оффшор бүсэд хамаарах хориглолтын талаар яам, агентлаг, аймаг, нийслэл болон холбогдох албан тушаалтнуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгч, хуулийг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралтын “Оффшор бүсэд хамаарах

гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт” гэснийг “Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, нутаг дэвсгэрийн жагсаалт” гэж өөрчилж, шинэчлэн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар тогтоолоор баталсан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.5-3. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх / Хууль зүй, дотоод хэргийн яам, 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2-т “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол төрийн албанаас халах” зохицуулалтыг, Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.1.6-д “гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэл” байхаар, 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” бол, мөн зүйлийн 9.1.2-т “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан бол” тус тус Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр тусгасан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.6-1. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх / Авлигатай тэмцэх газар, 2017-2018/

Улс төрийн бүх намын удирдлагуудаас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хуулийн зохицуулалт байхгүй тул Улсын Их Хуралд суудалтай намуудын удирдлага болон гишүүд ХАСХОМ гаргах албан тушаалтнаар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргаж байна. Мөн холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалгаа хийж байна. Энэ хүрээнд, Улс төрийн намын болон сонгуулийн

үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар 2017, 2018, 2019 онуудад Авлигын эсрэг “Шилэн нам” авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын түншлэл, “Транспэрэнси интернэшнл-Монгол”, Авлигатай тэмцэх газар (АТГ) хамтран Европын холбооны дэмжлэгтэйгээр “Улс төрийн намын тухай хуулийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замууд”, “Шилэн нам” санаачилгатай хамтран “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, авлигын эрсдэлээс сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь” хэлэлцүүлгийг, 2019 оны 11 дүгээр сард МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо хамтран зохион байгуулсан “Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зэрэг хэлэлцүүлэг зохион байгуулж судлаачид, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл тус тус оролцсон. Эдгээр хэлэлцүүлгүүдээр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтууд, олон улсын бусад стандарт, сайн туршлагыг хэрхэн тусгах, шийдэл арга замын талаар талаар хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээлэл солилцож, хуулийн төсөлд тусгуулах талаар ажлын хэсэгт санал хүргүүлсэн. 2020 онд Үндэсний аудитын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо болон ТББ-ууд хамтран “Улс төрийн санхүүжилтийн хяналтын тогтолцоо олон улсын туршлага” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох санал, дүгнэлтийг гаргасан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна. Уг төслийн 5 дугаар хавсралтаар “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг боловсруулав. Уг жагсаалтад авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл бүхий албан тушаалтан тухайлбал, улс төрийн намын удирдах албан тушаалтныг мэдүүлэг гаргуулдаг байхаар төсөлд тусгасан.

Авлигын эсрэг хуулийн дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол сануулах, цалин бууруулах, албан тушаал бууруулах, албан тушаалаас огцруулах буюу ажлаас халах хариуцлагыг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай. Хэдий тийм ч, улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтнуудын хувьд дээрх хариуцлагыг хүлээлгэх бодит боломж хязгаарлагдмал байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.6-2. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын талаар олон нийтэд мэдээлэх /АТГ, 2018-2022/

Улсын Их Хуралд суудалтай Монгол Ардын Намын дарга, Ардчилсан намын дарга нарын ХАСХОМ-ийн мэдээллийг Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор 2018, 2019, 2020 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын <http://www.hasxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.

2021 онд явагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч 3 хүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг <https://meduuleg.iaac.mn/> цахим системд бүртгэх, хүлээн авах, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран хэрэгжүүллээ.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу жил бүр нийт мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын ХОМ-ийг хураангуй байдлаар тус газрын олон нийтийн сүлжээгээр танилцуулж хэвшсэн бөгөөд үүнд УИХ-д суудалтай улс төрийн намын дарга, удирдлагууд эрхэлж байгаа буй албан тушаалтныхаа хувьд АТГ-т уг мэдүүлгийг хуулийн хугацаанд бүртгүүлдэг. Тухайлбал, УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтнууд буюу АТГ-т мэдүүлгээ шинэчлэн бүртгүүлсэн дүнг танилцуулбал: 2019 оны ХАСХОМ-ийг 282, 2020 оныг ХАСХОМ-

ийг 283, 2021 оны ХАСХОМ-ийг 311, 2022 оны ХАСХОМ-ийг 336 албан тушаалтан тус тус мэдүүлсэн байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.7-1. Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэний оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2019 онд өргөн мэдүүлсэн бөгөөд Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу уг хуулийн төслийг Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болгон боловсруулаад байна. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд оролцох, хяналт тавих шаардлага гаргах эрхтэй” гэж, 5.4-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу олж авах, түгээх, өөрийн байр сууриа илэрхийлэх эрхтэй.” гэж, 5.5-д “Холбоо нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор холбогдох эрх бүхий этгээдэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэж тус тус тусгаад байна. Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбоо, сан нь улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулах; улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид хандив өгөх, дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой хязгаарлалтуудыг хийсэн бөгөөд иргэний нийгмийн байгууллагын хувьд жагсаал цуглаан хийх эрх нээлттэй байх юм.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нийтийн мэдээллийн ангиллыг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан бөгөөд нээлттэй мэдээллийн хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1-д “олон

нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал”-ыг нээлттэй байршуулахаар болсон. (Биелэлт 70 хувь).

4.1.9.8-1. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

ТББ нь аж ахуйн үйл ажиллагаа болон төрийн зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр явуулж болохоор заасан боловч аж ахуйн үйл ажиллагааг явуулах нөхцөл, шаардлага, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. ТББ-ын хэлбэр, үйл ажиллагааны онцлогт тулгуурласан судалгаа мэдээллийн цогц тогтолцоогүй тул иргэний нийгмийн, тэр дундаа төрийн бус байгууллагын хөгжилд оруулж буй эдийн засгийн болон бусад хувь нэмрийг ойлгох, тодорхойлох, үнэлэх боломжгүй, хангалттай мэдээллийн сан, статистик мэдээллийн тогтолцоо бүрдэхгүй байна. Иймд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн боловсруулах ажилд олон улсын туршлагыг судалж, олон төрлийн судалгаануудыг хийсэн. Төрөөс иргэний нийгмийн хөгжлийг дэмжих суурь тогтолцоог бүрдүүлэх зорилгоор иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлаар төртэй харилцах, зөвшилцөх, холбон ажиллах чиг үүрэг бүхий “Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл”-ийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоож өгснөөр иргэний нийгмийн хөгжил, чадавхыг дэмжих хөгжүүлэх, дотоод засаглал, ёс зүйн жишгийг тогтоож хөгжүүлэх, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтлэг хөгжлийн асуудлаар төр болон олон улсын байгууллагуудтай харилцах, нийгэмд үйлчилдэг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн болон нийтэд тустай үйл ажиллагааны үр нөлөөг нэгтгэх, тэдгээрийг татварын хөнгөлөлт,

чөлөөлөлт болон бусад дэмжлэгт хамруулахтай холбоотой санал, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байх зохицуулалтыг тусгасан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.8-2. Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох тогтолцоо бий болгох, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг хуульчлан тогтоох /ХЗДХЯ, 2017-2020/

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн батлагдсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан. Засгийн газрын 2018 оны 105 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл” байгуулагдсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд 2020 онд “Эрх зүйн хөтөч” бэлтгэх сургалтыг аймгуудын Засаг даргын Тамгын газартай хамтран цахимаар зохион байгуулж, Завхан аймагт 31, Дорнод аймагт 26, Сүхбаатар аймагт 53 иргэнийг эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн. Нээлттэй нийгэм форумын бэлтгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 150 тусгай сургагч багшид эрх зүйн хөтчийн гэрчилгээ олгосон. Хууль зүй, дотоод хэргийн яам болон Харьяа агентлаг, байгууллагууд МҮОНРТ-тэй хамтран долоо хоног бүрийн даваа гаригт “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэг, “Иргэдийн эрх зүйн боловсролд” шууд нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн. Харьяа агентлаг, байгууллагууд өөрийн байгууллагын веб сайт, пэйж хуудас, нийгмийн сүлжээгээр дамжуулан цаг үе, үйл явдалтай холбоотой энгийн болон эерэг нийт фото мэдээ, цагаан мэдээ, ярилцлага, нийтлэл, сурвалжлага, нэвтрүүлэг, видео, зурагт хуудас /инфографик/, подкаст зэргийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.9.8-3. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад сайн дураараа оролцож байгаа иргэн, иргэний нийгмийн байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлэх /СЯ, ХЗДХЯ, 2018-2022/

Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын

Их Хуралд 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлж, хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсэн. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд оролцох, хяналт тавих шаардлага гаргах эрхтэй” гэж, 5.4-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу олж авах, түгээх, өөрийн байр сууриа илэрхийлэх эрхтэй.” гэж, 5.5-д “Холбоо нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор холбогдох эрх бүхий этгээдэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэж тус тус заасан болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасны дагуу холбогдох төслийг боловсруулж, олон нийтээс санал авахаар хэлэлцэх шатанд байна. Тус төслийг боловсруулахад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулахад төвлөрлийг сааруулж, зөвлөл болон салбар зөвлөлөөс олгох, зохион байгуулсан ажил, арга хэмжээг тодорхой шалгуурын дагуу бодитой үнэлэх, үр дүнг тооцож урамшуулахад чиглэсэн хэлбэрт шилжих нь зүйтэй гэж үзсэн. Журмын төслийг <https://mojha.gov.mn/newmojha/> цахим хуудсанд байршуулж олон нийтээр хэлэлцүүлж, холбогдох саналыг тусгаж байна.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хуулийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг УИХ-аас хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийтийн ашиг сонирхол, сайн сайхны төлөө, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг бичгээр болон цахимаар гаргах тухай асуудлыг тусгасан. Мөн энэ хуулиар шүгэл үлээгчийн

гаргасан нийтийн эрх ашгийн эсрэг үйлдлийн мэдээллийг холбогдох байгууллагууд шалгаад, учруулсан хор хохирлын хэмжээнээс нь шалтгаалж урамшуулна. Шүгэл үлээгч нь эрхээ хэрэгжүүлэхдээ өөрөө болон түүний хамаарал бүхий этгээд бусдын өш хонзон, ялгаварлан гадуурхалт зэрэг аливаа хэлбэрийн цээрлэлтүүдээс ангид байна гэж хуулийн төсөлд тусгасан. Мөн Гэрч, хохирогчийн тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийн адилаар төрийн хамгаалалтад байх боломжоор хангаж өгөх юм. (Биелэлт 0 хувь)

Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.10.1.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж байна. Авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2017 онд 11345, 2018 онд 14783, 2019 онд 25007, 2020 онд 13820, 2021 онд 59983 27645, 2022 онд 53183 нийт 145783 хүнийг сургалтад хамруулав. 2022 онд Авлигын эсрэг сургалтад хамрагдсан нийт хүний тоог 2021 оныхтой харьцуулан үзэхэд 1,9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Харин 2020 оноос цар тахлын улмаас улс орны хэмжээнд хатуу хөл хорио тогтоосон тул орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгууллаа. 2021 онд 134, 2022 онд 277 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтын үнэлгээг Google forms ашиглан авч, дүн шинжилгээ хийж ажиллав.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд Удирдлагын академи “Ёс зүй менежмент, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь”, “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага” зэрэг сэдвээр; мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг УИХ-ны Тамгын газраас УИХ-ын гишүүд, тэдний зөвлөх, туслахуудад;

Эрүүл мэндийн яам харьяа байгууллагууддаа; ГБХЗХГ салбарын хэмжээнд; Баянгол дүүргийн Татварын хэлтэс; Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид; Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнууддаа тус тус сургалт зохион байгуулжээ.

Авлигын эсрэг иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх аян, социал акцыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тэднийг оролцоог, идэвх санаачилгыг дэмжих ажлыг эрчимжүүлэх хүрээнд тодорхой ахицыг гаргав. Тухайлбал, 2020 онд соён гэгээрүүлэх аян, спорт өдөрлөг, хувийн хэвшлийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах санаачилга өрнүүлж, соён гэгээрүүлэх контент түгээлтийн 8 акц, 1 аяныг өрнүүлж, нийт соён гэгээрүүлэх 9 цогц арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, идэвх санаачилгыг дэмжиж, тэдний оролцоо, соён гэгээрүүлэх ажлын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг 2020 онд эхлүүлж, нийслэл, 21 аймаг, 330 сумыг хамруулан зохион байгуулсан бөгөөд тус аян нь хөдөө, орон нутгийн иргэдэд шударга ёсны талаарх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, авлигыг үл тэвчих үзэл санааг төлөвшүүлэх, арга хэмжээг сонирхлын олон бүлгүүдэд чиглүүлснээрээ онцлог байв. Зөвхөн аяны хүрээнд бус цаашид тогтмол явагдах олон төрлийн санал, санаачилгыг аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс гарган хэрэгжүүлснээрээ урьд өмнө хийгдэж байсан арга хэмжээнүүдээс чанар, хүртээмжийн хувьд ахиц гаргасан шинэлэг үйл ажиллагаа байв. Уг аяны хүрээнд аймгууд соён гэгээрүүлэх чиглэлийн 15 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, сурталчлан давхардсан тоогоор 2020 онд 1,063,456, 2021 онд 7,811,912 хүнд хүргэсэн байна. Энэ хүрээнд аймаг бүр онцлох ажил, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд тоймлон танилцуулбал, Дорноговь аймаг “Дорноговь авлигагүй хөгжинэ” уриалгыг дэвшүүлж уриалгад аймгийн хэмжээний удирдах албан тушаалтнууд нэгдсэн бол Дундговь, Говь-Сүмбэр аймгууд “Шинэ

үеийн залуус шударга ёсыг юу гэж ойлгодог вэ?” хэлэлцүүлэг өрнүүлж, Хэнтий аймаг “Авлигын эсрэг видео нэвтрүүлэг” хийж, Баянхонгор, Өмнөговь аймаг “Авлигагүй нийгмийн төлөө Хамтдаа”, Орхон аймаг “Соёлыг түгээе” нэг сарын аяныг өрнүүлсэн, Орхон аймаг ерөнхий боловсролын 5-6 дугаар ангийн сурагчдын дунд “Шударга ёс” видео бичлэгийн, гэрэл зураг сонирхогч залуусын дунд “Авлига ба хүний эрх” гэрэл зургийн уралдааныг зохион байгуулсан бол Баянхонгор аймаг Авто тээврийн төвтэй хамтран “Улаанбаатар-Баянхонгор”, “Баянхонгор-Улаанбаатар” чиглэлийн автобусанд зорчиж байгаа иргэдэд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг нэвтрүүлэг, контентуудыг түгээсэн. Түүнчлэн Дорнод аймаг нь 14 сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан чэлленж (давалгаа) өрнүүлэн “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аянд нэгдэхийг уриалсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн багш нар, сурагчид, цэцэрлэгийн багш нар, хүүхдүүд Шударга Монголын төлөө #Dance-chance бүжгийн челленжид хамгийн идэвхтэй оролцсон зэргээс үзэхэд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажил үр дүнтэй, бусдад үлгэр дуурайлал болохуйц онцлох ажил байв. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд 21 аймгаас ирүүлсэн тоон мэдээгээр 2020 онд 43.596, 2021 онд 88.094 хүнд мэдээллийн хуудас, нугалбар зэрэг хэвлэмэл материал түгээж мэдээлэл хүргэжээ.

“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулган, “Ковид ба авлига: Иргэдийн чөлөөт индэр” цахим хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулав. Мөн аяны хүрээнд хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн видео контент “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё”, “Зөв зөвд шударга зөв” #шударга тоглоцгооё бүжгийн челленж аяныг өрнүүлэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдэд цахим хэлбэрээр 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэг, 21 аймгийн 552 сургууль, 699 цэцэрлэгийн 560,000 сургуулийн багш, ажилтан, сурагч, эцэг эхийг нэгтгэж, өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлсэн бичлэгүүдийг социалд түгээн сурталчилжээ. Аяны хүрээнд

контент бүтээж, түгээх явцыг дэмжиж, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж, арга зүйн зөвлөгөө өгч боловсролын байгууллагын багш, ажилтнуудыг контент түгээх дэд бүтцийг нэгтгэх зорилгоор “Зөв Зөвд Шударга Зөв” фейсбүүк группийг үүсгэж, “Авлигын эсрэг сургагч багш” зэрэг групп, пэйж хуудсаар мэдээлэл түгээн аяныг идэвхжүүлэв. “Зөв зөвд шударга зөв” аяны баннер бүхий зурагт хуудсыг автобусны буудлын 46 гэрэлт самбар, төв зам дагуух явган 80 самбар, мөн 10 байршилд сурталчилгааны том самбарт байршуулан, 9 төрлийн видео шторкийг авто замын уулзвар дахь 7 лед дэлгэцээр өдрийн 80-150 удаагийн давтамжтайгаар цацаж сурталчлав.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилгоор “Үнэгүй фитнес” Төрийн бус байгууллагатай хамтран “Эрүүл бие-Эрүүл нийгэм” спортоор дамжуулан иргэдийн хандлагыг өөрчлөх, шударга байдлыг сурталчлах акцыг зохион байгуулсан. Энэ хүрээнд “Амьдралын хэв маягаа өөрчилъе» урианы доор 2020 онд “Let’s change” соён гэгээрүүлэх спорт өдөрлөгийг Үндэсний соёл, амралтын хүрээлэнд зохион байгуулсан. Энэхүү соён гэгээрүүлэх арга хэмжээг иргэдэд сонирхолтой байдлаар мэдээлэл хүргэх арга хэлбэрийг туршиж, өртөөчилсөн уралдаан тэмцээнээр дамжуулан иргэдэд авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, авлигын эсрэг иргэний оролцоо, боломжийг ухуулан таниулах ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, цахимаар шууд дамжуулалт (25,826 хүн үзсэн) хийсэн.

Бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн санаачилгаар авлига болон түүнийг тойрон тэлсээр буй хууль бус, ёс зүйгүй, авлигыг өөгшүүлсэн зохисгүй хандлагыг өөрчлөх, хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулж, шударга, нийгмийн хариуцлагатай бизнесийг төлөвшүүлэхэд уриалах, авлигын эсрэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дотоод хяналтын тогтолцоог дэмжих зорилго бүхий “Шударга ёс хөгжил дэвшилд-хувийн хэвшлийн оролцоо” санаачилгыг эхлүүлэв. Уг санаачилгад нэгдэж, ёс зүйтэй, авлигаас ангид бизнес эрхлэгчдийн

дуу хоолой, хамтын ажиллагааг нэгтгэх зорилгоор Хан Уул дүүргийн “Авлигагүй дүүрэг” уриалга гаргасантай уялдуулан тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 150 аж ахуйн нэгжид хамтран ажиллах саналыг хүрүүлж аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж буй 40 төрлийн бүтээгдэхүүн болон бараа түгээлтийн машины гадна талд, мөн орон нутгийн зоригчийн тасалбар дээр 110 утасны дугаарын сурталчилгааг тус тус байршуулан олон нийтэд хүргэв. АТГ-т гомдол, мэдээлэл хэрхэн гаргах тухай танилцуулга нугалбарыг зарим үйлчилгээний байгууллагуудын өрөө тасалгаанд байршуулаж, түгээв.

“АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийн 17 дугаарыг 2020 онд, 24 дугаарыг 2021 онд, 24 дугаарыг 2022 онд тус тус бэлтгэн МҮОНТ-ээр, 2021 оноос МҮОНТ, Монголын мэдээ, UBS, Малчин, орон нутгийн телевизүүдээр үзэгчдийн хүртээл болгов. Мөн тус нэвтрүүлгийг “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсанд байршуулсан бөгөөд 2021 онд нийт үзэлтийн тоо 133700 хүрсэн байна. 2022 онд бэлтгэсэн 24 нэвтрүүлгийн нэг нэвтрүүлгийг дундажлан үзэхэд тогтмол 5,000 хүн байгууллагын пэйж хуудсуудаар үзэж, 120,000 хүн нэвтрүүлгийг сонирхсон байна. Авлигатай тэмцэх газрын “iaac.mn” инстаграм хаягт 2022 онд нийт 21 нийтлэл оруулж, өдөр тутмын ажлын 113 түүх оруулсан нь 1130 хүнд хүрсэн байна. Техник, технологи хурдацтай хөгжиж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийн хүртээмж нэмэгдэж байгаатай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас өдөр тутам болж буй онцлох үйл явдлуудыг бичмэл мэдээ байдлаар мэдээлэхээс гадна 2020 оноос 20 секундын англи орчуулгатай бэлтгэж, Авлигатай тэмцэх газар, АТГ-Олон нийтийн төв пэйж хуудсаар стори мэдээ болгон хүргэж байна. 2022 онд 65 стори мэдээ бэлтгэн олон нийтийн хүртээл болгов.

Авлигатай тэмцэх газар 2020 онд авлигын эсрэг видео контентуудыг улсын хэмжээний 25 телевиз, кабелийн сувгаар дамжуулж олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж, нийт 2397 удаагийн цацалтыг хийж, түгээсэн бол 2021 онд арилжааны 12, орон нутгийн 24 телевизээр олон нийтэд хүргэв. “Гэр бүлийн радио 104.5”, “Дэлхийн монголчуудын радио 88.3”, “Таны радио 103.6”, “Зохист аялгуу 89.3”, Монголын үндэсний олон нийтийн

радио, Инээмсэглэл FM 99.3, Kiss FM 100.1, Монголчуудын радио 102.1, Эрүүл амьдралын радио 104, орон нутгийн радио FM 89.1 зэрэг радиотой хамтран ажилласны дээр, тэдгээр радиогийн “Нэг дусал”, “Радио зөвлөгөө”, “Ашигтай мэдлэг”, “Уран зохиолын цаг” зэрэг олон сонсогчтой хөтөлбөрүүдээр дамжуулан авлигын хор аюулыг ухуулан таниулахад чиглэгдсэн мэдээ, мэдээллийн тогтмол урсгалтай болов. “Хаштаг110” подкаст нэвтрүүлгийг цувралаар хийж, байгууллагын болон mplus.mn сайтад 51 удаагийн мэдээлэл байршуулав. Тухайлбал, 2022 онд “MGL” радиогийн “Нэг дусал” контентоор олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн болон байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийг нийт 180 сэдвээр бэлтгэн олон нийтэд хүргэхийн зэрэгцээ 3 минутаар бэлтгэсэн сэдвийг өдрийн 9 удаагийн давталттай олон нийтийн хүртээл болгов.

Авлигын эсрэг зохион байгуулсан цаг үеийн асуудлаар 181 хэвлэлийн мэдээ боловсруулан байгууллагын албан ёсны цахим хуудаст, 127 мэдээ, мэдээллийг бэлтгэн “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудаст байршуулсан, мөн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой мэдээллийн хуудас 1 дугаарыг эрхлэн хэвлүүлж, олны нийтэд хүргэв.

Авлигатай тэмцэх газраас шударга ёсны сэдэвтэй, авлигыг үл тэвчих агуулга бүхий видео контент, шторк, дуу клип, богино хэмжээний кино, зохиомжит нэвтрүүлэг зэргийг нийслэлийн төв зам дагуух болон автобусны буудал дахь сурталчилгааны дэлгэц, самбарт байршуулан түгээв. Түүнчлэн Улаанбаатар хотын орон сууцны болон 20 оффисын цахилгаан шатанд байршуулсан 228 дэлгэцээр авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааг нэвтрүүлэх, зурагт хуудас, нугалбар танилцуулга, үзүүлэн тараах материалыг мэдээллийн самбарт байрлуулах зэргээр сурталчилла. 2022 онд Баянгол дүүргийн 1, 3, Баянзүрх дүүргийн 3, 7, 26 хороодын орон сууц, хотхоны нийт 816 орцонд байршуулж, 20,471 өрхийн 70,964 иргэнд авлигыг эсрэг мэдээллийг хүргэж ажиллав. Авлигатай тэмцэх газраас иргэд, олон нийтэд зориулан бүтээсэн авлигын эсрэг шторк, видео нэр бүхий 12 телевизээр 2 сарын туршид цацалт хийлгэж, авлигын эсрэг зурагт

хуудсыг гудамж талбай, автобусны буудалд байрлах 37 самбарт байршуулсан, “OECD Public integrity” гарын авлагыг Англи хэлнээс Монгол хэл рүү орчуулан, Нийслэлийн 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний 4 төвд мэдээллийн самбар хэвлүүлэн байршуулж, иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулав.

“АТГ-Олон нийтийн төв” цахим хуудсыг 2020 онд нээж, мэргэжлийн байгууллагатай хамтран идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулснаар 45519 дагагчтай болсон ба тус (page) хуудсаар дамжуулан 335 зурагт хуудас болон бусад мэдээ мэдээллийг байршуулж, 486 мэдээлэл, 151 видео контентыг олон нийтэд хүргэн, 40 стори (story) мэдээг сошиалаар түгээсэн, 2021 онд нийт 65 контентыг 12 телевизийн оргил цагаар цацуулж, 21 аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллан хэвлэлийн мэдээ бэлтгэх, түгээх, байгууллагын үйл ажиллагааны талаар инфографик, видеографик зэрэг мэдээг бэлтгэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж, арга зүйн удирдлагаар ханган ажиллав.

Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Шударга ёсны үнэ цэнэ, Авлигын эсрэг олуулаа нэгдье, Гэрэл тусгая, Арын хаалга..., Албаны мэдээллийг аминдаа..., Гайтай бэлэг..., Танилын гуйлт..., Авлигын шилэн бөмбөлөг, Авлига-хожихгүй нүүдэл, Төрийн албан хаагч танаа 1, 2; 110 дугаарын сурталчилгаа 1, 2, 3 шторкуудыг 21 аймагт хүргэж, орон нутгийн иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулав. Орон нутагт Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 6 төрлийн хэвлэмэл материалыг тарааж (110 дугаарын утасны сурталчилгаа, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, Авлигын хэлбэрүүд, Авлигын болон Эрүүгийн хуулийн холбогдох заалтуудаас, Авлигыг мэдээлэх нь зэрэг) сурталчилгааны материал, видео контент, шторк зэргийг багцлан сум бүрт хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулав. Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан НҮБ-аас “Recover with integrity” уриаг гаргасан бөгөөд цар тахлын үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Stop the virus Stop corruption” хэмээх нэмэлт уриаг зарласан. Энэ дагуу Авлигатай тэмцэх газраас НҮБ-ын “Recover with integrity” аяны

санааг тусгасан монгол хувилбарын зурагт хуудсыг бэлтгэн хэвлэл мэдээллийн гол гол цахим хуудаст байршуулан 19 өдрийн турш сурталчилсан. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор багш нарын оролцсон 5, эдийн засагчдын оролцсон 10, ардын уран зохиолчдын оролцсон 3, телевизийн нэвтрүүлэгч нарын оролцсон 4, богино хэмжээний кино, клип 10, сэтгүүлчдийн оролцсон 15, нийт 47 видео, контент, шторк бүтээж, олон нийтийн сүлжээ, радио, телевизээр тасралтгүй сурталчлан түгээж ажиллалаа.

2019 онд Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан 41 төрлийн ном, гарын авлага, эмхэтгэл, товхимол, тойм танилцуулга зэргийг 25 их, дээд сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Тусгаар тогтнолын ордон, мөн 21 аймгийн номын сан, Улаанбаатар хотын 73 байгууллагын номын сан, сэтгүүлчдэд зориулсан сургалт, цэргийн штабын удирдах албан тушаалтнууд, Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш нар, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын шинээр томилогдсон албан хаагчид, татварын байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд, 6 дүүргийн Татварын хэлтэс, угтах үйлчилгээ, иргэдэд үйлчлэх хэсэгт түгээж, байршуулав. АТГ-аас 2020 онд 37 төрлийн 16962 ширхэг ном, гарын авлага, 2021 онд шинээр 13054 ширхэг ном гарын авлага хэвлүүлж, 25 төрлийн 19402 ном гарын авлагыг иргэд, байгууллагуудад хүргүүлэв. Байгууллагаас эрхлэн гаргадаг "www.iaac.mn" мэдээллийн хуудас болон бусад хэвлэмэл материалуудыг Монголын Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлтэй хамтран СӨХ-доор дамжуулан айл өрхүүдэд хүргэх, мөн 21 аймаг, 9 дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд нэгдсэн журмаар хүргэх ажлыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газраас Хүүхэлдэйн театртэй хамтран "Бүлтээхэй, Дэлдээхэй хоёрын шударга тоглоом" сэдэв бүхий хүүхдийн жүжгийг дэглэн тайзнаа тавиулж, "ЕТВ" үнэ төлбөргүйгээр бичлэгийг хийж, телевиз болон цахим хуудсаар олон нийтэд хүргэв.

Барилга, хот байгуулалтын яам "Газрын харилцаа-Цахим шилжилт" нэг сарын аяныг зарлаж, захирамж нь гарсан газрын гэрчилгээ, кадастрын зургаа цахимаар өөрөө, үнэ

төлбөргүй хэвлэж авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд энэ аяны хүрээнд иргэн, хуулийн этгээд 8742 үйлчилгээг авсан байна. Мөн аяны хүрээнд MGLRADIO-88.3 радио, Монгол коммент -TV9, Сошиал ПиAP-ын баг болон олны танил хүмүүстэй хамтран видео контент бэлтгэн Ega-zag.gov.mn системийг сурталчлан ажиллажээ.

Баянхонгор аймаг, "АЯНЫ АЛТАН ЖОЛОО" аян өрнүүлж такси үйлчилгээний жолооч нарын машинд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг радиогийн 36 ярилцлага, шторкыг 1 сарын хугацаанд 60 машинд байршуулж, давхардсан тоогоор 8700 гаруй иргэдэд сонсгож байна. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагч нарын дунд иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд авлигын хуульд заасан хориглолт, хязгаарлалтуудыг сурталчилсан контент бүтээх уралдаан зарлаж, "Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт", "Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох" зохицуулалтыг сурталчилсан агуулгатай контентыг шалгаруулан, авлигын эсрэг радио зөвлөгөөг бэлтгэн хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиогоор 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фейсбүүк хуудсаар 40 удаагийн давтамжтайгаар түгээж, нийт 65000 гаруй иргэнд хүргэжээ.

Орхон аймаг, гэрэл зураг сонирхогч залуусын дунд "Авлига ба хүний эрх" сэдэвт гэрэл зургийн уралдаан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Шударга ёс" сэдэвт видео бичлэгийн уралдааныг зарлаж, шалгарсан бүтээлийг www.erdenet.mn болон "Хууль эрх зүйн хэлтэс" цахим хуудсаар сурталчилж, 15 сургуулийн 924 эцэг эхийг хамруулсан хүүхдийг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга байдлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, "Бомбуулай Бөмбүүлэй хоёрын зөвлөмж" зурагт номыг тараажээ.

Хэнтий аймаг, авлигын эсрэг олон улсын өдрийг угтан эсээ бичлэгийн уралдаан зарлан 145 хүүхдээс эхний 5 байранд шалгарсан бүтээлээр подкаст бэлтгэн, 15 хүүхдийн бүтээлээс эшлэл авч видео хэлбэрээр түгээж, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд ерөнхий боловсролын 27 сургууль, 34 цэцэрлэгт авлигын эсрэг 5 шторкийг хүргүүлж, эцэг эхийн болон сурагчдын фейсбүүк группээр

дамжуулан сурталчилж, 2485 хүнд хүргэжээ.

Булган аймгийн Засаг даргын тамгын газар, Прокурорын газар хамтран төрийн албан хаагчдаас үйлдсэн “Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, цаашид анхаарах асуудал”-ын талаар 60 минутын подкастыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.

Дархан-Уул аймгийн Залуучууд театрын уран бүтээлчид авлигын эсрэг ухуулга, сурталчилгаа бүхий видео контентыг бэлтгэн олон нийтийн хүртээл болгожээ.

Авлигатай тэмцэх газраас гомдол, мэдээлэл хүлээн авдаг 110 тусгай дугаарын утсыг олон нийтэд сурталчлах зорилго бүхий 11 минут 0 секундэн богино хэмжээний подкастыг хийж, шүүхээр шийдэгдсэн авлигын гэмт хэргүүдээс сонгож, 20 гаруй кэйс, жишээг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарлан таниулсан. Мөн 2022 онд “Хахууль өгөх, авах гэмт хэрэг зөвхөн төрийн албан хаагчдад хамаатай юу?”, “Эмнэлгийн салбарт үйлдэгдсэн гэмт хэргийн тухай”, “Хөдөлмөрийн чадвар алдалтыг хуурамчаар тогтоосон тухай”, “Шударга ёсны клубыг байгуулахын ач холбогдол”, “Дулааны цахилгаан станцын асуудлаар”, “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах ажил үр дүнтэй байна уу?”, “Хүүхдийн шударга байдлын 2022 оны судалгаа хийгдэж дууслаа”, “Авлигын эсрэг олон улсын өдөрт зориулсан тусгай дугаар”, “Азын дугаарын борлуулалтаас олсон орлогын тодорхой хувийг хүүхдийн хөгжилд зарцуулдаг уу”, “АТГ-аас хийж, хэрэгжүүлсэн 2022 оны онцлох ажлуудаас” зэрэг сэдвээр нийт 10 подкаст бэлтгэн нийтийн хүртээл болгожээ.

“Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай хамтран 2022 онд “Авлигын хор хөнөөл” агуулгын хүрээнд гэрэл зургийн уралдаан зохион байгуулж, нийт 79 бүтээл хүлээн авснаас, 44 бүтээлийг шалгаруулж, тус бүтээлүүдээр гэрэл зургийн үзэсгэлэн гаргах, авлигын эсрэг постер, зурагт хуудас бүтээхэд ашиглах зэргээр байгууллагын үйл ажиллагаанд цаашид тогтмол ашиглах, нөхцөл боломжийг бүрдүүлж, гэрэл зургуудыг чанар, стандарт хангуулсан байдлаар хэвлүүлэв. Мөн авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан авлига, ашиг сонирхлын улмаас хохирсон нийтийн эрх ашиг, хулгайлагдсан боломж, эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны бодит

түүхийг эрэн сурвалжлан нийтэд хүргэх, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад олон нийтийн анхаарлыг хандуулах, оролцоог бий болгох зорилгоор Авлигатай тэмцэх газар, Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв хамтран “Түүний түүх” сэдэвт Storytelling сэтгүүл зүйн бүтээлийн уралдааныг зохион байгуулав.

“Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ-тай хамтран “Авлигатай тэмцэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо” сэдэвт сургалт, семинарыг 2022 оны 02 дугаар сард зохион байгуулж, сургалтад нийт 69 сэтгүүлч хамрагдсан. Уг сургалтаар “Авлигатай тэмцэхэд хэвлэлийн мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо”, “Мөс хагалах хэлэлцүүлэг: Мэдээллийг яагаад нягтлан шалгах ёстой вэ?”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нягтлан шалгах сэтгүүл зүй болох тухай”, “Уламжлалт сэтгүүл зүйгээс ялгарах шинж чанар”, “Эх сурвалжийн найдвартай байдал, эх сурвалжийн таамаглал Багийн ажил: Таамаг дэвшүүлэх дасгал Баримт гэж юуг хэлэх вэ?”, “Баримтыг нягтлан шалгах алхмууд, түлхүүр асуулт, логик дараалал”, “Интернэтийг сэтгүүл зүйд ашиглах нь Google-д мэдээлэл хайх эхний алхмууд болон стратеги”, “Худал, гуйвуулсан, бүрэн бус мэдээллийн ангилал”, “Худал мэдээлэл хэмээх ойлголтын тухай”, “Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх худал мэдээллийн нийтлэг шинж чанар”, “Эвлүүлсэн видеог нягтлан шалгах арга, зарим апп, tools, дасгал ажил”, “Өгөгдөл гэж юуг хэлэх вэ?”, “Дата сэтгүүл зүйн удиртгал” сэдвээр суралцаж, “Хаалтын хэлэлцүүлэг: Өнөөдөр бид юу сурав?”, “Дараагийн сургалтын сэдэв Бие халаалт: Өмнөх хичээлээр сурсан зүйлсийг сэргээх”, “Хэлэлцүүлэг: Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх худал мэдээллийг хэрхэн таних вэ?” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагатай хамтран эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан ээлжит сургалтыг Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын төслийн санхүүжилтээр 2022 оны 05 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад эрэн сурвалжлах чиглэлээр ажилладаг 54 гаруй

сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан ба “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба уламжлалт сэтгүүл зүйн ялгаа”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга техникийн суурь мэдлэг, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын туршлагын талаарх ойлголт”, “Интернэтийг эрэн сурвалжлагад ашиглах чадвар, хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв судалж, мэдээлэх”, “Нийтийн мэдээллийн тухай хуулийн анхаарах асуудлууд”, “Сэтгүүлчийн аюулгүй байдал, авлигын гэмт үйлдэлтэй тэмцэхэд сэтгүүлчийн үүрэг оролцоо”, “АТГ-ын олон нийттэй харилцах бодлого” зэрэг сэдвээр сургалт хийсэн.

Нийслэлийн 9 дүүргийн 191 хорооны 1734 хэсгийн ахлагчийг чадавхжуулах сургалтад хамруулж, “Таны эрх, таны оролцоо” фейсбүүк группийг ажиллуулж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.10.1-2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах /АТГ, 2017-2022/

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг олон нийтэд хүргэхэд сэтгүүлчид, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр 2017-2020 онд 47 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. 2021 онд Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах, хамтарч ажиллах чиглэлээр 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулах, сургалт хийх, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх, уулзалт, хэлэлцүүлэг хийх зэргээр хамтран ажиллаж, авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх ажлын хүрээнд сурталчилгааны материал, эмхэтгэл, товхимол

хэвлүүлж тараах, видео шторк, радио спот, сошиал вирал видео, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, ярилцлага хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажлыг тогтмол хийж хэрэгжүүлж байна. Тухайлбал, Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан НҮБ-ын “Recover with integrity” аяны санааг тусгасан монгол хувилбарын зурагт хуудас хэвлүүлж, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг энгийн иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор “Хэрсүү залуус” ТББ-тай хамтран комикс (зурагт номын) цуврал гаргаж, лого бичвэр бүхий амны хаалт нийт 3000 ширхгийг захиалгаар хийлгэн, иргэд олон нийт, албан тушаалтнууд, Төрийн тусгай хамгаалалтын газар, хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчид, цар тахлын хүнд нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдад тараав. Мөн 15 сэтгүүлч оролцсон 15 шторк, 20 постер хийж, телевизүүд болон сошиалаар олон нийтэд түгээх, аяны баннер бүхий зурагт хуудсыг олон нийтийн газарт байршуулах, 9 төрлийн видео шторкийг лэд дэлгэцээр олон удаагийн давтамжтайгаар сурталчилсан байна. Авлигын хор хөнөөл, шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан 38 төрлийн видео контентуудыг цувралаар тогтмол бүтээж, цахим хуудас, пэйж хуудас болон телевизүүдтэй хамтран түгээх ажлыг зохион байгуулан ажиллалаа. “Салхитын мөнгөний орд”, “Зайсангийн хууль бус газар олголт”, “Авлигатай тэмцэхэд иргэдийн оролцоо”, “Залуу үе авлигын эсрэг” зэрэг 4 төрлийн сэдвээр “Цахим сэтгүүл зүй” ТББ-тай хамтран баримтад суурилсан “Өөр өнцөг” нэвтрүүлгийг бэлтгэв. Мөн “Цахим сэтгүүл зүйн мэдээ” ТББ-тай хамтран 2022 онд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан 5 удаагийн шууд лайв нэвтрүүлэгт хамтран оролцож олон нийтэд мэдээлэл хүргэв. Үүнд: “Авлигатай тэмцэх газрын жилийн эцсийн ажлын онцлох ажлуудаас” цуврал 3 дугаар, “Авлигатай тэмцэх газар 9 сарын байдлаар 2 их наяд төгрөгийн хохирол нөхөн төлүүлэв”, “Шударга байдлын үнэлгээ судалгаа 2022”-г тус тус хүргэж, олон нийтийн хүртээл болгов.

Арга хэмжээний талаарх мэдээллийг

телевиз, радио, цахим хуудас, фейсбүүк болон олон нийтийн мэдээллийн бүхий л сувгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, арга хэмжээний талаарх мэдээллийг телевиз, радио, цахим хуудас, фейсбүүк болон олон нийтийн мэдээллийн бүхий л төрлийн сувгаар нэвтрүүллээ.

2020 онд Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад хэвлэл, мэдээллийн байгууллагууд (22 телевиз, өдөр тутмын 5 сонин, богино долгионы 6 радио, мэдээллийн гол 6 сайт, 21 аймгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл), нийтлэлч, зохиолч, яруу найрагч, соёл урлагийн болон спортын алдартнууд, сэтгэл судлаач нараас гадна нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллав. Тухайлбал, авлигыг жигшээх, хор аюулыг ойлгуулах, шударга ёсны үйл хэрэгт уриалах, дуу хоолойгоо хүргэх чиглэлээр сагсан урлаг, спортын одод, алдартнуудтай хамтран “Үр” богино хэмжээний кино, “Төрийн албан хаагч танаа”, “Шударга ёсны үнэ цэнэ”, Авлигын шилэн бөмбөлөг”, “Авлигын эсрэг улам олуулаа нэгдье”, “Аавын захиас”, “Тангараг”, “Ээжийн хайр”, “Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр”, “Шударга ёс гэж юу вэ?” сэдэвт богино хэмжээний кино контентүүд, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан шторкуудыг бүтээв. Хүүхэд багачуудад зориулсан цуврал видео контентыг vuond программ ашиглан бүтээж, олон нийтэд хүргэж байна.

Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрүүдийг 2020 онд боловсрууллаа. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт сургалтын хөтөлбөр (9 цагийн лекц, 9 цагийн дасгал, 3 цагийн хэлэлцүүлгээс бүрдсэн), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд төрийн албан

хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилготой сургалтын хөтөлбөр (төрийн байгууллагын худалдан авах, санхүү, хууль зүй, дотоод хяналт шалгалт, аудитын болон удирдах албан тушаалтанд зориулсан 5 төрлийн сургалтын 20 модуль)-ийг тус тус боловсруулж, сургалтад нэвтрүүлэв.

Шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл бие-Эрүүл нийгэм” аяныг зарлаж, энэ хүрээнд “Амьдралын хэв маягаа өөрчилъе» уриан дор 300 гаруй иргэнийг хамруулсан “Let’s change” сэдэвт өдөрлөгийг “Үнэгүй фитнес” ТББ-тай хамтран зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газар, “Залуус өөрчлөлтийн төлөө” үндэсний хөдөлгөөн, “Хуулийн хөтөч” клуб хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “New generation-No corruption”, “Шинэ үе авлигыг тэвчихгүй” илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулав. Уралдаанд оролцогчид бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгэм дэх авлига, хүнд суртал зэрэг сөрөг үзэгдэлд шүүмжлэлт байдлаар хандах, асуудлыг танин мэдэх, шийдвэрлэх арга зүй, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээрээ ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тэмцээнд нийт 275 сурагч видео бичлэгээ ирүүлж, шалгарсан илтгэгчдийн онцлох эшлэлээр зурагт хуудас, богино видео контентыг бэлтгэж, олон нийтэд түгээлээ.

“Зорилготой залуу” ТББ-тай хамтран “Шударга ёс” хүүхдийн цуврал кино зохиолын уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд цахимаар зохион байгуулж, тус уралдаанд нийт 250 зохиол ирснийг ажлын хэсэг сонгон шалгаруулж, ялагчдыг тодруулав. Хүүхэд багачуудыг зөв шударга, хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн Том хамтлагийн тоглосон “Шударга ёс” богино хэмжээний видео контентын үргэлжлэл 2 анги (Түрүүвч, Цахим хичээл)-ийг бэлтгэсэн.

“Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал хакатон”-ыг 2020 оны 5

дугаарсард, мөн залуусэтгүүлчдийн дунд хакатон 2021 оны 9 дүгээр сард танхимын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд оролцогчид орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сантай холбоотой мэдээлэл (өгөгдөл)-д дүн шинжилгээ хийж үр дүнг танилцуулав. Мөн “Бодлогод залуусын оролцоо”, “Тунгаахуй өгөгдлийн урлан” зэрэгт ТББ-тай хамтран “Дата эрх чөлөө ба мэдэх эрх” сэдэвт инфографик үзэсгэлэн 2021 оны 12 дугаар сард тус тус зохион байгуулав.

Сонгуулийн ерөнхий хороотой хамтран “Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч танаа” гарын авлагыг боловсруулан нэр дэвшигчдийг мэдээлэл, арга зүйгээр хангасан болно.

2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон И-Монгол академитай хамтран “Сонголт” интерактив сонголтот видео, “Ачлалт багш” жүжигчилсэн контент, Уриалга контент, гэрэл зураг, эсээ бичлэг, нийтлэлийн уралдаанд байр эзэлсэн хүмүүсийн оролцсон нийт 13 контентыг хийж, гүйцэтгэн олон нийтийн хүртээл болгов.

“УБТЗ” ХНН-ийн Зорчигч тээврийн үйлчилгээний төвийн билетийн касс, маркетингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “DM SKY” ХХК-тай хамтран ажиллаж, тус компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд “Авлигыг мэдээлэх 110” тусгай дугаарын утасны сурталчилгаа бүхий текстийг зорчигч тээврийн орон нутгийн тасалбарт байршуулан нийт 40,000 ширхэгийг хэвлүүлэн сурталчилсан нь хамгийн богино хугацаанд хамгийн олон хэрэглэгчийн гарт шууд хүрсэн сурталчилгаа боллоо.

“Авлигатай тэмцэх газраас “Монголын хөлбөмбөгийн холбоо” ТББ-тай 2022-2026 он хүртэлх хугацаанд хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулж, спорт дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга ёсны талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хандлага тогтооход чиглэгдсэн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, холбооны гишүүдийн ёс зүйн дүрмийг тогтоох, мөрдүүлэх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээллийг ил тод, нээлттэй болгох, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, багийн спортоор дамжуулан хүүхэд залууст шударга ёсны үзэл дадлыг бий болгох чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэ

хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Нийтийн хөлбөмбөг” арга хэмжээний үеэр “Зөв шүүлт-шударга тоглолт” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 12, 13, 14-ны өдрүүдэд зохион байгуулав. Багийн спортоор дамжуулан үнэнч, шударга, зөв дадалд сургах, уг арга хэмжээнд тэднийг татан оролцуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, тэмцээн уралдаан зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагаа болон “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг сурталчлах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Тус холбооны удирдлага, ажилтан, шүүгч, дасгалжуулагч, тамирчдыг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөлбөмбөгийн холбооны байр, тоглолтын талбайд байршуулах 49 төрлийн сурталчилгааны зурагт хуудас, стикер, хулдаасан хэвлэлийг байршуулав.

“Монголын шүүгчдийн холбоо” ТББ-тай хамтран шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, иргэдийн дунд үүссэн төөрөгдлийг арилгах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох, зөвлөлдөх 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар, Монголын шүүгчдийн холбоотой соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран хэрэгжүүлэх 16 асуудал бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт ажиллаж байна. Энэ хүрээнд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх агуулга бүхий 3 мэдээг Дэлхийн Монголчуудын радио MGL радио 88.3-аар нэг дусал богино хэмжээний контент бүтээж, 2022 оны 11 сарын турш түгээсэн ба “Шүүх ба Олон нийт” сэдвээр “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” нэг удаагийн бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн түгээв.

“Үнэний ташуур” НҮТББ-тай хамтран олон нийтэд авлигын нийгмийн, хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, эерэг, зөв хандлагыг төлөвшүүлэх, түүнд уриалсан агуулга бүхий богино хэмжээний цуврал видео контент буюу “Тик Ток” 10 цувралыг бүтээсэн.

Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” 2017-2022 оны эмхэтгэлүүд,

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн 2013-2020 оны цуврал эмхэтгэлүүд, “Зөв зөвд шударга зөв”, “Улсын Их Хурлын гишүүн танаа”, “Засгийн газрын гишүүн танаа”, “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч танаа”, “Засаг дарга танаа”, “Хувийн хэвшил дэх авлигаас сэргийлэх 9 зөвлөмж”, “Бизнесийн ёс зүй” хувийн хэвшилд зориулсан гарын авлага”, “Мөнгө угаахтай тэмцэх нь”, Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” гарын авлага, “Шударга ёсны боловсрол /авлигатай тэмцэх, үнэт зүйлс болон хууль дээдлэх талаар боловсрол олгох нь/ OECD зэрэг гарын авлага, сурталчилгааны материал, зурагт хуудсыг эрхлэн хэвлүүлж түгээсэн, мөн 38 төрлийн зурагт хуудас, постерыг бэлтгэн цахим орчинд түгээж, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашигласан.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн үг, сургамжит өгүүллэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох чиглэлээр “Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага”, төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлыг шинжлэх, Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны суурь зарчимтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрд эргэцүүлэн бодож байх боломжийг олгох, сургалтад ашиглах зорилгоор “Бодлогын хураамж: Төрийн албаны ёс зүй, ашиг сонирхлын зөрчил” гарын авлагыг тус тус боловсруулан хэвлүүлж, авлигын эсрэг сургалтад ашиглаж байна.

2021 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас эрхлэн хэвлүүлсэн “Шударга байдлын боловсрол” гарын авлагыг орчуулан, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ-тай хамтран нийслэлийн ЕБС-ын сургуулиудад хүргэж, сургалт-соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд ЕБС-ийн багш нарын дунд шударга ёсны сэдэвт ээлжит хичээлийн хөтөлбөрийн уралдаан зарлаж, Шударга ёсны боловсрол олгох ажлын хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын

1 дүгээр сургуулийн багш М.Золжаргалын боловсруулсан “Хүний хөгжлийн индекс” (11 дүгээр анги), 67 дугаар сургуулийн багш Э.Идэржаргалын боловсруулсан “Процент” (8 дугаар анги), “Хароума фүжи” сургуулийн багш Ц.Галбадрахын боловсруулсан “Шог зураг” (7 дугаар анги), “Монгени цогцолбор” сургуулийн багш С.Мөнхбаатарын боловсруулсан “Зөрчил маргааныг шийдвэрлэх нь” (8 дугаар анги), мөн сургуулийн багш Б.Амаржаргалын боловсруулсан “Секторын талбай” (9 дүгээр анги), Гётё сургуулийн багш М.Буянцэцэгийн боловсруулсан “Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалт” (9 дүгээр анги) сэдэвт теле хичээлийг түгээхээр ажиллаж байна

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг дагаж мөрдөх, багшийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн сургууль болон гэр бүлээр дамжуулан сурагч, эцэг эх, багш нарт авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад туслах зорилгоор 2021 онд “Шударга ёсны клуб”-ыг Нийслэлийн ерөнхий боловсролын 6 (1, 12, 24, 32, 40, 84 дүгээр) сургууль дээр байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын ном, гарын авлага, сурталчилгааны материалаар ханган үйл ажиллагааг нь эхлүүлсэн. 2022 онд энэ ажлын цар хүрээг нэмэгдүүлж Нийслэлийн Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори цогцолбор сургууль, Хэнтий аймгийн Хэрлэн 1, Хэрлэн 4, Тэмүүжин цогцолбор, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Бор-Өндөр цогцолбор сургуульд “Шударга ёсны клуб” нээж, шаардлагатай тоног төхөөрөмж, “Багшийн ёс зүйн дүрэм” самбар, Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан ном, гарын авлага зэргийг хүлээлгэн өгч, гэрээний хэрэгжилтийг дүгнэв.

Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий мэдээлэл агуулсан “Шударга ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарыг 2021 онд Монгол Улсын 12 яам, 36 агентлагт, “Багшийн ёс зүйн дүрэм” самбарыг Нийслэлийн боловсролын газар, 9 дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран төрийн өмчийн 148, төрийн бус 127, төрийн өмчийн 265 цэцэрлэг нийт 546 сургууль, цэцэрлэгт байршуулав.

2021 онд Иргэдтэй харилцах 110 мэдээллийн аппликэйшнийг бүтээж, хөгжүүлэлтийг хийн, иргэдэд сурталчлав. Тус аппликэйшнээр дамжуулан иргэдээс санал асуулга авах боломж бүрдсэн бөгөөд playstore, Appstore-с татан авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд, “110-Иргэдэд мэдээлэл өгөх аппликэйшн”-д 2022 оны 12 дугаар сарын байдлаар Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны 139 мэдээллийг оруулж мэдээллийн баяжуулалт хийв. Тус аппликэйшнд сард 631 хандалт, нийт хандалтын тоо 16745 болсон байна.(Биелэлт 100 хувь)

4.1.10.1-3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран зохион байгуулах чиглэлээр холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн ба 2016, 2017 онд 21 аймагт албан томилолтоор ажиллах явцдаа Иргэний танхим хариуцсан ажилтнуудыг Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтад хамруулснаас гадна хувийн хэвшилтэй хамтран аймаг бүрт “Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг хийв.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр орон нутгийн иргэний танхимын оролцоотойгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2017 оны 05 дугаар сард зохион байгуулж, өдөрлөгт нийт 600 орчим хүн оролцсон. Мөн Баянхонгор аймгийн ЗДТГ-аас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

АТГ нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын

Тамгын газартай хамтран нийслэлийн төсвөөр авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр брошюр, гарын авлага, зурагт хуудас зэрэг сурталчилгааны материалыг 2018-2020 онд хэвлүүлж, иргэд, олон нийтэд түгээв.

Иргэний хяналтын төвийг нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Дүнжингарав, Мишээл, Оргил салбаруудад нээн ажиллуулах бэлтгэл ажлыг 2018 онд хангаж, 2019 оны нэгдүгээр улирлаас эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2019 онд 21 аймагт ажиллах явцад болон орон нутаг, нийслэлд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явцдаа авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ном, гарын авлага зэрэг 20 орчим төрлийн 48275 ширхэг сурталчилгааны материалыг иргэд, төрийн байгууллага, аймаг, нийслэлийн Иргэний танхим, нийтийн номын сангуудад түгээсэн бөгөөд иргэд, төрийн албан хаагчид дээрх байгууллагуудаар дамжуулан авлигын эсрэг ном, гарын авлагатай танилцах, судлах нөхцөл боломжоор хангасан.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Авлигатай тэмцэх газраас 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг судлан үзэж, салбар зөвлөлүүдийн дарга, нарийн бичгийн дарга нартай цахим уулзалт зохион байгуулсан ба тэдгээрт орон нутагт дахь авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудлуудыг танилцуулж, 2020 онд авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх чиглэлээр зөвлөгөө өгч, мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. Энэ хүрээнд 2020 онд орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар чиглэл өгөх, судалгаа хийх, сургалт, сурталчилгаа явуулах, хууль тогтоомжийг сурталчлах, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах

контент (видео, шторк г.м) түгээх ажлыг зохион байгуулах ажлыг тусгуулах арга хэмжээг авч ажиллав.

2021 онд аймаг, нийслэл, дүүргийн Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвийн 2021 онд 65, 2022 онд 74, нийт 139 ажилтантай хамтран ажиллаж, 211 албан хаагчдад авлигын эсрэг сургалтыг зохион байгуулан, авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан 10500 ширхэг хаалганы наалт, 19 төрлийн 2976 ном, гарын авлага, 35 төрлийн 2900 зурагт хуудас, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 72 төрлийн шторк, видео контентыг хүргүүлж, албан ёсны цахим хуудас, сошиал сувгуудад байршуулж иргэдэд сурталчилж, давхардсан тоогоор 1200312 хүнд хүргэсэн байна. Аймаг, нийслэл, дүүргийн Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвүүд нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс, урьдчилан сэргийлэх, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 1502 иргэнд хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгч, авлигын эсрэг сургалтыг 9958 албан хаагч, иргэн, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зохион байгуулж, авлигын эсрэг сурталчилгааны материалыг 10024 ширхгийг хэвлэн олон нийтэд түгээж, авлигын эсрэг контентыг албан ёсны цахим хуудас, сошиал сувгуудаар дамжуулан 1.016.911 хүнд; орон нутгийн телевиз, FM радиогоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентуудыг түгээж 313400 гаруй хүнд, лэд дэлгэцээр 51 төрлийн шторк, зурагт хуудсыг өдөрт 250-300 удаагийн давтамжтайгаар олон нийтэд сурталчилж ажилласан байна. (Биелэлт 70 хувь)

Мөн Өмнөговь аймаг Төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд ашиг сонирхлын зөрчлөөс ангид ёс зүйтэй байх, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, сурталчлан таниулах зорилгоор орон нутгийн Монгол говь, Говийн мэдээ сонинд Авлигын тухай ойлголт, Авлигын түгээмэл хэлбэр, төрөл, хор хөнөөл, Авлига үүсэх шалтгаан, Ашиг сонирхлын зөрчил, авлигын нийтлэг шалтгаан, Та авлигын эсрэг юу хийж чадах вэ? зэрэг нийтлэлүүдийг нийтлэн 4000 уншигчдад хүргэсэн байна.

Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийнхээ төлөө ажиллаж, гарч буй шийдвэр бүр нь иргэдэд

боломж болж очих ёстой, аливаа шийдвэр гаргахын өмнө иргэдээсээ асууж, тэднийг сонсож байх нь чухал гэж үзэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Иргэний танхим” нь 2022 онд танхимаар болон цахимаар 11 удаагийн хэлэлцүүлэг, 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газар нь 2022 онд 21 аймгийн Хууль зүйн туслалцааны төвийн 52 өмгөөлөгчийг сургагч багшаар бэлтгэн төрийн байгууллагын албан хаагч, олон нийтэд авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургагч багш бэлтгэж, сургагч багшаар дамжуулан иргэдэд чиглэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.10.1-4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын өөрсдийн хариуцсан үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, төлөвлөгөөг албан ёсны цахим хуудас дээрээ ил тод мэдээлж, үр дүнгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх талаар яам, агентлаг, аймаг, нийслэлд албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллав.

Авлигатай тэмцэх газраас аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн байгууллагуудын Авлигын эсрэг төлөвлөгөө болон авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн хэрэгжилттэй танилцан шалган зааварлах, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэсэн.

2020 онд төрийн байгууллагуудаас авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, тайлагнах, арга зүйг боловсруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, сайн туршлагыг солилцох зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөлт, үр дүнг сайжруулах-арга зүйн асуудал” сэдэвт

уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, олон нийтэд мэдээлэх, үр дүнг дээшлүүлэх зорилгоор авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загварыг шинэчлэн боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүлэв. Өнгөрсөн хугацаанд Авлигатай тэмцэх газар нь орон нутаг, яам, агентлагт ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, авлига үүсэх нөхцөл боломж бүрдүүлсэн дүрэм, журмыг хүчингүй болгох, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2 удаа, Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 1 удаа, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус бүр 3 удаагийн Зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авсан.

2021 онд Авлигын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор “Их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Монгол улсын Ерөнхий сайдад; Дорнод аймгийн албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээнд үндэслэн ил тод байдлыг хангах талаар тус аймгийн Засаг даргын Тамгын газарт; Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад; Авлигын гэмт хэрэг үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдад; Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад; Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, мөрдөгчийн мэдэгдлийн гүйцэтгэлийг

хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газарт тус тус хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигад өртөх боломжийг багасгах талаар 2022 онд төрийн байгууллага, албан тушаалтанд 47 зөвлөмж хүргүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 4,7 дахин өссөн байна. Боловсролын салбарт 7, хөдөлмөр, нийгмийн хамгаалал 4, зам, тээвэр 3, хөдөө, аж ахуй 3, эрүүл мэнд 2, нутгийн захиргааны байгууллага 13 зөвлөмж боловсруулан хүргэжээ. Нийт 16 зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээ, түүний үр дүнг тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийсэн болно.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтад мэргэжил арга зүйн өгөх зорилгоор авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар, дүгнэх хуудсыг боловсруулан 2021-2022 онуудад төрийн бүх байгууллагуудад нэгдсэн байдлаар хэрэгжүүлэв.

Өнгөрсөн хугацаанд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, Авлигын эсрэг үндэсний сүлжээ цахим санд “Авлигын эсрэг үйл ажиллагаа” дэд санг үүсгэсэн. Үүнтэй холбоотойгоор санд хэрхэн төлөвлөгөөний хэрэгжилт тайлагнах талаар цахим сургалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулан зохион байгуулж, 2021, 2022 онуудад төлөвлөгөөний хэрэгжилтийг цахим сангаар хүлээн авч, үнэлгээг хийж хэвшээд байна. Төрийн байгууллагууд 6 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг нийтлэг байдлаар хэрэгжүүлсэн. 2021 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг авлигын эсрэг үндэсний сүлжээ цахим сангийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө дэд санд хүлээн авч нийт 6 зорилтын хүрээнд 14 арга хэмжээний биелэлтэд цахимаар дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн ба орон нутгийн дундаж нь 77.6 хувиар үнэлэгдсэн байна. 2022 онд, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 70.1 хувьтай, яамд 55.7, агентлаг 53.2 хувиар тус тус үнэлэгдсэн байна.

2023 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээний загварыг шинэчлэн сайжруулж 5 зорилт 13 арга хэмжээг төрийн байгууллагуудад хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Төрийн байгууллагын цахим хуудсан дахь мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, яам, агентлаг, 21 аймгийн болон нийслэлийн 9 дүүргийн цахим хуудасны ил тод, нээлттэй байдалд үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад авлигын эрсдэлийн тайланг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхийг зөвлөж ажилласан.

Хянан шалгасан гомдол, мэдээлэлтэй холбогдуулан дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, зөрчилтэй захиргааны актыг хүчингүй болгуулах зэргээр шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн.

Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мөрдөгчийн 53 мэдэгдлийн мөрөөр авсан арга хэмжээ, үр дүн хяналт тавьсан байна. Үүнээс удирдамжийн дагуу 2 мэдэгдлийн мөрөөр 3 байгууллагад ажиллаж, бусад 51 мэдэгдлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллахад 39 мэдэгдлийн дагуу гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн бол 12 мэдэгдлийн мөрөөр авсан арга хэмжээ нь хангалттай үр дүнд хүрээгүй байв.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулахаар төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 48 албан бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлж ажиллав. (Биелэлт 100 хувь)

4.1.10.2-1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах /БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд насан туршийн боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажлын хэсэгт 2017 онд боловсролын бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтыг зохион байгуулж эхлүүлэх, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, их, дээд сургууль, коллежийн багш нарт авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулж, үндэсний сургагч багшийг бэлтгэх болон нийт багш нарын сургалтыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгосон боловч тус шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалын хүрээнд АТГ, БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн Боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулж сургагч багш нарт зориулсан “Багшийн ёс зүй: ёс суртахууны харилцаа” сэдэвт гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэсэн ба сургагч багш нар аймаг, нийслэлийн 36000 орчим багш нарт ёс зүйн сургалтыг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай”

А/492 дугаар тушаалаар баталсан агуулгад бага ангийн “Хүн ба нийгэм”, дунд, ахлах ангийн “Нийгэм судлал”, бага, дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт шударга ёс, ёс зүй, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх агуулга тусгагдан ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна. Тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн Х ангид судлах “Нийгэм судлал” хичээлийн агуулгад 1) Шударга ёсны ойлголт, түүний шалгуур, 2) Гажуудал ба нийгмийн хяналт, 3) Соёлын олон янз байдал, харилцаан дахь шударга ёсны үнэлэмж, 4) Үл ялгаварлан гадуурхах, 5) Эдийн засгийн өсөлт ба амьдралын чанар, 6) Шударга ёс ба авлига гэж бичсэн/, 7) Улсуудын орлогын ялгаатай байдал гэсэн сэдвүүдийг тусгасан бөгөөд Нийгэм судлал хичээлийн сонгон суралцах цагт “Үл ялгаварлан гадуурхах”, “Шударга ёс ба авлига” бүлэг сэдвийн хүрээнд авлигын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлд үзүүлэх сөрөг үр нөлөөг тодорхойлох, хүнийг эрхэлсэн ажил, боловсрол, нийгмийн байдал, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхахгүй байх, шүүхийн тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, эрх хэмжээний талаарх ойлголт, шүүх хэрэг маргааныг шударгаар хянан шийдвэрлэж байгаа эсэхэд өөрийн үзэл бодлыг илэрхийлж нотлон тайлбарлах чадвар эзэмшүүлэх, авлигаас зайлсхийх иргэний санаачилгын хувилбар дэвшүүлэх зэрэг агуулгыг суралцагчид судалж байна.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар батлагдсан 1-12 дугаар ангийн суралцагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, сурах бичигт бие, хэл, сэтгэлийн үйлдлээ ажиглан хянаж аливаа буруу үйлдэл хийхгүй байх, авлигыг үл тэвчих, шударга төв шулуун ёс зан төрхийг ямагт эрхэмлэх зэрэг агуулгыг тусган хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн

үг, сургамжит өгүүллэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох чиглэлээр “Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага”-ыг боловсруулсан.

2021 онд, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулан “Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд, залууст шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт шударга ёсны хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга туссан байдалд хийсэн дүн шинжилгээ хийсэн тайланг хэлэлцэж, санал зөвлөмж боловсруулан Ерөнхий сайдад хүргүүлэв.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн мэргэжлийн бус 1-2 дугаар курсийн оюутнууд, мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагсдад зориулсан эрх зүйн албан бус хөтөлбөр, агуулга, багш, сурагчдад зориулсан гарын авлага /модуль/ боловсруулах” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Хөгжих эрх судлал тулгуур” ТББ-тай хамтран ажилласан.

Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Шударга ёсны боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж тус хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд шударга ёсны боловсрол агуулгаар бэлтгэгдсэн сургагч багшаар дамжуулан 827 багшийг бэлтгэж 6-12 дугаар ангийн 20000 гаруй мянган хүүхдэд шударга ёсны боловсрол номын агуулгаар хичээл заах ажлыг зохион байгуулав. 2022 онд Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Хэнтий аймгийн ерөнхий боловсролын Хэрлэн-1, Хэрлэн-4, Тэмүүжин, Бор-Өндөр цогцолбор сургуулийн “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, клубээр дамжуулан сурагч, багш нарт шударга ёсны боловсрол олгох, түгээн дэлгэрүүлэх,

нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад дэмжин туслах зорилгоор арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх 60 багш, 30 идэвхтэн сурагч нийт 90 сурагч багшийг бэлтгэсэн.

Архангай аймгийн Эрдэм сургуулийн насан туршийн боловсролын нэгжээс бэлдсэн нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах гэсэн бүлгийн хичээлийг ахлах ангийн нийгмийн ухаан сонгон судалдаг, сонирхлын бүлгийн сурагчдаар судлуулан, бэлтгүүлж залуу багш нарт хичээлийг заалгасан нь сурагчдын эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, бусдад нөлөөлөх чадварыг сайжруулсан үр дүнтэй арга хэмжээ болсон.

Авлигатай тэмцэх газраас 2021-2022 онд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд өөрсдийн заадаг хичээлийн агуулга, хөтөлбөрт шударга ёсны талаарх ойлголт мэдлэгийг шингээж өгсөн шударга ёсны боловсрол олгох ээлжит хичээлийн хөтөлбөрийн уралдааныг зохион байгуулав. Энэ хүрээнд нийт 252 ээлжит хичээлийн хөтөлбөрийг хүлээн авч, сонгон шалгаруулалтыг Боловсролын ерөнхий газартай хамтран 2 үе шаттайгаар зохион байгуулж уралдааны дүнг гаргав. Уралдаанд нийт 15 хичээл буюу 43 багшийн боловсруулсан ээлжит хичээлийн хөтөлбөр шалгарсан.

Ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад зориулан сэтгэхүй хөгжүүлэх бодлого, математик үг хэллэгээр дамжуулан шударга ёсны үзэл санааг ойлгон, зөв буруу үйлийг ялган, найз нөхдөдөө зөв үлгэр дуурайлал үзүүлэхэд төлөвшүүлэн авлигын эсрэг боловсролын суурь мэдлэгийг олгох “Шударга ёс:Сэтгэхүй хөгжүүлэх бодлого” гарын авлагын эхийг боловсруулан 2021 онд 500, 2022 онд мөн 500 ширхгийг хэвлүүлэн тарааж, түгээн сурталчилсан.(Биелэлт 70 хувь)

4.1.10.2-2. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах / БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/533 дугаар тушаалаар баталсан бодлогын баримт бичгийн 4.1.6-д

заасны дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 их, дээд сургуулийн 436 бакалаврын хөтөлбөрт 10 чиглэлээр дүн шинжилгээ хийж гарсан үр дүнг “CDIO-2019” эрдэм шинжилгээний хуралд танилцуулан төрийн болон төрийн өмчийн бус их, дээд сургуулийн удирдлагад танилцуулж, цаашид хөтөлбөрийн чанарыг сайжруулах чиглэлд шинжлэх ухаан, боловсрол, нийгмийн хүрээнд ёс зүйн өндөр төлөвшилтэй, манлайлагч байх, үлгэр дуурайл үзүүлэх, залуу үеийг мэдлэг боловсролтой, чадварлаг ажиллах хүч, ухамсартай иргэн болгон төлөвшүүлэх, багш нарын ур чадварыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар хөтөлбөрт нэмж тусгах талаар зөвлөмжийг хүргүүлсэн.

Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээлүүд болох Төрийн онол, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүй, Эрүүгийн эрх зүй, сонгох хичээл Хүний эрх, Шударга ёсны онол, Шүүхийн эрх зүй, Хүний эрх ба олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, Нийгмийн хамгааллын эрх зүй, Төр, захиргааны хууль тогтоомжийн хэрэглээ, Үндсэн эрх, түүнийг хамгаалах механизм зэрэг хичээлийн агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тусган зааж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/433 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Авлигатай тэмцэх газрын төлөөлөл оролцож, 15 их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгасан эсэхэд дүн шинжилгээ хийж ажилласан ба 15 сургууль бакалаврын 199, магистрын 78, докторын 23, нийт 300 хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнээс 6 сургууль нь 6 хөтөлбөрт мэргэжлийн ёс зүй, 3 хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусган хэрэгжүүлж, харин 12 сургууль хөтөлбөртөө оруулаагүй байлаа. Энэхүү ажлын хүрээнд их, дээд сургуулийн захирал, сургалтын бодлогын албаны төлөөлөлтэй уулзаж,

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан ба 2023 оны сургалтын хөтөлбөрт мэргэжлийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгыг нэмэлтээр тусган баталгаажуулж, хэрэгжүүлэхээр тогтсон. (Биелэлт 70 хувь)

4.1.10.2-3. Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах / БСШУСЯ, ГБХЗХГ, АТГ, 2017-2022/

Шударга ёсны сэдэвт соён гэгээрүүлэх аян, социал акцыг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэд, хүүхэд, залуучуудын идэвх санаачилга, оролцоог дэмжиж, соён гэгээрүүлэх ажлын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж ажиллав. Тухайлбал:

“Томтолгойтын адал явдал” хүүхэд багачуудад зориулсан соён гэгээрүүлэх акц. Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын хамгаалах өдрийг угтан хүүхэд багачуудад зориулан цуврал контентыг бүтээж, сурталчлах зорилготой акцыг зохион байгуулав. Хүүхэд багачуудад “Том толгойтын адал явдал” олон ангит киногоороо танил болсон “Том хамтлаг”-ийн гишүүдтэй хамтран ажиллаж “Шударга ёс” цувралыг бүтээж, эхний анги “Хичээл дээр” контентыг АТГ-Олон нийтийн төв фейсбүүк хуудсаар олон нийтэд танилцуулан, уг бүтээлд тоглосон гол дүрийн хүүхдүүдийг АТГ-ын Олон нийтийн төвд урьж хүүхдийн шударга байх, шударга бус, буруу зүйлээс ангид байхын ач холбогдлын талаар харилцан яриа өрнүүлэн шууд дамжуулсан(8796 хүн үзсэн). Мөн гол дүрийн хүүхдүүдийг оролцуулан бэлтгэсэн 6 видео контент, 5 төрлийн зурагт хуудас бүтээн түгээв. Хүүхдүүдийг шударга ёсны сэдэвт соён гэгээрүүлэх ажилд татан оролцуулж, “Шударга ёс” цувралын дараагийн ангиудын зохиолын уралдааныг хүүхдүүдийн дунд зарлаж, дүгнэсэн. Уг уралдаанд 3 насны ангилалд нийт 256 гаруй хүүхдээс цахимаар ирүүлсэн уралдааны материалыг хүлээн авч уншиж сонгон шалгаруулалт хийж, уралдаанд түрүүлсэн хүүхдийн бүтээлээр “Шударга ёс” богино хэмжээний цуврал контентын дараагийн

ангийг бүтээж байна. “Шударга ёс” цувралын “Хичээл дээр” контент Авлигатай тэмцэх газрын албан ёсны youtube (<https://www.youtube.com/watch?v=SBnqsBDSNUM>) хуудсанд 1.176.907, АТГ-Олон нийтийн төв фейсбүүк хуудсанд 499 мянган хандалтыг тус тус авсан нь АТГ-аас бэлтгэсэн контентуудаас хамгийн их хандалттай контент болсон.

“Шударга ёс: Хичээл дээр...” соён гэгээрүүлэх акц. Энэхүү акцыг ЕБС, цэцэрлэгүүдийн /багш, ажилчид, хүүхэд багачууд, эцэг эхчүүдийг хамруулсан/ “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн видео контент “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё”, “Зөв зөвд шударга зөв” аяныг идэвхжүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдийг цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нараар дамжуулан идэвхжүүлэлтийг хийсэн. Тус акцын хүрээнд 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэгийн 386,000 сургуулийн багш, ажилтан, сурагчид, эцэг эхчүүд нэгдэж сургуулийн цахим хуудас, фейсбүүк групп дээр байршуулан түгээсэн. Тус акцыг 2020 оны 11 сараас эхлүүлсэн бөгөөд Нийслэлийн дүүргийн Боловсролын газар, хэлтэс, сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар хамтран ажилласан.

“Шударга тоглоё” бүжгийн давлагаа (челленж). Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн багш, ажилтнуудын болон ангийн фейсбүүк групп, пэйж хуудсаар дамжуулан сурагчид, эцэг эхчүүдийг авлигын эсрэг контентыг хүргэх, шударга зөв зан чанарыг түгээх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдийг хамруулан “Шударга тоглоё” бүжгийн давлагаа (челленж) аяныг “RoyalDance” бүжгийн хамтлагтай хамтран цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус бүжгийн давалгаанд хүүхэд багачууд болон эцэг, эхчүүдийг идэвхтэй хамруулах зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагын багш, ажилтнуудтай хамтран ажилласан. Энэхүү давлагаа АТГ-ын Олон нийтийн төв фейсбүүк хуудас болон #DanceChance фейсбүүк пэйж хуудас болон #RoyalDanceChanceMongoliaYoutube сувгаар үргэлжилж, 21 аймаг, нийслэлийн сургууль, цэцэрлэг, Засаг

даргын Тамгын газрууд хамрагдан, 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэг, 21 аймгийн 552 сургууль, 699 цэцэрлэгийн 560,000 сургуулийн багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл нэгдэн өөрсдийн дуу хоолойг бүжгээр шударга ёсыг илэрхийлсэн бичлэгүүдийг олон нийтэд түгээж, сурталчлах ажлыг зохион байгуулсан.

“Зөв Зөвд Шударга Зөв” соён гэгээрүүлэх аян. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан соён гэгээрүүлэх аяныг эхлүүлж, хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлчдийг авлигын эсрэг уриалах, олны танил эрхмүүдтэй шударга байдал, зөв хандлага, авлигаас ангид байхын учир холбогдлын талаар цуврал ярилцлагууд хийлгэх, шударга байх, зөв байх нь нэг удаагийн үйлдэл биш, амьдралын турш баримтлах зарчим, чанар болохыг тайлбарлан, ухуулах “Зөв дадал 20” чуулган болон уг аяны санааг дэмжсэн видео, аудио контентууд боловсруулах, зурагт хуудсыг бэлтгэх, түгээх олон акцыг нэгтгэн зохион байгуулав.

“Зөв дадал 20” дижитал чуулган. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд түгээн сурталчлав. Чуулганыг илтгэгчдээр сонгогдсон үзэл санааны удирдагчид амьдралдаа тохиолдсон явдал, бодит жишээ, түүнийг даван туулсан арга туршлага, өөрийн зөв дадлыг ажил, амьдралдаа хэрхэн мөрдлөг болгож байгааг мэдрүүлэх, тэдний зөв дадлаас залуус үлгэр жишээ авах боломжийг олгоход чиглэсэн болно. Илтгэгчдийн илтгэлээс хэлсэн гол санааг түүвэрлэн эшлэл бүхий, нэг загвартай постер хуудаснуудыг цувралаар оруулж, контентыг сурталчлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тус арга хэмжээг АТГ-ын болон бусад хамтрагч байгууллагууд, оролцогчдын нийт 10 орчим пэйж хуудсаар шууд дамжуулсан болно. Арга хэмжээний эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд зөвхөн АТГ-ын “Олон нийтийн төв” пэйж хуудасны шууд дамжуулалтын үзэлт 1000 гаруй хүнээс буугаагүй бөгөөд 120 минутын арга хэмжээ өндөрлөхөд нийтдээ 147,000 хүн үзэж, хүртээмж буюу тухайн цагт 350,000 гаруй хүнд мэдээлэл хүрсэн байна.

“Зөв дадал-20” дижитал чуулганыг

сурталчлах акц. Шударга ёсны үнэ цэнийг таниулах, нэг удаагийн үйлдлээр биш шударга байдлыг хэмждэггүй харин түүнийг дадал, хандлага, зарчим болгохын учир холбогдлыг олон нийтэд ойлгуулах зорилгоор үзэл санааны соён гэгээрүүлэгчдийг оролцуулсан чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр цахимаар зохион байгуулахтай холбогдуулан БШУЯ-тай хамтран 12 их, дээд сургуулиудын социал хуудас, группүүдээр дамжуулан оюутан залуус хүргэж, зөв хандлага, шударга байдалд уриалан, татан оролцуулах акцыг зохион байгуулав. Боловсролын байгууллагын багш, ажилтнуудыг цаашид авлигын эсрэг соён гэгээрүүлэх контент түгээхэд татан оролцуулах, зохион байгуулсан аян, акцийн хүрээнд хамтран ажилласан хамтын ажиллагааг тогтмолжуулж, мэдээлэл солилцох дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор “Зөв Зөвд Шударга Зөв” фейсбүүк групп (<https://www.facebook.com/groups/zuvzuv2021>)-ыг шинээр үүсгэж, гишүүдийг шинээр бүртгэж хамтран ажиллаж байна. “Зөв дадал 2020” цахим арга хэмжээний социал хаяг, хуудас хөтлөлтийн цогц байдлаар төлөвлөж, зохион байгуулсан бөгөөд “Зөв Зөвд Шударга зөв” аяны хүрээнд фейсбүүк группийг хөгжүүлж, арга хэмжээтэй холбоотой бүхий л мэдээллийг нийтэлж, нэгдсэн загвар дизайн боловсруулж, нийт 80 гаруй контент, 8 төрлийн видеог бэлтгэж албан ёсны хуудас болон твиттер болон инстаграм хуудсыг хамтад хөгжүүлэв. “Зөв дадал 20” арга хэмжээний хүрээнд эвэнт суваг хөгжүүлэлт 183 мянган хүнд хүрч, 1244 хүн мэдээлэл авсан. “Зөв зөвд шударга зөв” болон “Зөв дадал” 20 арга хэмжээний хүрээнд 14 хоногийн турш 80 гаруй пост хийгдэж, 700,000 гаруй хүнд фейсбүүк хуудасны мэдээллээр хүрсэн. Бүтэн нэг сарын хугацаанд бол 1,0 сая гаруй хандалтыг хамтрагч байгууллагуудын хуудсанд орсон пост бүрээр тооцвол давсан байна. Өнгөрөгч нэг сарын хугацаанд 5000+ дагагчдыг эгнээндээ нэгтгэжээ. Аяны уриа лого бүхий фэйсбүүк зургийн хүрээ (frame)-гээр нийтдээ 1000 гаруй хүн нүүр номынхоо зургаа сольж, аянд нэгдсэнээ илэрхийлсэн байна. “Зөв дадал-20” арга хэмжээний шууд дамжуулалтын үр дүнд “АТГ-Олон нийтийн төв” пэйж хуудаснаас гадна “Авлигатай тэмцэх газар” фэйсбүүк хуудаснаас давхар шууд дамжуулалт хийсний үр дүнд пэйж хуудасны дагагчдын тоо 2500,

дагагчдын тоо 2000 гаруйгаар өссөн байна.

World Learning байгууллагын (LEAD) хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах багийн “Сайн сургууль” төслийн багтай хамтран Нийслэлийн 2, орон нутгийн 1 сургууль дээр авлига, ил тод байдлын тухай ойлголт, хандлагын талаар хэлэлцүүлэг, сургалт, уралдааныг сургуулийн захиргаа, багш, сурагчид, эцэг эхийг хамруулан зохион байгуулсан.

“Зөв дадал-21” цахим арга хэмжээ. 2021 онд хүүхэд, багачуудад шударга ёсны үнэ цэнийг ойлгуулах, үнэт зүйлээ тодорхойлоход туслах, аливаа зүйлийн зөв, бурууг ялган таних, улмаар зөв хүмүүжил, зөв дадлыг бий болгох, үе тэнгийнхэндээ шударга ёсны үзэл бодлоо хуваалцах, нийгэмд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Зөв дадал-21” арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулав. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Шинэ үе авлигыг тэвчихгүй” цахим илтгэлийн уралдааныг зарлаж, уралдаанд 150 хүүхэд бүртгүүлэн оролцлоо. Оролцогчдыг цаг баримтлал, сонсогчид нөлөөлөх чадвар, биеийн хэлэмж, үг сонголт найруулга зүй, сэдвийн агуулга, сэдвээ эзэмшсэн байдал зэрэг 6 үзүүлэлтээр дүгнэж, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан зохион байгуулж буй “Good habits 21” арга хэмжээнд шилдэг 9 оролцогчийн илтгэлийг хэлэлцүүлэн орон даяар, фейсбүүк шууд дамжуулалтаар дамжуулан 3 дугаар шатны дүнг гаргасан.

“New generation-No corruption” илтгэх ур чадварын нээлттэй тэмцээн. Авлигатай тэмцэх газраас “Залуус өөрчлөлтийн төлөө үндэсний хөдөлгөөн”, “Хуулийн хөтөч” клубтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “New generation-No corruption” илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, уралдаанд түрүүлсэн зохиолуудаас шилдгийн шилдэг нэг зохиолыг сонгож “Brosis Pictures” кино компанитай хамтран цуврал, богино хэмжээний кино контентыг бүтээж байна. Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон

нутгийн төсвийн ил тод байдал” хакатон / тодорхой өгөгдсөн сэдвийн хүрээнд төрөл бүрийн мэргэжил, чадвартай хүмүүсээр үр дүнтэй багийг бүрдүүлэн, богино цаг хугацаанд шинэ санааг хөгжүүлж асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх нэг төрлийн уралдаант үйл ажиллагаа/-ыг зохион байгуулав.

Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 890 сурагчид, МСҮТ-ийн 220 оюутан, сурагчийг хамруулан 6 удаагийн сургалт, 3 хэлэлцүүлэг, 1 өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Мөн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд жүжигчилсэн тоглолтын уралдааныг амжилттай зохион байгуулсан. Жүжигчилсэн тоглолтоос харахад хууль тогтоомжийг уншиж судалсан байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс гарах арга зам, урьдчилан сэргийлэх чиглэлээр оновчтой агуулгууд тусгасан байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 320 хүүхдийн дунд шударга байдлын үнэлгээ хийж, 13 удаагийн сургалтыг “Ашиг сонирхлын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ, үндсэн механизм, шударга ёсонд хэрхэн суралцах вэ?” сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас “Шударга ёс” видео бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын 5-6 дугаар ангийн сурагчдын дунд ба “Авлига ба хүний эрх” гэрэл зургийн уралдааныг гэрэл зураг сонирхогч залуусын дунд тус тус зохион явуулсан бөгөөд дээрх уралдааны зорилго нь хүүхэд залуусын авлигыг харах өнцгийг гэрэл зураг, урлагаар дамжуулан гаргаж ирэх зорилготой байснаараа онцлог байв.

“Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил” арга хэмжээ. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шударга ёсны боловсрол, түүнд эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэх зорилгоор “Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил” чөлөөт уулзалтыг нийслэлийн 6 дүүргийн 10 сургуулийн эцэг эх, сурагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулав. 2022 онд уг арга хэмжээг үргэлжлүүлэн “Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил-2” чөлөөт уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн

төвд зохион байгуулав. Энэхүү арга хэмжээ нь энэ жил 2 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа ба өнгөрсөн жил Нийслэлийн төвийн 6 дүүргийн 10 сургуулийн 4-5 дугаар ангийн төлөөлөл 12 сурагч эцэг, эхийн хамт нийт 36 хүнийг хамруулан зохион байгуулж байсан бол энэ жил Авлигатай тэмцэх газрын “Шударга ёсны клуб”-ыг байгуулан ажиллуулж байгаа 7 сургууль тус бүрээс 6-8 дугаар ангийн 3 сурагч аав, ээжийн хамт мөн сургуулиудын сэтгэл зүйч нар, нийт 70 хүнийг хамруулав. Уг чөлөөт уулзалт зорилгодоо хүрч, амжилттай зохион байгуулагдсан ба 100 хувийн ирцтэй, гэр бүлүүд идэвхтэй оролцсон төдийгүй шилжилтийн буюу өсвөр насны хүүхдүүдэд төдийлөн анхаарч чадахгүй байгаа эцэг, эхчүүдэд хүүхэдтэйгээ хамт байх, тэднийгээ сонсох, хүүхдийнхээ шударга байдал, хүмүүжил, төлөвшилд чанартай цаг гаргаж тогтмол анхаарч байх ёстой гэдгийг мэргэжлийн багш, сэтгэл зүйч нартай хамтран тэдний оролцоонд тулгуурласан хэлбэрээр зохион байгуулсан нь нийт оролцогчдын талархлыг хүлээсэн.

“Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” өдөрлөг. Их, дээд сургуулийн оюутнуудад шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжих зорилгоор чөлөөт ярилцлага өрнүүлэх “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” нээлттэй өдөрлөгийг 4 үе шаттай зохион байгууллаа. 1 дүгээр үе шат арга хэмжээнд 13 их дээд сургуулийн 65 оюутан, 2 дугаар үе шат арга хэмжээнд чөлөөт индэр мэтгэлцээнд 27 оюутан, 3 дугаар үе шат арга хэмжээнд Монгол Улсын гавьяат зүтгэлтэн С.Цогтбаярын 32 бүтээл болон бусад хэрэглэгдэхүүнийг 2019-2021 оны авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн байдлыг харьцуулан үзэсгэлэн гаргаж “Залуучууд авлигыг тэвчихгүй” мэтгэлцээн зохион байгуулсан, 4 дүгээр үе шат арга хэмжээнд “Late Night Entertainment”-ийн “Late Night with Miko” шоу нэвтрүүлгийн 36 дахь дугаарыг хамтран бэлтгэв.

“Таны эрх, таны оролцоо-өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөг: Энэхүү арга хэмжээг 2022 онд Үндэсний батлан хамгаалах их сургууль, Дотоод хэргийн их сургууль, МУИС-ийн Бизнесийн

сургуулиудтай хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд 936 оюутан хамрагджээ.

“Шударга байх хамгийн гоё” сургалт арга хэмжээ: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа төрийн үйлчилгээний байгууллага болох Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбортой хамтран 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдөр тус цогцолборт амарч буй 500 хүүхдэд “Шударга байх хамгийн гоё” сургалт арга хэмжээг зохион байгуулав.

“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, халамжлах, нийгэмшүүлэх төв” төрийн бус байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр хаалттай хорих ангид хүмүүжиж буй залууст гэр бүлийн боловсрол олгох 2 удаагийн сургалт, Хувь хүний хөгжлийн болон шударга иргэн болж төлөвших тухай 4 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулжээ.

“Бодлогод залуусын оролцоо”, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” болон “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагуудтай хамтран улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагуудын худалдан авалтын дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний ил тод байдалд иргэдийн зүгээс хяналт тавих арга зүйд сургах, үр дүнтэй хяналт, оролцоог төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Орон нутгийн төсвөө хяная-BudgeThon” хакатон зохион байгуулав.

Ерөнхий боловсролын сургуулийн “Эцэг эхийн боловсролыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Боловсролын газрын мэргэжилтэн, нийгмийн ажилтан 60, БМДИ-ийн судлагдахуун хариуцсан арга зүйч 27, нийт 87 төлөөллийг сургагч багшаар бэлтгэн, арга зүйн зөвлөмж болон сургалтын модуль боловсруулан, сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургуулийн зүгээс эцэг эхийн боловсролыг дэмжих үйл ажиллагааг үндэсний хэмжээнд цувралаар зохион байгуулав.

Архангай аймаг Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд “Шударга ёс гэрэлт ирээдүйг бүтээнэ” цахим хичээлийн уралдаан, “Авлигыг өнгөөр илэрхийлбэл” гар

зургийн уралдаан, Батцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 105 сурагчдад Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн шторк, видео, контентыг танилцуулж, “Шинэ үеийн залуус шударга ёсыг юу гэж ойлгодог вэ?”, “Авлига гэж юу вэ?” богино хэмжээний видео бичлэгийн уралдаан зарлаж дүгнэв. Хүүхдийн цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн сурагчдын дунд “Шударга тоглоцгооё” дууны уралдаан зарлаж, нийт 30 хүүхэд оролцож эхний 3 байрыг шагнаж урамшуулсан.

Дорноговь аймаг соёл урлагаар дамжуулан хүүхэд залууст шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор аймгийн “Саранхөхөө” театртэй хамтран “ГЭРЭЛ АСАА”+14 нийгэмд тулгамдаж буй асуудлыг хөндөж үе тэнгийн болон хүүхдийн хүчирхийлэл, бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх мөн шударга ёс, хүнлэг сэтгэл, цахим орчны зөв зохистой хэрэглээнд өсвөр үеийн хүүхэд, залуус, эцэг, эхчүүдийг уриалан дуудсан ёс зүйн шоу драмыг зохион байгуулж 1600 гаруй хүнд хүргэсэн байна.

Их, дээд сургуулийн оюутнуудын дунд “Оюутны эрдэм шинжилгээний илтгэл, эсээ бичлэгийн уралдааныг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр амжилттай зохион байгуулав. Илтгэлийн уралдаанд 23, эсээ бичлэгийн уралдаанд 45 бүтээл ирсэн ба СЭЗИС-ийн Бизнесийн эдийн засгийн 3 дугаар курсийн оюутан А.Буянзаяа, П.Номуунзаяа, Т.Мөнхцэцэг нарын “Монгол Улсын авлигын өнөөгийн нөхцөл байдал макро эдийн засагт нөлөөлөх нь” сэдэвтэй илтгэл, “Отгонтэнгэр” их сургуулийн Хууль зүйн сургуулийн 2 дугаар курсийн оюутан А.Энхжингийн “Эргэж ирэхгүй амь насыг мөнгөөр бүү үнэлээч” сэдэвтэй эсээ шалгарсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.10.3-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсанаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд зохион байгуулах боломж

бүрдсэн. Энэ хүрээнд авлигын эсрэг сургалтыг хөтөлбөр, материалыг шинэчлэн, сэдвийг төрөлжүүлэн, практик жишээгээр баяжуулж сургалтад хамрагдагсдыг зорилтот бүлгээр нь ангилан сургалт зохион байгуулж байна. 2017 онд Авлигатай тэмцэх газарт Олон нийтийн төвийг нээн ажиллуулж, нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг албан тушаалын ангилал, эрхэлж буй ажил үүргийн онцлогтой нь уялдуулан, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэн, сургалтыг улирлаар төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Энэ хүрээнд Олон нийтийн төвд зохион байгуулсан сургалтад 2018 онд 8497, 2019 онд 4947, 2020 онд 1019, 2021 онд 179, 2022 онд 146 нийт 14,788 төрийн албан хаагчийг хамруулаад байна. Сургалтыг салбар, мэргэжил, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулсан нь шинэлэг байв. Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020, 2021 онд танхимын сургалтын тоо буурсан бол цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтын тоо нэмэгдсэн байна.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан, тодорхой сэдвээр нэг удаагийн сургалтыг зохион байгуулж 2018 онд 6286, 2019 онд 6381, 2020 онд 6855, 2021 онд 6,182, 2022 онд 5,889, нийт 31,593 иргэнийг хамруулсан байна.

Авлигын эсрэг сургалтыг зөвхөн нийтийн албан тушаалтнуудад бус оюутан, сурагч, эцэг, эх, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдэд зэрэг зорилтот бүлгүүдэд зориулан үе шаттайгаар зохион байгуулах, нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулж, зохион байгуулж, холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, 2017 онд Глоб Интернэшнл төв, “Мэдэх эрхийг хөхиүлэн дэмжих” төслийн хүрээнд “Ус дээшээ урсдаг” олон ангит киног ашиглан авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар кино сургалтыг Азийн сангийн санхүүжилтээр зохион байгуулсан бөгөөд нийслэлийн ЕБС-ийн Ирээдүй цогцолбор сургууль, 23 дугаар

сургууль, “Монгени” цогцолбор сургууль, “Хобби” сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчид болон МУИС, Хууль сахиулахын их сургууль, Их засаг Олон улсын их сургуулийн 237 оюутан, сурагчид сургалтад хамрагдсан байна. Багшийн хөгжлийн ордонд тус төслийн хаалт “Тусгал” нэртэй туршлага хуваалцах уулзалтыг зохион байгуулж, үр дүнг дүгнэсэн.

Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшлийн байгууллагад зориулсан сургалтын хөтөлбөрийг Азийн сан, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран боловсруулж, цуврал сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд сургалтын агуулгыг өөрчилж, хөтөлбөрийг шинэчлэн, хувийн хэвшлийн байгууллагуудаас “Шунхлай групп” удирдах болон гүйцэтгэх ажилтан, менежер “Таванбогд” ХХК-ийн ахлах болон удирдах ажилтан, 6.4.5 өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг зохион байгуулах хүрээнд МҮХАҮТ-ын дэргэдэх “Бизнесийн ёс зүйн төв”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж, хувийн хэвшлийн бизнесийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, 6 удаагийн сургалтад 245 хүнийг хамруулав.

Монголын бизнесийн зөвлөлөөс олон улсын туршлагыг судалж, хувийн хэвшлийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтын хөтөлбөрийг эхлүүлсэн. Түүнчлэн эдгээр сургалтын хөтөлбөрт тулгуурлан хувийн хэвшлийнхэнд зориулсан “Шударга ёс, хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо”, “Хувийн хэвшилд зориулсан авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, “Шударга ёс, хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо” гарын авлагыг боловсруулан хэвлэж, аж ахуйн нэгжүүдэд түгээв.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоодын санал санаачилга, хүчин чармайлтыг идэвхжүүлэх, өргөжүүлэх, бизнесийн орчин дахь авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангах, бизнесийн ёс зүйг дээшлүүлэх, цаашид хамтран ажиллах зорилгоор “Бизнес төс зүйг эрхэмлэнэ” уулзалтыг 2022 онд зохион байгуулав. Тус уулзалтад Монголын

худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн дарга, “Скайтел” ХХК-ийн хүний нөөц, хууль эрх зүйн албаны захирал, зөвлөлийн нарийн бичгийн дарга, Бодлого, стратегийн газар, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын зөвлөлийн гишүүн, “Мобиком корпораци” ХХК, “Хасу Мегаватт” ХХК нар оролцов. Мөн авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор хувийн хэвшлийн байгууллагуудтай 8 удаагийн уулзалт зохион байгуулж, авлигын хор хөнөөлийн талаар сургалт мэдээлэл өгч, хамтын ажиллагаанд татан оролцуулсан. Түүнчлэн Дорнод аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо”, Өвөрхангай аймгийн “Оновчтой шийдэл”, Дорнод аймгийн “Буйр нуур”, Ховд аймгийн “Ховдын толь сонин”, Орхон аймгийн “Эрдэнэт хүмүүний нийгэмлэг”, “Буурь нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн”, “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” зэрэг ТББ-ын төлөөлөлд авлигын эсрэг сургалт зохион байгуулав.

2020 онд Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт, төрийн албаны удирдах албан тушаалтан, худалдан авах алба, хуулийн хэлтэс, санхүү, дотоод хяналт, аудитын албан тушаалтнуудад зориулсан 5 төрлийн 20 сургалтын модулийг боловсруулсан. 2021 онд Төрийн байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүй, манлайллыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, таслан зогсоход чиглэсэн чадавхыг нэмэгдүүлэх 4 модуль, хуулийн асуудал хариуцсан албан тушаалтнуудад зориулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд

хуулийн асуудал хариуцсан албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах 4 модуль сургалтыг 5 өдрийн турш танхимаар зохион байгуулж нийт 179 алба хаагчийг хамруулсан. 2022 онд дээрх модулийн дагуу давтан сургалтыг зохион байгуулж, нийт 146 албан тушаалтныг хамруулсан байна. Тухайлбал, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтанд зориулсан сургалтад 54, төсөв санхүүгийн асуудал хариуцсан албан тушаалтанд зориулсан сургалтад 48, дотоод хяналт, аудитын асуудал хариуцсан албан тушаалтанд зориулсан сургалтад 44 албан хаагч тус тус хамрагджээ.

Төрийн болон нутгийн захиргааны төв болон тэдгээрийн салбар нэгж байгууллага дээр улсын хэмжээнд нийт 17,166 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгааг мэргэшүүлэх, чадваржуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангаж, “ЭБАТ-тай ярилцах” хөтөлбөрийг боловсруулж, онлайн уулзалт, ярилцлагыг хийж, фейсбүүк группээр дамжуулан харилцан мэдлэг, мэдээлэл, туршлага солилцож, мэдээлэл арга зүйгээр хангаж ажилласан. Шүүхийн ерөнхий зөвлөл, Гадаадын иргэн харьяатын газар, нийслэлийн Боловсролын газар, Ашигт малтмал газрын тосны газар, Улаанбаатар хотын Гаалийн газар, Ус сувгийн удирдах газар, Тагнуулын академи, Стандартчилал хэмжил зүйн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагын ЭБАТ-ууд зэрэг нийт 1,558 мэдүүлэг гаргагч болон удирдах албан тушаалтанд танхимын сургалт зохион байгуулж, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэдээлэл арга зүйгээр арга хангаж ажилласан. “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”-ыг шинэчлэн 7 дахь хэвлэл, загвар жишээ бүхий “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ын шинэчилсэн 6 дахь хэвлэлтийг шинэчлэн хэвлүүлж, холбогдох байгууллага, орон нутаг, мэдүүлэг гаргагч нарт түгээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан 29 тойргийн хорооны дарга болон нарийн бичгийн дарга нийт 160 гаруй

албан тушаалтныг хамруулан “Нэр дэвшигчийн ХОМ-ийг цахим системд мэдүүлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нэр дэвшигчдэд зориулсан гарын авлага боловсруулан түгээв.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтран “Иргэдэд зориулсан нээлттэй өдөрлөг”-ийг нийслэлийн 8 байршилд хийлээ. Арга хэмжээний үеэр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг 1,158 иргэнд сурталчилж, 70 иргэнээс өдөрлөгийн талаарх санал, сэтгэгдлийг сонсож, 14 төрлийн нийт 8,184 танилцуулга, ном, гарын авлагыг иргэдэд түгээж, иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгуулсан нь иргэдэд байгууллагын үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээ, мэдээлэл хүргэсэн, авлигын талаарх мэдлэг мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болов. (Биелэлт 100 хувь)

4.1.10.4-1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас 2019 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах сургагч багш бэлтгэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтран цагдаа, дотоодын цэргийн 65 алба хаагчийг сургагч багшаар бэлтгэж гэрчилгээ олгосон бол 2022 онд эдгээр сургагч багш нарын заах сургалтын сэдэв, агуулгыг өргөжүүлэх, кейс, жишээн дээр багаар ажиллах чадвар эзэмшүүлэх, харилцан туршлага солилцох боломж бүрдүүлэх зорилготой “Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаа” сэдэвт чадавхжуулах сургалтыг зохион байгуулав. Сургагч багш нараар дамжуулан давхардсан тоогоор нийт 96 удаагийн 266 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 15,710 алба хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтыг явуулсан байна.

Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулан “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион байгуулав. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын 57 албан хаагч хамрагдсан.

Хууль зүй дотоод хэргийн яам, “Нээлттэй нийгэм форум”-тай хамтран Эрүүгийн хууль тогтоомжийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд Боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүй зэрэг зорилтот салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүдийг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшаар бэлтгэх, чадваржуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх сургалтыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулав. Сургалтад Боловсролын салбарын Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, Монголын өмгөөлөгчдийн холбоо, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжлийн холбоод, эрүүл мэнд, сэтгүүл зүйн салбарын иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүд хамрагдаж, цахим гарын авлага, сургалтын материалаар хангав.

2021 онд Боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүйн салбарын иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг чадавхжуулах сургагч багшийн анхан шатны сургалтад хамрагдсан иргэдэд давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж, сургагч багшаар ажиллах болзол хангасан 7 иргэнд, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 37 ажилтныг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийн 5 удаагийн сургалтад тус тус хамруулж нийт 44 хүнд сургагч багшийн гэрчилгээ олгов. “Шударга ёсны боловсрол” номын агуулгын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад шударга ёсыг хэрхэн ойлгох, авлигын талаарх ойлголт өгөх зорилгоор нийт 827 сургагч багшийг бэлтгэж, жилийн эцэст явуулсан сургалт, сурталчилгааны ажлын тайлан хүлээн авч, дүн шинжилгээ хийх ажлыг хэвшүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2021 онд орон нутгийн хэмжээнд авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах 37 иргэнийг сургагч багшийн анхан шатны цахим сургалтад хамруулж, суралцагсдад гэрчилгээ олгосон ба орон нутгийн сургагч багш нарын заах сургалтын

сэдэв, агуулгыг өргөжүүлэх, кейс, жишээн дээр багаар ажиллах чадвар эзэмшүүлэх, харилцан туршлага солилцох боломж бүрдүүлэх зорилгоор сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг 2022 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Одоогийн байдлаар 35 сургагч багш тухайн орон нутгийн хэмжээнд авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд давхардсан тоогоор 2021 онд нийт 28,800, 2022 онд нийт 57,000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, авлигын эсрэг сурталчилгаа явуулж ажилласан байна. Сургагч багшийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, хэрэгжилтийг хагас жил, жил тутамд дүгнэн ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг сургалт, сурталчилгааг явуулах сургагч багш нарыг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох, сургалт сурталчилгааны ажлын үр дүнг үнэлэх чиглэлээр тогтмол эргэх холбоотой хамтран ажиллав. (Биелэлт 100 хувь)

4.1.10.5-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг олон улсын академи, “StAR” санаачилга”, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Авлигатай тэмцэх товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны Хээл хахуультай тэмцэх алба зэрэг байгууллагын улсын авлигатай тэмцэх сайн туршлага, оновчтой шийдлийн талаар судлан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тухайлбал, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) болон тус улсын Прокурорын дээд газраас зохион байгуулсан “Авлигын хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Шри Ланка Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон

далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Франц Улсад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан уулзалт, Египет Улсын Шарм Эль-Шейх хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон өөрчлөх тухай хэлэлцээрт оролцогч талуудын 6 дугаар хурал, Азербайжан Улсад зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хууль сахиулах сүлжээний уулзалтад, БНСУ-аас Азийн хөгжлийн банк, ЭЗХАХБ-тай хамтран зохион байгуулсан хурал болон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалтад АТГ-ын албан хаагчид тус тус оролцож, харилцан мэдээлэл солилцон, туршлагаа хуваалцсан байна. Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд АТГ-ын төлөөлөгчид зочилж, тус хороо, дүүргийн салбар нэгжийн үйл ажиллагаатай танилцан, тэдний сайн туршлагад тулгуурлан нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүд (Дүнжингарав, Саппоро, Оргил, Мишээл) авлигын эсрэг Иргэний хяналтын төвүүдийг байгуулан ажиллуулсан.

2020 онд “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалт, ахисан түвшний сургалт, “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинар, БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалт, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, 2021 онд “Иргэний нэхэмжлэлээр олон улсад хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт цахим сургалтад Авлигатай тэмцэх газрын 65 албан хаагч, 2021 онд “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл-Дарквек” богино хугацааны цахим семинар, “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт сургалтад АТГ, ЦЕГ, УЕПГ зэрэг хууль сахиулах байгууллагуудын албан хаагчийг

тус тус оролцуулсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн авлигын эсрэг сүлжээ, Ази номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээ, ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг гадаад улсын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн сургалтуудад албан хаагчдыг тогтмол хамруулж ажилласан. 2022 онд АТГ-аас гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулж, туршлага судлууллаа. Үүнд: Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-оос зохион байгуулсан «Санхүүгийн аудит хийх техник, стратеги» сэдэвт 2 удаагийн сургалт, АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох” сэдэвт 2 өдрийн сургалт, StAR санаачилгаас зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сэдэвт 4 өдрийн сургалт, “Виртуал валютын тухай ахисан түвшний семинар” сэдэвт 4 өдрийн сургалтад албан хаагчдаа хамруулсан.

2021 онд, Их дээд сургуулийн оюутнуудын авлигын эсрэг үзэл бодолд нь нөлөөлсөн Украин улсын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх зорилгоор их, дээд сургуулийн оюутнуудад шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх зорилгоор 13 их, дээд сургуулийн 65 оюутныг оролцуулан Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг 3 шторк(жүжигчин С.Ариунбямбын тоглосон “Үнэний үнэ цэнэ”, жүжигчин Б.Амарсайханы тоглосон “Чи бол Авлигатай тэмцэх газар”, “Төрийн албан хаагч Та...”)-ийг танилцуулан (reaction) видео контент хийж, олон нийтэд хүргэсэн. “Транспэрэнси Интернэшнл-Бангладеш” олон улсын байгууллагын Иргэдийн хяналт, оролцоо хариуцсан захирал хатагтай Ferhana Ferdous Бангладеш улсад амжилттай хэрэгжиж олон

улсад сайшаагдсан авлигын эсрэг иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах туршлагын талаар “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт туршлага судлах сургалт зохион байгуулж 89 иргэнийг хамруулсан. Бангладеш Улсын эцэг, эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12 дугаар сургуулийн сурагчид, эцэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгаа хийж, үр дүнг нэгтгэсэн.

“Хариуцлагатай ээжүүд” бүлгэмийг байгуулан хүүхдэд авлигын хор хөнөөлийг тайлбарлан таниулах, шударга зан үйлийг төлөвшүүлэх, багш нарын ёс зүй харилцаа хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулж, фейсбүүк групп нээснээр тухайн группэд 1879 ээж нэгдэн ажиллаж байна. “Хүүхдийн эерэг хүмүүжлийн аргуудыг ашиглаж, хүүхдийн өмнө зөв үлгэр дуурайлал үзүүлдэг байх” зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, 6-12 дугаар ангийн 379 ээж үзэл бодлоо илэрхийлэн, харилцан мэдээлэл солилцож, бие биеэсээ суралцсан. Бангладеш Улсын эцэг, эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг 3 дахь жилдээ нэвтрүүлж буй Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар дунд сургуулийн “Хариуцлагатай ээжүүд” бүлгэмийн үйл ажиллагаа, сайн туршлагыг Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын Ирээдүй цогцолбор сургууль, Өнөр цогцолбор сургууль, 62 дугаар дунд сургуульд түгээн дэлгэрүүлэх ажлыг эхлүүлээд байна.(Биелэлт 70 хувь)

Арван нэг. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 13 арга хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.11.1-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг үндэслэл болгож, гадаад улсын эрх бүхий байгууллагад эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг илгээхэд Хууль зүй, дотоод хэргийн яам болон Улсын ерөнхий прокурорын газар голлох үүргийг гүйцэтгэж байна.

2017-2022 онуудад Монгол Улсаас гадаад улсад илгээсэн 121 хүсэлтийн 43 буюу 35.5 хувь нь Авлигатай тэмцэх газраас бичсэн, үүний 31 буюу 72 хувь нь Авлигын эсрэг конвенцыг баримтлан илгээсэн хүсэлт байна.

Монгол Улсын талаас гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулахаар 2022 онд 17 хүсэлтийг хүргүүлсний дотор Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг конвенцыг баримтлан 4 хүсэлт бичсэн нь нийт хүсэлтийн 23.5 хувийг эзэлж байна. Авлигатай тэмцэх газраас бичсэн 2 хүсэлтийн хариуг холбогдох улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн байна.

Авлигын эсрэг НҮБ-ийн конвенцыг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон ашиглаж байгаа боловч Монгол Улсын дотоодын хууль тогтоомжид тодорхой зохицуулалтууд тусгагдаагүйгээс дараах хүндрэл бэрхшээл учирч байна.Үүнд:

а/Гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой процесс ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Тухайлбал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ” гэж заасан. Энэхүү заалтын “... хөрөнгө хураан авах” гэсэн ойлголтод “хөрөнгө буцаан авах ажиллагаа” багтаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 6, 34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд прокурор нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулсан ба прокурор энэхүү эрх болон Конвенцын заалтыг үндэслэн гадаад улсын шүүхэд нэхэмжлэл гаргах, түүнтэй холбоотойгоор эрх зүйн туслалцааны хүсэлт бичих зэргээр гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг хураан авах, битүүмжлэх, улсын орлого болгох ажиллагааг хийлгэх боломжтой.

Авлигын эсрэг конвенцын 53 дугаар зүйлд гэмтхэрэгүүлдэжолсонхөрөнгө,орлогыгбуцаан авахад иргэний эрх зүйн процессыг ашиглах, шүүхийн шийдвэр гаргахад шаардлагатай арга хэмжээг авах боломжтой байдлаар дотоодын хууль тогтоомжид тусгахыг гишүүн орнуудад үүрэг болгосон. Гэтэл Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний журмаар хэлэлцэхгүй” гэж заасан тул практикт прокурорын нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг шийдвэрлэгдсэний дараа гаргаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэгдээгүй байхад хөрөнгө буцаах асуудлаар эрх зүйн туслалцаа хүсэх бол түүнийг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт үндэсний хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

б/Гадаад улсад байгаа гэрч, хохирогч, шинжээчийн мэдүүлгийг видео хэлбэрээр авах, хэрэг хянан хэлэлцэх талаар эрх зүйн орчин бүрдээгүй байна. Авлигын эсрэг конвенцын 15 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт видео уулзалтын хэлбэрээр байцаалтыг явуулах, хэрэг хэлэлцэхийг зөвшөөрч, энэ талаар урьдчилан тохиролцож болохыг баталгаажуулсан боловч

дотоодын хууль тогтоомжид энэ талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

в/Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 49 дүгээр зүйлд “Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах” арга хэмжээг тусгасан. Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд олон улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтарсан, зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар зохицуулалт байхгүй байна. Мөн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг шуурхай хүргүүлж, гүйцэтгүүлэх, дотооддоо байгууллага хооронд нягт уялдаа холбоотой ажиллахаас гадна Конвенцын заалтад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал: ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ олон улсын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах журам боловсруулж батлуулах;

ФАТФ-ын Зөвлөмж 37/Эрх зүйн харилцан туслалцаа/, Зөвлөмж 38/Хөрөнгө царцаах, хураах/-ийг тус тус хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд УЕПГ, ГХЯ, ХЗДХЯ-аас харилцан мэдээлэл солилцох, тайлан мэдээ гаргах үйл ажиллагааны ил тод, аюулгүй, шуурхай байдлыг хангуулах зорилгоор боловсруулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”, бүртгэлийн маягтыг батлуулах;

Дээрх журамд тулгуурлан, гадаад улсад илгээсэн хүсэлтийн хариуг шуурхай авах, эрх бүхий төв байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажиллах, мэдээлэл солилцох “Хүсэлтийг хянах цахим мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох шаардлагатай байна.(Биелэлт 100 хувь)

4.1.11.1-2. Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх
/ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ 2018-2021/

Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, НҮБ-аас батлагдсан бусад олон талт гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох нь авлигатай тэмцэх ажилд чухал

түлхэц болохоор байна. Монгол Улс НҮБ-аас баталсан хүний эрхийн 43, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбарын 22, дипломат консулын эрх зүйн 4, гэмт хэрэгтэй тэмцэх 25 конвенц, протоколд нэгдэн орсон бөгөөд тэдгээр олон улсын гэрээ, конвенцод заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига албан тушаалын болон хар тамхитай холбоотой хэргүүд, хүн худалдаалах зэрэг үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр өргөн хүрээнд, үр дүнтэй хамтран ажиллах суурь эрх зүйн орчин бүрдсэн. Авлигын эсрэг конвенцын заалтад тулгуурлан, гишүүн орнуудтай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хийх боломжтойгоос гадна Монгол Улсын Засгийн газраас бусад оронтой байгуулсан 2 талт гэрээ, хэлэлцээрийн дагуу энэ ажиллагааг хийж байна.

Монгол Улс нь 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 36 улстай тодорхой чиглэлээр хоёр талт гэрээг байгуулаад байна. Үүнээс 16 улстай иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх нийтлэг гэрээ, 18 улстай эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, 16 улстай гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээ, 10 улстай ялтан шилжүүлэх гэрээг тус тус байгуулжээ. Эдгээрээс хөтөлбөр хэрэгжсэн 6 жилийн хугацаанд 9 улстай шинээр хоёр талт гэрээг соёрхон баталсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлыг 2019 оны 05 дугаар сарын 07-нд зохион байгуулсан. Ажлын хэсэгт Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газраас төлөөлөл оролцож, хурлын үеэр ялтан шилжүүлэх үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээлээс гадна дараах асуудлуудын талаар хэлэлцсэн. Үүнд:

- БНХАУ-аас ялтан шилжүүлэн авах ажиллагаа удаашралтай буй талаар;
- БНХАУ-аас шилжүүлэн авсан ялтанд Монгол Улсын шүүхээс дүйцүүлэн оногдуулсан ялын хэмжээ БНХАУ-ын шүүхээс оногдуулсан ялын хэмжээнээс зөрүүтэй байгаа байдал нь БНХАУ-ын талаас ялтан шилжүүлэн өгөх ажиллагаанд нөлөөлж буй талаар;

- Ялтан шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэхэд ШШГЕГ-аас ирүүлж буй албан бичигт мэдээлэл дутуу байх, дутуу мэдээллийг ХЗДХЯ-аас ГХЯ-нд нөхөж мэдээлэхэд хугацаа тулгамдах тохиолдол гарч буй талаар;
- Зарим ялтны ар гэртэй холбогдох холбоо барих утас, бусад суваг тодорхой бус байгаагаас төлбөр болон ялтны бусад мэдээллийг дамжуулахад хүндрэлтэй байгаа зэрэг болно.

Мөн хурлын үеэр эрх зүйн туслалцааны хүсэлт, ялтан шилжүүлэх ажиллагааны холбогдох баримт бичгийн орчуулгын ажил, орчуулгын зардлын асуудал, мөн эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх ажлын хүрээнд холбогдох хүсэлт, баримт бичгийн нэгдсэн бүртгэлийн талаар хэлэлцсэн болно. Ажлын хэсгийн гишүүд хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал боловсруулж ажиллахаар тохиролцож, хурлын үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан. Цаашид шинээр байгуулах гэрээнд албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын гэмт хэрэгтэй холбоотой заалтыг тусгаж ажиллахаар болсон.

БНХАУ, Монгол Улсын хооронд 1989 онд байгуулсан “Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэж, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Хууль Зүйн Яам, Ардын Дээд Прокурорын Газар, Ардын Дээд шүүхтэй хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах ажиллагаа”-ны талаарх цахим хуралд Улсын ерөнхий прокурорын газраас оролцож, “БНХАУ-д илгээж, хариу ирүүлээгүй хүсэлтийн судалгаа”-г гарган, шийдвэрлүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Цахим хурлын үеэр хятадын талаас тус улсад хорих ял эдэлж буй Монгол Улсын 4 иргэнийг ойрын хугацаанд шилжүүлэн өгөхөөр шийдвэрлэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Нийслэлийн шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны Консулын хэлтэс зэрэг байгууллагыг оролцуулан, “Ялтан шилжүүлэх асуудлаарх эрх

зүйн зохицуулалт"-ын талаар цахим хурал хийж, хамтран ажилласан байна.

Монгол Улсын нэгдэн орсон 2 талт гэрээний ихэнхийг хуучин социалист тогтолцоотой байсан Ази, Европын орнуудтай байгуулсан тул орчин цагийн эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны төрөл, хэлбэр хоцрогдсон, хэт ерөнхий заалттай байна. Энэ байдал нь Авлигын эсрэг НҮБ-аас конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц зэрэг олон талт гэрээ, конвенцуудад тусгасан тодорхой заалтаар нөхөгдөн хэрэгжиж байна.

Гадаад улсын эрх бүхий байгууллагатай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлэн нотлох баримт цуглуулах, тухайн улсын нутаг дэвсгэрт тодорхой мөрдөн шалгах ажиллагааг явуулах, мэдээлэл, баримт авах, өгөх, хавтаст хэргийн материалыг хүргүүлж, шалгуулж шийдвэрлүүлэх, шилжүүлэн авсан хэргийг шалгаж шийдвэрлэх, хөрөнгө хураан авах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх зэргээр харилцан туслалцаа үзүүлэх боломжтой ерөнхий заалтууд дотоодын хууль тогтоомжид тусгагдсаныг боловсронгуй болгох шаардлага байна.

Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд, дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

1. Монгол Улс 1959 оны Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын Холбооны Конвенц, 2001 оны Цахим гэмт хэргийн тухай Конвенц, Зүүн Өмнөд Азийн орнуудын эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ зэрэг бүс нутгийн олон талт гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох замаар хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг судалж шийдвэрлэх хэрэгтэй. Эдгээр олон талт болон бүс нутгийн гэрээ, конвенцод нэгдэн орсноор тухайн гэрээ, конвенцын гишүүн орон тус бүртэй улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны хүрээнд шуурхай хамтран ажиллах, хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг явуулах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх, электрон нотлох баримт солилцох эрх зүйн орчин бүрдэх болно.

2. Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц, НҮБ-ын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг хариуцан зохион байгуулах бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгох, үйл ажиллагааны дүрэм журам, зааврыг боловсруулж гаргах шаардлагатай.

3. ФАТФ-ын Зөвлөмж 37/Эрх зүйн харилцан туслалцаа/, Зөвлөмж 38/Хөрөнгө царцаах, хураах/, Зөвлөмж 39/Гэмт хэрэгтэн шилжүүлэх/-д заасан "Хүсэлтийн удирдлагын систем" болон "Эрүүгийн шийтгэлгүйгээр хөрөнгө хураах" талаар дотоодын эрх зүйн орчныг бий болгох.

4. Олон улсын эрх бүхий байгууллагуудын сүлжээ, холбоонд нэгдэн орох замаар хамтын ажиллагааг үр дүнтэй шуурхай хэрэгжүүлэх.

Дүгнэж хэлбэл, одоо байгаа гэрээ, хэлэлцээрийг шинэчлэх ажлаас илүү нэгдэн орсон гэрээ, конвенцод дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэн боловсронгуй болгох ажил тулгамдаж байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1-44.4 дүгээр зүйл, Прокурорын тухай хуулийн 26-30 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг солилцох ажиллагааны талаар тусгасан. Түүнчлэн тухайн хүсэлтийг хүлээн авагч оронтой ямар нэгэн гэрээ байгуулаагүй, эсхүл олон улсын гэрээнд талуудын аль нэг нь гишүүнээр элсэн ороогүй тохиолдолд "reciprocity" буюу харилцан ижил төрлийн туслалцаа үзүүлэх зарчмын дагуу хамтран ажиллах талаар Прокурорын тухай хуулийн 26 дүгээр зүйлд заасан.

Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлд "олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага нь прокурорын төв байгууллага" буюу УЕПГ байхаар заасан бол нөгөө талаас, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 2 талт олон улсын гэрээнд ХЗДХЯ, зарим тохиолдолд "эрх бүхий төв байгууллага" байхаар заасан тул хуулийн заалтыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар ХЗДХЯ-тай нэгдсэн байр суурьт хүрэх хэрэгтэй байна. (Биелэлт 100 хувь)

4.1.11.1-3. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх /ХЗДХЯ, УЕПГ, 2017-2022/

Өнгөрсөн хугацаанд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудаас сургалт, хэлэлцүүлгүүдийг тогтмол зохион байгуулж иржээ. Тухайлбал, АТГ-аас “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтарч, 2018 онд эрх зүйн туслалцааны хүсэлт, гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг буцаах, мөнгө угаах сэдвээр, 2019 онд мөнгө угаах, хулгайлагдсан хөрөнгийг буцаах чиглэлээр хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сургалтыг тус тус зохион байгуулсан.

Мөн 2019 онд УЕПГ-аас Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлтийг хэрхэн зөв, үндэслэлтэй боловсруулах талаар сургалт, мөн нийслэл, төвийн 6 дүүргийн прокурорын газруудын прокурор, туслах ажилтнуудад “Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхэд анхаарах асуудал”, “Гэмт этгээдийг шилжүүлэн авах ажиллагаа” сургалтыг зохион байгуулсан бол ХЗДХЯ-аас жил бүр Монгол Улсаас гадаад улсад томилогдон ажиллах дипломат ажилтнуудад зориулсан “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” сэдвээр сургалт зохион байгуулсан.

АТГ-аас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлсэн.

Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын

19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна. Дээрх аргачилсан заавар батлагдсантай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын газраас харьяа нэгж прокурорын газруудын хэмжээнд аргачлал, зааврын талаар дотоод сургалт, мэдээлэл зохион байгуулав. 2019 онд Улсын ерөнхий прокурорын газраас эрх зүйн туслалцааны хүсэлт бэлтгэн боловсруулж байгаа прокурор, мөрдөгч нарт тусгайлан анхаарах асуудлуудын талаар тайлбарлах, заавар чиглэл өгөх зэргээр гадаад улсад илгээхээр төлөвлөсөн эрх зүйн туслалцааны 6 хүсэлтэд практик зөвлөмж өгч ажилласан.

Улсын ерөнхий прокурорын газраас ОХУ-ын Ерөнхий прокурорын газарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр тавьсан тодорхой саналуудыг үндсэн дээр Монгол Улсын прокуроруудыг ОХУ-ын Эрхүү хотод жил бүр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байхаар харилцан тохиролцжээ. Түүнчлэн Улсын Ерөнхий прокурор тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын газрын Ерөнхий прокурорын урилгаар 2019 оны 11 дүгээр сард БНХАУ-д ажлын айлчлал хийж, “Монгол Улсын ерөнхий прокурорын газар, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ»-г байгуулав. Энэхүү гэрээгээр Монгол Улсын прокуроруудыг БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын дэргэдэх Эрх зүйн академид жил бүр мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах, хил залгаа муж, аймгийн прокурорын газруудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн. Ялангуяа хоёр орны хооронд эрх зүйн туслалцааны хүсэлтийг цахим хэлбэрээр хүргүүлэхээр тохиролцсон нь энэхүү ажиллагааг шат дамжлага багатай, түргэн шуурхай гүйцэтгэхэд нэн чухал алхам болсон. 2019 оны 10 дугаар сард ОХУ-ын Эрхүү муж дахь Прокурорын их сургуульд 5 прокурор, мөн оны 11 дүгээр сард БНХАУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 30 прокурор тус тус хамрагдсан байна.

2021 онд шинэчлэн баталсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ыг нийт

прокуроруудад таниулах, нэг мөр хэрэгжүүлэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр прокуроруудыг сургах зорилгоор УЕПГ-ын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсээс 2021.06.02-ны өдөр аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын нийт прокуроруудыг хамруулсан цахим сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн тус байгууллагатай хамтран 2021.04.13-ны өдөр "Иргэний процессын дагуу хөрөнгө буцаах ажиллагааг зохион байгуулах, прокурорын нэхэмжлэлийг гадаад улсад илгээх" сэдэвт цахим уулзалт, хэлэлцүүлгийг УЕПГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, харьяа прокурорын газрын дээд шатны прокурор, шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан прокурорууд зэрэг нийт 100 орчим прокурорыг хамруулан зохион байгуулсан байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2021.12.24-ний өдөр УЕПГ болон нийслэл, дүүргийн прокурорын газрын 50 прокурорт "Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтын үеэр УЕПГ-ын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсээс "Олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн туслалцаа, хөрөнгө буцаах ажиллагаа" сэдвээр сургалт хийсэн байна.

2022 онд ХЗДХЯ-аас албан хаагчдыг мэргэшүүлэх, чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд анхаарч, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран хэрэгжүүлж буй "Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чадамжийг дээшлүүлэх" төслийн хүрээнд: 2020 оны 10-р сараас эхлэн "Мөнгө угаах, хил дамнасан гэмт хэрэг болон авлигатай тэмцэх" сэдэвт цуврал сургалтыг Холбооны санхүүгийн хяналтын хороо (BaFin) болон Холбооны цагдаагийн дээд сургуультай тус тус хамтран зохион байгуулж байна. Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны "Хулгайлагдсан хөрөнгө буцаан авах санаачилга" (СТАР хөтөлбөр)-тэй ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга СТАР хөтөлбөрийн Монгол Улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хөтөлбөрийн удирдагч, сургагч багш нарын

уулзалтыг 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын мөрөөр СТАР хөтөлбөрөөс 2022 оны 5 дугаар сарын 9-12-ны өдрүүдэд зохион байгуулсан "Санхүүгийн мөрдлөг" сэдэвт сургалт, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан "Удиртгал: хөрөнгийн менежмент" сэдэвт сургалт, 2022 оны 10 дугаар сарын 10-12-ны өдөр зохион байгуулсан "Хөрөнгө хураан авах, буцаан авах болон түүний менежмент" семинарт АТГ, УЕПГ, Дотоод хэргийн их сургуулийн багш нэр, Эрүүгийн цагдаагийн алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагын албан хаагчид хамрагдсан.

Мөн онд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр УЕПГ-аас албан хаагчдыг мэргэшүүлэхэд анхаарч байгууллага дангаар болон бусад байгууллагатай хамтарсан сургалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр мөрдөгч нарт зориулсан "Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхэд анхаарах асуудал" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

- УЕПГ нь нэгж прокурорын газрууд, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас гадаад улсад хүргүүлж буй эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг урьдчилан авч хянах замаар гаргасан алдааг засуулах, прокурор, мөрдөгчид зөвлөгөө өгөх зэргээр эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах шаардлагыг хангуулан ажиллаж байна.

- НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газар, Дэлхийн банкны хамтарсан "Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга" /СТАР/ олон улсын байгууллагатай хамтран 2022 оны 2, 4, 10, 11 дүгээр саруудад зохион байгуулсан "Санхүүгийн мөрдлөг", "Виртуал валютын тухай ахисан түвшний семинар", "Хураан авсан хөрөнгийн менежмент" сэдэвт сургалтад нийт 18 прокурор,

- "СТАР" байгууллагаас 2022 оны 06, 10 дугаар сард зохион байгуулсан "Гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгийн менежмент, хөрөнгө буцаах ажиллагаа" сэдэвт 2 цагийн цахим сургалт, "Хураан авсан хөрөнгийн менежмент" сэдэвт 3 өдрийн ахисан түвшний сургалтад 3

прокурор тус тус хамрагдсан.

- АНУ-ын Төрийн департаментаас 2022 оны 2, 3, 6 дугаар саруудад “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах бодистой холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх” сэдвээр нийт 4 удаа зохион байгуулсан сургалтад 26 прокурор оролцсон байна.

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн хүрээлэн болон КОЙКА байгууллагатай хамтран “Монгол Улсын Прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь 2022-2024” төслийн хүрээнд 2022 оны 06 дугаар сард зохион байгуулсан “Үндэстэн дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагаа” сэдэвт цахим сургалтад харьяа нэгж прокурорын газрын нийт 20 прокурор хамрагдсан.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, хар тамхитай тэмцэх албанаас 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Үндэстэн дамнасан кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд хөрөнгө буцаан авах олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт мэдээлэл хийх онлайн уулзалт, Баруун болон Төв Азийн Хөрөнгө буцаан авах сүлжээ байгууллага /ARIN-WCA/-ын Нэгдсэн цахим хуралдаан, сургалтын “Гишүүн орнуудын хууль бус хөрөнгийг буцаан авах талаарх танилцуулга” салбар хуралдаанд /ажиглагчийн хувиар/ тус тус 1 прокурор оролцлоо.

- Бүгд Найрамдах Солонгос Улсад 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Үндэстэн дамнасан гэмт хэргийг шийдвэрлэх: Олон улсын хамтын ажиллагаа” сэдэвт Олон улсын прокуроруудын холбооны Анхдугаар сургалт; “Хөрөнгө буцаах ажиллагаа” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн “АРИН-АП” сүлжээ байгууллагын 7 дахь удаагийн сургалт; Шинэ Зеланд Улсын Квинстаун хотноо 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Өнөөдрөө аваръя: Криптовалют ба үйл ажиллагааны туршлага” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн “АРИН-АП” сүлжээ байгууллагын нэгдсэн хуралдаан, сургалтад тус тус 1 прокурор оролцсон.

Улсын ерөнхий прокурорын тушаалаар “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон

хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ыг шинэчлэн боловсруулж, зааврын хэрэгжилтийг хангуулахаар давтамжтай сургалтуудыг зохион байгуулсан нь үр дүнтэй болсон.

Мөн Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны чиглэлээр Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” гарын авлага, “Монгол Улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ”-ний эмхэтгэлийг прокуроруудын албан хэрэгцээнд зориулан хэвлүүлсэн.

Цаашид эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр прокурорыг мэргэшүүлэх, сургалтыг тогтмол зохион байгуулах, гадаад орны туршлагыг судлах шаардлага, хэрэгцээ хэвээр байна.(Биелэлт 100 хувь)

4.1.11.1-4.Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, бусад материалын орчуулгын зардлын асуудлыг ГХЯ-ны “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-д тусгуулах саналыг ХЗДХЯ-аас гаргаж, Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтын 4.3.8-д “гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан Монголын талын төв байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах” талаар заажээ.

Гэвч эрх зүйн харилцан туслалцааны зарим хүсэлтийг орчуулахтай холбоотой зардлыг тухайн илгээж байгаа байгууллага хариуцан гаргах тохиолдол элбэг байна. Энэ асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулах үүрэг бүхий

Ажлын хэсгийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар авч хэлэлцсэн. Энэхүү ажлын хэсгийн хурлаар Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газрын холбогдох албан тушаалтнууд ажил хэргийн уулзалтыг зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байх талаар санал солилцсон.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хэн бичих, орчуулгын зардлыг хэрхэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт тодорхой зохицуулалт байхгүй. Мөн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д "Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал" гэж заасны дагуу Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэрэгт гадаад улсад тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, түүнтэй холбоотой материалыг орчуулахтай холбоотой зардлыг хамааруулж болохоор байна. Харин гадаад улс орноос эрх зүйн туслалцаа хүсэж, ирүүлсэн хүсэлт, даалгавар, холбогдох материалыг орчуулах, уг хүсэлт, даалгаврыг биелүүлэх хүрээнд цуглуулж бэхжүүлсэн баримт, материал, тэдгээрийг буцаан хүргүүлэхтэй холбоотой зардлыг тооцох, санхүүжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй, тус зардал Прокурорын байгууллагын төсөвт тусгагддаггүй байна. Практикт уг зардлыг даалгавар, хүсэлтийг гүйцэтгэж буй мөрдөн шалгах байгууллагаас гаргуулж байгаа нь холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдаагүй байх тул хүндрэлтэй асуудал дагуулж байв.

Дээр дурдсан байцаан шийтгэх ажиллагааны зардалд төсөвлөгдсөн хөрөнгийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцох, эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт даалгавар, бусад материалыг орчуулах зэрэгт зарцуулдаг. Прокурорын байгууллагын 2020 оны төсөвт байцаан шийтгэх ажиллагааны зардалд 291 сая төгрөг төсөвлөсөн бол 2021 онд төсөвлөгдсөн 498.9 сая төгрөгөөс 391.6 сая төгрөгийг зарцуулсан байв.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардагдах зардлыг улсын төсөвт буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд тусгадаг болсон байна. Цаашид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон орчуулгатай холбоотой зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай.(Биелэлт 100 хувь)

4.1.11.2-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын өөрийн үнэлгээний тайланг боловсруулж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэн, тайланг хамгаалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх /АТГ, ХЗДХЯ, УЕПГ, СЯ, ГХЯ, ТАЗ, Монголбанк 2017-2022/

Монгол Улсын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг үнэлүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн тушаалаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд тайлагнах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг тус Конвенцын 2, 5 дугаар бүлгийн зүйл, заалт, дэд заалт тус бүрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэж, 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд холбогдох тайлангийн системээр дамжуулан илгээв.

2022 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд тус алба болон энэхүү үнэлгээг хариуцан хийх Сингапур, Буркино Фасо Улсын шинжээчид Улаанбаатар хотод ажиллаж, холбогдох байгууллагын төлөөллүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Гадаад улсын шинжээчдийн хүссэн холбогдох мэдээллийг цуглуулж, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлсэн. 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Монгол Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн хураангуй тайлан эцэслэгдэн батлагдсан.(Биелэлт 70 хувь)

4.1.11.2-2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Авлигатай тэмцэх үйл ажиллагааны Станбулын төлөвлөгөөний тайланг гаргаж хүргүүлэх, тайлагнах, хамгаалах /АТГ 2017-2022/

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн

байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийх зорилгоор 2003 онд байгуулагдсан. Уг төлөвлөгөөгөөр Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц болон бусад олон улсын стандарт, сайн засаглалын туршлагын хэрэгжилтийг хангахад шаардлагатай зөвлөмжийг шат дараатайгаар хийсэн үнэлгээний үндсэн дээр боловсруулан гаргаж, гишүүн улсуудын авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа шинэчлэлийг дэмжих зорилготой юм.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн билээ. Үнэлгээний цар хүрээ нь авлигатай тэмцэх байгууллага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дотоод хяналт шалгалт, дотоод аудит, шүүх, прокурорын байгууллага, хувийн хэвшил зэрэг байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа, эрх зүйн орчноос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх асуудлуудыг хамарсан.

АТГ-аас тус Сүлжээнээс 2014, 2015, 2019 онуудад зохион байгуулсан 2, 3, 4 дүгээр шатны хяналт-шинжилгээнд хамрагдаж, авлигын эсрэг орчноо үнэлүүлсэн бөгөөд холбогдох тайлангийн дүнг олон нийтэд танилцуулсан.

2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Авлигын эсрэг сүлжээний 25 дахь удаагийн Удирдах зөвлөлийн уулзалт болж, энэхүү цахим хуралд тус байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Нарийн бичгийн даргын газар, тус Сүлжээний гишүүн орнууд, донор байгууллагын 95 төлөөлөгч оролцсон. Хурлын хөтөлбөрийн дагуу Авлигын эсрэг сүлжээний гишүүн улсуудын авлигын эсрэг орчинд хийх үнэлгээний 5 дугаар шатны талаар оролцогч талууд санал солилцов. Хурлын үеэр гишүүн улсуудын авлигын эсрэг орчинд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг оролцогч нар эцэслэн баталсан.

Тус сүлжээ нь 2020-2024 онд гишүүн

орнуудын авлигын эсрэг орчныг үнэлэхдээ шинэ аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөхөөр болсон бөгөөд энэхүү шинэ аргачлалын дагуу Монгол Улсын авлигатай тэмцэх бодлого, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой хуулийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилт, шүгэл үлээгчийг хамгаалах, шүүх байгууллагын хараат бус байдал зэрэг 13 шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын авлигын эсрэг орчныг 2023 онд үнэлэх юм. (Биелэлт 100 хувь)

4.1.11.2-3. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран төсөл хэрэгжүүлэх /АТГ 2017-2019/

АТГ-аас 2017 оны 4 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус санаачилгаас ирүүлсэн хамтын ажиллагааны шинэ төсөлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлсэн. Үүнээс дараа “StAR” санаачилгатай хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтарсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулав. Энэ хүрээнд 2018 оны 04 дүгээр сард хууль сахиулах байгууллагуудын дундах “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж, “Хөрөнгө буцаах гарын авлага”-ын төслийн талаар хэлэлцэж, байгууллагуудын саналуудын нэгтгэсний үндсэн дээр эцсийн хувилбарыг УЕПГ бэлтгэн, батлахаар болсон. “StAR” санаачилгатай хамтран 2018 онд хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт”, мөн хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн стратеги, менежмент семинар” зохион байгуулсан. “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдох санал боловсруулж, ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээнээс жил бүр

гишүүн орнуудаас хүргүүлдэг. Авлигын эсрэг үйл ажиллагааны явцын тайлан болон орон нутаг дахь авлигын асуудлаар мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн.

Түүнчлэн тус Санаачилгатай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчдыг хамруулан хөрөнгө царцаах, хураах, хөрөнгө буцаах, олон улсын хамтын ажиллагаа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ахисан түвшний арга хэрэгслүүд зэрэг сэдвээр “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”-ыг, 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

2020 оны 4, 5 дугаар сард “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт ахисан түвшний цахим сургалтыг 3 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, Авлигатай тэмцэх газрын 18 мөрдөгчийг хамруулав. Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга(StAR)-аас Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтсийн нийт мөрдөгчдөд зориулан “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох 33 албан хаагчийг хамруулсан.

2021 онд АТГ-аас дээр дурдсан санаачилгатай хамтран АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 400 гаруй албан хаагчийг хамруулан 2021 онд “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл - Дарквеб” богино хугацааны цахим семинарыг тус тус зохион байгуулсан.

Тус санаачилгаас 2022 оны 5 дугаар сард зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт 4 өдрийн, “Удиртгал: хөрөнгийн менежмент” сэдэвт сургалт, «Хөрөнгө хураан авах, буцаан авах болон түүний менежмент» сэдэвт 3 өдрийн семинарт АТГ, УЕПГ, Дотоод

хэргийн их сургуулийн багш нэр, Эрүүгийн цагдаагийн алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагын албан хаагчид хамрагдсан.(Биелэлт 100 хувь)

4.1.11.2-4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай сургалт, семинар зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Австри Улсад болсон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалт, БНХАУ-ын Хонгконг мужид зохион байгуулагдсан “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Гүрж улсад зохион байгуулагдсан “Авлигын эсрэг сургалт”-д тус тус хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл оролцов. Мөн АТГ-аас тус байгууллагатай хамтран 2017 оны 5 сард Улаанбаатар хотноо “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт гурван өдрийн сургалт, 2017 оны 9 дүгээр сард “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт гурван өдрийн сургалтыг тус тус хамтран зохион байгуулсан.

АТГ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалт зохион байгуулж, хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагчдыг хамруулсан. Мөн тус байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг Монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээсэн.

2019 оны 5 дугаар сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага болон Цагдаагийн ерөнхий газраас хамтран зохион байгуулсан “Цахим мөнгөн тэмдэгтийг ашиглан гэмт хэрэг үйлдэх явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалт, 2019 оны 10 дугаар сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан “Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх туршлага солилцох нь” сэдэвт семинарыг тус тус зохион байгуулж, АТГ, Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч, хяналтын прокурорууд оролцсон.

2021 онд ГХЯ-аас ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Сонгуулийн асуудал эрхэлсэн газрын дэд захирал, зөвлөх нарын 2020 онд манай улсад хийсэн ажлын айлчлалд дэмжлэг үзүүлэв. Энэ үеэр төлөөлөгчид АТГ-ын удирдлагуудтай уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон. (Биелэлт 100 хувь)

4.1.11.3-1. Гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулах, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулах /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2019-2020/

АТГ нь 2016-2019 оны хооронд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Авлигын эсрэг олон улсын академи, Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбоо, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох StAR санаачилга, ЭЗХАХБ, ЕАБХАБ, Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департамент, Холбооны мөрдөх товчоо, Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Хонгконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, БНКУ, Азербайжан Улсын Авлигын эсрэг газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцаагаа өргөжүүлэн, хөгжүүлж ирсэн.

Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд Швейцарын Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийж, эрүүгийн хэрэг хамтран мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож байна.

Мөн АТГ нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын

санамж бичиг байгуулсан.

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийн 7 дугаар зүйлд авлигатай тэмцэх асуудлаар АНУ-тай хамтран ажиллах эрх зүйн хүрээг тодорхойлов. Энэхүү хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болсон. Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд: "5. Талууд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэхэд бүс нутгийн болон олон улсын санал санаачилга чухал болохыг хүлээн зөвшөөрнө. Талууд олон улсын хурал чуулганд холбогдох санал санаачилгыг урамшуулан дэмжих талаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ" гэж тусгасан бөгөөд цаашид уг асуудлаар АНУ-тай цаашид нягт хамтран ажиллана. Түүнчлэн ХБНГУ-ын энэ төрлийн байгууллагатай туршлага солилцох, сургалт зохион байгуулах ажлыг судалж байна. ГХЯ-аас Дипломат төлөөлөгчдийн газруудад суугаа орны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага тооцох сайн туршлагыг судалгаа хийж ирүүлэх үүргийг тус яамнаас хүргүүлсэн.

2019 онд УЕПГ нь Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

2019 оны 07 дугаар сард "Монгол Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын 2020-2021 оны хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийг харилцан гарын үсэг зурж, батлав.

2019 оны 11 дүгээр сард "Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар, БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын Газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулав. Энэхүү гэрээгээр хоёр орны хооронд байгуулсан эрх зүйн туслалцааны хүсэлтийг цахим хэлбэрээр шууд илгээж байх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад тогтмол хамруулах, хил залгаа муж, аймгийн прокурорын газруудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн. Ялангуяа хоёр орны хооронд эрх зүйн туслалцааны хүсэлтийг цахим хэлбэрээр хүргүүлэхээр тохиролцсон нь энэхүү ажиллагааг шат дамжлага багатай, түргэн шуурхай

гүйцэтгэхэд нэн чухал алхам болсон.

“Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яамны харьяа Хорих байгууллагын удирдах газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”;

“Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Бүгд Найрамдах Беларусь Улсын Шүүхийн шинжилгээний улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” -ийг тус тус байгуулсан.

1. ОХУ-ын Москва хотод 2019 онд зохион байгуулагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Евроазийн бүсийн байгууллагын 30 дахь удаагийн хуралд Улсын ерөнхий прокурорын газрын прокурор оролцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ажиллагааны хэв шинж, эдгээр гэмт хэргийг илрүүлэхэд учирч байгаа бэрхшээлийн талаар бусад улсын прокуроруудтай санал солилцож, туршлага судалсан.

УЕПГ болон БНХАУ-ын Дээд прокурорын газар хооронд 2017 онд байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”, 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээ”-ий хүрээнд тус газар нь 2021 онд БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Прокуроруудын үндэсний академийн болон БНХАУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн төрийн албан хаагчдад зориулсан сургалтад Монголын прокурор, ажилтнуудыг хамруулах, мөн эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар харилцан мэдээлэл солилцох, шууд харилцах цахим сувгийн талаар мэдээлэл солилцсон байна. Мөн хамтын ажиллагааны хүрээнд хил орчмын прокурорын газар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор БНХАУ-ын Ард Улсын Ардын Дээд прокурорын газрын Олон Улсын хамтын ажиллагааны газартай хамтран ӨМӨЗО-ны Ардын прокурорын газар, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар аймгийн прокурорын газруудыг оролцуулсан

онлайн уулзалтыг зохион байгуулсан.

Түүнчлэн НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас 2021 оны 03 дугаар сард Япон улсын Киото хотод зохион байгуулсан «Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх НҮБ-ын XIV дүгээр Конгресс» Олон улсын хуралд Монгол Улсын Ерөнхий прокурор тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид цахим хэлбэрээр оролцсон байна.

2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дарах санамж бичгийн төслийг хянаж, холбогдох зөвшөөрлийг авч, холбогдох байгууллагуудад хүргүүлжээ. Үүнд:

1. тус яамны харьяа Дотоод хэргийн их сургууль болон Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Волгоградын академи хоорондын “Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай протокол”-ын төслийг хянаж, Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

- 2.Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургууль болон Оросын Холбооны Улсын Холбооны ял эдлүүлэх албаны харьяа Эрх зүй, удирдлагын академи хоорондын “Боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаанд хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хянаж, Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

- 3.Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Манипал” мөн “Аakash” эмнэлэгүүдтэй “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалтын чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийн төслийг хянаж, байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

- 4.Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль зүйн яамны харьяа Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэн хоорондын “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

5. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар БНСВУ-ын НАБЯ-ны Хар тамхитай тэмцэх цагдаагийн газартай

байгуулах санамж бичгийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

6. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургууль болон БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургуультай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

7. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Архивын ерөнхий газрын Унгар Улсын Үндэсний архивын газартай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

8. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газрын БНСУ-ын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

9. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газрын БНСУ-ын Тэгү хотын цагдаагийн газартай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг хянаж Гадаад харилцааны яамнаас байгуулах зөвшөөрөл авч хүргүүлэв.

Улсын ерөнхий прокурорын газар, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага /IDLO/-тай 2022-2024 онд “Монгол Улсын институтын шударга, ил тод байдал” төслийг хамтран хэрэгжүүлэх хүрээнд “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 03 дугаар сарын 22-нд байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Санамж бичигт эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, хууль бус хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаатай холбоотой дотоодын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ чиглэлээр прокурорын чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, гадаад улс орны туршлагыг судлах зэрэг ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2022 онд Авлигатай тэмцэх газраас гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

1. Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газрын дарга, эрх бүхий албан хаагчид

2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газарт харилцан албан ёсны айлчлал хийж, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц болон авлигын эсрэг олон улсын хамтын ажиллагааны сувагт тулгуурлан зохион байгуулалттай гэмт бүлэглэл эсхүл гэмт хэргийн байгууллагыг мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажиллагаа болон дүн шинжилгээ гүйцэтгэхэд харилцан туслалцаа үзүүлж хамтран ажиллах, мэдээлэл солилцох, уулзалт, сургалт зохион байгуулах, зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэгт оролцох, харилцан туршлага солилцох, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, авлигатай тэмцэх төсөл, хөтөлбөрт хамрагдах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцож, “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав.

2. Эрх бүхий албан хаагчид Бүгд Найрамдах Латви Улс, ХБНГУ-ын Авлигатай тэмцэх газарт албан ёсны айлчлал хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Малайз Улсын Куала Лумпур хотноо 2022 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн жилийн хуралд оролцож, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хамгааллаа. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээнээс Франц Улсад 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг шийдвэр гаргагчдын Өндөр түвшний уулзалт, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан Сүлжээний Удирдах зөвлөлийн 27 дугаар хуралд байгууллагын удирдлага, эрх бүхий албан хаагчид оролцож, Истанбулын Авлигын эсрэг мониторинг хийх аргачлалыг баталж, ажлын төлөвлөгөөг эцэслэв.

3. Австри Улсын Вена хотноо 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганы үеэр баталсан улс төрийн тунхаглалын хэрэгжилтийг

хэлэлцэх Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн орнуудын чуулган хоорондын уулзалтад НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны урилгаар Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал оролцож, “Хөрөнгө буцаан авах” сэдэвт панелд илтгэл хэлэлцүүлээ. НҮБ-ын МБГХТА-аас Кени Улсад 2022 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан Хөрөнгө буцаан авах ажиллагааны талаарх олон улсын хуралд, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (АРИН-АП)-ний 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан жилийн бүгд хуралд Монгол Улсын авлигын нөхцөл байдал, гадаад улсаас хулгайлагдсан хөрөнгө хураасан, буцаасан сайн туршлагын талаар илтгэл хэлэлцүүлсэн нь хуралд оролцогчдын зүгээс өндрөөр үнэлэгдсэн.

4. Түүнчлэн Турк Улсад 2022 оны 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ (АСН)-ний Хууль сахиулагчдын 12 дугаар хурал, Испани Улсад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (Globe)-ний гуравдугаар чуулганд эрх бүхий албан хаагчид оролцож, Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаар зөвшилцөв.
5. Авлигын эсрэг олон улсын академи (ІАСА)-аас дэвшүүлсэн Авлигын эсрэг дэлхийн хотуудын сүлжээ буюу “Global Anti-Corruption Cities Network” шинэ санаачилгад Улаанбаатар хотыг нэгдэн оруулах ажиллагаанд Авлигатай тэмцэх газар зохицуулагч байгууллагаар ажиллахаар боллоо.
6. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тайлан боловсруулах, Алжир болон Ливан Улсын тайланг хянах” ажлын дэд хэсгийн хуралд оролцож, Алжир Улсын тайлангийн холбогдох дүгнэлтийг боловсруулан хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.11.3-2. Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2018/

Гадаад улсад хөрөнгө буцаан авах чиглэлээр илгээх хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагыг хангахуйц, оновчтой, үндэслэлтэй боловсруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

Мөн 2021 онд УЕПГ-аас гадаад улсаас хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах асуудлаар гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, прокурорын нэхэмжлэл бичиж, хүргүүлэх асуудлаар дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенциудыг судлан Дэлхийн Банк, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын хамтарсан хөтөлбөр болох Хулгайлагдсан хөрөнгө хураан авах санаачилгатай хамтран харьяа прокурорын газрын прокуроруудыг хамруулан цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, ЦЕГ, АТГ, ТЕГ, Интерполын үндэсний товчоо зэрэг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын саналыг авч, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ыг шинэчлэн боловсруулж, УЕП-ын 2021 оны А/65 дугаартай тушаалаар батлууллаа.

“Яллахгүйгээр хөрөнгө хураах ажиллагаа” судалгааны ажлыг гүйцэтгэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх тухай дотоодын хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох /ХЗДХЯ, УЕПГ, АТГ 2018-2022/

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх ажиллагаатай холбогдсон эрх зүйн суурь орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд ажиллаж байна. Хэдийгээр Улсын ерөнхий прокурорын газраас “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ыг батлуулан мөрдөж байгаа боловч процесс ажиллагааг нарийвчлан зохицуулах, олон улсын стандартад нийцүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод тулгуурлан, гишүүн орнуудтай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх ажиллагааг хийх боломжтойгоос гадна Монгол Улсын Засгийн газар бусад оронтой байгуулсан хоёр талт гэрээ, хэлэлцээрийн дагуу энэ ажиллагааг явуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай тусгайлсан гэрээг 6 улстай байгуулсан ба Авлигын эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд буюу 2018, 2019 онд Беларусь, Вьетнам улсуудтай шинээр гэрээ байгуулсан. Мөн эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар 9 оронтой байгуулсан гэрээнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх асуудлыг бие даасан бүлэг болгон зохицуулсан.

ФАТФ-ын Зөвлөмж 39 /Гэмт хэрэгтэн шилжүүлэх/-д заасан “Хүсэлтийн удирдлагын систем”-ийг бий болгоогүй байдалд дүгнэлт хийж, олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжид заасан “эрх бүхий төв байгууллага”-ууд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцааны хүсэлтийг дамжуулах, бүртгэх, “Цахим бүртгэл, мэдээллийн сан” бүрдүүлэх, харилцан мэдээлэл

солилцох, үйл ажиллагааны ил тод, аюулгүй, шуурхай байдлыг хангуулах зорилгоор УЕПГ-аас санаачлан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төслийг боловсруулж, холбогдох бүртгэлийн маягтын загваруудын хамт ГХЯ, ХЗДХЯ-нд хүргүүлэн саналыг авч, уулзалт зохион байгуулж хэлэлцүүлсэн. Энэ чиглэлээр Улсын ерөнхий прокурорын тушаалаар холбогдох аргачилсан зааврыг батлан прокурорын хяналтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх журамд тулгуурлан гадаад улсад илгээсэн хүсэлтийн хариуг шуурхай авах, эрх бүхий төв байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажиллах, мэдээлэл солилцох “Хүсэлтийг хянах цахим мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох боломжтой.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хуульд заасан эрх бүхий байгууллагуудаас гадна ХЗДХЯ, ГХЯ зэрэг төрийн захиргааны байгууллагуудын оролцоо чухал үүрэгтэй. Энэ чиглэлээр ХЗДХЯ, ГХЯ-ны эрх, үүрэг, хариуцлага зэрэг асуудлыг зохицуулсан эрх зүйн бичиг баримт үндэсний хэмжээнд одоогоор байхгүй байна.

2022 онд АТГ-аас боловсруулан илгээсэн 1 хүсэлтийг АНУ дээрх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан хариу ирүүлсэн. Иймд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авахад заавал тухайн оронтой гэрээ байгуулсан байхыг үндэсний хууль тогтоомжоороо шаарддаг орнуудын судалгааг гаргаж, энэ чиглэлээр тухайн оронтой тусгайлсан гэрээ байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна. Засгийн газраас дэвшүүлсэн “Шувуу ажиллагаа”-ны хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэгт сэжиглэгдэж мөрдөн шалгах ажиллагааны явцад оргон зайлсан хүмүүсийг гадаад улсаас авчрах ажиллагааг гадаадын 23 улстай эрх зүйн харилцан туслалцах гэрээний хүрээнд эрэн сурвалжилж, эх оронд нь дуудан ирүүлэх ажиллагааг зохион байгуулахаар болсон. Үүнд авлига албан тушаалын болон бусад хэргүүдэд

эрэн сурвалжлагдаж байгаа нийт 91 хүний нэр багтжээ. (Биелэлт 70 хувь)

4.1.11.5-1. Олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан хурал, сургалтад албан хаагчдыг тогтмол оролцуулан мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. Мөн ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар ажил хэргийн уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцон ажиллаж байна. Тухайлбал,

2018 онд Индонези улсын Бали хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, тус Сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах эрхийг авч, 2019 онд даргалагч улсаар томилогдов. Улмаар 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурал болон Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран хөрөнгө буцаан авах чиглэлээр олон улсын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тус арга хэмжээнүүдэд гадаадын гишүүн 24 улс, 5 олон улсын байгууллагын 70, дотоодын 7 хууль сахиулах байгууллагын 56 төлөөлөгч буюу нийт 126 оролцогч хамрагдсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн баг Монгол Улсын авлигын

эсрэг орчныг үнэлж, 2019 оны 3 дугаар 22-ны өдөр тайланг эцэслэн баталсан байна. Энэхүү тайланд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, прокурор, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хараат бус байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдал, нийтийн алба болон төрийн улс төрийн албан тушаалтны шударга байдал, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, бизнесийн шударга байдал зэрэг сэдвийн хүрээнд 29 хэсэг бүхий 153 зүйл зөвлөмжийг Монгол Улсад өгсөн байна. Авлигатай тэмцэх газраас уг үнэлгээний ажлыг зохион байгуулахад анхнаас нь оролцож, тайлан гарсны дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас «Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга» (StAR)-тай 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд олон удаагийн, үе шат бүхий сургалтыг зохион байгуулдаг. 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд тус Санаачилгын сургагч багш нартай хамтран “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”, 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчид хамруулсан.

2020 онд Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ДХИС, УЕПГ, Монгол банкны холбогдох алба хаагчдыг хамруулан зохион байгууллаа.

Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийн гишүүнийнхээ хувьд олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж, гишүүн орнуудын албан хаагчид тус академийн сургалтад хамрагдаж байна. 2020 оны 11 дүгээр сард болсон Оролцогч талуудын Ассамблейн 9 дүгээр чуулган, 2021 онд 10 дугаар чуулганд Монгол Улсаас төлөөлөл оролцсон.

Дэлхийн нийтийг хамарсан цартахлын улмаас хилийн чанадад газар дээр нь очиж танилцах сургалтад хамрагдах боломжгүй байсан боловч дотоодын нөөц бололцоогоо хангаж Гадаад улс орны төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага тооцох сайн туршлагыг судалж ажилласан болно. Тухайлбал,

“Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ”-г шинээр үүсгэн байгуулах ажлын хэсэгт болон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын Оролцогч талуудын “Хэрэгжилтийг хянах бүлгийн 12 дугаар чуулга уулзалт”-д АТГ-ын төлөөлөл оролцов. Улмаар “Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ”-нд Авлигатай тэмцэх газар 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр элсэн орж, гишүүн улсуудтай харилцан мэдээлэл, туршлага солилцох чиглэлээр хамтран ажиллах нөхцөл бүрдэв.

2022 онд АТГ-аас гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулж, туршлага судлууллаа. Үүнд:

1. Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE Network)-оос 2022 оны 04 дүгээр сарын 28, 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан «Санхүүгийн аудит хийх техник, стратеги» сэдэвт сургалтад 30 албан хаагч;
2. АНУ-ын ЭСЯ-тай хамтран 2022 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын луйвар”, “Криптовалют”, “Цахим нотлох баримтын талаарх үндсэн мэдлэг олгох” сэдэвт сургалтад 10 албан хаагч;
3. Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Удиртгал: Хөрөнгийн менежмент” сургалтад 52 албан хаагч;
4. БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооноос 2022 оны 07 дугаар сарын 12-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан АСРС Авлигын эсрэг виртуал сургалтын курс зохион байгуулах сургалтад 10 албан хаагч;
5. Дэлхийн Банк, НҮБ-ын Мансууруулах бодис,

гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (СтАР)-аас 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сургалтад 15, 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 18-ны өдрүүдэд зохион байгуулсан «Виртуал валютын тухай ахисан түвшний семинар» сэдэвт сургалтад 30 албан хаагч;

Түүнчлэн олон улсын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр “Авлигатай тэмцэх төрийн бус байгууллага” гарын авлагыг орчуулж, хэвлүүлж, “Хэргийн менежмент, зохион байгуулалтыг боловсруулахад анхаарах стратегийн асуудлууд” гарын авлагын холбогдох хэсгийг болон Дэлхий банкны “Олон Улсад хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж”-ийн 2 дэх хэвлэлийг орчуулсан.

АТГ нь олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор олон улсад авлигатай тэмцэх чиглэлээр өрнөж буй үйл ажиллагааг судлан өдөр бүр гадаад мэдээний тойм бэлтгэн, зарим шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Мөн тус газраас зохион байгуулдаг авлигын эсрэг сургалтын агуулгад гадаад улсын сайн туршлагуудын талаар мэдээллийг тусган хүргэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.5-2. Олон улсын туршлага судлах, чадавх бэхжүүлэх, үнэлгээ мониторингийн чиглэлээр олон улсын сүлжээ, санаачилгад идэвхтэй оролцох /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Мянганы хөгжлийн сангийн Хоёрдугаар компакт гэрээний Монгол Улсын авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд АНУ-ын Элчин сайдын яамны урилгаар АТГ-ын туршлага судлах айлчлалыг тус улсын 2018 оны 03-р сарын 05-13-ны өдрүүдэд зохион байгуулж, авлигатай тэмцэх чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтуудад оролцож, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай нь танилцан, төрийн байгууллага, төрийн албан тушаалтны үйл ажиллагаан дахь иргэдийн хяналт, оролцооны

талаарх туршлагыг судлан, байгууллагууд хоорондын цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

Бүгд найрамдах Киргиз Улс “Станбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөх олон улсын шинжээчдийн багт Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдон ажиллаж, Киргиз Улсын нөхцөл байдлын талаарх тайланг бэлтгэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад хүргүүлэв.

2019 онд Гадаад улсын авлигатай тэмцэх байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газрын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн албан ёсны айлчлал 2019 оны 07 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны төлөөлөгчдийн 2019 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд хийсэн айлчлал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны төлөөлөгчдийн 6 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд тус байгууллагад хийсэн айлчлалыг зохион байгуулж, харилцан туршлага солилцов.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороо байгуулагдсаны 45 жилийн ойн арга хэмжээ, БНКаУ-ын Авлигын эсрэг агентлагаас 2019 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд НурСултан хотод зохион байгуулсан арга хэмжээнд албан хаагчид болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо. Олон улсын байгууллагаас Монгол Улсад зохион байгуулсан сургалтад 90 албан хаагч, гадаад улс оронд зохион байгуулагдсан сургалтад 19 албан хаагчийг суралцуулсан.

- 2019 оны 01 дүгээр сард БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконгд туршлага солилцох гадаад томилогчдын ажлын хүрээнд 9 алба хаагч туршлага солилцох уулзалт, 2019 оны 6 дугаар сард тус хороонд 10 мөрдөгчийг 7 хоногийн эрчимжүүлсэн сургалтад хамруулсан.
- Нидерландын Вант Улсын Гааг хотод 2019 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан

Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээнүүдийн нэгдсэн хуралд тус газраас төлөөлөл оролцож, Монгол Улсын авлигатай тэмцэх, хууль бус хөрөнгийг эргүүлэн авчрахтай холбоотой туршлагаас хуваалцав.

- Австралийн Холбооны Улсын Канберра хотод 2019 оны 8 дугаар сард зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хуралд холбогдох чиглэлийн албан хаагчид оролцсон.
- Тайванийн Тайпаа хотод 2019 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан Америкийн Нэгдсэн Улсын Холбооны мөрдөх товчооны академийг төгсөгчдийн холбооны бүс нутгийн давтан сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
- Тайландын Вант Улсын Бангкок хотод 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн уулзалтад 1 албан хаагч оролцож, Монгол Улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, хэрэг шалгаж, хянан шийдвэрлэсэн тоо үзүүлэлтийг танилцуулж, холбогдох үнэлгээг дээшлүүлэв.
- Ази, Номхон далайн бүс нутгийн Авлигын эсрэг санаачилгын Нарийн бичгийн дарга нарын газраас Вьетнам улсын Ханой хотноо 2019 оны 12 дугаар сарын 3-6 өдрүүдэд зохион байгуулагдсан Авлигын эсрэг бүс нутгийн хуралд 1 албан тушаалтан оролцсон.
- “Транспэрэнси Интернэшнл-Бангладеш” олон улсын байгууллагатай хамтран олон улсад сайшаагдсан тус улсын авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах туршлагаар “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтад Нийслэлийн Сүхбаатар дүүргийн хороодын иргэд, Хан-Уул дүүргийн сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн төлөөлөөс гадна “Глоб интернэшнл”, “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”, “Зориг сан”, “Хүний эрх хөгжил төв”, “Нээлттэй нийгэм форум”, “Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг” “Монголын залуучуудын холбоо” зэрэг ТББ, АТГ-аас зохион байгуулж байгаа “Түлхүүр” уралдаанд оролцогч оюутнууд

зэрэг 89 оролцогч хамрагдав.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлэх “Монгол улсын Засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Азийн хөгжлийн банк хамтран 2018 оны 12 дугаар сараас 2 жилийн хугацаатай “Монгол Улс: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлсэн.

2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжийн албан хаагчдыг суралцуулав. Тус хорооноос 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Олон улсын авлигын эсрэг салбарын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”-д Авлигатай тэмцэх газрын 6 албан хаагчийг хамруулав. Мөн БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулав. 2021 онд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас үүсгэн байгуулж буй “Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ” (GlobE)-нд Авлигатай тэмцэх газар гишүүнээр элссэн.

Улсын Ерөнхий прокурорын газраас 2020 онд гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийн талаар мэдээлэл солилцох, техникийн туслалцаа үзүүлэх Ази, Номхон далайн орнуудын сүлжээ байгууллага болох АРИН-АП, мөн Европын Холбооны Эрүүгийн шүүхийн системийн хамтын ажиллагааны байгууллагад бүртгүүлэн, хууль бусаар олсон хөрөнгийг хураан авах ажиллагаатай холбоотой дотоодын хууль тогтоомж, тогтолцооны талаар мэдээлэл солилцож ажилласан. ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Сонгуулийн асуудал эрхэлсэн газрын дэд захирал, зөвлөх нарын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн манай улсад хийсэн ажлын айлчлалын үеэр Авлигатай тэмцэх газрын төлөөлөл уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов.


ГХЯ-аас Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албаны 2020 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн тогтвортой хөгжлийг хангах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг дэмжих, “Бүс ба зам” санаачилгын хүрээнд авлигын эрсдэлийг бууруулах, хариуцлагатай, шударга дэд бүтцийг “Бүс ба зам” санаачилгыг дэмжигч улсуудад бий болгох зорилготой «Торгоны замын эдийн засгийн бүс»-ийн дагуух улсуудад Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой хөгжлийг тэтгэх нь «төсөлд манай улс 2020 оны III улирлаас эхэлж хамрагдах чиглэлээр ажиллав. 2021 онд Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Элчин сайд БНПУ-ын Авлигатай тэмцэх төв товчооны дарга, түүний ажлын албаны дарга нартай, мөн Латви Улсын Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх товчооны үйл ажиллагааны асуудал эрхэлсэн орлогч даргатай тус тус уулзаж хоёр талын холбогдох байгууллагуудын хооронд хамтын ажиллагаа тогтоох, өргөжүүлэх, туршлага судлах, харилцан айлчлал зохион байгуулах, ажилтан нарыг солилцох, хүн сургах боломжийн талаар санал солилцов.

2022 онд Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR)-тай хамтран 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 11, 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” анхан шатны сургалтад тус байгууллагын болон ЦЕГ, УЕПГ-ын 47 албан хаагчийг; 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт сургалтад тус байгууллагын болон УЕПГ, ЦЕГ, ДХИС-ийн нийт 26 албан хаагчийг; 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан “Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн менежмент” сургалтад УПЕГ, ШШГЕГ, ДХИС-ийн 20 албан хаагчийг хамруулан суралцуулав. (Биелэлт 100 хувь)

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН 2022

№	Хөтөлбөрийн зорилт	Үйл ажиллагаа	Нийт арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн үнэлгээ				Дуднаж хувь
				100	70	30	0	
1	Зорилт №1	10	26	19	7	0	0	91.9
2	Зорилт №2	7	18	9	7	2	0	80.6
3	Зорилт №3	10	35	12	19	4	0	75.7
4	Зорилт №4	5	15	11	4	0	0	92.0
5	Зорилт №5	17	34	15	13	6	0	76.2
6	Зорилт №6	5	18	3	12	3	0	68.3
7	Зорилт №7	6	18	8	5	3	2	68.9
8	Зорилт №8	5	9	2	2	3	2	47.8
9	Зорилт №9	8	17	1	6	7	3	42.9
10	Зорилт №10	5	10	7	3	0	0	91.0
11	Зорилт №11	5	13	8	5	0	0	88.5
Нийт		83	213	95	83	28	7	75.8

АТҮХ-ийн зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээний дундаж, 2021 ба 2022 оны харьцуулалт



04.



**ДӨРӨВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН-2022**



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2022

Монгол Улсад анх удаа Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор батлан гаргасан ба уг хөтөлбөр нь 2002-2005 он, 2006-2010 он гэсэн хоёр үе шаттай хэрэгжсэн. Мөн тогтоолоор үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна.

Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоохоор, Үндэсний зөвлөлийн үүргийг орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гүйцэтгэхээр үндэсний хөтөлбөрт заажээ.

1996 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Авлигын эсрэг хууль батлагдсан ба 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Авлигын эсрэг хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдсөн. Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Авлигатай тэмцэх газар байгуулагдсантай холбогдуулан Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан тогтоолын заалтыг Улсын Их Хурлын 2006 оны 70 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.

Дээр дурдсанчлан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа нь 2010 онд дууссан ба Авлигын эсрэг хуулийг даган мөрдөж, авлигын түвшинг бууруулах, төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байсан ч авлига нийгмийн түгээмэл асуудал хэвээр байсан тул авлигатай тэмцэх үйл ажиллагааг бүх нийтийн үйл хэрэг болгон үндэсний хэмжээнд тэмцэх

арга хэрэгслийг тодорхойлох бодлогын баримт бичиг шаардлагатай болсон.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 5 дугаар зүйлд “Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авилгалын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан.

Авлигатай тэмцэх газраас боловсруулсан Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн барьсан юм. Улсын Их хурлаар хэлэлцэх явцад “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” гэж нэрлэхээр тогтсон ба 8 бүлэг, 11 зорилтыг тусгаж, нийтийн алба, төрийн үйлчилгээ, төсөв санхүү, аудит, худалдан авах ажиллагаа, шүүх эрх мэдлийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олонийт, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон улсын хамтын ажиллагаа зэрэг нийгмийн бүхий л салбар хүрээн дэх авлигатай тэмцэх төрийн бодлогыг тодорхойлсон.

Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулахад 50 гаруй улсын авлигын эсрэг хууль тогтоомж болон 48 улс орны авлигын эсрэг стратеги, хөтөлбөрийг судалсны зэрэгцээ хөтөлбөрийн төслийг улс орон даяар хэлэлцүүлэн иргэд, олон нийт, судлаач, мэргэжлийн байгууллагын саналыг авч тусгасан байна.

Энэхүү хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан ба үндэсний хөтөлбөрийн зорилгыг “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” хэмээн тодорхойлж, зургаан жилийн хугацаанд 2016-2019, 2020-2023 он гэсэн хоёр үе шаттайгаар

хэрэгжүүлэхээр тогтоосон.

Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д нийт 216 арга хэмжээ тусгагдсан ба арга хэмжээ тус бүрээр хэрэгжих хугацаа, хоёр шатны үр дүнгийн үзүүлэлт болон хүрэх түвшинг тодорхойлсон.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа нь дуусч байгаатай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дараагийн хөтөлбөрийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг хэрэгжээд дуусч байгаа хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тодорхойлох журамтай болно.

Иймээс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын дэмжлэгтэйгээр хөндлөнгийн хараат бус судлаачдын зөвлөх баг (Үнэлгээний багт эдийн засагч, магистр С.Баттулга, Б.Ариунаа, Т.Түвшинбаяр нар ажилласан)-аар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Уг үнэлгээний тайланд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хараат бус зөвлөх Л.Мөнхцэцэг гүйцэтгэлээ.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийх явцад “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын гарын авлага”-ыг жишиг болгон харгалзсан болно.

Үнэлгээ хийх ажлын зорилт:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, цаашид шинээр боловсруулах авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар

санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үнэлгээ хийхэд баримталсан зарчим:

Үнэлгээг холбогдох хууль, аргачлалын дагуу хийж, дүгнэлтийг зөвхөн тухайн үнэлгээний хүрээгээр тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

ХОЁР. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

Үнэлгээг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

ГУРАВ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх шатны зорилго нь “үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ” гэсний дагуу дор дурдсан арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

3.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно. Иймд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалтгааныг дор дурдсанаар тодорхойлж байна:

Авлигын эсрэг хуулийн 2¹ дүгээр зүйлд “Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална” гэж заасан. Энэхүү хуулийн заалт нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь хугацаа нь дууссанаар нэг удаа хэрэгжээд өнгөрөх арга хэмжээ биш бөгөөд авлигатай тэмцэх эрх

зүйн тогтолцооны нэг хэсэг болж, дараагийн хөтөлбөр үргэлжлэн хэрэгжих үндэслэл болж байна.

Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хугацаа 2022 онд дуусгавар болж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хөтөлбөр боловсруулах юм.

3.2. Үнэлгээний хүрээг тогтоох нь

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.2 дэх заалтын дагуу үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хууль тогтоомжийг бүхэлд нь, эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь 2016 оноос 2023 он хүртэл 6 жилийн хугацаатай хэрэгжээд хугацаа нь дуусч байгаа тул дээр дурдсан шалтгаан, нөхцөл байдлыг харгалзан хөтөлбөрийг бүхэлд нь буюу хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дараахь чиглэлээр үнэлгээ хийхээр үнэлгээний хүрээг тодорхойллоо.

Үнэлгээний хүрээ 1	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх
Үнэлгээний хүрээ 2	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх
Үнэлгээний хүрээ 3	Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх
Үнэлгээний хүрээ 4	Худалдан авах ажиллагааны, хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх
Үнэлгээний хүрээ 5	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах
Үнэлгээний хүрээ 6	Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх
Үнэлгээний хүрээ 7	Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих
Үнэлгээний хүрээ 8	Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх
Үнэлгээний хүрээ 9	Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх
Үнэлгээний хүрээ 10	Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх
Үнэлгээний хүрээ 11	Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх

3.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Шалгуур үзүүлэлт нь үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байх бөгөөд оновчтой, бодит, хэмжиж болохуйц байна. Иймээс аргачлалд заасан үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс аль нь оновчтой, бодитой тухайн асуудлыг хэмжиж болохыг нь сонгож тогтоох

ба үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой нэг шалгуур үзүүлэлтийг сонгон авч болохоор аргачлалд заасан тул сонгосон үнэлгээний хүрээнд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг “зорилгод хүрсэн түвшин” байхаар сонголоо.

Зорилгод хүрсэн түвшин-шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс

хойших хугацаанд хууль тогтоомжийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хөтөлбөрийн хэрэгжилт тавьсан зорилтдоо хүрсэн түвшинг тодорхойлно.

3.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглана.

Аргачлалын 3.5.3.1-д “..Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль тогтоомжид байвал зохих тодорхой үзүүлэлтийг зааж өгсөн бол тэрхүү үзүүлэлтийг одоо байгаа үзүүлэлттэй шууд харьцуулж болно.” гэж заасан тул Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Тав”-ын 5.1, 5.2-т заасан “хүрэх үр дүнг одоо хүрсэн байгаа үр дүнтэй харьцуулах”-аар сонголоо.

3.5. Мэдээлэл цуглуулах арга сонгох

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлгээ хийх болсон шалтгаан болон үнэлгээ хийх хүрээ, сонгосон харьцуулах хэлбэр, зэргийг харгалзан “бэлэн байгаа мэдээллийг цуглуулах арга”-ыг сонгосон болно.

Энэхүү сонгосон арга нь нийтлэг хэрэглэгдэг, үр дүнтэй арга бөгөөд бэлэн байгаа материал буюу тухайн сэдвээр гаргасан ном, товхимол, судалгаа, илтгэл, албан ёсны статистик мэдээлэл, хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан мэдээлэл зэрэгт үндэслэдэг болно.

ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Дээр дурдсанаар төлөвлөлтийн шатанд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах аргыг сонгосны дагуу дараахь мэдээлэл цуглуулсан:

Судалгаа, тайлан

- 1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
- 2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
- 3.Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-2017 он

4.Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2021 он

5.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн I үе шатны хэрэгжилт-2019

6.Хэрэгжүүлэгч байгууллагууд /2022/ Арга хэмжээний хэрэгжилтийн тайлан

7.Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь АХБ-ны техник туслалцааны төсөл “Авлигын гэмт хэргийн дүн шинжилгээний тайлан” 2020

8. МҮХАҮТ- Хүнд суртлын индекс 2021 судалгаа

9.Сант Марал сан, Азийн сан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа-2019”

10.Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх төсөөллийн судалгаа-2021

11.Шударга байдлын үнэлгээ-2021

12.Хүүхдийн шударга байдлын үнэлгээ-2021

13.Шүүхийн индекс-2021

14.Хэвлэлийн эрх чөлөөний 2022 оны индекс

15.Шилэн нам-авлигын эсрэг түншлэлээс хийсэн “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээ” судалгааны тайлан 2018

16. “Монгол Улс дахь авлигын шинэтгэл” Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний IY үе шат-/Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн Монгол Улсын авлигын эсрэг орчныг 2019 онд үнэлж, өгсөн зөвлөмж/

17.Глобал интернэшнл- Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2021

18.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан

19. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II,Ү бүлгийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас өгсөн зөвлөмж

20.“Ардчилсан засаглал судалгаа”-ны 2019-2021 оны үр дүн, Үндэсний статистикийн хороо

Хууль тогтоомж, эрх зүйн акт

- 1.Монгол Улсын Үндсэн хууль,
- 2.Хууль тогтоомжийн тухай хууль
- 3.Захиргааны ерөнхий хууль
- 4.Төрийн албаны тухай хууль,
5. Авлигын эсрэг хууль
- 6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл, 2012, №8
- 7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль,
- 8.Эрүүгийн хууль
- 9.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 10.Нийтийн сонсголын тухай хууль
- 11.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- 12.Шилэн дансны тухай хууль
- 13.Зөрчлийн тухай хууль
- 14.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл
- 15.Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
- 16.Авлигын эсрэг НҮБ-ын конвенц
- 17.Шүүхийн тухай хууль
- 18.Прокурорын тухай хууль
- 19.Зөвшөөрлийн тухай хууль

ТАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

- 5.1.Энэ үе шатанд үнэлгээний ажлыг эцэслэн, үр дүнг нэгтгэн дүгнэж зөвлөмж боловсруулах бөгөөд дараах дарааллыг баримталж ажиллана:
- 5.1.1.цуглуулсан мэдээллийг үнэлэх;
 - 5.1.2.тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлэх.
- 5.2.Хэрэгжүүлэх үе шатанд цуглуулсан мэдээлэл нь үр дагаврын үнэлгээг хийхэд аргачлалд заасны дагуу хангалттай, зайлшгүй шаардлагатай, хамааралтай, бодитой байх шаардлагыг бүрэн хангасан.
- 5.3.Аргачлалд зааснаар тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан

үнэлгээний хүрээгээр үнэлгээг хийлээ.

Тайлбар:Хөтөлбөрийн зургаан жилийн хугацааны хэрэгжилтийн тухай мэдээллийн хэмжээнээс шалтгаалан үнэлгээний шатанд хөтөлбөрийн тухайн зорилтод хамаарах арга хэмжээний хэрэгжилтээс заримыг нь төлөөлөл болгон товчхон дурдаж тусгасан.

Үнэлгээний явцад аргачлалд заасны дагуу судалгааны дүн болон тоон мэдээллийг хөтөлбөр эхлэх үеийнхийг одоо байгаатай харьцуулж өсөлт, бууралтыг харуулсан.

5.3-Үнэлгээний хүрээ 1

Үнэлгээний хүрээ	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	-Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийтийн албанд цогц шинэтгэл хийх үйл ажиллагаа эрчимжсэн байх -Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх

Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хөтөлбөрт 10 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 26 арга хэмжээ тусгагдсан.

Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлэхийн тулд хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Төрийн албаны тухай хууль батлагдсан. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан. Уг хуулийн заалттай холбогдуулан УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр 46 журмыг батлан хэрэгжүүлж

байна. Энэхүү хууль, эрх зүйн баримт бичигт иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, үнэлэх, дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэхэд хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглох, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж, дүгнэх зэрэг асуудлыг тусган мөрдөж байна.

Сонирхлын зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх хуулийн заалтыг хэрэгжүүлсэн. АТГ-аас 2017 -2021 онд 55820 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч, хянан шийдвэрлэсэн. 2017 онд 11143 ХАСУМ хүлээн авч хянан шийдвэрлэсэн бол энэ тоо 2021 онд 12504 болж өссөн байна. Хянан шалгасан мэдүүлгээс 2020 онд 848, 2021 онд 1018 нэр дэвшигчийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан, шаардлага хангаагүй үндэслэлээр 2020 онд 489, 2021 онд 266 мэдүүлгийг буцаасан, 2020 онд 8, 2021 онд 22 нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдож байгаа талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн байна. 2021 онд ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг бүрэн цахимжууллаа.

ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулахаар ирүүлсэн тоо 2017 онд 844, 2018 онд 211, 2019 онд орон нутгийн төрийн байгууллагуудад 40, 2021 онд 44 болж буурч байна. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд

хүргүүлсэн. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд өөрчлөлт оруулж, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдийг дур мэдэн томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх эрсдэлийг бий болгож байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дагаврын талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

Төрийн албанд шударга байдлыг тогтоох үндсэн арга хэрэгсэл нь ёс зүйн хэм хэмжээ юм. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг, УИХ-ын 2021 оны 105 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг тус тус шинэчлэн баталсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 1422 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан бөгөөд үүнээс төрийн тусгай 809 албан хаагч, төрийн захиргааны 353 албан хаагч, төрийн үйлчилгээний 260 албан хаагч хамаарч байгаа ба 2019 оны ёс зүйн зөрчилтэй харьцуулахад 24 нэгж буюу 4.8 хувиар буурсан байна.

2021 оны байдлаар бүх төрийн байгууллагуудад ёс зүйн зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолд байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан. Авлигын эсрэг хуулийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө АТГ-аас санал авах үүргийг хүлээдэг. Үүний дагуу төрийн байгууллагын ёс зүйн 13 дүрмийн төслийг хянаж, санал өгсөн байна.

Шударга байдлын үнэлгээг шалгуур үзүүлэлт болгоно. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2016 онд хийсэн шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагууд 69.7 оноо авч байсан бол 2021 онд хийсэн шударга байдлын үнэлгээнд

төрийн байгууллагууд 72.9 оноо авч 2016 оны үнэлгээний дүнгээс 3.2 пунктээр өссөн байна. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д “..Шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шударга байдлын үнэлгээг шалгуур үзүүлэлт болгон ашиглаж байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах ажиллагааг хялбаршуулсан. Авлигатай тэмцэх газраас албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, www.iaas.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, утсаар болон байгууллагын байранд биечлэн ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд өгөх боломжийг бүрдүүлж, 110 тусгай дугаарын утсыг ажиллуулж байна. 110 тусгай дугаарын утсанд 2020 онд 17851, 2021 онд 13,474 дуудлага ирсэн байна. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 57.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 28.8 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 3.2 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна. Энэ нь иргэний өргөдөл гомдол гаргах эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд бодитой үр нөлөө үзүүлж байна. Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээллийн программыг шинэчлэх ажлыг зохион байгуулж программын болон гэрээний маягтуудыг Үндэсний статистикийн хорооны хурлаар батлуулан туршиж дууссан. Энэхүү программ ашиглалтад орсноор иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах явц, шийдвэрлэлтэд нэгжийн дарга тухай бүр хяналт тавих, байгууллагын дотоод хяналтыг давхар хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно.

Зөвлөл ажиллана. 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байгаа

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлийг ХЗДХЯ-ны дэргэд ажиллуулахаар хуульчилсан. Тус зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд төрийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдах үр дүнтэй юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Шалгалтын процесс бүрэн цахимжсан. Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад бүртгэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг бүрэн цахимжуулснаар энэ үйл явцад хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөл орохоос сэргийлж, ил тод, нээлттэй зарчмыг ханган, шалгалтад оролцогчид мэдлэгээ бодитоор сорих боломжийг бүрдүүлсэн. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, IV бүлгийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын тайланг хэлэлцээд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас өгсөн урьдчилсан зөвлөмжид төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах шалгалтыг бүрэн цахимжуулсныг ололт амжилт гэж дүгнэсэн.

Төрийн албан хаагч улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглосон. Төрийн албаны хуулийг шинэчилсэн найруулж баталснаар төрийн албан хаагч /улс төрийн албан хаагчаас бусад/ улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох явдлыг таслан зогсоож, улс төрийн нөлөөнөөс ангид, ард түмний тусын тулд төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах Үндсэн хуулийн үзэл санаа бодитоор хэрэгжих нөхцөл бүрдсэн. Төрийн албаны тухай хуулийн 31.2-т “Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийн сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, гишүүн, Ерөнхий сайд, .. бусад этгээдийн зүгээс нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно” гэж заасан. Зөрчсөн тохиолдолд улс төрийн албан тушаалтныг огцруулах үндэслэл болохоор хуульчилсан. Мөн хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн

шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Төрийн албаны зөвлөл өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг Төрийн албаны зөвлөлийн мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө 14 хоногийн дотор хүчингүй болгохоор заасан.

Төрийн албан хаагчийн сургалтын агуулгыг тогтоосон. "Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр"-ийг Засгийн газрын ХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар, "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор тус тус баталсан ба үүний дагуу зорилтот арга зүйн сургалт зохион байгуулж, 6500 төрийн албан хаагчийг хамруулжээ. Засгийн газрын 2022 оны 312 дугаар тогтоолоор 299 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулсан. АТГ авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр 2019 онд нийт 40 сэдвээр, Удирдлагын Академи, МУИС, МУБИС-тай хамтран нийт 20 сэдвээр тус тус сургалтын модуль боловсруулан нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан ба 2020 онд 5 төрлийн сургалтын 20 модуль, сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургалтад ашиглаж байна.

Хууль бус томилгоог залруулсан. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн заалтыг баримтлан төрийн жинхэнэ албаны сул орон тоонд хуулийн шаардлага хангаагүй 1037 хүнийг удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр томилсныг Төрийн албаны зөвлөлөөс хийсэн хяналт шалгалтаар тогтоосон. Энэхүү хууль бус томилгоог таслан зогсоох, зөрчлийг арилгуулах зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс гаргасан 2021 оны "Албан тушаалын сул орон тоог нөхөх зарим арга хэмжээний тухай" 411 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж байна.

Шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд учруулсан хохирлыг төлүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хийсэн ажлаас

дурдвал:

Хариуцлагын тогтолцоо бүрдсэн. Захиргааны ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хуульд хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтны шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай заасан. Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны зөвлөл төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаж байхаар хуульчилсан.

Хяналт шалгалт хийсэн. Төрийн албаны зөвлөлөөс ЗГХЭГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулж, 2021 оны 10, 11 дүгээр сард 10 аймагт ажиллаж, төрийн 350 гаруй байгууллагын 4606 албан хаагчийг хамруулан төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, томилгооны байдалд хяналт шалгалт хийж, томилгоотой холбогдсон 95 шийдвэрийг хүчингүй болгожээ. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож, нийтийн албанд ажиллах эрх хасуулах шийтгэл хүлээсэн 91 иргэнийг төрийн албанаас чөлөөлүүлсэн байна.

Хохирол нөхөн төлүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 04/993 дугаар албан бичгээр Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай шаардлага хүргүүлсний дагуу төрд учруулсан хохирол болох 2,055,699 төгрөгийг нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн. Төрд учирсан нийт 221,696,774 төгрөгийг нөхөн төлүүлэх шаардлагыг хууль бус шийдвэр гаргасан 20 хүнд хүргүүлж, төрд учирсан 215,096,774 төгрөгийг нөхөн төлүүлэх 19 нэхэмжлэлийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Соён гэгээрүүлэх ажиллагаа эрсдэлийн үнэлгээнд суурилан зохион байгуулдаг.

Авлигатай тэмцэх газар авлигын шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсоох, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ирсэн. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны а/185 дугаар тушаалаар “Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ыг баталсан. Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлнэ гэдэг нь тухайн байгууллага дахь авлига үүсч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг тодруулж байгаа явдал бөгөөд төрийн үйлчилгээг сайжруулах мэдээллийн эх сурвалж болгон ашиглах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг чиглүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлж ажилласан.

Эрсдэлийн үнэлгээнд 56 байгууллага хамрагдаад байна. Аргачлалын дагуу 2018 онд 6 ТББ-аар 24 яам, агентлагт, 2019 онд 5 ТББ-аар 15 байгууллагад авлигын эрсдэлийн үнэлгээг хийлгүүлсэн ба 2020 онд 9 байгууллага, 2021 онд 14 байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээгээр дээрх байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн чиглэлийн үйл ажиллагаа, байгууллагын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, бүртгэл хөтлөлтөд авлигын эрсдэлийн түвшин өндөр үнэлэгдсэн байна. 2018 онд төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулж эхэлснээс хойш нийт 56 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаад байна.

Авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдах байгууллагыг сонгодог. Авлигатай тэмцэх газраас 2021 оны Авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдах байгууллагуудыг сонгохдоо Шударга байдлын үнэлгээнд хамрагддаггүй, мөн 2017 оноос эхлэн авлигын гэмт хэрэгт холбогдон шүүхээр шийдэгдсэн хэргийн тоо зэрэг үзүүлэлтийг харгалзсан. Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэргээр авлигын эрсдэлийг

үнэлэх, тогтоох, таслан зогсоох ажлыг үр дүнтэй зохион байгуулж байна.

Тухайн чиглэлд эрсдэл тодорхойлсон нь бүхэлдээ эрсдэлтэй гэж дүгнэх үндэслэл болохгүй юм. Тодорхойлсон эрсдэлүүдийн нөлөө, хамрах хүрээ, сөрөг үр дагавар төдийлөн өндөр бус бөгөөд богино хугацаанд уг эрсдэлийг бууруулан, цаашид бий болох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой юм. Мөн тодорхойлсон эрсдэлээс цөөнгүй нь зөвхөн тухайн байгууллагын хувьд биш, тухайн салбарын удирдлагын түвшинд шийдвэрлэх боломжтой, холбогдох хууль тогтоомж, журам, төсөв санхүү, хүний нөөцийн хангамж зэрэг асуудалтай холбоотой байна.

Тухайлбал, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар дахь авлигын эрсдэлийн үнэлгээг Авлигатай тэмцэх газрын захиалгаар “Онч шийдэл” ТББ 2021 оны 7 дугаар сараас эхлэн 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн. Дорнод аймгийн МХГ-ын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүсгэж болзошгүй 9 эрсдэл буюу байгууллагын чиг үүрэг, бүтэц орон тоо, төсөв санхүү, шийдвэр гаргах үйл явц, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, мэдээллийн хүртээмж, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн харилцаанд тодорхой эрсдэлүүд байна гэж тодорхойлж, шалтгаан нөхцөл, тохиолдох магадлал, үр дагаврыг дүгнэсэн байна.

Зөвлөмж өгч ажилласан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Авлигатай тэмцэх газрын ажлын баг 2017 онд 21 аймагт 3 удаа, давхардсан тоогоор 144 суманд, 2018 онд 21 аймаг, 50 суманд, 2019 онд 21 аймгийн 21 сумдад ажилласан. Хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдсэн. 2020-2021 онуудад 23 байгууллагад ажилласан байна. Засгийн газарт болон Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдлын талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Дүгнэлт

Байгууллагын болон хувь хүний түвшинд шударга байдлыг ханган сахиулах тухай Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь төрийн албан дахь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг таслан зогсоох цогц бодлого болж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлснээр улс төрөөс хараат бус, төрийн албаны эрх зүйн үндэс бүрдэж, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвараар тодорхойлогддог болох нөхцөл хангагдсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Төрийн албаны хууль /шинэчилсэн найруулга/, Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль /шинэчилсэн найруулга/, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/, зэрэг холбогдох хууль батлагдсанаар нийтийн албыг бэхжүүлэх хүрээнд хууль эрх зүйн орчин бүрдсэн нь тогтвортой хадгалагдах хэрэгжилтийн үр дагавар юм. Иймээс хүрсэн үр дүн нь хүрэх үр дүн болох “Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийтийн албанд цогц шинэтгэл хийх үйл ажиллагаа эрчимжсэн байх” гэсэн үр дүнд хүрсэн байна.

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээг тодорхой хугацаагаар тогтмол хийж байгаа ба 2016 оныг 2021 оны үнэлгээтэй харьцуулахад өссөн дүнтэй гарчээ. Шударга байдлыг үнэлээд орхихгүй, авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шалгуур үзүүлэлт болгох зэргээр арга хэмжээ авч ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас тухайн жилд эрсдэлийн үнэлгээ хийх төрийн байгууллагыг сонгон эрсдэлийн үнэлгээ хийх ажил хэвшсэн бөгөөд энэ нь 2018 оноос хойш 56 байгууллагад үнэлгээ хийснээр илэрч байна. Энэхүү хүрсэн үр дүн нь хүрэх үр дүн болох “Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх” гэсэн хүрэх үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна.

Үнэлгээний хүрээнд харьцуулсан үр дүнг үндэслэн холбогдох зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж дүгнэж байна.

5.3-Үнэлгээний хүрээ 2

Үнэлгээний хүрээ	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх

Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх. зорилтын хүрээнд хөтөлбөрт 7 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 18 арга хэмжээ тусгагдсан.

Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулахын тулд хэрэгжүүлсэн арга хэмжээнээс тухайлан заримыг дурдвал:

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн. Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг баталсан. Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний цахим системд холбох 167 үйлчилгээний жагсаалтыг баталсан. Авлигатай тэмцэх газар 2017 оны 1 дүгээр сард зохион байгуулсан Авлигын эсрэг үндэсний чуулганаар “Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал” сэдвээр салбар хуралдаан хийж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх шаардлага, хүндрэл бэрхшээл, олон улсын сайн туршлага, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцүүлсэн.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн албан тушаалтны нөлөө, бусад хүчин зүйлээс ангид, авлигын эрсдэлгүй, хүнд сурталгүй үйлчилгээг үзүүлэх шаардлагын дагуу төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажил Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд эрчимтэй явагдсан. 2017 онд

“Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ийг ашиглалтад оруулж, 2018 онд системд төрийн 47, хувийн 118 байгууллага холбогдож байсан бол 2022 оны 5 дугаар сарын байдлаар төрийн 86, хувийн хэвшлийн 215 байгууллага холбогдон, 462 сервисээр дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

2021 онд ДАН» системээр нийт 188 байгууллага холбогдож, үүнээс идэвхтэй ашиглагдаж буй 83 байгууллагын системийг ашиглаж 1,266,165 хэрэглэгч бүртгүүлж ашигласан байна. “Танилт, баталгаажуулалтын ДАН» системээр 2019 онд 18 байгууллага холбогдож 31.852 хэрэглэгч бүртгүүлж ашиглаж байсан бол 2021 онд 188 байгууллага холбогдож, үүнээс идэвхтэй ашиглагдаж буй 83 байгууллагын системийг ашиглаж 1,266,165 хэрэглэгч бүртгүүлж ашигласан байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдсан.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 259 дугаар тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 320 үйлчилгээ болгож шинэчлэн баталж Үндэсний цахим үйлчилгээний <https://e-mongolia.mn/> системийг нэвтрүүлсэн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлж байх үед буюу 2017 онд 167 үйлчилгээний 10,8 хувийг л цахимжуулсан бол 2022 оны 6 дугаар сарын байдлаар 62 байгууллагын 680 үйлчилгээ болон нэмэгдсэн.Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр байгуулж төрийн байгууллагуудын цахим засгийн тогтолцоог бүрдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах бүтцийг бий болгожээ. МҮХАҮТ-ын “Хүнд суртлын индекс” 2021 оны судалгаагаар төрийн үйлчилгээний цахим “e-mongolia” нэгдсэн системд бизнес эрхлэгчид уламжлалт үйлчилгээнээс илүү сайн үнэлгээ өгсөн байна.

2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Дижитал хөгжилд хамтдаа форум”-ын үеэр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний цахим систем буюу www.mgov.mn порталыг нээж, 25 байгууллагын 181 нэр төрлийн үйлчилгээг дижитал хэлбэрээр үзүүлэхэд бэлэн болсон. Энэхүү систем нь ХУР, ДАН, Орон зайн өгөгдлийг дундын мэдээллийн

сан, Үндэсний төлбөрийн систем, бусад төлбөрийн систем, ebarimt төлбөрийн баримтын систем, esign тоон гарын үсэгтэй холбогдсон.

Тоон гарын үсэг хэрэглэх иргэдийн тоо нэмэгдсэн. 2019 онд 1960 албан хаагч тоон гарын үсгийг төрийн үйлчилгээнд ашиглаж байсан бол 2021 онд энэ тоо 9710 болж нэмэгдсэн. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 байгууллагаас иргэн, аж ахуйн нэгжид 54 мянга гаруй тоон гарын үсгийн гэрчилгээ олгожээ. Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж олгохоор тогтоосон. 2022 оны 5 сарын 01-ээс эхлэн иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг суулгаж, олгож эхэлсэн ба 2022 оны 8 сарын байдлаар 265,365 иргэнд иргэний үнэмлэхийн санах ойд суулгаж тоон гарын үсэг олгоод байна.

Ил тод байдлын үнэлгээг хийж хэвшсэн. Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор АТГ-аас төрийн байгууллагуудын ил тод байдлын үнэлгээг 2020, 2021 онуудад гүйцэтгэсэн. Үнэлгээг Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад үндэслэн боловсруулсан ба 2020 онд 13 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд судалгаа хийсэн бол 2021 онд яамд, ЗГ-ын агентлаг, 21 аймгийн болон нийслэлийн 9 дүүргийн ил тод, нээлттэй байдалд үнэлэлт дүгнэлт өгчээ.Цахим хуудасны 2021 оны үнэлгээний дүнгээр яамдаас ЭХЯ хамгийн өндөр оноо буюу 97.5 оноо авсан бол ХНХЯ 45.5 оноо оноо, Соёл урлагийн газар хамгийн бага 19 оноо авчээ.

Үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Зөвшөөрөл, лицензийн тоог цөөрүүлсэн. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийт 19 чиглэлээр 104 нэр төрлийн

тусгай зөвшөөрөл олгохоор тогтоосон. Гэвч зөвшөөрлийн ерөнхий төрлийг салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн актаар задалж, тусгай зөвшөөрлийг шинээр бий болгон эрх бүхий 54 байгууллагаас 900 гаруй төрлийн тусгай зөвшөөрөл олгож байсан байна. МҮХАҮТ-ын “Хүнд суртлын индекс” 2021 оны судалгаагаар төрийн үйлчилгээний үндсэн 4 төрлөөс зөвшөөрлийн үйлчилгээ хамгийн их хүнд сурталтай гэж бизнес эрхлэгчид дүгнэж хамгийн бага үнэлгээ өгсөн ба үнэлгээ 2.48 гарсан байна.

Хууль хоорондын зөрчил, хийдлээс болж иргэдийн аж ахуй эрхлэх эрх зөрчигдөж, улмаар эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа нөхцөл байдлыг арилгах, зөвшөөрөл лицензийн тоог цөөрүүлж, шат, дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан ба 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөнө. Зөвшөөрлийн тухай хуульд 249 тусгай зөвшөөрөл, 113 энгийн зөвшөөрөл олгохоор цөөрүүлж тусгажээ.

Стандартын тоог цөөрүүлсэн. Олон улсын стандарт хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчилсөн. Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.2.3-д заасны дагуу СХЗГ-аас олон улс, гадаад орны дэвшилтэт стандартыг хэрэглэхээр нийт 17 байгууллагын 35 стандартад бүртгүүлэн хэрэглэх зөвшөөрлийг 2022 онд олгосон. Энэ нь тухайн байгууллага өөрийн нутагшуулсан технологи, олон улсын стандартаар бараа, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, боломжийг бүрдүүлсэн. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох зорилтын хүрээнд. 2018-2020 онуудад нийт 137 стандартыг хүчингүй болгож, 97 стандартыг шинэчлэн сайжруулж, 261 стандартыг шинээр баталсан байна. Одоогоор улсын хэмжээнд 6702 стандарт мөрдөж байна.

Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн. Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын 30%-д шалгалт, үлдсэн 70%-д зөвлөн туслах үйлчилгээ болон хяналтын бусад хэлбэрүүдийг ашиглах бодлого баримталж байна. Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан

хяналт шалгалтын хэлбэрүүдийг тогтоож, МХЕГ-ын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар баталсан.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас бизнес эрхлэгчдийг дэмжих, хяналт шалгалтыг зөвхөн эрсдэл ихтэй объект, асуудал руу чиглүүлж, эрсдэл үүсэх магадлал багатай объектыг хяналт шалгалтаас чөлөөлж байна. 2020 оны ээлжит эрсдэлийн үнэлгээг 79076 аж ахуйн нэгж, байгууллагын хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 137171 объектод 31 нэгжийн 1560 улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд бүртгэсэн. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 147 дугаар тушаалаар хяналт шалгалтын эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг баталж, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулсан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг олон нийтэд 12 дугаар сарын 1-ний өдөр хуулийн хугацаанд khyanalt.gov.mn, shienkhyanalt.gov.mn цахим системээр, inspection.gov.mn цахим хуудсаар зарласан байна.

Зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай хуулийг батлав. ХЗДХЯ төрийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хийхийг дэмжих, хэвшүүлэх зорилгоор зарим салбарт төлөвлөгөөт хяналт шалгалт хийхийг түр зогсоох, хяналт шалгалт хийсэн бол тэргүүн ээлжинд зөвлөн туслах, сануулахад чиглэсэн арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай хуулийн төслийг боловсруулж УИХ өргөн мэдүүлснийг УИХ-аас хэлэлцэн баталсан.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Хяналт тавих боломжийг хуульчилсан. Төрийн албаны тухай хуульд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батлахаар тусгасан болно. Сонгуулийн тухай хуулийн 5.5-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас

тогтоосон журмын дагуусонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ / мониторинг/ хийх, ажиглалт хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.” гэж зааснаар Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагын мэргэжлийн төлөөлөл шууд оролцож хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлсэн. Засгийн газраас 2019 оны 12 дугаар сард «Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа»-г улсын хэмжээнд зохион байгуулав. Судалгаанд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн 291 сум, 545 багийг хамруулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэг хувийг хөдөө, орон нутгийн багт амьдардаг иргэд эзэлж байна. Төрийн үйлчилгээний салбар, чиг үүргийг нийт 13 салбарт хуваан иргэдээр үнэлүүлсэн. Салбарууд дунджаар 3.1 гэсэн үнэлгээтэй байгаа бол 7 салбар дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад нь дунджаас доогуур үр дүнг харуулж байна. Төрийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой бүлэг асуултаас мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдалтай холбоотой асуултауд илүү өндөр үнэлгээтэй байна. Харин үйлчилгээний ачааллын хэвийн байдлыг хамгийн тааруу үнэлжээ.

Иргэд саналаа цахим хэлбэрээр илэрхийлэх боломж бүрдүүлсэн. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр илэрхийлэх боломжтой цахим үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn систем болон 11-11.mn системийг харилцан мэдээлэл солилцох боломжтой байдлаар холбосон. Уг ажлын хүрээнд иргэдийн сэтгэл ханамжийг тандан судалж, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг төрийн үйлчилгээний чанарын талаар иргэдийн санаа бодлыг тандан судалж, судалгааны дүгнэлт, зөвлөмжийг төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бодлого шийдвэрийг

боловсруулах, үнэлэх явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар үнэлэх боломжтой юм.

Үйлчилгээний ажилтанд иргэн үнэлгээ өгнө. Төрийн үйлчилгээний операторын www.operator.e-mongolia.mn системд үйлчилгээний ажилтанд иргэн үнэлгээ өгөх модулийг 2020 оны 06 дугаар сарын 01 нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй иргэдээр төрийн үйлчилгээний чанар, үр дүнг төхөөрөмж ашиглан “Маш сайн”, “Сайн”, “Дунд”, “Муу” гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлж, тухайн салбарын нийт үнэлгээний дундаж дүн мэдээг нэгтгэн, статистик тоон үзүүлэлт хэлбэрээр өдөр бүр иргэдэд нээлттэйгээр байршуулан хүргэж байна. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх зорилгоор төрийн үйлчилгээний оператор ажилтнуудын үйлчилгээ үзүүлж буй байдалд үнэлгээ өгөх үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосон бөгөөд 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн үнэлгээ авах ажлыг хэвийн зохион байгуулж байна. Тус хугацаанд нийт 183,202 иргэн үнэлгээ өгснөөс 19,804 иргэн маш сайн, 1,651 иргэн сайн, 110 иргэн дунд, 44 иргэн муу үнэлгээ өгсөн ба 161,593 иргэн үнэлгээ өгөөгүй байна. Нийт үнэлгээ өгсөн иргэдийн дундаж үнэлгээ 97,2 хувь байна.

Дүгнэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Зөвлөлдөх санал асуулгын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/, Цахим гарын үсгийн тухай / шинэчилсэн найруулга/ зэрэг хууль батлагдсан нь энэхүү зорилтын хэрэгжилтийн тогтвортой үргэлжлэх үр дагавар юм. Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар ярихад төрийн албыг шинэчлэн хөгжүүлэх, төрийн албан хаагчийн ур чадварыг дээшлүүлэх асуудлыг хамтад нь ярих шаардлага үүснэ. Иймээс үнэлгээний хүрээ 1-д төрийн албаны шинэчлэл, хүрсэн үр дүнг тодорхойлсон. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимтэй явуулж үйлчилгээ цахим болохын хирээр төрийн байгууллага болон иргэнд учрах зардал буурч,

төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдал нэмэгдэж байна.

Зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрсэн үр дүнг хүрэх үр дүнтэй харьцуулахад “Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх” гэсэн үр дүнд хүрсэн гэж дүгнэж зорилтод хүрсэн түвшинг дараахь байдлаар тодорхойлж байна: Албан тушаалтны нөлөө, бусад хүчин зүйлээс ангид, авлигын эрсдэлгүй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлагын дагуу төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд үр дүнтэй явагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол УТУГ-ыг шинээр байгуулсан нь цаашдын үйл ажиллагааны үр дүнд эерэгээр нөлөөлнө.

Энэ ажил цаашид үргэлжлэн байнгын шинж чанартай үйл ажиллагаа болох орчин бий болсон ба одоогоор эхлэлийн байдалтай байгаа болон бэлтгэл нь хангагдсан арга хэмжээ хэрэгжээд явах бүрдсэн. Иймээс үнэлгээний хүрээнд тавьсан зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж дүгнэж байна.

5.3–Үнэлгээний хүрээ 3

Үнэлгээний хүрээ	Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх

Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд хөтөлбөрт 10 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 35 арга хэмжээ тусгагдсан.

Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны

удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлаас тухайлан дурдвал:

Улсын төсвийг олон нийтэд нээлттэй болгох ажиллагааг зохион байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах, олон нийтэд нээлттэй ил тод болгохын тулд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг баталсан. Уг журмын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтыг <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглан гүйцэтгэх болсон. 2020, 2021 онд төсөл, арга хэмжээний санхүүжилт онлайн байдлаар шуурхай шийдэгдэх, төсөл бүрээр нарийн мэдээлэл авах, орон нутаг болон салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцах, хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүй, тоон мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг авах боломжтой болсон.

Судалгааны үзүүлэлт сайжирсан. Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас 2 жил тутам хийгддэг төсвийн ил тод байдлын судалгаагаар 2017 онд 46 оноо /100 оноо авахаас/ авч байсан бол 2021 онд 60 оноо авч, Монгол Улс судалгаанд хамрагдсан 120 орноос 38-д эрэмбэлэгдэж, 2017 оноос 18 байраар ахиж, 14 оноогоор илүү дүгнэгдсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн. 2023 оны төсвийн төсөлд иргэдийн саналыг “D-parliament” цахим систем, гар утас, цахим шуудангаар авсан. Цахим системээр 68 641 мянган хүн зочилж 14563 иргэн 2023 оны төсвийн тухай хуультай танилцжээ. Иргэдийн 798 саналаас 302 нь цахимаар ирснийг тухай бүрд нь хариуг нь өгч, холбогдох ажлын хэсэг Төсвийн байнгын хороонд уламжилжээ. Эдгээр саналын ихэнх нь зардлыг танах, халамжийг оновчтой болгох, төсвийн алдагдлыг багасгах тухай байв. УИХ-ын Төсвийн байнгын хорооноос санаачилж, олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн төсөв дэх оролцоо, хяналтыг сайжруулах зорилгоор 2023 төсвийн олон нийтийн анхны хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн. Төрийн аудитын байгууллагаас 2015-2020 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 8 удаа нийцлийн аудит хийж, нэгдсэн тайланг УИХ болон холбогдох байгууллагуудад хүргүүлж, цахим хуудсанд ил тод байршуулсан. Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах, цахим хуудсыг боловсронгуй ажил хийгдэж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдсан. Тус хуулийн "Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт" бүлэгт тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж байхаар тусгасан.

"Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр"-ийг Монгол банкны ерөнхийлөгчийн 2020 оны А-366 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Үр дүн буюу гүйцэтгэлд суурилсан тогтолцоо. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоог үр дүн буюу гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх ажил хийгдэж байна. Тухайлбал, улсын төсвийн одоогийн санхүүжилтийг өвчин, эмгэгийн нэр төрөл, тусламж, үйлчилгээний өртөг, тоо хэмжээнд үндэслэн тооцож эрүүл мэндийн даатгалын санд жил бүр шилжүүлснээр иргэн эрүүл мэндийн даатгалаар эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй авах, бүх шатлалын эмнэлгийн эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт авах боломж бүрдсэн.

Тусгай зөвшөөрлийг цахимаар олгоно. Сангийн сайдын 2021 оны 122 дугаар тушаалаар "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа

байгууллагаас олгох тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх журам"-ыг баталснаар Сангийн яам болон харьяа байгууллагаас олгодог хийт 12 тусгай зөвшөөрөл, 3 зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгож байна. Иргэн, аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрлийн хүсэлтээ <https://license.mof.gov.mn> цахим хуудсанд илгээснээр систем автоматаар хянан хариу болон бар код бүхий тусгай зөвшөөрлийг хүсэлт гаргагчид илгээдэг болсон байна.

Төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагаа ил тод болсон. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг хяналт-шалгалт, үнэлгээний цахим систем [/odamis.mof.gov.mn](https://odamis.mof.gov.mn)-д тухай бүр байршуулж, үйл ажиллагааны явц, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг бий болгох зорилгоор Сангийн яам орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлага мэдээллийн системийн бүх модулийн хөгжүүлэлтийг 2020 оны 12 дугаар сард дуусган ашиглалтад оруулсан. Тус системд хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлан, хяналт, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, санал хүсэлт, гомдол, олон нийт хандах сайт болон веб гарын авлага гэсэн цэсүүдийг багтаасан тул тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчин бүрдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ 2016 онд улсын хэмжээнд дунджаар 31.7 хувь байсан бол 2020 онд 60.1 хувьд хүрч өссөн. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд 2019 онд 22 сум буюу нийт сумдын 67 хувь урамшуулал авч байсан бол 2020 онд 248 сум буюу нийт сумдын 75 хувь нь урамшуулал авсан нь орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэсэн үзүүлэлт юм.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг audit.mn сайтад ил тод, нээлттэй байршуулдаг. «Нээлттэй аудит» портал сайтыг визуаль тайлан, статистик

мэдээ, тайлан, иргэдийн оролцоо гэсэн 4 үндсэн цэстэйгээр ажиллуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 7 дугаар хавсралтаар “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудитор тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон.

Төрийн аудитын тухай хуульд нийцүүлэн Улсын Ерөнхий аудитын 2020 оны А/95 дугаар тушаалаар “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг баталсан. 2020 онд MNS 6817 : 2020 Төрийн аудитын 8 стандартыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөн “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”, “Шинжээч (шинжээч/санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд)- ийн ажлын даалгаврын загвар”, “Шинжээч сонгох саналын жишиг баримт бичиг”-ийг Улсын Ерөнхий аудитын тушаалаар тус тус батлан мөрдүүлж байна. Эдгээр цогц арга хэмжээ нь Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангаж ажиллах үндэслэл болж байна.

Зээл тусламжийн зарцуулалтад хяналт тавьсан. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг хяналт-шалгалт, үнэлгээний цахим систем / odamis.mof.gov.mn/-д тухай бүр байршуулж, үйл ажиллагааны явц, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлж байна. Системд санхүүжилтийн цахим үйлчилгээг оруулснаар иргэдийг мэдээллээр хангах, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломж бүрдсэн. Засгийн газартай байгуулсан гэрээ хэлцлийн хүрээнд олон улсын 2 банк, санхүүгийн байгууллага болон 11 орны гадаадын зээл, тусламжийн 103 төсөл, арга хэмжээг 1,242.3 тэрбум, ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөрийн санхүүжилтээр 3 хөтөлбөрийг 578.5 тэрбум, нийт 1,820.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Үндэсний аудитын газраас нийт 134 /Сангийн ямаар дамжин хэрэгжих 115, ТЕЗ-д хамаарах 19/ төсөл хөтөлбөрөөс Монгол Улсын Ерөнхий

аудиторын 2019 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/60 дугаар тушаалын дагуу нийт 67 төсөл, хөтөлбөрийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж дүгнэлт гаргасан.

Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Гэрээний биелэлт сайжирсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г төрийн өмчит болон төрийн оролцоотой хуулийн этгээдтэй байгуулдаг нь төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах үндсэн арга болдог. 2020 онд төрийн өмчит 961 хуулийн этгээд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнүүлснээс 182 хуулийн этгээд “сайн”, 779 хуулийн этгээд “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Гэрээний биелэлтийн 2020 оны улсын дундаж дүн 93.03 хувь байсан нь 2019 оныхоос 1.2 пунктаар өссөн. 2021 онд 985 хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулсан.

Төрийн өмчийн захиран зарцуулалтад дүн шинжилгээ хийсэн. 2021 онд төрийн өмчит 38 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт явуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад дүн шинжилгээ хийсэн. Энэ чиглэлээр санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, зөрчлийг арилгах талаар 146 арга хэмжээ бүхий үүрэг даалгавар, 141 арга хэмжээ бүхий зөвлөмж өгч ажилласан байна. Засгийн газраас өгсөн чиглэл, үүргийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 87 хуулийн этгээдийн 2020, 2021 оны эхний 2 сарын байдлаарх тухайн хуулийн этгээдээс цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлтгэсэн хөрөнгө, бараа материалын судалгааг авч, зориулалт, зарцуулалт, зарцуулсан зардлын байдалд дүн шинжилгээ хийсэн. Судалгаагаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 78 компани, төрийн өмчит үйлдвэрийн газар

нийт дүнгээр 6.7 тэрбум төгрөгийн 514 нэр төрлийн бараа материал, ажил үйлчилгээ худалдан авсан дүнтэй байна. 2020 онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажлыг хийсэн ба баримтын шалгалтад 15, системийн шалгалтад 7, гүйцэтгэлийн шалгалтад 10 хуулийн этгээд тус тус хамрагдсан болно. Баримтын шалгалтаар 21.2 тэрбум, системийн шалгалтаар 370,4 сая төгрөгийн зөрчил тус тус илрүүлжээ. Түүнчлэн, төлөвлөгөөт бус баримтын шалгалтыг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд гүйцэтгэсэн байна.

Дүгнэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль, Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль батлагдсан нь зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд голлох нөлөө үзүүлсэн. Мөн энэхүү үнэлгээний хүрээнд хамаарах асуудлаар Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Дотоод аудитын тухай хуулийн төсөл, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг төслийг боловсруулж байгаа болон УИХ-д өргөн барьсан байна.

Хүрсэн үр дүнг хүрэх үр дүнтэй харьцуулахад “Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх” үр дүнд хүрсэн гэж дүгнэж, зорилгод хүрсэн түвшинг дараахь байдлаар тодорхойлж байна: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаад зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх

чиглэлээр арга хэмжээ авч ажилласан, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох хууль батлагдсан болон боловсруулсан, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор цахим системд шилжсэн зэрэг үйл ажиллагаа явуулж үнэлгээний хүрээнд холбогдох зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж дүгнэж байна.

5.3-Үнэлгээний хүрээ 4

Үнэлгээний хүрээ	Худалдан авах ажиллагааны, хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх

Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах зорилтын хүрээнд хөтөлбөрт 5 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 15 арга хэмжээ тусгагдсан.

Худалдан авах ажиллагааны, хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлын дурдвал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, холбогдох журам, жишиг баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдаж худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болсон.

Худалдан авах ажиллагаа бүрэн цахимжсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2017 онд нийт 4567 тендерийн урилгыг нээлттэй мэдээлсэн, 2144 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь нийт зарласан

тендер шалгаруулалтын 47.0 хувийг эзэлж байсан бол 2021 оны байдлаар давхардсан тоогоор нийт 21,739 төсөл, арга хэмжээний урилга нийтлэгдсэнээс 21,585 төсөл, арга хэмжээг цахим тендер шалгаруулалтаар зохион байгуулсан нь нийт урилгын 99.3 хувийг эзэлж байна. Энэ нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна.

“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” буюу www.tender.gov.mn-ийг одоогийн байдлаар худалдан авах ажиллагааг 100 хувь цахимжуулан ашиглаж байна. Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2018 онд 1433 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21417 төлөвлөгөө бүртгэгдэж байсан бол 2021 онд 2694 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21739 мэдээлэл бүртгэгдэж, цахим системээр олон нийтэд нээлттэй мэдээлэгдсэн байна.

Цахим системийн хөгжүүлэлт хийсэн. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн шаардлагатай хөгжүүлэлтийн ажлыг хийж, боловсронгуй болгож байгаагийн зэрэгцээ нэгдсэн системийн дэд системүүдийг үе шаттай нэвтрүүлэн ашиглаж байна. 2019 онд системийг боловсронгуй болгох, хууль журамтай холбоотой өөрчлөлтүүдийг хийж, 2020 онд үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Тухайлбал, Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, ШӨХТГ цахим хэлбэрээр хүлээн авч хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн, 2020 оны байдлаар 292 гомдлыг бүртгэсэн. Мөн гэрээний гүйцэтгэлийн модулийг ашиглалтад оруулж, системд 19652 гэрээний мэдээлэл бүртгэсэн, тодруулгыг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг нэмж бүрдүүлсэн ба 2020 оны байдлаар уг системд 879 тодруулгыг бүртгэсэн ба түншлэлийг цахим хэлбэрээр гаргах нөхцөл бүрдүүлж, уг системд 1141 хүсэлт бүртгэгдэж, 769 түншлэлийн гэрээг байгуулсан байна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 12 арилжааны банктай цахим систем /www.tender.gov.mn/-ийг холбосон бөгөөд тус байгууллагуудын тендерийн баталгаа гаргах үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар гэрээ

байгуулсан 120 төсөл, арга хэмжээний 136 багцын 98 гэрээний мэдээллийг цахим системд бүрэн оруулсан.

Гомдлын тоо буурсан. 2021 онд нийт 1,207 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 262 гомдол буюу 22 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 870 буюу 72 хувь нь захиалагчийн шийдвэрт, 75 буюу 6 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсхүл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын тоо 2017-2018 онд өсөх хандлагатай байсан боловч сүүлийн 2 жил тасралтгүй буурсан. Энэ нь 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, тендер оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг улсын орлого болгох болсонтой холбоотой байх магадлалтай юм.

Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн. Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Тендер оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталсан. Энэхүү журамд эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсан шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэхээр, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж нь эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг тухай бүр шинэчилж, худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д олон нийтэд нээлттэй байршуулахаар заасан.

2019 онд гэрээний үүргээ биелүүлээгүй 20 этгээдийн мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт Худалдан авах ажиллагааны цахим систем болон Сангийн яамны <https://mof.gov.mn/article/tender/blacklist> цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлж байсан бол 2021 оны байдлаар уг бүртгэлд 51 тендер оролцогчдыг хамруулж, олон нийтэд мэдээлсэн. Мөн тогтоолд эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд

хамруулах хугацаа нь энэ тухай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 3 жил байна гэж, захиалагч хуулийн 14.5-д заасны дагуу эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзана” гэж тус тус заасан.

Концесс, гэрээ шууд байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 52.1.3-т “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах эрхтэй” гэж заасан байна. Сангийн яамнаас “Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх заавар”-ын төслийг боловсруулсан.

Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхэд анхаарах асуудлын талаар зөвлөмж гаргасан. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн саналыг үндэслэн “Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх заавар”-ыг боловсруулах явцад Улсын дээд шүүхийн 2021 оны 126 дугаар тогтоолоор гэрээ шууд байгуулахтай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд гэрээ шууд байгуулах заавар батлах тухай тусгайлан заагаагүй тул дээр дурдсан шүүхийн практикийг таниулан сурталчлах, хууль хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр захиалагч нарт тодорхой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2021 оны 6-1/6076 тоот албан бичгээр «Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхэд анхаарах асуудлын талаар зөвлөмж» хүргүүлсэн. Зөвлөмж нь хуульд заасан гэрээ шууд байгуулах үндэслэлийг

нийтлэг 6 хэсэгт хувааж тус бүрд нь анхаарах шаардлагатай асуудлын талаар дурдсанаас гадна тендерт оролцогчтой хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад алдаа гаргахгүй байх дараалал журмыг тодорхой тусгасан.

Концессын тухай хуулийг боловсронгуй болгох. Засгийн газрын тухай хуульд орсон 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч улмаар концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг Үндэсний хөгжлийн газраас Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжсэн байна. Төрийн худалдан авах ажиллагааны газраас концесс олгох уралдаант шалгаруулалт, концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох ажлын хүрээнд хуулийн төсөл боловсруулах, судалгаа хийх ажлыг эхлүүлсэн боловч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьсантай холбоотойгоор хойшилсон байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг орчныг үнэлж, өгсөн зөвлөмжид: “Монгол Улс цахим-худалдан авалтын цогц системийг нэвтрүүлж байгаа нь сайшаалтай байна” гэж тэмдэглээд “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээнд бүх төрийн байгууллагуудыг оруулахаар өргөтгөх, (Монгол Улсын Хөгжлийн банк гэх мэт) хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг багасгах. Ялангуяа шууд гэрээ байгуулахыг багасгах, шударга өрсөлдөөн, үр дүнтэй, нээлттэй байдлыг хангахын тулд концессын гэрээ олгох үе шат болон төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах” зэрэг зөвлөмж өгсөн.

Шударга байдлын үнэлгээний дүнг дурдвал:

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас шударга байдлын үнэлгээг гаргаж байна.

Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэлх оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ.

Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед буюу 2016 онд явуулсан шударга байдлын үнэлгээгээр ТӨБЗГ 100 оноо авахаас 71.2 % оноо авч байсан ба 2021 онд явуулсан шударга байдлын үнэлгээгээр Худалдан авах ажиллагааны газар /тусдаа гарсан/ 72.6 % оноо авч, үнэлгээгээ ахиулсан үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

2022 оны 6 дугаар сарын 10-нд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Хууль дагаж гарах холбогдох журмууд батлагдан үйлчилж байна. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх талаар үйл ажиллагаа явуулснаар энэхүү зорилтын хэрэгжилт нь худалдан авах ажиллагааны үр ашигтай цахим тогтолцоог бий болгон хөгжүүлэхэд голлох үр нөлөө үзүүлсэн. Мөн зарим хуулийн төсөл УИХ-д өргөн барьсан болон боловсруулж байна. Тухайлбал, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл, Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн энэ хугацаанд худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлагыг дээшлүүлэх, үр ашиг нэмэгдэх нөхцөл үндсэндээ бүрдсэн. 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аар батлагдсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд зарим төрлийн худалдан авалт нийтлэг дүрэм, журмаар бус онцгой горимоор хийгдсэн тохиолдлууд бий боловч цар тахлын аюул арилах цагт нэгэнт тогтсон хууль, эрх зүйн зохицуулалт үйлчлэх нь тодорхой тул энэ нь түр зуурын нөлөөлөлтэй гэж үзлээ.

Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед буюу 2016 онд явуулсан шударга байдлын үнэлгээгээр ТӨБЗГ 100 оноо авахаас 71.2 % оноо авч байсан ба 2021 онд явуулсан шударга байдлын үнэлгээгээр

Худалдан авах ажиллагааны газар /тусдаа гарсан/ 72.6 % оноо авч, үнэлгээгээ ахиулсан үзүүлэлттэй байна. Иймээс хүрсэн үр дүн нь хүрэх үр дүн болох "төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх" үр дүнд хүрсэн гэж дүгнэж зорилтод хүрсэн түвшинг дараахь байдлаар тодорхойлж байна: Худалдан авах ажиллагааны цахим системийг нэвтрүүлж, хөгжүүлснээр тендерийн будилаан, авлига хээл хахуулыг халах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хангахад чухал нөлөө үзүүлж, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүй хүссэн үедээ цахим хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлж, худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн үр дагавар гарсан байна.

5.3-Үнэлгээний хүрээ 5

Үнэлгээний хүрээ	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд хөтөлбөрт 17 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 34 арга хэмжээ тусгагдсан.

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Хууль шинэчлэн баталсан. УИХ-аас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдаж,

2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдсөн Шүүхийн тухай хуульд /шинэчилсэн найруулга/ шүүгчийг/ сонгон шалгаруулах журам, шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигчийн шалгалт, шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх, томилох, бүрэн эрх үүсгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох процессыг тодорхой тусгаж, шүүгчийг сонгон шалгаруулах процесс олон нийтэд нээлттэй, ил тод байх эрх зүйн орчин бүрдсэн. Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг Шүүхийн тухай хуулиар тодорхой болгосон. Прокурорын тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан ба хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Прокурорын мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын Ерөнхий прокурор батална.” гэж заасны дагуу УЕПГ-аас “Прокурорыг сонгон шалгаруулах журам”, “Прокурорыг албан тушаалд дэвшүүлэх, бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журам”, “Дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, ур чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна.

Ёс зүйн хэм хэмжээ тогтоосон. Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд шүүгчид хориглох зүйлийг нарийвчлан тусгасан ба энэхүү хориглолтууд нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ болж, зөрчсөн талаарх гомдол, мэдээллийг Сахилгын хороогоор шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна. Мөн шүүгчийн ашиг сонирхлын зохицуулалт, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг, шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт зэргийн хуульчилж, энэ талаарх зөрчлийг Сахилгын хороо шийдвэрлэхээр болсон. Өөрөөр хэлбэл, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг хуулиар тогтоосон болно. Прокурорын тухай хуулийн 65.2-т “Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар зарлигаар “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах

журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зохицуулалт тусгагдсан. Шүүх хуралдааныг нууцтай холбоотой асуудал хэлэлцэх хэсгийг хаалттайгаар бусад хэсгийг нээлттэй явуулах эрх зүйн орчин бүрдсэн. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 3.2 дугаар зүйлд “Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна”, Шүүхийн тухай хуулийн 12.2-т “Шүүх хуралдааныг хуульд зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.”, мөн зүйлийн 12.6-д “Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлж болох бөгөөд холбогдох журмыг Ерөнхий зөвлөл батална.” зэрэг зохицуулалт туссан.

Цахим системийг нэвтрүүлсэн. ШЕЗ-өөс «Монгол Улсын шүүхийн цахим сан», «Эрэн сурвалжлах албадан ирүүлэх» бүртгэл тайлангийн систем, “Санал хүсэлт»-ийн систем, «Иргэний хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем, “Захиргааны хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем гэсэн 5 цахим үйлчилгээний системийг нэвтрүүлжээ. 2021 онд Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн системд хөгжүүлэлт хийж “Судалгааны модуль”-ийг шинээр бий болгон 2021 оны 10 дугаар сараас эхлэн ашиглалтад оруулсан ба энэхүү системээс прокурорын хяналтад орсон авлигын гэмт хэрэг, түүний төрөл, зүйл хэсэг, шийдвэрлэлтийн болон бусад мэдээллийг аль ч нэгж прокурорын газраас улсын хэмжээнд болон тодорхой бүс, нутаг дэвсгэрээр судлах, дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн Прокурорын байгууллагаас цаашид авах арга хэмжээг тодорхойлох, албан хаагчийг сургах, дадлагажуулах, чадавхжуулах зэрэг үйл ажиллагаанд ашиглах нэгдсэн мэдээллийн санг бий болгосон байна.

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Авлигатай тэмцэх газар 2017 оны 1 дүгээр сард Авлигын эсрэг үндэсний чуулганыг зохион байгуулж, “Авлигатай тэмцэх эрх зүйн

орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдвээр салбар хуралдаан хийж, анхаарах асуудал, эрх зүйн орчин шийдвэрлэх арга замын талаар хэлэлцүүлсэн.

Нэгдсэн мэдээллийн сантай болсон. Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 оноос эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, цахим хуудсыг 2018 оны 06 сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна. Мөрдөн шалгах ажиллагаа болон прокурор, шүүхийн байгууллагуудын дунд “гэмт хэргийн цахим сан”-тай болсон бөгөөд энэхүү цахим мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох ажил тогтмол хийгдэж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл нэгдсэн санд бүрэн бүртгэгдэж, бүртгэсэн мэдээллийг хайлтаар шүүж үзэх боломжтой болсон.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан гарсан. Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2020 онд хийгдсэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайланд “Мөрдөгч, прокурор, шүүгч нарын дунд ойлголт хандлага, арга ажиллагааны хувьд зөрүүтэй зүйлүүд байгаа нь судалгаанаас харагдсан. Тиймээс харилцан бие биеэсээ суралцах, мэдлэг, мэдээлэл хуваалцах, хууль тогтоомж, журам, арга ажиллагааны талаар ижил ойлголт, нэгдмэл хандлага бий болгох шаардлагатай” гэжээ.

Хамтын ажиллагааг сайжруулахаар ажилласан. Энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласан ба авлигын хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих, шийдвэрлэх ажиллагаанд авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар нэгдмэл ойлголт, хууль хэрэглээг бий болгохоор шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд хамтарсан хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, харилцан санал зөвлөмжөө

солилцож, хэлэлцсэний дүнд холбогдох гарын авлага боловсруулж гаргасан байна. Тухайлбал, “Авлигын хэргийг мөрдөн шалгах арга зүй”, “Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт”, “Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик” гэсэн гурван гарын авлага гарсан нь Эрүүгийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чухал ач холбогдолтой болжээ.

Авлигын гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, нийт шалгасан хэргийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. 2007-2016 онд жилд дунджаар 200 орчим хэрэг шалгаж байсан бол сүүлийн гурван жилд дунджаар 1300 орчим хэрэг шалгаж байгаа нь 6.5 дахин өссөн үзүүлэлт юм. Шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоо болон хохирол нөхөн төлүүлэлт, хөрөнгө буцаах байдалд эрс өөрчлөлт гарч байна. 2019 онд 11.3 тэрбум, 2020 онд 35.6 тэрбум, 2021 онд 96.2 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулж, улсын санд хуримтлуулсан байна. Шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан хэргийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулдаг. Тус хэвлэлийн бага хурлаар олон нийтийн анхаарал татсан, авлига албан тушаалын хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн дүн мэдээг танилцуулж хэвшээд байна. “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг 2020 онд 8 удаа, 2021 онд 7 удаа зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 255 хэвлэл мэдээллийн байгууллага, 293 сэтгүүлч сурвалжилж олон нийтэд хүргэлээ. “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг 2021 онд нийт 7 удаа зохион байгуулсан.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосон. Авлигатай тэмцэх газраас шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолын хуулбарыг шүүх, прокурорын байгууллагаас хуулбарлан авч сан бүрдүүлэн, дүн шинжилгээ хийж байна. 2011-2020 онд шүүхээр шийдвэрлэгдсэн “Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” 10 ботийг хэвлүүлэн олон нийтэд түгээсэн. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ

болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой болсон.

Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоох, нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны хүрээ нэмэгдсэн. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны хүрээг тодорхойлоход тухайн албан тушаалын авлигад өртөх эрсдэлийг үндэслэл болгохоос гадна хуулиар тогтоосон хэрэгжүүлэх чиг үүрэг, албан тушаалын ангилал зэрэглэл зэргийг баримталдаг. Мэдүүлэг гаргагчийн тоо 2021 онд 43692 байсан бол 2022 онд 47553 болж өссөн нь 2021 оны сүүлчээр зарим байгууллага шинээр байгуулагдсан, нөгөө талаас, Авлигатай тэмцэх газраас 2021 онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компаниудад мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалт явуулж, удирдах болон эрх бүхий албан тушаалтныг илрүүлж, тэднийг мэдүүлэг гаргагчаар нэмсэнтэй холбоотой юм.

Мэдүүлгийг хяналт шалгалтыг цахим системийг ашиглан явуулах нөхцөл бүрдүүлсэн. Албан тушаалтны сүүлийн 5 жилийн ХАСХОМ-ийг хянахад ашигладаг мэдүүлгийн хяналт шалгалтын харьцуулалтын хүснэгтийг боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж хэвшүүлсэн нь гар ажиллагааг багасгаж, хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэх ач холбогдолтой болсон. Мэдүүлгийн хяналт шалгалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх үүднээс мэдүүлгийн цахим мэдээллийн сангаас орлого, хөрөнгийн өсөлтийн харьцаа алдагдсан, үнэн зөв мэдүүлээгүй байж болзошгүй мэдүүлгүүдийг хүний оролцоогүйгээр сонгох техникийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж байна. Улсын бүртгэлийн эд хөрөнгийн, хуулийн этгээдийн, иргэний, гэр бүлийн, тээврийн хэрэгслийн, үнэт цаасны зэргээр нийт мэдээллийн 80 хувийг авч ашиглаж байгаа ба ингэснээр албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгах хугацаа богиносгож, хяналт

шалгалтын тоо, үр дүн дээшилсэн.

Нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгосон. Шүүхийн тухай хуульд шүүгчийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах эрх зүйн орчныг баталгаажуулах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, УДШ-ийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын Ерөнхий прокурор зэрэг албан тушаалтан нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд өгч байх, түүнчлэн Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, УДШ-ийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор ийм шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Шүүхийн ерөнхий зөвлөл нэн даруй хуралдаж Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг УДШ-ээр уламжлуулан хүргүүлж, шийдвэрлүүлж байх зэргээр ШЕЗ шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх ажиллагааг тодорхой тусгасан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор "Нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам", "Нөлөөллийн мэдүүлгийн загвар", "Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримт", "Нөлөөллийн мэдүүлгийн бүртгэл", "Тэмдэглэлийн бүртгэл", "Баталгааны тэмдгийн загвар"-ыг тус тус шинэчлэн баталсан. 2013-2021 оны байдлаар шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс нийт 57 удаагийн нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсэн байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

-УИХ-аас 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд "Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулах"-тай холбогдсон хориглолтыг

нэмж тусгасан.

-Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хууль батлагдаж, 2019 оноос эхлэн даган мөрдөж байна. Хуульд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих, төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох зэрэг албан тушаалтныг хариуцлагуулахад чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн. Тус хуульд төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгохоор тусгасан. Мөн төрийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгохоор тусгасан нь тодорхой төрлийн гэмт хэргийн нэг болох авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд ач холбогдолтой зохицуулалт юм.

-Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг АТГ хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулах, төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг батлахдаа түүнийг тогтоосон үндэслэл, аргачлалыг урьдчилан баталж, нийтэд мэдээлэх, хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайланд тусгах зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан болно.

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор Авлигын эсрэг хуульд холбогдох өөрчлөлт орж Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар улиралд багтаан цахим

мэдээллийн сүлжээнд байрлуулах, тэдгээрийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгалахаар зохицуулсан.

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлснээр тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих, чанаргүй гэрээний үүргээ биелүүлдэггүй компанийг дахин тендерт оролцуулахгүй байх, ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөл боломж бүрдсэн болно.

- Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг Засгийн газарт хүргүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр мөрдөн шалгах ажлын шуурхай байдалд тодорхой ахиц гарсан. Тухайлбал мөрдөн шалгах албаны дарга гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл шалгах хугацааг 14 хүртэл хоногоор сунгах, мөрдөгч нар төрийн болон иргэний хувийн захидал харилцаа, эрүүл мэндийн нууцаас бусад мэдээллийг бие даан иргэд байгууллагаас авдаг болсон.

Мөн хөтөлбөр хэрэгжих хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай, Татварын ерөнхий хууль зэрэг шинээр гаргасан, шинэчлэн найруулсан хуулиуд батлагдан хэрэгжиж байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах зорилгоор боловсруулсан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэхээр дэмжсэн. Авлигатай тэмцэх газар, ХЗДХЯ-аас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганаар төслийг хэлэлцэхээр дэмжсэн болно. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын

төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлж шударга ёсыг тогтоохын төлөө хувийн эрх ашгаас нийтийн эрх ашгийг өндөрт тавьж байгаа шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тусгасан. Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэж, дэмжин эхний хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн байна.

Мөн Зөвлөлдөх санал асуулгын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/, Цахим гарын үсгийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг баталсан.

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх судалгааны дүнгээс дурдвал:

УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг шинээр тодорхойлон баталсан. Уг тогтоолд “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл”-ийн судалгааг Авлигатай тэмцэх газар зохион байгуулахаар заасан. Судалгаанд “1”-ээс “5” гэсэн үнэлгээг ашигладаг бөгөөд “1” нь авлига огт байхгүй байгааг илэрхийлдэг бол “5” нь авлигын хамгийн өндөр түвшинг илэрхийлдэг. 2016 оны төсөөллийн судалгаагаар авлигын төсөөллийн индекс 3.65 пункт байсан бол 2021 онд 3.85 гарч өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхийн индекс-21. Нээлттэй нийгэм Форум санаачлан “Эрх зүйн судалгааны Оюуны инноваци” ТББ хамтран Шүүхийн индекс-21 судалгааг шүүхийн үйл ажиллагаанд хийсэн ба шүүхийн үйл ажиллагаа 100 онооноос 51.94

оноогоор дүгнэгдсэн байна. Шүүхийн нээлттэй ил тод байдал шалгуур үзүүлэлтээр 62.30 оноо, шүүгчийн ёс зүй ба хариуцлагаар 45.17 оноо, шүүхийн эрх хэмжээ бие даасан байдлаар 51.60, шүүхэд итгэх олон нийтийн итгэл 53.17 оноогоор дүгнэгджээ.

Дүгнэлт

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэхийн тулд хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, шударга, нээлттэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд цахим мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авсан нь тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд голлох үр нөлөө үзүүлсэн. Шүүхийн болон Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Мөн Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын шинэчилсэн найруулга батлагдсан. Хуулийн заалттай холбогдох журмууд батлагдан гарсан. Хүрсэн үр дүнг буюу 2016 оны болон 2021 оны төсөөллийн судалгааны дүнг харьцуулсан үр дүн нь хүрэх үр дүн болох “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх” гэсэн үр дүнтэй харьцуулахад судалгааны дүн өссөн үзүүлэлттэй гарч сайжраагүй байна. Хөтөлбөрийн холбогдох зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласан боловч харьцуулалтаар хүрэх үр дүнд хүрээгүй байгааг харгалзан тавьсан зорилтын хэрэгжилтийн үр дагавар тодорхой гараагүй гэж дүгнэж байна.

5.3-Үнэлгээний хүрээ 6

Үнэлгээний хүрээ	Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байх

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтын хүрээнд хөтөлбөрт 5 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 21 арга хэмжээ тусгагдсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Эрх зүйн баримт бичгийг баталсан. Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, ашиглах журам”, ХЗДХ-ийн сайд, Гадаад харилцааны сайдын 2019 оны А/16, А/07 дугаар хамтарсан тушаалаар “Олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, ХЗДХ-ийн сайдын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулснаар Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгосон байна.

Авлигын эсрэг үндэсний чуулганы салбар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газар 2017 оны 1 дүгээр сард

Авлигын эсрэг үндэсний чуулганыг зохион байгуулж, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал” сэдвээр хэлэлцүүлэг явуулж авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой, санал бодлоо солилцож, тулгамдсан асуудлаа хэлэлцсэн.

Шинэ сэргэлтийн бодлого. 2021 онд УИХ-ын 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодод эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэхээр тусгагдсан байна. “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоол гарсан. Уг тогтоолоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох газруудад үүрэг болгосон.

Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороог байгуулсан. Бизнес, хөрөнгө оруулалтын орчинд тулгарч буй түгээмэл саад, бэрхшээлийг төр, хувийн хэвшлүүд хамтран шийдвэрлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахад хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх хуулийн этгээдийн төлөөллөөр тухай асуудлыг хэлэлцүүлж, санал авч, зөвшилцөл хийх, мэдээллээр хангах үүрэг бүхий “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо”-г 2017 онд Засгийн газрын ХЭГ-ын даргын тушаалаар «Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл»-ийн дэргэд байгуулсан. 2017-2020 оны хугацаанд Зөвлөлдөх хорооны хурлыг нийт 10 удаа, техникийн ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, гурван зөвлөмж гаргажээ.

МУХАУТ-ын 21 аймаг дахь Салбар танхимууд аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

Хуулийн төсөл боловсруулж, батлуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, сахилга батыг сайжруулах, хувийн хэвшил хийж болох бизнесийн салбар болон талбарт төр бизнес эрхэлж өрсөлдөхгүй байх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 5 сарын 04-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай хуулийг УИХ-аас баталсан.

Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллагад “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөө”-г нийтлэг байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд “төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах” зорилтыг 2021 оноос эхлэн тусгасан. Үүний дагуу 50 гаруй байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх агуулга бүхий заалтыг хувийн хэвшил, ТББ болон иргэнтэй байгуулсан гэрээндээ тусгажээ.

Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Бизнесийн ёс зүйн төвийг байгуулсан. Монгол Улс дахь бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх, бизнесийн таатай орчныг дэмжих зорилгоор МҮХАҮТ, “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ болон “Рио Тинто Монгол” ХХК нь хамтран “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд МҮХАҮТ-ын дэргэд “Бизнесийн ёс зүйн төв”-ийг 2021 онд байгуулж, тус төвөөр дамжуулан бизнесийн байгууллагуудад ёс зүйн дүрэм боловсруулах, бизнесийн болон мэргэжлийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Бизнесийн ёс зүйн төвөөс “Ёс зүй тогтвортой бизнес” цахим аяныг өрнүүлж, томоохон аж ахуйн нэгжүүд бизнесийн ёс зүйн тогтолцоог бүрдүүлж байгаа сайн туршлагаас сурталчилсан байна.

Комплаенс бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэгч энтрепринер номинаци бий болгосон. МҮХАҮТ-аас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг авлигаас ангид, бизнесийн ёс зүйг

эрхэмлэх, комплаенсыг хэрэгжүүлэх бодлого зохицуулалтыг дотоод дүрэм журамдаа оруулж хэрэгжүүлэх, ёс зүйн кодтой болох шаардлага тавьж ажиллаж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг орчныг үнэлж 2019 онд өгсөн зөвлөмжид: “Аж ахуйн нэгжүүдэд авлигын эсрэг үр дүнтэй комплаенс хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх түлхэц, урамшуулал өгөх” гэж зөвлөснийг МҮХАҮТ хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах ёслолын ажиллагаанд “Комплаенс бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэгч энтрепринер” номинацийг 2021 онд шинээр оруулсан.

МҮХАҮТ-ын дэргэдэх Комплаенсын үндэсний зөвлөлөөс “Комплаенсын төлөв байдал-2021” судалгааг 2 дахь жилдээ түүврийн аргаар авч явуулсан байна. Судалгааны дүнгээс харахад бизнес эрхлэгчид ёс зүйн мэдрэмжтэй бөгөөд байгууллагынхаа ашгаас илүүтэй хууль, журамд нийцүүлж ажиллахад ач холбогдол өгөх хандлагатай боловч Монгол Улсад хууль зөрчсөн хэрнээ амжилттай ажиллаж буй байгууллагууд байгааг илтгэж байх тул уг тогтолцоог өөрчлөх, хууль ёсны дагуу ажиллаж байж гагцхүү амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Гэрээний ил тод байдлын цахим санг бий болгосон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба хамтран «www.iltodqeree.mn» гэрээний ил тод байдлын цахим санг бий болгож, 2019 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан. 2020 оны байдлаар уг санд 796 гэрээ байршуулснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ 26, Хөрөнгө оруулалтын гэрээ 4, Тогтвортой байдлын гэрээ 11, Орон нутагтай хамтран ажиллах 167 гэрээг байршуулсан. 2021 онд мэдээллийг шинэчлэн 883 гэрээ байршуулснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ 26, Хөрөнгө оруулалтын гэрээ 4, Тогтвортой байдлын гэрээ 11, Орон нутагтай хамтран ажиллах гэрээ 167-г байршуулжээ.

Хууль батлагдсан. Иргэдийн аж ахуй эрхлэх эрх зөрчигдөж, улмаар эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа нөхцөл байдлыг арилгах, зөвшөөрөл лицензийн тоог

цөөрүүлж, шат, дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан ба 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөнө. Татвар төлөгчийн эрсдэлийг тооцох, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Татварын ерөнхий хуулийн дагуу холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн баталж мөрдөж байна. 2018-2020 онуудад нийт 137 стандартыг хүчингүй болгож, 97 стандартыг дахин хянаж шинэчлэн сайжруулж, 261 стандартыг шинээр баталсан байна.

Хяналт шалгалт хийсэн. ШӨХТГ-аас төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэр нь Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхэд хяналт шалгалт 13 удаа хийсэн. Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн 9 шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, Гадаад улсад зорчих иргэдээс ПСР шинжилгээг Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Интермед эмнэлэгт төлбөртэйгөөр авахуулах агуулга бүхий Эрүүл мэндийн сайдын тушаал нь нэг аж ахуйн эрхлэгчид давуу байдал олгосон хэмээн тушаалыг хүчингүй болгуулжээ.

Мэдээлэл нээлттэй болсон. Улсын бүртгэлийн багцхуулийг 2018 онд Улсын Их Хурлаас баталсан. Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжсэнээр хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй болгосон.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгосон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг цуглуулах системийг хөгжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулах институцийг бэхжүүлэх чиглэлээр УБЕГ, АМГТГ, ТЕГ-тай хамтран цахим сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл солилцох зэргээр хамтран ажиллаж байна. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2020 оны тайланд

687 компанийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгосон бол 2021 онд 751 компанийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгосон.

Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

2020 онд Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшлийн 21 байгууллагын 320 хүнд сургалт зохион байгуулж, гарын авлага материал түгээсэн. МҮХАҮТ-ын дэргэдэх “Бизнесийн Ёс Зүйн Төв”-өөс 2021 онд “Хариуцлагатай бизнес, бизнесийн шударга байдлын аргачлал хэвшүүлэх” модуль сургалтыг зохион байгуулж, хувийн хэвшлийн төлөөлөл 150 хүн хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас үл хөдлөх хөрөнгө зуучлалын сургалтыг 3 удаа зохион байгуулж, 60 зуучлагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр сургалт явуулсан. Стандарт, хэмжил зүйн газраас хувийн хэвшлийн байгууллагуудад олон улсын стандарт, хэм хэмжээг үйл ажиллагаандаа тусгаж нэвтрүүлэх, чадавхжуулах 38 удаагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж компаниудын 1140 хүнийг хамруулжээ. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 155 аж ахуйн нэгжийн 2500 албан тушаалтныг хамруулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа. Татварын ерөнхий газраас Улсын хэмжээнд 2147 удаагийн сургалт зохион байгуулж хувь хүн 77948, нийт 142327 татвар төлөгчийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас “Хариуцлагатай бизнес, бизнесийн шударга байдлын аргачлал хэвшүүлэх” сургалтыг 30 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөлд зохион байгуулж, бизнесийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад дотоод хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага, удирдлага болон үйл ажиллагаа, нэр хүндийг энэ төрлийн эрсдэлээс хамгаалахад чиглэгдсэн бодит бодомж /кейс/ дээр суурилсан үнэлгээний аргачлал, зааварчилга өгсөн.

Дүгнэлт

Тус зорилтын хүрээнд хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

чиглэлээр Авлигатай тэмцэх газар, МҮХАҮТ болон бусад байгууллага, аж ахуйн нэгж хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажилласан. Авлигын эрсдэлийг бууруулахын тулд ил тод байдлыг дэмжиж цахим сан байгуулах, ашиглах чиглэлээр үр дүнд хүрсэн үйл ажиллагаа явуулжээ. 2019 онд Татварын ерөнхий хууль, 2022 онд Зөвшөөрлийн тухай хууль батлагдсан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл, Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг хэд хэдэн хуулийн төсөл боловсруулж байгаа болон УИХ-д өргөн барьсан байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зорилгоор iltodgeree.mn-д аж ахуй нэгжүүдтэй хийсэн гэрээнүүдийг ил тод болгосон нь авлигын эрсдэлийг бууруулахад хувь нэмрээ оруулах арга хэмжээ болсон. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд тодорхой төрлийн зарим үйл ажиллагааг явуулах эрхийг хувийн хэвшилд шилжүүлэх ажиллагаа хийгдэж, энэ асуудлыг төрөөс бодлогын түвшинд авч үзэж байна. Хүрсэн үр дүнг хүрэх үр дүн болох “Хувийн хэвшилд дэх авлигын эрсдэлийг бууруулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байх” гэсэн үр дүнд хүрсэн байх тул “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх” зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж дүгнэж байна.

5.3-Үнэлгээний хүрээ 7

Үнэлгээний хүрээ	Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	-Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх -Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлж эхэлсэн байх

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтын хүрээнд хөтөлбөрт 6 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 18 арга хэмжээ тусгагдсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Авлигын эсрэг хамтын ажиллагаа. Авлигатай тэмцэх газар 2017 оны 1 дүгээр сард Авлигын эсрэг үндэсний чуулганыг зохион байгуулж, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон ТББ-ын оролцоо” салбар хуралдаан явуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой, санал бодлоо солилцож, тулгамдсан асуудлаа хэлэлцсэн. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ТББ, мэргэжлийн холбоодыг татан оролцуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 60 гаруй ТББ, мэргэжлийн холбоодын удирдлага, төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг хамтын ажиллагаа: ТББ-ын оролцоо” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2020 онд 117,

2021 онд 68 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын санаачилгыг дэмжин хамтран ажиллаж, 2020 онд 47, 2021 онд 23 удаагийн уулзалт, ярилцлагыг тус тус зохион байгуулсан.

Иргэний хяналтын зөвлөл ажиллуулсан. Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд олон нийтийн хяналтыг бий болгох, нийтийн албан тушаалтын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2017-2019 онд иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээ байгуулан ажиллуулсан. Иргэд, олон нийтээс төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилго бүхий “Иргэний хяналтын төв”-ийг 2018-2021 онуудад Дүнжингарав худалдааны төв, Мишээл Экспо, Драгон төв, 6 буудал дахь нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллуулсан.

“АМЖ клуб” байгуулсан. Олон нийтийн зөвлөлийн дэргэд Их Британийн Засгийн газраас 2010 онд ашигласан сайн туршлага болох авлигыг мэдээлэхэд хэрэглэж буй Мэдээлж, Жигш аргад тулгуурлан “Авлигыг мэдээлж, Жигш (АМЖ)” клуб байгуулсан. АМЖ клуб” нь <https://www.facebook.com/naming.shaming> сувгийг ашиглан мэдээлэл хүлээн авч, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг мэдээллийг олон нийтэд хүртээмжтэйгээр түгээх, ард иргэдийн санал бодлыг нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авах, авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх арга замыг түгээн ажиллаж байна.

Хохирол нөхөн төлүүлсэн. Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийн улмаас төр, иргэн, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийн хүрээнд 2020 онд 35,6 тэрбум төгрөгийн, 2021 онд 96,2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж төр, иргэн, нийтийн зөрчигдсэн эрхийг сэргээсэн бөгөөд

энэ талаар байгууллагын цахим хуудас, iaas.mn мэдээллийн хуудас, “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлэг, твиттер facebook пэйж хуудас, МҮОНР-ийн 110 мэдээллийн хөтөлбөр зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгосон.

Ёс зүйн дүрэм баталсан. СЗХ-ны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ын дагуу Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооноос байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийг баталсан ба ингэснээр салбарын холбоодыг бэхжүүлэх, ёс зүйтэй болох улмаар даатгуулагчийн эрх хамгаалагдах тогтолцоо бүрдсэн. СЗХ, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран ажиллах гэрээг 2019 онд 2 жилийн хугацаатайгаар байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалт, “Комплаенс ба ёс зүй” цахим сургалтуудыг хамтран зохион байгуулж, 2020 онд ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалтыг 2 удаа, “Комплаенс ба ёс зүй” цахим сургалтыг 8 удаа явуулсан. Хорооны цахим хуудсанд Хууль, журмын төсөлд санал авах хэсэгт 2020 онд 22 журам байршсан бөгөөд үүний үр дүнд 91 ТББ саналаа өгч оролцсон.

Иргэд, олон нийтийн хяналт. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор Авлигатай тэмцэх газраас “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмаар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн ба төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулахаар журамласан.

Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд

иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулан ажиллуулсан. ХЗДХ-ийн сайд, АТГ-ын даргын 2017 оны А/53, А/44 тоот тушаалаар "Аймаг, нийслэлийн ГХУСАЗЗ болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам"-ыг батлан иргэний хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулсан ба 2017-2019 онуудад Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулсан байна.

Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилгыг дээшлүүлэх, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Хуулийн төсөл боловсруулсан. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд ашгийн төлөө бус хуулийн этгээдийг төрөл тус бүрээр нь нарийвчлан зохицуулахаар, ялангуяа Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр холбооны төрөл, дотоод зохион байгуулалт, удирдлага, төлөөлөл, үүсгэн байгуулагчийг тодорхой болгож, бүртгэл, хяналт, тайлагналт, ил тод байдал, татан буугдах нөхцөл, журмыг тогтоож, төрөөс холбоонд үзүүлэх дэмжлэг зэрэг асуудалтай холбоотой зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн. Үүний дагуу Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг тус тус эцэслэн боловсруулж, УИХ-д 2021 онд өргөн мэдүүлсэн.

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байна. Засгийн газрын ХЭГ-аас 2020 оны 10 сард Засгийн газрын шийдвэрээр төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, явцын мэдээллийг нэгтгэн үнэлгээ хийсэн. Уг судалгаанаас харахад 2020 оны байдлаар Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасныг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авалгүйгээр төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг 10 байгууллага байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажил,

үйлчилгээг үзүүлж байна.

Төрөөс хэрэгжүүлэх зарим чиг үүргийг шилжүүлсэн. Засгийн газрын 2016 оны 124 дүгээр тогтоолд "Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" заасан. Төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ыг батлан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг" төслийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан. Тухайлбал: Сангийн сайдын тушаалаар олгодог байсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг "Мэргэшсэн нягтлан бодогчийн институт" ТББ-д, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг "Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг", нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээг "Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн", Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлсэн. ХНХЯ, Монголын ахмадын холбооны хооронд "Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ"-г 2016 оноос хойш жил бүр шинэчлэн байгуулж, ахмад настны талаар төрөөс хэрэгжүүлэх зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлж, хуульд заасны дагуу санхүүжилтийг олгон ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн яам авто замын салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн материал хүлээн авах, хянах чиг үүргийг "Монголын авто замчдын холбоо" ТББ, олон улсын автотээвэр гүйцэтгэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг "Монголын Авто тээвэрчдийн нэгдсэн холбоо"-нд тус тус шилжүүлсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлсэн. Авлигатай тэмцэх газраас 2020 оны 11 дүгээр сард цахим хэлбэрээр зохион байгуулсан "Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөө" сэдэвт хэлэлцүүлэгт нийт 15

төрийн бус байгууллагын 42 төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлэгт оролцогчдоос 5 чиглэлээр гаргасан санал, дүгнэлтэд тулгуурлан зөвлөмж боловсруулсан

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа этгээдийг мэдээлэл хариуцагч байхаар, энэхүү этгээд нь тус хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг нээлттэй ил тод байлгах аргаар заасан. Нээлттэй байлгах мэдээлэлд ТББ-ын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж хамаарч байна.

Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

ТББ-ыг бүртгэсэн. Улсын бүртгэлийн багц хуулийг 2018 онд Улсын Их Хурлаас баталсан 2019 оны 9 дүгээр сараас ашгийн төлөө бус төрийн бус байгууллагын анхны үүсгэн байгуулагч, эцсийн өмчлөгч, удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж эхэлсэн. Тухайлбал, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээр 1998 онд 1075 ТББ санд бүртгэлтэй байсан бол 2019 онд 21040, 2021 оны 8 дугаар сарын 25-ны байдлаар нийт 26441 ТББ-ыг тус тус бүртгэсэн байна.

Үйл ажиллагааны тайлан гаргасан. Төрийн бус байгууллагын тухай хуульд заасны дагуу төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг ирүүлэхээр заасны дагуу 2020 онд 401, 2021 онд 609 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч ажилласан. Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй төрийн бус байгууллагуудын судалгааг Сангийн яаманд цахим хаягаар хүргүүлж, санхүүгийн тайлан өгсөн эсэх талаар мэдээллийг үндэслэн 2019 онд санхүүгийн тайлан өгсөн төрийн бус байгууллагын жагсаалтыг гарган, Улсын бүртгэлийн нэгдсэн архивд хадгалагдаж байгаа хувийн хэрэгтэй тулгалт хийсэн байна.

Олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн

мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх зорилгоор төрийн байгууллагуудыг холбогдох мэдээлэл судалгаагаар хангаж ажилласан. Тухайлбал, 2020 онд Сангийн сайдын 2020 оны 20 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг”-т улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй төрийн бус байгууллагын, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдаа эрхлэгчийн, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлалын үйл ажиллагаа эрхлэгчийн судалгаа, Зам, тээврийн хөгжлийн яаманд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн 44 төрийн бус байгууллагын судалгаа, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд улсын бүртгэлд бүртгэлтэй холбоо /НҮТББ/-ны судалгаа, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын судалгааг гарган, cnd_data@police.gov.mn цахим хаягаар тус тус хүргүүлэн ажилласан.

Эцсийн өмчлөгчийн мэдээлэл нээлттэй болсон. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар “хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл” нээлттэй мэдээлэлд хамаарахаар болсон, мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.2.3-д “хувьцаа эзэмшигчийн нэр,” гэсний дараа “эцсийн өмчлөгчийн нэр” гэж нэмэлт оруулсан нь ТББ-уудын үүсгэн байгуулагчийн мэдээлэл олон нийтэд ил тод болох эрх зүйн орчин бүрдсэн. УИХ-д өргөн мэдүүлсэн Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд мэдээллийг нээлттэй байлгах асуудлын талаар холбогдох зохицуулалт тусгагдсан.

Дүгнэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй хамтран ажилласан ба олон нийтийн зөвлөл, иргэний хяналтын зөвлөл, клуб зэрэг хэлбэрээр нэгдэн ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, хэрэглэгчийн үнэлгээ хийх, төрийн байгууллагын хүрээн дэх авлигын

төсөөллийн судалгаа хийхэд оролцох, хуулийн төсөл боловсруулахад нөлөөллийн ажиллагаа явуулж, саналаа өгөх зэргээр хамтран ажилласан. Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны үр дүн нь хүрэх үр дүн буюу “Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх” гэсэн үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. Энэхүү зорилтын хэрэгжилтийн үр дагавар нь төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмрээр илэрхийлэгдэж байна.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх ажиллагаа салбар болгонд явагдаж байна. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хийлгэх арга хэмжээний хүрээнд 2021 онд гэхэд Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөр, бодлогын зорилтыг хэрэгжүүлэх явцад төрийн зарим чиг үүргийг 16 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор нийт 721.439.820 төгрөгийн ажил үйлчилгээг гүйцэтгүүлсэн байна. Эдгээр үйл ажиллагааны хүрсэн үр дүнг хүрэх үр дүнтэй харьцуулахад “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлж эхэлсэн байх” гэсэн үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. Харьцуулсан үр дүнг үндэслэн дүгнэхэд үнэлгээний хүрээнд тавьсан зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан байна.

5.3-Үнэлгээний хүрээ 8

Үнэлгээний хүрээ	Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага дээшилсэн байх

Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах хүрээнд хөтөлбөрт 5 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 9 арга хэмжээ тусгагдсан.

Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Хуулийн төсөл боловсруулсан. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 дугаар тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсэгт хэвлэл мэдээллийн салбараас МСНЭ, “Глоб Интернэшнл төв” ТББ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, эрдэмтэн судлаачдын төлөөллийн бүрэлдэхүүн орж ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудад хэлэлцүүлэг хийж саналыг нь аван ажиллаж байна. Хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагын хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, редакцын талаарх мэдээлэл олон нийтэд ил тод

байх шаардлагыг тусгасан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.19-д хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг ил тод байлгах, тус мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж, нээлттэй ил тод байлгахгаар заасан.

Өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2019 онд баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, компанийн эрхбүхий албан тушаалтны жагсаалт, эзэмшиж байгаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нэр, төрөл, тоо, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад хуулийн этгээдэд эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, хэрэв нөхөрлөл бол оруулсан эд хөрөнгийн хэмжээ зэргийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхээр заасан.

2021 оны байдлаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 258 үйлчилгээ эрхлэгч байгаагаас Монголын үндэсний олон нийтийн телевизийн 5, өргөн нэвтрүүлгийн телевиз 78, арилжааны телевиз 65, төлбөртэй телевиз 11, Монголын үндэсний олон нийтийн радио 4, арилжааны радио 59, олон суваг дамжуулах 34, радио телевизийн газрын сүлжээний 2 үйлчилгээ эрхлэгч, эдгээрийн 147 нь Улаанбаатар хотод үйлчилгээ эрхэлж байгаа бол 111 нь орон нутагт үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд энэ тухай мэдээллийг Зохицуулах хорооны цахим хуудас (<https://crc.gov.mn/k/4x/9B>)-нд байршуулсан байна

Эрх зүйн орчныг сайжруулах шаардлага. "Глоб интернэшнл төв" ТББ-аас "Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2021"-д тусгасан Сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүнгээс үзэхэд ажил үүргээ гүйцэтгэх явцад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж судалгаанд оролцсон 247

сэтгүүлчийн 47 хувь нь хариулсан байна. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 20 хувьд нь шүүх, цагдаа, прокуророос дуудах, 18 хувьд нь имэйл, болон утасны мессежээр заналхийлэх асуудал тулгарч байсан ба цаашлаад биечлэн заналхийлэх, мэдээлэл хулгайлах, хувийн онлайн орон зайд халдаж мөрдлөг хийх, хакердах гэсэн асуудлуудыг нэрлэсэн байна. Эдгээр асуудлын эсрэг авч хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрх зүйн орчныг сайжруулах гэж нийт оролцогчдын 64 хувь нь хариулжээ.

Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) олон улсын байгууллагаас 180 орныг хамруулан жил бүр гаргадаг хэвлэлийн эрх чөлөөний 2017 оны индексээр Монгол Улс 69 дүгээр байранд жагсаж байсан бол 2022 онд 90 дүгээр байрт жагсаж байна. Энэ нь 21 байр ухарсан үзүүлэлт болсон.

Хэвлэлийн эрх чөлөөний төлөө Үндэсний түр зөвлөл байгуулсан. Хэвлэлийн хүрээлэнгээс ХБНГУ-ын Ханс Зайдель Сан, Эрх зүйн боловсролын академийн дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн эрх зүйн асуудлаар гурван удаагийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд хэвлэн нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбартай холбоотой амин чухал хууль, эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал, "Гүтгэх үйлдлийн тухай ойлголт", Төрийн ба албаны нууцын тухай хуулийн зохицуулалтыг хөндөв. Хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулж буй эвлэл, холбоод 2020.12.18-ны өдөр нэгдэж, Хэвлэлийн эрх чөлөөний төлөө Үндэсний түр зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь Хэвлэлийн эрх чөлөөг хангах, хамгаалах, баталгаажуулах үндсэн чиглэлээр ажиллах бөгөөд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг батлах хүртэл үндэсний хэмжээний зөвшилцлийн үйл ажиллагаа явуулж байхаар тогтсон байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ. Үндэсний статистикийн хорооноос гаргасан "Ардчилсан засаглал судалгаа"-ны 2018-2021 оны үр дүнд Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг тодорхойлсон ба хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг гэдэгт итгэх иргэдийн итгэл буурчээ. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хэвлэл,

мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хувьд хараат бус байдал хангагдсан эсэхээр илэрхийлэгдэнэ. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг гэдэгт иргэдийн өгсөн оноо 2021 онд 23 болж 2018 оноос өөрчлөлтгүй, 2020 оноос 3 оноогоор буурсан байна. Эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг гэдэгт 2021 онд 2018 оноос 1 оноогоор өссөн, 2020 оноос 4 оноогоор буурчээ.

Нийт иргэдийн 33.6 хувь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус гэдэгтэй санал нийлдэггүй гэж үзсэн байхад 10.8 хувь санал нийлдэг гэж 2020 онд хариулж байжээ. Харин 2021 онд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус гэдэгтэй санал нийлдэг иргэдийн хувь 10.9 хувь буюу өмнөх оноос өөрчлөлтгүй байгаа ч санал нийлдэггүй иргэдийн хувь 38.7 хувь болж өмнөх оноос 5.1 нэгж хувиар өссөн буюу сөрөг хандлага нэмэгджээ. Нийт иргэдийн 24.4 хувь нь хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулжээ.

Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Сэтгүүлчийг чадавхжуулсан.Баримтад суурилсан сэтгүүл зүйг дэмжих,орон нутгийн сэтгүүлчдийг чадавхжуулах зорилгоор Монголын сэтгүүлчдийн холбооноос санаачлан "Орон нутгийн хэвлэл мэдээллийн II форум", Хэвлэлийн хүрээлэнгээс "Хуурамч мэдээлэл ба төөрөгдөл-Иргэдийн мэдэх эрхийг хамгаалах нь" чуулганыг тус бүр 100 гаруй сэтгүүлчийг хамруулан зохион байгуулсан. "Investigative Journalism Dialogue" эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын хурлыг хоёр жил дараалан зохион байгуулжээ. ХБНГУ-ын Дойче Велле Академи, Фридрих Эбертийн сангийн тэтгэлгээр Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн 21 хоногийн сургалтад төв орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 17 сэтгүүлч хамрагдаж амжилттай төгсөв. Залуусын дуу хоолой" чуулга уулзалтын "Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба залуусын оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж 100 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хамрагдсан. Монголын хэвлэлийн хүрээлэнгээс тоон мэдээллийг ашиглаж эрэн сурвалжилсан бүтэл бэлтгэх чадавхыг дээшлүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд цуврал

5 сургалт, 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2022 оны 5 сард АТГ-аас санаачлан Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, "Глоб Интернэшнл төв" ТББ-тай хамтран зохион байгуулсан сургалтад эрэн сурвалжлах чиглэлээр ажилладаг 60 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан.

Ёс зүйн хороо байгуулсан.Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, Радио телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг "Хэвлэл мэдээллийн зөвлөлийн дүрэм", "Үйл ажиллагааны журам", "Гомдол хүлээн авах, барагдуулах журам", "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим"-д тулгуурлан хэлэлцэж, дүгнэлт гаргаж байна. Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015-2020 онд нийт 385 өргөдөл, гомдол, 2021 онд 26 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. МСНЭ 2021 оныг ёс зүйтэй, мэргэжлийн, хараат бус сэтгүүл зүйг төлөвшүүлэх, сэтгүүлчдийн мэргэжил боловсролыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч "Ёс зүй хариуцлагын жил"-ээр зарлан ажиллажээ.НҮБ-ын Ардчиллын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2021 оны 6 дугаар сард сэтгүүлчдийн ажил, үүргээ гүйцэтгэх явцад интернэтээс мэдээлэл эрж хайх, нягтлан шалгах, цахим орчинд эх сурвалжтай харьцах аюулгүй байдлыг хангах аргад суралцах, зайлшгүй мэдэх шаардлагатай зарим мэдээлэл, зөвлөмж бүхий "Сэтгүүлчийн аюулгүй байдал" гарын авлагыг бэлтгэн хүргэжээ.

Хуурамч мэдээлэлтэй хамтын хүчээр тэмцье. Хэвлэлийн хүрээлэнгээс «Хуурамч мэдээлэлтэй хамтын хүчээр тэмцье» уриатай "TechCamp Mongolia-2019" Ази, Номхон далайн бүсийн цугларалтыг Монголд анх удаа АНУ-ын ЭСЯ, "Мидас" ТББ болон Хэвлэлийн Хүрээлэн хамтран зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагаанд Монгол, АНУ, Узбекстан, Казакстан, Киргиз, Вьетнам, Бутан, Непал, Мьянмар улсаас төлөөлөн ирсэн сэтгүүлч, нийгмийн сүлжээний идэвхтнүүд оролцсон бөгөөд сургагч багшаар гадаад, дотоодын 8 үндсэн багш болон Хэвлэлийн хүрээлэнгийн багш ажиллав. "Fast

checking and verification"-ы сургалтын хөтөлбөр шинээр боловсруулж, сэтгүүлчдэд зориулсан нийгмийн сүлжээнд түгээж буй мэдээллийг ашиглах, бусдад түгээхээс өмнө нягтлан шалгах үндсэн алхам, баримтыг нягтлан шалгах, эх сурвалжийг баталгаажуулах зарим арга, нийгмийн мэдээллийн сүлжээ болон Интернэтийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэрхэн ашиглах талаарх мэдлэг олгосон цуврал сургалт зохион байгуулсан.

"Зөвийг түгээе" аян."Нийгмийн сүлжээ болон тоон контентын эрх зүйн орчин" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан. Иргэн, төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн сүлжээг зүй зохистой ашиглах мэдлэг ойлголт өгөх, цахим орчинд үйлдэгдэж байгаа аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын ХЭГ-ын Хэвлэл мэдээллийн алба, ХХМТГ, ГХЯ, ЦЕГ хамтран «Нийтлэхээсээ өмнө бодъё, тунгаая» санаачилгыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, бүх нийтэд түгээх зурагт хуудас, төрийн байгууллагуудад түгээх зурагт хуудас, Хэвлэл, мэдээллийн байгууллага болон мэдээллийн вэб сайтуудад түгээх зурагт хуудасны агуулга тус бүр 10 төрлийг бэлтгэсэн. ГХУСАЗЗ-ийн Ажлын алба, ЦЕГ, НҮБ-ын Хүүхдийн сан, "Faro foundation Mongolia" ТББ-тай хамтран "Зөвийг түгээе" аяныг нэг сарын хугацаатай амжилттай зохион байгуулсан байна.

Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах хүрээнд сэтгүүлчдийг сургалтад хамруулах, чадавхжуулах, ёс зүйг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2019 онд Өргөн нэвтрүүлгийн хууль, 2021 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдсан. Хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан хараат бус байдлыг хангах, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг

боловсруулаад байна. Хүрсэн үр дүнг хүрэх үр дүнд буюу "Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага дээшилсэн байх" гэсэн үр дүнд хүрээгүй гэж дүгнэж байгаа ба энэ нь зорилтод түвшингийн үзүүлэлтэд мөн адил нөлөөлж байна. Тодорхой арга хэмжээ авч ажилласан боловч голлох хуулийн төсөл батлагдаагүй, эрх зүйн орчин бүрдээгүй тул хэрэгжилтийн үр дагавар тодорхой гараагүй байна.

5.3-Үнэлгээний хүрээ 9

Үнэлгээний хүрээ	Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх

Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах хүрээнд хөтөлбөрт 8 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 17 арга хэмжээ тусгагдсан.

Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Сонгуулийн хуульд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал тусгагдсан. УИХ-ын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан байна. Тухайлбал, нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн

аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэхээр тусгасан. УИХ-ын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиудад холбогдох зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон аргачлал буюу хэрхэн тооцож дээд хэмжээг тогтоох асуудлыг тодорхой болгосон. Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах болон сонгуулийн зардлыг бууруулахад чиглэгдсэн үр дүнтэй зохицуулалтуудыг холбогдох хуульд туссан. Тухайлбал, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах талаар тусгасан.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсаар олон нийтэд нээлттэй байршуулж, СЕХ болон сонгуульд оролцогчдод хандсан зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хуулиар чиг үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахаас гадна гадаадын болон дотоодын төрийн бус байгууллага хяналт шинжилгээ, мониторинг хийж, үр дүнгээ нийтэд танилцуулах нь сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой байна. Иймд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 67.13-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй ТББ нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй” гэж хуульчилсан. Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл болон Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.

Мэдээллийг нээлттэй болгох УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 58.3-т “Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 26.3.6, 26.4.6, 38.5-д заасан мэдээллийг дүгнэлт гаргаж дууссан өдрөөс эхлэн, 58.4-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим

хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгоно.” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар холбогдох мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй мэдээлж ажилласан. Сонгуулийн бус үед улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох нөхцөлийг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Тухайлбал, намын санхүүгийн тайлан гаргах, тухайн санхүүгийн тайланд сонгуулийн төв байгууллагаас сонгон шалгаруулсан жагсаалтад орсон аудитын байгууллагаар хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулж, Шилэн дансны хуульд заасны дагуу мэдээлж байх зохицуулалт тусгагдсан.

Хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчлийн төрлүүдийг тодорхой хуульчилсан. Мөн хуулийн 17.1 дэх хэсгийн 21-27 дугаар зүйлд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах, хандив өгөх, авах, шилжүүлэх, сонгуулийн явцын болон эцсийн тайланг гаргах хугацаа, журам, сонгуулийн зардлын данс ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлагыг заасан.

Улс төрийн намын санхүүжилт, түүний тайланг олон нийтэд ил тод нээлттэй болгох, улс төрийн намын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Үндсэн хуулийн заалт. Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, Арван ес дүгээр зүйлийн 19¹.3-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалтыг нэмж тусгасан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд улс төрийн намыг мэдээлэл хариуцагч байхаар, нам нь санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон

намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын талаарх мэдээллээ нээлттэй, ил тод байлгахгаар, энэ үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Зөвлөмж өгсөн. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг орчныг үнэлж, 2019 онд өгсөн зөвлөмжид: “Улс төрийн намуудын санхүүжилт зохицуулалт муутай, ил тод бус, аудитад хамрагддаггүй хэвээр байна. Компаниудаас далдуур өгсөн хандив нь улс төрийн намуудыг хувийн санхүүжүүлэгчдээс хараат байдалд оруулж, улмаар тэдний ашиг сонирхолд нийцүүлэн хөдлөхөд хүргэдэг. Парламентад суудалтай улс төрийн намуудад улсаас өгч байгаа санхүүжилт нь намын санхүүжилтэд идэвхтэй аудит хийх болон санхүүжилтийн ил тод байдлыг бий болгож чадахгүй байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөөр улс төрийн намын санхүүжилттэй холбоотой эрх зүйн орчин, жишгийг сайжруулах хэд хэдэн зорилтыг дэвшүүлсэн боловч төрийн хэрэгжүүлэх байгууллагууд нь энэ салбарыг шинэчлэх талаар арга хэмжээ авахгүй, хууль тогтоомжид зохих нэмэлт өөрчлөлтүүд ороогүй байна. Түүнчлэн улс төрийн намын санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дотоодын холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаа бөгөөд багагүй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэжээ.

Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх, улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Оффшор бүс дэх хөрөнгөө мэдүүлэх. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10^{1.3}-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг ЗГ-ын 2017 оны 244 дүгээр тогтоол, 2017 оны 326 дугаар тогтоолоор тус тус баталсан. АТГ-ын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны 91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс

эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэл”-ийн маягт»-ыг баталсан. Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан АТГ-т мэдүүлж бүртгүүлсэн байна.

Хуулийн зохицуулалт. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах асуудлаар. дараахь хуулийн зохицуулалт үйлчилж байна: Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2-т “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол төрийн албанаас халах” зохицуулалтыг, Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.1.6-д “гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэл” байхаар, 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” бол, мөн зүйлийн 9.1.2-т “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан бол” тус тус Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр тусгасан

Хариуцлага хүлээлгэх. Улс төрийн бүх намын удирдлагуудаас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хуулийн зохицуулалт байхгүй тул УИХ-д суудалтай намуудын удирдлага болон гишүүд ХАСХОМ гаргах албан тушаалтнаар

хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргаж байна. Авлигын эсрэг хуулийн дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол сануулах, цалин бууруулах, албан тушаал бууруулах, албан тушаалаас огцруулах буюу ажлаас халах хариуцлагыг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай. Хэдий тийм ч, улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтнуудын хувьд дээрх хариуцлагыг хүлээлгэх бодит боломж хязгаарлагдмал байна.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүнг дурдвал:

2016 оны төсөөллийн судалгаагаар 2016 онд 3.65 пункт байсан бол 2021 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.82 болж өссөн дүнтэй байна. Төрийн институц дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээг тодорхойлсон шинжээчдийн үнэлгээний дунджийг 2019-2021 оны байдлаар нэгтгэн гаргаж, өөрчлөлтийг тооцсон ба улс төрийн намуудын хувьд өөрчлөлт гараагүй, УИХ 2020-2021 онд 0.27 индексээр буурсан үзүүлэлттэй байна. Авлигын тархалтын үзүүлэлт буурч байгаа хэдий ч улс төрийн намууд, УИХ, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага авлига хамгийн түгээмэл тархсан институцээр тооцогдсон хэвээр байна

Сант Марал сан, Азийн сангаас хийсэн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа-2019” судалгааны дүнгээр авлигад хамгийн их автсан 5 салбарын хамгийн эхэнд улс төрийн намууд, гуравт УИХ орсон байна.

Дүгнэлт

Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2019-2020 онд сонгуультай холбоотой хуулиуд шинэчлэн батлагдаж, улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод нээлттэй болгох, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлж байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд улс төрийн намыг мэдээлэл хариуцагч байхаар зааж ил тод байлгах мэдээллийн талаар тодорхой зохицуулалт оруулсан. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний 2016 оны төсөөллийн

судалгаагаар 3.65 пункт байсан бол 2021 онд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 3.82 гарч 0.17 пунктээр өссөн дүнтэй байна. Энэхүү хүрсэн үр дүн нь хүрэх үр дүн болох “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх” үр дүнд хүрээгүй гэж дүгнэж байгаа ба мөн адил зорилтод хүрэх түвшингийн үзүүлэлтэд нөлөөлнө. Сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох тухай болон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан байдлыг шинэчлэн хуульчилсан зэрэг ахиц гарсан ч харьцуулсан үр дүнг үндэслэн дүгнэхэд тавьсан зорилтын хэрэгжилтийн үр дагавар тодорхой гараагүй байна.

5.3-Үнэлгээний хүрээ 10

Үнэлгээний хүрээ	Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	-Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх -Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх

Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд хөтөлбөрт 5 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 10 арга хэмжээ тусгагдсан.

Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттай зохион байгуулсан. АТГ-аас авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж байна. Авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалтад 2017 онд 11345 хүн хамрагдаж байсан бол 2021 онд 59983 хүн хамрагдаж энэ хугацаанд нийт 124938 хүнийг сургалтад хамруулав. 2020 онд цар тахлын улмаас улс орны хэмжээнд хатуу хөл хорио тогтоосон тул авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгууллаа. 2021 онд 134 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтын үнэлгээг Google forms ашиглан авч, дүн шинжилгээ хийж ажилласан.

Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг 2020 онд эхлүүлж, нийслэл, 21 аймаг, 330 сумыг хамруулан зохион байгуулсан ба тус аян нь хөдөө, орон нутгийн иргэдэд шударга ёсны талаарх үзэл санааг дэлгэрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, авлигыг үл тэвчих үзэл санааг төлөвшүүлэх, арга хэмжээг сонирхлын олон бүлгүүдэд чиглүүлснээрээ онцлог байв. Зөвхөн аяны хүрээнд бус цаашид тогтмол явагдах олон төрлийн санал, санаачилгыг аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс гарган хэрэгжүүлснээрээ урьд өмнө хийгдэж байсан арга хэмжээнүүдээс чанар, хүртээмжийн хувьд ахиц гаргасан шинэлэг үйл ажиллагаа байв. Уг аяны хүрээнд аймгууд соён гэгээрүүлэх чиглэлийн 15 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, сурталчлан давхардсан тоогоор 2020 онд 1.063.456, 2021 онд 7.811.912 хүнд хүргэсэн байна. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд 21 аймгаас ирүүлсэн тоон мэдээгээр 2020 онд 43.596, 2021 онд 88.094 хүнд мэдээллийн хуудас, нугалбар зэрэг хэвлэмэл материал түгээж сурталчилгаа хийсэн байна.

“АТГ-ын мэдээлэл 2020 онд “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийн 17 дугаарыг, 2021 онд 24 дугаарыг бэлтгэн, МҮОНТ-ээр, 2021 онд МҮОНТ, Монголын

мэдээ, UBS, Малчин, орон нутгийн телевизүүдээр үзэгчдийн хүртээл болгов. Тус нэвтрүүлгийг “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсанд байршуулсан бөгөөд 2021 онд нийт үзэлтийн тоо 133700 хүрсэн байна. АТГ 2020 онд авлигын эсрэг видео контентуудыг улсын хэмжээний 25 телевиз, кабелийн сувгаар дамжуулж олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж, нийт 2397 удаагийн цацалтыг хийж, түгээсэн бол 2021 онд арилжааны 12, орон нутгийн 24 телевизээр олон нийтэд хүргэсэн.

“АТГ-Олон нийтийн төв” цахим хуудсыг 2019 онд нээж, мэргэжлийн байгууллагатай хамтран идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулснаар 45519 дагагчтай болсон ба тус (page) хуудсаар дамжуулан 335 зурагт хуудас болон бусад мэдээ мэдээллийг байршуулж, 486 мэдээлэл, 151 видео контентыг олон нийтэд хүргэсэн, 40 түүх(story) мэдээг сошиал орчинд түгээсэн. Авлигын эсрэг зохион байгуулсан цаг үеийн асуудлаар 181 хэвлэлийн мэдээ боловсруулан байгууллагын албан ёсны цахим хуудаст, 127 мэдээ, мэдээллийг бэлтгэн “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудаст байршуулсан нийтэд хүргэжээ.

Авлигыг үл тэвчих шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Ёс зүйн сургалт. АТГ, БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн Боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулж сургагч багш нарт зориулсан “Багшийн ёс зүй: ёс суртахууны харилцаа” сэдэвт гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэсэн ба сургагч багш нар аймаг, нийслэлийн 36000 орчим багш нарт ёс зүйн сургалтыг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна.

Шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох. БСШУС-ын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан ерөнхий боловсролын сургуулийн Х ангид судлах “Нийгэм судлал” хичээлийн агуулгад 1) Шударга

ёсны ойлголт, түүний шалгуур, 2) Гажуудал ба нийгмийн хяналт, 3) Соёлын олон янз байдал, харилцаан дахь шударга ёсны үнэлэмж, 4) Үл ялгаварлан гадуурхах, 5) Эдийн засгийн өсөлт ба амьдралын чанар, 6) Шударга ёс ба авлига, 7) Улсуудын орлогын ялгаатай байдал гэсэн сэдвүүдийг тусгасан байна. БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар баталсан бага ангийн "Хүн ба нийгэм", дунд, ахлах ангийн "Нийгэм судлал", бага, дунд, ахлах ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын талаарх агуулгыг тусган ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна. ЕБС-ийн сурагч, багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн үг, сургамжит өгүүллэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох чиглэлээр "Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага"-ыг боловсруулсан.

Дүн шинжилгээ хийсэн. АТГ-аас их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгадаг эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн. Сургалтын хөтөлбөрийн төсөлтэй танилцаж санал өгч, туршилт сургалтыг 2018 оны 11 дүгээр сард хийсэн ба тус хөтөлбөр батлагдсанаар ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсогчдод ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээлийн хөтөлбөрийн дагуу заавал хамрагдах боломж бүрдсэн. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээлийн агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тусгаж зааж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах талаар хийсэн ажлаас дурдвал:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан нь олон нийтэд нээлттэй болсон. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болсноор цаасан тайланг халж, байгууллагууд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээ тайланг цахимаар ирүүлэх, тухай бүр баяжилт хийх боломж бүрдүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн

талаарх тайлан, мэдээг цахимаар авч хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан нь олон нийтэд нээлттэй байна.

Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэв. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Авлигын эсрэг үндэсний сүлжээ буюу khutulbur.iaас.mn цахим мэдээллийн санд хүлээн авч, гүйцэтгэлийг үнэлэхэд 21 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дундаж 77.6 хувь, яамдууд 76 хувиар үнэлэгдсэн байна. Аймгуудаас Баянхонгор-93,57 хувь, Хэнтий-93,08, Баян-Өлгий 91,67 хувиар үнэлүүлсэн бол Сүхбаатар аймаг-61,54, Увс аймаг-55 хувь болж хамгийн баг үнэлгээ авчээ. Яамдаас Соёлын яам-88 хувь, ХЗДХЯ-86,4, БХБЯ-84,7 хувийн үнэлгээ авсан бол ЗТХЯ-66,2, УУХҮЯ-48,2 хувиар үнэлүүлжээ. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Авлигатай тэмцэх газраас гаргасан контентуудыг байгууллагынхаа цахим хуудас болон бусад олон нийтийн платформуудаар сурталчлах, мэдээллийн самбар ажиллуулах, авлигын эсрэг сургалтад албан хаагчдыг хамруулах, худалдан авах ажиллагаа, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний нэг дэх үе шатны биелэлт 58,8 хувьтай байсан бол 2021 оны биелэлт 75 хувьтай болж биелэлтийн явц ахисан дүнтэй байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажилласан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын өөрсдийн хариуцсан үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, төлөвлөгөөг албан ёсны цахим хуудас дээрээ ил тод мэдээлж, үр дүнгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх талаар яам, агентлаг, аймаг, нийслэлд албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажилласан. Авлигатай тэмцэх газраас аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн байгууллагуудын Авлигын эсрэг төлөвлөгөө болон авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний

хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн хэрэгжилттэй танилцан шалган зааварлах, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэж байна.

2020 онд төрийн байгууллагуудаас авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, тайлагнах, арга зүйг боловсруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, сайн туршлагыг солилцох зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөлт, үр дүнг сайжруулах-арга зүйн асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, олон нийтэд мэдээлэх, үр дүнг дээшлүүлэх зорилгоор авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загварыг шинэчлэн боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүлжээ.

Дүгнэлт

2017 онд иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар нийт 599 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэж байсан бол 2021 онд иргэн, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас 2314 гомдол мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд авлигыг үл тэвчих иргэдийн ухамсар дээшилж шударга ёсны үнэлэмжид өөрчлөлт орж байгаа нь харагдаж байна.

Хүүхдийн шударга байдлын 2017 оны судалгаагаар 3.97 гарч байсан бол 2021 оны судалгаагаар 4.06 гарч өссөн дүнтэй байгаа нь авлигыг үл тэвчих шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гэж үзэж байна. ЕБС-ийн сургалтын агуулгад шударга ёсны ойлголтын талаар тусгах, мөн багш нарт энэ чиглэлээр боловсрол олгох талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан. Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагааны хүрсэн үр дүн нь хүрэх үр дүн буюу

“Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх” гэсэн үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлуулан 216 арга хэмжээ төлөвлөн ажилласан ба холбогдох байгууллагууд өөрийн байгууллагад хамаарах арга хэмжээг байгууллагын хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллаж биелэлтээ тодорхой хугацаагаар дүгнэж, ажилласнаар 2021 онд төлөвлөгөөний биелэлт ахисан дүнтэй байна. Хүрсэн үр дүнг хүрэх үр дүнтэй харьцуулахад “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх” гэсэн хүрэх үр дүнд хүрсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх ажлыг гардан хийж, нийгмийн хүрээнд тодорхой түвшин тогтсон, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх тул хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж дүгнэж байна.

5.3-Үнэлгээний хүрээ 11

Үнэлгээний хүрээ	Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх
Тогтоосон шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хүрэх үр дүнг хүрсэн үр дүнтэй харьцуулах
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагаа сайжирсан байх

Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах хүрээнд хөтөлбөрт 5 үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 13 арга хэмжээ тусгагдсан.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг өргөжүүлэх хүрээнд хийсэн ажлаас дурдвал:

Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээсэн. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг үндэслэл болгож, гадаад улсын эрх бүхий байгууллагад эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг илгээхэд ХЗДХЯ болон УЕПГ голлох үүргийг гүйцэтгэж байна. 2018 онд Монгол Улс нь 7 улсад 4 эрх зүйн туслалцааны хүсэлт, 2019 онд 12 улсад Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг үндэслэл болгосон 26 эрх зүйн туслалцааны хүсэлт, 2020 онд 12 улсад 15 эрх зүйн туслалцааны хүсэлт, 2021 онд 4 улсад 9 эрх зүйн туслалцааны хүсэлтийг гадаад улсын эрх бүхий төв байгууллагуудад тус тус уламжлан хүргүүлжээ.

Шинээр гэрээ, хэлэлцээр байгуулсан. 2018 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг, “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-г байгуулжээ. 2019 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”, “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г УИХ-аар соёрхон батлуулав. Мөн “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-д гарын үсэг зурсан.

2020 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г УИХ-аас тус тус соёрхон баталсан. Мөн “Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн улсууд хоорондын конвенци”-д нэгдэн орсон. ХЗДХЯ-

аас “Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын конвенц”, “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын конвенц”-д нэгдэн орох ажлыг зохион байгуулж байгаа ба Европын зөвлөлийн Нарийн бичгийн даргын газарт конвенцид нэгдэн орох саналаа хүргүүлсэн. Эдгээр конвенцид нэгдэн орсноор конвенцид заасан нөхцөлийн дагуу эрүүгийн хариуцлагад татах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор хэрэгт холбогдсон этгээдийг шилжүүлэн өгөх, авах эрх зүйн үндэс бий болно.

Зөвлөмж өгсөн. ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улс 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн билээ. АТГ-аас Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх явцын мэдээллийг жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна. ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үнэлэх ээлжит ажил 2018 оны 8 дугаар сард эхэлсэн бөгөөд 2019 оны 3 дугаар сард Парис хотод гишүүн улсуудын төлөөллийг оролцуулсан Удирдах зөвлөлийн уулзалтыг зохион байгуулж, Хурлын үеэр Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн багаас үнэлгээний тайлангийн талаар танилцуулж, талууд харилцан санал солилцсоны дараа Монгол Улсын авлигын эсрэг орчны үнэлгээний тайланг тус сүлжээнээс эцэслэн баталж ирүүлсэн ба ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээний зөвлөхүүд 2019 оны 7 дугаар сард Монгол Улсад айлчлал хийж, мониторингийн тайлан, зөвлөмжийг танилцуулах хэвлэлийн бага хурал хийсэн.

Энэхүү зөвлөмжид: Авлигын гэмт хэрэгт олон улсын хамтын ажиллагаа явуулах чиглэлээр бусад улс оронтой байгуулах хоёр талт гэрээний тоог нэмэгдүүлэх. Хамтарсан ажлын хэсэг байгуулах, хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад хүсэлтийг биелүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, хүсэлт илгээхээс

өмнө албан бусаар зөвлөгөө авах, хүсэлтийг биелүүлэх явцад зохицуулалтын арга хэмжээ авахад чиглэсэн төрөл бүрийн хэлбэрийн шууд хамтын ажиллагааг авлигын гэмт хэрэг дээр, түүний дотор хөрөнгө буцаах ажиллагаан дээр өрнүүлэх ажлыг хөхиүлэн дэмжих. Эрх бүхий төв байгууллага дахь олон улсын хамтын ажиллагаа хариуцсан нэгжийн албан хаагчид болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт боловсруулж, ирүүлсэн хүсэлтийг биелүүлдэг АТГ-ын мөрдөгч, прокуроруудыг сургалтад сайтар хамруулж, орчуулагч, шаардлагатай харилцааны арга хэрэгсэл зэрэг зохих эх үүсвэрээр тэднийг хангах. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 53 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө шууд буцаах ажиллагаа, түүнчлэн уг Конвенцын 57 дугаар зүйлд заасан хөрөнгө буцаах болон зарцуулах нөхцөл, журмыг хууль тогтоомжид заах зэрэг асуудлыг зөвлөсөн.

Авлигатай тэмцэх газраас “Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тухай” албан бичгийг холбогдох байгууллагуудад явуулж, “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлан хамгаалсан. Монгол Улсын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг үнэлүүлэх ажлын хүрээнд конвенцын 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн тухай тайланг бэлтгэж 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх албанд холбогдох тайлангийн программаар дамжуулан илгээсэн. 2022 оны 04 дүгээр сарын 27-ноос 29-ний өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны шинжээчдийн баг Монгол Улсад тайлангийн мөрөөр ажилласан ба 2022 оны 10 дугаар сард урьдчилсан байдлаар зөвлөмжөө ирүүлээд байна.

Гадаад улсын авлигатай тэмцэх болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал:

Санамж бичиг байгуулсан. Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд Швейцарын Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын

Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийж, эрүүгийн хэрэг хамтран мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож байна. Мөн АТГ нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. ХЗДХЯ-ны харьяа ШШГЕГ болон БНСВУ-ын НАБЯ-ны харьяа ХБУГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”, “Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын ХЗДХЯ-ны харьяа ШШҮХ, Бүгд Найрамдах Беларусь Улсын Шүүхийн шинжилгээний улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” –ийг байгуулсан

Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 2019 оны 07 дугаар сард Монгол Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөгчид ОХУ-ын Ерөнхий прокурорын газарт ажлын айлчлал хийж, “Монгол Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын 2020-2021 оны хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг харилцан гарын үсэг зурж, батлав. УЕПГ-ын төлөөлөгчид БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Ерөнхий прокурорын урилгаар 2019 оны 11 дүгээр сард БНХАУ-д ажлын айлчлал хийж, “Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар, БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын Газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулав.

Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. 2018 онд Индонези улсын Бали хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, тус Сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах эрхийг авч, 2019 онд даргалагч улсаар томилогдсон. 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурал болон Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран хөрөнгө буцаан авах чиглэлээр олон

улсын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. АТГ «Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга» (StAR)-тай 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба үе шат бүхий сургалтыг хамтран зохион байгуулсаар ирсэн.

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлэх “Монгол улсын Засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд АТГ, ШЕЗ, УЕПГ, АХБ хамтран 2018 оны 12 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн “Монгол Улс: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн уялдуулан зохицуулах хэрэгжүүлэгч байгууллагаар Авлигатай тэмцэх газар сонгогдсон бөгөөд төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой ажлууд зохион байгууллаа.

Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар АНУ-ын Төрийн Департаментын харьяа Олон улсын хар тамхитай тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” төслийг АТГ, УЕПГ болон холбогдох бусад байгууллагын хүрээнд хэрэгжүүлж байна.

Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

Гадаад улсад хөрөнгө буцаан авах чиглэлээр илгээх хүсэлтийг үндэслэлтэй боловсруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, УЕПГ-аас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг УЕПГ-ын 2019 оны А/16 дугаар тушаалаар баталж, мөрдүүлж байна.

Мөн 2021 онд УЕПГ-аас гадаад улсаас хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах асуудлаар гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, прокурорын нэхэмжлэл бичиж,

хүргүүлэх асуудлаар дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенциудыг судлан Дэлхийн Банк, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын хамтарсан хөтөлбөр болох Хулгайлагдсан хөрөнгө хураан авах санаачилгатай хамтран харьяа прокурорын газрын прокуроруудыг хамруулан цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, ЦЕГ, АТГ, ТЕГ, Интерполын үндэсний товчоо зэрэг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын саналыг авч, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ыг шинэчлэн боловсруулж, УЕПГ-ын 2021 оны А/65 дугаартай тушаалаар баталсан.

УЕП, Авлигатай тэмцэх газар хамтран 2020 онд “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” гарын авлага боловсруулан гаргаж, хэрэглэж байна.

Дүгнэлт

Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийсэн. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажилласан, гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын өөрийн үнэлгээний тайланг боловсруулж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлсэн, тайланг хэлэлцэх ажлыг зохион байгуулсан, ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Авлигатай тэмцэх үйл ажиллагааны Станбулын төлөвлөгөөний тайланг боловсруулах, хамгаалах ажлыг зохион байгуулсан ба өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа, гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулсан, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулсан зэрэг бодитой үр дүн гарсан байна. Хүрсэн үр дүнг хүрэх үр дүн болох “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагаа сайжирсан байх” гэсэн үр дүнд хүрсэн байна. Харьцуулсан үр дүнг үндэслэн дүгнэхэд “Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны

хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх” зорилтын хэрэгжилтийн үр дагавар гарсан байна.

Үнэлгээний хүрээнд хамаарахгүй бусад асуудлын талаар

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Тав”-д заасан нийт 20 хүрэх үр дүнгээс үнэлгээний 11 хүрээний агуулгатай тохироогүйн улмаас 4 хүрэх үр дүн үнэлгээнд сонгогдоогүй үлдсэн. Эдгээр хүрэх үр дүнгийн чиглэлээр хийсэн ажлаас дурдвал:

1. Транспэрэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сайжирсан байх::

Транспэрэнси интернэйшнл байгууллагын 2016 оны авлигын төсөөллийн судалгаагаар Монгол Улс 38 оноогоор 87 дугаарт жагссан бол 2021 онд 35 оноо авч 180 улс орноос 110 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Монгол Улсын индексийг тооцоход ашигласан эх сурвалжийн 2016 оны үнэлгээг 2021 оны үнэлгээтэй харьцуулахад: «Бертелсман» сангийн Шилжилтийн индекс, «Пи Ар Эс» групп - Эрсдэлийн үнэлгээ тус тус өссөн, Ардчиллын олон талт байдлын төсөл /V-Dem/, Эдийн засгийн мэдээллийн нэгжийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ өсөөгүй, буураагүй тус тус хэвээрээ, Дэлхийн эдийн засгийн форумын Үзэл бодлын судалгаа, Глобал инсайт» байгууллагын Улс орнуудын эрсдэлийн түвшингийн үнэлгээ, “Ай Эм Ди” байгууллагын Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл Үзэл бодлын судалгаа, Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс тус тус буурсан, Дэлхийн банкны Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2016 онд 47 байсан бол 2022 онд Монгол Улсын индексийг боловсруулахад ашиглаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар Авлигын индексийг сайжруулж, байрыг 100-аас дотогш оруулах зорилготой Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд Хууль, эрх зүйн орчинг

боловсронгуй болгох, Төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, цахим үйлчилгээний чанарыг сайжруулах, Урьдчилан сэргийлэх, олон нийтийг мэдээллээр хангах, Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын хэргийг хянан шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх 4 чиглэлийн хүрээнд нийт 50 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх:

Авлигатай тэмцэх газар, ХЗДХЯ-аас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлж шударга ёсыг тогтоохын төлөө хувийн эрх ашгаас нийтийн эрх ашгийг өндөрт тавьж байгаа шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тусгасан.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн ба үүнд практик хэрэглээнд гарч байгаа зөрчлийг арилгах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын заалтад нийцүүлэх чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах тодорхой зөвлөмжүүд өгсний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулж, 2021 онд ХЗДХЯ-нд хүлээлгэн өгсөн ба уг хуулийн төсөлд мэдээлэгчийг гэрч, хохирогчтой адил түвшинд хамгаалах талаар тусгасан болно.

3. Авлигад илүү өртсөн салбаруудын болон өндөр түвшний авлигын гэмт хэрэг, зөрчил

гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх:

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8, 2019 онд 41 байгууллагад Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийг хүргүүлж тэдгээрийн мөрөөр газар дээр нь ажиллахад мэдэгдэлд дурдсан эрсдэлээс сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг дутагдал илэрсэн бөгөөд төрийн байгууллагуудын Авлигын эсрэг хуулийн 6.1.12-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” нийтлэг үүргийн хэрэгжилт хангалтгүй байв. Авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2021 онд 162 мөрдөгчийн мэдэгдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж, 124 мэдэгдлийн хариуг тухайн байгууллагаас хүлээн авсан ба мэдэгдэлд дурдсан гэмт хэргийн шалтгаан, нөхцөл бүрэн арилгасан эсэхийг газар дээр нь шалган туслах зорилгоор 40 байгууллагад ажилласан.

Хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахуулахаар 61 аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд зөрчил арилгуулах албан бичгийг хүргүүлж холбогдох зөрчлийг арилгуулах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 21 байгууллагад ажиллав. Нийтлэг зөрчлүүдээс дурдвал, нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, үйл ажиллагааны стандарт, журам зөрчсөн, тендерийн хууль тогтоомж зөрчсөн, бусдад давуу байдал олгосон, төсвийн болон хандивын мөнгийг хувьдаа завшсан, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, албан тушаалдаа хайнга хандсан зэрэг болно.

Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэргээр авлигын

эрсдэлийг үнэлэх, тогтоох, таслан зогсоох ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

4.Төрийн байгууллагад итгэх иргэний итгэл нэмэгдсэн байх:

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар 2019.12.09-нд “Шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвээр хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан ба зөвлөгөөнд УДШ, ШЕЗ, УЕПГ, ХЗДХЯ, ЦЕГ, ШШГЕГ, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцсон. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчид мэргэжлийн өндөр ёс зүйтэй байж, хуулийн хүрээнд, хараат бусаар, аливаад алагчлалгүйгээр хандан шийдвэр гаргаж ажиллах нь хуулийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, түүнийг хадгалах гол гарц юм. Урьд өмнө нь хуулийн байгууллагуудын төлөөлөл нэг дор хуран цуглаж өөрсдийнх нь үйл ажиллагаа ба шударга байдалд иргэд, олон нийт хэр зэрэг итгэлтэй байдаг талаар ярилцаж байсан удаагүй. Энэхүү зөвлөгөөн цаг үеэ олсон арга хэмжээ болж, хуулийн байгууллагуудын цаашдын ажилд хувь нэмэр болсон.

Үндэсний статистикийн газраас “Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж буй бөгөөд уг судалгааны 2018-2021 оны үр дүнг харьцуулан танилцуулснаас үзэхэд Төрийн захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн өгсөн хариулт нь төр, засагтаа хэр зэрэг итгэл хүлээлгэж буйг илэрхийлэх үзүүлэлт юм. Төрийн эрх барих дээд байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг харвал, Ерөнхийлөгчид өгсөн үнэлгээ 2018-2021 онд 44-59, Улсын Их Хуралд өгсөн үнэлгээ 13-42, Засгийн газарт өгсөн үнэлгээ 32-56 болж нэмэгджээ. Шүүх засаглалын байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор авч үзэхэд, Дээд шүүхэд өгсөн иргэдийн үнэлгээ 43-50, Нийслэл/аймгийн шүүхэд өгсөн үнэлгээ 45-50, Дүүрэг/сум дундын шүүхэд өгсөн үнэлгээ 49-53, Шүүхийн шийдвэр биелүүлэх газарт өгсөн үнэлгээ 49-60 болж өссөн хандлагатай байна.

Сүүлийн 12 сард эмнэлгийн үйлчилгээ авахад авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 3.1 байсан бол 2021 онд 1.6

хувь болж буурсан эерэг хандлага ажиглагджээ. Төрийн байгууллагад автын үзлэг, оношилгоо, дугаар авахтай холбоотой асуудлыг шийдэх үед авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 1.3 байсан бол 2021 онд 0.8 хувь болон буурсан, хүүхэд сургууль, цэцэрлэгт оруулах үед авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 2.7 байсан бол 2021 онд 0.5 хувь болж буурах хандлага ажиглагдсан байна.

5.4. ДҮГНЭЛТ ГАРГАЖ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ

Үнэлэх үе шатны төгсгөлд томъёолсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дор дурдсаны дагуу дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулав:

- Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах,
- Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргах.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод нээлттэй хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” гэсэн зорилгод хүрэхийн тулд үе шаттайгаар хэрэгжүүлэх 11 зорилт тавьж, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 216 арга хэмжээ төлөвлөж 2016-2022 оны хугацаанд хэрэгжүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ аргачлалын дагуу Хөтөлбөрийн 11 чиглэлийг үнэлгээний хүрээ болгон авч, хөтөлбөрийн 2.1-д заасан зорилтуудын хэрэгжилтийн үр дүнг хөтөлбөрийн 5.1, 5.2-т заасан хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Нийт 11 зорилтын найм нь хөтөлбөрийн 5.1, 5.2-т заасан хүрэх үр дүнд хүрч, хэрэгжилтийн үр дагавар гарсан гэж, гурав нь зорилтот үйл ажиллагааг явуулж, арга хэмжээ авч ажилласан боловч хөтөлбөрт заасан хүрэх үр дүнд (томъёологдсон шалгуур үзүүлэлт) хүрээгүй гэж үнэлэгдэж, нийт дүнгээрээ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн

“Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод нээлттэй хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” гэсэн зорилгод хүрэх үйл ажиллагаа явуулж, төлөвлөсөн арга хэмжээг авч ажилласан гэж дүгнэж байна.

Аргачлалд заасны дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад гарсан ололт, амжилтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, цаашид шинээр боловсруулах хөтөлбөрийн талаар санал, зөвлөмж боловсруулахаар үнэлгээ хийхийн өмнө үнэлгээ хийх ажлын зорилтыг тодорхойлсон тул үнэлгээний хүрээ болгон дээр хэрэгжилтийн явц дахь ололт буюу хүрсэн үр дүнг тодорхойлж, хүрэх үр дүнтэй харьцуулсан бөгөөд төлөвлөгөөний биелэлт гаргаж байгаа биш тул төлөвлөгөөнд заасан арга хэмжээнээс дутуу биелсэн, биелээгүй асуудлыг тус бүрээр тоочин тодорхойлсонгүй.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн ололт, амжилтыг үнэлгээний хүрээ болгонд хамаарах зорилттой холбон тодорхойлсон тул энд давтах шаардлагагүй гэж үзэж байна. Иймээс нэгтгэн дүгнэхэд:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд авлигатай тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлогыг нийгмийн бүхий л салбар хүрээнд хүргэж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулж, үр дүнтэй ажилласан нь дараагийн хөтөлбөр хэрэгжих суурь болж, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хүрсэн түвшинг ахиулах, гарсан алдааг залруулах, шинэчлэлийн ажлыг урагшлуулах үйл ажиллагаа үргэлжлэн явагдах хэрэгцээ, шаардлага тодорхой болсон.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон тооны хуулиуд батлагдан гарсан нь авлигатай тэмцэх, авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилт цаашид байнга хэрэгжих, тогтвортой хадгалагдах хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагавар болж байна. Мөн холбогдох хуульд өөрчлөлт оруулахаар шинээр гаргах хуулийн төслийг боловсруулсан, өргөн барьсан нь хэрэгжилтийн үр дагаварт эерэгээр

нөлөөлж байна.

Гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг хөтөлбөрийн хэмжээнд нэгтгэн дүгнэхэд:

1/Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалтыг үзэхэд нэг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дээд тал нь хөтөлбөрийн 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэх 34 арга хэмжээ, доод тал нь 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэх 9 арга хэмжээ төлөвлөсөн байна. Хөтөлбөрийн зарим зорилтыг хэтэрхий олон арга хэмжээ болгон задалснаас үүдээд зорилтын хүрээнд хамааралгүй арга хэмжээ тусгагдсан, зарим арга хэмжээ бусад зорилтын хүрээнд хамаарч байгаа арга хэмжээтэй агуулгаараа давхардсан, байгууллагын байнга хийдэг ажлыг арга хэмжээ болгон оруулсан зэрэг асуудал гарч байна.

2/Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх тухай заасан Хууль тогтоомжийн тухай хууль нь 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Иймд энэхүү хуулийн зохицуулалт практикт хэрэгжээгүй үед хөтөлбөр батлагдсанаас үүдэн хөтөлбөрт хүрэх үр дүнг хөтөлбөрийн зорилт болгонтой уялдуулж тогтоогоогүй, хэмжих боломжгүй ерөнхий томъёолсон, төсөөллийн судалгааны дүнг хүрэх үр дүн болгосон зэрэг асуудал байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн "Тав"-д хугацаа, хүрэх үр дүнг тогтоосон ба нэг дэх үе шатанд 11 хүрэх үр дүн, хоёр дахь үе шатанд 8 хүрэх үр дүн, нийт хүрэх үр дүн 20-ыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд аль болохоор эдгээр хорин хүрэх үр дүнгээс хамааруулахын тулд зарим үнэлгээний хүрээнд хоёр хүрэх үр дүнг харьцуулахаар авсан, зарим үнэлгээний хүрээнд агуулгаараа тохирох хүрэх үр дүн байхгүйн улмаас өөр үнэлгээний хүрээнд тавьсан хүрэх үр дүнг авч давхар сонгож хэрэглэсэн, мөн зарим үнэлгээний хүрээнд төсөөллийн судалгааны дүнгийн харьцуулалтаар хүрэх үр дүн нь тодорхойлогдсон.

3/Үнэлгээ хийхээр цуглуулсан мэдээлэл, нэгдсэн тайлан, байгууллагуудын тайлан мэдээ зэрэгтэй танилцаж судлахад авлигатай

тэмцэх ажлыг байгууллагынхаа зорилт, үүрэг гэж үзэхээсээ илүү Авлигатай тэмцэх газрын ажлыг хамт хийлцэж байгаа мэт хандлага ажиглагдаж байна. Мөн хөтөлбөр боловсруулах шатанд санал өгөхдөө өөрийн байгууллага, салбар дахь авлига үүсэх эрсдэл, шалтгаан нөхцөлийг арилгах, бууруулах чиглэл барьж арга хэмжээ төлөвлөхөөсөө илүү байгууллагын чиг үүргийн дагуу байнга хийж хэрэгжүүлдэг ажлаа тусгуулах нь ач холбогдол багатай болж байна.

4/Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ холбогдох хуульд тусгагдаагүйн улмаас хэрэгжих боломжгүй асуудал үүсч байна. Тухайлбал, Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох /худалдан авах ажиллагаатай холбоотой/, Төсвийн хяналтын сонсголын журам боловсруулж мөрдөх зэрэг арга хэмжээ нь тухайн аргачлал, журмыг гаргах эрхийг хуулиар тусгайлан олгоогүйн улмаас хэрэгжээгүй, аргачлал нь зөвлөмж хэлбэрээр гарсан байна. Эдгээр асуудлыг дараагийн хөтөлбөр боловсруулахдаа анхаарах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ

1. Дараагийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо 2017-2022 онд хэрэгжсэн хөтөлбөрийн хүрээнд хүрсэн үр дүн, бий болсон тогтолцоо, бүрдсэн хууль эрх зүйн орчныг харгалзаж, дахин давтахгүй байх, цааш хөгжүүлэх, түвшинг ахиулахад анхаарах;
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр хөтөлбөрт заасан хүрэх үр дүнд хангалттай түвшинд хүрээгүй гэж дүгнэгдсэн гурван зорилтын хэрэгжилтэд гарсан асуудлыг шийдвэрлэх, биелүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг дараагийн хөтөлбөрт тусгах. Мөн бусад зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг анхаарч авч үзэх;
3. Шударга байхын үндэс нь ёс зүй, авлига үүсэх нэг шалтгаан нь ёс зүйн зөрчил учраас нийтийн албан тушаалтны хандлага, ёс зүй, ёс суртахуунд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, мөн ёс зүйн хариуцлагын асуудал, хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах,

оюутан сурагч байхаас нь ёс зүйн асуудлыг төлөвшүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг батлуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авах талаар тусгах;

4. 1995 онд баталсан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж, цахимаар өргөдөл, гомдол гаргах, цахимаар хариугаа авах ажиллагааг хуулийн нэгдсэн зохицуулалтад оруулах;
5. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх талаарх хуулийн зохицуулалтыг хэрэгжилтийн түвшинд зохион байгуулах арга хэмжээний талаар тусгах;
6. Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүсэлт боловсруулах, хүсэлтэд тусгагдсан байх ёстой тодорхой мэдээллүүдийг албан болон албан бусаар хэрхэн олж авах арга замуудын талаар хуульчдад зориулсан аргачлал, гарын авлагыг боловсруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр тогтмол сургалт явуулах, хөрөнгө буцаан олгох чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг тусгах.

-оОо-



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. Гадаад харилцаа

No.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Гадаад улсад богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2	31	17	1	-	28
2	Монгол Улсад зохион байгуулагдсан гадаад улсын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	5	5	15	40	120	224
3	Гадаад улсад томилолтоор ажилласан албан хаагчийн тоо	9	8	28	3	7	44
4	Хүлээн авсан гадаад улсын төлөөлөгчдийн тоо	12	2	80	-	-	17
5	Монгол Улсад зохион байгуулсан олон улсын хурал, семинар, арга хэмжээний тоо	-	-	1	-	-	4
6	Гадаад улсын дипломат албан хаагч, эрх бүхий албан тушаалтантай хийсэн уулзалтын тоо	10	6	9	7	5	10
7	Олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын тоо	16	15	11	5	4	7
8	Гадаад улстай болон олон улсын байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээний тоо	-	2	-	-	-	2
9	Нэгдэн орсон олон улсын гэрээний тоо	-	-	-	-	-	-
10	Гадаад улсад хийсэн айлчлалын тоо	1	2	2	-	3	17
11	Гадаад улсаас Монгол улсад хийсэн айлчлалын тоо	2	-	3	-	-	1

МӨРДӨН ШАЛГАХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН СУДАЛГАА

No.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Нийт шалгасан эрүүгийн хэрэг	427	1,138	1,300	1,331	1,307	1,520
2	Яллах дүгнэлтээр	106	224	156	236	269	262
3	Хэрэгсэхгүй болгох	94	467	556	509	429	389
4	Харьяаллын дагуу шилжүүлсэн	48	125	80	48	61	50
5	Эрүүгийн хэрэг нэгтгэсэн	14	9	22	46	63	93
6	Түдгэлзүүлсэн	2	1	1	6	5	11
7	Ажиллагаанд	163	312	485	486	480	715
8	Хэргийн холбогдогч	639	1,224	481	696	909	1,184
9	Төрийн үйлчилгээний	38	145	48	116	175	84
10	Төрийн захиргааны	113	204	103	97	149	127
11	Төрийн тусгай	168	434	101	116	145	103
12	Төрийн улс төрийн	58	166	48	81	91	56
13	Энгийн	277	275	181	286	349	814
14	Эрүүгийн хууль - 2002 он						
	Эрүүгийн хууль - 2015 он / шинэчилсэн/						
15	263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	168	461	688	799	820	1,011
	264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх						
16							
17							
18	268 дугаар зүйл. Хээл хахууль авах	115	140	172	207	225	239
19	269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх	110	142	174	108	134	138
20	270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах	-	-	-	-	-	-

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

21	-	22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	-	-	-	-	-	-
22	-	22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	-	-	-	1	-	-
23	273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	28	40	24	23	20	22
24		22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	1	6	3	-	-	-
25	270. ¹ дүгээр зүйл. Хууль бусаар хөрөнгөжих	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	30	25	40	41	36	52
26	-	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах	1	-	2	3	-	-
27	265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	4	17	10	21	26	34
28	266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх							
29	Бусад		184	642	423	332	282	310
30	Хохирол / тэрбум төг/	Нийт учирсан хохирол	69.5	663.2	12,123.2	12,133.5	1,002.0	5,024.9
31		Нөхөн төлүүлсэн	3.4	17.4	11.3	35.6	96.2	2,374.9
32		Хөрөнгө битүүмжилсэн	29.3	180.7	9,736.8	10,112.7	119.5	518.0
33		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	44	84	68	114	160	188
34		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн холбогдогчийн тоо	120	121	115	222	307	346

Хүснэгт 2. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Нийт шалгасан гомдол, мэдээлэл	658	858	894	1,020	1,144	1,413
2	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	375	327	362	487	594	684
3	Харьяаллын дагуу шилжүүлсэн	93	76	34	27	44	52
4	Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	174	447	489	462	460	621
5	Нэгтгэн шалгасан	-	-	1	-	-	-
6	Ажиллагаанд	16	8	8	44	46	56

**Хүснэгт 3. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
/аймаг, нийслэлээр/**

Но.	Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021	2022
1	Улаанбаатар	447	520	564	625	676	767
2	Архангай	9	16	14	22	17	35
3	Баян-Өлгий	16	27	18	31	37	54
4	Баянхонгор	13	16	21	23	21	35
5	Булган	8	18	20	16	23	25
6	Говь-Алтай	9	6	14	14	16	40
7	Говьсүмбэр	5	9	6	6	3	15
8	Дархан-Уул	9	12	13	10	21	43
9	Дорноговь	21	9	20	21	20	32
10	Дорнод	9	12	22	19	20	31
11	Дундговь	6	22	16	12	13	8
12	Завхан	5	20	12	15	19	26
13	Орхон	11	25	18	41	24	27
14	Өвөрхангай	2	10	9	20	19	16
15	Өмнөговь	11	14	11	16	18	28
16	Сүхбаатар	7	12	12	12	7	12
17	Сэлэнгэ	11	29	17	22	44	73
18	Төв	20	22	30	22	33	37
19	Улс	7	14	10	17	41	35
20	Ховд	23	17	18	14	25	27
21	Хөвсгөл	1	9	14	25	26	34
22	Хэнтий	8	19	15	17	21	13
23	НИЙТ	658	858	894	1,020	1,144	1,413

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Мэдүүлгээ гаргавал зохих	39,742	40,073	41,382	41,686	43,692	47,554
2	Төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан	290	272	282	283	311	336
3	Төрийн улс төрийн	7,142	7,443	7,448	7,518	7,741	7,741
4	Төрийн захиргааны	10,480	10,440	10,749	11,021	12,141	11,957
5	Төрийн тусгай	8,865	13,478	12,863	13,289	13,445	15,872
6	Төрийн үйлчилгээний	4,434	4,370	4,597	4,746	5,700	6,838
7	Бусад	8,531	4,070	5,443	4,829	4,354	4,810
8	Мэдүүлгээ гаргасан	39,740	40,071	41,381	41,685	43,692	47,554
9	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	1	4	-	-	-	-
10	Мэдүүлгээ гаргаагүй	2	2	1	1	-	-

Хүснэгт 2. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА ТООЦУУЛСАН БАЙДАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хариуцлага тооцуулсан ХАСХОМ	-	197	248	8	14	28
2	Сануулах	-	124	235	4	5	28
3	Цалин бууруулах	-	67	13	4	9	-
4	Албан тушаал бууруулах	-	-	-	-	-	-
5	Ажлаас халах	-	6	-	-	-	-

Хүснэгт 3. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хянан шалгасан ХАСХОМ	274	171	381	542	315	366
2	Төлөвлөгөөт хяналт шалгалтаар	228	79	316	464	257	288
3	Гомдол, мэдээллээр	10	72	30	23	11	18
4	Хэлтэс, албадаас шилжүүлснээр	36	20	35	55	47	60

Хүснэгт 4. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ХАРИУЦЛАГА ТООЦУУЛСАН БАЙДАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хариуцлага тооцуулсан ХАСХОМ	43	14	35	46	94	93
2	Сануулах	19	3	6	1	22	8
3	Цалин бууруулах	23	10	20	26	46	40
4	Албан тушаал бууруулах	-	-	1	11	22	37
5	Ажлаас халах	1	1	8	8	4	8
6	Бусад	-	-	-	-	-	-

**Хүснэгт 5. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХҮЛЭЭН АВСАН,
ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ**

No.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Нийт ирүүлсэн мэдүүлэг	11,143	10,464	8,682	13,151	12,504	14,861
2	Хянан шийдвэрлэсэн мэдүүлэг	11,115	10,381	8,627	13,030	12,468	14,695
3	Зөрчилгүй	9,329	9,063	7,634	11,684	11,162	13,616
4	Илт ашиг сонирхлын зөрчилтэй	39	25	28	8	22	37
5	Анхааруулсан	763	844	659	848	1,018	918
6	Буцаасан	984	449	306	490	266	124
7	Үлдэгдэл	28	83	55	121	36	166

**Хүснэгт 6. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ
МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ**

No.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хүлээж авсан өргөдөл, гомдол	599	672	692	656	560	653
2	Албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн	97	101	110	118	128	112
3	Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон	97	96	108	112	120	120
4	Ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан	138	68	239	138	138	146
5	Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн	19	29	-	-	16	-
6	Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр, хууль бус үйлдэл гаргасан талаар	171	160	102	157	138	193
7	Бусад	77	218	132	131	20	82
8	Хянан шийдвэрлэсэн	556	622	694	616	561	662
9	Зөрчлийг тогтоон шийдвэрлэсэн	40	38	64	73	90	135
10	Зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсэн	8	-	24	29	-	-
11	Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхааруулсан буюу шаардлага хүргүүлсэн	7	68	54	35	52	98
12	Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэс болон Цагдаагийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн	85	95	98	116	74	62
13	Төрийн бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн	-	136	139	128	108	104
14	Хариу өгч буцаасан /гомдлоос татгалзсан/	-	-	75	36	42	37
15	Хариуцлага хүлээлгэсэн байдал	40	38	37	25	30	37
16	Сануулах	12	8	8	3	10	9
17	Цалин бууруулах	20	23	22	20	14	24
18	Албан тушаал бууруулах	-	-	4	1	-	-
19	Ажлаас халах	8	7	3	1	6	4
20	Бусад	-	-	-	-	-	-

**Хүснэгт 7. ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТАД ХАМРАГДСАН
АЛБАН ТУШААЛТНЫ ТОО**

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Сургалтад хамрагдсан албан тушаалтан	11,988	6,313	11,349	3,271	1,405	8,894
2	Мэдүүлэг гаргагч	8,983	5,008	9,138	1,558	1,158	7,174
3	Эрх бүхий албан тушаалтан	807	737	1,311	1,713	247	1,720
4	Удирдах албан тушаалтан	2,198	568	900	-	-	-

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. ТУШААЛ, ШИЙДВЭР, ДҮРЭМ, ЖУРАМ ХЯНАСАН БАЙДАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хянасан тушаал, шийдвэр, дүрэм, журмын тоо	-	98	43	18	18	42
2	Хүчингүй болгосон тушаал, шийдвэр, дүрэм, журмын тоо	-	-	10	-	2	3
3	Хянаж, санал өгсөн ёс зүйн дүрмийн тоо	5	9	7	-	3	11

Хүснэгт 2. УДИРДАМЖИЙН ДАГУУ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Ажилласан төрийн байгууллагын тоо	384	214	26	36	46	118
2	Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр ажилласан тоо	8	30	13	18	40	53

**Хүснэгт 3. ХАМТРАН АЖИЛЛАСАН ОЛОН УЛСЫН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,
ХӨТӨЛБӨР**

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Олон улсын байгууллага, хөтөлбөрийн тоо	-	-	2	2	4	3
2	Төрийн бус байгууллагын тоо	-	-	2	2	3	7

**Хүснэгт 4. ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, ӨДӨРЛӨГ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨР**

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хурал, хэлэлцүүлэг, сургалтын тоо	8	4	25	35	139	277
2	Нээлттэй хаалганы өдөр, өдөрлөгийн тоо	-	-	3	-	8	8
3	Төсөл, хөтөлбөрийн тоо	-	-	-	-	1	2

Хүснэгт 5. ЗӨВЛӨМЖ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН БАЙДАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Төрийн байгууллагуудад хүргүүлсэн Зөвлөмжийн тоо	2	3	14	15	10	47
2	Зөвлөмжийн хэрэгжилттэй нь танилцсан байгууллагын тоо	-	-	21	21	12	16

Хүснэгт 6. АВЛИГЫН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, САНАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Тайлангийн тоо	-	1	1	-	-	1
2	Саналын тоо	-	-	-	-	-	2

Хүснэгт 7. ХИЙСЭН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Судалгаа, дүн шинжилгээний ажлын тоо	1	-	-	3	4	3
2	Төрийн байгууллагын цахим сайтад хийсэн үнэлгээний тоо	23	17	-	35	64	83

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Төрийн албан хаагчдад зориулсан сургалтын тоо	165	-	41	27	129	277
2	Төрийн албан хаагчдад зориулсан сургалтад оролцсон хүний тоо	11,345	8,497	24,378	13,820	27,304	53,183
3	Иргэдэд зориулсан сургалтын тоо	2	1	1	-	2	12
4	Иргэдэд зориулсан сургалтад оролцсон хүний тоо	142	1,635	6,381	-	125	4,917
5	Оюутан, сурагчдад зориулсан сургалтын тоо	-	7	1	-	3	2
6	Оюутан, сурагчдад зориулсан сургалтад оролцсон хүний тоо	-	743	-	-	216	520
7	Цахим хэлэлцүүлгийн тоо	1	-	-	8	94	87
8	Цахим хичээлд оролцсон хүний тоо	525	-	-	2,371	22,645	21,938
9	Цахим хэлэлцүүлгийн тоо	-	-	-	3	5	0
10	Сургагч багш бэлтгэх сургалтын тоо	6	1	1	1	6	0
11	Сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан хүний тоо	827	20	65	25	42	278
12	Боловсруулсан сургалтын хөтөлбөр, модулийн тоо	-	-	-	27	34	17

Хүснэгт 2. ХЭВЛҮҮЛСЭН МАТЕРИАЛ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Ном, гарын авлага, эмхэтгэлийн тоо	2	2	-	16	9	6
2	Ном, гарын авлага, эмхэтгэл хэвлэсэн тоо	1,000	4,000	-	-	5,554	11,200
3	Зурагт хуудасны тоо	4	5	14	52	6	10
4	Зурагт хуудас хэвлэсэн тоо	1,200	15,000	2,100	-	3,000	3,000
5	Календарь хэвлэсэн тоо	-	-	-	-	5,685	3,000
6	Мэдээллийн болон сурталчилгааны хуудасны тоо	-	-	1	-	-	0
7	Мэдээллийн болон сурталчилгааны хуудас хэвлэсэн тоо	-	-	5,000	-	-	0
8	Стикер хэвлэсэн тоо	2,000	-	-	-	-	47,400
9	Нугалбарын тоо	1	-	-	3	2	15
10	Нугалбар хэвлэсэн тоо	3,000	-	-	-	6,000	21,000
11	Номын хавчуурганы тоо	-	-	1	-	-	-
12	Номын хавчуурга хэвлэсэн тоо	-	-	1,000	-	-	-
13	Хэвлэсэн хавтасны тоо	1,000	1,000	-	-	-	-
14	Хэвлэсэн дэвтэрний тоо	2,000	2,000	-	-	400	3,000
15	Мэдээллийн самбарын тоо	-	-	170	520	328	-

Хүснэгт 3. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Зохион байгуулсан аяны тоо	1	3	-	2	2	1
2	Аяны үйл ажиллагаанд оролцсон хүний тоо	-	345	-	1,426	150,396	-
3	Зохион байгуулсан өдөрлөгийн тоо	-	2	3	-	8	11
4	Өдөрлөгт оролцсон хүний тоо	-	3,848	170	-	1,158	32,948
5	Үндэсний хурал, чуулган, зөвлөгөөний тоо	1	-	2	-	2	-
6	Үндэсний хурал, чуулганд оролцсон хүний тоо	-	-	529	-	385	-
7	Зохион байгуулсан уралдаан, тэмцээний тоо	-	1	5	1	2	4
8	Уралдаан, тэмцээнд оролцсон хүний тоо	-	-	589	125	205	108
9	Зохион байгуулсан хэлэлцүүлэг, уулзалт, хурлын тоо	5	2	-	1	91	8
10	Хэлэлцүүлэг, уулзалт, хуралд оролцсон хүний тоо	57	110	-	-	1,352	420
11	Сурталчилгааны материал түгээсэн тоо	-	8,600	48,275	17,060	19,402	40,000

Хүснэгт 4. СУРТАЛЧИЛГААНЫ КОНТЕНТ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Кино, анимэйшн, зохиомж, жүжиг, дууны тоо	-	3	-	14	7	10
2	Подкастын тоо	-	-	-	51	-	10
3	Телевизийн нэвтрүүлгийн тоо	1	40	1	21	24	24
4	Телевизийн ярилцлагын тоо	1	-	1	2	2	2
5	Видео шторкны тоо		4	5	29	46	11
6	Видео шторкийг мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн тоо	-	-	-	17,633	27,900	20
7	Радио нэвтрүүлгийн тоо	1	3	-	100	15	2
8	Радио шторкны тоо	6	6	-	1	219	180
9	Радио шторкийг нэвтрүүлсэн тоо	-	60	-	265	5,933	65,700
10	Хэвлэлийн мэдээний тоо	-		-	243	525	62
11	Сонин, сайтын нийтлэл, ярилцлагын тоо	-	6	-	18	16	-
12	Гудамжны LED дэлгэц, самбарт байршуулсан сурталчилгааны тоо	-	3	8	136	38	8

Хүснэгт 5. ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Телевиз	16	5	17	57	18	3
2	Сонин	2	-	-	5	3	-
3	Сайт	3	1	2	8	8	1
4	Радио	3	2	3	23	7	2
5	Компани, студи	5	4	2	5	54	3
6	Төрийн бус байгууллага	22	9	14	25	8	8
7	ОУ-ын байгууллага, хөтөлбөр	3	1	1	3	4	1

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР

Хүснэгт 1. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хэвлэлийн албан мэдээ, мэдээлэл	151	162	172	243	181	207
2	Албаны эх сурвалжийн ярилцлага, тодруулга	7	11	26	18	3	91
3	Мэдээлэл, сурталчилгааны ажил, аян	2	11	26	6	2	319
4	Мэдээллийн хуудас /сонин/	3	2	4	2	1	4
5	Хэвлэлийн бага хурал	5	14	10	-	-	3
6	Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга бүхий ном, эмхэтгэл, товхимол, хэвлэмэл материал	-	1	1	1	1	135
7	Нийтлэл, нэвтрүүлэг	17	22	66	25	24	36
8	Интерактив мэдээлэл	4	23	102	23	20	41
9	Цахим хуудсан дахь мэдээллийн тоо	181	477	534	712	313	501

УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүснэгт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИН

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Улс төрийн авлигын түвшин	3.97	3.93	4.08	3.98	3.82	4.18
2	Цар хүрээ	3.94	3.99	4.13	4.10	4.13	4.24
3	Хэлбэр	3.92	3.81	4.04	3.89	4.04	4.10
4	Шалтгаан нөхцөл	4.15	4.09	4.21	4.13	3.93	4.29
5	Хор уршиг, үр дагавар	3.91	3.81	3.98	3.93	3.98	4.15

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүснэгт 1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, хүйсээр

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хүүхдийн шударга байдлын түвшин	3.97	3.91	3.91	4.01	4.06	3.96
2	Эрэгтэй	3.85	3.73	3.85	3.91	3.94	3.82
3	Эмэгтэй	4.07	3.90	3.96	4.09	4.10	4.01

Хүснэгт 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, аймаг, нийслэлээр

Но.	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	Архангай	3.95	3.79	3.88	3.99	4.05	4.00
2	Баян-Өлгий	3.98	3.72	3.61	3.80	3.51	3.66
3	Баянхонгор	4.04	3.99	3.95	4.04	4.10	4.05
4	Булган	3.95	3.98	3.88	3.92	4.00	4.00
5	Говь-Алтай	4.03	4.39	4.04	3.89	4.08	4.01
6	Говьсүмбэр	4.09	3.90	3.88	4.04	4.09	3.87
7	Дархан-Уул	4.02	4.11	3.93	4.03	4.04	3.96
8	Дорноговь	3.70	4.14	3.95	4.08	4.03	3.89
9	Дорнод	4.11	3.96	3.93	4.02	4.10	4.03
10	Дундговь	4.26	4.19	3.93	4.07	4.13	4.14
11	Завхан	4.04	4.21	3.97	3.97	4.09	4.01
12	Орхон	3.99	3.40	3.83	4.06	4.02	3.97
13	Өвөрхангай	3.72	4.06	3.91	4.05	4.01	4.06
14	Өмнөговь	3.97	3.39	4.03	4.03	4.17	4.01
15	Сүхбаатар	3.96	3.92	3.90	4.08	4.10	4.00
16	Сэлэнгэ	4.10	4.13	3.91	4.01	4.08	3.90
17	Төв	3.81	4.11	3.97	3.95	4.14	3.99
18	Увс	4.03	4.11	3.98	4.09	4.09	4.05
19	Ховд	4.00	3.97	3.94	3.98	4.03	3.96
20	Хөвсгөл	4.28	4.01	3.99	4.07	4.07	4.04
21	Хэнтий	4.24	3.89	3.94	3.95	4.05	3.98
22	Улаанбаатар	3.95	3.78	3.88	4.03	4.09	3.92

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүснэгт 1. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Но.	Үзүүлэлт	2015	2016	2018	2019	2021	2022
1	Шударга байдлын түвшин	73.80	69.70	68.70	74.10	72.90	73.90
2	Гадаад шударга байдлын үнэлгээ	69.80	63.30	63.30	71.70	67.00	70.50
3	Дотоод шударга байдлын үнэлгээ	81.90	80.90	76.80	80.80	81.20	82.20
4	Бодлогод оролцогчдын үнэлгээ	69.80	64.80	66.00	69.80	70.40	69.00

Хүснэгт 2. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, байгууллагаар

Но.	Үзүүлэлт	2015	2016	2018	2019	2021	2022
1	Шударга байдлын үнэлгээ	73.80	69.70	68.70	74.10	72.90	73.90
2	Яам	72.83	69.19	68.90	73.20	72.80	74.40
3	Батлан хамгаалах яам	78.90	77.72	76.80	80.40	69.50	80.50
4	Гадаад харилцааны яам	77.23	73.54	80.20	76.70	73.70	77.60
5	Сангийн яам	75.59	75.53	67.10	75.50	73.40	75.30
6	Хууль зүй, дотоод хэргийн яам	72.24	66.62	66.20	73.60	70.90	71.50
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	71.36	73.34	73.20	73.50	72.10	78.80
8	Эрчим хүчний яам	75.37	69.04	64.90	73.50	79.90	78.70
9	Барилга, хот байгуулалтын яам	65.82	65.73	68.00	73.20	73.00	68.00
10	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	69.32	65.50	66.10	71.90	66.10	71.10
11	Эрүүл мэндийн яам	66.14	66.74	66.30	71.50	68.20	65.20
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	73.51	71.94	66.80	70.90	75.60	76.00
13	Боловсрол, шинжлэх ухааны яам	77.15	64.03	67.10	70.60	72.20	68.40
14	Зам, тээврийн хөгжлийн яам	69.04	64.47	70.30	70.40	73.60	74.50
15	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	71.27	65.29	64.60	70.20	72.40	71.20
16	Аж үйлдвэрийн яам	72.61	-	-	-	-	-
17	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	70.01	-	-	-	-	-
18	Соёлын яам	-	-	-	-	77.80	79.50
19	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-	-	-	-	-	75.20
20	Эдийн засаг, хөгжлийн яам	-	-	-	-	-	79.40
21	Агентлаг	75.51	70.54	70.70	75.20	73.90	75.60
22	Соёл, урлагийн газар	-	62.95	83.60	83.70	71.40	74.80
23	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-	-	83.10	82.30	72.20	73.60
24	Гадаадын иргэн, харьяатын газар	77.49	74.13	76.60	82.30	76.80	80.00
25	Онцгой байдлын ерөнхий газар	77.80	73.39	70.60	81.70	69.40	78.90
26	Оюуны өмчийн газар	79.44	-	76.10	81.60	78.70	79.20
27	Цаг уур, орчны шинжилгээний газар	81.42	73.75	76.00	80.70	74.80	72.80
28	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	75.67	73.82	75.50	79.30	73.30	78.40
29	Архивын ерөнхий газар	75.34	77.30	66.10	79.20	76.90	79.60
30	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.09	71.44	80.40	78.70	75.70	72.10
31	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	73.90	69.55	72.00	78.20	79.20	78.20
32	Улсын бүртгэлийн ерөнхий газар	73.71	73.54	67.90	78.20	67.30	72.20

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ - 2022

33	Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.67	72.38	73.70	77.80	70.50	82.30
34	Мал эмнэлгийн ерөнхий газар	73.36	69.86	70.30	76.70	67.80	70.80
35	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	73.09	66.96	74.20	75.10	74.30	76.70
36	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	76.86	72.14	70.40	75.00	78.30	74.80
37	Цагдаагийн ерөнхий газар	77.07	61.99	69.20	74.60	73.40	73.60
38	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	79.00	74.13	72.60	73.90	67.90	-
39	Ашигт малтмал, газрын тосны газар	68.19	64.85	65.90	73.90	67.70	74.80
40	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	77.28	71.24	72.90	73.00	79.50	76.50
41	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	67.27	70.46	65.90	72.40	71.50	68.10
42	Стандарт, хэмжил зүйн газар	79.22	74.11	68.20	70.30	77.10	79.30
43	Татварын ерөнхий газар	69.21	70.73	63.40	70.10	70.40	72.60
44	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-	-	66.90	69.50	74.80	75.20
45	Иргэний нисэхийн ерөнхий газар	72.26	71.55	68.90	66.00	69.70	75.00
46	Үндэсний хөгжлийн газар	76.45	75.25	76.40	65.70	81.40	-
47	Биеийн тамир, спортын улсын хороо	-	61.41	62.70	65.00	73.20	69.90
48	Гаалийн ерөнхий газар	68.89	65.92	67.70	64.80	68.20	65.80
49	Газрын тосны газар	77.61	-	-	-	-	-
50	Тахарын ерөнхий газар	79.33	-	-	-	-	-
51	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	-	-	-	72.60	79.60
52	Усны газар	-	-	-	-	77.10	81.30
53	Үндэсний геологийн алба	-	-	-	-	75.40	75.50
54	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	-	-	-	79.90	88.00
55	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	-	-	-	79.30	72.80
56	Боловсролын ерөнхий газар	-	-	-	-	-	70.50
57	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР	72.95	69.04	66.10	73.20	71.40	71.00
58	Завхан аймгийн ЗДТГ	66.18	67.38	83.20	81.10	68.20	79.50
59	Төв аймгийн ЗДТГ	71.27	66.95	63.90	77.30	74.50	81.60
60	Өвөрхангай аймгийн ЗДТГ	72.58	75.25	61.40	77.20	78.40	77.60
61	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	73.63	77.69	71.70	77.00	76.30	61.20
62	Орхон аймгийн ЗДТГ	72.23	68.69	57.80	76.60	76.50	77.90
63	Дархан-Уул аймгийн ЗДТГ	70.89	69.85	72.00	76.60	74.60	66.20
64	Дорноговь аймгийн ЗДТГ	81.29	64.02	70.90	75.90	68.00	78.40
65	Дорнод аймгийн ЗДТГ	71.35	70.53	69.00	75.70	71.40	68.50
66	Хэнтий аймгийн ЗДТГ	70.80	71.54	66.80	75.60	81.10	75.00
67	Булган аймгийн ЗДТГ	75.31	68.18	68.10	75.10	71.50	70.60
68	Архангай аймгийн ЗДТГ	72.24	67.50	62.50	73.10	68.00	70.00
69	Увс аймгийн ЗДТГ	79.44	71.87	74.00	72.40	77.80	74.00
70	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	78.53	64.53	67.20	72.00	68.80	69.50
71	Хөвсгөл аймгийн ЗДТГ	78.97	68.61	64.70	71.80	59.00	64.30
72	Баянхонгор аймгийн ЗДТГ	72.99	67.80	66.70	71.30	68.80	68.50
73	Нийслэлийн ЗДТГ	72.76	71.27	67.70	71.20	72.00	74.10
74	Дундговь аймгийн ЗДТГ	66.58	66.31	55.50	69.80	72.80	75.70
75	Сүхбаатар аймгийн ЗДТГ	77.14	74.86	68.30	69.80	72.90	71.80
76	Өмнөговь аймгийн ЗДТГ	67.57	66.15	67.90	68.70	68.40	69.60
77	Говь-Алтай аймгийн ЗДТГ	76.26	68.47	59.30	68.30	72.40	62.90
78	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	65.48	64.20	55.60	67.70	61.80	63.00
79	Ховд аймгийн ЗДТГ	71.33	67.13	61.20	66.70	67.30	64.60

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА

Хүснэгт 1. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГЫН ТОО

Но.	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
1	Судалгаанд хамрагдсан нийт байгууллагын тоо	24	15	10	7	4
2	Яам	10	-	-	-	1
3	Агентлаг	14	-	7	4	2
4	Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	15	1	1	1
5	Засаг даргын Тамгын Газар	-	-	1	-	-
6	Засгийн газрын тусгай сан	-	-	1	2	-